МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -05- 18
БҮРТГЭВ-03

СЗХ он сар өдөр БҮРТГЭВ

ERDENES SOLUTIONS

# "ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС" ХК

## ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

"Эрдэнэс Сольюшинс" ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурлын ТУЗТ 11/2021 тоот тогтоолоор компанийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөг баталж, уг төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг төвлөрүүлэх зорилгоор компанийн зарласан энгийн хувьцаанаас тодорхой хэсгийг "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-аар дамжуулан нэмж эргэлтэд гарган олон нийт болон стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгохоор шийдвэрлэсэн билээ. Мөн 2022 оны 5 дүгээр сарын 15-ний өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурлын ТУЗТ 09/2022 тоот тогтоолоор нэмж гарган нийтэд санал болгох энгийн хувьцааны нэг бүрийн үнийг 108 төгрөг байхаар тогтоож, тогтоосон үнийн аргаар санал болгох тухай шийдвэр гарсан. Нэмж гаргаж буй Үнэт цаасны танилцуулгыг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйл, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 225 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 3.5 дахь хэсэг болон "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 2018/01 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 4 дүгээр зүйлд тус тус заасныг үндэслэн бэлтгэв.

| | |
|---|---|
| Нийт нэмж гаргаж буй хувьцааны тоо ширхэг | 16,572,469 |
| Нэмж гаргаж буй хувьцааны төрөл | Энгийн хувьцаа |
| Нэмж гаргаж буй хувьцааны нийтэд санал болгох нэг бүрийн үнэ | 108 төгрөг |
| Нийт татан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ | 1,789,826,652 төгрөг |
| Нэмж гаргаж буй хувьцааны нийт хувьцаанд эзлэх хувь | 9.5% |
| Үнэт цаас гаргагчийн бүртгэлтэй бирж | Монголын Хөрөнгийн бирж |
| Үнэт цаасны код | AMT / 175 |

**Үндсэн андеррайтер**

**ГҮҮДСЕК ҮЦК ХХК**

**Туслах андеррайтер**

**ЭС ЖИ КАПИТАЛ ҮЦК ХХК**

2022 .05. 25 БҮРТГЭВ

2022 -03- 22 БҮРТГЭВ-03

## ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД

Үнэт цаас гаргагч "Эрдэнэс сольюшинс" ХК нь "Монгол Улсын Компанийн тухай" хууль, "Үнэт цаасны зах зээлийн тухай" хууль болон "Санхүүгийн зохицуулах хороо", "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн холбогдох журмуудын дагуу нэмэлт хувьцаа гарган олон нийтэд санал болгож байна.

Энэхүү Үнэт цаасны танилцуулга нь Хөрөнгө оруулагч таны хараат бус үнэлгээ гаргах, шинжилгээ хийхийг орлохгүй бөгөөд тэдгээрт тооцогдохгүй. Хөрөнгө оруулагч та Үнэт цаас гаргагч болоод түүний гаргаж буй үнэт цаас, холбогдох мэдээллийн талаар өөрийн хөндлөнгийн судалгаа шинжилгээг хийсний үндсэн дээр хөрөнгө оруулалт хийж буй бөгөөд санхүүгийн, хуулийн болон бусад зохих мэргэжлийн зөвлөгөөг авахыг зөвлөж байна.

**Үнэт цаасыг "Монголын хөрөнгийн бирж" бүртгэсэн нь уг үнэт цаасны эрсдэлийн талаар аливаа баталгаа гаргаагүй болохыг анхаарах нь зүйтэй. Энэхүү үнэт цаасыг худалдан авах замаар хөрөнгө оруулалт хийх нь хөрөнгө оруулагч таны хувьд ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ үйлдэл байдгийг онцгойлон анхаарч, үнэт цаасны танилцуулга, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.**

Тус үнэт цаасны танилцуулгад хөрөнгө оруулагч таны хувьцаа худалдан авах шийдвэр гаргалтад туслах, шаардлагатай гэсэн бүхий л мэдээллийг оруулахыг зорилоо. Хөрөнгө оруулагч таны шийдвэр гаргалтад танилцуулгад тусгагдсан мэдээллээс бусад дэлгэрэнгүй мэдээлэл шаардлагатай буюу лавлах тодруулах зүйлсийг үнэт цаас гаргагч "Эрдэнэс сольюшинс" ХК болон үндсэн андеррайтер "Гүүдсек ҮЦК" болон туслах андеррайтер "Эс Жи Капитал ҮЦК" ХХК-д хандана уу.

ERDENES SOLUTIONS Joint Stock Company

УЛААНБААТАР ХОТ ГҮҮДСЕК ҮЦК ХХК

2022 -05- 25

2022 -03- 22
БҮРТГЭВ-03

# ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

## БЭЛТГЭХЭД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД

### ҮНДСЭН АНДЕРРАЙТЕР

GOODSEC ГҮҮДСЕК ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗӨВЛӨХ, БРОКЕР, ДИЛЛЕР, АНДЕРРАЙТЕР

Нэр: ГҮҮДСЕК ҮЦК ХХК
Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Чингисийн гудамж 8/1, Сити Тауэр, 1803 тоот.
Утас: (976) 11-33-1878
Вэб: www.goodsec.mn
И-мэйл: ipo@goodsec.mn

### ТУСЛАХ АНДЕРРАЙТЕР

SGC

Нэр: ЭС ЖИ КАПИТАЛ ҮЦК ХХК
Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, 30-р байр, 10 давхар.
Утас: (976) 7011-2191
Вэб: www.sgcapitalsec.com
И-мэйл: info@sgcapitalsec.com

### ХУУЛИЙН ЗӨВЛӨХ БАЙГУУЛЛАГА

B&P

Нэр: ӨМГӨӨЛЛИЙН БАТБАЯР ЭНД ПАРТНЭРС ХХК
Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө-8, Монгол ТВ цамхаг, 10 давхар, 1001-1003 тоот
Утас: (976) 7711-9008
Вэб: www.bnp.mn
И-мэйл: contact@bnp.mn

### АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

PKF

Нэр: ПИ КЭЙ ЭФ МОНГОЛИА АУДИТ ХХК
Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг-14240, 1-р хороо, Жамьян гүний гудамж-18/1, Даун Таун Бьюлдинг, 602 тоот.
Утас: (976) 7505-7979, (976) 9919-3732
Вэб: www.pkf.mn
И-мэйл: bayarmaa@ pkf.mn

### ҮНЭЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА

Нэр: МӨНХ ОРГИЛ ТРЕЙД ХХК
Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, МҮЭ-ийн Холбооны Ерөнхий Зөвлөлийн байр, 211 тоот өрөө.
Утас: (976) 7013-3256
И-мэйл: bestcon6@gmail.com

Эрдэнэс Солюшинс ХК ERDENES SOLUTIONS Joint Stock Company

УЛААНБААТАР ХОТ ГҮҮДСЕК ҮЦК ХХК

***ГАРЧИГ***

Товчилсон үгийн тайлбар 8
Нэр томъёоны тайлбар 9
**1.Үнэт цаас гаргагчийн тухай** **10**
1.1 Үнэт цаас гаргагчийн хуулийн этгээдийн бүртгэл 10
1.2 Компанийн товч танилцуулга 10
1.3 Түүхэн замнал 11
1.4 Компанийн эрхэлж буй үйл ажиллагаа 12
1.4.1 D3ARS систем 13
1.4.2 БРОКЕРС.МН СИСТЕМ 15
1.4.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮРТГЭЛИЙН СИСТЕМ 16
1.4.4 ПРОГРАММЫН ТҮВШНИЙ НУУЦЛАЛ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ 20
1.4.5 ЗОЧИД БУУДЛЫН БҮРТГЭЛИЙН СИСТЕМ 21
1.4.6 СИСТЕМҮҮДИЙГ ХӨГЖҮҮЛЖ ДУУСАХААР ТӨЛӨВЛӨСӨН ХУГАЦАА 21
1.5 Компанийн санхүүгийн үзүүлэлтүүд 21
1.5.1 БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО, АШИГ 21
1.5.2 Актив хөрөнгө 22
1.5.3 Өр төлбөр болон Эздийн өмч 23
1.6 Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн тухай 24
1.6.1 Компанийн нөлөө бүхий 5 хувиас дээш хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл 24
1.6.2 Үнэт цаас гаргагчийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид, тэдгээрийн дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмшиж байгаа хувьцааны тоо, хэмжээ 25
1.7 Үнэт цаас гаргагчийн бүтэц зохион байгуулалт, эрх бүхий албан ТУШААЛТАН 26
1.8 Үнэт цаас гаргагчийн хийсэн гэрээ, хэлцэл 34
1.8.1 Хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, хэлцэл 34
1.8.2 Их хэмжээний хэлцэл 35
1.8.3 Сонирхлын зөрчилтэй хэлцэл 35
1.9 Үнэт цаас гаргагчийн холбогдох этгээдийн тухай 36
1.10 Үнэт цаас гаргагчийн засаглалын журмууд болон ногдол ашгийн бодлого боловсруулж баталсан тухай 36
1.10.1 Компанийн тухай хуулийн 75,79,81 дүгээр зүйлүүдийг дагаж мөрдөх талаар 37
1.10.2 Компанийн эрх бүхий байгууллагаар батлуулсан ногдол ашгийн бодлого 38
1.11 Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй зах зээл болон макро орчны судалгаа 38
1.11.1 Финтек салбарын дэлхийн чиг хандлага 38
1.11.2 Макро орчны судалгаа 45

1.12 Үнэт цаас гаргагчийн зах зээлд эзлэх байр суурь 58
1.13 Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт 59
1.13.1 Эйс Ассошиэйтс ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгө нэмэгдүүлэх 59
1.13.2 Кларо трейд ххк 60
1.14 Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөний тойм 63
1.14.1 Стратеги 63
1.14.2 Байгууллагын бүтэц зохион байгуулалт 64
1.14.3 Маркетинг 64
1.14.4 SWOT шинжилгээ 65
1.14.5 Санхүүгийн төлөвлөгөө 68
1.14.6 Ноогдол ашгийн бодлого ба төлөвлөгөө 70
1.14.7 Эрсдэлийн шинжилгээ 70
1.14.8 Монголын хөрөнгийн биржийн арилжаа 74
**2.Үнэт цаасны тухай 76**
2.1 Үнэт цаасны танилцуулга 76
2.2 Үнэт цаас гаргах тухай эрх бүхий этгээдээс гаргасан шийдвэр 77
2.3 Нийтэд санал болгох үнэ тогтоосон үндэслэл, шийдвэр 79
2.4 Нийтэд санал болгох үнэт цаасны төрөл тоо, хэлбэр, нэрлэсэн үнэ, нөлөө бүхий энгийн хувьцаа эзэмшигчдийн эзэмшлийн өөрчлөлт 81
2.5 Нийтэд санал болгох болон арилжих нөхцөл 82
2.6 Үнэт цаас худалдан авах заавар 84
2.7 Нийтэд санал болгож байгаа үнэт цаасаар гэрчлэгдэх эрх, үүрэг 84
2.7.1 Үнэт ЦААС эзэмшигчийн эрх 84
2.7.2 Үнэт цаас эзэмшигчийн үүрэг 86
2.8 Үнэ тогтворжуулах хөтөлбөр 86
**3.Үнэт цаас гаргах ажиллагаанд оролцсон этгээдүүдийн тухай мэдээлэл 87**
3.1 Үнэлгээний компанийн мэдээлэл 87
3.2 Үнэлгээний компанитай байгуулсан гэрээний эрх, үүрэг хариуцлагын тухай мэдээлэл 88
3.3 Аудитын компанийн мэдээлэл 89
3.4 Аудитын компанитай байгуулсан гэрээний эрх, үүрэг хариуцлагын тухай мэдээлэл 90
3.5 Хуулийн компанийн мэдээлэл 91
3.6 Хуулийн компанитай байгуулсан гэрээний эрх, үүрэг хариуцлагын тухай мэдээлэл 92
3.7 Андеррайтерийн компанийн мэдээлэл 93
3.8 Андеррайтерийн компанитай байгуулсан гэрээний эрх, үүрэг хариуцлагын тухай мэдээлэл 94

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -03- 22
БҮРТГЭВ-03

**Хүснэгт**

Хүснэгт 1. Хуулийн этгээдийн мэдээлэл ........ 10
Хүснэгт 2. Системүүдийн зах зээлд нийлүүлэх хугацаа ........ 21
Хүснэгт 3. Борлуулалтын орлого болон Татварын дараах ашиг /мян.төг/ ........ 21
Хүснэгт 4. Нийт актив /мян.төг/ ........ 22
Хүснэгт 5. Нийт өр төлбөр ба Эздийн өмчийн дүн /мян.төг/ ........ 23
Хүснэгт 6. Нөлөө бүхий 5 хувиас дээш хувьцаа эзэмшигчид /2022.03.02-ны өдрийн байдлаар/ ........ 24
Хүснэгт 7. Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшил /2022.03.02-ны өдрийн байдлаар/ ........ 24
Хүснэгт 8. "Субашид тек" ХХК-ны хувьцаа эзэмшигчид ........ 25
Хүснэгт 9. Компанийн хувьцаа эзэмшигчдийн холбогдох этгээдүүдийн хоорондын хамаарал, тэдгээрийн тухай мэдээлэл ........ 25
Хүснэгт 10. Компанийн эрх бүхий албан тушаалтны компани дах хувьцаа эзэмшил ........ 34
Хүснэгт 11. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээний төрлийн тоо үзүүлэлт ........ 34
Хүснэгт 12. Инфляцын төсөөлөл ........ 48
Хүснэгт 13. Инфляцын төсөөллийг өөрчилж болзошгүй тодорхой бус байдал ........ 49
Хүснэгт 14. Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл 30 хувийн магадлалтай итгэх интервал ........ 52
Хүснэгт 15. Эдийн засгийн өсөлтийн төлөвт гарсан өөрчлөлт (2021) ........ 52
Хүснэгт 16. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт /сая.төг/ ........ 59
Хүснэгт 17а. Хувьцаа нэмж гаргахын өмнө хувьцаа эзэмшигчдийн эзэмшлийн хувь ........ 61
Хүснэгт 187б. Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт ........ 61
Хүснэгт 198а. Хувьцаа нэмж гаргахын өмнө хувьцаа эзэмшигчдийн эзэмшлийн хувь ........ 62
Хүснэгт 20б. Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт ........ 62
Хүснэгт 21. SWOT шинжилгээ ........ 65
Хүснэгт 22. Орлогын тайлангийн төсөөлөл 2022-2025 /мян.төг/ ........ 69
Хүснэгт 23. Санхүүгийн байдлын тайлангийн төсөөлөл 2022-2025 /мян.төг/ ........ 70
Хүснэгт 24. Нэмж гаргах хувьцааны тоо ширхэг, үнэ, нийт татах дүн, зарцуулалт ........ 76
Хүснэгт 25. Дахин нэмж гаргах хувьцааны тоо ширхэг, үнэ, нийт татах дүн ........ 76
Хүснэгт 26. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид анхдагч зах зээлд арилжих хувьцааны тоо ширхэг, үнэ, нийт дүн ........ 77
Хүснэгт 27. Үнэлгээний дүгнэлт ........ 80
Хүснэгт 28. Олон нийтэд нэмж 9.5%-ийн энгийн хувьцааг нэмж гаргасаны дараах нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн эзэмшлийн өөрчлөлт 2022 оны 03-р сарын 02-ны өдрийн эцсийн байдлаар ........ 81
Хүснэгт 29. Олон нийтэд нэмж 10.5% -ийн энгийн хувьцааг нэмж гаргасны дараах нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн бүтэц ........ 81

ERDENES SOLUTIONS Joint Stock Company
УЛААНБААТАР ХОТ ГҮҮДСЕК ҮЦК ХХК

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -05- 18
БҮРТГЭВ-03

Хүснэгт 31. Нөлөө бүхий энгийн хувьцаа эзэмшигч тус бүрийн нийтэд худалдах хувь............**Error! Bookmark not defined.**

Хүснэгт 32. Үнэ тогтворжуулах нөхцөл....................86

Хүснэгт 33. Мөнх-Оргил трейд ХХК-ний үнэлгээчдийн мэдээлэл....................87

**График**

График 1. Финтекийн санхүүгийн салбарт үзүүлж буй нөлөөллийн харьцуулалт....................39

График 2. Финтек орлогыг нэмэгдүүлнэ....................39

График 3. Финтекийн салбарт 2010-2017 онуудад хийгдсэн хөрөнгө оруулалт, бүс нутгаар....................40

График 4. Финтекийн салбарын 2010-2017 онуудын хөрөнгө оруулалт....................41

График 5. Дэлхийн Финтек компаниуд ба Монгол компаниуд (тэрбум ам.доллар)....................44

График 6. Инфляци....................45

График 7. Ерөнхий инфляц болон инфляцад өндөр нөлөөтэй бүтээгдэхүүнүүдийн жилийн өсөлт.46

График 8. Улаанбаатар хотын жилийн инфляцын бүрэлдэхүүнээр....................47

График 9. Инфляцын төсөөлөл....................48

График 10. Нийт эрэлт....................50

График 11. Нийт нийлүүлэлт....................50

График 12. 4 улирлын нийлбэр ДНБ-ий жилийн өсөлт....................51

График 13. М2 мөнгөний жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, актив тал....................53

График 14. Төгрөгийн ам.доллартой харьцах ханш....................54

График 15. Төгрөгийн гол валютуудтай харьцах ханш болон нэрлэсэн үйлчилж буй ханшийн жилийн өөрчлөлт....................55

График 16. Төгрөгийн бодит ханшийн жилийн өөрчлөлт....................55

График 17. Төгрөгийн харьцангуй өгөөж....................56

График 18. Хөрөнгийн захын голлох үзүүлэлтүүд....................57

График 19. Хөрвөх чадварын харьцаа....................57

График 20. Түүхэн ханш....................75

**Зураг**

Зураг 1.ББСБ-ын системийн бүтэц....................17

Зураг 2. Бүтэц зохион байгуулалт, Охин компаниуд....................26

Зураг 3. Финтекийн хөгжиж буй 8 чиглэл....................42

Зураг 4. Компанийн дунд хугацааны стратеги....................63

Зураг 5. Байгууллагын бүтэц зохион байгуулалт....................64

Зураг 6. Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах явц....................82

Зураг 7. Хувьцаа худалдан авах заавар....................84

ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК

ONGOLIAN STOCK EXCHA
2022 -03- 22
БҮРТГЭВ-03

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

| | |
|---|---|
| AI | Хиймэл оюун ухаан (Artificial Intelligence) |
| APAC | Ази номхон далайн орнууд |
| API | Нээлттэй протокол (Application programming interface) |
| АПП | Аппликейшн (Application) |
| BI | Бизнесийн ухаалагжилт (Business Intelligence) |
| EMI | Цахим мөнгө гаргагч (Electronic money issuer) |
| EPS | Нэгж хувьцаанд ногдох ашиг (Earnings per share) |
| ERP | Банкны дотоод бүртгэл (Enterprise Resource Planning) |
| IT | Мэдээллийн технологи (Information Technology) |
| NES | Бизнесийн, уян хатан, цогц, суурь систем (Nomad Enterprise Suite) |
| NFC | Богино зайд харилцах технологи (Near Field Communication) |
| P/B | Үнэ ба эзэмшигчдийн өмчийн харьцаа (Price to Book ratio) |
| P/E | Үнэ ашгийн харьцаа (Price to Earning ratio) |
| ROA | Хөрөнгийн өгөөж (Return on Assets) |
| ROE | Эзэмшигчдийн өмчийн өгөөж (Retun on Equity) |
| SWOT | Давуу тал, Сул тал, Боломж, Аюул (Strengths, Weaknesses, Opportunites, Threats) |
| ААН | Аж ахуйн нэгж |
| ААНОАТ | Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар |
| АТТ | Арилжааны төлбөр тооцоо |
| ББӨ | Борлуулсан бүтээгдэхүүний өртөг |
| ББСБ | Банк бус санхүүгийн байгууллага |
| ГЗ | Гүйцэтгэх захирал |
| ДНБ | Дотоодын нийт бүтээгдэхүүн |
| КТХ | Компанийн тухай хууль |
| МХБ | Монголын хөрөнгийн бирж |
| СЗХ | Санхүүгийн зохицуулах хороо |
| СТОУС | Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт |
| ТУЗ | Төлөөлөн удирдах зөвлөл |
| УОО | Урьдчилж орсон орлого |
| ҮСХ | Үндэсний статистикийн хороо |
| ҮЦЗЗ | Үнэт цаасны зах зээл |
| ҮЦЗЗТХ | Үнэт цаасны зах зээлийн тухай хууль |
| ҮЦК | Үнэт цаасны компани |
| ҮЦТХТ | Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв |
| ХК | Хувьцаат компани |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ХХОАТ | Хувь хүний орлогын албан татвар |
| ХЭХ | Хувьцаа эзэмшигчдийн хурал |
| ШШГЕГ | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар |

ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company



УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК

# НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

| | |
|---|---|
| Үнэт цаас гаргагч | Хувьцаагаа олон нийтэд худалдахаар санал болгож буй компани |
| Финтек | Санхүүгийн үйлчилгээг технологитой хамтатгасан бизнесийн төрөл |
| Аппликейшн | Гар утсанд суулгаж ашигладаг програм |
| Андеррайтер | Үнэт цаас гаргагчийн хувьцааг олон нийтэд санал болгох үйл ажиллагааг гүйцэтгэгч байгууллага |
| Нэгж хувьцаанд ногдох ашиг | Цэвэр ашгийн дүнг гаргасан хувьцааны тоонд харьцуулсан дүн |
| Үнэ ашгийн харьцаа | Зах зээлийн үнийг нэгж хувьцаанд ногдох ашигт харьцуулсан дүн |
| Хөрөнгийн өгөөж | Цэвэр ашгийг нийт хөрөнгөд харьцуулсан дүн |
| Эзэмшигчдийн өмчийн өгөөж | Цэвэр ашгийг эзэмшигчдийн өмчид харьцуулсан дүн |
| Их хэмжээний хэлцэл | Компанийн өөрийн хөрөнгийн 25 хувиас дээш үнийн дүн бүхий гэрээ, хэлцэл |
| Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлд заасан гэрээ, хэлцэл |
| Анхдагч зах зээл | Анх удаа олон нийтэд хувьцаагаа худалдаж буй арилжаа |
| Арилжаа | Үнэт цаас худалдах, худалдан авах ажиллагаа |
| Хиймэл оюун ухаан | Өөрийгөө хөгжүүлж байдаг төгс програм |
| Домайн нэр | Цахим хуудас буюу вэб сайтын хаяг |
| Сервер | Тусгай програм хангамж суулгасан, өндөр хурдны интернетэд холбогдсон, байнга асаалттай байж, вэб сайтын хэвийн үйл ажиллагааг хангадаг тусгай зориулалтын тоног төхөөрөмж |
| Клауд | Үүлэн тооцоолол (cloud computing): Сүлжээнд холбогдсон програм хангамж ба виртуал хэлбэрт шилжсэн техник тоног төхөөрөмж, тэдгээрийг уян хатан удирдан зохицуулах програм хангамж болон түүнд үндэслэсэн үйлчилгээ |

# 1.ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ

## 1.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛ[1]

***Хүснэгт 1. Хуулийн этгээдийн мэдээлэл***

| | |
|---|---|
| Оноосон нэр: | "Эрдэнэс сольюшинс" ХК - Erdenes solutions LLC |
| Улсын бүртгэлийн дугаар: | 9010001131 |
| Улсын бүртгэлд бүртгэгдсэн огноо: | 1996.04.20 |
| Регистрийн дугаар: | 2015358 |
| Үйл ажиллагаа: | - Программ хангамжийн үйл ажиллагаа<br>- Компьютерын тоног төхөөрөмжийн худалдаа<br>- Вэб сайт хийх, онлайн худалдаа эрхлэх<br>- Бусад мэдээллийн технологийн үйлчилгээ |
| Хувьцаа эзэмшигчдийн тоо: | 241 |
| Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ: | 1,578,745,700.00 (нэг тэрбум таван зуун далан найман сая долоон зуун дөчин таван мянга долоон зуу) төгрөг |
| Хөрөнгийн биржид бүртгэлтэй эсэх : | МХБ-ийн III ангилалд бүртгэлтэй |
| Оршин байгаа хаяг: | Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, Бакула Ринбучийн гудамж, 30-р байр, 10-р давхар |
| Холбоо барих утас: | (976) 7011-9588 |
| И-мэйл: | khudermunkh@erdenes.solutions |
| Вэб сайт: | www.erdenes.solutions |

## 1.2 КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Компани нь анх Монгол Улсын Засгийн газрын 1991 оны 170-р тогтоолд заасны дагуу "Хар хорин хүнсний үйлдвэр"-ийг хувьчлахаар шийдвэрлэсний дагуу хүнс спиртийн үйлдвэрийг төрийн өмч давамгайлсан ХК болгон хувьчлахаар заасны дагуу Өвөрхангай аймгийн Ардын Хурлын Гүйцэтгэх захиргааны Өмч хувьчлалын комиссын 1992 оны 4-р сарын 02-ны өдрийн №6 тоот тогтоолыг үндэслэн "Амтлаг" нэртэйгээр үүсгэн байгуулагдаж, мөн оны 10-р сарын 21-ний өдөр хувьцаагаа "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн үнэт цаасны бүртгүүлэн "Амтлаг" ХК болж үйл ажиллагаагаа эхэлсэн. Түүнээс хойш компанийн оноосон нэрээ 2 удаа өөрчилж /1997 онд "Шимтлэг" ХК, 2014 онд "Хар хорум пропертийс" ХК болгож тус тус/, 2020 оны 2-р сард программ хангамжийн "Эрдэнэс сольюшинс" ХХК-

[1] Хавсралт 1 - Улсын бүртгэлийн гэрчилгээ, Компанийн дүрэм.

тай нэгдэх замаар өөрчлөн байгуулагдаж одоогийн "Эрдэнэс сольюшинс" ХК /цаашид "Компани" гэх/ болсон байна.

Монгол Улсын санхүүгийн салбар сүүлийн жилүүдэд программ хангамжийн чиглэлд шинэ боломж, шинэ үйлчилгээг нэвтрүүлж дэлхийн жишигтэй хөл нийлүүлэн хөгжиж байх ба Компани нь энэ үйл явцад дэлхийн жишигт нийцсэн хэн ч, хаанаас ч холбогдон хэрэглэх бүрэн боломжтой, бүртгэл тооцооны үндсэн суурь системийг нэвтрүүлэн ажиллаж байна.

***Компанийн эрхэм зорилго***

Компани нь ил тод нээлттэй, хуулийн дагуу, оролцогч талуудыг харилцан ашигтай байлгах, харилцагчдаа найдвартай, ашиглахад хялбар, илүү хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэхийг эрхэм зорилгоо болгон үйл ажиллагаа явуулж байна.

***Компанийн үнэ цэнэ***

Компанийн үнэ цэнэ нь үнэнч шударга, бүрэн бүтэн, мэргэжлийн, гэр бүлсэг, нөхөрсөг, сэтгэл хангалуун байх болно.

***Компанийн амжилтад хүрэх түлхүүр***

Шинийг байнга эрэлхийлэх, шаргуу ажиллах, хийж байгаа ажил бүрээ нь үр дүнтэй байлгах, болзошгүй нөхцөл байдлыг урьдчилан харах, чанартай бүтээгдэхүүн үйлчилгээг боломжит хэрэглэгчид хүргэх, чадварлаг боловсон хүчинтэй байх нь Компанийн амжилтад хүрэх түлхүүр байх юм.

***Компанийн бизнес загвар***

Компанийн бизнесийн үндсэн загвар нь төрөл бүрийн үйл ажиллагаа эрхлэх чиглэлээр охин компани байгуулж, тэдгээр компаниудыг технологижуулах замаар хөрөнгө оруулах, дотооддоо программ хангамж болон систем хийж нэвтрүүлэн, түүний дотроос боломжтой программ хангамжуудыг гадаад улс оронд экспортлох гэсэн 2 үндсэн загвартай байна.

## 1.3 ТҮҮХЭН ЗАМНАЛ

| | |
|---|---|
| 1992.04 сар | Монгол Улсын Засгийн Газраас 1990 оны 170-р тогтоолоор "Хар хорин хүнсний үйлдвэр"-ийг буюу төрийн өмч давамгайлсан хүнс спиртийн үйлдвэрийг хувьчлах шийдвэр гарсны дараагаар Өвөрхангай аймгийн Ардын Хурлын Гүйцэтгэх захиргааны Өмч хувьчлалын комиссын 1992 оны 04-р сарын 02-ны өдрийн №6 тоот тогтоол гарч, түүнийг үндэслэн "Амтлаг" ХК үүсгэн байгуулагдсан. |
| 1998.01 сар | Үнэт цаасны хорооны 1997 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 18 дугаар тогтоолыг үндэслэн компанийн нэрийг "Шимтлэг" ХК болгон өөрчилсөн бөгөөд Үнэт цаасны хорооны 1998 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 08 дугаар тогтоолоор "Шимтлэг" ХК-ийн нийт гаргасан 90 038 ширхэг хувьцаанаас төрийн эзэмшлийн 53 843 ширхэг хувьцааг хасаж, 36 195 ширхэг хувьцаатай байхаар шийдвэрлэсэн. |
| 2014.02 сар | Компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2014 оны 02-р сарын 26-ны өдрийн ээлжит хурлаас компанийн оршин байх хаягийг Улаанбаатар хот руу шилжүүлж, "Шимтлэг" ХК-ны оноосон нэрийг "Хар хорум пропертийс" ХК болгохоор шийдвэрлэсэн. |
| 2019.12 сар | Гадаад валютын арилжааны зах зээлийг хөгжүүлэх зорилгоор 2019 онд "Эрдэнэс капитал маркетс" ХХК-ийг үүсгэн байгуулсан. |
| 2019.06 сар | Үнэт цаасны арилжааны төлбөр тооцооны системийг "Ариг банк"-ны захиалгаар хийж гүйцэтгэсэн. |

| | |
|---|---|
| 2020.01 сар | "Хар хорум пропертийс" ХК-ийн 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас Компанид программ хангамжийн "Эрдэнэс сольюшинс" ХХК-ийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулж, Компанийн оноосон нэрийг өөрчлөхөөр шийдвэрлэсний дагуу "Эрдэнэс сольюшинс" ХК нэртэй болсон. |
| 2020.03 сар | Үл хөдлөх хөрөнгийн салбарт зуучлалын үйл ажиллагаа эрхлэх зорилгоор тусгай зөвшөөрөл бүхий "Эрдэнэс рийл эстэйт" ХХК-ийг үүсгэн байгуулсан. |
| 2020.04 сар | Компанийн нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 15,787,457 ширхэг энгийн хувьцааг 10 хувааж нэг бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 157,874,570 ширхэг энгийн хувьцаа болгон хуваасан. |
| 2020.03 сар | Компани сууц өмчлөгчдийн холбооны мобайл аппликейшнийг "Хангал" ХХК-ийн захиалгаар хийж гүйцэтгэсэн. |
| 2020.09 сар | Компани Нийслэлийн шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацын газрын цахим хуудасны хөгжүүлэлтийг хийж ашиглалтад оруулсан. |
| 2021.03 сар | Компани аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх зорилгоор "Эрдэнэс агро энд ресортс" ХХК-ийг үүсгэн байгуулсан. |
| 2021.01 сар | Банк бус санхүүгийн салбарт үйл ажиллагаа эрхлэх "Эйс ассошиэйтс" ББСБ-ын хувьцааны 85 хувийг худалдан авсан. |
| 2021.06 сар | Банк бус санхүүгийн байгууллагын бүртгэлийн системийг зах зээлд нэвтрүүлэх зорилгоор "Буман дусал ББСБ" ХХК-тай гэрээ байгуулж хамтран ажиллахаар болсон. |
| 2021.07 сар | Үнэт цаасны зах зээлийн үйлчилгээ үзүүлэгч болон тэдний харилцагчдад зориулан "Брокерс.мн" системийн хөгжүүлэлтийг хийж, эхний хувилбарыг зах зээлд нэвтрүүлсэн. |
| 2021.12 сар | Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны хүсэлтээр мэдээлэл, гишүүний бүртгэл, сургалтын модуль бүхий программыг хөгжүүлж нэвтрүүлсэн. |
| 2022.01 сар | Хувьцаат компани, хөрөнгө оруулалтын сан болон койн гаргагч зэрэг нийтэд мэдээлэл хүргэх үүрэг бүхий этгээдүүдийн нийтэд мэдээлэх мэдээллийг мэдүүлэх, цахим өгөгдөл цуглуулах, баримт бичигт дүн шинжилгээ хийх, олж авах зохиогчийн эрх бүхий D3ARS-the Digital Data Disclosure, Analysis and Retrieval System-ыг хийж дуусгасан. |

## 1.4 КОМПАНИЙН ЭРХЭЛЖ БУЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

"Эрдэнэс Сольюшинс" ХК нь техник технологи, программ хангамжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг банкны болон дотоодын санхүүгийн системд танигдсан чадварлаг боловсон хүчнээс бүрдсэн компани юм. Одоогийн байдлаар дотоодын санхүүгийн зах зээлд программ хангамж нийлүүлэх хэд хэдэн гэрээ хэлцлүүдийг хийн амжилттай ажиллаж байгаа бөгөөд гадаадын зах зээлд нэвтрэхээр анхан шатны гэрээ хэлцэл, хамтран ажиллах гэрээнүүд мөн хийгдсэн байна.

Компанийн хийж гүйцэтгэсэн программ хангамжуудын шийдлүүдээс дурдвал:

1.4.1 D3ARS СИСТЕМ

Энэ систем нь хувьцаат компани, хөрөнгө оруулалтын сангууд болон койн гаргагч эрх бүхий этгээдүүдийн нийтэд мэдээлэх үүрэг бүхий мэдээллийг мэдүүлэх, цахим өгөгдөл цуглуулах, баримт бичигт дүн шинжилгээ хийх, олж авах буюу англиар the Digital Data Disclosure, Analysis and Retrieval System болон the Digital Data Gathering, Analysis, and Retrieval System гэх үгнүүдийн эхний үсгүүдийн нийлбэр, зохиогчийн эрх бүхий D3ARS системийг 2019 оноос хойш хөгжүүлж дуусгаад байна. D3ARS систем нь мэдээлэх үүрэг бүхий этгээдүүдийн тухай бүр мэдүүлж буй мэдээллийг огноо болон цагаар бүртгэж, мэдүүлсэн мэдээллийг мэдээллийн санд цуглуулан, цугларсан мэдээллийг интернэтээр дамжуулан олон нийтэд чөлөөтэй хүргэх боломжтой систем юм. Тухайлбал Монголын хөрөнгийн бирж болон бусад санхүү, бараа таваарын арилжааны биржид оролцогч олон нийтийн компаниуд, бусад үнэт цаас гаргагчид болон оролцогч байгууллагууд хууль, төрийн эрх бүхий байгууллагын журмаар шаардсан мэдээллийг /дата өгөгдөл/ мэдүүлэг гаргах замаар заавал бүрдүүлэх, мэдээллийг тогтсон маягтын дагуу системд оруулах замаар цуглуулж, баталгаажуулах, индексжүүлэх, хүлээн авах, дамжуулах, хайх ажлыг энэ систем гүйцэтгэнэ.

$D^3$ARS системийн өгөгдлийн сангийн хөгжүүлэлт банк болон санхүүгийн байгууллагуудын ашиглаж эхлээгүй байгаа Oracle 21c version дээр хөгжүүлэгдсэн тул блокчэйнтэй технологи ашиглах, өгөгдлийн тандалт хийх боломжтой, веб технологид суурилсан тул олон нийтэд мэдээлэх болон хэрэглэгчийн олон ялгаатай эрхээр хандах боломж бүрдсэн, бусад системтэй холболт API-тай тул төрийн болон хувийн хэвшлийн системүүдтэй мэдээлэл солилцох бүрэн боломжтой, XBRL ашигладаг тул олон улсын бизнесийн мэдээлэл солилцох стандарттай олон хэлээр нийтлэгдэх боломжтой бөгөөд компани одоогоор Хувьцаа эзэмшигчдийн болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг хуульд нийцэж буй эсэхэд хянах хиймэл оюун ухаан дээр ажиллаж байна.

$D^3$ARS систем нь АНУ-д EDGAR of the US Form 8-K, Form 10-K, Form 10-Q, Form S-1, Канадад Sedar, Англид Companies House, Япон улсад EDINET, БНСУ-д DART гэх мэтээр хөгжүүлсэн систем мэдүүлсэн үнэт цаас гаргагчдын мэдүүлгийг /Filing/ хөрөнгө оруулагчид ашиглан хөрөнгө оруулах эсэх шийдвэрээ гаргадаг системтэй ижил түвшинтэй ижил хэмжээнд хөгжүүлсэн систем юм.

$D^3$ARS систем нь үнэт цаас гаргагчид болон бусад зохицуулалттай этгээдүүдийн нийтэд мэдээлэх үүрэг бүхий мэдээллийг "Үнэт цаасны зах зээлийн тухай" хуулийн "9 дүгээр зүйл.Дотоод мэдээллийг нийтэд мэдээлэх" хэсгийн "79.2.3.тухайн мэдээллийг сонирхогч этгээд саадгүй авах боломжийг хангасан бусад хэлбэрээр.", Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06-р сарын 11-ний өдрийн Дугаар 225 тоот "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын "АРАВ. Үнэт цаас гаргагчийн тогтоосон хугацаанд болон тухай бүр ирүүлэх мэдээллийн төрөл, мэдээлэх хэлбэр," Монголын хөрөнгийн бирж нь үнэт цаас гаргагчдын мэдээллийн ил тод байдлыг сайжруулах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зохицуулалтыг боловсронгуй болгох, тогтвортой санхүүжилтийн зарчмуудыг хөрөнгийн зах зээлд нэвтрүүлэх ажлын хүрээнд "Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журам"-тай бүрэн нийцэж байна.

***$D^3$ARS системийн хийж гүйцэтгэх ажлууд***

Хувьцаат компаниудын хувьцаагаа халаaслах, сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийх, эцсийн өмчлөгчийн мэдүүлэг, үнэ ханшид нөлөөлөхүйц мэдээлэл, эрх бүхий албан тушаалтнуудын хамаарал, эзэмшил, Хорооны хяналт тавих зэрэг нийт 32 мэдүүлгээр компаниудыг мэдээллийг ил болгоно. Тухайлбал:

- Компанийн хувьцаа эзэмшигчдэд хагас жилийн болон жилийн эцсийн санхүүгийн тайлангуудыг тайлагнах;
- Компанийн хувьцаа эзэмшигчдэд компанийн үйл ажиллагааны тайлангуудыг тайлагнах;
- Компанийн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлүүдийг тайлагнах;
- Компанийн 5 хувиас дээш болон хяналтын хувьцааг эзэмшигчдийг тайлагнах;
- Үнэт цаас гаргагчаас тухай бүр мэдээлэх мэдээлэл гэдэгт хувьцаа эзэмшигч болон хөрөнгө оруулагчаас шийдвэр гаргахад шаардлагатай компанийн бизнесийн болон санхүүгийн үйл ажиллагаанд бий болсон ажил хэрэг, үйл ажиллагаатай холбоотой цогц мэдээллүүдийг тайлагнах;
- Компанийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, бизнест шууд нөлөө үзүүлэхүйц гэрээ, хэлцэл байгуулах, нэмэлт өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, дуусгавар болгох, татгалзах, гэрээний хугацаа дууссантай холбоотой мэдээллийг олон нийтэд мэдээлэх бөгөөд мэдээлэлд гэрээг байгуулсан огноо, гэрээний нөхцөл, гэрээнд оролцогч талуудын эрх үүрэг, гэрээний нэг талд түүний охин хараат компани оролцсон эсэх талаарх мэдээллийг тайлагнах;
- Шүүх, прокурор, төрийн эрх бүхий байгууллагаас үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан, түүний хараат, охин компанийг хариуцагчаар татаж, захиргааны болон эрүүгийн хэрэг үүсгэсэн, шүүхээс дампуурлын тухай хууль тогтоомжийн дагуу эрх хүлээн авагч томилогдсон талаарх мэдээллийг тайлагнах;
- Үнэт цаас гаргагч нийт активын 25 хувь ба түүнээс дээш хэмжээтэй тэнцэх үл хөдлөх хөрөнгийг бусдад шилжүүлэх, барьцаалсан эсхүл бусад компанийн хяналтын багц худалдан авсан талаарх мэдээлэл, холбогдох гэрээ, хэлцлийг тайлагнах;
- Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдлын гадуурх бүртгэлтэй холбоотой санхүүгийн болон санхүүгийн бус эрх үүрэг бий болгосон гэрээ, хэлцэл, гүйлгээтэй холбоотой мэдээллийг мэдээлэх бөгөөд мэдээлэлд гэрээ, хэлцлийн хугацаа, үнийн дүн, төлбөрийн нөхцөл, гүйлгээний товч утга, богино болон урт хугацаат түрээсийн гэрээнээс бий болсон эрх үүрэг, төлбөр түргэн гүйцэтгэх чадвартай холбоотой мэдээлэл Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь үүрэгт ажлаас чөлөөлөгдсөн, гарсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд тухайн ажиллаж байсан компанийн хувьцааг бирж болон биржийн бус зах зээл дээр худалдах, худалдан авахыг хориглосон арга хэмжээ болон үүнтэй холбогдуулан компанийн төлөөлөн удирдах зөвлөлөөс гарсан шийдвэрийг тайлагнах;
- Компани хувьцаа болон бондыг олон нийтэд гаргаж буй үнэт цаасны танилцуулга зэргийг тодорхой маягтын дагуу харуулах.
- Хөрөнгө оруулагчид Мэдээллийн сангийн хайлтыг компанийн нэр, салбарын бүлэг, баримт бичгийн төрөл эсвэл гаргасан огноогоор хайж болох боломжтой.

***$D^3$ARS системийн ач холбогдол***

Олон тооны компанийн мэдүүлгийг багтаасан D3ARS систем нь хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, нийтэд мэдүүлэх үүрэг бүхий мэдээллийн төрлийг нэмэгдүүлж, мэдээлэл хүргэх процессыг хялбаршуулж, олон нийтэд түргэн шуурхай хүргэх боломжийг бий болгон, үнэт цаасны зах зээлийн үр ашиг, ил тод байдал, компаниудын шударга байдлыг нэмэгдүүлэх замаар хөрөнгө оруулагчид, компаниуд болон Монгол улсын эдийн засагт үр өгөөжөө өгнө.

Нээлттэй компаниуд санхүүгийн болон бусад чухал мэдээллүүдийг тогтмол, цаг тухайд нь үнэн зөв, бүрэн гүйцэд гаргаж байх ёстой бөгөөд хөрөнгө оруулалтын сан, хөрөнгийн менежерүүд, хөрөнгө оруулалтын мэргэжилтнүүд болон бусад зах зээлд оролцогчдоос мэдлэг, мэдээлэлтэй байдлаар хэзээ, ямар компанид хөрөнгө оруулах болон хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад энэ систем ихээхэн ач холбогдолтой.

Түүнчлэн Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, буруутай этгээдэд хариуцлага тооцох, цаашдын буруутай үйлдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хөрөнгө оруулагчдыг хамгаалахад системийн ач холбогдол өндөр юм. Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

### 1.4.2 БРОКЕРС.МН СИСТЕМ

Үнэт цаасны арилжааны "Брокерс.мн" системийн зорилго зах зээлийн зуучлагч брокер, тэдний харилцагчдад үнэт цаасны болон арилжааны төлбөр тооцоо гүйцэтгэх эскроу данс нээх, үнэт цаасны арилжаанд оролцох, брокерийн компаниуд харилцагчдадаа чанартай хурдан үйлчилгээг хурдан шуурхай, хялбар үзүүлэхэд оршино.

Энэхүү "Брокерс.мн" систем нь таваарын арилжааны бирж болон хөрөнгийн бирж дээр иргэн, аж ахуйн нэгж шууд зайнаас оролцож арилжаа хийх, брокерийн болон банк санхүүгийн байгууллагуудын харилцагчдын бүртгэл үүсгэх, хөтлөх, харилцагчийн харилцах дансны бүртгэл хөтлөх, үнэт цаасны төлбөр тооцоо хийх, хувьцааны бүртгэл хөтлөх цогц систем юм.

"Брокерс.мн" систем нь дараах үндсэн хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

- Брокерийн үндсэн модуль - Brokers Core Module
- Хувьцааны болон Валютын Арилжаа хийх платформ – Stock/FX Trading Platform
- Харилцагчийн бүртгэл – Customers Registration
- Харилцагч арилжаа хийсэн болон нээлттэй байгаа арилжаагаа харах, хийгдсэн хэлцлүүдээ харах, түүнтэй холбоотой ашиг алдагдлаа харах, тооцоолох – Open Position & Profit / Loss & Historical Reports
- Харилцагч өөрийн дансны мөнгөн хөрөнгийн гүйлгээнүүдээ хянах, дансаа зузаатгах болон мөнгө татаж авах – Customer Account, Money Deposit & Withdrawal
- Арилжааны арын алба – Back Office
- Арилжааны дундын алба – Middle Office
- Хувьцааны үүсмэл хэрэгсэл арилжаа – CFD & Margin Trade
- Санхүүгийн бүртгэл болон тайлан – Financial Module & Reports
- Харилцагч үнэт цаасны төлбөр тооцоо гүйцэтгэгч арилжааны банканд үнэт цаасны төлбөр тооцоо гүйцэтгэх эскроу данс нээх хүсэлт илгээх - Open Escrow Account at Commercial Banks
- Брокер харилцагчийн дансыг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд дансыг нь үүсгэх- Create Customer Account at Mongolian Central Securities Depository

Системийн дээр дурдсан хэсгүүдийг дэлгэрүүлбэл Брокерын үндсэн модуль нь:

- нягтлан бодох бүртгэлийн ерөнхий дэвтэр;
- харилцагчийн бүртгэл хөтлөх модуль;
- арилжааны бүртгэл хөтлөх модуль;

- дансны бүртгэл хөтлөх модуль;
- төлбөр тооцооны бүртгэл зэрэг үндсэн модулиас бүрдэнэ.

Арилжаа хийх платформ нь веб суурьтай бөгөөд харилцагч веб болон мобайл аппликейшн IOS, Android үйлдлийн систем ашиглан арилжаанд оролцох боломжийг олгоно.

Харилцагчийн бүртгэл нь системд бүртгэлтэй брокерын компаниас сонголт хийн харилцагч болох хүсэлтийг алсын зайнаас бүртгүүлж дараах үйлчилгээг харилцагч хүлээн авна. Үүнд:

- Харилцагч брокерын болон банк бус санхүүгийн байгууллагын компанид данс нээх хүсэлт илгээх;
- Арилжааны бүтээгдэхүүний үнэ ханш харах;
- Арилжааны бүтэгдэхүүнтэй холбоотой зах зээлийн мэдээлэл авах;
- Харилцагч арилжааны бүтэгдэхүүнтэй холбоотой хийсэн хэлцлүүд, дансны гүйлгээнүүдээ харах;
- Харилцагчийн тухайн мөчид худалдан авсан эсхүл худалдсан арилжааны бүтэгдэхүүний хэлцлийг харах, зах зээлийн ханштай харьцуулсан ашиг, алдагдлаа харах;
- Дансны мөнгөн гүйлгээнүүдээ харах;
- Харилцагч дансаа зузаатгах, мөнгө татан авах үйлчилгээ авах.

Харилцагчийн бүртгэл нь систем нь харилцагчид хийсэн болон нээлттэй байгаа арилжаа, хийгдсэн хэлцлүүд, түүнтэй холбоотой ашиг алдагдлаа харах, тооцоолох, харилцагч тухайн үед худалдан авсан болон худалдсан арилжааны бүтэгдэхүүнээ зах зээлийн ханштай харьцуулах, ашиг алдагдлыг түүхийг харах боломж олгоно. Мөн харилцагч өөрийн дансны мөнгөн хөрөнгийн гүйлгээнүүдээ хянах, удирдах боломжтой юм.

Брокерын компанийн хувьд харилцагчдын хийсэн арилжааны хэлцлүүдийг баталгаажуулах, хийгдсэн арилжааны дотоод гүйлгээнүүдийг автоматаар хийх, харилцагчийн зээлжих зэрэглэл /Credit Rating/-ийг тогтоох, тэдгээрт VAR-Value at Risk арга ашиглах, харилцагчдын арилжааны стоп лосс, лимит зэргийг тооцоолно.

Хувьцааны үүсмэл хэрэгслийн арилжаа функц нь харилцагчдад үүсмэл хэрэгсэл санал болгох, зээлээр арилжаанд оролцох боломжийг олгоно.

Санхүүгийн бүртгэл болон тайлан нь брокерын компанийн нягтлан бодох бүртгэл, холбогдох тайланг тухай бүр өндөрлөгөө хийж боловсруулан гаргах боломжтой.

Харилцагч үнэт цаасны төлбөр тооцоо гүйцэтгэгч арилжааны банканд үнэт цаасны төлбөр тооцоо гүйцэтгэх эскроу данс нээх хүсэлт илгээж нээлгэх, банк санхүүгийн байгууллагын харилцагчдын хувьд дансыг арилжааны банкнуудад хүсэлт илгээн нээх боломжийг олгоно. Мөн брокер энэхүү системээс харилцагчийн дансны мэдээллийг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд илгээж, зайнаас нээлгэх боломжтой.

### 1.4.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮРТГЭЛИЙН СИСТЕМ

Банк санхүүгийн байгууллагын цогц систем нь ОУ-ын нягтлан бодох бүртгэлийн стандарт, Монгол Улсын Сангийн яам, Монгол банк, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан хууль, тогтоомж, холбогдох дүрэм, журам, заавар нийцсэн банк бус санхүүгийн байгууллагад зориулсан цогц шийдэл юм.

ББСБ-ийн цогц систем нь веб технологи ашиглан олон хэрэглэгчийн горимтой, өндөр ачаалал даах чадамжтай, нууцлал аюулгүй байдлыг бүрэн хангахаар хөгжүүлсэн туе

компанийн 2020 оноос эхлэн хөгжүүлсэн нэрийн бүтээгдэхүүнүүдийн нэг бөгөөд шийдлийн хувьд одоогийн зах зээл дээр хэрэглэгдэж буй уламжлалт санхүүгийн систем дээр тулгуурлан хөгжүүлсэн системийн дутагдалтай талыг нөхөж үндсэн үйл ажиллагааны системийг банкны системийн түвшинд хүргэх, санхүүгийн модулийг илүү өргөжүүлж өгснөөр ББСБ-ийн үйл ажиллагаанаас гадна тухайн байгууллагын бүхий л төрлийн санхүүгийн бүртгэлийг хөтлөх, улирал болон жилийн төсвийн төлөвлөгөөг гаргах, тайлан мэдээлэл боловсруулах, өдөр бүр тайлан гаргах боломжоог бий болгох, албан бичгийн хөтлөлт хийх, харилцагч болон байгууллагын албан бичгийг дижитал хэлбэрээр хадгалах, цахим хуудас ашиглан маркетингийн мэдээллийг цахим сувгуудаар тараах, мобайл үйлчилгээг харилагчдад онлайнаар хүргэх болон бусад олон давуу талуудыг бий болгох харилцагч байгууллагын үйл ажиллагааг хялбарчлахыг зорьсон болно.

***Системийн ерөнхий бүтэц***

Энэхүү систем нь үндсэн буюу веб технологид суурилсан ББСБ-ийн веб аппликейшн, бусад систем, интерфейстэй мэдээлэл солилцох API /Application Programming interface/, харилцагч зориулсан мобайл аппликейшн гэсэн гурван программ хангамжаас бүрдэнэ.

***Зураг 1.ББСБ-ын системийн бүтэц***




***Системийн модулиуд***

1. Үндсэн: Системийг ажиллуулахад шаардагдах суурь тохиргоонуудыг багцлан системийн үндсэн модуль гэх ба дараах дэд модулиудыг агуулна
   - Хэрэглэгч, хэрэглэгчийн эрх
   - Салбарын нэгжийн бүртгэл
   - Системд ашиглагдах валютын бүртгэл
   - Амралт, баяр ёслолын өдрийн бүртгэл
   - Данс төлөвлөгөө
   - Журналын данс

- Бүтээгдэхүүний ангилал

2. Харилцагч: ББСБ-ийн харилцагчийн төрлөөс хамааран ялгаатай мэдээллүүдийг бүртгэх бололцоотой байна.
3. Харилцах, хугацаагүй хадгаламж: Банк Бус Санхүүгийн Байгууллага харилцагчийн харилцах дансны бүтээгдэхүүн үүсгэж эх үүсвэр татах боломжгүй ч урьдчилж төлсөн зээлийн төлбөр байршуулж эргэн төлөлт хийх өдөр орлого болгон хүлээн авах мөн хуримтлагдсан хүүгийн орлогыг харилцагчид өгөх орлого болгон шилжүүлэх, итгэмжлэлийн хугацаа дууссан үед өглөг хэлбэрээр байршуулах зориулалтаар ашиглах ижил төрлийн бүтээгдэхүүн үүсгэн ашиглах бололцоотой байна. Энэ бүтээгдэхүүнийг системийн хувьд харилцагч талд өгөх өглөгийн буюу кредит утгатай харилцах, хугацаагүй хадгаламжийн данс болгон бүртгэлд ашиглана.
4. Хугацаатай хадгаламж: Банк Бус Санхүүгийн Байгууллагууд зарчмын хувьд хугацаат хадгаламжийн бүтээгдэхүүн байхгүй хэдий ч итгэмжлэлээр харилцагчийн мөнгийг байршуулж кредит хүү олгох боломжтой байдаг. Системийн хувьд бид энэ төрлийн бүтээгдэхүүнийг үүсгэж итгэмжлэлээр хуримтлагдсан эх үүсвэрт банкны хугацаат хадгаламжийн бүтээгдэхүүнтэй ижил төрлийн бүтээгдэхүүн үүсгэж ашиглах бололцоотой байна. Ингэснээр харилцагч бүрийн итгэмжлэл өглөг, гэрээнд тусгагдсан кредит хүүгийн хуримтлалын тооцооллыг өдөр бүр хуримтлуулан бүртгэх боломжтой.
5. Зээл: Зээлийг төрөл болон зориулалт, үнийн дүн, зээлийн эх үүсвэрээс хамааруулан ангилах боломжтой бөгөөд тухайн бүтээгдэхүүний онцлогоос харилцагчийн бүрдүүлэх материал, судлах аргачлал, тавигдах нөхцөл, зээлдэгчид тавигдах шаардлага, зээлийн хүүгийн хувь, зээлийн хэмжээ харилцан адилгүй системд бүртгэлийг динамик байдлаар үүсэх хөтлөх.
6. Барьцаа хөрөнгө: Зээлийн барьцааны хөрөнгийн төрөл, барьцааны хөрөнгийн мэдээлэл бүртгэх талбар, холбогдох зураг, дижитал мэдээллийг динамикаар үүсгэж бүртгэл хөтлөх.
7. Кредит скоринг: Харилцагчийн зээл авах хүсэлтийг үндэслэн тухайн харилцагчид зээл олгох боломжийг тооцоолон зээлжих чадамжийг тоон дүнгээр илэрхийлдэг. Энгийнээр үгээр хэлбэл зээлжих чадамжийг илэрхийлсэн энэ тоон утгыг credit scoring гэнэ.

   Кредит скорингийг тооцоолоход уламжлалт буюу мэргэжилтэн судалж тооцоолох, технологид суурилсан хуримтлагдсан зээлийн түүх, зах зээлийн судалгаан, зан төлөвт үндэслэн зээл хүсэгчийн мэдээллийг автоматаар тооцоолох, дээрх 2 аргыг хамтад нь хэрэглэх хосолмол аргуудыг ашиглах бололцоотой.

   ББСБ-ийн хувьд дээрх аргуудыг иргэдийн бага дүнтэй зээлүүдэд аналитик тооцоололд суурилсан автомат аргыг ашигладаг бол өндөр дүнтэй зээлийн судалгааг уламжлалт аргаар тооцох боломжтой.
8. Цахим зээл: Цахим зээлийн модуль нь мобайл аппликейшнтэй хослон ажиллах ба ирсэн хүсэлт дээр үндэслэн зээлдэх чадамжийг тодорхойлж харилцагчид мэдэгдэх бөгөөд харилцагчтай гэрээ хийсний дараа ББСБ-аас бүх төрлийн үйлчилгээг гэрээнд заасан хүрээний дагуу дижитал хэлбэрээр авах бололцоог бий болгоно.
9. Валют арилжаа: Валютын ханш тохируулах, ханшийн өөрчлөлтөөс шалтгаалсан гадаад валютын ашиг алдагдлын тооцоо хийх, валютын арилжаа хийх боломжтой байна.

10. Хар жагсаалт: Найдваргүй харилцагчийн мэдээллийн сан үүсгэх, муу зээл төлүүлэх процессын бүртгэлийг хөтлөх боломжтой байна.

11. Төсвийн модуль: ББСБ-ийн төсвийн модуль нь эздийн өмчийг өсөлтийн хувь, өөрийн хөрөнгийн дүн дээр суурилан тухайн хэмжээний ашгийг олоход шаардагдах эх үүсвэрийн хэмжээ, зардал зэрийг урьдчилан тохируулсан өгөгдөл томъёон дээр суурилан төсвийн тооцооллыг хийнэ.

12. Албан бичиг хэрэг хөтлөлт: Харилцагчтай байгуулах гэрээний загвар бэлтгэх, гэрээг системээс хэвлэх, бусад төрлийн албан бичгийг хөтлөх, цахим хэлбэрээр хадгалах.

13. Санхүү: ББСБ-ийн үндсэн болоод аж, ахуйн нэгжийн бүхий л бүртгэлийг хөтлөх боломжтой байх ба СЗХ, болон татвар, санхүүгийн тайлан, удирдлагын бусад тоон мэдээллийг боловсруулах.

14. Тайлан: Үйл ажиллагаатай холбоотой холбох бүхий л тайланг системээс авах боломжтой ба нэмэлтээр бусад системийн мэдээллийг нэгтгэж Data Warehouse үүсгэн Oracle Business Intelligence, Tableau болон бусад ижил төрлийн бүтээгдэхүүнтэй холбох замаар интерактив тайлангийн хөгжүүлэлт хийх боломжтой.

15. Байгууллагын цахим хуудас: Цахим хуудсыг динамикаар үүсгэх тус модулийг ашиглан ББСБ-ын танилцуулга хуудсыг үүсгэж өөрийн домэйн нэртэй холбох боломжтой. Нэгдсэн удирдлагын системтэй тул системд бүртгэлтэй мэдээллээс бүхий төрлийн тоон мэдээллийг хугацааны алдагдалгүй танилцуулга хуудсанд харуулах, сошиал сувгуудаар түгээх боломжтой байна.

16. Мэдээлэх үйлчилгээ: Урьдчилан тохируулсан дүрмийн дагуу харилцагч болон ББСБ-ийн мэргэжилтнүүдэд анхааруулах, мэдэгдэх үйлчилгээг мессеж, мобайл аппликейшн, цахим шуудан зэргийг ашиглан хүргэнэ.

17. Бусад системтэй зохицон ажиллах чадамж: ББСБ-ийн цогц системийн тус компанийн хөгжүүлж буй цалин, цаг бүртгэл, хүний нөөцийн системтэй холбон ERP хэлбэрээр ашиглах боломжтой.

Технологиос үл хамааран өөр бусад шаардлагатай системүүдтэй API-аар дамжуулан холболт хийх бүрэн боломжтой.

***Ашигласан технологи***

**Oracle Apex 21.2** – Томоохон хэмжээний мэдээллийн системийг хамгийн үр ашигтайгаар, нууцлалт аюулгүй байдлыг бүрэн хангасан байдлаар бүтээх технологийг ашигласан. Ингэснээр уг системийг харьцангуй богино хугацаанд хөгжүүлсэн ба цаашдын нэмэлт хөгжүүлэлт, засварлалтыг хялбар гүйцэтгэнэ.

**Oracle ORDS 21.4** – Гадаад системүүдтэй сүүлийн үеийн RESTful стандартын дагуу холбогдох API боловсруулсан.

**Oracle Database 21c** – Мэдээлэлд хоцрогдолгүйгээр хандах, аюулгүй хадгалах болон Тасралтгүй ажиллагааг хангана.

**Flutter** – Мобайл аппликейшн хөгжүүлэхэд зориулан Google компанийн хөгжүүлсэн платформ.

2022 05 25
2022 -03- 22
БҮРТГЭВ-03

### 1.4.4 ПРОГРАММЫН ТҮВШНИЙ НУУЦЛАЛ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ

***Мэдээ, мэдээллийн нууцлал***

Хэрэглэгчийн мэдээлэл болон нууц мэдээллийг (нууц үг, ПИН код г.м.) сүлжээний аль ч түвшинд end-to-end шаардлагыг хангахаар кодчилж илгээдэг бөгөөд тус мэдээлэл нь нууцлалын алгоритмаар кодлогдон хадгалагддаг.

***Удирдлага ба администраторын эрхийн зохицуулалт***

Системд хандах хэрэглэгчдийн эрхийг тус бүрчлэн хязгаарлах боломжтой бөгөөд системд хийгдсэн аливаа үйлдлийг системийн лог болгон хадгална.

***Эрхийн түр хязгаарлалт***

Хэрэглэгчийн нууцлалыг тогтоосон давтамжтайгаар буруу оруулах үед хэрэглэгчийн эрхийг түр блоклох бөгөөд хязгаарлалтыг зөвхөн системийн удирдах ажилтан нээх эрхтэй байна. Энэ нь хэрэглэгчийн нууц мэдээллийг таах оролдлогыг хааж байгаа явдал юм.

***Системд хандалт хийх хязгаарлалт***

Системд олон дахин хандах, автоматжуулсан довтолгоог хязгаарлах үүднээс CAPTCHA (Completely Automated Public Turning test to tell Computer and Humans Apart) функц суурилуулсан болно.

***Веб түвшний нууцлал***

Веб хандалтын нууцлалыг тусгайлан хангах үйлчилгээ үзүүлдэг гуравдагч этгээдийн SSL сертификатаар хэрэглэгч ба систем хоёрын хоорондын мэдээллийг баталгаажуулан дамжуулна.

***Техник, тоног төхөөрөмжийн түвшний нууцлал, аюулгүй байдал***

Системийн тоног төхөөрөмжийг Web (цахим хуудас), Application (боловсруулах), Data (мэдээ, мэдээлэл) гэсэн гурван шатлалд хуваарилсан бөгөөд шатлал тус бүр firewall төхөөрөмжөөр тусгаарлагдана. Шатлал хооронд харилцах мэдээллийн урсгалыг зөвхөн зөвшөөрсөн эх болон төгсгөл хаягаар хязгаарласан нь зөвшөөрөлгүй аливаа хандалтыг нэвтрүүлэхгүй байх боломжийг бүрдүүлдэг.

***Хэрэглэгчийн мэдээлэл, бүртгэл, түүний нууцлал***

Хэрэглэгчийн бүртгэл:

- Хэрэглэгч нь Компанийн хамтран ажиллагч банканд биеэр очин өөрийгөө баталгаажуулахад шаардлагатай бүхий л бичиг баримтыг үзүүлэн банкны шаардлагыг хангаж бүртгүүлнэ;
- Хэрэглэгч бүртгүүлэхдээ нэвтрэх нэр, утасны дугаар гэсэн талбаруудыг өөрөө бөглөж өгөөд системээс үүсгэсэн нууц үг, пин кодоор үйлчилгээнд нэвтрэх эрхээ авна;
- Бүртгэхдээ хэрэглэгчийн гар утасны дугаарыг үүрэн холбооны операторын систем рүү хандаж дугаар ашиглалтад байгаа эсэх, идэвхтэй эсэхийг шалгаж нэг удаагийн код (явуулж баталгаажуулна.

Хэрэглэгчийг таних:

- Хэрэглэгчийг өөрийнх нь бүртгүүлэхдээ оруулсан нэвтрэх нэр, утасны дугаар, нууц үг (утасны аппликейшнээр нэг удаагийн пин код) гэсэн гурван өгөгдөхүүний бүрдлээр систем таньж баталгаажуулна. Эдгээр өгөгдөхүүний аль нэг нь л зөрөхөд систем хэрэглэгчийг таньсан гэж тооцохгүй;
- Хэрэглэгч дээрх гурван өгөгдлийг өөрийн утсанд бүртгүүлсэн хурууны хээ эсвэл нүүрний төрхөөрөө баталгаажуулж нэвтрэх боломжтой;

ERDENES SOLUTIONS Joint Stock Company 9020030899 2015558
УЛААНБААТАР ХОТ ГҮҮДСЕК ҮЦК ХХК

- Аюулгүй байдлын бас нэгэн хамгаалалт бол таны байнга ашигладаг утасны бүртгэл юм. Үүнийг "тогтмол хандах төхөөрөмж" гэж нэрлэдэг. Ажиллах зарчим нь:
  - Өмнө нь огт хандаж байгаагүй төхөөрөмжөөс хандвал таны утсанд анхааруулга мессежийг нууц кодын хамт илгээдэг. Хэрэв та өөрөө мөн бол нууц кодыг оруулаад асуудалгүй үйлчилгээгээ ашиглана;
  - Анхааруулга нь и-мэйлээр мөн давхар илгээгддэг тул гадаад оронд байхдаа ч асуудалгүй ашиглаж болно;
  - Та гар утсаа сольсон тохиолдолд нэвтрэн орохдоо "Тогтмол ашиглах төхөөрөмж" гэсэн сонголтыг идэвхжүүлэх хэрэгтэй. Ингэснээр таныг тухайн төхөөрөмжийг байнга ашиглах юм байна гэж систем ойлгон, дахин код нэхэхгүй болно.

### 1.4.5 ЗОЧИД БУУДЛЫН БҮРТГЭЛИЙН СИСТЕМ

Захиалга хүлээн авах, бүртгэх процесстой, буудлын өрөө, үйлчилгээний төрлүүдийг ангилсан үндсэн үнэ болон хямдралтай үнийн зохицуулалт хийх, захиалгын төлөвлөгөө, хуваарийг хүссэнээрээ зохион байгуулах боломжтой үр дүн, тайлан болон анализ шинжилгээ хийх боломжтой систем юм.

### 1.4.6 СИСТЕМҮҮДИЙГ ХӨГЖҮҮЛЖ ДУУСАХААР ТӨЛӨВЛӨСӨН ХУГАЦАА

*Хүснэгт 2. Системүүдийн зах зээлд нийлүүлэх хугацаа*

| № | Хөгжүүлж буй систем | Зах зээлд нэвтрүүлэх хугацаа | Хэнд |
|---|---|---|---|
| 1 | Үнэт цаасны арилжааны платформ | 2022-IY улирал | Үнэт цаасны компаниуд |
| 2 | Банк бус санхүүгийн байгууллагын систем | 2022-I улирал | Эйс ассошиэйтс ББСБ болон бусад ББСБ-д |
| 3 | Зээлийн оноо өгөх & Онлайн байдлаар зээл олгох модуль | 2022-II улирал | Эйс ассошиэйтс ББСБ-д |
| 4 | Гадаад валютын арилжааны платформ | 2022-IY улирал | Эрдэнэс капитал маркетс ХХК-д |
| 5 | Үнэт металлын арилжааны платформ | 2022-IY улирал | Эрдэнэс коммодитийс трейдинг ХХК-д |
| 6 | Үл хөдлөх хөрөнгө зуучлалын систем | 2023-IY улирал | Эрдэнэс рийл эстэйт ХХК-д |

## 1.5 КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД[2]

### 1.5.1 БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО, АШИГ

Компанийн борлуулалтын орлого болон татварын дараах ашгийг онуудаар харьцуулан харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

*Хүснэгт 3. Борлуулалтын орлого болон Татварын дараах ашиг /мян.төг/*

| Он | Борлуулалтын орлого | Татварын дараах ашиг алдагдал |
|---|---|---|
| 2019 | | (3,100.0) |
| 2020 | 21,262.6 | (147,381.9) |
| 2021 | 869,800.0 | 697,590.4 |

Компанийн нийт борлуулалтын орлого Компанид программ хангамжийн "Эрдэнэс сольюшинс" ХХК-ийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулсан 2020 оноос хойш тогтвортой

[2] Хавсралт 3 - Аудитлагдсан санхүүгийн тайлан.

өсөж 2021 онд программ хангамжийн борлуулалтын орлого 869.8 сая төгрөгт хүрсэн ба тухайн жилд зарим хийгдэж дуусаагүй ажил үйлчилгээний орлогыг Орлогын тайланд тусгаагүй болно.

## 1.5.2 АКТИВ ХӨРӨНГӨ

Компанийн Санхүү байдлын тайлангийн үзүүлэлтийг сүүлийн 3 жилээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

***Хүснэгт 4. Нийт актив /мян.төг/***

| Үзүүлэлт | 2019 он | 2020 он | 2021 он |
|---|---|---|---|
| ***Эргэлтийн хөрөнгө*** | | | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | | 17,066.2 | 12,752.3 |
| Татвар, НДШ-ийн авлага | | | 928.8 |
| Бусад авлага | | | 260.0 |
| Бараа материал | | 24,660.0 | 91,055.1 |
| Урьдчилж төлсөн зардал / тооцоо | | 33,575.0 | 46,500.0 |
| **Эргэлтийн хөрөнгийн дүн** | - | **75,301.2** | **151,496.2** |
| ***Эргэлтийн бус хөрөнгө*** | | | |
| Үндсэн хөрөнгө | | | 297,174.2 |
| Биет бус хөрөнгө | 45.30 | 1,528,455.9 | 1,528,455.9 |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | | 20,060.0 | 890,054.7 |
| **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **45.30** | **1,548,515.9** | **2,715,684.8** |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **45.30** | **1,623,817.1** | **2,867,181.0** |

Компанийн нийт хөрөнгө "Эрдэнэс сольюшинс" ХХК-ийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулсан 2020 оноос шинэ бүтээгдэхүүн гаргах захиалгат ажил гүйцэтгэл гэх мэт бизнесийн оновчтой шийдлүүдийн дүнд тогтвортой нэмэгдэж 2021 онд өмнөх оноос нийт хөрөнгө 77 хувиар нэмэгдэж 2.9 тэрбум төгрөг болсон байна.

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-03-22
БҮРТГЭВ-03

### 1.5.3 ӨР ТӨЛБӨР БОЛОН ЭЗДИЙН ӨМЧ

Үнэт цаас гаргагчийн өр төлбөрийн бүтцэд урт хугацаат өр байхгүй, богино хугацаат өр байна.

***Хүснэгт 5. Нийт өр төлбөр ба Эздийн өмчийн дүн /мян.төг/***

| Үзүүлэлт | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|
| ***Өр төлбөр*** | | | |
| Богино хугацаат өр төлбөр | - | - | - |
| Дансны өглөг | 10,804.90 | 30,032.40 | 159,854.20 |
| Цалингын өглөг | - | 21,959.80 | - |
| Татвар, НДШ-ийн өр | - | 6,413.20 | 97,813.90 |
| Урьдчилж орсон орлого | - | - | 30,000.00 |
| Бусад богино хугацаат өр төлбөр | - | 148,427.00 | 464,937.80 |
| Богино хугацаат өр төлбөрийн дүн | 10,804.90 | 206,832.40 | 752,605.90 |
| Урт хугацаат өр төлбөрийн дүн | - | - | - |
| **Өр төлбөрийн нийт дүн** | **10,804.90** | **206,832.40** | **752,605.90** |
| ***Эздийн өмч*** | | | |
| Хувийн өмч | 3,619.50 | 1,578,745.70 | 1,578,745.70 |
| Хуримтлагдсан ашиг | (14,379.10) | (161,761.00) | 535,829.40 |
| **Эздийн өмчийн дүн** | **(10,759.60)** | **1,416,984.70** | **2,114,575.10** |
| **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **45.30** | **1,623,817.10** | **2,867,181.00** |

Компани 2021 онд 465 сая төгрөгийн өрийн хэрэгсэл гаргаж 130.16 $м^2$ талбай бүхий оффисын зориулалтай үл хөдлөх хөрөнгө худалдаж авсан бөгөөд аж ахуйн нэгжийн орлогын албан татварт 77.6 сая төгрөг, хувь хүний орлогын болон нийгмийн даатгалын шимтгэлд 20.2 сая төгрөг, үлдэх 81.2 сая төгрөгийн өр төлбөрийг хувьцаа эзэмшигч "Субашид тек" ХХК нь 2023 оны 12-р сарын 31-н хүртэл хүүгүй зээлсэн байна.

ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company



УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК

## 1.6 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТУХАЙ

Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь нэг бүр нь 10 (арав) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 157,874,570 (нэг зуун тавин долоон сая найман зуун далан дөрвөн мянга таван зуун дал) ширхэг нийт 1,578,745,700.00 (нэг тэрбум таван зуун далан найман сая долоон зуун дөчин таван мянга долоон зуу) төгрөг байна[3].

*Хүснэгт 6. Нөлөө бүхий 5 хувиас дээш хувьцаа эзэмшигчид /2022.03.02-ны өдрийн байдлаар/*

| Хувьцаа эзэмшигчийн нэр | Хувьцааны тоо | Эзэмшлийн хувь |
|---|---|---|
| "Субашид тек" ХХК | 100,451,734 | 63.63% |
| Г.Дулмаа | 9,076,765 | 5.75% |
| Ц.Хүдэрмөнх | 9,514,310 | 6.03% |
| М.Бат-Эрдэнэ | 9,400,000 | 5.95% |
| Т.Дөлгөөн | 9,400,000 | 5.95% |
| **НИЙТ** | **137,842,809** | **87.31%** |
| Бусад хувьцаа эзэмшигчид | 20,031,761 | 12.69% |
| **НИЙТ** | **157,874,570** | **100.00%** |

Үнэт цаас гаргагчийн дүрмийн 5.2-т "Компани нь зарласан нийт энгийн хувьцаанаас нэг бүрийн 10 (арав) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 157,874,570 (нэг зуун тавин долоон сая найман зуун далан дөрвөн мянга таван зуун дал) ширхэг гаргасан энгийн хувьцаатай байх бөгөөд Компанийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан журмын дагуу компани нь нийт 1,578,745,700 (нэг тэрбум таван зуун далан найман сая долоон зуун дөчин таван мянга долоон зуу) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байна." гэж тусгасан байна[4].

### 1.6.1 КОМПАНИЙН НӨЛӨӨ БҮХИЙ 5 ХУВИАС ДЭЭШ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ

Компанийн дүрмийн 6.1-д зааснаар "Компанийн хувьцаа эзэмшигч нь эзэмшиж буй хувьцаа буюу хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулсан хэмжээгээр хариуцлага хүлээнэ." гэж заасан.

*Хүснэгт 7. Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшил /2022.03.02-ны өдрийн байдлаар/*

| Компанийн хувьцаа эзэмшигчид | | Эзэмшлийн хувь | Улсын бүртгэлийн дугаар | |
|---|---|---|---|---|
| | | | Регистрийн дугаар | Улсын бүртгэлийн дугаар |
| 1 | "Субашид тек" ХХК | 63.63% | 6295541 | 9011736019 |
| 2 | Иргэн Ц.Хүдэрмөнх | 6.03% | ТЯ85080719 | |
| 3 | Иргэн Т.Дөлгөөн | 5.95% | ТЯ89053012 | |
| 4 | Иргэн Г.Дулмаа | 5.75% | УЗ48070209 | |
| 5 | Иргэн М.Бат-Эрдэнэ | 5.95% | РЭ76032576 | |

Хувьцаа эзэмшигч "Субашид тек" ХХК[5]-ийн танилцуулга:

Оноосон нэр: "Субашид тек" ХХК
Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, Денверийн 4-р давхар
Холбоо барих утас: (976) 9999-3396
Вэб сайт: www.subashid.com

[3] Хавсралт 3 - Аудитлагдсан санхүүгийн тайлан.
[4] Хавсралт 2 - "Эрдэнэс сольюшинс" ХК-ийн дүрэм.
[5] Хавсралт 9 - "Субашид тек" ХХК-ийн дүрэм.

И-мэйл: info@subashid.com

*Хүснэгт 8. "Субашид тек" ХХК-ны хувьцаа эзэмшигчид*

| д/д | Хувьцаа эзэмшигчид | | Хувь нийлүүлсэн хөрөнгөнд эзлэх хувь |
|---|---|---|---|
| 1 | Цогтбаяр | ХҮДЭРМӨНХ | 33.33% |
| 2 | Төмөрболд | ЗОЛБОО | 33.33% |
| 3 | Базар | БАТХҮҮ | 33.33% |

1998-2021 онуудын хооронд Компанийн хувьцааны 5-аас дээш хувийн хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлт, хөдөлгөөн:

1998 он Үнэт цаасны хорооны 1997 оны 02-р сарын 27-ны өдрийн 18 дугаар тогтоолыг үндэслэн компанийн нэрийг "Шимтлэг" ХК болгон өөрчилсөн бөгөөд Үнэт цаасны хорооны 1998 оны 01-р сарын 22-ны өдрийн 08 дугаар тогтоолыг үндэслэн "Шимтлэг" ХК-ийн нийт гаргасан 90,038 ширхэг хувьцаанаас төрийн эзэмшлийн 53,843 ширхэг хувьцааг хасаж 36,195 ширхэг хувьцаанаас бүрдэж байхаар шийдвэрлэсэн байна.

2013 он: Компанийн 41.71 хувийг нэг хуулийн этгээд, 31.98 хувийг иргэн Б.Батхүү нар эзэмшиж байсан байна.

2016 он: Компанийн эргэлтэд буй хувьцааны 31.97 хувийг иргэн Ж.Баярмаа, дээр заасан хуулийн этгээд 41.71 хувийг эзэмшиж байсан байна.

2020 он: Компани 2020 оны 01-р сарын 24-ний өдрийн ээлжит бус хурлаар "Эрдэнэс сольюшинс" ХХК-ийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулахаар шийдвэрлэсний дагуу зарласан хувьцаанаас 15,751,262 ширхэг хувьцааг эргэлтэд нэмж гаргасан. Эргэлтэд гаргасан хувьцааг Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 02-р сарын 28-ны өдрийн 80 тоот тогтоолоор "Субашид тек" ХХК 71.20 хувь, М.Бат-Эрдэнэ 5.95 хувь, Г. Дулмаа 5.95 хувь, Т.Дөлгөөн 5.95 хувь, Ц.Хүдэрмөнх 5.95 хувь эзэмшүүлэхээр үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулсан.

### 1.6.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД, ТЭДГЭЭРИЙН ДАНГААР БОЛОН ХОЛБОГДОХ ЭТГЭЭДИЙН ХАМТ ЭЗЭМШИЖ БАЙГАА ХУВЬЦААНЫ ТОО, ХЭМЖЭЭ

Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн холбогдох этгээдийн хоорондын хамаарал, тэдгээрийн хамт эзэмшиж байгаа хувьцааны тоо, хувь хэмжээ дараах байдалтай байна.

*Хүснэгт 9. Компанийн хувьцаа эзэмшигчдийн холбогдох этгээдүүдийн хоорондын хамаарал, тэдгээрийн тухай мэдээлэл*

| Хувьцаа эзэмшигч | | Холбогдох этгээдийн хамаарал | | |
|---|---|---|---|---|
| | | Хамаарал | Холбогдох хуулийн этгээд | Эзэмшлийн хувь |
| 1 | "Субашид тек" ХХК | Хувьцаа эзэмшигч Т.Дөлгөөн нь Т.Золбоогийн төрсөн дүү | Т.Золбоо нь"Субашид тек" ХХК-ийн 33.33%-ийн хувьцаа эзэмшигч | 5.95% |
| | | Хувьцаа эзэмшигч Г.Дулмаа нь Б.Батхүүгийн төрсөн ээж | Б.Батхүү нь"Субашид тек" ХХК-ийн 33.33%-ийн хувьцаа эзэмшигч | |
| 2 | Т.Дөлгөөн | "Субашид тек" ХХК-ийн хувьцаа эзэмшигч Т.Золбоогийн төрсөн дүү | Т.Золбоо"Субашид тек" ХХК-ийн 33.33%-ийн хувьцаа эзэмшигч | 5.95% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 3 | Г.Дулмаа | “Субашид тек” ХХК-ийн хувьцаа эзэмшигч Б.Батхүүгийн төрсөн ээж | Б.Батхүү“Субашид тек” ХХК-ийн 33.33%-ийн хувьцаа эзэмшигч | 5.81% |

## 1.7 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН

***Зураг 2. Бүтэц зохион байгуулалт, Охин компаниуд***




- “Эрдэнэс капитал маркетс” ХХК-ийг худалдааны зуучлалын үйл ажиллагаа эрхлэх зорилгоор 2019 онд байгуулсан, 17 мянган төгрөгийн;
- “Эрдэнэс агро энд ресорт” ХХК-ийг аялал жуулчлалын зорилгоор үйл ажиллагаа эрхлэх зорилгоор 2020 онд байгуулсан, 14 мянган төгрөгийн;
- “Эрдэнэс рийл эстэйт” ХХК-ийг үл хөдлөх хөрөнгийн зуучлалын үйл ажиллагаа эрхлэх зорилгоор 2020 онд үүсгэн байгуулагдсан, Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны ТЗ 601/54 тоот үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын тусгай зөвшөөрөл авсан, 19.7 сая төгрөгийн тус тус актив хөрөнгөтэй болно.

Дээрх компаниуд нь байгуулагдсан цагаас хойш “Ковид-19”-ын нөхцөл байдлын улмаас идэвхтэй үйл ажиллагаа эрхлээгүй байна.

- “Эйс ассошиэйтс ББСБ” ХХК нь 2012 оны 11-р сарын 16-ны өдөр байгуулагдсан. Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 06-р сарын 12-ны өдрийн дугаар 202 тоот тогтоолоор банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авч, гадаад валютын үйл ажиллагаа эрхэлж байна. Үнэт цаас гаргагч тус банк бус санхүүгийн байгууллагын 85 хувийг Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны 02-р сарын 05-ны өдрийн 39 тоот тушаалаар худалдан авч, үлдэх 15 хувийг иргэн Б.Батхүү эзэмшдэг байна. Тус ББСБ нь 2021 оны 12-р сарын 31-ний

өдрийн эцсийн байдлаар 851 сая төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 5.6 сая төгрөгийн хуримтлагдсан ашигтай байна.

***Компанийн эрх бүхий албан тушаалтан***

Компанийн дүрмийн 15.1[6]-д зааснаар Компанийн ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн, ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.

***Хувьцаа эзэмшигчдийн хурал***

Компанийн дүрмийн 8.1[7]-д тусгагдсаны дагуу Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна.

***Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлах***

Компанийн дүрмийн 8.3[8]-д тусгагдсаны дагуу шаардлагатай тохиолдолд КТХ-ийн 61.1, 61.7-д заасан этгээд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хэдийд ч зарлан хуралдуулж болно, 8.4-д хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах тухай шийдвэрийг компанийн ТУЗ нь КТХ-ийн 60.2-т заасан журмын дагуу гаргана[9].

***Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал***

Компанийн дүрмийн 8.3-д тусгагдсаны дагуу шаардлагатай тохиолдолд КТХ-ийн 61.1, 61.7-д заасан этгээд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хэдийд ч зарлан хуралдуулж болно.

***Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал***

Компанийн дүрмийн 8.3-д тусгагдсаны дагуу шаардлагатай тохиолдолд КТХ-ийн 61.1, 61.7-д заасан этгээд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хэдийд ч зарлан хуралдуулж болно.

***Төлөөлөн удирдах зөвлөл***

Үнэт цаас гаргагч нь КТХ-ийн 75 дугээр зүйл, Компанийн дүрмийн 9.1-д тус тус заасны дагуу Компанийн ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт түүний бүрэн эрхийг хэрэгжүүлэх, компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Компанийн дүрмийн 9.2-д заасны дагуу Компанийн ТУЗ нийт 9 гишүүнтэй байх бөгөөд КТХ-ийн 75.4[10]-д зааснаар тэдгээрийн 1/3-ээс доошгүй нь хараат бус гишүүн байх бөгөөд Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн

---

6 Хавсралт 2 - "Эрдэнэс сольюшинс" ХК-ийн дүрэм, 15.1.

7 Хавсралт 2 - "Эрдэнэс сольюшинс" ХК-ийн дүрэм, 8.1.

8 Хавсралт 2 - "Эрдэнэс сольюшинс" ХК-ийн дүрэм, 8.3.

9 КТХ – 61.1.Дараах тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулна:, 61.7.Энэ хуулийн 61.4-т заасан хугацаанд төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ шийдвэр гаргаагүй тохиолдолд энэ хуулийн 61.2-т заасны дагуу санал, шаардлага гаргасан хувьцаа эзэмшигч, эсхүл төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай шийдвэрийг бие даан гаргаж болно., 60.2.Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэрт дараах зүйлийг заана:.

10 КТХ – 75.4.Хувьцаат компани болон төрийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна.

Ээлжит бус хурлаас дараах гишүүд ТУЗ-ийн гишүүдээр дор дурдсан хүмүүсийг 2020 оны 01-р сарын 24-ны өдрөөс эхэлж 3 жилийн хугацаатайгаар томилсон. Үүнд:

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд

1. Т. Золбоо ТУЗ-ын дарга
2. Ц.Хүдэрмөнх ТУЗ-ын ердийн гишүүн
3. Г.Аззаяа ТУЗ-ын ердийн гишүүн
4. Э.Цэндсүрэн ТУЗ-ын ердийн гишүүн
5. Ц.Хишигбаатар ТУЗ-ын ердийн гишүүн
6. Б.Батхүү ТУЗ-ын ердийн гишүүн
7. С.Энхжаргал ТУЗ-ын хараат бус гишүүн
8. Б.Энхзориг ТУЗ-ын хараат бус гишүүн
9. П.Нарантунгалаг ТУЗ-ын хараат бус гишүүн

ТУЗ-ын дарга, ердийн гишүүн: Төмөрболд ЗОЛБОО

| | | |
|---|---|---|
| **Боловсрол** | | |
| 1993-2003 | Дархан-Уул аймаг, Шарын гол сум 2-р 10 жил | Бүрэн дунд боловсрол |
| 2003- 2007 | ШУТИС-КТМС | Компьютерийн ухааны инженер |
| **Ажлын туршлага** | | |
| 2006-2007 | Каракас зураг ХХК | Програмист |
| 2007-2009 | МИАТ ХК | Програмист |
| 2009-2010 | Алтан тариа ХХК | Системийн шинжээч |
| 2010-одоог хүртэл | ШУТИС-МХТС-д | Багш |
| **ШШГЕГ-ийн тодорхойлолт:** | | Өргүй |
| **Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт:** | | Хугацаа хэтэрсэн өргүй |
| **Компанийн засаглалын гэрчилгээний дугаар:** | | №0430728 |

ТУЗ-ын ердийн гишүүн: Цогтбаяр ХҮДЭРМӨНХ

| | | |
|---|---|---|
| **Боловсрол** | | |
| 2001-2003 | ШУТИС ДаТИС лицей сургуульд | Бүрэн дунд боловсрол |
| 2003-2007 | ШУТИС-КТМС | Програм хангамжийн инженер |
| **Ажлын туршлага** | | |
| 2009-2016 | Хас банк | Систем хөгжүүлэгч, систем дизайнер, системийн шинжээч, системийн ахлах шинжээчээр, төслийн удирдагч, бизнесийн ахлах шинжээч |
| 2016-2018 | Бодь даатгал ХХК | Системийн шинжээч, цахим банкны хэлтэсийн захирал |
| 2019-2020 | Эрдэнэс сольюшинс ХХК | Гүйцэтгэх захирал |
| 2020-одоог хүртэл | Эрдэнэс сольюшинс ХК | Гүйцэтгэх захирал |
| 2009-2016 | Хас банк | Систем хөгжүүлэгч, систем дизайнер, системийн шинжээч, системийн ахлах шинжээчээр, төслийн удирдагч, бизнесийн ахлах шинжээч |

| | |
|---|---|
| **ШШГЕГ-ийн тодорхойлолт:** | Өргүй |
| **Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт:** | Хугацаа хэтэрсэн өргүй |
| **Компанийн засаглалын гэрчилгээний дугаар:** | №0430729 |

ТУЗ-ын ердийн гишүүн: Цэрэндулам ХИШИГБААТАР

| | | |
|---|---|---|
| **Боловсрол** | | |
| 1979-1989<br>1989-1994 | Ховд аймгийн 2-р 10-н жил<br>ОХУ Новосибирск Геодизийн дээд сургууль | Бүрэн дунд боловсрол<br>Аэрофото геодиз |
| **Ажлын туршлага** | | |
| 1994 - одоог хүртэл | Хувиараа | Хувиараа |
| **ШШГЕГ-ийн тодорхойлолт:** | | Өргүй |
| **Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт:** | | Хугацаа хэтэрсэн өргүй |
| **Компанийн засаглалын гэрчилгээний дугаар:** | | №0430732 |

ТУЗ-ын ердийн гишүүн: Галбадрах АЗЗАЯА

| | | |
|---|---|---|
| **Боловсрол** | | |
| 1988-1998 | Улаанбаатар хотын Оюуны ундраа цогцолбор | Бүрэн дунд боловсрол |
| **Ажлын туршлага** | | |
| 1998-одоог хүртэл | Союз номин ХХК | Харуулын дарга |
| **ШШГЕГ-ийн тодорхойлолт:** | | Өргүй |
| **Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт:** | | Хугацаа хэтэрсэн өргүй |
| **Компанийн засаглалын гэрчилгээний дугаар:** | | №0430730 |

ТУЗ-ын ердийн гишүүн: Базар БАТХҮҮ

| | | |
|---|---|---|
| **Боловсрол** | | |
| 1979-1989 | Улаанбаатар хот, 10 жилийн 28-р дунд сургууль | Бүрэн дунд боловсрол |
| 1993-1997 | СЭЗДС | Банк санхүү |
| **Ажлын туршлага** | | |
| 1996-2004 | ХХБанк | Эдийн засагч, ахлах эдийн засагч, Үйл ажиллагаа эрхэлсэн захирал |
| 2004-2007 | Улаанбаатар хотын банк | Дэд захирал, Гүйцэтгэх захирал |
| 2007-2009 | Капитрон банк | Гүйцэтгэх захирлын зөвлөх |
| 2009-2011 | Үндэсний аюулгүй байдлын зөвлөл | Банк санхүү хариуцсан референт |
| 2011 – Одоог хүртэл | Экспонэйншл фанд менежмент ҮЦК ХХК | Гүйцэтгэх захирал |
| **ШШГЕГ-ийн тодорхойлолт:** | | Өргүй |
| **Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт:** | | Хугацаа хэтэрсэн өргүй |
| **Компанийн засаглалын гэрчилгээний дугаар:** | | №0430452 |

ТУЗ-ын ердийн гишүүн: Эрдэнээ ЦЭНДСҮРЭН

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-03-22
БҮРТГЭВ-03

| | | |
|---|---|---|
| 2001 - 2004 | Шинэ Монгол сургууль | Бүрэн дунд боловсрол |
| 2005 - 2009 | Шиншү Их сургууль, Нагано аймаг, Япон улс | Шиншү Их сургууль, Япон улс- Иргэний барилгын инженер |
| **Ажлын туршлага** | | |
| 2009 - 2011 | Човы ХК | Үйлдвэр харнуцсан ахлах менежер |
| 2011 - 2015 | Таны зам ХХК, Таванбогд трейд ХХК | Технологи инженер, Брэнд менежер, |
| 2015-2017 | Монос Улаанбаатар ХХК | Төслийн туслах менежер<br>Төслийн менежер |
| 2017-одоог хүртэл | Шинэ Монгол сургууль | Гүйцэтгэх захирал |
| **ШШГЕГ-ийн тодорхойлолт:** | | Өргүй |
| **Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт:** | | Хугацаа хэтэрсэн өргүй |
| **Компанийн засаглалын гэрчилгээний дугаар:** | | №0430731 |

ТУЗ-ын хараат бус гишүүн: Пүрэвдорж НАРАНТУНГАЛАГ

| | | |
|---|---|---|
| **Боловсрол** | | |
| 1994-2003 | Завхан аймаг, 1-р 10 жил | Бүрэн дунд боловсрол |
| 2003- 2007 | ШУТИС-КТМС | Компьютерын ухааны инженер |
| 2011-2013 | ШУТИС-КТМС | Мэдээллийн систем, Магистр |
| **Ажлын туршлага** | | |
| 2007-2012 | Интерактив ХХК | Программист |
| 2012-одоог хүртэл | Хас банк | Систем аналист |
| **ШШГЕГ-ийн тодорхойлолт:** | | Өргүй |
| **Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт:** | | Хугацаа хэтэрсэн өргүй |
| **Компанийн засаглалын гэрчилгээний дугаар:** | | №0430725 |

ТУЗ-ын хараат бус гишүүн: Сумбараа ЭНХЖАРГАЛ

| | | |
|---|---|---|
| **Боловсрол** | | |
| 1988 - 1998 | Улаанбаатар хот 10-н жилийн 21-р сургууль | Бүрэн дунд боловсрол |
| 1998 - 2002 | Улсын багшийн их сургууль | Дүрслэх урлаг, дизайн багш |
| **Ажлын туршлага** | | |
| 2002 - 2003 | Говь ХХК | Дизайнер |
| 2003 - 2004 | Эдмон ХХК | Дизайнер |
| 2008-2019 | Монхорус интернэйшнл ХХК | Гэрээт дизайнер |
| 2019-одоог хүртэл | Авто ойл ХХК | Гэрээт дизайнер |
| **ШШГЕГ-ийн тодорхойлолт:** | | Өргүй |
| **Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт:** | | Хугацаа хэтэрсэн өргүй |
| **Компанийн засаглалын гэрчилгээний дугаар:** | | №0430726 |

ТУЗ-ын хараат бус гишүүн: Бавуужамц ЭНХЗОРИГ

| | | |
|---|---|---|
| **Бавуужамц овогтой Бавуужамц** | | |
| ТУЗ-ын хараат бус гишүүн | | |
| **Боловсрол** | | |
| 1993 - 2003 | Улаанбаатар хот 10-н жилийн 53-р сургууль | Бүрэн дунд боловсрол |

ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS
ГҮҮДСЕК ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ

| | | |
|---|---|---|
| 2003 - 2007 | ШУТИС-КТМС | Шиншу Их сургууль, Япон улс- Иргэний барилгын инженер |
| **Ажлын туршлага** | | |
| 2006 - 2007 | Хасабэ интернэйшнл ХХК | Захиргааны ажилтан |
| 2008 - 2011 | НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр | Төслийн нарийн бичгийн дарга |
| 2011-2014 | Швейцарийн хөгжлийн агентлаг | Төслийн менежер |
| 2014-одоог хүртэл | СЭЗДС | Сургалтын менежер |
| **ШШГЕГ-ийн тодорхойлолт:** | | Өргүй |
| **Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт:** | | Хугацаа хэтэрсэн өргүй |
| **Компанийн засаглалын гэрчилгээний дугаар:** | | №0430727 |

Үнэт цаас гаргагч нь одоогийн байдлаар ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо болон Цалин, урамшууллын хороодтойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

"Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 01-р сарын 28-ний өдрийн ээлжит хурлын №ТУЗТ 02/2020 тоот тогтоолоор ТУЗ-ийн дарга болон ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо болон Цалин, урамшууллын хороодын дарга, гишүүдийг сонгосон. Үүнд:

***Аудитын хороо***

Компанийн дүрмийн 10.1[11]-д тусгагдсаны дагуу аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байх бөгөөд уг хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулна. Үүнд:

- ТУЗ-ийн аудитын хорооны дарга нь хараат бус гишүүн байх бөгөөд санхүү, бүртгэл, эрсдэлийн удирдлагын чиглэлээр мэргэшсэн байна.
- ТУЗ-ийн аудитын хороо нь Компанийн тухай хуульд зааснаас гадна дараах чиг үүрэгтэй байна:
  - компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;
  - компанийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байгаа эсэх, хууль болон эрх бүхий байгууллагаас тогтоосон мэдээллийг нийтийн хүртээл болгож байгаа байдалд хяналт тавих;
  - дотоод хяналтын албаны удирдлага, ажилтныг томилох, цалин урамшууллын талаарх гүйцэтгэх удирдлагын саналыг хянах, ТУЗ-д танилцуулах;
  - хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох, түүний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах, Хорооны чиг үүрэгт хамаарах асуудлаар шалгалт хийж дүгнэлт гаргах талаар хөндлөнгийн аудитын байгууллагад чиглэл өгөх /чухам ямар чиглэлээр шалгалт хийж, дүгнэлт гаргасан байх талаар аудитын байгууллагатай байгуулах гэрээнд тусгах замаар энэ эрхээ хэрэгжүүлнэ/;
  - их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих;
  - ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад асуудал.

Аудитын хорооны гишүүд

1. П.Нарантунгалаг Хорооны дарга

[11] Хавсралт 2. "Эрдэнэс сольюшинс" ХК-ийн дүрмийн Дөрөвдүгээр бүлэг, 10.1.

2. С. Энхжаргал Гишүүн
3. Э. Цэндсүрэн Гишүүн

***Нэр дэвшүүлэх хороо***

Компанийн дүрмийн 11[12]-д тусгагдсаны дагуу ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хороо нь Компанийн тухай хуульд зааснаас гадна дараах чиг үүрэгтэй:
    - ТУЗ-ийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох;
    - ТУЗ-ийн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигч нь ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлага, хараат бус гишүүний хувьд заасан шалгуурыг хангаж байгаа эсэх талаар дүгнэлт гаргах;
    - ТУЗ-д нэр дэвшигчийг сонгон шалгаруулж, хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлэх /саналын хуудсанд шууд нэрийг нь оруулах/;
    - ТУЗ-ийн болон гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;
    - гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөлийг тодорхойлох;
    - ТУЗ-ийн гишүүдээс бусад эрх бүхий албан тушаалтны ажил үүргийн гүйцэтгэлд гүйцэтгэх захирлаас өгсөн үнэлгээнд дүгнэлт гаргах;
    - ТУЗ-д нэр дэвшсэн аливаа этгээдийн нэрийг саналын хуудсанд оруулах эсэх тухай асуудлыг хэлэлцэхдээ тухайн этгээд нь дараах нөхцөл байдлыг хянах үүрэгтэй;
    - Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан ТУЗ-ийн гишүүнд тавигдах ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлагын талаарх шаардлагыг хангаж байгаа эсэх;
    - жил бүрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа хуралдуулаагүй, эсхүл зохих журмын дагуу хуралдуулаагүйгээс бүрэн эрх нь дуусгавар болсон ТУЗ-д ажиллаж байсан эсэх;
    - ТУЗ-ийн гишүүнээр дахин нэр дэвшүүлж байгаа бол ТУЗ-ийн гишүүний хувьд үүргээ зохих ёсоор хэрэгжүүлсэн эсэх;
    - компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан эсэх.

Нэр дэвшүүлэх хорооны гишүүд

1. Б.Энхзориг Хорооны дарга
2. Ц. Хүдэрмөнх Гишүүн
3. П.Нарантунгалаг Гишүүн

[12] Хавсралт 2 - "Эрдэнэс сольюшинс" ХК-ийн дүрмийн Дөрөвдүгээр бүлэг, 11 дүгээр зүйл.

*Цалин урамшууллын хороо*

Компанийн тухай хуулийн 81.2[13], Компанийн дүрмийн 12[14]-д заасан ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хороо нь Компанийн тухай хуульд зааснаас гадна дараах чиг үүрэгтэй:

- эрх бүхий албан тушаалтны цалин урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;
- эрх бүхий албан тушаалтанд олгох цалин урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин урамшуулал олгох санал боловсруулах;
- компанийн цалин урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх.

Цалин урамшууллын хорооны гишүүд

1. Т. Золбоо — Хорооны дарга
2. С. Энхжаргал — Гишүүн
3. Б. Энхзориг — Гишүүн

*Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлага*

Үнэт цаас гаргагчийн дүрмийн 14.1-д заасны дагуу Гүйцэтгэх удирдлага нь энэхүү дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан хөлсөөр ажиллах гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, ажлаа ТУЗ-д тайлагнана. Компанийн дүрмийн 14.2-д зааснаар гүйцэтгэх удирдлагыг хувь хүн хэрэгжүүлдэг байна, 14.3-д зааснаар Компанийн Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн дарга байж болохгүй бөгөөд харин ТУЗ-ийн гишүүн байж болно[15].

Гүйцэтгэх захирал: Цогтбаяр ХҮДЭРМӨНХ

| **Боловсрол** | | |
|---|---|---|
| 2001-2003 | ШУТИС ДаТИС лицей сургуульд | Бүрэн дунд боловсрол |
| 2003-2007 | ШУТИС-КТМС | Программ хангамжийн инженер |
| **Ажлын туршлага** | | |
| 2009-2016 | Хас банк | Систем хөгжүүлэгч, систем дизайнер, системийн шинжээч, системийн ахлах шинжээчээр, төслийн удирдагч, бизнесийн ахлах шинжээч |
| 2016-2018 | Бодь даатгал ХХК | Системийн шинжээч, цахим банкны хэлтсийн захирал |
| 2019-2020 | Эрдэнэс сольюшинс ХХК | Гүйцэтгэх захирал |
| 2020-одоог хүртэл | Эрдэнэс сольюшинс ХК | Гүйцэтгэх захирал |

13 81.2.Хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын, цалин, урамшууллын, нэр дэвшүүлэх хороодтой байх бөгөөд эдгээр хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээс бүрдэнэ.

14 Хавсралт 2 - "Эрдэнэс сольюшинс" ХК-ийн дүрмийн Дөрөвдүгээр бүлэг, 12 дугаар зүйл.

15 Хавсралт 2 - "Эрдэнэс сольюшинс" ХК-ийн дүрмийн Дөрөвдүгээр бүлэг, 12 дугаар зүйл.



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-03-22 БҮРТГЭВ-03
ERDENES SOLUTIONS Joint Stock Company
УЛААНБААТАР ХОТ ГҮҮДСЕК ҮЦК ХХК

***Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтны өмчлөл дэх хувьцааны тоо, хувь хэмжээ***

***Хүснэгт 10. Компанийн эрх бүхий албан тушаалтны компани дах хувьцаа эзэмшил***

| Эрх бүхий албан тушаалтны нэр | | Эрх бүхий албан тушаал | Хувьцаа эзэмшлийн хувь |
|---|---|---|---|
| 1 | Ц.Хүдэрмөнх | ТУЗ-ын ердийн гишүүн бөгөөд, Гүйцэтгэх захирал | 6.03% |

## 1.8 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХИЙСЭН ГЭРЭЭ, ХЭЛЦЭЛ

Компани нь нийтэд санал болгон нэмж хувьцаа гаргахтай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны №225 тоот тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”, Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны №2018/01 тоот тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-д заасны дагуу “Өмгөөллийн Батбаяр энд Партнэрс” (цаашид “Хуулийн фирм” гэх) ХХН-тай Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан. Хуулийн фирмийн зүгээс гаргасан Хууль зүйн дүгнэлтэд Компанийн сүүлийн 3 жилийн буюу 2019 оны 01-р сарын 01-ний өдрөөс 2022 оны 01-р сарын 01-ний өдрийн хооронд хийгдсэн хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, хэлцэл, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй гэрээ хэлцлийг хуульд заасан журмын дагуу байгуулагдсан эсэх талаар дүгнэсэн болно.

### 1.8.1 ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН 5 БОЛОН ТҮҮНЭЭС ДЭЭШ ХУВЬТАЙ ТЭНЦЭХ ХЭМЖЭЭНИЙ ҮНИЙН ДҮН БҮХИЙ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН ГЭРЭЭ, ХЭЛЦЭЛ

Компани нь хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн бөгөөд Үнэт цаас гаргагчийн гэрээ хэлцлийг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа нийт 5 гэрээ, хэлцлийн мэдээллийг Хуулийн фирмд хүргүүлж дүгнэлт гаргуулсан. Мөн гэрээ, хэлцлийг тасалбар болгосон өдрөөс өмнө буюу 2020 оны 09 сарын 01-ний өдрөөс өмнө байгуулагдсан хэдий ч гэрээ, хэлцлийг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа 4 гэрээ байна. Гэрээ, хэлцлүүдийг гэрээний агуулгаар нь дараах байдлаар ангиллаа. Үүнд:

***Хүснэгт 11. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээний төрлийн тоо үзүүлэлт***

| № | Гэрээний нэр, төрөл | Хүчин төгөлдөр бус | Хүчин төгөлдөр |
|---|---|---|---|
| 1. | Худалдах, худалдан авах гэрээ | 3 | 1 |
| 2. | Зээлийн гэрээ | - | 1 |
| 3. | Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх гэрээ | - | 3 |
| 4. | Бусад гэрээ | 1 | - |
| **НИЙТ** | | **4** | **5** |

Хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 болон түүнээс дээш хувьцаатай тэнцэх хүчин төгөлдөр гэрээ[16]:

1. Монгол Улсын иргэн Ц.Бат-Эрдэнийн өмчлөл дэх үл хөдлөх эд хөрөнгийг худалдан авахаар харилцан тохиролцож байгуулсан Худалдах, худалдан авах гэрээ:

   Гэрээ байгуулсан огноо: 2021.06.02

2. "Субашид Тек" ХХК-тай байгуулсан хүүгүй Зээлийн гэрээ:
   Гэрээ байгуулсан огноо: 2021.01.01
   Дуусгавар болох огноо: 2023.12.31

3. Монгол Улсын иргэн Ц.Жаргалсайхан болон Бүгд Найрамдах Солонгос Улсын иргэн Чун Ёонг /Chun Yong/ нартай байгуулсан хаалттай Бондын гэрээ:
   Гэрээ байгуулсан огноо: 2021.05.27

4. Бүгд Найрамдах Солонгос Улсын иргэн Чун Ёонг /Chun Yong/-тай байгуулсан хаалттай Бондын гэрээ:
   Гэрээ байгуулсан огноо: 2021.09.06
   Бондын хэмжээ: 100,000,000 төгрөг

5. "Нүбисоцт" ХХК-тай байгуулсан Ажил гүйцэтгэх гэрээ:
   Гэрээ байгуулсан огноо: 2021.10.21

### 1.8.2 ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ

Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1.1 дэх заалтад "хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл (компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй) болон 87 дугаар зүйлийн 87.1.2 дахь заалтад "компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалт"-ыг их хэмжээний хэлцэлд тооцохоор заасан байдаг.

Үнэт цаас гаргагчийн хувьд дээр дурдсан нөхцөл бүхий их хэмжээний хэлцэл байхгүй байна.

### 1.8.3 СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ

Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэгт "Компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшиж байгаа компанитай Компанийн тухай хуульд тодорхойлсон харилцаанд орсон бол компанитай, эсхүл түүний хараат болон охин компанитай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тооцогдоно" гэж хуульчилсан.

Үнэт цаас гаргагчийн хувьд сонирхлын зөрчил бүхий 4 гэрээ хүчинтэй хэрэгжиж байгаа бөгөөд Хуулийн дүгнэлтэд дурдсанчлан сонирхлын зөрчилгүй ТУЗ-ийн гишүүдийн олонхын саналыг үндэслэж уг гэрээ хэлцлүүд хийгдсэн байна.

[16] Хавсралт 4 - Хуулийн дүгнэлт.

Сонирхлын зөрчилтэй, хүчин төгөлдөр хэрэгжиж буй гэрээ, хэлцлүүд[17]:

1. "Эс Жи Капитал ҮЦК" ХХК-тай байгуулсан Лиценз ашиглалтын гэрээ:
   Гэрээ байгуулсан огноо: 2020.03.31
2. "Субашид Тек" ХХК-тай байгуулсан хүүгүй Зээлийн гэрээ:
   Гэрээ байгуулсан огноо: 2021.01.01
   Дуусгавар болох огноо: 2023.12.31
3. "Эс Жи Капитал ҮЦК" ХХК-тай байгуулсан Түрээсийн гэрээ:
   Гэрээ байгуулсан огноо: 2021.08.02
   Дуусгавар болох огноо: 2026.08.01
4. "Экспонэйшнл Фанд Менежмент ҮЦК" ХХК-тай байгуулсан Түрээсийн гэрээ:
   Гэрээ байгуулсан огноо: 2021.09.08
   Дуусгавар болох огноо: 2026.09.07

## 1.9 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХОЛБОГДОХ ЭТГЭЭДИЙН ТУХАЙ

***Үнэт цаас гаргагчийн толгой компани***

"Субашид тек" ХХК нь Үнэт цаас гаргагчийн энгийн хувьцааны 63.74%-ийг эзэмшдэг толгой компани юм.

| | |
|---|---|
| Хуулийн этгээдийн нэр | "Субашид тек" ХХК |
| Хуулийн этгээдийн хаяг | Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, Денверийн 4-р давхар |
| Холбоо барих утас | 976-11-99993396 |
| Вэб сайт | www.subashid.com |
| И-мэйл | info@subashid.com |

***Үнэт цаас гаргагчийн зэргэлдээ компаниуд***

Үнэт цаас гаргагч компанид зэргэлдээ компани байхгүй болно.

## 1.10 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЗАСАГЛАЛЫН ЖУРМУУД БОЛОН НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО БОЛОВСРУУЛЖ БАТАЛСАН ТУХАЙ

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2016 оны 05-р сарын 12-ны өдрийн хурлын дараах тогтоолуудаар компанийн засаглалын журмуудыг батлан мөрдөж байна. Үүнд:

ТУЗТ 03/2016 тоот тогтоолоор:

- Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам

ТУЗТ 03/2016 тоот тогтоолоор:

- Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах журам
- Мэдээллийн үйл ажиллагааны журам
- Ногдол ашгийн бодлого

[17] Хавсралт 4 - Хууль зүйн дүгнэлт.

ТУЗТ 03/2016 тоот тогтоолоор:

- ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүрэм
- ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны дүрэм
- ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны дүрэм

## 1.10.1 КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 75,79,81 ДҮГЭЭР ЗҮЙЛҮҮДИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ТАЛААР

***Төлөөлөн удирдах зөвлөл***

Үнэт цаас гаргагч нь Компанийн дүрмийн 9[18] дэх хэсэгт КТХ-ийн 75 дугаар зүйлтэй холбоотой зохицуулалтыг дэлгэрэнгүй тусгаж дагаж мөрддөг болно.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих дээд байгууллага нь ТУЗ байна.

Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь 9 гишүүнээс бүрдэх бөгөөд хараат бус 3 гишүүнтэй. Ердийн гишүүдэд Ц.Хүдэрмөнх, Т.Золбоо, Б.Батхүү, Ц.Хишигбаатар, Э.Цэндсүрэн, Г.Аззаяа нар, хараат бус гишүүдэд Б.Энхзориг, С.Энхжаргал, П.Нарантунгалаг нар багтана[19].

Дээрх ТУЗ-ийн 9 гишүүн нь КТХ-ийн 75.8-д заасны дагуу компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан.

***Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн***

ТУЗ-ийн бүрэлдэхүүний 3 хараат бус гишүүн нь КТХ-ийн 79-р зүйлд зааснаар:

- Өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны тавaac дээш хувийг эзэмшдэггүй;
- Өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид ажил, албан тушаал эрхэлдэггүй, эсхүл сүүлийн 3 жилийн хугацаанд ажил, албан тушаал эрхэлж байгаагүй;
- Төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй;
- Компанитай бизнесийн аливаа холбоогүй учир уг хуулийн зүйл заалтыг дагаж мөрддөгт тооцогдож байна.

[18] Хавсралт 2 - "Эрдэнэс сольюшинс" ХК-ийн дүрмийн Дөрөвдүгээр бүлэг, 9 дүгээр зүйл.
[19] ҮЦТ-ын 1.7 дахь хэсгээс харна уу.

### 1.10.2 КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГААР БАТЛУУЛСАН НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

КТХ-ийн 46.1[20]-д заасны дагуу Компани нь ногдол ашгийг бэлэн мөнгө болон эд хөрөнгийн, түүнчлэн компанийн болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болох бөгөөд энэ тухай шийдвэрийг ТУЗ-өөс гаргана.

Компанийн жилийн санхүүгийн тайлан гарсны дараа дор дурдсан нөхцөлд татвар төлсний дараах цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилна:

- Компанийн ногдол ашгийн ойрын ба хэтийн бодлого, хуваарилалт нь ирээдүйд компанид хөрөнгө оруулалт татахуйц байх.
- Хуваарилж буй ногдол ашгийн хэмжээ нь компанийн тухайн жилийн бодит боломжоос хэтэрхий дээгүүр, эсхүл хэтэрхий доогуур биш байх.
- Компанийн жилийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгаас бизнес төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалт, нийгмийн арга хэмжээний хуваарилалтыг хасаад үлдэх хэсгийг ногдол ашигт хуваарилах зарчим баримтлах.
- Хуваарилж буй ногдол ашгийн хэмжээг (тухайн санхүүгийн жилд олсон цэвэр ашиг нь өмнөх жилийнхээс буураагүй тохиолдолд) бууруулахгүй байх бодлого баримтлах.

Компани нь эрх бүхий этгээдээр батлуулсан "Ногдол ашгийн бодлого"-ын хүрээнд ирхэ 4 жилийн хугацаанд татвар төлсний дараах цэвэр ашийн 50 болон түүнээс дээш хувьцааны ногдол ашигт хуваарилахаар төлөвлөж байна.

## 1.11 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ ЗАХ ЗЭЭЛ БОЛОН МАКРО ОРЧНЫ СУДАЛГАА

### 1.11.1 ФИНТЕК САЛБАРЫН ДЭЛХИЙН ЧИГ ХАНДЛАГА

Fintech /Financial Technology/ буюу Финтек гэдэг нь технологийн дэвшлийг ашиглан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг сайжруулж, хялбаршуулж буй санхүүгийн шинэ салбар юм. Ухаалаг гар утас ашиглан банкны болон хөрөнгө оруулалтын үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэж байгаа нь үүний нэг жишээ юм.

***Банкны сектор***

Финтек салбарын компани нь шинээр бий болж буй стартап компани байж болно эсвэл одоо явуулж буй санхүүгийн үйлчилгээгээ сайжруулах эсвэл шинээр өөрчлөх зорилготой санхүүгийн болон технологийн компаниуд байж болно.

Open Banking гэдэг нь Финтектэй холбогдох санхүүгийн нэг төрлийн хэллэг юм. Энэ нь гуравдагч этгээд болох технологийн компани "Application Programming Interface" буюу API-д тулгуурлан дата мэдээлэл боловсруулан тухайн санхүүгийн байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээг сайжруулах, үйлчлүүлэгчид болон хамтран ажилладаг байгууллага хоорондын мэдээлэл солилцооны уялдаа холбоог хялбаршуулах явдал юм.

2015 оны 10-р сард Европын парламент (PSD2) гэж нэрлэгддэг Төлбөрийн Үйлчилгээний удирдамжийг шинэчлэн баталсан. Уг шинэчлэгдсэн дүрэм нь "open-banking"-д тулгуурлан

[20] КТХ - 46.1.Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэрийг гаргах бөгөөд уг шийдвэрт хувьцаа бүрд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр болон ногдол ашиг төлөх өдөр зэргийг заана.

MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-03-22 БҮРТГЭВ

интернэт болон гар утасны төлбөрийн системийг хөгжүүлэх, ашиглах явдлыг дэмжих зорилготой юм.

***Финтек-ийн давуу тал***

Санхүүгийн үйлчилгээг илүү хялбар, хурдан, хүртээмжтэй болгоно.

***График 1. Финтекийн санхүүгийн салбарт үзүүлж буй нөлөөллийн харьцуулалт***[21]




***Финтектэй холбогдсоноор үүсэх орлогын өсөлт***

Америкийн нэгдсэн улсын FIS (Fidelity National Information Services Inc) компанийн судалгаагаар компаниуд Финтектэй холбогдсоноор орлогоо дараах байдлаар өсгөдөг байна.

***График 2. Финтек орлогыг нэмэгдүүлнэ***[22]




[21] Эх сурвалж: PwC, n=974, 2017

[22] Эх сурвалж: PwC, n=974, 2017

ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК ERDENES SOLUTIONS Joint Stock Company 9020060899

ГҮҮДСЕК ҮЦК ХХК УЛААНБААТАР ХОТ

### Финтекийн салбарын хөрөнгө оруулалтууд ба ирээдүй[23]

*График 3. Финтекийн салбарт 2010-2017 онуудад хийгдсэн хөрөнгө оруулалт, бүс нутгаар*




***Финтекийн салбарт 2010 оноос хойш 100 орчим тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Хойд Америк, Европ ба Ази номхон далайн орнуудад (APAC) нийт хөрөнгө оруулалтын ихэнх нь хийгдсэн байна. Европт хөрөнгө оруулалтын хэмжээ 2015 оноос хойш их хэмжээгээр нэмэгдэх болсон. Өнгөрсөн 2017 онд нийт 27,445 сая долларын хөрөнгө оруулалт дэлхийн хэмжээнд хийгдсэнээс ихэнх нь Хойд Америк, Европ болон Ази номхон далайн орнуудад хийгджээ.***

[23] Эх сурвалж: Accenture Research analysis of CB Insights data.

*График 4. Финтекийн салбарын 2010-2017 онуудын хөрөнгө оруулалт*[24]




Финтекийн салбарын хөрөнгө оруулалт 2017 онд нийтдээ 2,694 хэлцэл хийгдсэнээс дийлэнх хэсэг нь Зээл олголт, Төлбөр тооцоо болон Даатгалын салбарт хийгдсэн байна.

***Финтек салбарын хөгжлийн 8 чиглэл***

**REGTECHS**

Сүүлийн жилүүдэд санхүүгийн салбарт хууль, эрх зүйн зохицуулалт нэмэгдэж мөн шинэ технологийн дэвшлүүд ашиглагдаж байгаатай холбогдон санхүүгийн байгууллагууд болон санхүүгийн зохицуулах байгууллагуудад Regulatory Technology /RegTech/ ашиглан Big Data буюу асар их мэдээллийг хурдан шуурхай мөн хямд өртгөөр боловсруулах шаардлага урган гарч ирсэн.

RegTech компаниуд санхүүгийн байгууллагууд болон зохицуулах байгууллагуудтай хамтран ажилладаг бөгөөд үүлэн тооцоолол болон өгөгдлийг ашиглаж мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлж өгдөг.

Мөн сүүлийн үед дижитал бүтээгдэхүүний өсөлт нэмэгдэхийн хэрээр, кибер халдлага, мөнгө угаах болон бусад залилангийн үйл ажиллагаа ихэссэн. Үүнээс үүдэн Big Data, Machine Learning болон хиймэл оюун ухааны технологийг ашиглаж regtech нь аливаа нэг байгууллагыг учирч болзошгүй санхүүгийн болон мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломжийг бүрдүүлж өгч байна.

Эрсдэлд суурилсан хандлагад тохирсон өгөгдлийг ашиглан зохих магадлан шинжилгээнүүдийг автоматжуулах нь энэ RegTech хувьсгалын тэргүүн зарчим юм.

[24] Эх сурвалж: Accenture Research analysis of CB

***Зураг 3. Финтекийн хөгжиж буй 8 чиглэл***[25]




## INSURTECH

Insurtech нь интернэтэд суурилсан тоног төхөөрөмжийг ашиглаж шаардлагатай мэдээллийг боловсруулж харилцагчийнхаа зан төлөв болон нийгмийн хэв маягт тохируулсан гэрээний нөхцөлийг санал болгон, түүндээ төлбөрийн уян хатан саналыг гаргаж байгаа явдал юм.

Тодруулбал, Deep learning trained AI буюу гүнзгийрүүлсэн судалгааны бэлтгэгдсэн хиймэл оюун ухаан нь брокеруудын үүрэг даалгаврыг автоматаар биелүүлэн тухайн харилцагчдад хамгийн оновчтой зөв даатгалын үйлчилгээнүүдийг багцалж өгдөг. Түүнчлэн, даатгалын олон төрлийн үйлчилгээг нэгтгэн нэгдсэн удирдлага, хяналтын платформ бий болгож, гэнэтийн богино хугацаанд нэн шаардлагатай бичил даатгалын үйлчилгээг гаргаж өгдөг программ хангамжийг үйл ажиллагаандаа ашиглах болсон. Найзынхаа тээврийн хэрэгслийг нэг, хоёр цагийн хугацаанд ашиглах явцад учирч болох эрсдэлээс урьдчилан даатгах үйлчилгээ нь үүний жишээ юм. Мөн гадаад улсад 2 долоо хоног аялахаас өөрийн улсдаа 2-3 хоног аялахад хамаагүй хямд даатгал хийдэг.

Insurtech нь илүү сайн үйлчилгээ үзүүлэхийн тулд хэрэглэгчийн мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийхэд ашигтай байдаг. Хэрэв хэн нэгэн гадаад улс руу аялах бол тухайн хүн өөрийн ухаалаг гар утаснаасаа даатгалын үйлчилгээ авах боломжтой.

Insurtech гарч ирснээр даатгалын компаниуд өөрсдийн харилцагчдад үйлчлэх үйлчилгээ болон санал болгох даатгалын үйлчилгээгээ сайжруулах өрсөлдөөн бий болгож байна.

[25] Эх сурвалж: BI Intelligence, 2017

**Robo Advisor & Personal Finance**

Robo Advisor гэдэг нь санхүүгийн зөвлөх хөлсөлж авах сонирхолгүй хүмүүст зориулагдсан тухайн хүний хөрөнгө оруулалтын зорилгод таарсан зохистой хуваарилалтыг автоматаар хийж өгдөг программ хангамж юм. Зарим тохиолдолд автоматаар арилжааг нь гүйцэтгэж хөрөнгө оруулалтын зөв балансыг бүрдүүлж явдаг.

Өрхийн буюу хувийн санхүүд Fintech-ийн шийдлүүд нь олон төрөл байж болдог.

Хэрэглэгч та өөрийн интернэтэд холбогдсон гар утсаараа хувийн санхүүгийн орлого, зарлага, зээлийн картын харьцуулалтаас авхуулаад хөрөнгө оруулалт болон хөрөнгийн удирдлагын талаар суралцах зэргээр олон төрлийн үйлчилгээ авч болно.

Шинээр гарч ирж буй Fintech компаниудад өрхийн буюу хувийн санхүүгийн дараах үндсэн дөрвөн чиглэлд хөгжих томоохон боломж нээлттэй байна. Үүнд, зардлын тооцоолол, санхүүгийн боломжит бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдийн харьцуулалт, хадгаламж болон хөрөнгө оруулалт багтана.

**ALTERNATIVE FINANCE**

Алтернатив санхүү нь уламжлалт санхүүгийн систем болох арилжааны банк болон хөрөнгийн захын хувьцаа, бондоос бусад санхүүгийн сувгууд ба хэрэгслүүдийг хэлдэг. Жишээлбэл, онлайн зах зээл дэх хөрөнгө оруулалтын нээлттэй болон хаалттай сангууд, crowdfunding, банк бус санхүүгийн байгууллага гэх зэрэг технологийн шийдлүүд хэрэглэгчид болон бизнесүүдийн үйл ажиллагааг дэмжин гарч иржээ.

**BLOCKCHAIN/ DLT & BITCOIN**

Блокчэйн технологи гэдэг нь удаах бичилт буюу гүйлгээ бүрийг өмнөхөөс нь нөхцөлдүүлэн гинжин хэлхээ үүсгэн хөтөлдөг бүртгэлийн журналын шийдэл юм.

Өнөөгийн нягтлан бодох бүртгэлийн давхар бичилт (double-entry) хийж хөтлөх арга бол угтаа бас л блокчэйн технологи. Нэг ёсондоо гүйлгээ бүр нь өмнөх гүйлгээнээсээ гинжин хэлхээний хамааралтай бөгөөд энэ нь ямарваа "булхай" хавчуулах аргагүй. Гагцхүү журналыг хүн хөтөлдөг учир давхар шалгаж байх шаардлага үүсдэг бөгөөд үүнтэй холбоотой аудитын институт ажилладаг. Аудит "авлига аваагүй" л бол гинжин хэлхээ тасарсан эсэхийг дор нь олж илрүүлнэ.

Харин блокчэйн бол журнал хөтлөх үүргийг өөр дээрээ авсан завсрын зуучлагч (тухайн улсын арилжааны банкнуудын хувьд "төв банк", банкны харилцагч нарын хувьд бол банк, нэг байгууллагын хувьд бол нябо нар г.м.) этгээд байхгүй, "систем" өөрөө гинжин хэлхээгээ дижитал аргаар үүсгэж, гинжин хэлхээнд нэгэнт үүссэн гүйлгээ бүрийг тэр чигт нь дижитал аргаар "бэх"-лэж байгаагаараа онцлог юм. Нэгэнт бэхлэгдсэн бүртгэлд булхай орох аргагүй бөгөөд энэ нь анхны бүртгэл тэр чигтээ байгаа эсэхийг хөндлөнгийн аудит оруулж давхар шалгах шаардлагыг үгүй болгож байгаа юм.

**PAYMENTS & REMITTANCES**

Хяналт, зохицуулалттай банкны салбар мөнгө шилжүүлэх нь дараалал ихтэй, шимтгэл хураамж нь ойлгомжгүй, өндөр байдаг бол уг салбарт технологийн шийдлийг ашиглаж түргэн шуурхай, маш бага зардлаар найз нөхөд болон хамаатан садандаа мөнгөн гуйвуулга хийх боломж бий болж байна.

**DIGITAL BANKING & BANKING SOFTWARE PROVIDER**

Банкны салбар дахь гол FinTech чиг хандлагуудын дотор Digital Banking & Banking software provider нь онлайн платформууд болон гар утасны программуудаар банкны үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэх цорын ганц шийдэл болоод байна.

Дижитал банкнууд нь уламжлалт банкнуудын бараг л бүх данс, үйлчилгээг санал болгодог. Ингэснээр дижитал банк нь оффисын зардал зэрэгт мөнгө зарцуулдаггүй тул өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээний өртийг бага байлгах үндсэн боломж бүрдэж байгаа юм.

**Digital Identity verification**

Digital Identity гэдэг нь хэрэглэгчийг бизнесийн салбарууд, веб, гар утас, өсөн нэмэгдэж буй түншлэлийн экосистем зэрэг бүхий л сувгуудаар чөлөөтэй зорчуулах үндсэн элемент юм. Хэрэглэгчээ таних, мөнгө угаахтай тэмцэх, open banking зэрэг олон төрлийн зохицуулалтын шаардлагуудын улмаас Digital Identity нь санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад зөвхөн нийцэмжтэй байхаас гадна өрсөлдөх чадвартай байх шинэ, шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэхэд тусалдаг.

***Технологийн компаниудын зах зээлийн үнэлгээ[26]***

***График 5. Дэлхийн Финтек компаниуд ба Монгол компаниуд (тэрбум ам.доллар)***




Дээрх графикаас харахад хамгийн их үнэлгээтэй Финтекийн компаниар 18.5 тэрбум долларын үнэлгээтэй Lu.com шалгарчээ. Lendmn 0.011, Itools 0.0001 тэрбум долларын үнэлгээтэй байна. (Lendmn болон Itools компанийн хувьцааны ханшийг Монголын хөрөнгийн биржийн 2022 оны 02-р сарын 21-ний өдрийн хаалтын ханшаар, ам.долларын ханшийг Монгол банкны 2022 оны 02-р сарын 20-ны өдрийн 2,860.95 төгрөгөөр тооцоолов. Харин "Эрдэнэс сольюшинс" ХК-ийн үнэлгээ болох 0.007 тэрбум долларыг "Мөнх оргил трейд" ХХК-ийн бизнесийн үнэлгээнд суурилан Компанийн ТУЗ-ын шийдвэрээр 1 ширхэг энгийн хувьцааг олон нийтэд санал болгож буй 115.00 төгрөгт үндэслэв.)

[26] Эх сурвалж: CB

## 1.11.2 МАКРО ОРЧНЫ СУДАЛГАА

***Эдийн засгийн өсөлт***

Монголбанк хэрэглээний үнийн индексээр илэрхийлсэн инфляцыг 2021-2023 онд жилийн 6 хувийн орчимд, +/-2 нэгж хувийн интервалд тогтворжуулах зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

***Инфляцын динамик***

Өнгөрсөн 2021 оны III улиралд инфляц 1 улсын хэмжээнд 8.6 хувь, Улаанбаатар хотод 8.9 хувь болж өмнөх улирлаас өслөө. Инфляцад нэг талаас эдийн засгийн сэргэлт тодорхой хэмжээгээр нөлөөлж байгаа бол дийлэнх хэсгийг нийлүүлэлтийн хүчин зүйлс тайлбарлаж байна. Тодруулбал, цар тахлын сөрөг нөлөөг зөөллөх бодлогын арга хэмжээнүүд үргэлжлэн хэрэгжиж, эдийн засгийн үйл ажиллагаа сэргэж буй хэдий ч өрхийн хэрэглээ 4 улирал дараалан буурсан, хэрэглээний зээлийн өсөлт бага байгаа зэргээс эрэлтийн шалтгаантай инфляц алгуур нэмэгдэх хандлагатай байна. Нийлүүлэлт талаас шатахууны үнэ III улиралд өмнөх улирлаас 31 хувиар огцом өссөн, тээвэр, логистикийн зардал нэмэгдэж нийлүүлэлтийн доголдол үүссэн нь инфляцад өндөр нөлөөтэй байлаа

***График 6. Инфляци***[27]




Өнгөрсөн 2021 оны 11 дүгээр сард инфляц улсын хэмжээнд жилийн 10.5 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 10.0 хувьд хүрэхэд махнаас бусад хүнсний бүлэг болон шатахууны үнэ нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

[27] Эх үүсвэр: Үндэсний Статистикийн Хороо

*График 7. Ерөнхий инфляц болон инфляцад өндөр нөлөөтэй бүтээгдэхүүнүүдийн жилийн өсөлт*[28]




Инфляцын хөдөлгөөнд гол нөлөө үзүүлж буй бүтээгдэхүүнүүд:

**Махны үнэ** улирлын хандлагаараа 11 дүгээр сард алгуур хямдарч жилийн инфляцын 2.1 нэгж хувийг бүрдүүлж байна. Тодруулбал, үхрийн махны үнэ өсөх хандлагатай байсан бол бусад төрлийн мах буурчээ. Орон нутагт дэгдсэн малын гоц халдварт өвчин нь голлон үхэрт халддаг учраас үхрийн махны нийлүүлэлтэд тавих хяналт чангарахаас гадна, нийлүүлэлтэд нь сөргөөр нөлөөлсөн байж болохоор байна.

**Махнаас бусад хүнс:** Хил хаагдсантай холбоотойгоор 10 дугаар сард үнэ нь огцом өссөн импортын нарийн ногоог төмөр замын тээврээр татан авах замаар нийлүүлэлтийг дэмжсэн нь үнэ[2] 20 орчим хувиар эргэн буурахад нөлөөллөө. Харин хүнсний ногооны бүлэгт өндөр жин эзэлдэг дотоодын хүнсний ногооны хувьд үнэ нь өссөн байна. Ийнхүү хүнсний ногооны бүлгийн инфляцад үзүүлэх нөлөө 0.9 нэгж хувь болж нэмэгдлээ. Түүнчлэн нарийн ногооноос бусад импортын хүнсний үнэ мөн өсөж, инфляцад үзүүлэх нөлөө нь 0.7 нэгж хувьд хүрч нэмэгдлээ. Замын-Үүд боомтын ачаа тээвэр саатсан, олон улсын хүнсний үнэ өндөр байгаа, тээврийн зардал өссөн зэрэг нь үнэ өсөх үндсэн шалтгаан болж байна.

**Шатахууны үнэ** 11 дүгээр сарын байдлаар оны эхнээс төрлөөсөө хамааран 700-750 орчим төгрөгөөр өсөн инфляцыг 2.0 нэгж хувийг бүрдүүлж байна. Дэлхийн зах зээл дэх газрын тосны үнэ (11 дугаар сарын дундаж үнэ брент газрын тос $81/баррель) өндөр байгаа нь хилийн үнээр дамжин дотоодын шатахууны үнэ өсөх үндсэн шалтгаан болсоор байна. Хатуу түлш бүлэгт багтдаг түлшний модны үнэ галлагааны улиралтай уялдан өсөж инфляцын 0.7 нэгж хувийг бүрдүүлж байна. Харин 10 дугаар сараас Засгийн газрын шийдвэрийн хүрээнд сайжруулсан түлшийг 50 хувийн хөнгөлөлттэй үнээр худалдаалж буй нь инфляцыг -1.4 нэгж хувиар бууруулах нөлөөтэй.

[28] Эх сурвалж: Монголбанк

***График 8. Улаанбаатар хотын жилийн инфляцын бүрэлдэхүүнээр[29]***




Үүнийг төсөөлөлд тусгахдаа галлагааны улиралтай зэрэгцэн 9 дүгээр сард эхэлнэ гэж үзсэн бол борлуулалт 10 дугаар сард буюу төсөөллөөс хожуу эхэлсэн нь төсөөллийн гол зөрүүг (0.6 нэгж хувь) тайлбарлаж байна. Мөн хүнсний бүтээгдэхүүний үнэ төсөөллөөс өндөр буюу жилийн 12.9 хувиар өссөн байна. Инфляцын цаашдын төлөв Ирэх улирлуудад хүнсний болон шатахууны үнийн өсөлт өмнөх төсөөллөөс нэмэгдэхээр байгаа нь нийт инфляцын төсөөллийг нэмэгдүүлэхэд голлон нөлөөллөө. Тодруулбал, орон нутагт малын халдварт өвчин дэгдсэн нь махны үнийн өсөлт улирлын хандлагаасаа давж нэмэгдэхэд хүргэж байгаа бол БНХАУ-ын хилийн хязгаарлалтаас шалтгаалан нийлүүлэлт саатсан нь импортын хүнсний ногоо болон бусад хүнсний үнэ өсөхөд нөлөөлж, үүнийг дагаад дотоодын хүнсний үнийн өсөлт мөн өмнөхөөс нэмэгдэх төлөвтэй байна. Түүнчлэн дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнийн өсөлтөөс үүдэн дотоодын шатахууны үнэ өндөр түвшинд хадгалагдахаар байгаа нь инфляцын төсөөллийг өмнөхөөс нэмэгдүүлэхэд нөлөөллөө.

[29] Эх сурвалж: Монголбанк

*График 9. Инфляцын төсөөлөл*[30]




2022 оны эхний хагаст инфляц зорилтот түвшнээс давахаар байгаа нь голлон өмнөх онд инфляц буурсан суурь үеийн нөлөө болон нийлүүлэлтийн шинжтэй хүчин зүйлсийн нөлөөгөөр тайлбарлагдаж байна. Тухайлбал, хилийн боомтын хязгаарлалтаас үүдэлтэй импортын хүнсний барааны үнийн өсөлт, тээврийн зардлын өсөлт болон малын өвчлөлтэй холбоотой махны үнийн өсөлт зэрэг нь ирэх оны эхний хагас хүртэл үргэлжлэх төлөвтэй бол 2022 оны сүүлийн хагасаас үнийн өсөлт тогтворжиж инфляц алгуур буурах хүлээлттэй байна. Засгийн газар болон Монголбанкнаас хэрэгжүүлж буй эдийн засгийг сэргээх бодлогын нөлөө уул уурхайн бус салбарыг дэмжиж дотоод эрэлт сэргэх, ханш сулрах нөлөөгөөр эрэлтийн шинжтэй инфляцын дарамт дунд хугацаанд алгуур нэмэгдэх хүлээлттэй байна. Түүнчлэн дэлхийн зах зээл дээрх хүнсний үнэ, гадаад инфляцын төсөөлөл нэмэгдсэн бөгөөд эдийн засгийн сэргэлтийг дагасан инфляцын дарамт нэмэгдэхээр байгаа зэрэг нь инфляцын дунд хугацааны төсөөллийг өмнөхөөс нэмэгдүүлж байгаа ч инфляц Төв банкны зорилтот интервалд тогтворжих хүлээлт хэвээр байна.

*Хүснэгт 12. Инфляцын төсөөлөл*[31]

| Инфляцын төсөөлөл | 2020 | 2021* | 2022* | 2023* |
|---|---|---|---|---|
| | | төсөөлөл | | |
| Инфляц, ХҮИ[5] | 2.9 | 10.5 [10.1-11.0] | 6.7 [5.0-8.4] | 7.4 [5.9-8.9] |

[30] Эх сурвалж: Монголбанк
[31] Эх сурвалж: Монголбанк

*Хүснэгт 13. Инфляцын төсөөллийг өөрчилж болзошгүй тодорхой бус байдал*

| Эрсдэл, тодорхой бус байдал | Магадлал | Нөлөө (чиглэл) |
|---|---|---|
| Бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийн доголдол эсвэл илүүдэл үүсвэл төсөөллийг өөрчлөх эрсдэлтэй. Тухайлбал, цаг агаарын нөхцөлөөс шалтгаалан мах, хүнсний ногооны үнэ огцом хэлбэлзэх, төрийн зохицуулалттай бараа үйлчилгээний үнэ төсөөллөөс давж нэмэгдэх зэрэг нь инфляцын төсөөллийг өөрчлөх шалтгаан болно. | Бага | Өндөр (өсгөх) |
| Дэлхий нийтийн тээвэр, ложистикийн түгжрэл, манай орны хилийн бүс дэх хязгаарлалт, түүний тодорхой бус байдал нь гадаад худалдааны тээвэрлэлтийн хугацаа удаашрах, тээврийн зардал өсөх, улмаар импортын болон дотоодын бараа бүтээгдэхүүний үнэ өсөх эрсдэлийг бий болгож байна. | Өндөр | Өндөр (өсгөх) |
| Орон нутагт малын халдварт өвчин дэгдсэн нь махны нийлүүлэлтэд сөргөөр нөлөөлж, махны үнэ өндөр түвшинд тогтох, мөн хилийн боомтууд дээрх ачаалал буурахгүй байгаа нь импортын хүнсний нийлүүлэлтийн тасалдлыг бий болгож, хүнсний бүлгийн үнэ нийлүүлэлтийн шалтгаантайгаар төсөөллөөс нэмэгдэх эрсдэлтэй. | Өндөр | Өндөр (өсгөх) |
| Цар тахлын тархалт дэлхийн улс орнуудад эрчимжих, вирусийн шинэ хувилбарууд тархах, геополитикийн асуудал зэргээс үүдэн гадаад орчинд тодорхой бус байдал нэмэгдэх тохиолдолд дэлхийн зах зээл дэх түүхий эдийн үнэ, манай улсыг чиглэх хөрөнгийн урсгалд сөргөөр нөлөөлж, улмаар төгрөгийн ханшид дарамт учруулж инфляцын хэлбэлзэл бий болгох эрсдэлтэй. | Бага-дунд | Дунд (өсгөх) |
| Засгийн газар, Монголбанкнаас хэрэгжүүлж буй эдийн засгийг сэргээх бодлогын арга хэмжээний хүрээнд олгох санхүүжилт, Засгийн газраас хэрэгжүүлэх томоохон төслүүд зэргээс инфляцын төсөөлөл өөрчлөгдөх боломжтой. | Дунд | Дунд (өсгөх) |

***Эдийн засгийн өсөлт***

Бодит ДНБ[6] 2021 оны эхний 3 улирлын нийлбэр дүнгээр өмнөх оны мөн үеэс 3.6 хувиар өслөө. I улиралд 14.8 хувьд хүрч огцом өсөж байсан эдийн засаг II, III улирлуудад дараалан саараад байна. Тухайлбал, III улирлын байдлаар эдийн засаг өмнөх оны мөн үеэс 0.9 хувиар агшив. Нэг талаас эдийн засгийг сэргээх, өрхийн орлогыг дэмжих бодлогын арга хэмжээ үргэлжилж, хөл хорионы дэглэм шат дараатай суларч байгаа нь эдийн засгийн идэвхжилийг дэмжих хэдий ч нөгөө талаас хилийн боомтууд дээр үүсээд буй логистикийн асуудлууд нь гадаад худалдааны эргэлтийг хязгаарлаж, сэргэлтэд сөргөөр нөлөөлж байна. Түүнчлэн, цар тахлын өмнөх үе буюу 2019 оны мөн үетэй харьцуулахад бодит ДНБ эхний 3 улиралд 3.4 хувиар бага бага байна.

***Нийт эрэлт***

Нийт эрэлт /эцсийн ашиглалтын аргаар тооцсон/ 2021 оны III улиралд 1.2 хувиар агшлаа. Нийт хөрөнгийн хуримтлал эрэлтийг дэмжих гол бүрэлдэхүүн хэвээр байгаа бол өрхийн хэрэглээ хүлээлтээс удаан сэргэж байна.

ERDENES SOLUTIONS Joint Stock Company
УЛААНБААТАР ХОТ ГҮҮДСЕК ҮЦК ХХК
2022 -03- 22 БҮРТГЭВ

*График 10. Нийт эрэлт*[32]




***Нийт нийлүүлэлт***

Эдийн засгийн өсөлтийг нийлүүлэлт үйлдвэрлэлийн аргаар тоцоосон ДНБ талаас авч үзвэл 2021 оны эхний 3 улиралд уул уурхайн салбар өмнөх оны мөн үеэс 11.7 хувь, уул уурхайн бус салбар 2.4 хувиар өсөөд байна. Харин цар тахлын өмнөх үе буюу 2019 оны эхний 3 улиралтай харьцуулахад уул уурхай 13.0 хувь, уул уурхайн бус салбар 1.7 хувиар бага байна.

*График 11. Нийт нийлүүлэлт*[33]




***Эдийн засгийн өсөлтийн цаашдын төлөв***

Эдийн засгийн өсөлтийг салбаруудаар авч үзвэл, уул уурхайн салбарын хувьд БНХАУ-ын хилийн хязгаарлалттай холбоотойгоор гол бүтээгдэхүүнүүдийн үйлдвэрлэл саарахаар байгаа хэдий ч зэсийн баяжмалын олборлолт, түүний алтны агууламж төлөвлөгөөнөөс давсан биелэлттэй байгаа нь энэ онд уул уурхайн салбарын өсөлтийн төсөөллийг өмнөхөөс нэмэгдүүлэхэд голлон нөлөөллөө. Харин Засгийн газар болон Төв банкнаас хэрэгжүүлж буй эдийн засгийг дэмжих бодлогын нөлөө нь уул уурхайн бус зарим салбарын өсөлтийг дэмжиж байгаа боловч хөдөө аж ахуй, барилга, тээвэр зэрэг бусад салбаруудын өсөлтийн төлөв хүлээлтээс бага байна.

[32] Эх сурвалж: ҮСХ
[33] Эх сурвалж: Монголбанк

Энэ онд төсвийн төлөв харьцангуй сулрахаар байгаа нь эдийн засгийн өсөлтийг дэмжих нөлөөтэй хэдий ч гадаад эрэлт өмнөх төсөөллөөс саарахын зэрэгцээ худалдааны нөхцөл, гадаадын шууд хөрөнгө оруулалтын төсөөлөл өмнөхөөс буурч байгаа нь өсөлтийн төсөөллийг бууруулах нөлөө үзүүллээ. Ийнхүү 2021- 2022 оны төсөөлөл буурсан суурь үеийн нөлөө болон худалдааны нөхцөл сайжирч, төсвийн төлөв өмнөх төсөөллөөс сулрах төлөвтэй байгаа нь 2023 оны эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхээр байна.

***График 12. 4 улирлын нийлбэр ДНБ-ий жилийн өсөлт***[34]




**Уул уурхай:** Уул уурхайн салбарын үйлдвэрлэл ирэх оныг дуустал саарч, 2023 онд сэргэх хүлээлт хэвээр байна. Хилийн боомтын үйл ажиллагаа хязгаарлагдаад байгаа нь нүүрс, төмрийн хүдэр, газрын тос зэрэг гол бүтээгдэхүүнүүдийн үйлдвэрлэлийг сааруулж байгаа хэдий ч зэсийн баяжмалын олборлолт, түүний алтны агууламж нэмэгдсэн нь уул уурхайн салбарын 2021 оны өсөлтөд эерэгээр нөлөөлж байна. 2022-оос 2023 онд түүхий эдүүдийн дэлхийн зах зээл дээрх үнэ харьцангуй өндөр түвшинд хадгалагдах, хилийн хязгаарлалт байхгүй гэж үзсэнээр түүхий эдүүдийн үйлдвэрлэлийн түвшин урт хугацааны хэвийн түвшиндээ алгуур хүрэх ч Оюу толгойн зэсийн баяжмал болон түүний алтны агууламж 2022 онд буурах хүлээлттэй байгаа нь уул уурхайн салбарын өсөлт саарахад хүргэж байна. Харин 2023 оноос Оюу толгойн алт, зэсийн агууламж буцаад сэргэх хүлээлттэй байна.

34 Эх сурвалж: Монголбанк

*Хүснэгт 14. Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл 30 хувийн магадлалтай итгэх интервал*[35]

| | 2020 | 2021* | 2022* | 2023* |
|---|---|---|---|---|
| ДНБ-ий өсөлт | -4.6 | 4.0 [2.8-5.2] | 5.5 [3.6-7.5] | 5.6 [3.0-8.2] |
| Уул уурхайн | -9.9 | 6.3 [5.1-7.5] | (-5.5) [(-7.5) – (-3.5)] | 3.5 [0.9–6.1] |
| Уул уурхайн бус | -3.7 | 3.6 [2.4-4.8] | 7.3 [5.3–9.3] | 5.9 [3.3–8.5] |

Уул уурхайн бус: Засгийн газар болон Төв банкнаас хэрэгжүүлж буй эдийн засгийг дэмжих бодлогын нөлөөгөөр уул уурхайн бус салбарын өсөлт алгуур сэргэж, дунд хугацаанд цар тахлын нөхцөл байдал сайжирснаар салбаруудын өсөлт хэвийн үеийн түвшинд тогтворжих төлөвтэй байна. Тодруулбал, худалдаа, мэдээлэл холбоо,санхүү даатгал, эрчим хүчний салбарууд 2021 оны өсөлтийг голлон тайлбарлаж байгаа бол төсвийн зардлын дутуу гүйцэтгэл болон хилийн хязгаарлалттай холбоотойгоор барилга, боловсруулах, тээврийн салбарын үйлдвэрлэл хүлээлтээс муу байж, бүтээгдэхүүний татвар бүрдүүлэлтийн төлөв бага байгаа нь эдийн засгийн өсөлтийг сааруулах нөлөөтэй байна. Эрэлт талаас гадаад худалдаа, өрхийн хэрэглээ төдийлөн сэргэхээргүй байна. 2022 онд төсвийн төлөв сулрах, гадаадын шууд хөрөнгө оруулалт, тэр дундаа Оюу толгойн хөрөнгө оруулалт нэмэгдэх нөлөөгөөр дотоод эрэлт сэргэж, салбарууд цар тахлын үеийн уналтаас гарснаар эдийн засгийн үйл ажиллагаа идэвхжиж, уул уурхайн бус салбарын өсөлт сэргэх төлөвтэй. Харин 2023 онд худалдааны нөхцөл эдийн засгийн өсөлтийг дэмжих хэдий ч гадаад эрэлтийн эерэг нөлөө саарч, хөрөнгө оруулалт болон дийлэнх салбарын үйлдвэрлэл хэвийн үеийн түвшинд хүрч тогтворжсоноор уул уурхайн бус салбарын өсөлт удаашрах төлөвтэй байна.

*Хүснэгт 15. Эдийн засгийн өсөлтийн төлөвт гарсан өөрчлөлт (2021)*

| НИЙТ ЭРЭЛТ | |
|---|---|
| Хэрэглээ | Төсөөлөл буурсан |
| Өрхийн орлогоор дамжуулан хэрэглээг дэмжих бодлогын арга хэмжээ үргэлжилж байгаа хэдий ч өрхийн хэрэглээ хүлээлтээс удаан сэргэж байна. Одоогийн төсөөллөөр өрхийн хэрэглээ 2022 оны эхний улиралд цар тахлын өмнөх үед хүрч сэргэх төлөвтэй байна. | |
| Хөрөнгө оруулалт | Төсөөллийн орчимд |
| Эдийн засгийг сэргээх арга хэмжээнүүдтэй уялдан бизнесийн зээл сэргэсэн хэдий ч ГШХО, төсвийн хөрөнгө оруулалт оны сүүлийн хагаст өмнөх оноос төдийлөн сайжрахааргүй байгаа тул үндсэн хөрөнгийн хуримтлалын өсөлт 2021 оны эхний хагасаас буурах төлөвтэй байна. • Нөгөөтэзгүүр түүхий эдийн экспорт удааширснаас гадна хэрэглээ удаан сэргэж байгаа тул бэлэн бүтээгдэхүүн, сэлбэг хэрэгсэл, дахин борлуулах бүтээгдэхүүн зэрэг эргэлтийн хөрөнгийн нөөц нэмэгдэхэд нөлөөлж байна. | |
| Цэвэр экспорт | Төсөөлөл буурсан нь |

[35] Эх сурвалж: Монголбанк

| |
|---|
| Бодит экспорт оны сүүлийн улиралд үргэлжлэн буурах төлөвтэй байна. Жилийн нийлбэр дүнгээр нүүрсний экспорт өмнөх оноос 11.5 сая тонн, Монголбанкны экспортолж буй боловсруулаагүй болон хагас боловсруулан алтны биет хэмжээ 13 тонноор буурахаар байгаа юм. |

| НИЙТ НИЙЛҮҮЛЭЛТ | |
|---|---|
| Уул уурхай | Төс. Бага зэрэг нэмэгдсэн |
| Зэсийн баяжмал олборлолт болон түүнд агуулагдах цэвэр зэс, алтны биет хэмжээ оны сүүлийн саруудад өндөр хадгалагдахаар байна. Нөгөөтэйгүүр, нүүрс, төмрийн хүдэр, газрын тосны олборлолт өмнө хүлээгдэж байснаас буурахаар байна. | |
| Уул уурхайн бус | Төсөөлөл буурсан |

- Төсвийн хөрөнгө оруулалтын зарцуулалт хүлээгдэж байснаас харьцангуй бага гүйцэтгэлтэй байгаа нь барилгын салбарын төлөвийг бууруулж байна.
- Замын Үүд - Эрээн, Шивээхүрэн - Сэхэ зэрэг хилийн боомтуудын үйл ажиллагаа хязгаарлагдсантай холбогдуулан авто замын тээвэрлэлт саарахаар хүлээгдэж байна.
- Эдгээр хилийн боомтын асуудлуудаас шалтгаалан бараа, бүтээгдэхүүний импорт буурч, улмаар үүнд ногдуулдаг НӨАТ, гаалийн татварын орлого багасахаар байна.
- Энэ оны мал бэлтгэл өнгөрсөн оны өндөр түвшнийг давж нэмэгдэхээргүй байгаа ч нөгөөтэйгүүр үр тарианы ургац хураалт өмнөх оноос 32.8%-аар нэмэгдэж байгаа нь хөдөө аж ахуйн салбарын төлөвт эергээр нөлөөлөхөөр байна.

***Мөнгө, санхүүгийн зах зээл***

Банкуудын зээлийн өсөлт тогтворжиж, мөнгөний нийлүүлэлтийн өсөлт саарч байна. Банкуудын зээлийн шалгуур 2021 оны 3 дугаар улиралд төдийлөн өөрчлөлтгүй, харин зээлийн нөхцөл суларч байна. Банкны системийн долларжилт сүүлийн саруудад харьцангуй тогтвортой хадгалагдав. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг зээлийн өсөлт голлон бүрдүүлж байна. Харин төлбөрийн тэнцлийн алдагдал нэмэгдэж гадаад цэвэр актив (ГЦА)-ын өсөлт огцом саарав.

***График 13. М2 мөнгөний жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, актив тал***[36]




[36] Эх сурвалж: Монголбанк

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-03-22
БҮРТГЭВ-03

***Валютын ханш***

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш тогтвортой хэвээр байна. Сүүлийн нэг жил гаруй хугацаанд ам.долларын ханш 2850 төгрөгийн орчимд тогтвортой, хэлбэлзэл багатай байгаа ба 2021 оны 11 дүгээр сарын эцсийн байдлаар 2849.2 төгрөгтэй тэнцэж байна. Тайлант улиралд импортын хэмжээ мэдэгдэхүйц өссөн хэдий ч экспортын хэмжээ өнгөрсөн оны мөн үеийн түвшинд байснаар худалдааны тэнцэл ашигтай гарлаа. Түүнчлэн, Монгол улсын Засгийн газрын гадаад өрийн дахин санхүүжилтийн амжилттай хийсэн нь зах зээлийн хүлээлтэд эергээр нөлөөлөв.

*График 14. Төгрөгийн ам.доллартой харьцах ханш*[37]




Гадаад худалдааны эргэлтээр жигнэж тооцсон төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханш (NEER) 2020 оны 4 сараас эхлэн суларч байгаа бөгөөд 2021 оны 10 дугаар сард өмнөх оны мөн үеэс 2.9 хувиар сулрав. Үүнд, төгрөгийн ханш юанийн эсрэг жилийн 4.7 хувиар, рублийн эсрэг 12.4 хувиар суларсан нь голлон нөлөөлөв. Харин 2021 оны 10 дугаар сарын байдлаар ам.доллар болон еврогийн эсрэг төгрөгийн ханш өмнөх оны мөн үеэс бараг өөрчлөлтгүй байна (Зураг III.2.3.2). Харин сарын өөрчлөлтийг авч үзвэл 7 сараас хойш төгрөгийн ханш еврогийн эсрэг алгуур чангарсан бол рублийн эсрэг сүүлийн 2 сарын хугацаанд 1-3 хувиар суларсан.

[37] Эх сурвалж: Монголбанк

ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК ERDENES SOLUTIONS Joint Stock Company 2015358
УЛААНБААТАР ХОТ ГҮҮДСЕК ҮЦК ХХК ТТБ6874 ДД.5208173

*График 15. Төгрөгийн гол валютуудтай харьцах ханш болон нэрлэсэн үйлчилж буй ханшийн жилийн өөрчлөлт*[38]




Төгрөгийн бодит ханш дотоод үнийн харьцангуй өсөлтөөс үүдэн чангарч буй хандлага үргэлжилж сүүлийн 3 жилийн хамгийн чанга түвшиндээ хүрээд байна. Төгрөгийн нэрлэсэн ханш 3.2 хувиар суларч, гадаад үнэтэй харьцуулахад дотоод үнэ20 8.4 хувиар чангарснаар бодит ханш энэ оны 9 дугаар сард өмнөх оны мөн үеэс 5.2 хувиар чанга тогтлоо.

*График 16. Төгрөгийн бодит ханшийн жилийн өөрчлөлт*[39]




[38] Эх сурвалж: Монголбанк
[39] Эх сурвалж: Монголбанк

Төгрөгийн харьцангуй өгөөж сүүлийн 1 жил гаруй хугацаанд эерэг түвшинд хадгалагдаж, төгрөгийн ханшийн өөрчлөлтийг даган тогтвортой байна. Тайлант улиралд өгөөж жилийн 4.9 хувьтай байна.

*График 17. Төгрөгийн харьцангуй өгөөж*[40]




Ийнхүү төгрөгийн харьцангуй өгөөж өндөр байгаа нь Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 6 сарын ээлжит хурлын шийдвэрээр өндөр хүүтэй гадаад валютын хадгаламж болон хүү төлж буй гадаад валютын харилцахын эзлэх хувиар банканд олгох төгрөгийн заавал байлгах нөөцийн урамшууллыг бууруулан тооцох шийдвэр гарснаар валютын хадгаламжийн хүү буурсантай холбоотой юм. Үр дүнд нь төгрөгийн хадгаламжийн хэмжээ нэмэгдэж, валютын хадгаламжийн хэмжээ буурч байна. Тодруулбал, хадгаламжийн долларжилтын хэмжээ 2020 оны 9 сараас хойш 10 орчим нэгж хувиар буурч 2021 оны 10 сарын байдлаар 24.1 хувьд хүрээд байна.

***Хөрөнгийн зах зээл***

Хөрөнгийн захын идэвхжил тайлант улиралд эрчимжиж, ТОП-20 индекс 2021 оны 9 дүгээр сард түүхэн дээд түвшиндээ хүрч өссөн бол 10 дугаар сараас эргээд буурах хандлага ажиглагдав. Тодруулбал, ТОП-20 индекс 2021 оны 9 дүгээр сард дунджаар 44,824.4 нэгжид хүрч, оны эхнээс хоёр дахин өссөн бол 10 дугаар сарын дунджаар 40,357.5 нэгжид хүрээд байна. Харин зах зээлийн үнэлгээ 10 дугаар сард оны эхэнтэй харьцуулахад 62.0 хувиар өсч, 4,867 тэрбум төгрөгт хүрлээ.

[40] Эх сурвалж: Монголбанк

*График 18. Хөрөнгийн захын голлох үзүүлэлтүүд*[41]




Хөрөнгийн зах зээлд арилжаалагдах бүтээгдэхүүний төрөл нэмэгдсэний зэрэгцээ хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын үйл ажиллагаа идэвхжин ногдол ашиг тараалт, шинээр үнэт цаас гаргах явдал ихэссэн бөгөөд нөгөө талаас банкны хадгаламжийн хүү буурснаар хөрөнгийн зах зээлд оролцогчдын идэвх өсч хөрөнгийн захын үзүүлэлтүүд сэргэхэд нөлөөлж байна.

*График 19. Хөрвөх чадварын харьцаа*[42]




[41] Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж
[42] Эх сурвалж: ҮСХ, Монголбанк

2021 оны эхний 10 сарын байдлаар Монголын хөрөнгийн бирж дээр нийт 1,173 тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжаа хийгдээд байна. Тайлант улиралд Эрдэнэс Таван Толгой компанийн ЭТТ бондын 2-р шатны захиалгын хүрээнд 164 тэрбум төгрөг, 13.1 сая ам.долларын арилжаа, Инвескор ББСБ-ын бондын 2 ба 3-р шатны захиалгын тус бүр 6 тэрбум төгрөгийн арилжаа анхдагч зах дээр хийгдсэн бол "Мандал Ассет Менежмент ҮЦК"-ий гаргасан "Мандал Ирээдүйн өсөлт" хамтын хөрөнгө оруулалтын сан нийт 47.5 тэрбум төгрөгийн хөрөнгийг олон нийтээс татан төвлөрүүлсэн зэрэг нь үнэт цаасны арилжаанд томоохон дүн эзэлж байна. Сүүлийн саруудад хувьцааны арилжааны идэвхийг үнийн дүнгээр "Ард санхүүгийн нэгдэл", "Тэнгэрлиг медиа групп", "АПУ" компаниуд тэргүүлсэн бол арилжааны тоо ширхгээр "Мандал даатгал", "Лэндмн ББСБ", "Монос хүнс" буюу санхүү болон хүнсний салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниуд тэргүүлжээ. Хөрөнгийн захын арилжааны идэвх сүүлийн саруудад харьцангуй идэвхжиж, 8 дугаар сард хөрвөх чадварын харьцаа 16.1 хувьд хүрч хамгийн өндөр түвшинд хүрсэн бол 10 дугаар сарын байдлаар 6.4 хувь болж буураад байна.[43]

## 1.12 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

***Программ хангамжийн өнөөгийн байдал***

Программ хангамжийн үйлдвэрлэл эрхэлдэг хувийн хэвшил үүсэн бий болсноос хойш даруй 25 гаруй жил өнгөрчээ. Энэ хугацаанд дотоодын зах зээлийн хэрэгцээ шаардлагыг хангах үүднээс үндэсний үйлдвэрлэгчид тодорхой хэмжээнд хөгжиж ирсэн. Гэвч энэхүү хөгжлийн хажуугаар дутагдалтай талууд бий болсон. Үүний нэгэн жишээ нь программ хангамжийн үндэсний үйлдвэрлэгчид дотоодын эдийн засгаас шууд хамааралтай болсон. Зөвхөн дотоодын зах зээлд тулгуурласан үйлдвэрлэгчид, зах зээлийн хэлбэлзлээс шалтгаалан үйл ажиллагаагаа хумих, чадварлаг программистууд өндөр хөгжилтэй орон руу ажиллахаар зорих зэрэг үзэгдэл ихээр ажиглагдах боллоо. Энэ нь программ хангамжийн үндэсний үйлдвэрлэлийн хөгжлийг хязгаарлаад зогсохгүй, цаашдын боломжит нөхцөл байдлуудад хүндрэл учруулж буй. Энэхүү нөхцөл байдлаас гарч, цаашдын программ хангамжийн үндэсний үйлдвэрлэлийн хөгжлийг урагшлуулах нэн шаардлага тулгарч байна. Бидэнд өнөөгийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан дэлхийд танигдсан программ хангамж үйлдвэрлэх бүрэн боломж байгаа. Энэ нь зөвхөн дотоодын зах зээлд тулгуурлах бус харин олон улсын зах зээлд бүтээгдэхүүнээ амжилттай танилцуулснаар эдийн засгийн өсөлтөд шууд нөлөөлж, оюуны бүтээлээр бий болсон экспортыг нэмэгдүүлж, улмаар валютын ихээхэн хэмжээний урсгалыг бий болгох боломжтой. Өнөөдөр олон Монгол залуус дэлхийд тэргүүний компаниудад ажиллаж, баялаг бүтээж байгааг бид мэднэ. Тэд бидэнд дэлхийд танигдсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх чадамж байгааг илт нотлон харуулж байна. Энэхүү салбарын хөгжилд төр засгийн дэмжлэг, програм хангамжийн компаниудын нэгдсэн ойлголт, стартап бизнесийг дэлхийн зах зээлд гаргах туршлага, хөгжлийн бодлого дутагдаж байна. Олон улсын туршлага дээр тулгуурлан бид асуудлуудыг нээлттэй хэлэлцэж нэгдсэн ойлголтод хүрэх нь нэн шаардлагатай.[44]

Програм хангамжийн хамгийн том гэсэн 56 компанийн хүний нөөцөд үндсэн 1180 хүн ажиллаж байгаагаас 417 эмэгтэй байна.

Компьютер программчлал, зөвлөгөө болон түүнд холбогдох үйл ажиллагааны орлого 2021 оны 4-р улирлын байдлаар 144 тэрбум төгрөг байна.[45]

[43] Эх сурвалж: Маркетинфо, www.marketinfo.mn
[44] Эх үүсвэр:https://mddc.gov.mn
[45] Эх үүсвэр: https://www.1212.mn/

## 1.13 ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

Үнэт цаас гаргагч нь МХБ-ээр дамжуулан энгийн хувьцааны 9.5% буюу 1.8 тэрбум төгрөгөөр санал болгон гаргаж, татан төвлөрүүлсэн хөрөнгөөр үнэт цаас гаргагч нь нийт гаргасан хувьцааны 85%-ийн эзэмшдэг "Эйс ассошиэйтс ББСБ" ХХК-ийн үйл ажиллагааг өргөтгөж, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, иргэдэд шаардлагатай зээлийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлж тус банк бус санхүүгийн байгууллагад эзэмшиж буй хувьцааны тоог 95%-д хүргэх зорилгыг тавьж байна.

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 225 дугаар тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 7 дугаар бүлгээр анхдагч зах зээлд үнэт цаас гаргагчийн хувьцааны захиалгын нийлүүлэлтээс эрэлт давсан тохиолдолд зах зээлийг тогтворжуулах зорилгоор үнэт цаас гаргагч олон нийтэд санал болгосон хувьцааны тодорхой хувьтай тэнцэх хувьцааг нэмж гаргах, хяналтын багц эзэмшигч хувьцааны 5 хүртэлх хувийг зах зээлд гаргах зохицуулалтын орчныг бүрдүүлсэн.

Тиймээс үнэт цаас гаргагч, андеррайтерийн компанийн зүгээс хувьцааны анхдагч зах зээлийн арилжаагаар захиалгын нийлүүлэлтээс эрэлт давсан тохиолдолд компанийн хувьцааны хяналтын багц эзэмшигчдээс өөрсдийн эзэмшлийн хувьцаанаас зах зээлд нийлүүлэхээр зөвшөөрч, олон нийтэд санал болгох хувь, татан төвлөрүүлэх хөрөнгө болон зарцуулалтын талаар дараах хувилбаруудыг дэвшүүлэн ажиллана. Үүнд:

- нийт гаргасан хувьцааны 9.5% буюу 1.8 тэрбум төгрөг татан төвлөрүүлсэн тохиолдолд;
- нийт гаргасан хувьцааны 10.5% буюу 2.0 тэрбум төгрөг татан төвлөрүүлсэн тохиолдолд:

*Хүснэгт 16. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт /сая.төг/*

| | Хөрөнгө оруулах компанийн нэр болон зарцуулалт | Зарцуулах мөнгөн дүн | Хөрөнгө оруулахын өмнөх эзэмшлийн хувь | Хөрөнгө оруулсны дараах эзэмшлийн хувь | Хөрөнгө оруулахаар төлөвлөж байгаа хугацаа |
|---|---|---|---|---|---|
| 1.1 | "Эйс ассошиэйтс ББСБ" ХХК | 1,650.0 | 85.00% | 94.90% | 2022 оны 2-р улирал |
| 1.2 | "Кларо трейд" ХХК | 139.8 | - | 44.79% | 2022 оны 2-р улирал |
| | **Нийт I** | **1,789.8** | | | |
| 2.1 | "Кларо трейд" ХХК | 210.5 | - | 67.02% | 2022 оны 2-р улирал |
| | **Нийт II** | **2,000.3** | | | |

### 1.13.1 ЭЙС АССОШИЭЙТС ББСБ-ЫН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ НЭМЭГДҮҮЛЭХ

***Эйс ассошиэйтс ББСБ-ын тухай***

"Эйс ассошиэйтс ББСБ" ХХК нь 2012 оны 11-р сарын 16-ны өдөр үүсгэн байгуулагдаж, улсын бүртгэлд хуулийн этгээдээр бүртгүүлсэн бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 06-р сарын 12-ны өдрийн дугаар 202 тоот тогтоолоор банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авч, гадаад валютын үйл ажиллагаа эрхэлж байна.

Хувьцаа эзэмшигчдийн хувьд үнэт цаас гаргагч нь нийт хувьцааны 85 хувийг, үлдэх 15 хувийг иргэн Б.Батхүү нар тус тус эзэмшиж байгаа бөгөөд дээрх хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнийг Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны 02-р сарын 05-ны өдрийн 39 тоот тушаалаар зөвшөөрөл олгосон. Тус ББСБ нь 2021 оны 12-р сарын 31-ний өдрийн эцсийн байдлаар 851 сая төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 5.6 сая төгрөгийн хуримтлагдсан ашигтай ажилласан.

Үнэт цаас гаргагчийн бизнесийн үндсэн загвар нь төрөл бүрийн үйл ажиллагаа эрхлэх чиглэлээр охин компани байгуулж, тэдгээр компаниудыг технологижуулах, замаар хөрөнгө оруулах, дотооддоо программ хангамж болон систем хийж нэвтрүүлэн, түүний дотроос боломжтой программ хангамжуудыг гадаад улс оронд экспортлох гэсэн 2 үндсэн загвараар ажилладаг бөгөөд "Эйс ассошиэйтс ББСБ" ХХК-д өөрийн хөгжүүлсэн банк бус үндсэн үйл ажиллагааны программ хангамжийг бүрэн нэвтрүүлсэн.

Энэхүү систем нь үндсэн буюу веб технологид суурилсан ББСБ-ийн веб аппликейшн, бусад систем, интерфейстэй мэдээлэл солилцох API /Application Programming interface/, харилцагч зориулсан мобайл аппликейшн гэсэн гурван программ хангамжаас бүрдэх бөгөөд программ нь банк бус санхүүгийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой 17 дэд функцийг агуулдаг. Жишээ нь цахим зээл, кредит скоринг, эрсдэлийн удирдлагыг цогц байдлаар хэрэгжүүлэх боломжтой.

Сүүлийн жилүүдэд иргэд, аж ахуйн нэгжүүд банк бус санхүүгийн үйл ажиллагааг эрхлэх сонирхол нэмэгдэж, Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөлтэй банк бус санхүүгийн байгууллагын тоо эрс өсөлт ажиглагдаж байгаа бөгөөд мөн санхүүгийн шинэ технологийн шийдлийг нэвтрүүлсэн "Лэндмн ББСБ", "Инвескор ББСБ", "Ард кредит ББСБ" зэрэг банк бус санхүүгийн байгууллагууд нь хувьцаа, өрийн хэрэгслээ олон нийтэд санал болгон гаргах замаар шаардлагатай зээлийн санхүүжилтийг татан төвлөрүүлсэн.

Тиймээс үнэт цаас гаргагчийн зүгээс нэмж хувьцаа гаргах замаар олон нийтээс санхүүжилт татан төвлөрүүлсэн хөрөнгөөр "Эйс ассошиэйтс ББСБ" ХХК-ийн 1 ширхэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 851,000 ширхэг энгийн хувьцааг 1 ширхэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1,630,000 ширхгээр нэмэгдүүлж, 2 тэрбум 501 сая төгрөгт хүргэснээр зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангаж, улмаар өөрийн хөгжүүлсэн программ хангамжаар дамжуулан цахим хэлбэрээр жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, эхлэлтийн бизнес эрхлэгч этгээдүүдэд шаардлагатай зээлийн санхүүжилтийн эх үүсвэрийг хангах замаар санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, улмаар банк бус санхүүгийн байгууллага дундаа технологийн шинэ шийдлийг нэвтрүүлэгч болохоор зорьж байна.

"Эйс ассошиэйтс ББСБ" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор хувьцаа нэмж гаргах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж дэмжсэн[46] бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгө нэмэгдүүлэхээр төлөвлөж буй хугацаа – 2022 оны 2-р улирал, Зарцуулах мөнгөн дүн 1,650.0 сая төгрөг.

### 1.13.2 КЛАРО ТРЕЙД ХХК

***Нийт гаргасан хувьцааны 9.5% буюу 1.9 тэрбум төгрөгийг амжилттай төвлөрүүлсэн тохиолдолд:***

Компани нийт гаргасан хувьцааны 9.5% буюу 1.9 тэрбум төгрөг татан төвлөрүүлсэн тохиолдолд 255.8 сая төгрөгөөр "Кларо трейд" ХХК-д урт хугацааны хөрөнгө оруулалт

[46] Хавсралт 17 - "Эйс ассошиэйтс ББСБ" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 02/2022 тоот шийдвэр.

хийж, тус компанийн энгийн хувьцааг худалдан авах замаар нийт хувьцааны 59.75%-ийг дангаар эзэмшиж, өөрийн охин компани болгохоор төлөвлөж байна.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн хамаарал бүхий тус "Кларо трейд" ХХК[47] нь 2011 оны 04-р сарын 04-ний өдөр "Жиргэр" ХХК нэртэйгээр гадаад худалдаа, үл хөдлөх хөрөнгийн түрээсийн үйл ажиллагаа эрхлэх зорилготойгоор байгуулагдсан, одоогоор төлбөр болон гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2021 оны жилийн эцсийн байдлаар 173 сая төгрөгийн нийт хөрөнгөтэй, 171.1 сая төгрөгийн хуримтлагдсан ашигтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

"Кларо трейд" ХХК нь хувьцаа нэмж гарган "Эрдэнэс сольюшинс" ХК-аас хөрөнгө оруулалт татсанаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээгээ 255.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэх ба компанийн хувь эзэмшилд дараах байдлаар өөрчлөгдөнө:

***Хүснэгт 17а. Хувьцаа нэмж гаргахын өмнө хувьцаа эзэмшигчдийн эзэмшлийн хувь***

| № | **Хувьцаа нэмж гаргахын өмнөх эзэмшлийн хувь** | | | | | **Нэмж гаргаж буй хувьцааны тоо ширхэг** | **Хувьцаа нэмж гаргасны дараах эзэмшлийн хувь** | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Хувьцаа эзэмшигчид | Тоо ширхэг | Нэрлэсэн үнэ /төг./ | Нийт үнэ /төг./ | Эзэмшлийн хувь | Тоо ширхэг | Тоо ширхэг | Эзэмшлийн хувь |
| 1 | Б.Батхүү | 43,087,500 | 1.00 | 43,087,500 | 25.00% | | 43,087,500 | 10.06% |
| 2 | Ц.Хүдэрмөнх | 43,087,500 | 1.00 | 43,087,500 | 25.00% | | 43,087,500 | 10.06% |
| 3 | Т.Золбоо | 43,087,500 | 1.00 | 43,087,500 | 25.00% | | 43,087,500 | 10.06% |
| 4 | Ц.Хуяг | 43,087,500 | 1.00 | 43,087,500 | 25.00% | | 43,087,500 | 10.06% |
| 5 | "Эрдэнэс сольюшинс" ХК | - | | | | 255,800,000 | 255,800,000 | 59.75% |
| | **Нийт** | **172,350,000** | | **172,350,000** | **100.00%** | | **428,150,000** | **100.00%** |

Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахаар төлөвлөж байна.

***Хүснэгт 18б. Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт***

| **Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт /төг/** | | |
|---|---|---|
| **1** | **Үйл ажиллагааны зардал** | **100,000,000.00** |
| **2** | **Тоног төхөөрөмж** | **155,000,000.00** |
| | Үндсэн сервер | 25,000,000.00 |
| | Нөөц сервер | 25,000,000.00 |
| | Камер, дохиоллын систем | 20,000,000.00 |
| | Компьютер, | 15,000,000.00 |
| | Принтер, бар код уншигч | 5,000,000.00 |
| | Сүлжээний тоног төхөөрөмж | 7,100,000.00 |
| | Түгээлтийн машин | 57,900,000.00 |
| **Нийт** | | **255,000,000.00** |

***Нийт гаргасан хувьцааны 10.5% буюу 2.1 тэрбум төгрөгийг амжилттай төвлөрүүлсэн тохиолдолд:***

Компани нийт гаргасан хувьцааны 10.5% буюу 2.1 тэрбум төгрөг татан төвлөрүүлсэн тохиолдолд 479.9 сая төгрөгөөр дээр дурдсантай мөн адил "Кларо трейд" ХХК-д урт хугацааны хөрөнгө оруулалт хийж, тус компанийн энгийн хувьцааг худалдан авах замаар нийт хувьцааны 73.58%-ийг дангаар эзэмшиж, өөрийн охин компани болгохоор төлөвлөж

[47] Хавсралт 19 - "Кларо трейд" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар.

байна. Ийнхүү хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлснээр компанийн хувь эзэмшилд дараах байдлаар өөрчлөгдөнө:

*Хүснэгт 198а. Хувьцаа нэмж гаргахын өмнө хувьцаа эзэмшигчдийн эзэмшлийн хувь*

| № | Хувьцаа нэмж гаргахын өмнөх эзэмшлийн хувь | | | | | Нэмж гаргаж буй хувьцааны тоо ширхэг | Хувьцаа нэмж гаргасны дараах эзэмшлийн хувь | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Хувьцаа эзэмшигчид | Тоо ширхэг | Нэрлэсэн үнэ /төг./ | Нийт үнэ /төг./ | Эзэмшлийн хувь | Тоо ширхэг | Тоо ширхэг | Эзэмшлийн хувь |
| 1 | Б.Батхүү | 43,087,500 | 1.00 | 43,087,500 | 25.00% | | 43,087,500 | 6.61% |
| 2 | Ц.Хүдэрмөнх | 43,087,500 | 1.00 | 43,087,500 | 25.00% | | 43,087,500 | 6.61% |
| 3 | Т.Золбоо | 43,087,500 | 1.00 | 43,087,500 | 25.00% | | 43,087,500 | 6.61% |
| 4 | Ц.Хуяг | 43,087,500 | 1.00 | 43,087,500 | 25.00% | | 43,087,500 | 6.61% |
| 5 | “Эрдэнэс сольюшинс” ХК | - | | | | 479,900,000 | 479,900,000 | 73.58% |
| | **Нийт** | **172,350,000** | | **172,350,000** | **100.00%** | | **428,150,000** | **100.00%** |

*Хүснэгт 20б. Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт*

| Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт /төг/ | | |
|---|---|---|
| 1 | **Систем хөгжүүлэлтэд** | **245,000,000.00** |
| | **Онлайн худалдааны ERP систем хөгжүүлэх** | **230,000,000.00** |
| | Цахим худалдааны модуль | 50,000,000.00 |
| | API/Application Programming Interface/ хөгжүүлэлт | 35,000,000.00 |
| | Мобайл аппликейшн | 50,000,000.00 |
| | Хүний нөөцийн модуль | 20,000,000.00 |
| | Санхүүгийн модуль | 40,000,000.00 |
| | Цалингийн модуль | 20,000,000.00 |
| | Нууцлал болон бусад шаардлагатай сертификатын төлбөр | 15,000,000.00 |
| | **Гадны системтэй холболт хийхэд** | **15,000,000.00** |
| 2 | **Үйл ажиллагааны зардал** | **100,000,000.00** |
| 3 | **Тоног төхөөрөмж** | **134,900,000.00** |
| | Үндсэн сервер | 25,000,000.00 |
| | Нөөц сервер | 25,000,000.00 |
| | Камер, дохиоллын систем | 20,000,000.00 |
| | Компьютер, | 15,000,000.00 |
| | Принтер, бар код уншигч | 5,000,000.00 |
| | Сүлжээний тоног төхөөрөмж | 10,000,000.00 |
| | Түгээлтийн машин | 34,900,000.00 |
| | **Нийт** | **479,900,000.00** |

Дээрх зарцуулалтад зах зээлийн нөхцөл байдал, тоног төхөөрөмжийн үнэ ханшийн өөрчлөлттэй холбоотойгоор тухайлсан барааны үнэд өөрчлөлт орж болох боловч нийт зарцуулалтын үнийн дүнд өөрчлөлт орохгүй болно.

“Кларо трейд” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор хувьцаа нэмж гаргах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна.[48]

[48] Хавсралт 20. “Кларо трейд” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 05/2022 шийдвэр.

## 1.14 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ДУНД ХУГАЦААНЫ БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТОЙМ

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12-р сарын 13-ны өдрийн хурлаар Компанийн 2022-2025 онуудад хэрэгжүүлэх бодлого, стратеги, маркетинг, шинэ бүтэц, зах зээлд гаргах шинэ бүтээгдэхүүн, санхүүгийн төлөвлөгөөг тусгасан Бизнес төлөвлөгөө баталсан байна.

### 1.14.1 СТРАТЕГИ

Үнэт цаас гаргагч нь үйл ажиллагаандаа юуны түрүүнд "хэрэглэгч төвтэй" байх бодлогыг баримталж байна. Нөгөө талаас шинжлэх ухаан, технологийн AI, BI, Blockchain болон бусад ололт, дэвшлийг ашиглан аливаа төвөгтэй процессыг хялбарчлах, цаг хугацааг хэмнэх, шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээ, шийдлийг бий болгож зах зээлд нэвтрүүлэхэд өндөр ач холбогдол өгч байна.

Компанийн өрсөлдөөнд хандах хандлага бол түүнд төвлөрөх бус, өөрийн гэсэн "үнэ цэнэ" бүтээхэд төвлөрч, бие биеэ нөхөх зарчмаар аль болох бүгдтэй хамтран, банк, төлбөр тооцоо, үнэт цаас, даатгал, еКоммерцийг хамарсан бүхэл бүтэн экосистемийн цогц шийдэл бүтээж, улмаар Зүүн Өмнөд Азийн орнуудын зах зээл дээр өрсөлдөхүйц үйлдвэрлэл, үйлчилгээний "хүчин чадал" хуримтлуулах бодлого баримталж байна.

Компани нь дараах гурван гол цэгт төвлөрсөн стратегийг мөрдөн ажиллана.

- Хэрэглэгч төвтэй байх
- Технологиор тэргүүлэх
- Ашигт ажиллагааг нэмэгдүүлэх

***Зураг 4. Компанийн дунд хугацааны стратеги***




***Үнэ цэнтэй хэрэглэгч бий болгох бодлого:***

- Хэрэглэгчийг хаана ч таньдаг байх, хамгийн тохиромжтой үйлчилгээг санал болгодог байх;
- Хэрэглэхэд тааламжтай UX (User Experience)-тэй байх;
- Хэрэглэгчид зориулсан дизайнтай байх UI (User Interface) ;
- Хэрэглэгчийн хэрэгцээнд тохирсон бүтээгдэхүүнийг санал болгох;
- Хэрэглэгчийн түүх үүсгэх, хэрэглэгчийн сегментэд тохирсон маркетингийн ажил хийх;
- Хэрэглэгчийн сэтгэл ханамжаар дамжуулан шинэ хэрэглэгч татах;
- Технологийн компанийн давуу талыг ашигласан маркетингийн арга, хэлбэр ашиглана.

ERDENES SOLUTIONS Joint Stock Company
УЛААНБААТАР ХОТ ГҮҮДСЕК ҮЦК ХХК

### 1.14.2 БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Компанийн 2022-2025 онуудад хэрэгжүүлэх Бизнес төлөвлөгөөнд компанийн бүтцийг Бизнесийн газар, Технологийн газар, Үйл ажиллагааны газартай байхаар төлөвлөсөн.

Бизнесийн газар нь борлуулалт, маркетинг хариуцах бол Технологийн газар нь шинэ технологи болох хиймэл оюун ухаан (AI), өөрөө суралцдаг машин (ML), блокчэйн (Blockchain), Биг дата, Лоялти, Крипто төлбөр, Цахим мөнгө, Кредит скоринг, Сошиал шийдэл зэрэг шинэ бүтээгдэхүүний технологийг хариуцан ажиллана.

Санхүү, хүний нөөцийн газар нь Компанийн санхүү, хүний нөөцийг хариуцан ажиллана ажиллана.

*Зураг 5. Байгууллагын бүтэц зохион байгуулалт*




### 1.14.3 МАРКЕТИНГ

Үнэт цаас гаргагч нь байгуулагдсан цагаасаа эхлэн зөвхөн эхний хэрэглэгч буюу банк санхүүгийн байгууллагууд, байгууллага хэрэглэгчдэд чиглэсэн маркетингийн ямар нэг ажил хийгээгүй.

Цаашид компани нь бүтээгдэхүүн үйлчилгээгээ сурталчлах зах зээлийг бүхэлд нь хамарсан маркетингийн бодлого баримтлан ажиллаж илүү өсөлтөд хүрэхээр төлөвлөж байна. Үүний тулд:

- Технологийн Компанийн давуу талыг ашиглах
- Хэрэглэгчийн хүсэл сонирхолд нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний тоог нэмэгдүүлэх

- Хэрэглэгчийн судалгаанд үндэслэн сегментчилсэн маркетингийн бодлого барих

***5с шинжилгээ***

**COMPANY (КОМПАНИ)**

- Компани платформ нь гүйлгээ хийхэд зориулагдсан. Гүйлгээг чанарын өндөр түвшинд бүх төрөл хэлбэрээр хийдэг.
- Одоогоор зөвхөн хувь хэрэглэгчдэд үйлчилж байгаа. Нэмж хувьцаа гаргахтай гаргахтай зэрэгцэн бид байгууллага хэрэглэгчид үйлчилгээгээ үзүүлж эхлэхээр төлөвлөж байна.
- Салбартаа 3-20 жил ажилласан туршлагатай мэргэшсэн боловсон хүчинтэй.

**CUSTOMERS (ХЭРЭГЛЭГЧИД)**

- Санхүүгийн зах зээлд финтек ойрын 5 жилийн хугацаанд байнга тэлсээр байх хандлага ажиглагдаж байна.
- Компани бүтээгдэхүүн хэрэглэгч нар харьцангуй өндөр хэрэглээтэй, олон төрлийн үйлчилгээг нэг дороос авах боломжтой харагдаж байна. Энэ нь цаашдын шинэ үйлчилгээнүүдийг нэвтрүүлэх таатай суурь болохоор байна.

**COMPETITORS (ӨРСӨЛДӨГЧИД)**

- Зах зээлд уламжлалт банкнуудаас гадна Финтек Компаниуд хүч түрэн орж ирж байна. ББСБ-ууд шинэ технологийн дэвшил ашиглан бүтээгдэхүүн, үйлчилгээгээ зах зээлд хурдацтайгаар нэвтрүүлж байна.
- Компанийн бүтээгдэхүүний хувьд өрсөлдөгч гэж байхгүй бөгөөд хэнийг ч өрсөлдөгч гэж үзэхгүй. Бүх оролцогчтой хамтран ажиллана. Хамтраад зах бүтээгдэхүүн үйлчилгээг тэлж, бүх талууд ашигтай байх зарчим баримтална.

**COLLABORATORS (ХАМТРАГЧ ТҮНШ)**

- Бүх оролцогчидтой хамтран ажилласнаар эцсийн хэрэглэгч хожно.
- Ижил төстэй байгууллагуудтай харилцаа үүсгэн ажиллана.

## 1.14.4 SWOT ШИНЖИЛГЭЭ

***Хүснэгт 21. SWOT шинжилгээ***

| ДАВУУ ТАЛ | СУЛ ТАЛ |
|---|---|
| Нийт брокерын Компанийн 70 гаруй хувь, нийт банк бус санхүүгийн байгууллагын 50 гаруй хувь нь программ хангамжгүй байна.<br>Өгөгдлийн сангийн хөгжүүлэлтэд Oracle 21c ORDS нь хэрэглэгчийн хандах нууцлалыг OAuth2.0 –ийн дагуу байх бөгөөд технологийн давуу талтай. Ингэснээр брокерын Компанийн харилцагчид программ гацах, удах зэрэг асуудал байхгүй болж нууцлалын өндөр зэрэглэлээр хангагдана.<br>Энэ технологийн давуу талыг аль ч программ хангамжийн Компани ашиглаж чадаагүй болно. | Маркетингийн үйл ажиллагаа сул<br>Зах зээлийн хэмжээ жижиг<br>Өрсөлдөгч Компаниуд тодорхой зах зээлийн хувийг эзэлсэн.<br>Хөрөнгийн зах зээлд оролцдог идэвхтэй брокерын Компанийн харилцагчид аль хэдийн үнэт цаасны дансаа нээсэн байдал |

| | |
|---|---|
| Монголын хөрөнгийн биржийн MIT программ хангамжтай FIX/FAST протоколоор онлайн холбогдоно.Зөв баримжаа<br>ББСБ-уудтай хамтрах технологийн давуу тал<br>Нээлттэй бодлого<br>Тогтвор суурьшилтай, мэргэшсэн боловсон хүчин | |
| **БОЛОМЖ** | **АЮУЛ** |
| Тус Компанийн арилжааны банкнуудад зориулж хөгжүүлж буй “Үнэт цаасны арилжааны мөнгөн төлбөр, тооцоо гүйцэтгэх программ хангамж”-аар дамжин брокерын Компаниуд, тэдгээрийн харилцагчдад үйлчлэх<br>Сүүлийн үеийн технологи ашигласан болон нууцлалын аюулгүй байдал | Шинэ Компаниудын хөгжүүлж буй өндөр түвшний ижил төстэй программ хангамж<br>Өрсөлдөөнөөс үүдэлтэй программ хангамжийн үнийн уналт |

**SWOT шинжилгээнд үндэслэн цаашид авах арга хэмжээ:**

**Сул тал:**

- Маркетингийн менежментээ сайжруулж, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллана.
- Хамтрагч байгууллагуудаа зах зээлд тэргүүлэх боломжийг олгосон шийдлийг бэлдэж өгөх. Улмаар хамтрагч байгууллагатайгаа хамтран зах зээлд тэргүүлэх бодлого баримтлах.

**Аюул:**

- Өөрийн гэсэн “үнэ цэнэ” бүтээх явдалд төвлөрч, нээлттэй хамтын ажиллагааны бодлого баримтална. Өрсөлдөгч гэсэн ойлголт компанийн хувьд байхгүй, зах зээлээ хамтдаа өргөтгөн, хамтдаа хөгжинө.
- Дижитал нэвтрүүлэх хөдөлгөөн өрнүүлж, сонирхсон бүх этгээдтэй хамтран ажиллана. Ингэхдээ хамтарсан хөрөнгө оруулалт хийх хувилбарт түлхүү анхаарна.
- Эцсийн хэрэглэгч үйлчилгээг авах эсэхээ өөрөө шийдээд, үйлчилгээнд чөлөөтэй бүртгүүлэх орчныг бүрдүүлнэ.

**Борлуулалтын стратеги:**

**Зах зээлийн зорилтод сегментэд хүрэх стратеги**

- Компанийн санал болгож буй бүтээгдэхүүнүүд нь бүтээгдэхүүнийг хэрэглэж байгаа компаниуд болон тэдгээрийн хэрэглэгч, харилцагчдад ашиглахад хялбар, найдвартай, боловсон хүчний зардлыг хэмнэсэн, байж болох бүх зүйлийг программчилсан, бүхий л системд холбогдож болохуйц, хямд, сүүлийн үеийн технологи бүхий систем, программ хангамжаар хангах явдал юм. Ингэснээр программ хангамжууд нь гацах, удах, шаардлага хангахгүй байх зэрэг асуудлуудтай тулгарч байгаа компаниуд, хэрэглэгчдийг өөртэй татаж бүтээгдэхүүн хэрэглэгчдийн тоогоо өсгөх зорилт тавьж байна.

**Зорилтот зах зээл:**

- Компани зах зээл дээр бүтэгдэхүүнээ борлуулахдаа гадаад болон дотоод зах зээл дээр гэсэн 2 зах зээл дээр борлуулахаар төлөвлөж байна. Аль ч зах зээл дээр нэмж захиалгат

2022-05-25
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -03- 22
БҮРТГЭВ-03

ажил нэмж авахаар төлөвлөж байна. Зах зээлийн хувьд аль ч зах зээл дээр программ хангамж хийлгэх эрэлт хангалттай байна.

**Гадаад зах зээл**

- Компани гадаад зах зээл дээр бүтээгдэхүүнээ 2023 оноос нэвтрүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд 2022 онд бэлтгэл хангах үүднээс АНУ-ын Делавер мужид охин компани болон Сингапур улсад төлөөлөгчийн газар нээхээр төлөвлөж байна.




- Гадаад зах зээл харьцангуй том бөгөөд хангалттай зах зээлтэй болно. Компани 2022 онд зочид буудлын, сууц өмчлөгчдийн, цаг захиалгын, гишүүнчлэлийн систем програм хангамжуудыг хөгжүүлж Монголын зах зээлд туршиж дуусгаснаар гадаад зах зээл дээр нэвтрүүлэхэд бэлэн болно. Компани гадаад зах зээлийг АНУ, Сингапур, Японы зах зээлд бүтээгдэхүүн гаргахаар төлөвлөж байгаа бөгөөд эдгээр зах зээлээс мобайл апп, веб сайтын программ хангамжийн захиалгыг аутсоурсинг хэлбэрээр авахаар төлөвлөж байна.

**Дотоод зах зээл**

- **Дарс систем**-ээр хувьцаат компани, нээлттэй хөрөнгө оруулалтын сангууд, койн гаргагчид нийтэд мэдүүлэх үүрэгтэй мэдээллийг заавал "Үнэт цаасны зах зээлийн тухай" хууль болон холбогдох журамд нийцүүлэн мэдүүлэх тул хөрөнгө оруулагчид, зах зээлийн шинжээчид, эдийн засгийн ангийн оюутнууд өргөн ашиглана гэж тооцоолж байна.

- Хөрөнгийн зах зээл дээр 2021 онд нийт 128'000 хүн оролцсон тул энэ зах зээлээс 2022 онд 1'000 гаруй хэрэглэгчдэд, 2025 он гэхэд 9'000 гаруй хэрэглэгчдэд бүтээгдэхүүнийг хүргэхээр зорилт тавин төлөвлөж байна.

- **Брокерс.мн систем**-нийт хөрөнгийн зах зээлд 55 гаруй үнэт цаасны компаниуд байгаа боловч өнөөдрийг хүртэл шаардлага хангасан иж бүрэн нэг ч программ хангамж байхгүй байгаа бөгөөд хэдийгээр хөрөнгийн зах зээлд 2021 онд 68'000 хүн оролцсон боловч энэ тоо компанийн хөгжүүлж буй программ хангамжийн ачаар 120'000 хэрэглэгчдэд хүргэх боломжтойгоор төлөвлөж байна. Энэ системийн борлуулалтын орлогыг бизнес төлөвлөгөөнд тусгаагүй болно.

- **Банк бус санхүүгийн байгууллагын ашиглах бүртгэлийн систем**-нийт зах зээл дээр 600 гаруй банк бус санхүүгийн байгууллага байгаагаас мэдэгдэж байгаагаар 200 гаруй банк бус санхүүгийн байгууллага огт программ хангамжгүй байгаа бөгөөд 100 гаруй компанийн ашиглаж буй програм хангамж нь бүрэн ашиглах боломжгүй

ERDENES SOLUTIONS Joint Stock Company
ГҮҮДСЕК ҮЦК ХК

хөгжүүлсэн компаниуд цаашид хөгжүүлэхээ больсон байна. Бусад компаниудын талаар мэдээлэл хомс байгаа бөгөөд Лендмн, Инвескор, Ард кредит, зэрэг цөөхөн компаниуд өөрсдийн хөгжүүлсэн программ хангамжийг ашиглаж байна.

- Компанийн хөгжүүлсэн банк бус санхүүгийн байгууллагын бүртгэлийн системийг 2022 онд 20 хүртэл, 2025 он гэхэд 50 банк бус санхүүгийн байгууллагад лиценз ашиглах замаар борлуулахаар төлөвлөж байна.Одоогоор 10 гаруй банк бус санхүүгийн байгууллагууд ашиглах сонирхолтойгоо илэрхийлсэн болно.

### 1.14.5 САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

***Борлуулалтын таамаглал***

Борлуулалтын таамаглалыг 4-н жилээр хийж хүснэгтэд харуулав.

Компани борлуулалтын орлогыг 4 зүйлийн борлуулалтын орлогоос бүрдүүлнэ:

- Өөрийн хөгжүүлсэн бүтээгдэхүүний орлогоос
- Охин компаниудын ноогдол ашгаас
- Захиалгаар хийсэн программ хангамжийн орлогоос
- Захиалгаар хийсэн программ хангамжийн жил тутмын үйлчилгээний орлогоос

Орлого нь дотоод болон гадаад зах зээлээс орлого олохоор төлөвлөсөн.

Нийт орлого 2022 онд 2.2 тэрбум төгрөг олохоор төлөвлөж байгаа бол 2025 онд 10.3 тэрбум төгрөг олохоор төлөвлөж байна. Энэ нь өөрсдийн бүтээгдэхүүнийг дотоодод хөгжүүлж бэлэн болсны дараа гадаад зах зээл дээр худалдахаар төлөвлөж байгаатай холбоотойгоос гадна гадаад зах зээл дээр программ хангамжийн үнэлгээ дотоод зах зээл дээрээс илүү үнэтэй байдагтай холбоотой. Гадаад зах зээлийг АНУ, Сингапур, Япон улсын зах зээл дээр тухай улсын программ хангамжтай чанар ижил, илүү хэд дахин хямд бүтээгдэхүүн, программ хангамжийг санал болгохоор төлөвлөж байна. 2022 онд нийт орлогод эзлэх өөрсдийн бүтээгдэхүүн 39.3 хувь, охин компанийн ноогдол ашиг 21.6 хувь, захилга ажил үйлчилгээ 31.2 хувь, программ хангамжийн жил тутмын төлбөр 7.9 хувь байсан бол 2025 он гэхэд өөрсдийн бүтээгдэхүүнээс олох орлого нийт орлогын 30 хувь, охин компаниудын ноогдол ашиг 44 хувь, захиалгат ажил үйлчилгээнээс 23 хувь, 3 хувь программ хангамжийн жил тутмын төлбөрт үйлчилгээнээс олохоор төлөвлөж байна.

Гадаад зах зээл дээр Мобайл апп захиалгыг 10 мянган ам доллароор, Вэб сайтын захиалгыг 5 мянган ам доллароор, зочид буудлын захиалгат программ хангамжийг 20 мянган ам доллароор, Сууц өмчлөгчдийн програм хангамжийг 15 мянган ам доллароор зарахаар төлөвлөж байгаа бөгөөд 2025 он гэхэд компанийн тухайн улсад байгуулсан байгуулсан охин компани, төлөөлөгчийн газраар дамжуулан АНУ, Сингапурын зах зээл дээр тус бүр 5 программ хангамжийг Япон улсын зах зээл дээр 2 программ хангамжийг борлуулахаар төлөвлөж байна. Эдгээр бүтээгдэхүүнүүд нь тухайн улсын программ хангамжтай чанарын хувьд ижил түвшний, хямд үнэтэй борлуулахаар төлөвлөж байна.

2022 -03- 22
БҮРТГЭВ-03

### *Орлогын тайлан 2022-2025*

*Хүснэгт 22. Орлогын тайлангийн төсөөлөл 2022-2025 /мян.төг/*

| | 2022 он | 2023 он | 2024 он | 2025 он |
|---|---|---|---|---|
| **Орлого** | **2,213,400** | **4,839,919** | **7,840,747** | **10,358,181** |
| Өөрсдийн хөгжүүлсэн бүтээгдэхүүнээс | 870,000 | 1,515,000 | 2,400,000 | 3,150,000 |
| Охин компаниудын ноогдол ашигаас | 478,050 | 2,425,789 | 3,772,322 | 4,570,527 |
| Програм хангамжийн жил тутмын төлбөр | 175,350 | 148,500 | 157,595 | 271,625 |
| Захиалгат ажил үйлчилгээнээс | 690,000 | 750,630 | 1,510,830 | 2,366,030 |
| **Үйл ажиллагааны зардал** | **743,440** | **525,521** | **698,354** | **831,002** |
| Үйл ажиллагааны зардал | 728,863 | 515,216 | 684,660 | 814,708 |
| Үйл ажиллагааны бус зардал | 14,577 | 10,304 | 13,693 | 16,294 |
| **Татварын өмнөх ашиг** | **1,469,960** | **4,314,398** | **7,142,393** | **9,527,179** |
| Орлогын татвар | 146,996 | 431,440 | 999,838 | 1,834,513 |
| **ЦЭВЭР АШИГ** | **1,322,964** | **3,882,958** | **6,142,556** | **7,692,667** |

Зардлын бүрэлдэхүүнд гол томоохон хувийг эзэлдэг зардлуудын тухайд:

Компанийн үйл ажиллагаанд хүний нөөцийн, элэгдлийн, сургалтын гэсэн 3 том зардал гарч байна.

- **Хүний нөөцийн зардал.** Компани 2025 он гэхэд нийт 30-аас 35 хүнтэйгээр үйл ажиллагаа эрхлэхээр төлөвлөж байна. Хүний нөөцийн зардлыг 2022 онд 517.6 сая, 2023 онд 710.9 сая, 2024 онд 918.4 сая, 2025 онд 1,098.9 сая төгрөгөөр тус тус төлөвлөж байна.

  Цалингийн өсөлтийг жил бүрийн инфляцтай уялдуулж 8 хувьд байхаар төсөвлөсөн. Энэ зардлыг олон улсын нягтлан бодох бүртгэлийн дагуу бүтээгдэхүүн хөгжүүлэх шууд хөдөлмөрийн зардал тул бүтээгдэхүүн болгон актив хөрөнгөд бүртгэсэн.

- **Сургалтын зардал.** Компани сургалтын зардалд гадаад дотоод зардалд 2022 оноос эхлэн 42.7 сая төгрөг 2025 он гэхэд 54 сая төгрөг зарцуулахаар төсөвлөж байна.

- **Сервер, интернэт, үүлэн тооцооллын зардал.** Компани 2022-2025 онд жилийн турш ашиглах интернэт ашиглах, сервер түрээслэх, үүлэн тооцооллын зардалд 39.6 сая төгрөг зарцуулахаар төсөвлөж байна. Энэ зардлыг технологийн хөгжилтэй холбоотойгоор өсөхгүйгээр тооцоолж байна.

ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК

*Хүснэгт 23. Санхүүгийн байдлын тайлангийн төсөөлөл 2022-2025 /мян.төг/*

| АКТИВ ХӨРӨНГӨ | 2022 он | 2023 он | 2024 он | 2025 он |
|---|---|---|---|---|
| Бэлэн мөнгө | 23,713 | 1,935,978 | 4,551,688 | 6,746,891 |
| Хөрөнгө оруулалт | 2,766,638 | 2,766,638 | 2,766,638 | 2,766,638 |
| Биет хөрөнгө | 499,135 | 799,135 | 1,199,135 | 1,599,135 |
| Биет бус хөрөнгө | 1,984,715 | 2,575,973 | 3,296,621 | 4,119,708 |
| **НИЙТ АКТИВ ХӨРӨНГӨ** | **5,274,201** | **8,077,724** | **11,814,082** | **15,232,372** |
| | | | | |
| **ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ** | | | | |
| Богино хугацаат өр төлбөр | 150,000 | - | - | - |
| Урт хугацаат өр төлбөр | - | - | - | - |
| **Өр төлбөр** | **150,000** | **-** | **-** | **-** |
| Энгийн хувьцаа | 1,725,405 | 1,725,405 | 1,725,405 | 1,725,405 |
| Нэмж төлөгдсөн капитал | 1,539,924 | 1,539,924 | 1,539,924 | 1,539,924 |
| Хуримтлагдсан ашиг | 535,908 | 929,436 | 2,406,197 | 4,274,376 |
| Тухайн жилийн ашиг | 1,322,964 | 3,882,958 | 6,142,556 | 7,692,667 |
| **Өөрийн хөрөнгө** | **5,124,201** | **8,077,724** | **11,814,082** | **15,232,372** |
| **ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ** | **5,274,201** | **8,077,724** | **11,814,082** | **15,232,372** |

## 1.14.6 НООГДОЛ АШГИЙН БОДЛОГО БА ТӨЛӨВЛӨГӨӨ

Компанийн ирэх 4 жилийн санхүүгийн тайлан ашигтай байхаар төсөвлөгдсөн бөгөөд хөрөнгө оруулагчдад жил бүр цэвэр ашгийн 50 хувь болон түүнээс дээш хувиар ногдол ашиг олгохоор төсөвлөж, Компанийн "Ноогдол ашгийн бодлого, шийдвэр гаргах, мэдээлэх, тарааж олгох журам"-д тусгасан байна.[49]

## 1.14.7 ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ

***Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн хүчин зүйлс***

Компанид төрөл бүрийн эрсдэл учирч болох боловч эдгээрээс чухал гэсэн эрсдэлүүдийг дараах байдлаар ангилж байгаа бөгөөд гадаад, дотоод болон үйл ажиллагаа, технологитой холбоотой, зах зээлийн эрсдэлийн хүчин зүйлсээс хамаарах эрсдэлүүд учирч болзошгүй гэж тооцоолж байна.

***Гадаад эрсдэл***

Энэ эрсдэл нь компанийн дотоод үйл ажиллагаанаас хамаарахгүй бөгөөд хянахад хэцүү байх болно.

- **Эдийн засгийн уналт.** Эдийн засгийн макро үзүүлэлтүүд муудсанаар Компанийн үйл ажиллагаанд тодорхой хэмжээгээр нөлөөлөх болно. Хэдийгээр энэ эрсдэл их байх тусам программ хангамжийг худалдан авах, үйлчилгээ авах худалдан авагчдын тоо буурахгүй байхаар тооцоолж байна. Учир нь программ хангамж эдийн засгийн уналтаар учрах зардлыг хэрэглэгчдийн хувьд бууруулах болно гэж тооцоолсон.
- **Өрсөлдөгч Компаниуд болон программ хангамж худалдан авагчдын өөрчлөлт.** Зах зээл дээр өрсөлдөгч Компаниуд шинэ программ хангамж нийлүүлэх эрсдэл нь өндөр зэрэглэлийн эрсдэлийг агуулна.Түүнчлэн программ хангамж худалдан авагчид

[49] Хавсралт 10 - ТУЗ-ийн 05/2022 тоот тогтоол, тус тогтоолын хавсралт "Ноогдол ашгийн бодлого, шийдвэр гаргах, мэдээлэх, тарааж олгох журам".

болон үйлчилгээ авагчид өөр программ хангамжийг сонирхох нь Компанид эрсдэл учруулна. Компанийн программ хангамжийг хийхдээ ирэх 4 жилд тооцоолж шинээр зах зээл дээр гарч ирэх технологийг тооцоолсон болно.

- **Технологи.** Программ хангамжийн зах зээл дээр шинэ технологи гарч ирснээр эрсдэл гарна. Ялангуяа хиймэл оюун ухааны чиглэлийг тооцоолж байна. Иймд Компанид биг дата авч ашиглах боломжийг судална.
- **Инфляц.** Дотоодын валют болох төгрөгийн ханшийн уналтаас хамаарч зах зээл дээр бүхий л бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ унаж болно. Төлөвлөгөөнд инфляцын уналтыг жилийн 8 хувиар тооцоолов.
- **Татварын өөрчлөлт болон эдийн засгийн бодлогын өөрчлөлт.** Энэ эрсдэл ирэх 4 жилд гарах магадлал багаар тооцоолов.

***Дотоод эрсдэл болон үйл ажиллагаа технологитой холбоотой эрсдэл.***

Энэ эрсдэл харьцангуй хяналттай, удирдаж байж болохуйцаар байх болно.

- **Хүний нөөцийн эрсдэл.** Компанид авах шинэ ажилтнуудын туршлага, тэдэнд олгох цалин хангамжаас ихээхэн хамаарна. Энэ эрсдэлийг бууруулахын тулд цалин хангамжийг зах зээл дээр өрсөлдөхүйц түвшинд баримтлах, хувьцааны опшён өгөх зэрэг болно.
- **Бэлэн мөнгөний дутагдал.** Компанийн санхүү түүн доторх бэлэн мөнгөний удирдлагаас хамаарна. Компанид гэнэтийн болон энэ төсөвт тусгагдаагүй худалдан авалт гарах, үйл ажиллагааны эрсдэл учрах үед төлбөр тооцоо хийхийн тулд бэлэн мөнгөний дутагдал гарч болзошгүй эрсдэл. Энэ эрсдэлийг бизнес төлөвлөлт сайн хийснээр бууруулна.
- **Үйл ажиллагааны эрсдэл.** Энэ эрсдэлийг Компанийн программ хангамжийн чанар, серверийн аюулгүй байдал, программ хангамжийг өөр газар нөөц хэлбэрээр байршуулж онлайн горимд давхар хуулбарлах зэргээр бууруулна.
- **Менежмент.** Энэ эрсдэлийг гадаад компаниудтай хамтарч, тэднээс суралцах, зөвлөгөө авах замаар ажиллахаар замаар бууруулна.
- **Мэдээллийн аюулгүй байдал.** Хэрэглэгч төвтэй үзэл баримтлалд тулгуурласан бизнесийн орчинд хэрэглэгчийн мэдээлэл гэдэг нь ямар ч байгууллагын хамгийн том үнэт зүйл болоод байна. Мэдээлэл өөрөө тун эмзэг, үнэ цэнтэй, өндөр зэрэглэлийн аюулгүй байдал, хамгаалалт шаардсан зүйл юм. Гүйлгээний мэдээлэл үүсэж, хэрэглэгчийн үйлчилгээний гүйцэтгэлийн аль нэг дамжлага дээр замаасаа болон харилцагчийн өөрийнх нь гар утсан дээрээс алдагдах, мөн гар утсаа хаяж гээх тохиолдолд түүнийг нь хөндлөнгийн этгээд ашиглах боломж нь бүрэн хаалттай байх ёстой. Энэхүү найдвартай ажиллагааны байдлыг Компани биет болон программ хангамжийн түвшинд дараах байдлаар ханган ажилладаг:
    - Платформ нь харилцагч байгууллагууд болон эцсийн хэрэглэгчийн ашиглаж буй төхөөрөмж системтэй харьцахдаа мэдээллийг encrypted байдлаар буюу өндөр түвшинд нууцлагдсан хэлбэрээр дамжуулдаг тул замаасаа алдагдах, алдагдсан байлаа ч тайлж ашиглах боломжгүй байдаг;
    - Мэдээлэл хадгалалтын аюулгүй байдлыг биет байдлаар хангахын тулд үндсэн өгөгдлийн сан серверээ Мэйжикнет болон Үндэсний дата төвд давхар байршуулах бөгөөд нөөц хувилбар /backup/-уудыг он цагийн дараалаар,

стандартын дагуу бэлдсэн байх ба нөөц хувилбарыг ашиглах заавар болон бусад холбогдох мэдээллүүдийг гамшгийн үед сэргээхэд бэлэн байдалд байлгадаг.

- **Систем, аюулгүй байдлын эрсдэл.** Компанийн үйлчилгээ үзүүлэх цөм нь платформ бөгөөд түүний найдвартай ажиллагаа нэгдүгээрт тавигддаг. Компани нь хэрэглэгчийн өдөр тутмын үйлчилгээг тасралтгүй найдвартай явуулах асуудлыг 24/7 горимд ажиллуулна.

- **Интернэт, сүлжээний ажиллагаа.** Платформ нь үйл ажиллагаагаа явуулах үүднээс олон төрлийн албан байгууллага, бизнесийн нэгжүүдтэй холбогдох шаардлага үүсдэг. Холболтууд нь аюулгүй байдлыг хангах шаардлагаасаа хамаараад сүлжээний тусгай нууцлалтай холболт эсвэл интернэт сүлжээний нууцлалтай холболт ашиглаж байна. Сүлжээний найдвартай ажиллагаа нь өөрөө ийм төрлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас шууд шалтгаалж байдаг.

- **АПП-ын найдвартай ажиллагаа.** Android, iOS үйлдлийн систем дээр тухайн системийн гарын авлага зөвлөмж стандартын дагуу "АПП"-уудаа хөгжүүлж, хийлгэсэн тул бүхий л аюулгүй байдал, найдвартай ажиллагааг хангасан байдаг. Түүнээс гадна "АПП"-аас хандаж байгаа системийн холболт нь өөрөө өндөр нууцлалтай, дамжиж байгаа мэдээлэл нь кодлогдсон байдаг тул алдагдах, алдагдсан ч тайлж ашиглах боломжгүй байдаг.

- **Цахилгаан эрчим хүчний хангамж.** Тус компанийн үйлчилгээний төв сайт буюу серверүүд нь серверүүд байршуулсан газрын автомат тог баригч, цахилгаан үүсгүүртэй дата төв дээр байрлуулсан байдаг тул цахилгаан түр болон удаан хугацаагаар тасрахад үйлчилгээний хэвийн байдлаа хадгалах боломжийг олгодог. Мөн өөрсдийн дотоод үйл ажиллагаандаа зориулсан сервер, оффисын цахилгааны доголдлоос хамгаалж түлшээр ажилладаг цахилгаан үүсгүүр ажиллуулж байна.

- **Мэдээлэл технологийн аюулгүй байдал.** Мэдээлэл технологийн аюулгүй байдлыг маш олон талаас харж болно, жишээлбэл гадны халдлага, дотоодын халдлага, вирус гэх мэт. Компани нь нууцлалын аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдэлүүдийг дараах байдлаар урьдчилан сэргийлж хамгаалах бодлого баримталдаг.

***Программын түвшний нууцлал, аюулгүй байдал***

- **Мэдээ, мэдээллийн нууцлал.** Хэрэглэгчийн мэдээлэл болон нууц мэдээллийг (нууц үг, ПИН код г.м) сүлжээний аль ч түвшинд end-to-end шаардлагыг хангахаар кодчилж илгээдэг бөгөөд тус мэдээлэл нь дата баазын түвшинд нууцлалын алгоритмаар кодлогдож хадгалагддаг.
- **Удирдлага ба администраторын эрхийн зохицуулалт.** Системд хандах хэрэглэгчдийн эрхийг нэг бүрчлэн хязгаарлах боломжтой бөгөөд системд хийгдсэн аливаа үйлдлийг өөр дээрээ болон логийн системд давхар хадгална.
- **Эрхийн түр хязгаарлалт.** Хэрэглэгчийн нууцлалыг тогтоосон давтамжтайгаар буруу оруулах үед хэрэглэгчийн эрхийг түр блоклох бөгөөд хязгаарлалтыг зөвхөн системийн удирдах ажилтан нээх эрхтэй байна. Энэ нь хэрэглэгчийн нууц мэдээллийг таах оролдлогыг хааж байгаа явдал юм.
- **Системд хандалт хийх хязгаарлалт.** Системд олон дахин хандах, автоматжуулсан довтолгоог хязгаарлах үүднээс CAPTCHA (Completely Automated Public Turning test to tell Computer and Humans Apart) функц суурилуулсан болно.
- **Вэб түвшний нууцлал.** Вэб хандалтын нууцлалыг тусгайлан хангах үйлчилгээ үзүүлдэг гуравдагч этгээдийн SSL сертификатаар хэрэглэгч ба систем хоёрын хоорондын мэдээллийг баталгаажуулан дамжуулна.

***Техник, тоног төхөөрөмжийн түвшний нууцлал, аюулгүй байдал***

Системийн тоног төхөөрөмжийг Web (гадаад ертөнцтэй харьцах), Application (боловсруулах), Data (мэдээ, мэдээлэл) гэх гурван шатлалд хуваарилсан бөгөөд шатлал тус бүр firewall төхөөрөмжөөр тусгаарлагдана. Шатлал хооронд харилцах мэдээллийн урсгалыг зөвхөн зөвшөөрсөн эх болон төгсгөл хаягаар хязгаарласан нь зөвшөөрөлгүй аливаа хандалтыг нэвтрүүлэхгүй байх боломжийг бүрдүүлдэг.

- **Давагдашгүй хүчин зүйл.** Давагдашгүй хүчин зүйлд байгалийн гамшиг, дайн байлдаан, Засгийн газрын тогтоол, журам, нийгмийн зөрчил мөргөлдөөн, дайралт халдлага ордог ба эдгээр зүйлээр хязгаарлагдахгүй. Энэ нөхцөл байдалд ямар арга хэмжээ авах, хэрхэн ажиллах талаар "Онцгой нөхцөл байдлын үед хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө" гарган журамласан байдаг.

***Зах зээл, орчны эрсдэл***

- **Өрсөлдөгчийн эрсдэл.** Компанийн хамтран ажиллагч банкууд өөрийн гэсэн систем хөгжүүлж, тус тусдаа зардал гаргасаар байна. Тэдэнд Компани гэдэг нь дундын ийм шийдэлтэй, хямд, үр ашигтай, уян хатан White Label-дамжуулан Старт АПП-ууд, Финтекүүд тус тусдаа хөгжүүлсэн давхардлыг Компанийн нээлттэй API, White Label –ийг ашиглах боломжтой байдлаар зохицуулах.
- **Платформын эрсдэл.** Платформыг бүрдүүлж буй оролцогч бүр дундаа нэгдсэн нэг стандартыг баримталдаг, тэр стандарт нь Монгол Улс дотроо хаана ч бүрэн хэрэгждэг, дан ялангуяа дэлхийн шийдэлтэй уялддаг байхыг Компани зорилгоо болгон ажиллаж байна.
- **Технологийн эрсдэл.** Орчин үед технологи нь өөрөө эрсдэл, технологийн хурд нь бас эрсдэл юм. Мөн платформын бизнесийн хувьд ямагт технологийн манлайд явах үүрэгтэй.Компани нь үйлчилгээгээ нэвтрүүлсэн цагаас хойш хоёр ч удаа суурь платформын шинэчлэлт хийсэн ба удахгүй гуравдах удаагаа суурь платформын шинэчлэлтээ хийх гэж байгаа нь үүнтэй холбоотой. AI (Artificial Inteligence) буюу хиймэл оюун ухаан дээр суурилсан үйлчилгээгээ зах зээлд гаргах гэж байна. Энэ нь зөвхөн зах зээлд гаргаад л болчих зүйл биш BI (Business Intelligence) дээрээ үндэслэн AI-аа хөгжүүлэх, боловсруулах, бойжуулах нь хамгийн чухал. Компани нь гүйлгээг BlockChain технологи дээр шилжүүлэх ажлыг урт хугацааны төлөвлөгөөндөө оруулаад байна.

***Эрсдэлийн удирдлагын тогтолцоо, баримтлах зарчим***

Компани нь платформын үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэхэд учирч болох эрсдэлүүд, тэдгээрт баримтлах бодлого зэргээ тодорхой болгосон. Компанийн хувьд дундын байр суурь нь стратегийн ач холбогдол бөгөөд эрсдэлээс сэргийлэх хамгийн гол түлхүүр юм.

***Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага***

Компани нь үйл ажиллагаандаа учирч болох эрсдэлийг хаах "Системд сайжруулалт хийх журам", "Гэмтэл саатлын үед ажиллах журам"-уудыг үйл ажиллагаандаа мөрдөнө. Мөн үйлчилгээ үзүүлэхэд учирч болзошгүй эрсдэл болон онцгой нөхцөл байдал үүсэхэд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, ажилчдын бэлэн байдлыг дараах байдлаар зохицуулж ажиллах журамтай:

<u>Сургалт</u>

Онцгой байдлын үед ажиллах баг(гэмтэл саатал гарсан үед системийг хэвийн үйл ажиллагаанд нь эргэн оруулах үүрэг бүхий баг)-ийн гишүүд бүгд тус тусын үүрэг

хариуцлагыг мэдэж, ямар арга хэмжээ авч болох талаар сургалтыг зохион байгуулах ба хагас жилд нэг удаа, шаардлагатай тохиолдолд энэ хугацаанаас өмнө зохион байгуулна.

Нөхөн сэргээх

- Онцгой байдлын нөхцөл байдлыг анх мэдсэн аливаа ажилтан системийг ажиллах багийн ахлагчид яаралтай мэдэгдэнэ.
- Мэдээлэл хүлээн авсан ахлагч боломжит хамгийн богино хугацаанд онцгой байдлын анхан шатны шалтгааныг тодорхойлон Компанид мэдээлнэ.
- Ажиллах багийн гишүүд үүссэн нөхцөл байдалд тулгуурлан гарах хохирлын урьдчилсан таамаглал судалгааг хийн сэргээх хугацааг тодорхойлон Компанийн удирлагад танилцуулан холбогдох шийдвэрийг гаргуулна.
- Үйл ажиллагаа хариуцсан захирал эсвэл Гүйцэтгэх захирал гамшгийн талаар нэгжүүдэд, шаардлагатай гэж үзвэл харилцагч хамтран ажиллагч байгууллагуудад албан ёсоор зарлаж мэдээлэл хийнэ.
- Ажиллах багийн ахлагч нь сэргээх үйл ажиллагаа төлөвлөгөөний дагуу амжилттай хийгдсэн эсэхийг шалган Компанийн удирдлагад танилцуулна.
- Үйл ажиллагаа хариуцсан захирал эсвэл Гүйцэтгэх захирал хэвийн үйл ажиллагаанд шилжсэн тухай нэгжүүдэд, шаардлагатай тохиолдолд харилцагч, хамтран ажиллагч байгууллагуудад албан ёсоор зарлана.

Ажиллах багийн эрх, үүрэг

Ахлагчийн эрх, үүрэг

- Онцгой байдал тохиолдсон үед зохицуулагч нь ажиллах багийн бүрэлдэхүүнийг цуглуулан хуралдаж, цаашид авах арга хэмжээний талаар хэлэлцэн, сэргээх ажиллагааг удирдан зохион байгуулах үүрэгтэй.
- Компанийн удирдлагаас гаргасан шийдвэр, Онцгой байдлаас сэргээх төлөвлөгөөний дагуу шуурхай арга хэмжээ авч, байгууллагын үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулахад анхаарна.
- Ажиллах багийн ахлагч нь онцгой байдлын үеийн нөхцөл байдлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Компанид цаг тухай бүр мэдээлнэ.
- Ахлагч нь төлөвлөгөөний хэрэгжилтэд бүрэн хяналт тавина.

Багийн гишүүдийн эрх, үүрэг:

- Багийн гишүүд гар утас болон холбогдох утсыг 24 цаг нээлттэй, дуудлага хүлээн авах боломжтой байлгах үүрэгтэй.
- Онцгой байдлыг ажлын бус цагаар зарласан тохиолдолд багийн гишүүд дуудлага хүлээн авч нэн даруй цуглана.
- Ажиллах багийн гишүүд нь онцгой байдлын үеийн нөхцөл байдлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг ажиллах багийн зохицуулагчид цаг тухай бүр мэдээлнэ.

## 1.14.8 МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Компани нь түүхэн замналын хувьд өмч хувьчлалын үеийн анхны 465 ХК-ны нэг болон хүнс үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байсан бөгөөд 2020 онд программ хангамж, орчин үеийн дэвшилтэт технологи хөгжүүлэгч "Эрдэнэс сольюшинс" ХХК-тай нэгдэн өөрийн оноосон нэрийг өөрчилж, бүтцийн хувьд бүрэн шинэчлэгдэн цаг үетэй хөл

нийлүүлэн алхах технологийн компани болж өөрчлөгдсөн. Үүнтэй холбоотой "Эрдэнэс сольюшинс" ХК-ны МХБ дээрх арилжааны идэвх эрс сайжирсан.

Тодруулбал Компанийн хувьцаа нь нэгдэх үйл явцаас өмнөх буюу 2020 оны 2 сар хүртэлх хугацаанд нийт 9 өдрийн арилжаагаар 38,672 ширхэг хувьцаа, үнийн дүнгээр 3,415,830 төгрөгийн арилжаа хийгдсэн бол 2020 оны 3 дугаар сараас эхлэн 2022 оны 2 дугаар сарыг дуусах хүртэл 2 жилийн хугацаанд 143 арилжааны өдрүүдэд 4,929,358 ширхэг хувьцаа, үнийн дүнгээр 464,088,912 төгрөгийн арилжаа хийгдсэн байна.

2021 оны 1 сард Компани нь нэгж хувьцаагаа 10 хуваасан бөгөөд нэгж хувьцаа хуваахын өмнө 580 төгрөг, хуваасны дараа 58 төгрөг болж өөрчлөгдсөн байна.

2022 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар Компанийн хувьцааны хаалтын ханш 90 төгрөг /сүүлийн 6 сарын өдөр тутмын хаалтын ханшийн дундаж ханш 81 төгрөг/ байгаа нь сүүлийн 1 жилийн дотор хувьцааны ханшийн өөрчлөлт 39.7%-ийн өсөлттэй байгааг харуулж байгаа ба хувьцаа хувааснаас хойш түүхэн дээд үнэ болох 120 төгрөгөөр 2021 оны 07 сарын 07-ны өдрийн хаалтын ханш тогтсон байна.

***График 20. Түүхэн ханш*** [50]




[50] Эх сурвалж- МХБ.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2022 -05- 18
БҮРТГЭВ-03

## 2.ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ

### 2.1 ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

*Хүснэгт 23. Нэмж гаргах хувьцааны тоо ширхэг, үнэ, нийт татах дүн, зарцуулалт*

| | |
|---|---|
| Үнэт цаасны бүртгэл | Монголын хөрөнгийн бирж |
| Үнэт цаас гаргагч | "Эрдэнэс сольюшинс" ХК |
| Нийтэд санал болгож буй хувь | Нийт энгийн хувьцааны 9.5% |
| Нийтэд санал болгож буй хувьцааны тоо, ширхэг | 16,572,469 (арван зургаан сая таван зуун далан хоёр мянга дөрвөн зуун жаран ес) ширхэг энгийн хувьцаа |
| Нэгж хувьцааны санал болгох үнэ | 108 (нэг зуун найм) төгрөг |
| Нийт татан төвлөрүүлэх 9.5%-ийн дүн | 1,789,826,652 (нэг тэрбум долоон зуун наян есөн сая найман зуун хорин зургаан мянга зургаан зуун тавин хоёр) төгрөг |
| Үнэт цаас арилжих арга | Тогтоосон үнийн арга |
| Зарцуулалт (сая.төг) | "Эйс ассошиэйтс ББСБ" ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгө нэмэгдүүлэхэд |
| | 1,650 |

Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон нэмж гаргаж буй энгийн хувьцааны анхдагч зах зээлийн арилжааны захиалгын эрэлтийн хэмжээ нэмж гаргаж буй 16,572,469 ширхэг энгийн хувьцааны захиалгаас давсан нөхцөлд Компанийн зарласан энгийн хувьцаанаас нэмж дахин 1,949,129 ширхэг хүртэлх энгийн хувьцааг нэмж гаргана.

*Хүснэгт 24. Дахин нэмж гаргах хувьцааны тоо ширхэг, үнэ, нийт татах дүн*

| | |
|---|---|
| Дахин нэмж гаргаж буй хувь | Нийт энгийн хувьцааны 1% (нэг) хүртэл |
| Дахин нэмж гаргаж буй хувьцааны тоо, ширхэг | 1,949,129 (нэг сая есөн зуун дөчин есөн мянга нэг зуун хорин ес) ширхэг энгийн хувьцаа |
| Дахин нэмж гаргаж буй хувьцаанаас татан төвлөрүүлэх дүн | 210,505,932 (хоёр зуун арван сая таван зуун таван мянга есөн зуун гучин хоёр) төгрөг хүртэл |
| Дахин нэмж гаргаж буй нэгж хувьцааны санал болгох үнэ | 108 (нэг зуун найман) төгрөг |
| Үнэт цаас арилжих арга | Тогтоосон үнийн арга |
| Нийт олон нийтэд гаргаж буй хувь | нийтдээ энгийн хувьцааны 10.5% (арав аравны тав) хүртэл |
| Нийт нэмж гаргаж буй хувьцааны тоо, ширхэг | 18,521,598 (арван найман сая таван зуун хорин нэгэн мянга таван зуун ерэн найм) ширхэг хүртэлх энгийн хувьцаа |
| Нийт татан төвлөрүүлэх 10.5%-ийн дүн | 2,000,332,584 (хоёр тэрбум гурван зуун гучин хоёр мянга таван зуун наян дөрөв) төгрөг |

ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company

УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК

## 2.2 ҮНЭТ ЦААС ГАРГАХ ТУХАЙ ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДЭЭС ГАРГАСАН ШИЙДВЭР

Компанийн ТУЗ-ын 2021 оны 12-р сарын 13-ны өдрийн ээлжит хурлаар Компанийн хувьцааг нэмж гаргахтай холбоотой дараах асуудлыг хэлэлцсэн байна. Үүнд:

- Компанийн зарласан хувьцаанаас эргэлтэд энгийн хувьцаа нэмж гаргах,
- Хувьцаа нэгж гаргахтай холбоотой андеррайтерийн компанийг сонгох, үр дүнг ТУЗ-д танилцуулах,
- Нэмж гаргах хувьцааг нийтэд санал болгохтой холбоотойгоор 2021 оны жилийн эцсийн байдлаар компанийн бизнесийн үнэлгээ, аудит болон хуулийн дүгнэлт гаргуулах компанийг сонгож, гэрээ байгуулах эрхийг олгох, тэдгээрт гарах зардлын дээд хэмжээг батлах,
- Нэмж хувьцаа гаргахтай холбоотойгоор хөрөнгө оруулагчтай хэлцэл хийх, худалдах үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах, шаардлагатай бусад гэрээ хэлцэл байгуулж ажиллах эрхийг Гүйцэтгэх захиралд олгох.

Компанийн ТУЗ-ын 2021 оны 12-р сарын 13-ны өдрийн ээлжит хурлаас Компанийн хувьцааг нэмж гаргахтай холбоотой дараах шийдвэрүүд гарсан [51]. Үүнд:

1. Компанийн дүрмийн 5.4 [52]-т заасан нэг бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 19,842,125,430 ширхэг зарласан энгийн хувьцаанаас 10,077,100 ширхэг

[51] ҮЦТ-ын Хавсралт 11 - ТУЗ-ийн хурлын тогтоол №ТУЗТ 11/2021.

[52] "Эрдэнэс Сольюшинс" ХК-ийн дүрэм – 5.4.Компани нь нэг бүрийн 10 \арав\ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 19,842,125,430 \арван есөн тэрбум найман зуун дөчин хоёр сая нэг зуун хорийн таван мянга дөрвөн зуун гуч\ зарласан энгийн хувьцааг хууль болон энэхүү дүрэмд заасан гүйлгээнд гаргах эрхтэй байна. Зарласан энгийн хувьцаанаас гүйлгээнд гаргах ,компанийн дүрэмд заасан бусад төрлийн үнэт цаас болон өрийн бичиг гаргах асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэх эрхтэй байна.

хувьцаа буюу нийт гаргасан хувьцааны 6 хувьтай[54] тэнцэх энгийн хувьцааг нэмж гарган МХБ-ээр дамжуулан нийтэд санал болгох замаар худалдах,

2. Нийтэд санал болгох анхдагч арилжааны захиалгын хэмжээ нэмж гаргаж буй энгийн хувьцаа 10,077,100 ширхэг хувьцаанаас давсан нөхцөлд зарласан энгийн хувьцаанаас дахин нэмж 5,536,868 ширхэг хүртэлх энгийн хувьцааг нэмж эргэлтэд гаргах,

3. Тус тогтоолын 2 болон 3-т заасан нэмж гаргаж буй хувьцааны тоо хэмжээ нийтдээ 15,613,968 ширхэг хүртэл байхаар буюу Компанийн эргэлтэд гаргасан нийт энгийн хувьцааны 9 хүртэлх хувь байхаар тогтоох,

4. Нэмж гаргах хувьцааны нийтэд санал болгох нэг бүрийн үнийг компанийн Бизнесийн үнэлгээний тайланд үндэслэн андеррайтерийн компанитай харилцан тохиролцсоны үндсэн дээр ТУЗ-ийн хурлаар шийдвэрлүүлэхийг Гүйцэтгэх захиралд үүрэг болгох,

5. Андеррайтерийн компанийг сонгон шалгаруулж ТУЗ-ийн хурлаар шийдвэрлүүлэхийг Гүйцэтгэх захиралд үүрэг болгох,

6. Нэмж хувьцаа гаргахтай холбоотойгоор СЗХ, МХБ болон улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх, зөвшөөрөл авахыг Гүйцэтгэх захиралд даалгах.

Компанийн ТУЗ-ын 2022 оны 01-р сарын 31-ний өдрийн ээлжит хурлаар Компанийн хувьцааг нэмж гаргахтай холбоотой дараах асуудлыг хэлэлцсэн байна. Үүнд:

- Компанийн ТУЗ-ын 2021 оны 12-р сарын 13-ны өдрийн ээлжит хурлын тогтоолын 2 болон 3 дах заалтад өөрчлөлт оруулах /нэмж гаргах хувьцааны тоонд өөрчлөлт оруулах/,
- Нэмж гаргах хувьцааны нийтэд санал болгох үнэ, худалдах аргыг тогтоох.

Компанийн ТУЗ-ын 2021 оны 01-р сарын 31-ний өдрийн ээлжит хурлаас Компанийн хувьцааг нэмж гаргахтай холбоотой дараах шийдвэрүүд гарсан [55]. Үүнд:

1. 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн ТУЗТ 11/2021 тоот тогтоолын 2-т Компанийн зарласан хувьцаанаас нэмж эргэлтэд гаргах хувьцааг 10,077,100 ширхэг гэж заасныг 14,665,944 ширхэг болгон өөрчлөх,
2. 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн ТУЗТ 11/2021 тоот тогтоолын 3-т Анхдагч зах зээлийн арилжааны захиалгын хэмжээ нэмж гаргаж буй хувьцааны захиалгаас давсан нөхцөлд Компанийн зарласан хувьцаанаас дахин нэмж гаргах хувьцааг 5,536,868 ширхэг гэж заасныг 3,855,654 ширхэг болгон өөрчлөх,
3. Тус тогтоолын 1 болон 2-т заасан нийтэд санал болгон нэмж гаргах хувьцааны тоо хэмжээг нийтдээ 18,521,598 ширхэг хүртэл байхаар тогтоох,
4. Нэмж гаргах хувьцааны нэг бүрийн үнийг 115 төгрөгөөр тогтоож, нийтэд тогтоосон үнийн аргаар санал болгох.

дөрвөн зуун гуч\ зарласан энгийн хувьцааг хууль болон энэхүү дүрэмд заасан гүйлгээнд гаргах эрхтэй байна. Зарласан энгийн хувьцаанаас гүйлгээнд гаргах ,компанийн дүрэмд заасан бусад төрлийн үнэт цаас болон өрийн бичиг гаргах асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэх эрхтэй байна.

[54] ТУЗ-ын 2022 оны 01-р сарын 31-ний өдрийн ээлжит хурлаар нэмж гаргах хувьцааны тоонд өөрчлөлт оруулсан байна.

[55] ҮЦТ-ын Хавсралт 12 - ТУЗ-ийн хурлын тогтоол №ТУЗТ 02/2022.

Компанийн ТУЗ-ын 2022 оны 03-р сарын 01-ний өдрийн ээлжит хурлаар Компанийн хувьцааг нэмж гаргахтай холбоотой дараах асуудлыг хэлэлцсэн байна. Үүнд:

- Компанийн ТУЗ-ын 2021 оны 12-р сарын 13-ны өдрийн ээлжит хурлын тогтоолын 2 болон 3 дах заалтад өөрчлөлт оруулах,
- Компанийн дүрмийн төслийг батлах.

Компанийн ТУЗ-ын 2021 оны 12-р сарын 13-ны өдрийн ээлжит хурлаас Компанийн хувьцааг нэмж гаргахтай холбоотой дараах шийдвэрүүд гарсан [56]. Үүнд:

1. 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн ТУЗТ 11/2021 тоот тогтоолын 2-т Компанийн зарласан хувьцаанаас нэмж эргэлтэд гаргах хувьцааг 10,077,100 ширхэг гэж заасныг 16,572,469 ширхэг болгон өөрчлөх,
2. 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн ТУЗТ 11/2021 тоот тогтоолын 3-т Анхдагч зах зээлийн арилжааны захиалгын хэмжээ нэмж гаргаж буй хувьцааны захиалгаас давсан нөхцөлд Компанийн зарласан хувьцаанаас дахин нэмж гаргах хувьцааг 5,536,868 ширхэг гэж заасныг 1,949,129 ширхэг болгон өөрчлөх,
3. Компанийн дүрмийн төслийг хавсралтаар батлах.

КТХ, ҮЦЗЗТХ болон Компанийн дүрмийн холбогдох заалтыг [57] тус тус үндэслэн Компанийн ТУЗ-ийн хурлаас дээрх тогтоол, шийдвэрүүдийг гаргасан байна.

## 2.3 НИЙТЭД САНАЛ БОЛГОХ ҮНЭ ТОГТООСОН ҮНДЭСЛЭЛ, ШИЙДВЭР

КТХ болон Компанийн дүрэмд заасны дагуу [58] Компанийн ТУЗ-ийн хурлаас нэмж гаргах хувьцааны нийтэд санал болгох үнийг тогтоосон.

Хараат бус үнэлгээний байгууллага болох "Мөнх-Оргил трейд" ХХК нь Компанитай байгуулсан 2022 оны 01-р сарын 20-ны өдрийн ЭС/МОТ-02-2022 тоот "Бизнесийн үнэлгээний гэрээ"-ний дагуу Компанийн бизнесийн үнэлгээг хийж гүйцэтгэсэн байна.

Компанийн бизнесийн үнэлгээний тайлангаар [59] дараах дүгнэлт гарсан байна. Үүнд:

- "

---

[56] ҮЦТ-ын Хавсралт 13 - ТУЗ-ийн хурлын тогтоол №ТУЗТ 04/2022.

[57] КТХ – 33.3.Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол зарласан хувьцааны төрөл тус бүрээс гаргах хувьцааны тоо, гаргах хугацаа, нөхцөлийг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ тогтооно., 42.1.Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол зарласан хувьцаанаас гүйлгээнд гаргах, компанийн дүрэмд заасан бусад төрлийн үнэт цаас болон өрийн бичиг гаргах тухай шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ гаргах бөгөөд уг шийдвэрт үнэт цаасны төрөл, тоо, гаргах хугацаа, нөхцөлийг заана., 42.2. Компани зарласан энгийн хувьцааг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг нь гаргах үүрэгтэй., 43 дугаар зүйлд Хувьцаа болон бусад үнэт цаасны үнийг тогтоох, 76 дугаар зүйлд Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх,
ҮЦЗЗТХ – 6.1. Үнэт цаасыг нийтэд санал болгон, эсхүл нийтэд санал болгохгүйгээр хаалттай хүрээнд худалдахаар гаргаж болно.,
"Эрдэнэс Сольюшинс" ХК-ийн дүрэм – 5.3.Компанийн зарласан хувьцаанаас гүйлгээнд гаргах, шинээр хувьцаа гаргах замаар, эсхүл хувьцааны нэрлэсэн үнийг өөрчлөх, өөрийн гаргасан хувьцааг эргүүлэн худалдаж авах зэргээр компани нь өөрийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчилж болно.

[58] КТХ – 43.1. Дор дурдсанаас бусад тохиолдолд хувьцаа болон бусад үнэт цаасны үнийг энэ хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ тогтооно. /нэмж хувьцаа гаргах нь уг үндэслэлд хамаарахгүй болно/.
"Эрдэнэс Сольюшинс" ХК-ийн дүрэм – 9.10.7. компанийн эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу тогтоох;.

[59] Хавсралт 5 - Бизнесийн үнэлгээний тайлан.

### 5.4. Үнэлгээний эцэслэсэн дүгнэлт

"Эрдэнэс сольюшинс" ХК-ийн бизнес /өмчийн эзний 100.0%-ийн хувь оролцоо/-ийн зах зээлийн үнэ, цэнийг 2022 оны 02-р сарын 25-ны байдлаар дээрх 2 хандлага, 3 аргаар үнэлсэн дүнг доорх хүснэгтэд оруулав.

*Хүснэгт 27. Үнэлгээний дүгнэлт*

| Үнэлгээний хандлага | Үнэлгээний арга | Үнэлгээний дүн, мян.төг | Жин | Үнэлгээний эцэслэсэн дүн, мян.төг |
|---|---|---|---|---|
| Орлогын хандлага | Мөнгөн гүйлгээг хорогдуулан тооцох арга | 22,876,390.8 | - | - |
| | Ногдол ашгийг хорогдуулан тооцох арга | **22,615,207.0** | 100.0 | **22,615,207.0** |
| Өртгийн хандлага | Цэвэр хөрөнгийн арга | **2,114,575.1** | - | - |

Дээрх 3 аргын үнэлгээний дүнг харьцуулан судалж үзээд орлогын хандлагын, "Ногдол ашгийг хорогдуулан тооцох арга"-аар тооцсон үнэлгээнд 100.0%-ийн ач холбогдол өгч эцсийн үнэлгээг **22,615,207.0 мян.төг** буюу **22,615.2 сая төг /хорин хоёр тэрбум зургаан зуун арван таван сая хоёр зуун мянга/**-өөр тодорхойлов.

Орлогын хандлагаар, "Ногдол ашгийг хорогдуулан тооцох арга"-аар тооцсон үнэлгээний дүн нь нөгөө 2 аргаар тооцсон дүнгээс үнэлгээний зорилго, зориулалттай илүү нийцэж байгаа бөгөөд компанийн зах зээлийн үнэ, цэнийг илүү бодитоор илэрхийлж байгаа тул 100.0%-ийн ач холбогдол өгсөн болно."

- "*Дүгнэлт.* "Эрдэнэс сольюшинс" ХК /эзний өмчийн 100.0%-ийн хувь оролцоо/-ны 2021 оны 12-р сарын 31-ний байдлаарх зах зээлийн үнэ, цэнийг **22,615,207.0 мян.төг** буюу **22,615.2 сая төг /хорин хоёр тэрбум зургаан зуун арван таван сая хоёр зуун мянга/**-өөр тодорхойлов."

Хөндлөнгийн үнэлгээний байгууллагаас гаргасан дүгнэлтийг үндэслэн Компанийн ТУЗ-ийн хурлаас тогтоол [60] гаргаж **Компанийн эргэлтэд нэмж гаргах энгийн хувьцааны нэг бүрийн үнийг 115 төгрөг, нийтэд тогтоосон үнийн аргаар** санал болгохоор шийдвэрлэсэн болно.

[60] Хавсралт 12 - ТУЗ-ийн хурлын тогтоол №ТУЗТ 02/2022.

## 2.4 НИЙТЭД САНАЛ БОЛГОХ ҮНЭТ ЦААСНЫ ТӨРӨЛ ТОО, ХЭЛБЭР, НЭРЛЭСЭН ҮНЭ, НӨЛӨӨ БҮХИЙ ЭНГИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЗЭМШЛИЙН ӨӨРЧЛӨЛТ

***Хүснэгт 28. Олон нийтэд нэмж 9.5%-ийн энгийн хувьцааг нэмж гаргасаны дараах нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн эзэмшлийн өөрчлөлт 2022 оны 03-р сарын 02-ны өдрийн эцсийн байдлаар***

| | Хувьцаа гаргахаас өмнө | | Нэмж 9.5%-ийн энгийн хувьцаа гаргасны дараа | |
|---|---|---|---|---|
| | Хувьцааны тоо | Эзэмшлийн хувь | Хувьцааны тоо | Эзэмшлийн хувь |
| "Субашид тек" ХХК | 100,451,734 | 63.63% | 100,451,734 | 57.58% |
| Г.Дулмаа | 9,076,765 | 5.75% | 9,076,765 | 5.20% |
| Ц.Хүдэрмөнх | 9,514,310 | 6.03% | 9,400,000 | 5.45% |
| Т.Дөлгөөн | 9,400,000 | 5.95% | 9,400,000 | 5.39% |
| М.Бат-Эрдэнэ | 9,400,000 | 5.95% | 9,400,000 | 5.39% |
| **НИЙТ** | **137,842,809** | **87.31%** | **137,842,809** | **79.02%** |
| Бусад хувьцаа эзэмшигчид | 20,031,761 | 12.69% | 36,604,229 | 20.98% |
| **НИЙТ** | **157,874,570** | **100.00%** | **174,447,038** | **100.00%** |

Компанийн гаргасан энгийн хувьцааны тоо ширхэг 157,874,570 (нэг зуун тавин долоон сая найман зуун далан дөрвөн мянга таван зуун дал) ширхэг байна.

Олон нийтэд энгийн хувьцааны 9.5%-тай тэнцэх 16,572,469 ширхэг энгийн хувьцааг нийтэд санал болгож, худалдсаны дараа Компанийн нийт энгийн хувьцаа нийт 174,447,039 ширхэг болох бөгөөд нийт эргэлтэд байгаа хувьцааны тоо ширхгийг олон нийтэд санал болгосон 115 төгрөгөөр тооцоход компанийн зах зээлийн үнэлгээ 20,061,409,485 төгрөг болохоор байна.

Хувьцаа худалдан авах эрэлт олон нийтэд санал болгосон 9.5% буюу 16,572,469 ширхгээс давсан тохиолдолд дахин 1,949,129 ширхэг /нэмж гаргаж буй хувьцааны 11.76 хувь/ хүртэлх хувьцааг нэмж гаргана. Энэ тохиолдолд нийтдээ энгийн хувьцааны 10.5% буюу нийт 18,521,598 ширхэг хүртэлх хувьцааг олон нийтэд санал болгож худалдах бөгөөд Компанийн эргэлтэд гаргасан энгийн хувьцааны тоо ширхэг 176,396,168 болж, үүнийг олон нийтэд санал болгосон үнэ 115 төгрөгөөр тооцоход компанийн зах зээлийн үнэлгээ 20,285,559,320 төгрөг болохоор байна.

***Хүснэгт 29. Олон нийтэд нэмж 10.5% -ийн энгийн хувьцааг нэмж гаргасны дараах нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн бүтэц***

| | Хувьцаа гаргахаас өмнө | | Нэмж 9.5%-ийн энгийн хувьцаа гаргасны дараа | |
|---|---|---|---|---|
| | Хувьцааны тоо | Эзэмшлийн хувь | Хувьцааны тоо | Эзэмшлийн хувь |
| "Субашид тек" ХХК | 100,451,734 | 63.63% | 100,451,734 | 56.95% |
| Г.Дулмаа | 9,076,765 | 5.75% | 9,076,765 | 5.15% |
| Ц.Хүдэрмөнх | 9,514,310 | 6.03% | 9,400,000 | 5.39% |
| Т.Дөлгөөн | 9,400,000 | 5.95% | 9,400,000 | 5.33% |
| М.Бат-Эрдэнэ | 9,400,000 | 5.95% | 9,400,000 | 5.33% |
| **НИЙТ** | **137,842,809** | **87.31%** | **137,842,809** | **78.15%** |
| Бусад хувьцаа эзэмшигчид | 20,031,761 | 12.69% | 38,553,358 | 21.85% |
| **НИЙТ** | **157,874,570** | **100.00%** | **176,396,167** | **100.00%** |

## 5. НИЙТЭД САНАЛ БОЛГОХ БОЛОН АРИЛЖИХ НӨХЦӨЛ

***Зураг 6. Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах явц***




***Үнэт цаасыг бүртгэх тухай зөвшөөрлийг эрх бүхий байгууллагаас авах***

- ҮЦЗЗТХ, СЗХ болон МХБ-ийн холбогдох журамд заасны дагуу үнэт цаасыг бүртгүүлэх хүсэлт гаргах, зөвшөөрөл авна.

***Үнэт цаасыг олон нийтэд танилцуулах***

- Байгууллагын болон маркетингийн стратеги боловсруулж, үнэт цаасны танилцуулга болон танилцуулгын хураангуйг боломжит хөрөнгө оруулагчдад танилцуулах;

- Roadshow: Үнэт цаасны танилцуулга (roadshow) зохион байгуулах төлөвлөгөө гаргаж, боломжит хөрөнгө оруулагчидтай уулзаж, танилцуулах;
- Санал болгож буй хувьцаатай холбоотой мэдээллийг олон нийтэд түгээх.

***Захиалга хүлээн авах, биелүүлэх***

- СЗХ-ны зөвшөөрлийн дагуу МХБ-тэй хамтран захиалга хүлээн авч эхлэх болон хаах хугацааг тогтоох;
- ҮЦК-уудад арилжааны талаарх зааварчилгаа, мэдээлэл өгөх;
- ҮЦК-ууд худалдан авах захиалгыг МХБ-ийн захиалгын нэгдсэн санд оруулна;
- Захиалга хаагдсанаар хувьцаа худалдан авах захиалгын дүнг нэгтгэн МХБ-тэй хамтран нийлүүлэх аргачлалыг тогтоох, Хувьцаа худалдан авах захиалга нийлүүлэх дүнгээс илүү гараагүй нөхцөлд захиалгыг шууд биелүүлэх;
- Сонгосон аргачлалын дагуу хувьцаа худалдан авах захиалгыг СЗХ-ноос зөвшөөрөл авснаар биелүүлнэ.

***Хувьцааг арилжих нөхцөл***

- Үнэт цаас гаргагчийн хувьцааг үнэт цаасны анхдагч зах зээл дээр арилжааг явуулахдаа Монголын хөрөнгийн биржийн Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журмын 3.1.3[60]-т заасан "ТОГТООСОН ҮНИЙН АРГА"-ыг олон нийтэд санал болгоно.
- Компанийн энгийн хувьцааны 9.5 хувьтай тэнцэх 16,572,469 ширхэг хувьцааг стратегийн хөрөнгө оруулагчид болон олон нийтэд санал болгохдоо ТОГТООСОН ҮНИЙН АРГААР нэг бүрийг нь 108 төгрөгөөр санал болгоно.
- Хувьцааны захиалгын ТОГТООСОН ҮНИЙН АРГА нь компанийн энгийн хувьцааны 9.5 хувьтай тэнцэх 16,572,469 ширхэг хүртэлх энгийн хувьцааны захиалгын сан бүрдсэнээр захиалгын санг дуусгавар болгоно.
- Үнэт цаас гаргагчийн олон нийтэд нэмж гаргаж буй энгийн хувьцааг худалдаж авах эрэлт нь 9.5 хувьтай тэнцэх 16,572,469 ширхгээс илүү гарсан тохиолдолд дахин 1,949,129 ширхэг хүртэлх хувьцааг нэмж нэг бүрийг нь 108 төгрөгөөр дахин ТОГТООСОН ҮНИЙН АРГААР нийтэд санал болгоно.

---

[60] МХБ-ийн Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам – 3.1.3. Тогтоосон үнэ (өгөөж)-ээр санал болгох арилжаа - Үнэт цаас гаргагчийн тогтоосон тодорхой үнэ (өгөөж)-ээр санал болгон арилжих үйл ажиллагаа.

- Андеррайтер нь үнэт цаас гаргагчийн нэмж гаргаж буй нийт 10.5% (арав аравны тав) хувь буюу нийт 18,521,598 (арван найман сая таван зуун хорин нэгэн мянга таван зуун ерэн найм) ширхэг энгийн хувьцааны 80% (ная) хүртэлх хувийг үнэт цаас гаргагчтай зөвшилцсөний үндсэн дээр стратегийн хөрөнгө оруулагчдад бусдаас давуу байдлаар тэргүүн ээлжид худалдах эрхтэй.

## 2.6 ҮНЭТ ЦААС ХУДАЛДАН АВАХ ЗААВАР

Хувьцаа худалдан авах хөрөнгө оруулагчид дараах зааврын дагуу анхдагч зах зээлийн арилжаанд оролцоно.

*Зураг 7. Хувьцаа худалдан авах заавар*




## 2.7 НИЙТЭД САНАЛ БОЛГОЖ БАЙГАА ҮНЭТ ЦААСААР ГЭРЧЛЭГДЭХ ЭРХ, ҮҮРЭГ

Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч нь КТХ, ҮЦЗЗТХ хууль, Компанийн дүрэмд зааснаар дараах эрхүүдийг эдэлнэ.

### 2.7.1 ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ

- Хувьцаа эзэмшигч нь бусад хувьцаа эзэмшигчийн саналыг харгалзахгүйгээр өөрийн эзэмшиж байгаа хувьцаагаа чөлөөтэй захиран зарцуулах эрх эдэлнэ.
- Нийлүүлэх, нэгтгэх буюу өөрчлөх замаар өөрчлөн байгуулагдаж байгаа компанийн саналын эрхтэй хувьцаа эзэмшигч нь өөрчлөн байгуулахын эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй бол КТХ-ийн 53, 54 дүгээр зүйлд заасан журмын дагуу өөрийн эзэмшиж байгаа хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхтэй.
- Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хурлаар хэлэлцэж байгаа бүх асуудлаар өөрийн эзэмшлийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн санал өгөх.

- Давуу эрхийн хувьцааны ногдол ашиг төлсний дараагаар компанийн Төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-өөс тогтоосон хэмжээгээр ногдол ашиг авах.
- Компанийг татан буулгах үед энэ хуулийн 28 дугаар зүйлд заасан журмын дагуу үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх.
- Хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйл болон дүрэмд заасны дагуу компаниас нэмж гаргах хувьцаа, түүнд хамаарах үнэт цаасыг тэргүүн ээлжид худалдан авах эрхтэй.
- Компанийн тухай хуулийн 53.1.1, 53.1.2, 53.1.3 [62] дурдсан асуудлаар хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргасан шийдвэрийн эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдан авахыг компаниас шаардах эрхтэй.
- Хувьцаа эзэмшигч дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд хамтран компанийн энгийн хувьцааны 75 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа, түүнчлэн төрийн өмчийн эзэмшилд байсан компанийн хувьцааны хяналтын багцыг хувьчлан авсан тохиолдолд бусад энгийн хувьцаа эзэмшигч хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг компаниас шаардах эрхтэй.
- Саналын эрхтэй хувьцаа эзэмшигч нь санал хураалтаар шийдвэрлэх асуудал бүрээр санал өгөх эрхтэй.
- Их хэмжээний хэлцэл хийх асуудлаар эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигч нь КТХ-ийн 53 дугаар зүйлд заасан журмын дагуу өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхтэй.
- Компанийн энгийн хувьцаа эзэмшигч болон компанийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан КТХ-ийн 90.1 [63] -д заасан хариуцлага хүлээлгэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.
- КТХ-ийн 89.1-т заасан этгээд нь энэ хуулийн 91, 92 [64] дугаар зүйлийн шаардлага, журам зөрчсөн, эсхүл компанитай хэлцэл байгуулсан хуулийн этгээдийн бүх хувьцааг уг этгээд дангаараа эзэмшдэг нөхцөлд компани нь учирсан хохирлыг тухайн хуулийн этгээдээр нөхөн төлүүлэх буюу энэ хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

---

[62] КТХ - 53.1.1.нийлүүлэх, нэгтгэх, хуваах болон хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах; 53.1.2.компани энэ хуулийн арван нэгдүгээр бүлэгт заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлах шаардлагатай их хэмжээний хэлцэл хийсэн; 53.1.3.компанийн дүрэмд хувьцаа эзэмшигчдийн эрхийг хязгаарласан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан, эсхүл ийм агуулгатай компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг баталсан;.

[63] КТХ - 90.1.Сонирхлын зөрчилтэй хэлцлийн улмаас компани, түүний хараат болон охин компанид учирсан хохирлыг гэм буруутай этгээд өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө.

[64] КТХ - 89.1.Компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшиж байгаа компанитай дор дурдсан харилцаанд орсон бол компанитай, эсхүл түүний хараат болон охин компанитай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тооцогдоно:, 91 дүгээр зүйл. 91 дүгээр зүйл.Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тавих шаардлага, 92 дугаар зүйл.Сонирхлын зөрчилтэй хэлцэл, түүнийг хийх журам.

- Хувьцаат компанийн энгийн хувьцаа эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, хязгаарлагдмал хариуцлагатай компанийн аль нэг хувьцаа эзэмшигч нь компанийн энгийн хувьцаа эзэмшигчийн эцэг/эх/-ийн нэр, оршин суугаа газрын хаяг, түүний эзэмшлийн хувьцааны тоо зэргийг агуулсан бүртгэлийг шаардан гаргуулах эрхтэй.[65]

### 2.7.2 ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧИЙН ҮҮРЭГ

- Хувьцаа эзэмшигч нь өөрийн нэр, оршин байгаа хаягийн өөрчлөлтөө тухай бүр ТУЗ-ийн нарийн бичгийн даргад мэдэгдэх;
- Нийт гаргасан хувьцааны 5-аас дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшсэн этгээд өмчлөх эрх үүссэнээс хойш ажлын 3 хоногийн дотор энэ тухай компанид бичгээр мэдэгдэх.

## 2.8 ҮНЭ ТОГТВОРЖУУЛАХ ХӨТӨЛБӨР

Үндсэн андеррайтер болох "Гүүдсек ҮЦК" ХХК нь үнэт цаас гаргагчийн гаргасан нэмж гаргасан энгийн хувьцааг хоёрдогч зах зээлийн арилжааны үнийн хэт өсөлт, бууралтаас хамгаалах, тогтвортой байдлыг хангах зорилгоор МХБ дээр хоёрдогч зах зээлийн арилжаанаас эргүүлэн худалдаж авах үнэ тогтворжуулах хөтөлбөрийг дараах байдлаар хэрэгжүүлнэ. Үүнд:

***Хүснэгт 32. Үнэ тогтворжуулах нөхцөл***

| | **Нөхцөл** | **Хязгаарлалт** |
|---|---|---|
| 1 | Хоёрдогч зах зээлээс эргүүлэн худалдан авах хувь, хэмжээ | Компанийн нэмж гаргасан энгийн хувьцааны 2.4 /хоёр аравны дөрөв/ хувиас хэтрэхгүй |
| 2 | Хоёрдогч зах зээлээс нэг өдөрт эргүүлэн худалдаж авах хэмжээ | Компанийн нэмж гаргасан энгийн хувьцааны 0.24 /тэг зууны хорин дөрөв/ хувиас хэтрэхгүй |
| 3 | Хоёрдогч зах зээлээс эргүүлэн худалдан авах үнэ | Өмнөх өдрийн хаалтын ханшаас дээш болон доош 15 /арван тав/ хувиас хэтрэхгүй |
| 4 | Үнэ тогтворжуулах хугацаа | Хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш 1 сарын хугацаатай |
| 5 | Үнэ тогтворжуулах хөтөлбөртэй холбоотой гарах зардал | Үнэ тогтворжуулах хөтөлбөртэй холбоотой гарах зардлыг андеррайтерийн компани өөрийн хөрөнгөөр |
| 6 | Хууль эрх зүйн хязгаарлалт | ҮЦЗЗТХ болон СЗХ, МХБ-ийн холбогдох дүрэм, журмын дагуу |

[65] КТХ – 98.3. Хувьцаат компанийн энгийн хувьцаа эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, хязгаарлагдмал хариуцлагатай компанийн аль нэг хувьцаа эзэмшигч нь компанийн энгийн хувьцаа эзэмшигчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, түүний эзэмшлийн хувьцааны тоо зэргийг агуулсан бүртгэлийг шаардан гаргуулах эрхтэй.

## 3.ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН ЭТГЭЭДҮҮДИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

### 3.1 ҮНЭЛГЭЭНИЙ КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

| | |
|---|---|
| Нэр: | МӨНХ ОРГИЛ ТРЕЙД ХХК |
| Хаяг: | Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, МҮЭ-ийн Холбооны Ерөнхий Зөвлөлийн байр, 211 тоот өрөө. |
| Утас: | (976) 7013-3256, (976) 9811-3250, (976) 9918-3250 |
| И-мэйл: | bestcon6@gmail.com |
| Үйл ажиллагааны чиглэл: | Хөрөнгийн үнэлгээ, Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, Бизнесийн зөвлөх үйлчилгээ |

Мөнх-Оргил трейд ХХК нь анх 1996 онд КТХ-ийн дагуу хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр үүсгэн байгуулагдсан.

Мөнх-Оргил трейд ХХК нь 1998 оноос эхлэн Хөрөнгийн үнэлгээний чиглэлээр тасралтгүй, тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Санхүүгийн Зохицуулах Хорооноос тавигддаг шаардлагуудыг хангаж, 2013 оноос Монгол Улсын Үнэт цаасны зах зээлд оролцогчдод хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний үйлчилгээ үзүүлж байна.

Мөнх-Оргил трейд ХХК нь газар, барилга, үл хөдлөх хөрөнгө, уул уурхай, хөдөө аж ахуй, газар тариалан, харилцаа холбоо, тээвэр, авто зам, эрчим хүчний салбарт бизнесийн болон хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлж ирсэн туршлагатай. Бодь групп, Бодь интернэйшнл, Голомт банк, Алтай групп, ДЦС-4 ТӨХК, Монгол базальт ХК зэрэг томоохон бизнесийн нэгжүүд болон түүний охин, хамаарал бүхий компаниудын бизнесийн үнэлгээг хийж гүйцэтгэсэн.

*Хүснэгт 33. Мөнх-Оргил трейд ХХК-ний үнэлгээчдийн мэдээлэл*

| Тусгай зөвшөөрөл эзэмшигч | Тусгай зөвшөөрөл олгосон байгууллага | Тусгай зөвшөөрлийн нэр, дугаар, олгосон огноо | Тусгай зөвшөөрлийг сунгуулсан эсэх | Тусгай зөвшөөрлийн хүчинтэй эцсийн хугацаа | Үнэт цаасны зах зээлийн сургалтад хамрагдсан он |
|---|---|---|---|---|---|
| Б.Эрдэнэбаатар | Сангийн яам | 1. Хөрөнгийн үнэлгээ хийх, 07120004, 2010.12.20 | 2013, 2017, 2019 онуудад сунгуулсан | 2022.12.17 | 2021 |
| Ч.Дарамбазар | Сангийн яам | 2. Хөрөнгийн үнэлгээ хийх, 071200078, 2010.12.20 | 2013, 2017, 2019 онуудад сунгуулсан | 2022.12.17 | 2020 |
| Ц.Сэржээ | Сангийн яам | 3. Хөрөнгийн үнэлгээ хийх, 071200016, 2010.12.20 | 2013, 2017, 2019 онуудад сунгуулсан | 2022.12.17 | 2020 |
| Э.Цацрал | Сангийн яам | 4. Хөрөнгийн үнэлгээ хийх, 131200016, 2013.12.20 | 2017, 2019 онуудад сунгуулсан | 2022.12.17 | 2020 |

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2013 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн 297 тоот тогтоолоор Үнэт цаасны зах зээлд оролцогчдод хөрөнгийн үнэлгээ хийх эрх авсан.

## 3.2 ҮНЭЛГЭЭНИЙ КОМПАНИТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ЭРХ, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

Мөнх-Оргил трейд ХХК нь СЗХ-ны 2013 оны 09-р сарын 13-ны өдрийн 297 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны зах зээлд оролцогчдод хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх" тусгай зөвшөөрлийн хүрээнд 2022 оны 01-р сарын 20-ны өдөр Үнэт цаас гаргагчтай байгуулсан ЭС/МОТ-02-2022 тоот "Үнэлгээний үйлчилгээ үзүүлэх" гэрээ байгуулсан.

Тус гэрээний зорилго нь Үнэлгээний компани нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам болон Үнэлгээний олон улсын стандартын дагуу Үнэт цаас гаргагчийн бизнесийн болон хөрөнгийн үнэлгээг СЗХ болон МХБ-ээс баталсан дүрэм, журамд нийцүүлэн, тэдгээр байгууллагаас тавигдсан шаардлагын дагуу мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэхэд оршино.

Энэхүү гэрээний хүрээнд талууд дараах үүргийг хүлээхээр тохиролцсон:

- Үнэлгээний компани нь Үнэт цаас гаргагчаас гаргаж өгсөн мэдээлэл, баримт материалд тулгуурлан өөрийн сонгосон аргачлалын дагуу Монгол Улсын үнэт цаасны зах зээлд шинээр хувьцаа гаргах үйл ажиллагаанд холбогдох хууль, тогтоомжийн дагуу мэргэжлийн үнэлгээчнээр оролцох, Үнэлгээний олон улсын стандарт болон Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, бусад холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журмын дагуу Үнэт цаас гаргагчийн бизнесийн болон хөрөнгийн үнэлгээг хийх, тайлан гаргах үйлчилгээг гүйцэтгэнэ.
- Гэрээнд Үнэлгээчин нь Захиалагч болон бусад талуудын аливаа шахалтгүйгээр чөлөөтэй нөхцөлд үнэлгээг явуулах, тухайн үнэлгээний ажилд шаардлагатай баримт, мэдээллийг Захиалагчаас гаргуулан авч ашиглах, үнэлгээнд хамрагдаж байгаа объектод саадгүй нэвтрэн орж, шаардлагатай үзлэг, хэмжилт, зураг авалт, дүрс бичлэг хийх, гэрээний 2.4., 2.5., 2.6-д заасан нөхцөлүүд хангагдахгүй тохиолдолд үнэлгээний ажлыг цаашид явуулахаас татгалзах, Захиалагчийн бизнесийн нууцыг чанд хадгалах зэрэг эрх, үүрэг тусгагдсан.
- Захиалагч нь үнэлгээнд шаардлагатай, гэрээний хавсралтад заасан болон үнэлгээчний шаардсан бусад баримт, материал, мэдээллүүдийг үнэн зөв бэлтгэж үнэлгээчинд гаргаж өгөх, үнэлгээчнийг үнэлгээнд хамрагдаж байгаа объектод саадгүй нэвтрэн орж, шаардлагатай үзлэг, хэмжилт, зураг авалт, дүрс бичлэг хийх боломжоор хангах, үнэлгээчинд ямар нэг шахалт, дарамт үзүүлэхгүй байх, Үнэлгээчний хийсэн тайлантай танилцаад үнэлгээний ажлыг хангалтгүй гэж үзвэл дахин тодруулах, нэмэлт тайлбар гаргуулах зэрэг эрх, үүрэгтэй байх зохицуулалтуудыг гэрээнд тусгасан.

## 3.3. АУДИТЫН КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

| | |
|---|---|
| Нэр: | ПИ КЭЙ ЭФ МОНГОЛИА АУДИТ ХХК |
| Хаяг: | Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг-14240, 1-р хороо, Жамьяан гүний гудамж-18/1, Даун Таун Бьюлдинг, 602 тоот. |
| Утас: | (976) 7505-7979, (976) 9919-3732 |
| Вэб: | www.pkf.mn |
| И-мэйл: | bayarmaa@ pkf.mn |

Пи Кэй Эф Монголиа Аудит ХХК нь 1998 оны 12 дугаар сарын 14-ний өдөр Координат Аудит ХХК нэртэйгээр үүсгэн байгуулагдаж, улсын бүртгэлд бүртгүүлсэн ба аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан, иргэний санхүүгийн баримтыг хянаж дүгнэлт гаргах, зөвлөмж өгөх хараат бус мэргэжлийн байгууллага юм.

2017 оны 06-р сарын 01-ний өдөр Ази, Номхон далайн бүсэд нэг дугаарт эрэмбэлэгддэг TOP ACCOUNTING FIRM болох PKF INTERNATIONAL LIMITED –ийн албан ёсны гишүүн фирм болсон байна.

Тус аудитын компани нь үнэт цаасны зах зээлд оролцогчдод аудитын үйлчилгээ үзүүлэх зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны №33 дугаар тогтоолоор авсан ба хөрөнгийн биржид бүртгэлтэй хэд хэдэн хувьцаат компаниудад санхүүгийн тайлангийн аудитын үйлчилгээг амжилттай хийж гүйцэтгэсэн туршлагатай, тэргүүлэх аудитын компаниудын нэг юм.

Тусгай зөвшөөрөл:

| Эрхлэх үйл ажиллагааны төрөл | Гэрчилгээг олгосон буюу хугацааг сунгасан огноо | Гэрчилгээний дугаар |
|---|---|---|
| Аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл | 2020.11.16 | №015-1998 |
| Үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл | 2015.01.21 | №33 |

Пи Кэй Эф Монголиа Аудит ХХК нь 1998 онд Сангийн сайдын тушаалаар 015-1998 дугаар бүхий "Аудитын үйл ажиллагаа эрхлэх" тусгай зөвшөөрлийг авч байсан ба үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж, холбогдох хууль тогтоомжоор тавигдах нөхцөл шаардлагыг бүрэн хангаж ажилласнаар гурван жил тутам тусгай зөвшөөрлийн хугацаагаа сунгуулсаар ирсэн байна.

Улмаар Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороо, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтээс хамтран зохион байгуулдаг мэргэжлийн сургалт, шалгалтад аудиторуудаа хамруулан, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 1 дүгээр сарын 21 -ний өдрийн №33 тоот тогтоолоор үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдээр бүртгүүлснээр №30 дугаарын гэрчилгээ олгогдсон байна.

## 3.4 АУДИТЫН КОМПАНИТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ЭРХ, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

Гэрээт ажлын хүрээ: "Үйлчлүүлэгч тал"-ын Монголын хөрөнгийн бирж дээр нэмж энгийн хувьцаа гаргах шийдвэрийг үндэслэн "Үйлчлүүлэгч тал"-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлан, анхан шатны баримт, бусад санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой баримт мэдээ, үйл ажиллагаанд Аудитын Олон Улсын Стандарт, "Үнэт цаасны зах зээлийн тухай" хууль болон "Санхүүгийн зохицуулах хороо"-ны 2021 оны 06-р сарын 11-ний өдрийн 225 тоот тогтоолоор баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"–д тус тус заасны дагуу хөндлөнгийн хяналт шалгалт хийж, дүгнэлт өгөх.

***Үйлчлүүлэгчийн эрх, үүрэг***

- Үйлчлүүлэгч тал нь Гүйцэтгэгч талын аудитораас гаргасан дүгнэлтийнхээ үндэслэлийг тайлбарлахыг шаардах эрхтэй.
- Гүйцэтгэгч талын гаргасан дүгнэлт нь үндэслэлгүй, шаардлага хангаагүй, шалгалтыг дутуу хийсэн гэж үзвэл зөрчлийг арилгуулах хүсэлт гаргах, удирдлагад нь мэдэгдэх, өөр аудитор гаргаж өгөхийг шаардах эрхтэй.
- Үйлчлүүлэгч Аудитын үйл ажиллагаа явуулах нөхцөл бололцоогоор хангах, үйл ажиллагаанд нь хөндлөнгөөс оролцохгүй, саад учруулахгүй байх үүрэгтэй.
- Үйлчлүүлэгч нь Гүйцэтгэгч талын шалгалтад шаардлагатай баримт, мэдээллийг цаг тухайд нь гаргаж өгөх үүрэгтэй.
- Үйлчлүүлэгч тал нь шалгалтын явцад илэрсэн бүртгэл хөтлөлтийн болон санхүүгийн тайлантай холбоотой алдаа, зөрчлийг залруулах үүрэгтэй.
- Үйлчлүүлэгч тал нь үйлчилгээний хөлсийг тогтоосон хугацаанд төлөх үүрэгтэй.
- Үйлчлүүлэгч тал нь аудитын дүгнэлтийг зөвшөөрөхгүй бол энэ талаар гуравдагч этгээдээр шалгуулах, шүүхэд гомдол гаргах эрхтэй.

***Гүйцэтгэгчийн эрх, үүрэг***

- Гүйцэтгэгч тал аудит хийхдээ Монгол Улсын Аудитын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын багц хууль болон бусад хуулийг чандлан сахиж, Аудитын Олон Улсын Стандартад заасан арга хэлбэрээр аудитын үйл ажиллагаа явуулах үүрэгтэй.
- Гүйцэтгэгч тал нь аудитын ажлыг Үйлчлүүлэгч талын үйл ажиллагааны цар хүрээ, хийгдэх ажлын хэмжээтэй уялдуулан аудитын багийг томилж, мэргэжлийн өндөр түвшинд, хууль тогтоомж, батлагдсан стандартын дагуу шударгаар гүйцэтгэх эрхтэй.
- Гүйцэтгэгч тал нь Үйлчлүүлэгч талын удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах бөгөөд гаргасан дүгнэлтийнхээ үнэн зөвийг хариуцах үүрэгтэй.
- Гүйцэтгэгч тал нь ажил гүйцэтгэх явцад аудитын ажлын чанар, үр дүнд сөргөөр нөлөөлөх Гүйцэтгэгч талаас үл хамаарах нөхцөл бий болсон тохиолдолд Үйлчлүүлэгч талд нэн даруй мэдэгдэнэ. Аудит хийж болохгүй нөхцөл байдал байгаа бол уг үйл ажиллагаа явуулахаас татгалзах эрхтэй.
- Гүйцэтгэгч тал нь гэрээнд заасан ажлын цар хүрээнд холбогдолтойгоор үйлчлүүлэгч талаас санхүүгийн баримт, хууль эрхийн актыг шаардаж авах, биет байдлаар үзэх,

мөнгө үнэт цаас, биет болон биет бус хөрөнгийг тоолох, шалгалтын явцад гарсан аливаа асуудлаар тайлбар, нотолгоо бичгээр гаргуулан авах эрхтэй.

- Гүйцэтгэгч тал нь аудитын үйл ажиллагаандаа хууль ёсны бөгөөд бодитой арга хэрэгслийг ашиглаж дүгнэлтээ баримтжуулах үүрэгтэй.
- Аудитын үйл ажиллагааг Үйлчлүүлэгч талын эсвэл өөрийн байранд явуулах бөгөөд аудит хийх явцад олж авсан Үйлчлүүлэгч талын аливаа мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, хуульд зааснаас өөр тохиолдолд бусдад мэдээлэхээс татгалзах ба Үйлчлүүлэгч талын бизнесийн үйл ажиллагаатай холбоотой баримтууд болон аудитын бусад ажлын баримт, материалыг өөрийн ажлын байранд тусгайлан хадгалж, нууцлал, бүрэн бүтэн байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй.
- Гэрээт ажлын хугацаанд аудитын ажлын тодорхой үе шатны тайлан, холбогдох материалтай Үйлчлүүлэгч талын удирдлагаас танилцах нөхцөлөөр хангах, Үйлчлүүлэгч тал хүсвэл аудитын дүгнэлтийн хууль зүйн үндэслэлийг тайлбарлаж өгөх үүрэгтэй.
- Аудиторын тайлан, зөвлөмжийг монгол хэл дээр тус бүр 2 хувь гаргаж хүлээлгэн өгөх.
- Үйлчлүүлэгч талаас шалгалтад шаардлагатай баримт материал, тайлбарыг бүрэн хэмжээгээр гаргаж өгөөгүй болон аудит хийж болохгүй бусад нөхцөл байдал үүссэн бол аудит хийхээс татгалзах эрхтэй. Хийгдсэн ажилтай холбоотой гарсан зардлыг үйлчлүүлэгчээс нэхэмжлэх, нөхөн төлүүлэх эрхтэй.

## 3.5 ХУУЛИЙН КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

| | |
|---|---|
| Нэр: | ӨМГӨӨЛЛИЙН БАТБАЯР ЭНД ПАРТНЭРС ХХК |
| Хаяг: | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө-8, Монгол ТВ цамхаг, 10 давхар, 1001-1003 тоот |
| Утас: | (976) 7711-9008 |
| Вэб: | www.bnp.mn |
| И-мэйл: | contact@bnp.mn |

Өмгөөллийн Батбаяр энд Партнэрс ХХН нь 2013 оны 06 дугаар сарын 18-ны өдөр улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн мэргэшсэн бизнесийн хуулийн фирм юм. Тус хуулийн фирм нь үнэт цаасны зах зээлийн оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны №72 тоот тогтоолын дагуу авсан. Үнэт цаасны зах зээлийн оролцогчдод хууль зүйн туслалцаа, хөндлөнгийн дүгнэлт гаргаж өгөх үйлчилгээ үзүүлэх эрхтэй. Гадаад, дотоодын хөрөнгийн биржид хувьцаа, өрийн бичиг, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах хэд хэдэн удаагийн ажлуудыг амжилттай хийж гүйцэтгэсэн туршлагатай, тэргүүлэх хуулийн фирм юм.

Өмгөөллийн Батбаяр энд Партнэрс ХХН-ийн тусгай зөвшөөрөл:

| Эрхлэх үйл ажиллагааны төрөл | Гэрчилгээ олгосон огноо | Гэрчилгээний дугаар |
|---|---|---|
| Үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх | 2014.03.12 | №72 |
| Өмгөөллийн хуулийн этгээдийн үйл ажиллагаа эрхлэх | 2015.10.01 | №039 |

Өмгөөллийн Батбаяр энд Партнэрс ХХН-ийн хуульчдын тусгай зөвшөөрөл:

| Овог нэрс | Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээний дугаар | Өмгөөлөгчийн шүүхэд төлөөлөх эрхийн гэрчилгээний дугаар | Үнэт цаасны зах зээлд оролцогчид үйлчилгээ үзүүлэх гэрчилгээний дугаар |
|---|---|---|---|
| Б.Баасандорж | 4927 | 2037 | 17029 |
| Д.Хулан | 2977 | 2821 | 17032 |

## 3.6 ХУУЛИЙН КОМПАНИТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ЭРХ, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

Үнэт цаас гаргагч "Эрдэнэс сольюшинс" ХК нь 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдөр Өмгөөллийн Батбаяр энд Партнэрс ХХН-тэй Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан. Хуулийн фирм нь тус гэрээний дагуу "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"-ийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэг, "Санхүүгийн зохицуулах хороо"-ны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн №225 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 11 дүгээр зүйлийн 11.14 дахь хэсэг, "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн №2018/01 тоот тогтоолоор батлагдсан, 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн №2020/06 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 2 дугаар зүйлийн 2.6 дахь хэсэгт заасан асуудлын хүрээнд хөндлөнгийн дүн шинжилгээ хийж, хуулийн дүгнэлт гаргана. Хуулийн дүгнэлт нь дараах мэдээллийг агуулсан байна. Үүнд:

| **Санхүүгийн зохицуулах хороо Үнэт цаасны бүртгэлийн журам** | **Монголын хөрөнгийн бирж ТӨХК Үнэт цаасны бүртгэлийн журам** |
|---|---|
| Үнэт цаас гаргагч нь хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн эсэх, үнэт цаас гаргах шийдвэр нь хуулийн дагуу гарсан эсэх;<br><br>Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомж, Хорооноос баталсан "Монголын компанийн засаглалын кодекс"-т заасан шаардлага хангаж байгаа эсэх, тэдгээрийн удирдах чадвар, дадлага туршлагын талаар мэдээлэл;<br><br>Үнэт цаас гаргагчийн дотоод дүрэм, журмууд нь холбогдох хууль тогтоомж, Хорооноос баталсан "Монголын компанийн засаглалын кодекс"-т нийцсэн эсэх;<br><br>бусадтай байгуулсан худалдах болон худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн гэрээ болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх;<br><br>бусадтай байгуулсан худалдах болон худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн гэрээ болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх;<br><br>Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг | Тухайн компанийн улсын бүртгэл, татвар төлөгчийн болон нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийн бүртгэлтэй холбоотой зөрчил байгаа эсэх;<br><br>Компанийн дүрэм, үнэт цаасаа анх удаа нийтэд санал болгон гаргаж байгаа компанийн хувьд хувьцаат компанийн дүрмийн төсөл, бусад дотоод журмууд нь хууль тогтоомж, Хорооноос баталсан "Монголын компанийн засаглалын кодекс"-т нийцсэн эсэх;<br><br>Бусадтай байгуулсан худалдах, худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн гэрээ болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой бусад гэрээ хэлцэл нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар байгаа эсэх;<br><br>Сүүлийн 1 жилийн дотор хийсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг хуульд заасан журмын дагуу байгуулсан эсэх;<br><br>Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, |

| | |
|---|---|
| нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл буй эсэх; | үйлчилгээний тэмдэг, газар эзэмших эрх нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн зэргээр үйл ажиллагаанд нь сөргөөр нөлөөлж болох нөхцөл байгаа эсэх; |
| үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн эсэх; | Үнэт цаас, хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх; |
| үнэт цаасыг бүртгүүлэх танилцуулгад тусгагдсан хууль зүйн мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх; | Үнэт цаас гаргагч нь Компанийн тухай хуулийн 6.13-т заасан хуулийн этгээдийн нэгдэлд хамаарч байгаа бол толгой, охин, хараат, зэргэлдээ компанийн талаарх мэдээлэлд үндэслэн үнэт цаас гаргагч компанийн хяналтыг жинхэнэ хэрэгжүүлэгч этгээд нь хэн болохыг тодорхойлох. |
| компанийн толгой, охин, хараат, зэрэгцээ компанийн талаарх мэдээлэлд үндэслэн үнэт цаас гаргагч компанийн хяналтыг хэрэгжүүлэгч, эцсийн өмчлөгч этгээдийг тодорхойлох; | |
| үнэт цаас гаргагч нь аж ахуйн үйл ажиллагааны эсрэг гэмт хэрэг, иргэн, захиргааны хэрэгт хариуцагчаар татагдаж байсан эсэх; | |
| татвар, нийгмийн даатгал болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт өр төлбөртэй эсэх. | |

## 3.7 АНДЕРРАЙТЕРИЙН КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

**ҮНДСЭН АНДЕРРАЙТЕР**

| | |
|---|---|
| Нэр: | ГҮҮДСЕК ҮЦК ХХК |
| Хаяг: | Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Чингисийн гудамж 8/1, Сити Тауэр, 1803 тоот. |
| Утас: | (976) 11-33-1878 |
| Вэб: | www.goodsec.mn |
| И-мэйл: | enkhtaivan@goodsec.mn |

"Гүүдсек ҮЦК" ХХК нь Монгол улсын хэмжээнд бүртгэлтэй харилцагчдын тоогоор салбартаа тэргүүлэгч компани бөгөөд үнэт цаасны арилжааны цахим системийг нэвтрүүлсэн, цаг үетэйгээ хөл нийлүүлэн алхаж буй үнэт цаасны компаниудын нэг юм. Тус компани нь СЗХ-ны 2016 оны 03-р сарын 11-ний өдрийн 74 тоот тогтоолын дагуу андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авсан байна.

| Эрхлэх үйл ажиллагааны төрөл, хэлбэр | Зөвшөөрөл олгосон огноо | Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар |
|---|---|---|
| Брокер | 2008.11.28 | №265 тогтоол |
| Дилер | 2008.11.28 | №265 тогтоол |
| Хөрөнгө оруулалтын зөвлөх | 2008.11.28 | №265 тогтоол |
| Андеррайтер | 2016.03.11 | №74 тогтоол |
| Номинал дансаар харилцагчдад үйлчилгээ үзүүлэх | 2019.02.22 | №110 тушаал |
| Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах | 2021.11.27 | №23 тогтоол |

**ТУСЛАХ АНДЕРРАЙТЕР**

| | |
|---|---|
| Нэр: | ЭС ЖИ КАПИТАЛ ҮЦК ХХК |
| Хаяг: | Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, 30-р байр, 10 давхар. |
| Утас: | (976) 7011-2191 |
| Вэб: | www.sgcapitalsec.com |
| И-мэйл: | info@sgcapitalsec.com |

| Эрхлэх үйл ажиллагааны төрөл, хэлбэр | Зөвшөөрөл олгосон огноо | Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар |
|---|---|---|
| Брокер | 2010.12.09 | №406 тогтоол |
| Дилер | 2010.12.09 | №406 тогтоол |
| Хөрөнгө оруулалтын зөвлөх | 2010.12.09 | №406 тогтоол |
| Андеррайтер | 2012.01.18 | №22 тогтоол |
| Номинал дансаар харилцагчдад үйлчилгээ үзүүлэх | 2019.01.28 | №46 тушаал |

Андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатай авсан. Санхүүгийн Зохицуулах Хорооны 2013 оны 12 сарын 04 өдрийн 475 тоот тогтоолоор андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг 3 жилийн хугацаатайгаар сунгасан. 2013 оны 5-р сарын 24-ны өдөр "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"-ийг шинэчлэн найруулж УИХ-аас баталсан бөгөөд үүнтэй холбоотой холбогдох журмууд шинэчлэгдэж андеррайтерийн тусгай зөвшөөрөл нь 3 жилийн хугацаагаар сунгагддаг байсан нь өөрчлөгдөн хугацаагүй болсон.

## 3.8 АНДЕРРАЙТЕРИЙН КОМПАНИТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ЭРХ, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

***Үндсэн андеррайтерийн гэрээгээр хүлээсэн хийх ажлын цар хүрээ***

Үнэт цаас гаргагч болон үндсэн андеррайттерын компанийн хооронд байгуулсан 2022 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн "Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ"-нд заасан андеррайтерийн зүгээс үзүүлэх үйлчилгээнүүд нь дараах зөвлөмж, үйлчилгээнүүдээр тодорхойлогдоно. Үүнд:

- Үнэт цаас гаргагчийн нэмж гаргах хувьцааг үнэт цаасны зохих бүртгэлд бүртгүүлэх асуудлаар үнэт цаас гаргагчийн нэрийн өмнөөс СЗХ, МХБ-тэй харилцах, тэдгээртэй холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах;
- Хувьцаа гаргаж олон нийтэд санал болгохтой холбоотойгоор Үнэт цаас гаргагч болон хувьцааг шаардлагатай танилцуулгыг бэлтгэх, видео контент, бусад олон нийтийн сурталчилгааны материалыг үнэт цаас гаргагчтай хамтран бэлтгэх;
- Холбогдох хуулиуд, зохицуулагч байгууллагын журам, дүрэм, зааврын хүрээнд хувьцааг гаргаж, олон нийтэд санал болгох ажлыг зохион байгуулах;
- Олон нийтэд нэмж гаргах хувьцааг санал болгох ажилтай холбоотой зохицуулагч байгууллагуудаас шаардлагатай бүртгэлийн зөвшөөрлүүд авах, МХБ-д бүртгүүлэх ажиллагаанд Үнэт цаас гаргагчтай хамтарч ажиллах, дэмжлэг үзүүлэх;
- Аудит, хуулийн зөвлөх, үнэлгээний компаниудтай хамтран ажиллах, дүгнэлт гаргуулах, түүнийг хянах, шаардлагатай зөвлөгөө, мэдээлэл солилцох;

- Үнэт цаас гаргагчийн олон нийтэд хувьцаа санал болгох ажиллагааг таниулах ажлыг Үнэт цаас гаргагчтай хамтран зохион байгуулах, удирдах;
- Хөрөнгө оруулагчтай хийх уулзалтуудыг товлох, зохион байгуулах, уг уулзалтуудад Үнэт цаас гаргагчийн төлөөллийг оролцуулах;
- Олон нийтэд санал болгох хувьцааны үнэлгээг тодорхойлоход Үнэт цаас гаргагчид зөвлөх;
- Үнэт цаасны танилцуулга, холбоотой баримт бичгийг бэлтгэх, эхний бөгөөд эцсийн хувилбарыг хэвлэх, тараах ажлыг зохион байгуулах, удирдах;
- Анхдагч захын арилжааг нээж, захиалга хүлээн авах, нийтэд танилцуулах ажиллагаа дуусгавар болсон үед нэмж гаргасан үнэт цаасыг анхдагч зах зээлд амжилттай арилжсан тухай тайланг МХБ-ийн дүгнэлтийн хамтаар СЗХ-нд хүргүүлэх.

***Туслах андеррайтерийн гэрээгээр хүлээсэн хийх ажлын цар хүрээ***

Үндсэн болон туслах андеррайтеруудын хооронд байгуулсан 2022 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн "Андеррайтерийн хамтран ажиллах гэрээ"-нд заасан Туслах андеррайтерийн ажлын цар хүрээ нь дараах байдалтай байна. Үүнд:

- Үнэт цаас гаргагчийг төлөөлөн танилцуулга хийх, олон нийттэй уулзалт зохион байгуулах зэрэг албан бичиг болон маркетингийн ажлуудад туслалцаа үзүүлэн ажиллах;
- Нэмж гаргах хувьцааг борлуулах үйл ажиллагааг өөрөөс хамаарах дээд зэргийн хүчин чармайлтаар буюу Андеррайтерийн Best Effort хэлбэрээр гүйцэтгэх;
- МХБ-ээр нээлттэй хүрээнд нэмж гаргах хувьцааг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд бүртгүүлэхэд шаардлагатай баримт бичиг, мэдээллийг бэлтгэхэд туслалцаа, дэмжлэг үзүүлэх;
- Хөрөнгө оруулагчдад хүргэх шаардлагатай мэдээллээс бусад бизнесийн болон байгууллагын нууцад хамаарах мэдээллийн нууцыг хадгалах.

***Хариуцлага***

Үндсэн андеррайтерийн гэрээнд хариуцлагын талаар "Зөвлөх үйлчилгээ үзүүлэгч мэргэжлийн байгууллага /хуульч, санхүүгийн шинжээч, үнэлгээний байгууллага, аудит гэх мэт/-аас баталгаажуулсан мэдээлэл, гаргасан дүгнэлт нь худал буюу бодит байдалд нийцээгүй, төөрөгдүүлсний улмаас ирээдүйд учрах хохирлыг Андеррайтер хариуцахгүй, хувьцаа нэмж гаргах үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, дүрэм журам зөрчсөн нь эрх бүхий байгууллагаас тогтоогдсон этгээд нь зохих хариуцлагыг бие даан хүлээнэ." гэж тус тус заасан байна.

Үндсэн болон туслах андеррайтеруудын хооронд байгуулсан гэрээнд хариуцлагын талаар гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс учирсан хохирлыг буруутай тал бүрэн хариуцах тухай зохицуулалтын тусгасан байна.

--ooOoo--

2022-05-25

2022 -03- 22
БҮРТГЭВ-03

ЭРДЭНЭС
СОЛЬЮШИНС

| | |
|---|---|
| Үнэт цаас гаргагчийн хаяг | Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, 40 50 мянгат /15171/ Бакула ринбучийн гудамж, 30-р байр, 10-р давхар |
| Холбоо барих утас | (976)-11-70119588 |
| Вэб сайт | www.erdenes.solutions |
| И-мэйл | Info@erdenes.solutions |

ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company



УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК
ҮЦК ХХК

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -03- 22
БҮРТГЭВ-03

# ХАВСРАЛТ

1. "Эрдэнэс сольюшинс" ХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ
2. "Эрдэнэс сольюшинс" ХК-ийн дүрэм
3. Аудитлагдсан санхүүгийн тайлан
4. Хууль зүйн дүгнэлт
5. Бизнесийн үнэлгээний тайлан
6. Андеррайтерийн дүгнэлт
7. Үндсэн болон туслах андеррайтерийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээ
8. "Субашид тек" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ
9. "Субашид тек" ХХК-ийн дүрэм
10. ТУЗ-ийн тогтоол №ТУЗТ 05/2022, хавсралт "Ноогдол ашгийн бодлого, шийдвэр гаргах, мэдээлэх, тарааж олгох журам"
11. ТУЗ-ийн тогтоол №ТУЗТ 11/2021
12. ТУЗ-ийн тогтоол №ТУЗТ 02/2022
13. ТУЗ-ийн тогтоол №ТУЗТ 04/2022
14. "Эйс ассошиэйтс ББСБ" ХХК-ийн дүрэм
15. "Эйс ассошиэйтс ББСБ" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ
16. "Эйс ассошиэйтс ББСБ" ХХК-ийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээ
17. "Эйс ассошиэйтс ББСБ" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр №02/2022
18. "Кларо трейд" ХХК-ийн дүрэм
19. "Кларо трейд" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ
20. "Кларо трейд" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр №05/2022

ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company
9020080899



УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК
5203173

ХАВСРАЛТ 1. "Эрдэнэс сольюшинс" ХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ

УБ-2

Монгол Улсын Засгийн газрын
2004 оны 20 дугаар тогтоолоор батлав

# МОНГОЛ УЛС
# УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

0000109077

2007.03.14
/ Бүртгэсэн он,сар,өдөр /

9010001131
/ Улсын бүртгэлийн дугаар /

2015358
/ Регистрийн дугаар /

Хархорум пропертийс Хувьцаат компани
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Тогтоол / шийдвэрийн нэр /
02 / дугаар /
1996.04.20 / он, сар, өдөр /

6810 Үл хөдлөх хөрөнгөд хөрөнгө оруулалт хийх, худалдах, худалдан авах, зуучлах, түрээслэх
/ код / / Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

6630 Үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийх

/ код / / Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй / хугацаа /
137 / гишүүдийн тоо /
3,619.50 / өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Чингэлтэй, 3-р хороо, энхтайвны өргөн чөлөө, 54-р байр Пийс Тауэр 1306 тоот, Утас1: 88101698, Утас2: , Факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Бүртгэлийн газар
/ бүртгэсэн байгууллагын нэр /

Гэрчилгээ дахин олгосон 2015 он 10 сар 13 өдөр

## Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтан тэмдэг |
| 1 | Дашпилжээ овогтой Энхбаатар-г Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв. | 2007.03.14 | Д.Алтанцэцэг |
| 2 | Дахин өрчилгээ олгов. | 2015.10.13 | О.Шижиртуяа |
| 2 | Цогтбаяр овогтой Хүдэрмөнх-г Гүйцэтгэх захирал-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв. | 2020.03.16 | М.Монголжин |
| 3 | 6319068 тоот регистрийн дугаартай Эрдэнэс сольюшинс-г нэгтгэснийг бүртгэв. | 2020.06.26 | М.Монголжин |
| 4 | Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 1575126.2 мян.төг-р нэмэгдэж нийт 1578745.7 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв. | 2020.06.30 | М.Монголжин |
| 5 | Улаанбаатар, Чингэлтэй, 1-р хороо, энхтайваны өргөн чөлөө, 7/2, Денвер оффис, 4-р давхар, 401 тоот Утас1: 70119588, Утас2: , Факс: хаягийг шинээр бүртгэв. | 2020.06.30 | М.Монголжин |
| 6 | 6810 Үл хөдлөх хөрөнгөд хөрөнгө оруулалт хийх, худалдах, худалдан авах, зуучлах, түрээслэх үйл ажиллагааг хассаныг бүртгэв.<br>6630 Үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийх үйл ажиллагааг хассаныг бүртгэв.<br>62010 Програм хангамжийн үйл ажиллагаа үйл ажиллагаа шинээр бүртгэв.<br>47410 Програм хангамж, компьютерын тоног төхөөрөмжийн худалдаа үйл ажиллагаа шинээр бүртгэв.<br>63120 Вэб сайт хийх үйл ажиллагаа шинээр бүртгэв.<br>47910 Вэб сайтаар онлайн худалдаа эрхлэх үйл ажиллагаа шинээр бүртгэв.<br>63990 Мэдээллийн технологийн үйл ажиллагаа үйл ажиллагаа шинээр бүртгэв.<br>46100 Худалдааны зуучлал үйл ажиллагаа шинээр бүртгэв. | 2020.06.30 | М.Монголжин |
| 7 | Хархорум пропертийс оноосон нэр Эрдэнэс сольюшинс болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2020.08.24 | У.Мандахтуяа |
| 8 | Шинэчилсэн дүрэм бүртгэв. | 2021.02.02 | О.Өлзийбат |

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

* 0 0 0 0 1 0 9 0 7 7 *

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн ээлжит хурлын ТУЗТ 04/2022 тоот шийдвэрийн нэгдүгээр хавсралт

**ТӨСӨЛ**

**"ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС"**
**ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ**
**НИЙТЛЭГ ЗҮЙЛ**

**1. Нийтлэг үндэслэл**

1.1. "Эрдэнэс сольюшинс" ХК (цаашид "**Компани**" гэх) нь Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.

1.2. Компани нь нээлттэй хувьцаат компани ("ХК") болно.

1.3. Компани нь гадаадын болон дотоодын хуулийн этгээдтэй хамтран ажиллах, хамтарсан хэлбэрээр үйл ажиллагаа явуулж болно.

1.4. Компани нь өөрийн бэлгэдэл \лого\, тогтоосон журмын дагуу хийлгэсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ. Компани нь хуульд нийцүүлэн өөрийн албан ёсны цахим хуудас, вэб сайт, цахим шуудангийн хаягийг чөлөөтэй нээж ажиллуулна.

1.5. Компани нь нийтээр хүлээн зөвшөөрсөн бизнесийн хэм хэмжээ болон олон улсын болон Монгол Улсын компанийн засаглалын шилдэг жишгийг үйл ажиллагаандаа удирдлага болгоно.

1.6. Компани Монголын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй, нийтэд хувьцаагаа арилжаалдаг хувьцаат компани тул Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржээс тогтоосон шаардлагыг үйл ажиллагаандаа баримтлан ажиллахын зэрэгцээ хувьцаа эзэмшигчийн нийтлэг эрх ашгийг үйл ажиллагаандаа ямагт дээдлэн ажиллана.

**2. Компанийн оноосон нэр, оршин байгаа хаяг**

2.1. Компанийн оноосон нэр:

Монгол хэлээр: "Эрдэнэс сольюшинс" ХК

Англи хэлээр: "Erdenes solutions" JSC

2.2. Компанийн төв захиргаа дараах хаягт байрлана.

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, 40 50 мянгат, Бакула ренбүчийн гудамж, 30-р байр, 10-р давхар.

Харилцах утас: 976-11-70119588
Электрон шуудан:

2.3. Компани нь өөрийн салбар, төлөөлөгчийн газартай байж болно. Салбар, төлөөлөгчийн газар нь хуулийн этгээдийн эрх эдлэхгүй ба Компаниас баталсан журмын дагуу үйл ажиллагаа явуулна.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ
## КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

**3. Компанийн эрхлэх үйл ажиллагааны чиглэл**

3.1. Компани нь ашиг олох зорилгоор хуулиар хориглоогүй бүхий л төрлийн үйл ажиллагаа эрхлэх бөгөөд дараах үндсэн үйл ажиллагааг явуулна:

3.1.1. программ хангамжийн үйл ажиллагаа;

3.1.2. программ хангамж, компьютерын тоног төхөөрөмжийн худалдаа;

3.1.3. вэб сайт хийх;

3.1.4. вэб сайтаар онлайн худалдаа эрхлэх;

3.1.5. мэдээллийн технологи;

3.1.6. худалдааны зуучлал.

3.2. Компани дараах эрхтэй байна. Үүнд:

3.2.1. үйл ажиллагаагаа өргөжүүлэх, хэрэглэгчид бүтээгдэхүүн үйлчилгээгээ ойртуулах зорилгоор гадаад улсад болон дотоодод салбар, төлөөлөгчийн газар байгуулах;

3.2.2. компанийн хүний нөөцийн бодлого, үйл ажиллагааг зүй зохистой хангаж, шагнал, цалин, урамшууллын нэгдсэн боддого баримталж ажиллах;

3.2.3. үйл ажиллагаагаа уялдуулах зорилгоор бусад хуулийн этгээдийн нэгдэлд оролцох, тодорхой гишүүнчлэл бүхий гадаадын болон дотоодын холбоонд эвлэлдэн нэгдэх, ашиг сонирхлоо илэрхийлэх;

3.2.4. компанийн бизнесийн үйл ажиллагаатай холбоотой зарим мэдээллийн нууцлалыг холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу хадгалах, хамгаалах;

3.3. Компани нь энэ дүрмийн 4.1-д заасан үндсэн үйл ажиллагаанаас гадна, дараах үйл ажиллагааг явуулж болно. Үүнд:

3.3.1. үйл ажиллагаатай холбоотой гэрээний хэрэгжилттэй холбогдох гуравдагч этгээдээс төлбөр нэхэмжлэх;

3.3.2. үндсэн үйл ажиллагаагаа дэмжих зорилгоор нээлттэй зах зээлийн үйл ажиллагаа явуулах.

**4. Мэдээллийг нээлттэй мэдээлэх**

4.1. Компани өөрийн үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг тухай бүр өөрийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.

4.2. Компани дараах мэдээллийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 56.1-д заасан журмын дагуу нийтэд мэдээлнэ:

4.2.1. компанийн удирдлагын бүтцэд өөрчлөлт орсон;

4.2.2. компанийн үйл ажиллагааны тайлан, мэдээ, гарсан өөрчлөлт;

4.2.3. хагас жилийн болон жилийн эцсийн аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлан;

4.2.4. компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн бүтэц, түүний бусад компанид эзэмшиж байгаа хувьцаанд орсон өөрчлөлт;

4.2.5. компани болон түүний охин, хараат, зэргэлдээ компанид орсон зохион байгуулалтын өөрчлөлт;

2022 -05- 25 БҮРТГЭВ

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -03- 22
БҮРТГЭВ-03

4.2.6. компанийн хөрөнгийг битүүмжилсэн, эсхүл хураасан;

4.2.7. компани тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэх болсон, эсхүл түүнийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон;

4.2.8. компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гарсан;

4.2.9. компанийн эрх бүхий албан тушаалтанд олгосон цалин, шагнал урамшуулал, удирдлагын зардлын хэмжээ;

4.2.10. компанийн бусадтай байгуулсан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцлийн талаарх мэдээлэл;

4.2.11. төлөөлөн удирдах зөвлөл /цаашид "ТУЗ" гэх/-өөс нийтэд мэдээлэх шаардлагатай гэж үзсэн болон Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон бусад мэдээлэл.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ
## КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ

### 5. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө, хувьцаа

5.1. Компани нь нэг бүрийн 10 \арав\ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 20'000'000'000 \хорин тэрбум\ ширхэг зарласан энгийн хувьцаатай байх бөгөөд зарласан хувьцаа нь компанийн хувь нийлүүлсэн хөрөнгөд хамаарахгүй.

5.2. Компани нь зарласан нийт энгийн хувьцаанаас нэг бүрийн 10 \арав\ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 176,396,168 \нэг зуун далан зургаан сая гурван зуун ерэн зургаан мянга нэг зуун жаран найм\ ширхэг гаргасан энгийн хувьцаатай байх бөгөөд Компанийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан журмын дагуу компани нь нийт 1,763,961,680 \нэг тэрбум долоон зуун жаран гурван сая есөн зуун жаран нэгэн мянга зургаан зуун ная\ төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байна.

5.3. Компанийн зарласан хувьцаанаас гүйлгээнд гаргах, шинээр хувьцаа гаргах замаар, эсхүл хувьцааны нэрлэсэн үнийг өөрчлөх, өөрийн гаргасан хувьцааг эргүүлэн худалдаж авах зэргээр компани нь өөрийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчилж болно.

5.4. Компани нь нэг бүрийн 10 \арав\ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 19,823,603,832 \арван есөн тэрбум найман зуун хорин гурван сая зургаан зуун гурван мянга найман зуун гучин хоёр\ ширхэг зарласан энгийн хувьцааг хууль болон энэхүү дүрэмд заасан журмын дагуу гүйлгээнд гаргах эрхтэй байна. Зарласан энгийн хувьцаанаас гүйлгээнд гаргах, компанийн дүрэмд заасан бусад төрлийн үнэт цаас болон өрийн бичиг гаргах асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэх эрхтэй байна.

5.5. Компанийн гаргасан энгийн хувьцаа нь үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэгдэж, нийтэд чөлөөтэй арилжаалагдана.

5.6. Компанийн энгийн хувьцаа нэг бүр нь нэг саналын эрхтэй байна.

5.7. Компани хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр давуу эрхийн хувьцаа гаргаж болно.

5.8. Компанийн хувьцааг нэрлэсэн үнээс доогуур үнээр гаргах \худалдах\-ыг хориглоно.

5.9. Компанийн нэг төрлийн хувьцааны нэрлэсэн үнэ ижил байх бөгөөд тухайн төрлийн хувьцааг нэмж гаргахад түүний нэрлэсэн үнэ өмнө гаргасан тухайн төрлийн хувьцааны нэрлэсэн үнэтэй ижил байна.

5.10. Компани хувьцаагаа биет бус хэлбэрээр гаргах бөгөөд компани нь хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг хөтөлж, түүнийг хадгалах ажлыг зохион байгуулах бөгөөд энэ үүргээ Компанийн

ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК ERDENES SOLUTIONS Joint Stock 9020080899

УЛААНБААТАР ХОТ ГҮҮДСЕК ҮЦК ХХК

тухай хуулийн 45.2-т заасны дагуу үнэт цаасны хадгаламжийн байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлнэ.

5.11. Компанийн хувьцаа эзэмшигчдийн бүртгэл нь тухайн үнэт цаас эзэмшигчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, түүний эзэмшлийн хувьцааны төрөл, тоо /хэмжээ/ болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан байна.

5.12. Компанийн хувьцаа эзэмшигч нь өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг болон эзэмшиж байгаа үнэт цаасны хэмжээ /тоо/-г компанид мэдээлэх, түүнчлэн эдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтийг тухай бүрд нь мэдэгдэх үүрэгтэй.

5.13. Энэ дүрмийн 6.10-т заасан үүргийг биелүүлээгүйгээс хувьцаа эзэмшигчид учирсан хохирлыг Компанийн тухай хуулийн 45.4-45.6-д заасны дагуу компани хариуцахгүй.

5.14. Компани нь өөрийн гаргасан энгийн хувьцааны таваас дээш хувийг худалдан авах шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн олонхын саналаар шийдвэрлэнэ. Харин тав хүртэл хувийг ТУЗ-ийн шийдвэрээр худалдан авч болно.

### 6. Компанийн хувьцаа эзэмшигч, тэдгээрийн эрх үүрэг

6.1. Компанийн хувьцаа эзэмшигч нь эзэмшиж буй хувьцаа буюу хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулсан хэмжээгээр хариуцлага хүлээнэ.

6.2. Компанийн хувьцаа эзэмшигч нь өөрийн эзэмшиж буй хувьцаагаа чөлөөтэй захиран зарцуулах /худалдах, бэлэглэх, барьцаалах, өв залгамжлуулах бусад хуулиар зөвшөөрсөн бусад хэлбэр/ эрхтэй байна.

6.3. Хувьцаа эзэмшигч нь компаниас нэмж гаргаж буй хувьцаанаас өөрийн эзэмшиж буй хувь хэмжээтэй хувь тэнцүүлэн тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан журмын дагуу хэрэгжүүлнэ.

6.4. Компанийн хувьцаа эзэмшигч нь компанийн талаарх бүх мэдээллийг авах, санхүүгийн болон бусад баримт бичигтэй танилцах эрхтэй бөгөөд компани нь энэ төрлийн мэдээллээр хангах үүрэгтэй.

6.5. Хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хууль, энэхүү дүрэмд заасан хувьцаа эзэмшигчийн бүх эрх, үүргийг эдэлнэ.

### 7. Компани болон хувьцаа эзэмшигчдийн хариуцлага

7.1. Компанийн эд хөрөнгө нь эзэмшиж байгаа эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхээс бүрдэх бөгөөд компани нь эдгээр бүх эд хөрөнгөөрөө хариуцлага хүлээнэ.

7.2. Компани нь хувьцаа эзэмшигчдийн хүлээх үүргийг хариуцахгүй.

7.3. Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр хариуцлага хүлээнэ.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
## КОМПАНИЙН УДИРДЛАГА

### 8. Хувьцаа эзэмшигчдийн хурал

8.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна.

8.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал ээлжит болон ээлжит бус хэлбэртэй байх бөгөөд ээлжит хурлыг ТУЗ Компанийн тухай хуулийн 59.4-д заасан хугацаа болох компанийн санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор буюу жил бүрийн 5 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө зарлан хуралдуулна.

8.3. Шаардлагатай тохиолдолд Компанийн тухай хуулийн 61.1, 61.7-д заасан этгээд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хэдийд ч зарлан хуралдуулж болно.

8.4. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах тухай шийдвэрийг компанийн ТУЗ Компанийн тухай хуулийн 60.2-т заасан журмын дагуу гаргана.

8.5. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг ТУЗ-ийн дарга, эсхүл тухайн хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчид шийдвэрлэсэн бол өөр этгээд даргалж болно.

8.6. Дараах асуудлыг зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ:

8.6.1. компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу шинэчилсэн найруулгыг батлах;

8.6.2. нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах;

8.6.3. компанийн хэлбэрийг өөрчлөх;

8.6.4. компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, нэмж гаргах хувьцааны тоог тогтоох;

8.6.5. хувьцааг хуваах болон нэгтгэх;

8.6.6. компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;

8.6.7. ТУЗ-ийн гишүүдийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;

8.6.8. компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлт, жилийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, хөрөнгийн талаар тайланг хэлэлцэж батлах;

8.6.9. компанийн үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөх, шинээр бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргах;

8.6.10. Компанийн тухай хуульд заасны дагуу их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах эсэхийг шийдвэрлэх;

8.6.11. ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;

8.6.12. ТУЗ-ийн тогтоолоор хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал.

8.7. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны олонх нь буюу 50 болон түүнээс дээш хувь нь хуралд оролцсоноор хүчин төгөлдөр болно.

8.8. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг хуралд оролцсон нийт саналын эрхтэй энгийн хувьцааны олонх буюу 50 болон түүнээс дээш хувийн саналаар шийдвэрлэнэ.

8.9. Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц энэ Дүрмийн 8.7-д заасан хэмжээнд хүрээгүй тохиолдолд хурлыг хойшлуулах бөгөөд харин хэлэлцэх асуудал хэвээр байна. Хойшлогдсон хурлыг 20 хоногийн дотор хуралдуулна.

8.10. Саналын эрхийн 20 хувь буюу түүнээс дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч хуралд оролцсоноор хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн хурал хүчин төгөлдөр болно.

8.11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах үед компани нь Компанийн тухай хуулийн 65.6-д заасан мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд танилцуулах үүрэгтэй.

2022 05 25 БҮРТГЭВ



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -03- 22
БҮРТГЭВ-03

8.12. Компани нь хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг Компанийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны журамд заасан нөхцөл шаардлагын дагуу хувьцаа эзэмшигчдэд хүргүүлнэ.

**9. Төлөөлөн удирдах зөвлөл**

9.1. Компанийн ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт түүний бүрэн эрхийг хэрэгжүүлэх, компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.

9.2. Компанийн ТУЗ нийт 9 гишүүнтэй байх бөгөөд Компанийн тухай хуулийн 75.4-д зааснаар тэдгээрийн 1/3-ээс доошгүй нь хараат бус гишүүн байна.

9.3. ТУЗ-ийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр хуралдаан байх бөгөөд хурлыг улиралд нэгээс доошгүй удаа хуралдуулна. Шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн 2-оос доошгүй гишүүн эсхүл гүйцэтгэх захирлын санаачилгаар ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж болно.

9.4. ТУЗ-ийн хуралд гишүүд биеэр, эчнээ санал хураалтаар эсхүл холбоо харилцааны бусад хэлбэрээр оролцож болох бөгөөд уг харилцааг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар нарийвчлан зохицуулна.

9.5. ТУЗ-ийн гишүүнийг хувьцаа эзэмшигчдийн хурлаас, санал хураах кумулятив аргыг хэрэглэн сонгох бөгөөд бүрэн эрхийн хугацаа 3 жил байна.

9.6. Энэхүү дүрмийн 10.4-д заасан санал хураах кумулятив аргыг хэрэглэхдээ Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон журмыг баримтлан ТУЗ-ийн гишүүдийг сонгоно.

9.7. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас компанийн аливаа хувьцаа эзэмшигч ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшиж болох бөгөөд ТУЗ-ийн гишүүнийг улируулан сонгож болно.

9.8. ТУЗ-ийн гишүүн удаан хугацаагаар үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, чөлөөлөх хүсэлтээ гаргасан, нас барсан, эсхүл томоохон хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон бол ТУЗ-ын гишүүнийг орлох этгээдийг дараагийн хувьцаа эзэмшигчдийн хурал хүртэл ТУЗ-өөс түр томилж болно. Энэ тохиолдолд Компанийн тухай хуулийн 77.6-д зааснаар томилогдсон гишүүн нь хараат бус гишүүний шаардлагыг хангасан этгээд байна.

9.9. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшуулал, бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох үндэслэл зэрэг ТУЗ-ийн үйл ажиллагаатай холбоотой бусад асуудлыг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар тогтооно.

9.10. ТУЗ нь Компанийн тухай хууль, энэхүү дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулснаас бусад асуудал буюу дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.10.1. Гүйцэтгэх захирлын эрх хэмжээг тогтоох, түүнийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах;

9.10.2. Гүйцэтгэх захирлыг сонгох, түүний бүрэн эрхийг тогтоох, бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;

9.10.3. компанийн хөндлөнгийн аудиторыг сонгох, түүнтэй гэрээ байгуулах;

9.10.4. ногдол ашиг тараах тухай шийдвэр гаргах, компанийн ногдол ашгийн бодлогыг батлах;

9.10.5. гүйцэтгэх удирдлагын дотоод бүтэц, зохион байгуулалтыг батлах;

9.10.6. компани хараат болон охин компани, салбар, төлөөлөгчийн газрыг байгуулах, тэдгээрийн удирдлагыг томилох;

9.10.7. компанийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу тогтоох;

ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК ERDENES SOLUTIONS 9020080899 2015



УЛААНБААТАР ХОТ ГҮҮДСЕК ҮЦК ХХК ТТБ6674 5208173

9.10.8. компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох;

9.10.9. компанийн үйл ажиллагаатай холбоотой нарийвчилсан дүрэм, журмыг баталж, гүйцэтгэлд нь хяналт тавих;

9.10.10. хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах

9.10.11. хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахтай холбоотой бусад асуудлыг шийдвэрлэх;

9.10.12. компанийн зарласан хувьцааны төрөл болон тоонд багтаан зарласан хувьцаанаас гүйлгээнд гаргах;

9.10.13. өөрийн гаргасан хувьцаагаа худалдан авах буюу эргүүлэн авах шийдвэр гаргах;

9.10.14. компанийн тухай хуульд заасан журмыг баримтлан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй гэрээ байгуулах зөвшөөрөл олгох;

9.10.15. компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах;

9,10.16. ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмуудыг батлах;

9.10.17. компанийг өөрчлөн байгуулах талаар төсөл боловсруулан хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулах;

9.10.18. гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийн гишүүдийн саналаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудлууд.

9.11. ТУЗ-ийн хуралд нийт гишүүний 2\3 нь оролцсоноор хүчин төгөлдөр болж, хуралд оролцсон саналын эрхтэй гишүүдийн дийлэнх олонхын саналаар хурлын шийдвэр хүчин төгөлдөр болно.

9.12. ТУЗ-ийн хуралд аливаа асуудлыг шийдвэрлэхэд гишүүн бүр саналын нэг эрхтэй байна.

9.13. Тухайн шийдвэрлэж буй асуудлаар ТУЗ-ийн зарим гишүүд Компанийн тухай хуульд заасны дагуу санал өгөх эрхгүй бол шийдвэрийг саналын эрхтэй гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэнэ.

9.14. ТУЗ-ийн гишүүн нь саналын эрхээ бусад гишүүд болон гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

9.15. ТУЗ эчнээ санал хураалтаар шийдвэр гаргаж болно. ТУЗ-ийн хурлын шийдвэр тогтоол хэлбэртэй байх бөгөөд үүнд ТУЗ-ийн дарга гарын үсэг зурсан байна.

9.16. ТУЗ-ийн гишүүдийн тоо нь тогтоосон нийт гишүүдийн тооноос 2 дахин бага болсон тохиолдолд компани нь 3 сарын дотор ТУЗ-ийн гишүүдийг сонгохоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулна.

9.17. Компанийн ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг үр өгөөжтэй, байнгын, мэргэшсэн байдлаар үйл ажиллагааг явуулах зорилготой Нэр дэвшүүлэх хороо, Аудитын хороо болон Цалин урамшууллын хороотой байна. Эдгээр хороодын гишүүд нь ТУЗ-ийн гишүүдээс бүрдэх бөгөөд тухайн хорооны нийт гишүүний 2/3-оос доошгүй нь хараат бус гишүүн байна.

**10. Аудитын хороо**

10.1. ТУЗ-ийн аудитын хорооны дарга нь хараат бус гишүүн байх бөгөөд санхүү, бүртгэл, эрсдэлийн удирдлагын чиглэлээр мэргэшсэн байна.

10.2. ТУЗ-ийн аудитын хороо нь Компанийн тухай хуульд зааснаас гадна дараах чиг үүрэгтэй байна:

10.2.1. компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;

10.2.2. компанийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байгаа эсэх, хууль болон эрх бүхий байгууллагаас тогтоосон мэдээллийг нийтийн хүртээл болгож байгаа байдалд хяналт тавих;
10.2.3. дотоод хяналтын албаны удирдлага, ажилтныг томилох, цалин урамшууллын талаарх гүйцэтгэх удирдлагын саналыг хянах, ТУЗ-д танилцуулах;
10.2.4. хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох, түүний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах, Хорооны чиг үүрэгт хамаарах асуудлаар шалгалт хийж дүгнэлт гаргах талаар хөндлөнгийн аудитын байгууллагад чиглэл өгөх /чухам ямар чиглэлээр шалгалт хийж, дүгнэлт гаргасан байх талаар аудитын байгууллагатай байгуулах гэрээнд тусгах замаар энэ эрхээ хэрэгжүүлнэ/;
10.2.5. их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих;
10.2.6. ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад асуудал.

**11. Нэр дэвшүүлэх хороо**

11.1. ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хороо нь Компанийн тухай хуульд зааснаас гадна дараах чиг үүрэгтэй:
11.1.1. ТУЗ-ийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох;
11.1.2. ТУЗ-ийн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигч нь ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлага, хараат бус гишүүний хувьд заасан шалгуурыг хангаж байгаа эсэх талаар дүгнэлт гаргах;
11.1.3. ТУЗ-д нэр дэвшигчийг сонгон шалгаруулж, хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлэх /саналын хуудсанд шууд нэрийг нь оруулах/;
11.1.4. ТУЗ-ийн болон гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;
11.1.5. гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөлийг тодорхойлох;
11.1.6. ТУЗ-ийн гишүүдээс бусад эрх бүхий албан тушаалтны ажил үүргийн гүйцэтгэлд гүйцэтгэх захирлаас өгсөн үнэлгээнд дүгнэлт гаргах;
11.1.7. ТУЗ-д нэр дэвшсэн аливаа этгээдийн нэрийг саналын хуудсанд оруулах эсэх тухай асуудлыг хэлэлцэхдээ тухайн этгээд нь дараах нөхцөл байдлыг хянах үүрэгтэй;
11.1.7.1. Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан ТУЗ-ийн гишүүнд тавигдах ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлагын талаарх шаардлагыг хангаж байгаа эсэх;
11.1.7.2. жил бүрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа хуралдуулаагүй, эсхүл зохих журмын дагуу хуралдуулаагүйгээс бүрэн эрх нь дуусгавар болсон ТУЗ-д ажиллаж байсан эсэх;
11.1.7.3. ТУЗ-ийн гишүүнээр дахин нэр дэвшүүлж байгаа бол ТУЗ-ийн гишүүний хувьд үүргээ зохих ёсоор хэрэгжүүлсэн эсэх;
11.1.7.4. компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан эсэх.

**12. Цалин урамшууллын хороо**

12.1. Цалин урамшууллын хороо нь Компанийн тухай хуульд зааснаас гадна дараах чиг үүрэгтэй:
12.1.1. эрх бүхий албан тушаалтны цалин урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;
12.1.2. эрх бүхий албан тушаалтанд олгох цалин урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин урамшуулал олгох санал боловсруулах;
12.1.3. компанийн цалин урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх.

**13. ТУЗ-ийн дарга болон ТУЗ-ийн нарийн бичгийн дарга**

13.1. ТУЗ-ийн даргыг ТУЗ-ийн гишүүдийн дотроос тэдгээрийн олонхын саналаар сонгоно.

13.2. ТУЗ-ийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, хяналт тавих, ТУЗ-ийн тогтоолд гарын үсэг зурах үүргийг гүйцэтгэнэ.

13.3. ТУЗ-өөс зөвшөөрч, эрх олгосон асуудлаар ТУЗ-ийн дарга нь тушаал гаргаж болно.

13.4. ТУЗ-ийн даргыг түр эзгүйд түүний үүргийг ТУЗ-ийн даргын томилсон, эсхүл ТУЗ-ийн шийдвэрлэсэн аль нэг гишүүн гүйцэтгэнэ.

13.5. хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бэлтгэлийг энэ дүрэмд заасны дагуу хангаж байгаа эсэхэд хяналт тавих, жил бүрийн 3 дугаар сарын 15-ны өдрийн дотор хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн шийдвэрийг гаргасан байх асуудлыг ТУЗ-ийн дарга хариуцна.

13.6. ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар ТУЗ-ийн даргын санал болгосон этгээдийг ТУЗ томилно.

13.7. ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар ажиллах этгээд нь компанийн засаглалын асуудлаар сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан этгээд байх бөгөөд түүний эзгүйд орлох этгээдийг ТУЗ-ийн дарга томилно.

13.8. ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үйл ажиллагаатай холбоотой асуудлыг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар тогтооно.

## 14. Гүйцэтгэх удирдлага

14.1. Гүйцэтгэх удирдлага нь энэхүү дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан хөлсөөр ажиллах гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, ажлаа ТУЗ-д тайлагнана.

14.2. Компанийн гүйцэтгэх удирдлагыг хувь хүн хэрэгжүүлэх бөгөөд уг этгээд компанийн Гүйцэтгэх захирал байна.

14.3. Компанийн Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн дарга байж болохгүй бөгөөд харин ТУЗ-ийн гишүүн байж болно.

14.4. Гүйцэтгэх захирал нь өөр компанийн удирдлагад давхар ажиллахыг хориглоно.

14.5. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-тэй байгуулсан хөлсөөр ажиллах гэрээний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна. Энэхүү гэрээнд Гүйцэтгэх захирлын эрх, үүрэг, хариуцлагын хэмжээ, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, цалин, шагнал, урамшуулал зэрэг асуудлыг тусгасан байна.

14.6. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.

14.7. Гүйцэтгэх захирал нь эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал гаргаж, биелэлтийг нь хангуулах эрхтэй.

## 15. Компанийн эрх бүхий албан тушаалтан

15.1. Компанийн ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн, ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.

15.2. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах чиг үүрэгтэй байна:

15.2.1. хууль болон компанийн дүрэм, журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, эрх мэдлээ хэрэгжүүлэх;

15.2.2. үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх;

СЗХ 2022 .05 .25 БҮРТГЭВ

MONGOLIAN STOCK EXCHANGE 2022 -03- 22 БҮРТГЭВ-03

15.2.3. компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах;

15.2.4. шийдвэр гаргахдаа сонирхлын зөрчлөөс зайлсхийж сонирхлын зөрчил үүсэхээр бол энэ тухайгаа тухай бүр мэдэгдэх;

15.2.5. өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хөндлөнгийн этгээдээс бэлэг, урамшуулал авахгүй байх;

15.2.6. компанийн нууцад хамаарах мэдээллийг бусдад задруулах, хувийн сонирхлын зорилгоор ашиглахгүй байх.

15.2.7. Компанийн ТУЗ-өөс тогтоосон бусад үүрэг.

15.3. Компанийн эрх бүхий албан тушаалтан албан тушаалаасаа өөрчлөгдсөнөөс хойш гурван жилийн туршид энэ дүрмийн 16.2.6-д заасан үүргийг хүлээнэ.

15.4. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь энэхүү дүрмийн 16.2, 16.3-д заасан үүргээ биелүүлээгүй, удаа дараа зөрчсөнөөс компанид хохирол учруулсан бол учруулсан хохирлыг Компанийн тухай хуульд заасны дагуу өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө.

## ТАВДУГААР БҮЛЭГ
## КОМПАНИЙН ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

### 16. Компанийн дотоод хяналт

16.1. Компанийн дотоод хяналтыг ТУЗ болон түүнээс томилсон эрх бүхий этгээд гүйцэтгэнэ.

16.2. Энэ дүрмийн 17.1-д заасан хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг ТУЗ-өөс баталсан журмын дагуу зохицуулна.

16.3. Компани нь аудитортай байна.

### 17. Компанийн хөндлөнгийн хяналт

17.1. Компани нь хөндлөнгийн хяналтын зарчмыг үйл ажиллагаандаа баримтлах, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжид заасан шаардлагыг тогтмол хангаж ажиллах бөгөөд санхүүгийн тайланг шалгуулж баталгаажуулан, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор хөндлөнгийн аудитын байгууллагатай гэрээ байгуулан томилж ажиллуулна.

17.2. Компанийн ТУЗ нь компанийн аудиторыг сонгож, түүнтэй гэрээ байгуулна. Аудиторын шалгалт нь ээлжит болон ээлжит бус байна.

17.3. Компанийн санхүүгийн жилийн тайланг баталгаажуулах зорилгоор ээлжит шалгалтыг хийнэ. Харин ээлжит бус шалгалтыг ТУЗ болон ТУЗ-ийн хараат бус гишүүн, эсхүл нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшигч хувьцаа эзэмшигчийн шаардлагаар хэдийд ч хийж болно.

17.4. Аудиторын шалгалтын явцад эрх бүхий албан тушаалтан компанид хохирол учруулсан нь тогтоогдвол шалгалтын хөлсийг буруутай этгээд төлөх ба бусад тохиолдолд компани өөрөө буюу шаардлага тавьсан талууд хариуцна.

17.5. Дараах этгээдийг компанийн аудитораар сонгон ажиллуулахыг хориглоно.

17.5.1. компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, компанийн эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээд, компанийн буюу нэгдмэл сонирхолтой компанийн хөлсний ажилтан, эрх бүхий албан тушаалтан бол;

ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК ERDENES SOLUTIONS Joint Stock Company



УЛААНБААТАР ХОТ ГҮЙДСЕК ҮЦК ХХК ТТБ8674 ... 5208173

17.5.2. компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн гаргасан үнэт цаас, эсхүл компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдэд холбогдох бусад эд хөрөнгө буюу эд хөрөнгийн эрх эзэмшдэг бол;

17.5.3. аудитын үйлчилгээ үзүүлэхээс бусад асуудлаар компанитай хэлцэл хийсэн этгээд бол.

17.6. Энэ Дүрмийн 18.5-т заасныг зөрчиж аудиторыг сонгосон бол түүний аудитын дүгнэлтийг хүчингүйд тооцно.

17.7. Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтын дүнг үндэслэн аудитор нь дараах мэдээллийг агуулсан дүгнэлт гаргана:

17.7.1. компанийн санхүүгийн тайлангийн үзүүлэлт үнэн зөв эсэх;

17.7.2. нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлан гаргалт зохих журмын дагуу хийгдсэн эсэх, зөрчил илэрвэл уг зөрчлийг тохиолдол тус бүрээр тодорхойлох;

17.7.3. шалгалтын хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн жагсаалт, уг хэлцлийг энэ хуульд заасан журмын дагуу хийсэн эсэх тухай тодорхойлолт;

17.7.4. аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээгээр тодорхойлсон бусад мэдээллүүд.

## ЗУРГААДУГААР БҮЛЭГ
## БУСАД ЗҮЙЛ

### 18. Компанийн санхүүгийн үйл ажиллагаа

18.1. Компанийн санхүүгийн жил 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, тухайн жилийн 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно.

18.2. Компани хуулиар тогтоосон журмын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн санхүүгийн тайлан гаргаж хувьцаа эзэмшигч болон эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.

18.3. Компанийн нягтлан бодох бүртгэл хөтлөлт болон санхүүгийн тайлангийн үнэн зөвийг компанийн гүйцэтгэх захирал бүрэн хариуцна.

18.4. Компанийн ТУЗ нь санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулна.

### 19. Их хэмжээний хэлцэл

19.1. Их хэмжээний хэлцэлд дараах хэлцлийг тооцно:

19.1.1. хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл /компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй/;

19.1.2. компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалт.

19.2. Их хэмжээний хэлцлийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг ТУЗ тогтооно.

19.3. Их хэмжээний хэлцэл мөн эсэхийг тодорхойлохдоо ТУЗ нь аудиторын зөвлөмжийн дагуу эд хөрөнгийн балансын үнийг мөнгөний ханшны уналтын түвшинтэй зохицуулан шинэчилж дахин тогтоож болно.

19.4. Их хэмжээний хэлцэл хийх шийдвэрийг ТУЗ-ийн хуралд оролцсон гишүүд санал нэгтэйгээр гаргана.

**20. Сонирхлын зөрчилтэй хэлцэл**

20.1. Компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшиж байгаа компанитай дор дурдсан харилцаанд орсон бол компанитай, эсхүл түүний хараат болон охин компанитай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тооцогдоно:

20.1.1. хэлцлийн нөгөө тал, эсхүл хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа;

20.1.2. хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл уг хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл энгийн хувьцааны /ногдол хувийн/ 20-оос дээш хувийг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;

20.1.3. хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн толгой компанийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл уг компанийн энгийн хувьцааны /ногдол хувийн/ 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;

20.1.4. хэлцлийн үр дүнд шууд буюу шууд бусаар үүсэх орлогоос хувь хүртэж байгаа.

20.2. Дор дурдсан этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтан болон хувьцааны хяналтын багц эзэмшигчтэй нэгдмэл сонирхолтой этгээд гэж үзнэ:

20.2.1. тэдгээрийн эхнэр, нөхөр, тэдэнтэй хамт амьдарч байгаа гэр бүлийн бусад гишүүн;

20.2.2. тэдгээрийн эцэг, эх, хүүхэд, ач, зээ болон ах, эгч, дүү;

20.2.3. тэдгээр нь өөрсдийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшдэг компанитай хийгдэж байгаа хэлцлийн үр дүнгээс шууд болон шууд бусаар үүсэх орлогоос хувь хүртэж байгаа тохиолдолд уг гэрээнд оролцогч талууд.

20.3. Компани тухайн тайлангийн хугацаанд хийсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн тоо, хэлцэл хийсэн этгээд, хэлцлийн үнийн талаарх мэдээллийг жилийн тайландаа тусган хувьцаа эзэмшигч болон нийтэд мэдээлэх үүрэгтэй.

20.4. сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай шийдвэрийг уг хэлцлийг хийх талаар сонирхлын зөрчилгүй ТУЗ-ийн гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

**21. Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах**

21.1. Компанийг өөрчлөн байгуулах асуудлыг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

21.2. Компанийг дараах тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр татан буулгана:

21.2.1. компанийн үйл ажиллагаа алдагдалтай байгаагаас цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон;

21.2.2. компанийг татан буулгах талаар ТУЗ-ийн хурлаас дүгнэлт гаргаж, үүнийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэсэн;

21.2.3. Компанийн тухай хуульд заасан үндэслэлээр;

21.2.4. Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу;

21.2.5. хуульд заасан бусад үндэслэл.

**22. Компанийн дүрэм хүчин төгөлдөр болох**

22.1. Энэхүү дүрэм нь компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлагдаж, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

22.2. Энэхүү дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэх бөгөөд ийнхүү шийдвэрлэсэн нэмэлт, өөрчлөлт нь энэ дүрмийн 23.1-д заасан байгууллагад бүртгүүлсэн өдрөөс эхлэн энэхүү Дүрмийн нэгэн адил хүчинтэй байна.

--ooOoo--

PKF

Accountants &
business advisers

# "ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС " ХК

(Монгол улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж)

Аудитлагдсан санхүүгийн тайлан
2021 оны 12 дугаар сарын 31

Улаанбаатар 2022

ONGOLIAN STOCK EXCHA
2022 -03- 22
БҮРТГЭВ-03

PKF
Accountants &
business advisers

**"ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС " ХК**

**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31 -НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛ**

| АГУУЛГА | ХУУДАС |
|---|---|
| КОМПАНИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ | 1 |
| ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА БА ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ | 2 |
| ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН | 3 – 4 |
| АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН | 5 |
| САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН | 6 |
| ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН | 7 |
| МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН | 8 |
| САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД | 9 – 33 |

ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company

УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК
ТТ58674 ... 5208173

ONGOLIAN STOCK EXCHA
2022 -03- 22
БҮРТГЭВ-03

**"ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС " ХК**

**КОМПАНИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

---

| | |
|---|---|
| АЛБАН ХАЯГ | 10-р давхар, Бакула ринбучийн гудамж 30 байр, Чингэлтэй дүүргийн 2 дугаар хороо, 40 50 мянгат /15171/, Улаанбаатар хот, Монгол улс. |
| ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ | Хувьцаа эзэмшигчид (241) |
| АУДИТОРУУД | Пи Кэй Эф Монголиа Аудит ХК<br>Мэргэшсэн нягтлан бодогчид |



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Stock Company
9020080609 2015358
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК
ТТБ8674 5208173

**"ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС " ХК**

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ БА ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ**

"ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС " ХК -ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Дарга Т.Золбоо Гүйцэтгэх Захирал Ц.Хүдэрмөнх, нягтлан бодогч бид, энэхүү тайлангийн 5-33 дугаар хуудсанд тусгагдсан Компанийн санхүүгийн тайлангууд нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын зөвлөл (СТОУСЗ)-өөс гаргасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу үнэн зөв, бодитойгоор илэрхийлсэн гэдгийг үүгээр мэдэгдэж байна.

"ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС " ХК –ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайланг нийтэд толилуулахыг зөвшөөрч батлав.

Ц.Хүдэрмөнх
Гүйцэтгэх Захирал

Нягтлан бодогч

Улаанбаатар хот, Монгол Улс

Огноо: 2022 оны 1 дүгээр сарын 13 өдөр

ОН 2022 САР 05 ӨДӨР 25
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -03- 22
БҮРТГЭВ-03

PKF
Accountants & business advisers

ПИ КЭЙ ЭФ МОНГОЛИА АУДИТ ХХК

Даун Таун Бьюлдинг, #602 тоот,
Жамъяан гүний гудамж -18/1,
1 -р хороо, Сүхбаатар дүүрэг-14240,
Улаанбаатар хот, Монгол улс

Утас: +976-75057979
Факс: +976-70186131

Имэйл: info@pkf.mn

Ref:03/ES/03/12272021/EN

**ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН**

**"ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС " ХК -ийн хувь нийлүүлэгчдэд**

**Дүгнэлт**

Бид "ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС " ХК –ийн 2021 оны 12 дугаар сарын 31 –ний өдрөөрх Санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр тасалбар болгосон жилийн Орлогын дэлгэрэнгүй тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тодруулга болон Нягтлан бодох бүртгэлийн бодлогуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, тус компанийн Санхүүгийн тайлангууд нь компанийн 2021 оны 12 дугаар сарын 31 –ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болгосон жилийн санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт /СТОУС/ -ын дагуу үнэн зөв, бодитойгоор илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт /АОУС/ -ын дагуу гүйцэтгэлээ. Энэ стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт тайлбарласан. Бид Монгол улсад мөрдөгддөг санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бус бөгөөд эдгээр шаардлагуудын дагуу тавигддаг ёс зүйн бусад хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж найдаж байна.

**Санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын болон засаглал хариуцсан этгээдүүдийн үүрэг**

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэж, толилуулах нь компанийн удирдлагын үүрэг болно. Энэхүү үүрэг хариуцлагад залилан болон алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд шаардлагатай дотоод хяналтыг тогтоох үүрэг орно.

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ удирдлага нь компанийг татан буулгах, түүний үйл ажиллагааг зогсоохоор төлөвлөж байгаа эсвэл эдгээрийг хийхээс өөр боломжит арга зам байхгүй байгаагаас бусад үед компани нь үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэх чадвар, илчлэл, шаардлагатай бол энэхүү тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг хэрэглэхтэй холбоотой асуудлуудыг үнэлэх үүрэгтэй.

Засаглал хариуцсан этгээдүүд компанийн санхүүгийн тайлагналын үйл явцыг хянах үүрэгтэй.

**Санхүүгийн тайлангуудын аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага**

Бидний зорилго бол санхүүгийн тайлангууд бүхэлдээ аливаа залилан эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг хэмжээний буруу илэрхийлэлгүй эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах болон бидний дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан бэлтгэх юм.



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company
2020080699



УЛААНБААТАР ХОТ
ТҮҮДСЕК ХХК
ТТБ8674 5208173

ОН 2022 05 12 БҮРТГЭВ №

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2022 ... БҮРТГЭВ-03

**ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)**

**"ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС " ХК-ийн хувь нийлүүлэгчдэд**

**Санхүүгийн тайлангуудын аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага (үргэлжлэл)**

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч Аудитын Олон Улсын Стандартын дагуу гүйцэтгэдсэн аудитаар оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгаа өгдөггүй. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас гарах бөгөөд хэрэв тэдгээр нь дангаараа болон нийлбэр дүнгээрээ санхүүгийн тайлангуудад үндэслэн хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт мэдэгдэхүйц нөлөөлөх бол материаллаг гэж үзнэ.

АОУС - ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох нэгтгэсэн санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэнд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоо тооцоолллууд, холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа нэгтгэсэн санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэвч ирээдүйн үйл явдал, нөхцөл байдал компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Компанийн санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг засаглал хариуцсан этгээдүүдэд мэдэгддэг.

**Бусад зүйл**

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Компанийн хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн, Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

П.БАЯРМАА
Гүйцэтгэх захирал

ПИ КЭЙ ЭФ МОНГОЛИА АУДИТ ХК
Мэргэшсэн нягтлан бодогчид

Улаанбаатар хот, Монгол улс
Огноо: 2022 оны 1 дүгээр сарын 13 өдөр



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК ERDENES SOLUTIONS Joint Stock Company

УЛААНБААТАР ХОТ ... ХХК ТТБ0674 ... 5203173

СЭХ 2022.05.25 БҮРТГЭВ №01
MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-03-22 БҮРТГЭВ-03

**"ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС " ХК**

**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ**
**АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН**

*(төгрөгөөр)*

| ҮЗҮҮЛЭЛТ | СТТ | 2020 | 2021 |
|---|---|---|---|
| БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО (ЦЭВЭР) | 18 | 21,262,623.71 | 869,800,000.00 |
| Борлуулалтын өртөг | | - | - |
| НИЙТ АШИГ (АЛДАГДАЛ) | | 21,262,623.71 | 869,800,000.00 |
| Хүүний орлого | 19 | - | 70,255.86 |
| Бусад орлого | 19 | - | 2,000,000.00 |
| | | - | **2,070,255.86** |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 20 | 168,644,516.88 | 74,772,958.59 |
| Санхүүгийн зардал | 21 | - | 21,035,326.92 |
| Бусад зардал | 21 | - | 790,000.00 |
| | | **168,644,516.88** | **96,598,285.51** |
| Гадаад валютын ханшийн зөрүүний бодит олз (гарз) | 22 | - | (83,726.33) |
| Гадаад валютын ханшийн зөрүүний бодит бус олз (гарз) | 22 | - | (19.10) |
| | | - | **(83,745.43)** |
| ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ (АЛДАГДАЛ) | | (147,381,893.17) | 775,188,224.92 |
| Орлогын татварын зардал | 23 | - | 77,597,824.40 |
| ТАТВАРЫН ДАРААХЬ АШИГ (АЛДАГДАЛ) | | (147,381,893.17) | 697,590,400.52 |
| Зогсоосон үйл ажиллагааны татварын дараахь ашиг (алдагдал) | | | |
| ТАЙЛАНТ ҮЕИЙН ЦЭВЭР АШИГ (АЛДАГДАЛ) | | (147,381,893.17) | 697,590,400.52 |
| БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГО | | - | - |
| ОРЛОГЫН НИЙТ ДҮН | | (147,381,893.17) | 697,590,400.52 |

*Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.*



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК ERDENES SOLUTIONS Joint Stock Company 20080899
УЛААНБААТАР ХОТ ГҮҮДСЕК ҮЦК ХК ТТ58674 5208173

"ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС " ХК

2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

(төгрөгөөр)

| ҮЗҮҮЛЭЛТ | СТТ | 2020/12/31 | 2021/12/31 |
|---|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | | |
| **Эргэлтийн хөрөнгө** | | | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 3 | 17,066,189.35 | 12,752,280.33 |
| Татвар, НДШ -ийн авлага | 4 | - | 928,840.46 |
| Бусад авлага | 5 | - | 260,000.00 |
| Бараа материал | 6 | 24,660,000.00 | 91,055,068.76 |
| Урьдчилж төлсөн зардал / тооцоо | 7 | 33,575,000.00 | 46,500,000.00 |
| **Эргэлтийн хөрөнгийн дүн** | | **75,301,189.35** | **151,496,189.55** |
| **Эргэлтийн бус хөрөнгө** | | | |
| Үндсэн хөрөнгө | 8 | - | 297,174,210.82 |
| Биет бус хөрөнгө | 9 | 1,528,455,912.09 | 1,528,455,912.09 |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | 10 | 20,060,000.00 | 890,054,745.50 |
| **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | | **1,548,515,912.09** | **2,715,684,868.41** |
| НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | | 1,623,817,101.44 | 2,867,181,057.96 |
| **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | | | |
| **ӨР ТӨЛБӨР** | | | |
| **Богино хугацаат өр төлбөр** | | | |
| Дансны өглөг | 11 | 30,032,388.20 | 159,854,197.16 |
| Цалингийн өглөг | 12 | 21,959,750.00 | - |
| Татвар, НДШ -ийн өр | 13 | 6,413,241.81 | 97,813,934.85 |
| Урьдчилж орсон орлого | 14 | - | 30,000,000.00 |
| Бусад богино хугацаат өр төлбөр | 15 | 148,427,000.00 | 464,937,804.00 |
| **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | | **206,832,380.01** | **752,605,936.01** |
| **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | | - | - |
| **ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН** | | **206,832,380.01** | **752,605,936.01** |
| **ЭЗДИЙН ӨМЧ** | | | |
| Хувийн өмч | 16 | 1,578,745,700.00 | 1,578,745,700.00 |
| Хуримтлагдсан ашиг | 17 | (161,760,978.57) | 535,829,421.95 |
| **ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | | **1,416,984,721.43** | **2,114,575,121.95** |
| ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН | | 1,623,817,101.44 | 2,867,181,057.96 |

*Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно*

- 6 -

ONGOLIAN STOCK EXCHA
2022 -03- 22
БҮРТГЭВ-03

"ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС " ХК

2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ
ЭЗДИЙН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

*(төгрөгөөр)*

| ҮЗҮҮЛЭЛТ | Өмч | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|
| 2019/12/31 –ний үлдэгдэл | 1,578,745,700.00 | (14,379,085.40) | 1,564,366,614.60 |
| НББүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | |
| **Залруулсан үлдэгдэл** | **1,578,745,700.00** | **(14,379,085.40)** | **1,564,366,614.60** |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | (147,381,893.17) | (147,381,893.17) |
| 2020/12/31 –ний үлдэгдэл | 1,578,745,700.00 | (161,760,978.57) | 1,416,984,721.43 |
| НББүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | |
| **Залруулсан үлдэгдэл** | **1,578,745,700.00** | **(161,760,978.57)** | **1,416,984,721.43** |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | 697,590,400.52 | 697,590,400.52 |
| 2021/12/31 –ний үлдэгдэл | 1,578,745,700.00 | 535,829,421.95 | 2,114,575,121.95 |

*Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.*



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company



УЛААНБААТАР ХОТ
ТТ58674 5208173

**“ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ” ХК**

**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

*(төгрөгөөр)*

| ҮЗҮҮЛЭЛТ | 2020 | 2021 |
|---|---|---|
| **Мөнгөн орлогын дүн (+)** | **19,160,000.00** | **899,800,000.00** |
| Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 19,160,000.00 | 899,800,000.00 |
| **Мөнгөн зарлагын дүн (-)** | **121,431,450.96** | **182,484,886.98** |
| Ажиллагсдад төлсөн | 21,234,690.00 | 62,069,022.50 |
| Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | | 2,000,000.00 |
| Бараа материал худалдан авахад төлсөн | 43,162,000.00 | 43,816,064.98 |
| Ашиглалтын зардалд төлсөн | 27,243,700.00 | 3,212,760.41 |
| Түлш, шатахуун, тээв.хөлс, сэл.хэр -д төлсөн | 27,763,772.06 | 271,000.00 |
| Хүүний төлбөрт төлсөн | | 21,035,326.92 |
| Татварын байгууллагад төлсөн | 2,027,288.90 | 1,050,000.00 |
| Бусад мөнгөн зарлага | | 49,030,712.17 |
| Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | (102,271,450.96) | (717,315,113.02) |
| **Мөнгөн орлогын дүн (+)** | **2,623.71** | **70,255.86** |
| Хүлээн авсан хүүний орлого | 2,623.71 | 70,255.86 |
| **Мөнгөн зарлагын дүн (-)** | **20,128,000.00** | **1,139,265,439.13** |
| Үндсэн хөрөнгө олж, эзэмшихэд төлсөн | | 269,270,693.63 |
| Биет бус хөрөнгө олж, эзэмшихэд төлсөн | 88,000.00 | |
| Хөрөнгө оруулалт олж, эзэмшихэд төлсөн | 20,040,000.00 | 869,994,745.50 |
| Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | (20,125,376.29) | (1,139,195,183.27) |
| **Мөнгөн орлогын дүн (+)** | **135,883,114.60** | **760,281,804.00** |
| Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 135,883,114.60 | 760,281,804.00 |
| **Мөнгөн зарлагын дүн (-)** | **30.00** | **342,715,642.77** |
| Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | | 342,799,388.20 |
| Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн | 30.00 | |
| Валютын ханшийн зөрүү | | (83,745.43) |
| Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 135,883,084.60 | 417,566,161.23 |
| **БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **13,486,257.35** | **(4,313,909.02)** |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 3,579,932.00 | 17,066,189.35 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 17,066,189.35 | 12,752,280.33 |

*Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.*

**"ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС" ХК**

**2021 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлан**
**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**

## 1. КОМПАНИЙН ТАЛААРХ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

"ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС" ХК нь (цаашид "Компани" гэх) 2007 оны 3 дугаар сарын 14-нд Монгол улсын Компанийн тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан ба Улсын бүртгэлд 2015358 тоот регистрийн дугаараар бүртгүүлсэн.

Компани нь нэг бүр нь 10 (Арав) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 157,874,570 (Нэг зуун тавин долоон сая найман зуун далан дөрвөн мянга таван зуун дал) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэх 1,578,745,700 (Нэг тэрбум таван зуун далан найман сая долоон зуун дөчин таван мянга долоон зуу) төгрөгийн дүрмийн сан ба 241 хувьцаа эзэмшигчтэй.

"ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС" ХК нь худалдааны зуучлал, программ хангамжийн үйл ажиллагаа, веб сайтаар онлайн худалдаа эрхлэх, мэдээллийн технологийн үйл ажиллагаа, программ хангамж тоног төхөөрөмжийн худалдаа, веб сайт хийх үйл ажиллагаа явуулдаг.

Компанийн үндсэн үйл ажиллагаа явуулдаг албан хаяг нь Улаанбаатар хот, Чингэлтэй дүүргийн 2 дугаар хороо, 40 50 мянгат /15171/ Бакула ринбучийн гудамж 30 байр, 10-р давхарт байрладаг.

Компанийн Гүйцэтгэх захирал Ц.Хүдэрмөнх ба нягтлан бодогч тэд Хан-Уул дүүргийн санхүү, татварын хэлтэстэй харилцдаг. Компани нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан бэлтгэхдээ " MS Excel" хэрэглээний программыг ашиглан гаргадаг. Санхүүгийн тайлан нь орлогын дэлгэрэнгүй тайлан, санхүүгийн байдлын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан гэсэн үндсэн дөрвөн тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулгаас бүрддэг.

## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО

### 2.1 ТАЙЛАН БЭЛТГЭХ ҮНДЭСЛЭЛ

**Нийцтэй байдлын мэдэгдэл**

Санхүүгийн тайлангууд нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс баталсан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС), Монгол улсад мөрдөгдөж буй Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хууль болон бусад хууль, тогтоомжийн дагуу түүхэн өртгийн зарчмаар бэлтгэсэн. Санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг тодруулгад өөрөөр зааснаас бусад тохиолдолд Монгол төгрөгөөр тайлагнасан.

**Хэмжилтийн суурь**

Санхүүгийн тайлангууд нь бодит үнэ цэнээр хэмжигдсэн үүсмэл санхүүгийн хэрэгслүүд, борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгүүд, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, үнэт металл, төлбөрийн системийн бүртгэлийн цахим программ хангамж болон цахим бүртгэлийн системийн мэдээлэл боловсруулах компьютер, серверийн тоног төхөөрөмжүүдээс бусад зүйлсийн хувьд нягтлан бодох бүртгэлийн түүхэн өртөгт суурилан бэлтгэгдсэн.

**Тасралтгүй үйл ажиллагаа**

Санхүүгийн тайлангууд нь тасралтгүй үйл ажиллагааны зарчимд суурилан бэлтгэгдсэн.

**Нягтлан бодох бүртгэлийн томоохон тооцоолол ба үнэлгээний хэрэглээ**

Санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэх нь удирдлагаас нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэглээ болон хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тайлагнасан дүнд нөлөөлөх үнэлгээ, таамаглал, тооцоолол хийхийг шаарддаг. Бодит үр дүн нь эдгээр тооцооллоос ялгаатай байж болно.

Үнэлгээ тооцоолол болон гол чухал таамаглалууд нь байнга шалгагдаж байдаг. Нягтлан бодох бүртгэлийн тооцоололд хийсэн өөрчлөлтийг тухайн өөрчлөлт хийгдсэн болон ирээдүйд нөлөөлөх тайлант үеүдэд нь хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн тайланд тусгагдсан тоон үзүүлэлтүүдэд материаллаг нөлөө үзүүлэхээр нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын хэрэглээ, тооцооллын эргэлзээтэй асуудал байхгүй болно.

**Санхүүгийн тайлангийн толилуулга**

Компани нь санхүүгийн байдлын тайлангийн зүйлсийг хөрвөх чадварынх нь дараалаар толилуулсан.

Зөвхөн хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг цэвэршүүлэх хуулиар олгогдсон эрхтэй, тооцоог цэвэр дүнгээр нь барагдуулах, эсвэл хөрөнгийг борлуулж өр төлбөрийг барагдуулах ажлыг нэгэн зэрэг хийхээр зэхэж байгаа л бол санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэршүүлэн, цэвэр дүнгээр санхүүгийн байдлын тайланд толилуулна. Нягтлан бодох бүртгэлийн аливаа нэг стандарт эсвэл тайлбараар шаардсан эсвэл зөвшөөрснөөс бусад тохиолдолд Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогод тусгайлан тодруулсанчлан орлого, зарлагыг ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд цэвэршүүлэн тайлагнаж болохгүй.

2022 -03- 22
БҮРТГЭВ-03

"ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС" ХК

2021 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлан
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

## 2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО БА ТОЛИЛУУЛГАД ОРСОН ӨӨРЧЛӨЛТҮҮД

2021 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон доорхи СТОУС-уудаас бусад хэрэгжүүлж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь өмнөх санхүүгийн жилийнхтэй адил юм. Тайлангийн хугацаанд шинээр хэрэгжиж эхэлсэн стандартууд болон бусад стандартын нэмэлт өөрчлөлтүүд:

| НББОУС болон СТОУС | Шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүдийн гол агуулга | Хэрэгжих огноо |
|---|---|---|
| **НББОУС 12 Орлогын Нэмэлт татвар**<br><br>"2015-2017 оны циклийн татвар жилийн сайжруулалт " -ын үр дүнд гарсан нэмэлт өөрчлөлт (2017 оны 12 дугаар сард гаргасан) | Нэмэлт өөрчлөлт нь ногдол ашгийн төлөлттэй холбоотой орлогын татварыг татвар хэрхэн ногдсоноос үл хамааран алдагдлын тайланд хүлээн зөвшөөрөхөөр заасан. /Орлогын албан татварын байнгын болон түр зөрүүг хэрхэн тодорхойлж, тайлагнах талаар СТОУС, Монгол улсын холбогдох журам хоорондын зөрүүтэй ойлголтоос шалтгаалан Банк уг стандартыг хэрэглээг хойшлуулсан/ | 2019 оны 1 дүгээр сарын 01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх |
| **НББОУС 23 Зээлийн зардал**<br><br>"2015-2017 оны циклийн жилийн сайжруулалт" – ын үр дүнд гарсан нэмэлт өөрчлөлт (2017 оны 12 дугаар сард гаргасан) | Хөрөнгө нь ашиглах эсвэл борлуулахад бэлэн болсны дараа зээл үлдсэн бол уг зээл нь ердийн зээлийн санхүүжилтийн нэг хэсэг болж хүүний зардлаар тооцогдоно. | 2019 оны 1 дүгээр сарын 01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх |
| **СТОУС 16 Түрээс**<br><br>(2016 оны 1 дүгээр сард гаргасан) | Дан түрээслэгчийн нягтлан бодох бүртгэлийн загварыг стандартад заасан. Түрээслэгч нь түрээсийн хугацаа 12 сар эсвэл түүнээс доош хугацаатай байх эсвэл хөрөнгө нь бага үнэтэйгээс бусад бүх тохиолдолд хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрно, Түрээслүүлэгч НББОУС 16-11 заасны дагуу үйл ажиллагааны эсвэл санхүүгийн түрээс гэж ангилах боломжтой хэвээр байна. | 2019 оны 1 дүгээр сарын 01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх |
| **НББОУС 19 "Ажилчдын тэтгэмж" – нд орсон нэмэлт өөрчлөлтүүд**<br><br>(2018 оны 2 дугаар сард гарсан нэмэлт өөрчлөлт) | Хэрэв төлөвлөгөөнд өөрчлөлт хасалт эсвэл төлөлт хийгдсэн бол үйлчилгээний өртөг болон дахин хэмжилт хийгдсэний дараах хугацааны цэвэр хүүг дахин хэмжилт хийхэд ашигласан таамаглалыг ашиглан тооцоолно. Түүнчлэн, хөрөнгийн дод хэмжээтэй холбоотой шаардлагад төлөвлөгөөнд орсон өөрчлөлт хасалт свал төлөлтийн үр нөлөөг харуулна . Банк ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн хөтөлбөр хэрэгжүүлдэггүй учир энэхүү өөрчлөлт хамаарахгүй. | 2019 оны 1 дүгээр сарын 01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх |



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company



УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК
ТТБ6674 5208173

2022 -03- 22
БҮРТГЭВ-03

**"ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС" ХК**

**2021 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлан**
**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**

| НББОУС болон СТОУС | Шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүдийн гол агуулга | Хэрэгжих огноо |
|---|---|---|
| **СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүр**<br><br>Санхүүгийн төлбөрт оруулсан өөрчлөлтийг тодруулах болон сөрөг нөхөн төлбөртэй холбоотой урьдчилан төлсөн төлбөрийн талаар юм өөрчлөлт (2017 оны 10 дугаар сард гаргасан) | Зээл авагч гэрээгээ цуцалсан тохиолдолд зээл өгөгчид хугацаанаас нь өмнө буцаан төлсний нөхөн төлбөр төлөх ба үүнийг сөрөг нөхөн төлбөр бүхий урьдчилж төлсөн төлбөр гэж ангилна. Бизнесийн загвараас шалтгаалан сөрөг нөхөн төлбөрийг хорогдуулсан өртөг эсвэл бодит үнэ цэнээр хэмжихийг зөвшөөрсөн.<br><br>Санхүүгийн өр төлбөрт өөрчлөлт орсон эсвэл солилцоо хийгдсэн өдрөөрх ашиг алдагдлын тайлан дахь өөрчлөлт эсвэл солилцоотой хобостой үүссэн санхүүгийн өр төлбөрийн хорогдуулсан өртөгт залруулга хийгдсэн бол түүнийг хүлээн зөвшөөрнө.<br><br>/Монголбанкнаас СТОУС 9 - ийн хэрэглээг 2021 оны дугээр сарын 01 - ний өдөр хүртэл хойшлуулсан Гэхдээ Банк энэхүү стандартыг нэвтрүүлэхээр мэргэжлийн байгууллагаас зөвлөх үйлчилгээ авсан/ | 2019 оны 1 дүгээр сарын 01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх |
| **Санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын хүрээ** | Санхүүгийн тайлагналын үзэл баримтлалуудыг дараах шинж чанаруудаар бүлэглэсэн байна<br><br>Бүлэг 1- Санхүүгийн тайлагналын зорилго<br>Бүлэг 2- Санхүүгийн мэдээллийн хэрэгцээтэй байдлын чанарын үзүүлэлтүүд<br>Бүлэг 3- Санхүүгийн тайлан болон тайлагнагч аж ахуйн нэгж<br>Бүлэг 4- Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд<br>Бүлэг 5- Хүлээн зөвшөөрөлт ба үл хүлээн зөвшөөрөлт<br>Бүлэг 6- Хэмжилт<br>Бүлэг 7- Толилуулга ба тодруулга<br>Бүлэг 8- Капиталын талаарх үзэл баримтлал ойлголт ба капитал засвар | 2019 оны 1 дүгээр сарын 01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх |
| **НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга,**<br><br>**НББОУС-8 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт ба алдаа** | Материаллаг байдлын талаарх тодорхойлолтыг нэг жил ойлголт болгохын тулд тухайлсан нэмэлт өөрчлөлтүүдийг баталсан.<br><br>Шинэ тодорхойлолтоор мэдээллийг орхигдуулсан, буруу тайлагнасан, гуйвуулсан бүрхэгдүүлсэн нь тухайн тайлагнагч аж ахуйн нэгжийн талаарх санхүүгийн мэдээллээр хангадаг нийтлэг зориулалттай санхүүгийн тайлангуудад үндэслэн шийдвэр гаргадаг гол хэрэглэгчдийн шийдвэр гаргалтад нөлөөлнө гэж үзэж байвал материаллаг гаж авч үзнэ. | 2021 оны 1 дүгээр сарын 01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх |



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company

УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК

СЭХ
2022.05.25
БҮРТГЭВ

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-03-22
БҮРТГЭВ-03

**"ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС" ХК**

**2021 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлан**
**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**

| НББОУС болон СТОУС | Шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүдийн гол агуулга | Хэрэгжих огноо |
|---|---|---|
| **СТОУС 3-т орсон нэмэлт өөрчлөлт:**<br><br>Бизнесийн тодорхойлолт | СТОУС 3 Бизнесийн нэгдэлд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр бизнес нь дор хаяж үйл ажиллагаа болон хөрөнгийн цогцдоо эцсийн бүтээгдэхүүнийг гаргах чадамжинд их хэмжээгээр нөлөөлж чадахуйц орц болон бодит үйл явцын нэгдлийг багтаасан байх ёстой. Цаашилбал, бизнес нь эцсийн бүтээгдэхүүнийг бий болгоход шаардагдах бүх орц болон процесстэйгээр оршин тогтнох шаардлагагүй болохыг тодруулсан болно. Нэмэлт өөрчлөлтүүд нь үйлчлүүлэгчдэд үзүүлж буй бараа, үйлчилгээ, хөрөнгө оруулалтын орлого эсвэл ердийн үйл ажиллагаанаас олох бусад орлогод чиглэсэн гарцын тодорхойлолтыг нарийсгаж өгсөн.<br><br>Цаашилбал, нэмэлт өөрчлөлтүүд нь олж авсан үйл явц нь бодитой эсэхийг үнэлэх удирдамжаар хангаж, худалдан авсан багц үйл ажиллагаа, хөрөнгө нь бизнес биш эсэхийг хялбаршуулсан үнэлгээ хийх боломжийг олгохын тулд нэмэлт үнэ цэнийн төвлөрөлийн туршилтыг нэвтрүүлнэ. Уг нэмэлт өөрчлөлт Банкны санхүүгийн тайланд нөлөөлөөгүй боловч Банк ирээдүйд аливаа бизнесийн нэгдэлд орох тохиолдолд нөлөөлж болзошгүй юм. | |
| **СТОУС 7, СТОУС 9 болон НББОУС 39-д орсон нэмэлт өөрчлөлтүүд:**<br><br>Жишиг хүүгийн түвшний шинэчлэл | СТОУС 9 ба НББОУС 39 нэмэлт өөрчлөлт, Санхүүгийн хэрэгсэл: Уг стандартын хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт хэсэг нь хүүгийн жишиг шинэчлэлд нөлөөлж буй бүх хеджийн хэрэгсэлд хэд хэдэн хөнгөлөлтийг үзүүлдэг. Хэрэв хүүгийн жишиг инэчлэл хеджийн зүйл эсвэл хеджийн хэрэгслийн жишигт суурилсан мөнгөн урсгалын цаг хугацаа ба/эсвэл хэмжээнд тодорхойгүй байдал үүсгэж байвал хеджийн хэрэгсэлд нөлөөлсөн гэж үзнэ. Банкинд хүүгийн хеджийн хэрэгсэл байхгүй тул эдгээр нэмэлт өөрчлөлт нь Банкны санхүүгийн тайланд нөлөөлөхгүй. | |
| **НББОУС 1, НББОУС 8-д орсон нэмэлт өөрчлөлт:**<br><br>Материаллаг байдлын тодорхойлолт | Нэмэлт өөрчлөлт нь "Материаллаг"-г шинэ тодорхойлолтыг: "Тайлагнагч байгууллагын санхүүгийн тайланд аливаа мэдээллийг орхигдуулах, эсвэл буруу ташаа, тодорхой бус байдлаар илэрхийлэх нь байгууллагын санхүүгийн тайлангийн үндсэн хэрэглэгчдийн уг тайланг үндэслэн гаргах шийдвэрт үндэслэлтэйгээр нөлөөлж болзошгүй тохиолдолд тухайн мэдээллийг материаллаг гэж үзнэ." гэжээ. Нэмэлт өөрчлөлтүүд нь "материаллаг"-г санхүүгийн тайлангийн агуулгаар, тухайн мэдээллийн шинж чанар ба/эсвэл хэмжээнээс хамаарна гэдгийг тодорхойлсон. Мэдээллийг буруу ташаа илэрхийлэх нь үндсэн хэрэглэгчидийн гаргах шийдвэрт үндэслэлтэйгээр нөлөөлөхүйц бол үүнийг материаллаг гэж үзнэ. Эдгээр нэмэлт, өөрчлөлт нь санхүүгийн тайланд нөлөөлөөгүй бөгөөд цаашид Банкинд нөлөөлөхгүй гэж үзэж байна. | |



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company



УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК
ТТБ8674 ☎ 5208173

**"ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС" ХК**

**2021 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлан**
**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**

| НББОУС болон СТОУС | Шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүдийн гол агуулга | Хэрэгжих огноо |
|---|---|---|
| **2018 оны 3 дугаар сарын 29-ний өдөр гаргасан**<br><br>Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал | Үзэл баримтлалын хүрээ нь стандарт биш бөгөөд үүнд агуулагдах ойлголтуудын аль нь ч ямар ч стандартын үзэл баримтлал, шаардлагыг үгүйсгэхгүй. Үзэл баримтлалын хүрээний зорилго нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл (НББОУСЗ)-д стандарт боловсруулахад туслах, холбогдох стандарт байхгүй тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн тууштай бодлого боловсруулахад туслах, бүх талуудад стандартыг ойлгож, тайлбарлахад туслах явдалд оршино. Энэ нь үзэл баримтлалын хүрээнд үндэслэн нягтлан бодох бүртгэлийн бодлогоо боловсруулсан аж ахуйн нэгжүүдэд нөлөөлнө. Шинэчилсэн үзэл баримтлалын хүрээнд зарим шинэ ойлголт, шинэчилсэн тодорхойлолт, хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх шалгуурыг багтаасан бөгөөд зарим чухал ойлголтыг тодруулсан болно. Эдгээр нэмэлт өөрчлөлт нь Банкны санхүүгийн тайланд нөлөөлөхгүй болно. | |
| **СТОУС 16-д орсон нэмэлт өөрчлөлт:**<br><br>Ковид-19-тэй холбоотой түрээсийн хөнгөлөлт | 2021 оны 5 дугаар сарын 28-нд НББОУСЗ нь Ковид-19-тэй холбоотой түрээсийн хөнгөлөлтийн тухай СТОУС 16 Түрээс-д нэмэлт, өөрчлөлт оруулсан. Нэмэлт өөрчлөлтүүд нь түрээслэгчдэд Ковид-19 цар тахлын шууд үр дагавраас үүдэлтэй түрээсийн хөнгөлөлтийг бүртгэх түрээсийн өөрчлөлтийн бүртгэлийн талаарх СТОУС 16-н заавраас хэрэгжүүлэхэд хөнгөлөлт үзүүлдэг. Энэхүү хөнгөлөлтийн зорилго нь түрээслэгч нь түрээслүүлэгчээс Ковид-19-тэй холбоотой авсан түрээсийн хөнгөлөлтийг түрээсийн өөрчлөлт мөн эсэхийг үнэлэхгүй байж болох сонголтыг оруулж өгсөн. Энэ сонголтыг хийсэн түрээслэгч нь Ковид-19-тэй холбоотой түрээсийн хөнгөлөлтийг СТОУС 16-д заасан түрээсийн өөрчлөлт гэж үзээгүй үед тооцсонтой адил аргаар тооцно. Энэхүү нэмэлт өөрчлөлт СТОУС 16-ын дагуу түрээслүүлэгчээс түрээслэх хөнгөлөлт нь Ковид-19 цар тахлаас үүдсэн эсвэл түрээсийн өөрчлөлтөд тооцоогүй болно гэсэн нь Банкны санхүүгийн тайланд мэдэгдэхүйц нөлөө үзүүлээгүй болно. | |

СТОУС-ын сайжруулалтын үр дүнд хийгдсэн нэмэлт стандартуудын өөрчлөлтүүд нь Компанийн санхүүгийн байдал эсвэл гүйцэтгэлд томоохон нөлөө үзүүлээгүй болно.

2022-05-25
MONGOLIAN STOCK EXCH
2022 -03- 22
БҮРТГЭВ-03

**"ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС" ХК**

**2021 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлан**
**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**

## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт)

#### 1) Валютын ханшийн тэгшитгэл

Компанийн санхүүгийн тайланг Компани болон толгой компанийн үйл ажиллагааны мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөгөөр илэрхийлнэ. Гадаад валютаарх ажил гүйлгээг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар үйл ажиллагааны мөнгөн тэмдэгт рүү хөрвүүлж бүртгэнэ.

Гадаад валютаар бүртгэгдсэн мөнгөн хөрөнгө, төлбөрүүдийг санхүүгийн байдлын тайлангийн өдрийн Монгол банкны зарласан албан ханшаар дахин хөрвүүлдэг. Мөнгөн зүйлсийн төлөгдсөн буюу хүлээн авсан эсвэл хөрвүүлснээс үүссэн бүх зөрүүг ашиг, алдагдлын тайланд бүртгэнэ.

Өөрийн өртөг нь гадаад валютаар хэмжигдэх мөнгөн бус зүйлсүүдийг анхны гүйлгээний өдрийн ханшаар хөрвүүлнэ. Бодит үнэ цэнэ нь гадаад валютаар хэмжигдэх мөнгөн бус зүйлүүдийг бодит үнэ тодорхойлогдсон өдрийн ханшаар хөрвүүлнэ. Бодит үнэ цэнээрээ хэмжигдэх мөнгөн бус зүйлсийг хөрвүүлснээс үүссэн олз, гарзыг тухайн зүйлийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн олз, гарзыг хүлээн зөвшөөрөхтэй адилаар авч үзнэ.

Төгрөгийн нэгж ам доллартай харьцах ханш 2021 оны 12 дугаар сарын 31 болон 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар харгалзан 2849.51 төгрөг болон 2733.52 төгрөг байв.

#### 2) Барилга, тоног төхөөрөмж

Барилга, тоног төхөөрөмжийг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрнө. Барилга, тоног төхөөрөмжийн өртөг нь худалдан авсан үнэ, импортын татвар, эргэн төлөгдөхүй худалдан авалтын татвар болон тухайн хөрөнгийг зориулалтын ажлын байршил, нөхцөлд бэлэн болгохтой холбогдсон бусад зардал зэргээс бүрдэнэ.

Хэрэв тухайн хөрөнгийн гол эд ангийн ашиглах хугацаа ялгаатай байгаа тохиолдолд тэдгээрийг салгаж тусад нь ангилдаг.

Барилга, тоног төхөөрөмжийг борлуулснаас үүссэн олз ба гарзыг борлуулж буй үнэ болон тухайн хөрөнгийн дансны үнэтэй харьцуулж тодорхойлдог бөгөөд цэвэр дүнгээр орлогын тайланд "бусад олз/гарз" -аар хүлээн зөвшөөрдөг.

Барилга, тоног төхөөрөмжийн эд ангийг дахин солих, орлуулахтай холбоотой өртгийг уг эд анги ирээдүйд эдийн засгийн үр өгөөж өгөх болон өртгийг найдвартай хэмжих боломжтой үед хөрөнгөөр хүлээн зөвшөөрнө.

Солигдсон эд ангийн дансны үнээр хөрөнгийн дансны үнийг бууруулна. Өдөр тутмын үйлчилгээний зардлыг тухайн зардалд гарсан тайлант үеийн орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрнө.



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company



УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК
ТТБ8674 № 5208173

"ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС" ХК

2021 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлан
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (үргэлжлэл)
(анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт)

**3) Үндсэн хөрөнгийн элэгдэл**

Элэгдлийг өмч, барилга, тоног төхөөрөмжийн ашиглагдах хугацаагаар нь шулуун шугамын аргаар байгуулж орлогын дэлгэрэнгүй тайланд тусгана. Өмч, барилга, тоног төхөөрөмжүүдийг ашиглахаар тогтоосон хугацаа нь дараах байдалтай байна.

- Барилга байгууламж — 25 жил
- Оффисын тавилга, тоног төхөөрөмж — 10 жил
- Компьютерийн дагалдах хэрэгсэл — 2 жил

Программ хангамжийг хүчинтэй хугацаанд нь элэгдүүлэлтийн арга, ашиглах хугацаа, үлдэх өртгийг тайлагнах үе бүрт дахин тооцож үзнэ.

**4) Түрээслсэн хөрөнгө**

Тухайлсан хөрөнгийг зөвшөөрсөн хугацаанд ашиглах эрхийг тодорхой төлбөртэйгээр шилжүүлэх хэлцэл гэж компани нь тодорхойлж байгаа тохиолдолд ажил гүйлгээ буюу бүлэг ажил гүйлгээнээс бүрдэх хэлцлийг түрээс гэж үздэг. Ийм тодорхойлолтыг хэлцлийн шинж байдлыг үнэлсний үндсэн дээр хийдэг бөгөөд энэ хэлцэл нь түрээсийн хууль зүйн хэлбэртэй эсэхээс үл хамаарна.

**Компанийн түрээслж буй хөрөнгийн ангилал**

- Хөрөнгийн өмчлөлтэй холбогдсон бүх эрсдэл болон урамшууллыг компанид бүрэн шилжүүлэх нөхцөлтэйгээр түрээсээр эзэмшиж буй хөрөнгө гэж ангилдаг.
- Хөрөнгийн өмчлөлтэй холбогдсон бүх эрсдэл болон урамшууллыг компанид бүрэн шилжүүлэх нөхцөлгүй түрээсийг үйл ажиллагааны түрээс гэж ангилдаг.

Хөрөнгийн өмчлөлтэй холбоотой холбогдсон бүх эрсдэл болон урамшууллыг компанид бүрэн шилжүүлэх үед үүсэх санхүүгийн түрээсийг түрээслсэн хөрөнгийн зах зээлийн бодит үнэ цэнээр эсвэл түрээсийн хамгийн бага төлбөрийн өнөөгийн үнэ цэнээр түрээс эхэлсэн үед нь хүлээн зөвшөөрдөг. Түрээсийн төлбөрүүд нь санхүүгийн зардал ба түрээсийн өглөгийн бууралтад хуваагдах бөгөөд өглөгийн эцсийн үлдэгдэлд тогтмол хүү тооцдог. Санхүүгийн зардлыг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрдөг.

Түрээслсэн хөрөнгийг нь хөрөнгийн ашиглалтын хугацааны турш элэгдүүлдэг. Түрээсийн хугацааны эцэст эзэмшил нь компанид шилжиж ирэх нь тодорхойгүй үед хөрөнгийг ашиглалтын хугацаа болон түрээсийн хугацааны аль богино хугацаагаар элэгдүүлдэг.

**Үйл ажиллагааны түрээс**

Компани нь үйл ажиллагааны түрээсийн дагуу эзэмших хөрөнгө ашиглаж буй тохиолдолд түрээсийн дагуу хийгдсэн төлбөрүүд нь түрээсийн хугацаанд хамрагдах тайлант үеүдэд тэнцүү хэмжээгээр орлого зардлаар тайлагнагддаг. Хүлээн авсан түрээсийн урамшууллыг түрээсийн цэвэр төлбөрийн нийт дүнгийн нэг хэсэг болгон орлого ба зардлаар хүлээн зөвшөөрдөг. Болзошгүй түрээсийг гаргасан тухайн тайлант хугацаанд нь орлого ба зардлаар хүлээн зөвшөөрдөг.

2022 .05. 25
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -03- 22
БҮРТГЭВ-03

**"ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС" ХК**

**2021 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлан**
**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**

## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (үргэлжлэл)
(анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт)

**5) Бараа материал**

Бараа материалыг өртөг, цэвэр боломжит үнийн аль багаар нь тусгана. Бараа материалын өртгийг жигнэсэн дундаж өртгийн аргаар тодорхойлох бөгөөд худалдан авалт, боловсруулалт, байршуулалт зэрэг тухайн байршил, нөхцөлд авчрах хүртэлх зардлыг өртөгт шингээнэ.

Бараа материалыг өртөг, цэвэр боломжит үнийн аль багаар нь үнэлнэ. Цэвэр боломжит үнийг бизнесийн хэвийн нөхцөл дэх тооцоолсон борлуулах үнээс түүнийг иж бүрдэл болгоход тооцсон зардал болон борлуулалтын зардлыг хасч тооцно.

**6) Худалдааны болон бусад авлага**

Бэлэн мөнгө хүлээн авах гэрээт эрх үүсэх буюу өөр нэг аж ахуйн нэгжээс санхүүгийн хөрөнгийг авах эрх үүссэн тохиолдолд худалдааны болон бусад авлагуудыг эхэндээ өртгөөр нь бүртгэдэг. Дараа үеүдэд худалдааны болон бусад авлага нь найдваргүй авлагын нөөцийг хассан цэвэр боломжит үнэ цэнээрээ тусгагддаг.

**7) Бэлэн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө**

Мөнгөн гүйлгээний тайланд заасанаар бэлэн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөд арилжааны банкуудад байршуулсан харилцах ба хугацаагүй эсвэл 3 сар хүртэлх анхны дуусгавар хугацаатай хадгаламжууд орно.

**8) Сангууд**

Компанид (а) өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн өнөөгийн үүрэг (хуулийн эсвэл ёс зүйн) байгаа (б) энэхүү үүргээ биелүүлэхэд эдийн засгийн өгөөж агуулсан баялгийг зарцуулах нь тодорхой болсон ба үүргийн дүнг бодитойгоор ойролцоолон тооцоолох боломжтой үед санг хүлээн зөвшөөрнө. Аливаа нэг сантай холбоотой зардлыг ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд аливаа нөхөн төлбөрийг хассан цэвэр дүнгээр нь толилуулна.

**9) Санхүүгийн хэрэглүүр**

**(i) Хүлээн зөвшөөрөх өдөр**

Бүх санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдийг анхлан хүлээн зөвшөөрөхдөө арилжаа хийсэн өдөр (Компани тухайн хэрэглүүрийн гэрээний нэг тал болсон өдөр) хүлээн зөвшөөрнө. Үүнд "хэвийн нөхцөлтэй арилжаа" буюу санхүүгийн хөрөнгө худалдан авах, худалдахад холбогдох хөрөнгийг зах зээлийн журам, хэлцлээр тогтоосон хугацаанд зайлшгүй шилжүүлэхийг шаарддаг арилжаа орно.



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company

УЛААНБААТАР ХОТ
ГҮЙДСЕК ҮНЭЛГЭЭ
ТТБ8674 5208173

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-03-22
БҮРТГЭВ-03



## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (үргэлжлэл)
(анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт)

**9) Санхүүгийн хэрэглүүр (үргэлжлэл)**

**(ii) Санхүүгийн хэрэглүүрүүдийн анхны хүлээн зөвшөөрөлт буюу анхлан бүртгэх**

Санхүүгийн хэрэглүүрийг анх бодит үнэ цэнээр буюу өгсөн (хөрөнгийн хувьд) эсвэл хүлээн авсан (өр төлбөрийн хувьд) төлбөрийн бодит үнэ цэнээр бүртгэнэ. Санхүүгийн хэрэглүүрийн анхдагч хэмжилтэд бодит үнэ цэнэ нь орлого, зардлын дансанд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрөөс бусад тохиолдолд ажил гүйлгээний өртгийг оруулна.

НББОУС 39 ангиллын дагуу Компанийн санхүүгийн хөрөнгө нь зөвхөн зээл болон авлага, харин санхүүгийн өр төлбөр нь зөвхөн баталгаажсан бонд болон зээлээр авсан санхүүжилтээс бүрдэнэ.

**(iii) Зээл ба авлага**

Компанийн зээл болон авлага нь зөвхөн орон сууцны зээлийн багцын авлагаас бүрдэнэ. Арилжааны банкуудаас худалдан авсан орон сууцны зээлийн багцын авлага нь идэвхитэй зах зээл дээр бүртгэлгүй, тогтмол эсвэл тодорхойлох боломжтой төлбөрүүдтэй дараахаас бусад үүсмэл бус санхүүгийн хөрөнгө юм:

- Компани нэн даруй эсвэл ойрын хугацаанд борлуулах хандлагатай байгаа ба Компани анх хүлээн зөвшөөрөхдөө "Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зардлын дансанд бүртгэгдэх" гэж ангилсан санхүүгийн хэрэглүүрүүд;
- Компани анх хүлээн зөвшөөрөхдөө "Борлуулахад бэлэн" гэж ангилсан санхүүгийн хэрэглүүрүүд;
- Компани зээлийн үнэ цэнийн бууралтын улмаас биш өөр бусад шалтгааны улмаас анх оруулсан хөрөнгөө нийт дүнгээр нь эргүүлэн олж авч чадахгүй болсон санхүүгийн хэрэглүүрүүд.

Анх хэмжсэний дараа худалдан авсан орон сууцны зээлийн хөрөнгийн авлагыг үр ашигт хүүний аргыг хэрэглэн хорогдуулсан өртгөөс үнэ цэнэ бууралтын санг хассан дүнгээр бүртгэнэ. Хорогдуулсан өртгийг үр ашигт хүүний салшгүй хэсэг болох худалдан авалтын урамшуулал, хөнгөлөлт болон шимтгэлийг оролцуулан тооцно. Хорогдуулалт нь орлогын тайлангийн "Хүүний орлого"-д багтана. Уг хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтаас үүссэн алдагдлыг ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

**Зээл ба зээлээр авсан эх үүсвэр**

Компанийн зээл болон зээлээр авсан эх үүсвэр нь Компанийн гаргасан, хөрөнгөөр баталгаажсан бонд болон бусад өглөгөөс бүрдэнэ. Зээл болон зээлээр авсан эх үүсвэрийн гэрээний онцлог нь Компанийг бонд эзэмшигчдэд мөнгө эсвэл бусад санхүүгийн хөрөнгийг шилжүүлэх, эсвэл тогтмол хэмжээний бэлэн мөнгө болон бусад санхүүгийн хөрөнгийг тогтмол тооны өөрийн хувьцаагаар солихоос бусад замаар биелүүлэх үүргийг хүлээлгэдэг. Зээл болон зээлээр авсан эх үүсвэрийг үр ашигт хорогдуулгын аргыг ашиглан хорогдуулна.



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company



УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК
ТТБ8674

2022.05.25 БҮРТГЭВ
MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-03-22 БҮРТГЭВ-03

"ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС" ХК

2021 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлан
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (үргэлжлэл)

(анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт)

#### 10) Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт

##### (i) Санхүүгийн хөрөнгө

Дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгийг (хэрэглэх боломжтой бол, санхүүгийн хөрөнгийн хэсгийг эсвэл хоорондоо төсөөтэй нэг бүлэг санхүүгийн хөрөнгүүдийн хэсгийг) үл хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрх нь дууссан, эсвэл
- Компани тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрхээ шилжүүлсэн эсвэл "дамжуулан өнгөрөөх" хэлцлийн дагуу хүлээн авсан мөнгөө нийт дүнгээр нь удаан хугацаагаар саатуулалгүйгээр гуравдагч талд төлөх үүрэг хүлээсэн, эсвэл
- Компани хөрөнгийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлсэн, эсвэл
- Компани тухайн хөрөнгөтэй холбоотой эрсдэл ба өгөөжийг шилжүүлээгүй боловч хөрөнгийн хяналтыг шилжүүлсэн.

Компани хөрөнгөөс мөнгө хүлээн авах эрхээ шилжүүлсэн эсвэл "дамжуулан өнгөрөөх" хэлцэл хийсэн боловч хөрөнгөтэй холбоотой ихэнхи эрсдэл, өгөөж болон хяналтыг шилжүүлээгүй тохиолдолд хөрөнгийг Компанийн уг хөрөнгөд үргэлжлүүлэн оролцсоор байх хэмжээгээр нь хүлээн зөвшөөрнө. Энэ тохиолдолд Компани холбогдох өр төлбөрийг мөн хүлээн зөвшөөрнө. Шилжүүлсэн хөрөнгө ба холбогдох өр төлбөр Компанийн хадгалж үлдсэн эрх, үүргийг тусган харуулсан сууриар хэмжинэ. Энэхүү үргэлжилсэн оролцоо нь шилжүүлсэн хөрөнгийн баталгаа хэлбэртэй байвал оролцоог тус хөрөнгийн анхны бүртгэлийн дүн ба Компанийн төлөх шаардлагатай болох хамгийн их дүнгийн аль багаар хэмжинэ.

##### (ii) Санхүүгийн өр төлбөр

Санхүүгийн өр төлбөрийг төлөхөөс чөлөөлөгдсөн, өр төлбөр цуцлагдсан эсвэл хугацаа нь дууссан бол үл хүлээн зөвшөөрдөг.

Хэрэв одоо байгаа санхүүгийн өр төлбөрийн зээлдүүлэгч нь хэвээрээ боловч ялгаатай нөхцөлтэй зээлийн гэрээгээр сольсон эсвэл одоо байгаа зээлийн нөхцөл эрс өөрчлөгдсөн бол эдгээр өөрчлөлт шинэчлэлтийг анхны санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт ба шинэ өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт гэж үзнэ. Анхны санхүүгийн өр төлбөрийн бүртгэлийн дүн ба төлсөн дүн хоёрын зөрүүг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

#### 11) Бодит үнэ цэнийн тодорхойлолт

Бодит үнэ цэнэ гэдэг нь хэмжилт хийсэн өдрийн зах зээлд оролцогчдын хооронд хийсэн дэс дараалалтай гүйлгээний үр дүнд хөрөнгө борлуулснаас орж ирэх мөнгөн дүн болон өр төлбөрт шилжүүлсэн мөнгөн дүн юм.



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК ERDENES SOLUTIONS Joint Stock Company 9020080899
УЛААНБААТАР ХОТ ГҮҮДСЕК ҮЦК ХХК ТТ58674 5208173

СЗХ
2022 .03. 25
БҮРТГЭВ
№ 1

2022 -03- 22
БҮРТГЭВ-03



## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (үргэлжлэл)
(анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт)

#### 11) Бодит үнэ цэнийн тодорхойлолт (үргэлжлэл)

Бодит үнэ цэнийн хэмжилт нь хөрөнгийг борлуулсан эсвэл өр төлбөрийг шилжүүлсэн гүйлгээ нь дараах зах зээлийн аль нэгэнд хийгдсэн гэж үзнэ. Үүнд:

- Хөрөнгө ба өр төлбөрийн үндсэн зах зээлд, эсвэл
- Үндсэн зах зээл байхгүй тохиолдолд, хөрөнгө ба өр төлбөрийн хувьд хамгийн ашигтай зах зээлд

Үндсэн болон хамгийн ашигтай зах зээл нь Компанийн хувьд оролцож болохуйц зах зээлүүд байх ёстой.

Хөрөнгө ба өр төлбөрийн бодит үнэ цэнийг хэмжихэд ашигласан үнэ нь зах зээлд оролцогчид нь хөрөнгө ба өр төлбөрийн эдийн засгийн хамгийн өндөр үр өгөөжийг хүртэнэ гэсэн төсөөлөл дээр үндэслэдэг.

Санхүүгийн бус хөрөнгийн бодит үнэ цэнийн хэмжилтийг, тухайн зах зээлд оролцогч тал нь хөрөнгийг ашигласнаар хамгийн өндөр эдийн засгийн үр өгөөжийг хүртэж чадаж байх эсвэл уг хөрөнгийг борлуулснаар худалдан авсан талд уг хөрөнгийг ашигласнаар хамгийн өндөр эдийн засгийн үр өгөөжийг өгч байх, нөхцөлд тооцно.

Компани нь бодит үнэ цэнэ тооцоход шаардлагатай мэдээллүүд нь хангалттай олдоцтой үед үнэлгээний техникүүдийг хэрэглэх нь тохиромжтой байдаг ба ажиглагдахуйц өгөгдлийн хэрэглээг нэмэгдүүлж, үл ажиглагдахуйц өгөгдлийн хэрэглээг хамгийн бага түвшинд байлгадаг.

Бодит үнэ цэнээрээ хэмжигдэж, санхүүгийн тайланд тайлагнаж байгаа бүх хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийг тодорхойлох, толилуулахдаа дараах түвшнийг хэрэглэдэг.

Түвшин 1 - Хөрөнгө, өр төлбөрийн хувьд хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй (залруулаагүй), идэвхитэй зах зээл дээрх үнэ,

Түвшин 2 - Бүртгэсэн бодит үнэ цэнэд томоохон нөлөө үзүүлэх бүх өгөгдлүүдийг нь шууд болон шууд бусаар ажиглах боломжтой бусад техникүүд,

Түвшин 3 - Бүртгэлд бүртгэгдсэн бодит үнэ цэнэд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг, зах зээл дээр ажиглагддаг мэдээлэл ашигладаггүй аргачлалууд.

Тайлант хугацааны эцэс бүрт Компани нь санхүүгийн тайландаа тайлагнасан хөрөнгө, өр төлбөрийн хувьд түвшин хооронд хөдөлгөөн гарсан эсэхийг дахин нягталж үздэг (бодит үнэ цэнийн хэмжилтэнд нөлөөлөхүйц хамгийн бага түвшний өгөгдөлд үндэслэн).

Санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн шинжилгээ болон бусад шаардлагатай мэдээллийг Тодруулга 16-д тусгасан.



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company

УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК
ТТ58674 ₮ 5208173

2022 -03- 22
БҮРТГЭВ-03

**"ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС" ХК**

**2021 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлан**
**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**

## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (үргэлжлэл)

(анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт)

#### 12) Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Компани нь санхүүгийн хөрөнгө эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгүүд нь үнэ цэнийн бууралтад орсныг нотлох бодит нотолгоо байгаа эсэхийг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр үнэлж үзнэ. Хэрэв хөрөнгийг анхлан хүлээн зөвшөөрсний дараа нэг буюу түүнээс олон тооны "Алдагдлын тохиолдол"-ын улмаас үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо бий болсон ба уг "Алдагдлын тохиолдол" нь санхүүгийн хөрөнгө эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийн ойролцоолон тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалд нөлөөлж байгаа үед санхүүгийн хөрөнгийг эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийг үнэ цэнийн бууралтад орсон гэж үзнэ.

Үнэ цэнийн бууралтын нотолгоонд зээлдэгч эсвэл бүлэг зээлдэгчид нь санхүүгийн томоохон хүндрэлд орсон, зээлийн хүү болон үндсэн төлбөр зөрчилд орсон, дампуурал эсвэл санхүүгийн өөр бусад дахин зохион байгуулалтанд орох магадлалтай болсон, зөрчилтэй холбоотой эдийн засгийн нөхцөл байдалд гарсан өөрчлөлт гэх мэт тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалд хэмжиж болохуйц бууралт байгааг харуулсан бодит өгөгдөл бий болох зэрэг орно.

##### (i) Хорогдуулсан өртгөөр нь бүртгэх санхүүгийн хөрөнгүүд

Хорогдуулсан өртгөөр нь бүртгэх санхүүгийн хөрөнгүүдийн хувьд Компани эхлээд дангаараа чухал ач холбогдолтой санхүүгийн хөрөнгө тус бүрийн хувьд үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байгаа эсэхийг нэг бүрчлэн (тусгайлан), дараа нь дангаараа чухал ач холбогдолгүй санхүүгийн хөрөнгийг нийлүүлэн (бүлгээр нь) үнэлнэ.

Хэрэв Компани нь нэг бүрчлэн үнэлэгдсэн санхүүгийн хөрөнгийн үнэлгээний хувьд (чухал ач холбогдолтой, холбогдолгүй эсэхийг үл харгалзан) үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байхгүй гэж үзвэл ойролцоо зээлийн эрсдэлийн шинж чанар бүхий санхүүгийн хөрөнгийн бүлэгт оруулан үнэ цэнийн бууралтыг нь нэгдсэн байдлаар үнэлдэг. Үнэ цэнийн бууралтын нэг бүрчилсэн үнэлгээ хийгдсэн, үнэ цэнийн бууралтын алдагдал нь хүлээн зөвшөөрөгдсөн, эсвэл үргэлжилж буй хөрөнгийг бүлгийн үнэ цэнийн бууралтын үнэлгээнд оруулахгүй.

Хэрэв үнэ цэнийн буурсан талаарх бодит нотолгоо байгаа бол үнэ цэнийн бууралтын гарзыг хөрөнгийн дансны үнэ болон ирээдүйн тооцсон мөнгөн урсгалын (тохиолдоогүй байгаа ирээдүйн, хүлээгдэж буй үнэ цэнийн бууралтын гарзыг оруулахгүй) өнөөгийн үнэ цэнийн зөрүүгээр хэмжинэ.

Хөрөнгийн бүртгэлийн дүнг эрсдэлийн сангийн дансаар бууруулах ба алдагдлын дүнг нэгтгэсэн ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө. Бүртгэлийн бууруулсан дүн дээр хүүний орлогыг үргэлжлүүлэн хуримтлуулахдаа үнэ цэнийн бууралтын алдагдлыг хэмжих зорилгоор ирээдүйн мөнгөн урсгалыг бууруулахад ашигласан хүүний хувиар тооцон хуримтлуулна.



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company



УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ХХК
ТТБ0674 ☎ 5208173

2022.05.25
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-05-22
БҮРТГЭВ-03

**"ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС" ХК**

**2021 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлан**
**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**

## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (үргэлжлэл)
(анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт)

**12) Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)**

**(i) Хорогдуулсан өртгөөр нь бүртгэх санхүүгийн хөрөнгүүд (үргэлжлэл)**

Цаашид эргэн төлөгдөх ямар нэг бодит чиг хандлага байхгүй байгаа, бүх барьцаа хөрөнгийг борлуулсан эсвэл Компанид шилжүүлсэн үед, зээлийг холбогдох зээлийн эрсдэлийн сангийн хамт данснаас хасна. Хэрэв дараагийн тайлант хугацаанд үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрсний дараах үйл явдлын улмаас тооцоолсон үнэ цэнийн бууралтын алдагдал өсөж эсвэл буурвал, сангийн дансыг залруулах замаар өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтыг өсгөж эсвэл бууруулна. Өмнөх жилүүдэд данснаас хассан хөрөнгө дараа нь эргэн төлөгдвөл эргэн төлөгдсөн дүнг нэгтгэсэн ашиг, алдагдлын тайланд орлогоор хүлээн зөвшөөрнө.

Орж ирнэ гэж тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг санхүүгийн хөрөнгийн анхны, үр ашигт хүүний хувиар бууруулан тооцдог. Зээлийн хүүний хувь нь хувьсах нөхцөлтэй бол үнэ цэнийн бууралтын алдагдлыг хэмжих хөнгөлөлтийн хувь нь дахин ангилсан өдрөөрх өнөөгийн үр ашигт хүүний хувьтай тэнцүү байна.

Барьцаатай санхүүгийн хөрөнгийн ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн тооцоо нь барьцааг хураан авах боломжтой эсэхээс үл хамааран тус барьцааг хураан авч, албадан борлуулахад гарах зардлыг хассаны дараах мөнгөн урсгалыг харуулдаг.

Үнэ цэнийн бууралтыг багцын үнэлгээг хийхдээ санхүүгийн хөрөнгийн төрөл, хамаарах салбар, газарзүйн байрлал, барьцаа хөрөнгийн төрөл, хугацаа хэтрэлтийн байдал болон бусад гол хүчин зүйлс зэрэг зээлийн эрсдэлийн шинж чанаруудыг харгалзан үзсэн Компанийн дотооддоо хэрэглэдэг зээлдэгчийн ангиллын систем дээр үндэслэн санхүүгийн хөрөнгийг бүлэглэнэ. Компани нь багцын үнэ цэнийн бууралтын үнэлгээг тооцохдоо эрсдэлийн бүлэг тус бүрийн түүхэн алдагдалд суурилсан. Өнөө үед үгүй болсон түүхэн нөхцөл байдлын нөлөөг арилгах, түүхэн алдагдлын суурилж буй жилүүдэд хамааралгүй өнөөгийн нөхцөл байдлын нөлөөг харуулах үүднээс түүхэн алдагдлын мэдээнд өнөө үед ажиглагдахуйц өгөгдлүүдэд үндэслэн тохиргоо хийнэ.

Ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалын өөрчлөлтийн тооцоолол нь жил жилийн ажиглаж болохуйц холбогдох өгөгдлүүдийн өөрчлөлтүүдийг тусгасан. (Үүнд: ажилгүйдлийн түвшин, эд хөрөнгийн үнэ, өргөн хэрэглээний барааны үнэ, төлбөрийн чадавхи, алдагдлыг илэрхийлэх хүчин зүйлс бүлгээр болон ач холбогдлоор нь). Ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалыг тооцоолоход ашигласан аргачлал, таамаглалуудыг тооцоолсон алдагдал, бодитоор хүлээсэн алдагдлын хоорондын зөрүүг багасгах зорилгоор тогтмол хянана.



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company
9020080699



УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК
ТТ58674 ★ 5208173

MONGOLIAN STOCK EXCHA
2022 -03- 22
БҮРТГЭВ-03

2022 05 25

**"ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС" ХК**

**2021 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлан**
**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**

## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (үргэлжлэл)

(анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт)

#### 13) Санхүүгийн хэрэглүүрүүдийг цэвэршүүлэх

Зөвхөн хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг цэвэршүүлэх хуулиар олгогдсон эрхтэй, тооцоог цэвэр дүнгээр нь барагдуулах, эсвэл хөрөнгийг борлуулж өр төлбөрийг нь барагдуулах ажлыг нэгэн зэрэг хийхээр зэхэж байгаа бол санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэршүүлэн, цэвэр дүнгээр нь тайлан тэнцэлд толилуулах эрхтэй. Мастер цэвэршүүлэлт гэрээнүүдийн хувьд энэ нь хэрэгждэггүй ба холбогдох хөрөнгө болон өр төлбөрийг нийт дүнгээр нь санхүүгийн байдлын тайланд тус тусад нь толилуулдаг.

#### 14) Орлого, зардлыг хүлээн зөвшөөрөх

Эдийн засгийн өгөөж нь Компанид орж ирэх нь тодорхой болсон хэмжээгээр, найдвартайгаар хэмжиж болох үед орлогыг хүлээн зөвшөөрнө. Орлогыг хүлээн зөвшөөрөхөөс өмнө дараах тусгай шалгуурууд хангагдсан байх ёстой. Үүнд:

##### (i) Хүүний орлого ба зардал

Хорогдуулсан өртгөөр нь хэмждэг бүх санхүүгийн хэрэглүүрүүд, "Борлуулахад бэлэн" гэж ангилагдсан хүүтэй санхүүгийн хөрөнгүүд, "Бодит үнэ цэнийн өсөлт бууралт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх" гэж ангилагдсан санхүүгийн хэрэгслүүдийн хүүний орлого, зардлыг үр ашигт хүүний хувийг (ирээдүйд төлөх эсвэл хүлээн авах мөнгөний ойролцоолон тооцоолсон дүнг санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацаа эсвэл түүнээс богино хугацааны туршид санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн бүртгэлийн цэвэр дүнрүү нь бууруулах хүү) хэрэглэн бүртгэнэ. Тооцоололд санхүүгийн хэрэглүүрийн гэрээний бүх нөхцлүүдийг (жишээ нь: урьдчилгаа төлбөрийн хувилбарууд) харгалзан үзсэн ба тухайн хэрэглүүрт шууд хамааралтай ба зээлийн ирээдүйн алдагдал биш харин үр ашигт хүүний салшгүй нэг хэсэг болж байгаа аливаа төлбөр эсвэл өсөн нэмэгдэх зардлуудыг багтаасан.

Компани хийх төлбөр, хүлээн авах мөнгөний талаар хийсэн өөрийн ойролцоолсон тооцоололдоо өөрчлөлт оруулбал санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өр төлбөрийн бүртгэлийн дүнг залруулна. Залруулсан бүртгэлийн дүнг анхны үр ашигт хүүний түвшин дээр үндэслэн тооцоолох ба бүртгэлийн дүнд орсон өөрчлөлтийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Гэхдээ ирээдүйд хүлээн авах мөнгөний хэмжээ өссөний улмаас Компани ирээдүйд хүлээн авах мөнгөний ойролцоолсон дүнг дараагийн тайлант хугацаанд өсгөсөн бол уг өсөлтийн нөлөөг ойролцоолсон тооцоололд өөрчлөлт оруулсан өдрөөс эхлэн "Үр ашигт хүүний түвшинд хийсэн залруулга" гэж хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хөрөнгийн эсвэл төсөөтэй бүлэг санхүүгийн хөрөнгүүдийн бүртгэлийн дүнг үнэ цэнийн бууралтын алдагдлын улмаас бууруулсан бол үнэ цэнийн бууралтыг хэмжих зорилгоор ирээдүйн мөнгөн урсгалыг бууруулахдаа хэрэглэсэн хүүний түвшинг ашиглан хүүний орлогыг үргэлжлүүлэн хүлээн зөвшөөрнө.

##### (ii) Хураамж ба шимтгэлийн зардал

Хураамж нь арилжааны банкуудад болон толгой компанид төлсөн удирдлагын болон тогтмол дүнтэй шимтгэл юм. Хураамжийг тухайн үйлчилгээг бодитоор авсан үед хүлээн зөвшөөрнө.



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company
9020080899

УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК

2022 -03- 22

БҮРТГЭВ-03

**"ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС" ХК**

**2021 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлан**
**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**

## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (үргэлжлэл)

(анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт)

**15) Татвар**

**(i) Тайлант хугацааны орлогын албан татвар**

Одоогийн болон өмнөх тайлант хугацааны өнөөгийн албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг татварын байгууллагаас буцаан авахаар хүлээж байгаа эсвэл татварын байгуулагад төлөх дүнгээр хэмжинэ. Энэ дүнг тооцоолоход хэрэглэсэн татварын хувь хэмжээ, татварын хуулиуд нь санхүүгийн байдлын тайлангийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байсан.

**(ii) Хойшлуулсан орлогын албан татвар**

Хойшлуулсан орлогын албан татварыг тайлагналын өдрийн байдлаарх хөрөнгө, өр төлбөрийн татварын суурь, тэдгээрийн санхүүгийн бүртгэлийн дүн хоёрын хооронд түр зөрүүний дүнгээс тайлан тэнцлийн аргыг хэрэглэн тооцдог. Дараахаас бусад бүх түр зөрүүнүүд дээр хойшлуулсан орлогын албан татварын өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Хэрэв хойшлуулсан орлогын албан татварын өр төлбөр нь гүүдвиллээс эсвэл бизнесийн нэгдлийн үеийн бус гүйлгээнээс үүссэн ба гүйлгээ хийх үед нягтлан бодох бүртгэлийн ашиг ба татвар ногдох ашгийн аль алинд нөлөө үзүүлэхгүй хөрөнгө, өр төлбөрийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн бол.

Дараахаас бусад бүх хасагдах түр зөрүүнүүд, ашиглаагүй татварын хөнгөлөлт, ашиглаагүй татварын алдагдлууд дээр, эдгээрийг ашиглаж болох татвар ногдох ашиг олох магадлал байгаа үед хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Хэрэв хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгө нь бизнесийн нэгдлийн үеийн бус гүйлгээнээс үүссэн ба гүйлгээ хийгдэх үед нягтлан бодох бүртгэлийн ашиг ба татвар ногдох ашгийн аль алинд нөлөө үзүүлэхгүй хөрөнгө, өр төлбөрүүдийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн бол.

Хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгийн бүртгэлийн дүнг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр хянаж үздэг ба энэхүү хөрөнгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн ашиглахад хангалттай хэмжээний татвар ногдох орлого орж ирэх магадлал буурах үед уг бүртгэлийн дүнг бууруулна. Үл хүлээн зөвшөөрсөн хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгийг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр дахин үнэлж үздэг ба хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгийг ашиглахыг зөвшөөрсөн татвар ногдох орлого ирээдүйд орж ирэх магадлалтай болсон үед хүлээн зөвшөөрнө.

Хөрөнгийг олж авах эсвэл өр төлбөрийг барагдуулах тэр тайлант хугацаанд хэрэглэгдэнэ гэж хүлээж байгаа (тайлант жилийн эцсийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байсан татварын хувь хэмжээ, татварын хуулиуд дээр үндэслэн) татварын хувь хэмжээгээр хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгө, өр төлбөрийг хэмжинэ.



ERDENES SOLUTIONS Joint Stock Company

УЛААНБААТАР ХОТ ГҮҮДСЕК ҮЦК ХХК

СЗХ 2022 .05. 25 БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2022 -03- 22 БҮРТГЭВ-03



## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (үргэлжлэл)
(анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт)

**15) Татвар (үргэлжлэл)**

**(ii) Хойшлуулсан орлогын албан татвар**

Ашиг алдагдалд хүлээн зөвшөөрөөгүй зүйлстэй холбоотой хойшлуулсан татваруудыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөхгүй. Хойшлогдсон орлогын албан татварыг тухайн гүйлгээтэй холбогдуулан бусад дэлгэрэнгүй орлогын тайлан эсвэл өөрийн хөрөнгөд шууд хүлээн зөвшөөрнө.

Нэг татвар төлөгч, нэг татварын байгууллагад хамаарах хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэршүүлэн тайлагнах хуулиар олгогдсон эрхтэй бол хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэршүүлэн тайлагнаж болно.

**16) Эздийн өмч**

**(i) Хувьцаат хөрөнгө**

Энгийн хувьцааг өөрийн хөрөнгөөр бүртгэсэн. Шинэ хувьцаа гаргахтай шууд холбоотой нэмэлт зардлыг татварын дараах дүнгээр нь хувьцаа борлуулсны орлогоос хассан дүнгээр өөрийн хөрөнгөд тусгадаг.

**(ii) Хуримтлагдсан ашиг**

Хуримтлагдсан ашиг нь тухайн тайлант хугацаанд хуримтлуулсан нийт ашиг юмуу алдагдлын дүнгээс зарлагдсан ноогдол ашгийг хассан дүнгээр тодорхойлогдох ба өнгөрсөн жилийн залруулга юмуу нягтлан бодох бүртгэлийн бодлогод гарсан өөрчлөлт зэргээс хамаарч өөрөөр илэрхийлэгдэж болно.

**17) Холбоотой талуудын ажил гүйлгээ**

Холбоотой талууд гэдэг Компанитай дараах байдлаар холбогдсон аж ахуй нэгж болон хувь хүн орно. Үүнд:

(a) Компанитай дараах байдлаар холбогдсон хувь хүн эсвэл тухайн хувь хүний ойрын төрөл садан:

- (i) Компанид дангаараа эсвэл хамтран хяналт тогтоосон;
- (ii) Компанид томоохон нөлөөлөлтэй эсвэл
- (iii) Компанийн эсвэл Компанийн толгой компанийн гол удирдах албан тушаалтнуудын нэг.



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК ERDENES SOLUTIONS Joint Stock Company 9020080899 5358
УЛААНБААТАР ХОТ ГҮҮДСЕК ҮЦК ХХК

## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (үргэлжлэл)
(анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт)

**17) Холбоотой талуудын ажил гүйлгээ (үргэлжлэл)**

(б) Дараах нөхцлүүдийн аль нэг нь биелсэн тохиолдолд аж ахуй нэгж нь Компанид хамааралтай болно. Үүнд:

(i) Аж ахуй нэгж болон Компани нь нэг ижил группын гишүүд байх (толгой компани, охин компани болон нөгөө охин компани тус бүр нь бусадтайгаа холбоотой).
(ii) Нэг аж ахуй нэгж нь нөгөө аж ахуй нэгжийн хараат компани эсвэл хамтын хэлэлцээрт компани (эсвэл нөгөө аж ахуй нэгж нь гишүүн болох группын хараат компани эсвэл хамтарсан хэлэлцээрт компани).
(iii) Аль аль аж ахуй нэгж нь нэг ижил гуравдагч этгээдийн хамтарсан хэлэлцээрт компаниуд.
(iv) Нэг аж ахуй нэгж нь гуравдагч аж ахуй нэгжийн хамтарсан хэлэлцээрт компани бөгөөд нөгөө этгээд нь гуравдагч аж ахуй нэгжийн хараат компани.
(v) Аж ахуй нэгж нь Компанийн эсвэл Компанитай холбоотой аж ахуй нэгжийн ажиллагсдыг урамшуулах зорилгоор ажил эрхлэлтийн дараах тэтгэмж олгодог. Хэрвээ Компани нь уг хөтөлбөрийг хэрэгжүүлдэг бол дэмжлэг хүртэж буй ажиллагсад нь мөн Компанитай холбоотой тал болно.
(vi) Аж ахуй нэгжийг (а)-д тодорхойлсон хувь хүнь дангаараа эсвэл хамтран хяналт тогтоодог.
(vii) (а) (i)-д тодорхойлсон хувь хүн нь аж ахуй нэгжид томоохон нөлөөлөлтэй эсвэл уг аж ахуй нэгжийн (эсвэл аж ахуй нэгжийн толгой компанийн) гол удирдах албан тушаалтнуудын нэг.
(viii) Аж ахуй нэгж нь эсвэл группын аль нэг гишүүн нь Компани эсвэл Компанийн толгой компанид гол удирдах албан тушаалтай.

СЗХ
он 2022 сар 05. 25 өдөр
БҮРТГЭВ
№ 01

...ОЛЫН ХӨРӨН...
...ONGOLIAN STOCK EXCHA...
2022 -03- 22
БҮРТГЭВ-03

**"ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС" ХК**

**2021 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлан**
**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**

## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.4 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ ҮНЭЛЭМЖ, ТООЦООЛОЛ, ТӨСӨӨЛЛҮҮД

Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэглэх явцдаа удирдлага нь санхүүгийн тайлангуудад хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг тодорхойлохдоо үнэлэмж, ойролцоолсон тооцооллуудыг хэрэглэдэг. Хамгийн том үнэлэмж, ойролцоолсон тооцооллуудыг дор үзүүлэв. Үүнд:

**Тасралтгүй үйл ажиллагаа**

Компанийн удирдлага Компанийн тасралтгүй үйл ажиллагаа явуулах чадварыг үнэлж үзсэн бөгөөд Компани нь ойрын ирээдүйд бизнесээ тасралтгүй явуулж чадах хэмжээний нөөцтэй гэж дүгнэсэн. Цаашилбал удирдлага нь компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадварын талаар эргэлзээ төрүүлж болох аливаа нэг материаллаг тодорхойгүй байдлын талаар олж мэдсэн зүйлгүй байна. Тиймээс, Компанийн санхүүгийн тайлангуудыг тасралтгүй үйл ажиллагааны зарчимд суурилан бэлтгэнэ.

**Хойшлогдсон орлогын албан татвар**

Хойшлогдсон татварын хөрөнгийг ашиглаагүй бүх татварын алдагдлуудын хувьд уг татварын алдагдлыг шилжүүлэн ашиглаж болох татвар ногдох ашиг олох боломжтой хэмжээгээр хүлээн зөвшөөрнө. Хүлээн зөвшөөрөх хойшлогдсон татварын хөрөнгийн дүнг тодорхойлоход удирдлагын томоохон үнэлэмж шаарддаг ба энэ нь боломжит хугацаа, ирээдүйн татвар ногдох ашиг болон ирээдүйн татварын төлөвлөлтөд үндэслэдэг.



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company
2015558



УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК

"ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС" ХК

**2021 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлан**
**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**

## 3. МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

*(төгрөгөөр)*

| № | Мөнгөн хөрөнгийн зүйлс | 2020/12/31-ийн үлдэгдэл | | 2021/12/31-ийн үлдэгдэл | |
|---|---|---|---|---|---|
| | | Валют | Төгрөг | Валют | Төгрөг |
| Банкин дахь мөнгө | | | | | |
| 1 | Ариг банк 2102026090-MNT | | 8,249.90 | | 112,203.64 |
| 2 | Ариг банк 2102033358-MNT | | 17,057,939.45 | | 87,166.78 |
| 3 | Худалдаа хөгжлийн банк 417068590-MNT | | | | 12,043,505.54 |
| 4 | Худалдаа хөгжлийн банк 417066591-USD | | | 179.06 | 509,404.37 |
| | Нийт дүн | | 17,066,189.35 | 179.06 | 12,752,280.33 |

## 4. ТАТВАР, НИЙГМИЙН ДААТГАЛЫН АВЛАГА

*(төгрөгөөр)*

| № | Үзүүлэлт | 2020/12/31 –ний үлдэгдэл | 2021/12/31 –ний үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | Нэмэгдсэн өртгийн албан татвар | | 928,840.46 |
| | Нийт дүн | | 928,840.46 |

## 5. БУСАД АВЛАГА

*(төгрөгөөр)*

| № | Үзүүлэлт | 2020/12/31 -ийн үлдэгдэл | 2021/12/31-ийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | Ажиллагсдаас авах авлага | - | 260,000.00 |
| | Нийт дүн | - | 260,000.00 |

## 6. БАРАА МАТЕРИАЛ

*(төгрөгөөр)*

| № | Үзүүлэлт | 2020/12/31 үлдэгдэл | Нэмэгдсэн дүн | Хасагдсан дүн (-) | 2021/12/31 үлдэгдэл |
|---|---|---|---|---|---|
| 1 | Дуусаагүй үйлдвэрлэл | 24,660,000.00 | 66,395,068.76 | | 91,055,068.76 |
| | Нийт дүн | 24,660,000.00 | 66,395,068.76 | 0.00 | 91,055,068.76 |

## 7. УРЬДЧИЛЖ ТООЦСОН ЗАРДАЛ/ТООЦОО

*(төгрөгөөр)*

| № | Үзүүлэлт | 2020/12/31 –ний үлдэгдэл | 2021/12/31 –ний үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | Урьдчилж төлсөн зардал | 2,925,000.00 | |
| 2 | Урьдчилж төлсөн тооцоо | 30,500,000.00 | 46,500,000.00 |
| 3 | Урьдчилж төлсөн түрээс | 150,000.00 | |
| | Нийт дүн | 33,575,000.00 | 46,500,000.00 |

2022 -03- 22
БҮРТГЭВ-03

**“ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС” ХК**

**2021 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлан**
**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**

## 8. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

*(төгрөгөөр)*

| № | Үзүүлэлт | Барилга, байгууламж | Тавилга эд хогшил | Компьютер, бусад хэрэгсэл | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| | ҮНДСЭН ХӨРӨНГӨ /ӨРТӨГ/ | | | | |
| 1.1 | 2020/12/31 –ний үлдэгдэл | - | - | - | - |
| 1.2 | Нэмэгдсэн дүн | 285,500,000.00 | 4,298,932.73 | 17,003,316.83 | 306,802,249.56 |
| | Худалдаж авсан | 285,500,000.00 | 4,298,932.73 | 17,003,316.83 | 306,802,249.56 |
| 1.3 | Хасагдсан дүн (-) | - | - | - | - |
| 1.6 | 2021/12/31 –ний үлдэгдэл | 285,500,000.00 | 4,298,932.73 | 17,003,316.83 | 306,802,249.56 |
| | ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ | | | | |
| 2.1 | 2020/12/31 –ний үлдэгдэл | - | - | - | - |
| 2.2 | Нэмэгдсэн дүн | 5,710,000.00 | 214,946.64 | 3,703,092.10 | 9,628,038.74 |
| | Байгуулсан элэгдэл | 5,710,000.00 | 214,946.64 | 3,703,092.10 | 9,628,038.74 |
| 2.3 | Хасагдсан дүн | - | - | - | - |
| 2.4 | 2021/12/31 –ний үлдэгдэл | 5,710,000.00 | 214,946.64 | 3,703,092.10 | 9,628,038.74 |
| | ДАНСНЫ ЦЭВЭР ДҮН | | | | |
| 3.1 | 2020/12/31 –ний үлдэгдэл | - | - | - | - |
| 3.2 | 2021/12/31 –ний үлдэгдэл | 279,790,000.00 | 4,083,986.09 | 13,300,224.73 | 297,174,210.82 |

## 9. БИЕТ БУС ХӨРӨНГӨ

*(төгрөгөөр)*

| № | Үзүүлэлт | Компьютерийн программ хангамж | Гудвилл | Нийт дүн |
|---|---|---|---|---|
| | БИЕТ БУС ХӨРӨНГӨ /ӨРТӨГ/ | | | |
| 1.1 | 2020/12/31 –ний үлдэгдэл | 1,515,106,230.00 | 13,349,682.09 | 1,528,455,912.09 |
| 1.2 | Нэмэгдсэн дүн | - | - | - |
| 1.3 | Хасагдсан дүн (-) | - | - | - |
| 1.4 | 2021/12/31 –ний үлдэгдэл | 1,515,106,230.00 | 13,349,682.09 | 1,528,455,912.09 |
| | ХУРИМТЛАГДСАН ХОРОГДОЛ | | | |
| 2.1 | 2020/12/31 –ний үлдэгдэл | - | - | - |
| 2.2 | Нэмэгдсэн дүн | - | - | - |
| 2.3 | Хасагдсан дүн (-) | - | - | - |
| 2.4 | 2021/12/31 –ний үлдэгдэл | - | - | - |
| | ДАНСНЫ ЦЭВЭР ДҮН | - | - | - |
| 3.1 | 2020/12/31 –ний үлдэгдэл | 1,515,106,230.00 | 13,349,682.09 | 1,528,455,912.09 |
| 3.2 | 2021/12/31 –ний үлдэгдэл | 1,515,106,230.00 | 13,349,682.09 | 1,528,455,912.09 |

## 10. УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

*(төгрөгөөр)*

| № | Үзүүлэлт | 2020/12/31 –ний үлдэгдэл | | 2021/12/31 –ний үлдэгдэл | |
|---|---|---|---|---|---|
| | | Хөрөнгө оруулалт % | Хөрөнгө оруулалтын дүн | Хөрөнгө оруулалт % | Хөрөнгө оруулалтын дүн |
| 1 | Эрдэнэс Капитал Маркетс ХХК | | 20,000.00 | | 20,000.00 |
| 2 | Эрдэнэс Агро энд Ресорт ХХК | | 20,000.00 | | 20,000.00 |
| 3 | Эрдэнэс Рийл Эстэйт ХХК | | 20,020,000.00 | | 20,020,000.00 |
| 4 | Эйс Ассошиэтс ХХК | | | 85% | 869,994,745.50 |
| | Нийт дүн | | 20,060,000.00 | | 890,054,745.50 |

2022 -03- 22
БҮРТГЭВ-03

**"ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС" ХК**

**2021 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлан**
**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**

## 11. ДАНСНЫ ӨГЛӨГ

*(төгрөгөөр)*

| № | Үзүүлэлт | 2020/12/31 –ний үлдэгдэл | 2021/12/31 –ний үлдэгдэл |
|---|---|---|---|
| | Төлөгдөх хугацаандаа байгаа : | | |
| 1 | Дотоодын байгууллагад өгөх өглөг | 30,032,388.20 | 154,805,455.00 |
| 2 | Ажиллагсдад өгөх өр | | 5,048,742.16 |
| | Дүн | 30,032,388.20 | 159,854,197.16 |

## 12. ЦАЛИНГИЙН ӨР

*(төгрөгөөр)*

| № | Үзүүлэлт | 2020/12/31 –ний үлдэгдэл | 2021/12/31 –ний үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | Цалингийн өглөг | 21,959,750.00 | |
| | Нийт дүн | 21,959,750.00 | |

## 13. ТАТВАРЫН ӨР

*(төгрөгөөр)*

| № | Үзүүлэлт | 2020/12/31 –ний үлдэгдэл | 2021/12/31 –ний үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар | | 77,597,824.40 |
| 2 | Хувь хүний орлогын албан татвар | 1,858,500.01 | 5,083,705.01 |
| 3 | Нийгмийн даатгалын шимтгэл | 4,554,741.80 | 15,132,405.44 |
| | Нийт дүн | 6,413,241.81 | 97,813,934.85 |

## 14. УРЬДЧИЛЖ ОРСОН ОРЛОГО

*(төгрөгөөр)*

| № | Үзүүлэлт | 2020/12/31 –ний үлдэгдэл | 2021/12/31 –ний үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | Урьдчилж орсон орлого | | 30,000,000.00 |
| | Нийт дүн | - | 30,000,000.00 |

## 15. БУСАД БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

*(төгрөгөөр)*

| № | Үзүүлэлт | 2020/12/31 –ний үлдэгдэл | 2021/12/31 –ний үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | Бусад богино хугацаат өр төлбөр | 148,427,000.00 | |
| 2 | Бондын өглөг | | 464,937,804.00 |
| | Нийт дүн | 148,427,000.00 | 464,937,804.00 |

## 16. ЭЗДИЙН ӨМЧ

*(төгрөгөөр)*

| № | Үзүүлэлт | Эргэлтэнд байгаа бүрэн төлөгдсөн энгийн хувьцаа | | Өмчийн дүн (төгрөгөөр) |
|---|---|---|---|---|
| | | Тоо ширхэг | Дүн (төгрөгөөр) | |
| 1 | 2020/12/31 –ний үлдэгдэл | 157,874,570 | 1,578,745,700.00 | 1,578,745,700.00 |
| | 2021/12/31 –ний үлдэгдэл | 157,874,570 | 1,578,745,700.00 | 1,578,745,700.00 |



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК ERDENES SOLUTIONS Joint Stock Company

УЛААНБААТАР ХОТ ГҮҮДСЕК ҮЦК ХХК ТТ56874 5208173

"ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС" ХК

**2021 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлан**
**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**

## 17. ХУРИМТЛАГДСАН АШИГ

*(төгрөгөөр)*

| № | Үзүүлэлт | 2020/12/31 –ний үлдэгдэл | 2021/12/31 –ний үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | Тайлант оны эхний үлдэгдэл | (14,379,085.40) | (161,760,978.57) |
| 2 | Тайлант үеийн ашиг | (147,381,893.17) | 697,590,400.52 |
| | Нийт дүн | (161,760,978.57) | 535,829,421.95 |

## 18. БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО БОЛОН БОРЛУУЛАЛТЫН ӨРТӨГ

*(төгрөгөөр)*

| № | Үзүүлэлт | 2020 | 2021 |
|---|---|---|---|
| 1 | БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО : | | |
| | Борлуулсан барааны орлого | 19,160,000.00 | 869,800,000.00 |
| | Үзүүлсэн үйлчилгээний орлого | 2,102,623.71 | |
| | Нийт борлуулалтын орлого | 21,262,623.71 | 869,800,000.00 |
| 2 | БОРЛУУЛАЛТЫН ХӨНГӨЛӨЛТ, БУЦААЛТ : | | |
| 3 | Цэвэр борлуулалт : | 21,262,623.71 | 869,800,000.00 |
| 4 | БОРЛУУЛАЛТЫН ӨРТӨГ : | | |
| | Нийт ашиг | 21.262,623.71 | 869,800,000.00 |

## 19. БУСАД ОРЛОГО

*(төгрөгөөр)*

| № | Үзүүлэлт | 2020 | 2021 |
|---|---|---|---|
| 1 | Хүүний орлого | - | 70,255.86 |
| 2 | Бусад орлого | - | 2,000,000.00 |
| | Нийт дүн | - | 2.070,255.86 |

## 20. ЕРӨНХИЙ УДИРДЛАГЫН ЗАРДАЛ

*(төгрөгөөр)*

| № | Үзүүлэлт | 2020 | 2021 |
|---|---|---|---|
| 1 | Үндсэн ба нэмэгдэл цалин | 28,140,000.00 | |
| 2 | Ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал | 1,680,000.00 | |
| 3 | Сургалт семинарын | 2,750,000.00 | 400,000.00 |
| 4 | Хоолны зардал | 2,666,904.00 | |
| 5 | Харуул, хамгаалалтын зардал | 80,000.00 | |
| 6 | Гадаад албан томилолт | 230,000.00 | |
| 7 | Элэгдлийн зардал | 45,300.00 | 9,628,038.74 |
| 8 | Түрээсийн зардал | 25,725,000.00 | 2,549,545.45 |
| 9 | Барилга засварын зардал | 1,610,000.00 | |
| 10 | Урсгал засварын зардал | | 11,726,314.07 |
| 11 | Ашиглалтын зардал | 589,400.00 | 1,425,319.94 |
| 12 | Мэргэжлийн үйлчилгээний зардал | 31,500,000.00 | 20,109,953.27 |
| 13 | Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зардал | | 1,900,000.00 |
| 14 | Харилцаа, холбооны зардал | 539,300.00 | 2,507,800.00 |
| 15 | Хэвлэл, шуудангийн зардал | 35,000.00 | |
| 16 | Зар сурталчилгаа | 300,000.00 | 560,000.00 |
| 17 | Цэвэрлэгээ үйлчилгээний зардал | | 580,000.00 |
| 18 | Албан татвар, төлбөр, хураамжийн зардал | | 3,062,442.28 |
| 19 | Бичиг хэргийн зардал | 2,494,400.00 | 2,257,800.00 |
| 20 | Хангамжийн материалын зардал | 18,073,923.86 | 11,443,201.82 |
| 21 | Тээврийн зардал | | 267,363.64 |
| 22 | Шимтгэл ба бусад төлбөрийн зардал | 46,547,388.20 | |

2022 -03- 22
БҮРТГЭВ-03

"ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС" ХК

**2021 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлан**
**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**

| | | | |
|---|---|---|---|
| 23 | Торгууль ба бусад хураамжийн зардал | 1,600,000.00 | |
| 24 | Банкны шимтгэл | 59,040.00 | 137,425.48 |
| 25 | Бизнес уулзалтын зардал | | 6,041,615.18 |
| 26 | Арга хэмжээ, хүлээн авалтын зардал | 607,384.00 | |
| 27 | Шатахууны зардал | 20,000.00 | |
| 28 | Бусад зардал | 3,351,476.82 | 176,138.72 |
| | Нийт дүн | 168,644,516.88 | 74,772,958 59 |

## 21. БУСАД ЗАРДАЛ

*(төгрөгөөр)*

| № | Үзүүлэлт | 2020 | 2021 |
|---|---|---|---|
| 1 | Санхүүгийн зардал | - | 21,035,326.92 |
| - | Зээлийн хүүний зардал | - | 21,035,326.92 |
| 2 | Бусад зардал | - | 790,000.00 |
| - | Алданги, торгуулийн зардал | - | 790,000.00 |
| | Нийт дүн | - | 21,825,326 92 |

## 22. ГАДААД ВАЛЮТЫН ХАНШИЙН ЗӨРҮҮНИЙ ОЛЗ, ГАРЗ

*(төгрөгөөр)*

| № | Үзүүлэлт | 2020 | 2021 |
|---|---|---|---|
| | Гадаад валютын ханшийн зөрүүний бодит олз, гарз : | | |
| 1 | Валютын арилжаанаас үүсэн олз, гарз | - | (83,726.33) |
| | Дүн | - | (83,726.33) |
| | Гадаад валютын ханшийн зөрүүний бодит бус олз, гарз : | | |
| 1 | Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд хийсэн ханшийн тэгшитгэл | - | (19.10) |
| | Дүн | - | (19.10) |
| | Нийт дүн | - | (83,745.43) |

## 23. ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ

*(төгрөгөөр)*

| № | Үзүүлэлт | 2020 | 2021 |
|---|---|---|---|
| 1 | Тайлант үеийн орлогын татварын зардал | - | 77,597,824.40 |
| | Нийт дүн | - | 77,597,824 40 |

## 24. ЦАЛИНГИЙН ЗАРДАЛ

*(төгрөгөөр)*

| № | Зардлын төвүүд | 2020 | | 2021 | |
|---|---|---|---|---|---|
| | | Ажилчдын тоо | Цалингийн зардал | Ажилчдын тоо | Цалингийн зардал |
| 1 | Үйлдвэрлэл, үйлчилгээний : | | | 8 | 55,471,931.82 |
| 2 | Ерөнхий ба удирдлагын : | | 28,140,000.00 | | |
| | Нийт дүн | | 28,140,000.00 | 8 | 55,471,931 82 |



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК

**"ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС" ХК**

**2021 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлан**
**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**

## 25. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН ТОДРУУЛГА

*(төгрөгөөр)*

| № | Холбоотой талын нэр | Холбоо хамаарал | Харьяалал | Эзэмшлийн хувь |
|---|---|---|---|---|
| 1 | Субашид Тек ХХК | Хамгийн дээд хяналт тавигч толгой компани | Монгол улс | 64% |
| 2 | Эс Жи Капитал ХХК | Хувь нийлүүлэгч | Монгол улс | 0.004% |
| 3 | Ц.Худэрмөнх | Хувь нийлүүлэгч | Монгол улс | 6% |

## 26. Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ

*(төгрөгөөр)*

| № | Холбоотой талын нэр | Ажил гүйлгээний утга | 2020 | 2021 |
|---|---|---|---|---|
| 1 | Субашид Тек ХХК | Авлага, өглөг | | 81,194,000.00 |
| 2 | Ц.Худэрмөнх | Авлага, өглөг | | 4,021,500.00 |
| | Нийт дүн | | | 85,215,500.00 |

## 27. БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР БА ҮҮРЭГ

**Татварын хууль тогтоомжууд**

Монгол Улсын татварын зохицуулалттай холбоотой хууль тогтоомжууд нь өөр хоорондоо зөрүүтэйгээр тайлбарлагдах, мөн үе үе өөрчлөгдөх хандлагатай байдаг. Эдгээр хууль тогтоомжуудыг Компанийн ажил гүйлгээ болон үйл ажиллагаанд удирдлагын тайлбарлан хэрэгжүүлсэн байдал нь татварын байгууллагынхаас зөрөх магадлалтай.

Монгол улсын татварын байгууллагууд нь үүнд өөрсдийн тайлбар болон үнэлгээндээ илүү бат байр суурь баримталж болох ба урьд өмнө нь хэлэлцэж байгаагүй үйл ажиллагаа болон ажил гүйлгээг татварын байгууллага энд үгүйсгэж болно. Үүний үр дүнд мэдэгдэхүйц хэмжээний нэмэлт татвар, торгууль болон алданги ногдуулж болох талтай. Татварын байгууллага нь шалгаж буй тайлант жилээс өмнөх 5 хүртэлх жилийн хугацааны татварын асуудлыг сөхөж шалгах эрхтэй байдаг. Зарим тодорхой нөхцөл байдалд үүнээс ч өмнөх хугацааг хамран шалгах боломжтой юм.

Монгол улсын татварын хууль тогтоомжуудын, ялангуяа нэмэгдсэн өртгийн албан татвар, суутгагчийн албан татвар, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар болон бусад татварын хуулиудын зарим нэгэн заалтууд нь тодорхой тайлбар зааварчилгаагүй байдаг. Ийм зарим нэг тохиолдолд удирдлага нь эдгээр тайлбарлалт нь тодорхой бус байх боломжтой хууль тогтоомжуудыг Компанид ногдох татварын хувь хэмжээг бууруулах байдлаар тайлбарлан үнэлдэг. Дээр дурьдсаны дагуу сүүлийн үед бий болсон захиргааны болон шүүхийн практикын шинэчлэлийн үр дүнд дээрх тодорхой бус байдлын талаарх байр суурь улам хатуу хяналт шалгалтанд өртөж болно. Хэдийгээр Компанийн санхүүгийн байдал хийгээд нийт үйл ажиллагаанд томоохон нөлөө үзүүлэх боломжтой боловч татварын байгууллагын байр суурийг урьдчилан баттайгаар таамаглах боломжгүй болно. Энэ нь байгууллагын санхүүгийн байдал буюу нийт үйл ажиллагаанд мэдэгдэхүйц нөлөөтэй байх магадлалтай юм.

Удирдлага нь татварын эрсдэлийг тогтмол дахин үнэлж дүгнэдэг ба одооноос урьдчилан харах боломжгүй нөхцлүүдээс үүдэн Компанийн байр суурь өөрчлөгдөж болно.

ХАВСРАЛТ 4. Хууль зүйн дүгнэлт.

Нууц баримт
Эх хувь

ӨМГӨӨЛЛИЙН БАТБАЯР ЭНД ПАРТНЭРС ХХН

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө - 15, Монгол ТВ цамхаг, 10-р давхар, 1001-1003 тоот, Утас/Факс: (+976) 7711 9008, Цахим шуудан: contact@bnp.mn, Веб: www.bnp.mn

ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ц.ХҮДЭРМӨНХ ТАНАА

Огноо: 2022.03.03
Дугаар: BNP-13/22
Утга: Хуулийн дүгнэлт

ERDENES SOLUTIONS

## ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК-ИЙН НИЙТЭД САНАЛ БОЛГОН НЭМЖ ГАРГАЖ БУЙ ХУВЬЦААГ ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛД БҮРТГҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДУУЛАН БЭЛТГЭСЭН ХУУЛИЙН ДҮГНЭЛТ

Өмгөөллийн Батбаяр энд Партнэрс ХХН (цаашид **"Хуулийн фирм"** гэх) нь танай компанитай 2021 оны 12 сарын 16-ны өдөр байгуулсан №BNP-14/21 тоот Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээний дагуу Эрдэнэс Сольюшинс ХК (цаашид **"Үнэт цаас гаргагч"** эсхүл **"Компани"** гэх)-ийн нийтэд санал болгон нэмж гаргаж буй хувьцааг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд болон хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгүүлэхэд шаардагдах хөндлөнгийн дүн шинжилгээг хийж гүйцэтгэх, улмаар хуулийн дүгнэлт гаргах ажлыг хийхээр тохиролцсон. Уг ажилтай холбогдуулан Хуулийн фирмийн зүгээс Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн бирж ТӨХК (цаашид **"Монголын хөрөнгийн бирж"** гэх)-аас баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-д заасан асуудлын хүрээнд Үнэт цаас гаргагч Эрдэнэс Сольюшинс ХК-ийн үйл ажиллагаанд хөндлөнгийн дүн шинжилгээ хийж, хуулийн дүгнэлт (цаашид **"Хуулийн дүгнэлт"** гэх)-ийг бэлтгэж үүгээр хүргүүлж байна. Хүлээн авна уу.

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Эрдэнэс Сольюшинс ХК, түүний эрх бүхий албан тушаалтан болон төрийн эрх бүхий гуравдагч этгээдээс бусад этгээдийн хувьд нууц материалд тооцогдоно. Зөвшөөрөл аваагүй этгээд болон бусад эрх олгогдсон этгээд аливаа хэлбэрээр энэхүү нууц материалд агуулагдсан мэдээ, мэдээллийг хэсэгчлэн болон бүтнээр нь бусдад дамжуулсан, цааш түгээсэн, түгээх нөхцөл боломжийг бүрдүүлсэн, задруулсан бол үүссэн үр дагаврыг бүрэн хариуцахыг анхаарна уу.

Тус Хуулийн фирм нь энэхүү Эрдэнэс Сольюшинс ХК-аас нийтэд санал болгон нэмж гаргах хувьцааг үнэт цаасны бүртгэлд бүртгүүлэх үйл ажиллагаанд оролцож байгаа андеррайтерийн компани болох тэргүүлэх андеррайтер Гүүдсек ҮЦК ХХК, дэд андеррайтер Эс Жи Капитал ҮЦК ХХК, үнэлгээний компани болох Мөнх Оргил Трейд ХХК болон Үнэт цаас гаргагч Эрдэнэс Сольюшинс ХК, тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан, холбоотой этгээдүүдтэй аливаа байдлаар харилцан хамааралгүй бөгөөд ашиг сонирхлын хувьд холбоогүй болохыг үүгээр мэдэгдэж байна.

Хуулийн фирм нь Хар хорум пропертийс ХК-д Эрдэнэс Сольюшинс ХК-ийг нэгтгэх болон Эрдэнэс Сольюшинс ХК-ийн хувьцааг хуваасантай холбогдуулан хуулийн хөндлөнгийн дүн шинжилгээ хийж, Хуулийн дүгнэлт гаргаж ажилласан бөгөөд өмнөх хуулийн дүн шинжилгээ, Хуулийн дүгнэлт дээр үргэлжлүүлэн энэхүү дүн шинжилгээг хийсэн болохыг дурдаж байна.

Өмгөөллийн Батбаяр энд Партнэрс ХХН, бизнесийн хуулийн фирм нь үнэт цаасны зах зээлийн оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны №72 тоот тогтоолын дагуу авсан болно.

он сар өдөр
2023 05 25
№
2022 -03- 22
БҮРТГЭВ-03

Нууц баримт
Эх хувь

Хуулийн дүгнэлт гаргах үндэслэл, ажлын даалгавар

Эрдэнэс Сольюшинс ХК-ийн нийтэд санал болгон нэмж гаргаж буй хувьцааг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд болон хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгүүлэх, нэмж хувьцаа гаргаж Компанийн гаргасан хувьцааны тоо ширхэгт өөрчлөлт оруулах замаар Санхүүгийн зохицуулах хорооны бүртгэлд өөрчлөлт оруулахтай холбогдуулан Хуулийн фирм нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэгт "Үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээллийн үнэн зөв, хүчин төгөлдөр эсэхийг ... хууль зүйн зөвлөгөө үзүүлэх үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээр, ... тус тус хянуулж, дүгнэлт гаргуулна", 10.7 дахь хэсэгт "... хууль зүйн дүгнэлт нь тухайн үнэт цаасны танилцуулгын салшгүй хэсэг байна" болон Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны №225 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 11 дүгээр зүйлийн 11.14 дэх хэсэг, Монголын хөрөнгийн биржийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны №2018/01 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 2 дугаар зүйлийн 2.6 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн дараах асуудлуудыг Үнэт цаас гаргагч үйл ажиллагаандаа мөрдөж, хангаж буй эсэхэд хөндлөнгийн дүн шинжилгээ хийж, Хуулийн дүгнэлт гаргаж өгөхөөр тохиролцсон. Үүнд:

(i) Үнэт цаас гаргагч нь хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж, бүртгэгдсэн эсэх, Үнэт цаас гаргагчийн улсын бүртгэл, татвар төлөгчийн болон нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийн бүртгэлтэй холбоотой зөрчил байгаа эсэх болон үнэт цаас гаргах шийдвэр нь хуулийн дагуу гарсан эсэх;

(ii) Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомж болон Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Компанийн засаглалын кодекс"-т заасан шаардлага хангасан эсэх, тэдгээрийн удирдах чадвар, дадлага туршлагын байдал;

(iii) Компанийн дүрэм, бусад дотоод дүрэм, журмууд нь холбогдох хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Компанийн засаглалын кодекс"-т нийцсэн эсэх;

(iv) Бусадтай байгуулсан худалдах болон худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн гэрээ болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх, компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар байгаа эсэх;

(v) Сүүлийн 3 (гурван) жилийн дотор хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх;

(vi) Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой, сөргөөр нөлөөлж болохуйц нөхцөл буй эсэх;

(vii) Үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх;

(viii) Үнэт цаасыг бүртгүүлэх танилцуулгад тусгагдсан хууль зүйн мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх;

(ix) Компанийн толгой, охин, хараат, зэрэгцээ компанийн талаарх мэдээлэлд үндэслэн Үнэт цаас гаргагч компанийн хяналтыг хэрэгжүүлэгч, эцсийн өмчлөгч этгээдийг тодорхойлох;

(x) Үнэт цаас гаргагч нь аж ахуйн үйл ажиллагааны эсрэг гэмт хэрэг, иргэн, захиргааны хэрэгт хариуцагчаар татагдаж байсан эсэх;

(xi) Үнэт цаас гаргагч татвар, нийгмийн даатгал болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт өр төлбөртэй эсэх.

Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээгээр хүлээсэн Ажлын даалгаварт багтсанаас бусад асуудлаар Хуулийн фирм хууль зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэхгүй болно.



ERDENES SOLUTIONS Joint Stock Company
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК

Нууц баримт
Эх хувь

**Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон нэмж гаргаж байгаа хувьцааны тухай**

Үнэт цаас гаргагчийн үнэт цаас гаргах шийдвэрийн хувьд Компанийн тухай хуулийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа холбогдох зохицуулалтаас үзвэл компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол зарласан хувьцаанаас гүйлгээнд гаргах, компанийн дүрэмд заасан бусад төрлийн үнэт цаас болон өрийн бичиг гаргах тухай шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл гаргах зохицуулалттай байна[1].

Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчийн дүрмийн холбогдох зохицуулалтаас үзвэл Компанийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.10.12 дахь заалтад[2] Компанийн зарласан хувьцааны төрөл болон тоонд багтаан зарласан хувьцаанаас гүйлгээнд гаргах эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлд олгосон, 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэгт Компани зарласан энгийн хувьцаанаас гүйлгээнд гаргах, компанийн дүрэмд заасан бусад төрлийн үнэт цаас болон өрийн бичиг гаргах асуудлыг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэх эрхтэй байхаар зохицуулсан байна.

Эрдэнэс Сольюшинс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2022 оны 01 сарын 31-ний өдрийн №ТУЗТ02/2022 тоот "Нийтэд санал болгох энгийн хувьцааны тоо хэмжээ, нэгж энгийн хувьцааны үнийг тогтоох тухай" тогтоолын дагуу Компанийн зарласан хувьцаанаас 18,521,598 (арван найман сая таван зуун хорин нэгэн мянга таван зуун ерэн найм) хүртэлх энгийн хувьцааг нийтэд санал болгон нэмж эргэлтэд гаргах, нийтэд санал болгож буй энгийн хувьцааны нэг бүрийн үнийг 115 (нэг зуун арван таван) төгрөгөөр тогтоож шийдвэрлэсэн байна.

Үнэт цаас гаргагчийн эрх барих дээд байгууллага төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэр, тогтоол нь Компанийн тухай хуульд болон Компанийн дүрэмд нийцсэн, хуульд заасан шаардлагыг хангасан, Компанийн эрх барих дээд байгууллага нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд гаргасан шийдвэр байна гэж Хуулийн фирм үзлээ.

Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон нэмж гаргаж буй хувьцааг үнэт цаасны бүртгэл болон арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд бүртгэхийг зөвшөөрсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасан нөхцөл, журмын дагуу Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулж, Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн нэмэлт, өөрчлөлтийг тусгаж Компанийн

[1] **Компанийн тухай хууль (2011 он).**
33 дугаар зүйл.**Компанийн зарласан болон гаргасан хувьцаа**
33.1.Компанийн энгийн болон давуу эрхийн хувьцааны тоог компанийн дүрмээр тогтоох бөгөөд үүнийг зарласан хувьцаа гэнэ.
33.2.Зарласан хувьцаанаас хувьцаа эзэмшигчдийн худалдан авч эзэмшсэн хэсгийг эргэлтэд гаргасан хувьцаа гэнэ.
33.3.Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол зарласан хувьцааны төрөл тус бүрээс гаргах хувьцааны тоо, гаргах хугацаа, нөхцөлийг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ тогтооно.
42 дугаар зүйл.**Үнэт цаас гаргах тухай шийдвэр**
42.1.Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол зарласан хувьцаанаас гүйлгээнд гаргах, компанийн дүрэмд заасан бусад төрлийн үнэт цаас болон өрийн бичиг гаргах тухай шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ гаргах бөгөөд уг шийдвэрт үнэт цаасны төрөл, тоо, гаргах хугацаа, нөхцөлийг заана.
42.2.Компани зарласан энгийн хувьцааг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг нь гаргах үүрэгтэй.
42.3.Компани давуу эрхийн хувьцааг зарласан хэмжээгээр нь, эсхүл зарим хэсгийг нь гаргаж болохоос гадна тодорхой хугацаанд гаргахгүй байж болно.
42.4.Компани нийтэд худалдахаар гаргаж байгаа үнэт цаас болон хувьцаат компанийн нэмж гаргаж байгаа хувьцааг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлнэ.
[2] **Эрдэнэс Сольюшинс ХК-ийн дүрэм.**
Ес. **Төлөөлөн удирдах зөвлөл**
9.10. ТУЗ нь Компанийн тухай хууль, энэхүү дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулснаас бусад асуудал буюу дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
9.10.12.Компанийн зарласан хувьцааны төрөл болон тоонд багтаан зарласан хувьцаанаас гүйлгээнд гаргах.
5. **Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө, хувьцаа**
5.4. Компани нь нэг бүрийн 10 (арван) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 19,842,125,430 (арван есөн тэрбум найман зуун дөчин хоёр сая, нэг зуун хорин таван мянга дөрвөн зуун гучин) ширхэг зарласан энгийн хувьцааг хууль болон энэхүү дүрэмд заасан журмын дагуу гүйлгээнд гаргах эрхтэй байна. Зарласан энгийн хувьцаанаас гүйлгээнд гаргах, компанийн дүрэмд заасан бусад төрлийн үнэт цаас болон өрийн бичиг гаргах асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэх эрхтэй байна.

2022-03-22
БҮРТГЭВ-03

Нууц баримт
Эх хувь

дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж баталж, улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэхийг Хуулийн фирмээс зөвлөж байна.

**Дүн шинжилгээ хийсэн арга, аргачлал**

Энэхүү дүн шинжилгээг хийж гүйцэтгэхдээ Үнэт цаас гаргагчтай Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээгээр тохиролцсон асуудлын хүрээнд Үнэт цаас гаргагчийн гаргаж өгсөн баримт материалд үндэслэх зарчмыг баримталсан болно.

Дүн шинжилгээг хийхдээ хараат бус байх зарчмыг баримталсан бөгөөд Хуулийн дүгнэлт гаргахад ашиглах эх сурвалжийг сонгохдоо хөндлөнгийн гуравдагч этгээдээс олгосон/тодорхойлсон лавлагаа, тодорхойлолт, баримт бичиг болон гуравдагч этгээдтэй байгуулсан, солилцсон зэргээр Үнэт цаас гаргагчаас хараат бусаар баталгаажсан үйл баримтад үндэслэгдсэн байхыг удирдлага болгож ажилласан.

Хууль тогтоомжоор тодорхойлсон төрийн эрх бүхий байгууллагын бүрэн эрхэд хамаарах асуудлаар болон гадаад улсын хуулийг хэрэглэх асуудлаар Хуулийн фирм дүн шинжилгээ хийж дүгнэлт гаргаагүй бөгөөд холбогдох лавлагаа, тодорхойлолтыг гаргуулан авч дүн шинжилгээндээ ашигласан болохыг тусгайлан анхаарч Хуулийн дүгнэлтэд дурдагдаагүй асуудлаар Үнэт цаас гаргагчаас, лавлагаа тодруулга бүхий албан бичигт дурдагдсан асуудлаар тухайн шатны төрийн эрх бүхий байгууллагаас тодруулж лавлана уу.

Хууль тогтоомжид тусгагдсан хэм хэмжээ, заалт, нөхцөл, журмыг тодорхойлж ойлгохдоо хууль зүйн ач холбогдол бүхий үг, үгс, утгыг Улсын Дээд шүүхийн гаргасан албан ёсны тайлбар, түүнд тодорхойлсон утгын дагуу, хэрэв тухайн нөхцөлд хэрэглэх албан ёсны тайлбар, практик байхгүй нөхцөлд хууль зүйн шинжлэх ухаанд түгээмэл тогтсон утга агуулгыг ашигласан бөгөөд ердийн хэрэглээний оноосон нэрийг тухайн үгийн хэлзүйн шууд утга агуулгаар ойлгон, ашиглаж тайлбарласан.

Үнэт цаас гаргагчийн шилжүүлэн өгсөн цаасан болон электрон хэлбэртэй баримт бичигт агуулагдаж байгаа эх болон хуулбар баримт материал, тэдгээрт агуулагдаж байгаа мэдээлэл, хөндлөнгийн эрх бүхий байгууллагын гаргаж өгсөн лавлагаа, тодорхойлолт, баримт бичиг, түүнд агуулагдсан мэдээ, мэдээлэл, баримт, үйл баримтыг үнэн, зөв, хууль ёсны, хүчин төгөлдөр гэж үзэж ашигласан.

Хөндлөнгийн эрх бүхий байгууллагуудаас гаргуулан авсан лавлагаа, тодорхойлолт нь үнэн зөв бөгөөд дурдагдсан үйл баримт нь Хуулийн дүгнэлт гаргах өдрийг хүртэл хугацаанд хэвээр хадгалагдаж байгаа гэж үзсэн.

Хуулийн фирм нь төрийн эрх бүхий байгууллагаас гаргаж өгсөн лавлагаа, тодорхойлолтод тусгагдсан оноосон нэр томьёонууд харилцан адилгүй тусгагдсан байсныг нэг ижил формат, стандартад оруулж илэрхийлсэн болно.

Хуулийн дүгнэлтэд дурдсан хуулийн этгээдүүдийн оноосон нэрийг улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн оноосон нэрээр, төрийн эрх бүхий байгууллагуудын нэрийг тухайн лавлагаа, тодорхойлолт, албан бичигт ашиглагдсан оноосон нэрээр ашиглаж хэрэглэсэн болно.

Энэхүү Хуулийн дүгнэлтийг Монгол Улсын хууль тогтоомж, хэм хэмжээний актаар тогтоосон нөхцөл, журмын хүрээнд бэлтгэсэн.

**Хуулийн фирмийн мэдэгдэл**

Хуулийн фирм нь дүн шинжилгээг Үнэт цаас гаргагчийн хүлээлгэн өгсөн баримт бичиг, материал, тэдгээрт агуулагдсан баримтат мэдээллийн хүрээнд хийж гүйцэтгэсэн бөгөөд Үнэт цаас гаргагчаас үнэн зөв, бүрэн мэдээлэл өгсөн, холбогдох шилжүүлж өгсөн баримт бичгүүд нь үнэн зөв, хүчин төгөлдөр, жинхэнэ эх эсхүл жинхэнэ эхээс хуулбарлагдсан гэж үзэж, ашигласан болно.



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company

УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК

Нууц баримт
Эх хувь

Энэхүү Хуулийн дүгнэлт нь хөндлөнгийн дүн шинжилгээ хийсэн баримт бичиг бөгөөд Үнэт цаас гаргагч, түүнээс хүлээн авсан бусад этгээдийн хувьд заавал дагаж мөрдөх, мөрдөхийг шаардах эрх, үүрэг, хариуцлага үүсгэхгүй, хууль зүйн туслалцаа, зөвлөгөө үзүүлсэнд тооцогдохгүй.

Хуулийн фирм нь Гэрээгээр хүлээсэн ажлын даалгаварт тусгагдсанаас бусдаар Үнэт цаас гаргагч Эрдэнэс Сольюшинс ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт, хувьцаа эзэмшигчдийн бүтцийн өөрчлөлт, Компанийн оноосон нэрийг өөрчлөх, компанийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулах, хувьцаа хуваах зэрэг Компанийн өмнөх асуудлаар тусгайлан дүн шинжилгээ болохыг анхаарна уу.

Хуулийн фирм нь Компанийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулах, хувьцааг хуваахтай холбоотойгоор Үнэт цаас гаргагчийн хувьцааны бүртгэлд өөрчлөлт оруулсан өмнөх ажилд хуулийн хөндлөнгийн дүн шинжилгээ хийж гаргасан Хуулийн дүгнэлтээ үргэлжлүүлэн энэхүү Хуулийн дүгнэлтийг бэлтгэсэн бөгөөд Үнэт цаас гаргагчийн бусадтай байгуулсан гэрээ, хэлцлийн хувьд 2020 оны 09 сарын 01-ний өдрөөс эхлэн 2022 оны 01 сарын 01-ний өдрийн хооронд Эрдэнэс Сольюшинс ХК-ийн бусадтай бичгээр байгуулсан нийт гэрээ, хэлцлийг гаргуулан авч хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа гэрээ, хэлцэл болон 2020 оны 09 сарын 01-ний өдрөөс өмнө байгуулагдсан хэдий ч гэрээ, хэлцлийг тасалбар болгосон өдөр буюу 2022 оны 01 сарын 01-ний өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа нийт гэрээ, хэлцлийг сонгон авч дүн шинжилгээ хийсэн болохыг дурдаж байна.

Хуулийн фирм нь Компанийн нэгдмэл сонирхолтой этгээдийг тодорхойлохдоо Эрдэнэс Сольюшинс ХК-аас гаргаж өгсөн бүртгэл, баримт бичиг дээр үндэслэсэн бөгөөд эдгээр баримт материал нь Компанийн тухай хуулийн 89.1 дэх хэсэгт заасан шаардлагыг бүрэн хамарсан эсэх болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд хэлцэл хийхдээ компанид тухай бүр мэдээлэх үүргээ биелүүлсэн эсэх асуудлаар бие даан дүн шинжилгээ хийх, баталгаа гаргах боломжгүй байгааг анхаарна уу.

Хуулийн дүгнэлтийг зөвхөн энд дурдагдсан зорилгоор хийж гүйцэтгэсэн бөгөөд Үнэт цаас гаргагч нь өөр бусад зорилгоор ашиглах, хэсэгчлэн болон бүхлээр нь нийтэд дэлгэх, түгээх болон Хуулийн фирмийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөлт оруулахыг хориглоно.

Хуулийн дүгнэлтэд ашигласан баримт бичиг, тэдгээрт агуулагдсан мэдээлэлд Хуулийн дүгнэлт гаргасан өдрөөс хойш аливаа өөрчлөлт орсон бол Хуулийн фирм хариуцлага хүлээхгүй.

Хуулийн фирм нь илэрхий үг үсэг, утга найруулгын зөрүүнээс бусдаар Үнэт цаас гаргагчийн шилжүүлж өгсөн баримт бичгийн материалд агуулагдаж байгаа дараах асуудлыг үнэн зөв гэж үзэж дүгнэлт гаргасан болно. Үүнд:

- *Баримт бичигт агуулагдсан хүсэл зориг, гол санаа, дурдсан/дурдагдсан асуудал нь үндэслэлтэй, үнэн зөв, хууль ёсны дагуу илэрхийлэгдсэн, хүчин төгөлдөр;*
- *Баримт бичгүүд нь цаг хугацаандаа үйлдэгдсэн, үнэн, зөв, бүрэн, гарын үсэг зурсан этгээд нь хуулийн дагуу албан ёсоор төлөөлөх эрхтэй;*
- *Хуулийн дүгнэлт гаргах иш үндэслэл болсон баримт материалд дурдагдсан нөхцөл байдал нь Хуулийн дүгнэлт гаргаснаас хойш эсхүл тухайн баримт бичгийг үйлдсэн огноо, хугацаанаас хойш өөрчлөгдөөгүй бөгөөд аливаа байдлаар талуудын эрх ашигт сөргөөр нөлөөлөх үйл явдал үүсээгүй;*
- *Аливаа дарагдсан тэмдэг (тамга) нь үнэн, зөв, жинхэнэ, эрх бүхий ашиглах эрхтэй этгээдийн зөвшөөрлөөр дарагдсан.*

**Энэхүү Хуулийн дүгнэлт нь Эрдэнэс Сольюшинс ХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаасанд гаргасан аливаа төрлийн амлалт, баталгаанд тооцогдохгүй болохыг анхаарна уу.**

Үнэт цаас гаргагчийн бичгээр тавьсан хүсэлтийг үндэслэн Хуулийн фирм нь шаардлагатай гэж үзвэл Хуулийн дүгнэлтийн талаар гуравдагч этгээдэд нэмэлт тайлбар, тодруулга өгөх

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -03- 22
БҮРТГЭВ-03

СЗХ
2022.05.25
БҮРТГЭВ
№01



боломжтой болохыг дурдаж байна. Хуулийн фирмийн зүгээс өгөх нэмэлт тайлбар, тодруулга нь Үнэт цаас гаргагчийн зүгээс гаргасан ажлын даалгаварт тусгаснаас бусад асуудлаар нэмэлт дүн шинжилгээ хийх, тайлбар өгөх үүрэг үүсгэхгүй болно.

Хуулийн фирм нь дүн шинжилгээ хийхэд ашиглагдсан лавлагаа, тодорхойлолт, Үнэт цаас гаргагчийн гаргаж өгсөн аливаа баримт, материалд дурдагдсан үйл баримт, нөхцөл байдал Хуулийн фирмд мэдэгдэлгүйгээр өөрчлөгдсөн аливаа асуудлаар хариуцлага хүлээхгүй.

Энэхүү Хуулийн дүгнэлтийг Монгол Улсын хууль тогтоомж, хэм хэмжээний актаар тогтоосон нөхцөл, журмын хүрээнд бэлтгэсэн бөгөөд гадаад улсын хууль тогтоомж, хэм хэмжээг тайлбарлах, хэрэглэх, ашиглахтай холбоотой асуудал багтаагүй болохыг илэрхийлж байна.

**Хууль тогтоомж, хэм хэмжээний акт**

Хуулийн дүн шинжилгээг хийж гүйцэтгэхдээ энэхүү Хуулийн дүгнэлтийг бэлтгэж өгөх өдрийн байдлаар Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж, тэдгээрийг дагалдаж батлагдсан холбогдох хэм хэмжээний актуудыг үндэслэл болгон бэлтгэсэн.

**Дүн шинжилгээ, дүгнэлт**

Нэн тэргүүнд Үнэт цаас гаргагч Эрдэнэс Сольюшинс ХК-ийн эрх зүйн байдал, хувь нийлүүлсэн хөрөнгийн талаар тодруулж авч үзлээ.

Үнэт цаас гаргагчийн Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 04 сарын 29-ний өдрийн №ХЭХ04/2020 тоот шийдвэрээр Эрдэнэс Сольюшинс ХК-ийн дүрмийг баталсан байх бөгөөд хуулийн этгээдийн улсын бүртгэлд 2021 оны 02 сарын 02-ны өдөр бүртгэгдсэн байх тул Хуулийн фирмийн зүгээс хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дүрэм (**"Дүрэм"**) гэж үзэж энэхүү Хуулийн дүгнэлтийг бэлтгэлээ.

Дүрмийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэгт "Компани нь нээлттэй хувьцаат компани[3] болно" гэж Компани өөрийн эрх зүйн байдлыг тодорхойлсон байна.

Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хувьд Компанийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт "Компани нь нэг бүр нь 10 (арван) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 20,000,000,000 (хорин тэрбум) ширхэг зарласан энгийн хувьцаатай байх бөгөөд зарласан хувьцаа Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгөд хамаарахгүй ", 5.2 дахь хэсэгт "Компани нь зарласан нийт энгийн хувьцаанаас нэг бүр нь 10 (арван) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 157,874,570 (нэг зуун тавин долоон сая найман зуун далан дөрвөн мянга таван зуун далан) ширхэг гаргасан энгийн хувьцаатай байх бөгөөд Компанийн тухай хуулийн 30 дугаар зүйлд[4] заасан журмын дагуу Компани

[3] **Компанийн тухай хууль (2011).**
3 дугаар зүйл.**Компани, түүний хэлбэр**
3.1.Хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг, өөрийн тусгайлсан эд хөрөнгөтэй, үндсэн зорилго нь ашгийн төлөө хуулийн этгээдийг компани гэнэ.
3.2.Хувьцаа нь тухайн компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн өмчлөлд оролцох эрхийг нотлох бөгөөд харин компанийн эд хөрөнгийг тусгайлан өмчлөх эрхийг нотлохгүй.
3.3.Хувьцаа эзэмшигчийн эрхийг энэ хууль болон компанийн дүрмээр тогтоох бөгөөд хувьцаа эзэмшигч нь ногдол ашиг авах, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хэлэлцэж байгаа асуудлаар санал өгөх, компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх зэрэг үндсэн эрх эдэлнэ.
3.4.Компани нь хязгаарлагдмал хариуцлагатай болон хувьцаат компани гэсэн хэлбэртэй байна.
3.6.Хувьцаат компани нь нээлттэй болон хаалттай гэсэн төрөлтэй байна.
3.7."**Нээлттэй хувьцаат компани**" гэж хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, хувьцаа нь үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэгдэж, нийтэд чөлөөтэй арилжаалагддаг компанийг хэлнэ..
[4] **Компанийн тухай хууль (2011).**
30 дугаар зүйл.**Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө болон өөрийн хөрөнгө**
30.1.Тухайн компаниас хувьцаа эзэмшигчдэд эзэмшүүлсэн буюу гаргасан нийт давуу эрхийн болон энгийн хувьцааны нэрлэсэн үнийн дүнг компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө гэх бөгөөд компанийн хувь нийлүүлсэн хөрөнгөд тухайн компанийн зарласан болон эргүүлэн худалдаж авсан халаасны хувьцаа хамаарахгүй.
30.2.Компанийн балансад тусгагдсан биет болон биет бус хөрөнгийн дүнгээс компанийн нийт өр төлбөрийг хасаад үлдсэн хэсгийг компанийн өөрийн хөрөнгө гэнэ.



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company

УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК
5208173

Нууц баримт
Эх хувь

нь нийт 1,578,745,700 (нэг тэрбум таван зуун далан найман сая долоон зуун дөчин таван мянга долоон зуун) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байна" гэж тусгасан.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн 2022 оны 03 сарын 02-ны өдрийн №22900002000834 тоот Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн лавлагаанаас үзвэл Үнэт цаас гаргагч Эрдэнэс Сольюшинс ХК нь нэг бүр нь 10 (арван) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 157,874,570 (нэг зуун тавин долоон сая найман зуун далан дөрвөн мянга таван зуун далан) ширхэг энгийн хувьцаатай буюу 1,578,745,700 (нэг тэрбум таван зуун далан найман сая долоон зуун дөчин таван мянга долоон зуун) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, хэлбэрийн хувьд хувьцаат компани болохыг тодорхойлсон байна.

Иймд Компанийн хүчин төгөлдөр хэрэгжиж буй Дүрэм болон улсын бүртгэлийн дэлгэрэнгүй лавлагаанд тусгагдсан мэдээлэлд үндэслэн энэхүү Хуулийн дүгнэлтийг бэлтгэсэн болохыг дурдаж байна.

Хуулийн фирм нь дүн шинжилгээ хийхэд шаардлагатай хөндлөнгийн лавлагаа, тодорхойлолтыг эрх бүхий байгууллагуудаас гаргуулан авч, Үнэт цаас гаргагчаас гаргаж өгсөн баримт материал, тэдгээрт агуулагдсан мэдээлэлд дүн шинжилгээ хийгээд дараах байдлаар дүгнэж үзэх үндэслэлтэй гэж үзлээ.

**Нэг. Үнэт цаас гаргагч нь хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж, бүртгэгдсэн эсэх, Үнэт цаас гаргагчийн улсын бүртгэл, татвар төлөгчийн болон нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийн бүртгэлтэй холбоотой зөрчил байгаа эсэх болон үнэт цаас гаргах шийдвэр нь хуулийн дагуу гарсан эсэх асуудлаар:**

Монголын Хөрөнгийн бирж ТӨХК-ийн 2022 оны 01 сарын 14-ний өдрийн №01/25 тоот Лавлагаа хүргүүлэх тухай албан бичгээс үзвэл Монголын Хөрөнгийн бирж ТӨХК-д бүртгэлтэй Эрдэнэс Сольюшинс ХК нь 1992 оны 10 сарын 21-ний өдөр Амтлаг ХК оноосон нэртэйгээр нэг бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 90,038 (ерэн мянга гучин найман) ширхэг энгийн хувьцааг тус хөрөнгийн биржийн үнэт цаасны бүртгэлд бүртгүүлсэн байна. Үнэт цаасны бүртгэлд бүртгүүлснээс хойш Үнэт цаасны хорооны 1997 оны 02 сарын 27-ны өдрийн №18 тоот тогтоолыг үндэслэн тус Компанийн нэрийг Шимтлэг ХК болгон өөрчилсөн байна. Үүний дараа Үнэт цаасны хорооны 1998 оны 01 сарын 22-ны өдрийн №08 тоот тогтоолыг үндэслэн Шимтлэг ХК-ийн нийт гаргасан 90,038 (ерэн мянга гучин найман) ширхэг энгийн хувьцаанаас төрийн эзэмшлийн 53,843 (тавин гурван мянга найман зуун дөчин гурван) ширхэг хувьцааг тус хөрөнгийн биржийн үнэт цаасны бүртгэлээс хасаж шийдвэрлэсэн байна. Улмаар Монголын Хөрөнгийн бирж ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2016 оны 05 сарын 13-ны өдрийн №187 тоот тушаалаар Шимтлэг ХК-ийн оноосон нэрийг Хар хорум пропертийс ХК болгон өөрчилсөн байна. Мөн Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 02 сарын 28-ны өдрийн №80 тоот тогтоол, Монголын Хөрөнгийн бирж ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2020 оны 02 сарын 19-ний өдрийн №А/16 тоот тушаалаар Хар хорум пропертийс ХК-ийн гаргасан нэг бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 36,195 (гучин зургаан мянга нэг зуун ерэн таван) ширхэг хугацааг 15,751,262 (арван таван сая долоон зуун тавин нэгэн мянга хоёр зуун жаран хоёр) ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлэн нэг бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 15,787,457 (арван таван сая долоон зуун наян долоон мянга дөрвөн зуун тавин долоон) ширхэг энгийн хувьцаатай болгож, Компанийн оноосон нэрийг Эрдэнэс Сольюшинс ХК болгон өөрчилсөн болохыг тодорхойлсон байна.

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 01 сарын 07-ны өдрийн №9/74 тоот тодорхойлолтоос үзвэл Эрдэнэс Сольюшинс ХК нь нэг бүр нь 10 (арван) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 157,874,570 (нэг зуун тавин долоон сая найман зуун далан дөрвөн мянга таван зуун

30.3.Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь тухайн компанийн өөрийн хөрөнгийн хэмжээнээс илүүгүй байна.
[illegible]
30.4.Хуульд өөрөөр заагаагүй бол компанийг үүсгэн байгуулахад хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хязгаар тавихгүй.
30.5.Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг компанийн дүрэмд тусгасан байна.

2022 -03- 22
БҮРТГЭВ-03

2022.05.25
БҮРТГЭВ

Нууц баримт
Эх хувь

далан) ширхэг энгийн хувьцаатай буюу 1,578,745,700 (нэг тэрбум таван зуун далан найман сая долоон зуун дөчин таван мянга долоон зуун) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй бөгөөд Хорооноос үнэт цаасны арилжааг зогсоох, тусгаарлах болон аливаа албадлагын арга хэмжээ авч байгаагүй болохыг тодорхойлсон байна.

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн 2022 оны 01 сарын 12-ны өдрийн Үнэт цаас эзэмшигчдийн хураангуй судалгаанаас үзвэл Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид Эрдэнэс Сольюшинс ХК-ийн нэр дээр 157,874,570 (нэг зуун тавин долоон сая найман зуун далан дөрвөн мянга таван зуун далан) ширхэг хувьцаа бүртгэгдсэн бөгөөд 2022 оны 01 сарын 10-ны өдрийн байдлаар 241 (хоёр зуун дөчин нэгэн) хувьцаа эзэмшигчтэй болохыг тодорхойлсон байна.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн 2022 оны 03 сарын 02-ны өдрийн №22900002000834 тоот Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн лавлагаанаас үзвэл Үнэт цаас гаргагч Эрдэнэс Сольюшинс ХК (Улсын бүртгэлийн дугаар №9010001131, Регистрийн дугаар №: 2015358) нь нэг бүр нь 10 (арван) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 157,874,570 (нэг зуун тавин долоон сая найман зуун далан дөрвөн мянга таван зуун далан) ширхэг энгийн хувьцаатай буюу 1,578,745,700 (нэг тэрбум таван зуун далан найман сая долоон зуун дөчин таван мянга долоон зуун) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, хэлбэрийн хувьд хувьцаат компани болохыг тодорхойлсон байна.

Үнэт цаас гаргагчийн үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэлийн хувьд Эрдэнэс Сольюшинс ХК нь улсын бүртгэлийн №9010001131 тоот дугаартай, регистрийн №2015358 тоот дугаартай, эрхлэх үйл ажиллагааны чиглэл программ хангамжийн үйл ажиллагаа (62010), программ хангамж, компьютерын тоног төхөөрөмжийн худалдаа (47410), вэб сайт хийх (63120), вэб сайтаар онлайн худалдаа эрхлэх (47910), мэдээллийн технологийн үйл ажиллагаа (63990), худалдааны зуучлал (46100) үйл ажиллагаа эрхлэхээр улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж, улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглэгдсэн байгааг дурдаж байна.

Үнэт цаас гаргагчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээд буюу Гүйцэтгэх захирлаар Монгол Улсын иргэн Ц.Хүдэрмөнх бүртгэлтэй байна. Тэрээр Ц.Хүдэрмөнх нь Эрдэнэс Сольюшинс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 03 сарын 06-ны өдрийн №ТУЗТ03/2020 тоот тогтоолоор Эрдэнэс Сольюшинс ХК-ийн Гүйцэтгэх захирлын албан тушаалд томилогдсон бөгөөд Гүйцэтгэх захирлаар томилогдсон бүртгэлийг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд 2020 оны 03 сарын 16-ны өдөр бүртгэгдэж, тэмдэглэгдсэн байгааг дурдаж байна.

Эдгээр хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний өөрчлөлт, хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлт, гүйцэтгэх удирдлагын мэдээлэл, оноосон нэр өөрчлөлт, шинээр эрхлэх үйл ажиллагааны чиглэл, тамга, тэмдгийн хяналтын дугаар олголт болон хуулийн компанийн өөрчлөн байгуулалттай холбоотойгоор гаргасан өөрчлөлт хийх үндэслэл болсон тогтоол, шийдвэр, Компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлт нь холбогдох хуульд нийцсэн, бичгээр хийгдсэн, гарын үсэг зурах эрхтэй этгээд баталсан, хүчин төгөлдөр баримт бичиг байх бөгөөд тухай бүр бүртгэлийн байгууллагад бүртгүүлж байсан байна.

**Нэгтгэн дүгнэж үзвэл Үнэт цаас гаргагч Эрдэнэс Сольюшинс ХК нь хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж, бүртгэгдсэн байна гэж үндэслэлтэй байна.**

Мөн энэхүү шалгуур асуултын хүрээнд Хуулийн фирм нь Монголын Хөрөнгийн биржийн Үнэт цаасны бүртгэлийн журмын 2 дугаар зүйлийн 2.6.1 дэх заалтад заасан Үнэт цаас гаргагчийн улсын бүртгэл, татвар төлөгчийн болон нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийн бүртгэлтэй холбоотой зөрчил байгаа эсэх асуудлыг тодруулж төрийн эрх бүхий байгууллагад хандан дэлгэрэнгүй лавлагаа, тодорхойлолт гаргаж өгөхийг хүссэн.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн 2022 оны 03 сарын 02-ны өдрийн №22900002000834 тоот Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн лавлагаанаас үзвэл Компанийн үндсэн мэдээлэл,



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company
9020080899 2015

УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК
ТБ0374 Д 5208173

2022 -03- 22
БҮРТГЭВ-03

Нууц баримт
Эх хувь

хаягийн мэдээлэл, хувьцаа эзэмшигч, гишүүний мэдээлэл, гүйцэтгэх удирдлагын мэдээлэл, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний өөрчлөлт, хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлт, эцсийн өмчлөгчийн өөрчлөлт, өөрчлөн зохион байгуулагдсан мэдээлэл, Компанийн үүсгэн байгуулах баримт бичиг, мэдээлэлд оруулсан өөрчлөлт бүртгэгдэж, тэмдэглэсэн байх тул Үнэт цаас гаргагч нь холбогдох бүртгэлийг улсын бүртгэлд бүртгүүлсэн байна гэж үзэх үндэслэлтэй гэж үзлээ.

Монголын татварын албаны 2022 оны 01 сарын 20-ны өдрийн №22.1003.3ba224a8-db4d-4388-92b6-10e2a55af5cd QR код бүхий тодорхойлолт, №220120020196 дугаартай татвар төлөгчийн гэрчилгээ болон Монголын татварын албаны 2022 оны 01 сарын 20-ны өдрийн №22.1003.8ef6bd8d-7ee9-44ae-ba9c-96990ed26cb1 QR код бүхий татвар төлөгчийн картаас үзвэл Эрдэнэс Сольюшинс ХК-ийн татвар төлөгч хуулийн этгээдийн бүртгэгдсэн татварын төрлийн мэдээллийн бүртгэлийн цахим тодорхойлолтод үндэслэн Үнэт цаас гаргагч нь холбогдох татварын албанд бүртгэлтэй, татвар төлөгчийн бүртгэлтэй холбоотой зөрчил байхгүй байна гэж үзсэн болно.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2022 оны 01 сарын 20-ны өдрийн №O221AW27K260023477642 тоот Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолтоос үзвэл Эрдэнэс Сольюшинс ХК нь нийгмийн даатгалын хэлтэст бүртгэлтэй байх тул нийгмийн даатгалын байгууллагад бүртгэлтэй холбоотой зөрчил байхгүй байна гэж үзлээ.

Эрдэнэс Сольюшинс ХК-тай холбогдуулан эрх бүхий байгууллагаас гаргуулан авсан лавлагаа, тодорхойлолтын эх хувийг энэхүү Хуулийн дүгнэлтэд хавсаргасан бөгөөд **Хавсралт №05. "Эрдэнэс Сольюшинс ХК-тай холбогдуулан эрх бүхий байгууллагаас авсан хөндлөнгийн лавлагаа, тодорхойлолт"** хүснэгтээс дэлгэрүүлэн үзнэ үү.

**Дүгнэж үзвэл Үнэт цаас гаргагч нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн байгууллага, татвар, нийгмийн даатгалын байгууллагад бүртгүүлсэн байх бөгөөд бүртгэлтэй холбоотой аливаа зөрчил байхгүй байна гэж Хуулийн фирмээс үзлээ.**

Үнэт цаас гаргагчийн үнэт цаас гаргах шийдвэрийн хувьд Компанийн тухай хуулийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа холбогдох зохицуулалтаас үзвэл компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол зарласан хувьцаанаас гүйлгээнд гаргах, компанийн дүрэмд заасан бусад төрлийн үнэт цаас болон өрийн бичиг гаргах тухай шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл гаргах зохицуулалттай байна[5].

Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчийн дүрмийн холбогдох зохицуулалтаас үзвэл Компанийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.10.12 дахь заалтад[6] Компанийн

[5] **Компанийн тухай хууль (2011 он).**
33 дугаар зүйл.**Компанийн зарласан болон гаргасан хувьцаа**
33.1.Компанийн энгийн болон давуу эрхийн хувьцааны тоог компанийн дүрмээр тогтоох бөгөөд үүнийг зарласан хувьцаа гэнэ.
33.2.Зарласан хувьцаанаас хувьцаа эзэмшигчдийн худалдан авч эзэмшсэн хэсгийг эргэлтэд гаргасан хувьцаа гэнэ.
33.3.Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол зарласан хувьцааны төрөл тус бүрээс гаргах хувьцааны тоо, гаргах хугацаа, нөхцөлийг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ тогтооно.
42 дугаар зүйл.**Үнэт цаас гаргах тухай шийдвэр**
42.1.Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол зарласан хувьцаанаас гүйлгээнд гаргах, компанийн дүрэмд заасан бусад төрлийн үнэт цаас болон өрийн бичиг гаргах тухай шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ гаргах бөгөөд уг шийдвэрт үнэт цаасны төрөл, тоо, гаргах хугацаа, нөхцөлийг заана.
42.2.Компани зарласан энгийн хувьцааг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг нь гаргах үүрэгтэй.
42.3.Компани давуу эрхийн хувьцааг зарласан хэмжээгээр нь, эсхүл зарим хэсгийг нь гаргаж болохоос гадна тодорхой хугацаанд гаргахгүй байж болно.
42.4.Компани нийтэд худалдахаар гаргаж байгаа үнэт цаас болон хувьцаат компанийн нэмж гаргаж байгаа хувьцааг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлнэ.
[6] **Эрдэнэс Сольюшинс ХК-ийн дүрэм.**
Ес. **Төлөөлөн удирдах зөвлөл**
9.10. **ТУЗ** нь Компанийн тухай хууль, энэхүү дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулснаас бусад асуудал буюу дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
9.10.12.Компанийн зарласан хувьцааны төрөл болон тоонд багтаан зарласан хувьцаанаас гүйлгээнд гаргах.
**5. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө, хувьцаа**
5.4. Компани нь нэг бүрийн 10 (арван) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 19,842,125,430 (арван есөн тэрбум найман зуун дөчин хоёр сая, нэг зуун хорин таван мянга дөрвөн зуун гучин) ширхэг зарласан энгийн хувьцааг хууль болон энэхүү дүрэмд заасан журмын дагуу



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕН
ТТБ0674 дд.5208173

2022 -03- 22
БҮРТГЭВ-03
Нууц баримт
Эх хувь

зарласан хувьцааны төрөл болон тоонд багтаан зарласан хувьцаанаас гүйлгээнд гаргах эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлд олгосон, 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэгт Компани зарласан энгийн хувьцаанаас гүйлгээнд гаргах, компанийн дүрэмд заасан бусад төрлийн үнэт цаас болон өрийн бичиг гаргах асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэх эрхтэй байхаар зохицуулсан байна.

Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2022 оны 01 сарын 31-ний өдрийн №ТУЗТ02/2022 тоот "Нийтэд санал болгох энгийн хувьцааны тоо хэмжээ, нэгж энгийн хувьцааны үнийг тогтоох тухай" тогтоолоор Компанийн зарласан хувьцаанаас 18,521,598 (арван найман сая таван зуун хорин нэгэн мянга таван зуун ерэн найм) хүртэлх энгийн хувьцааг нийтэд санал болгон нэмж эргэлтэд гаргахыг зөвшөөрч, нийтэд санал болгож буй энгийн хувьцааны нэг бүрийн үнийг 115 (нэг зуун арван таван) төгрөгөөр тогтоож шийдвэрлэсэн байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол, шийдвэрийн хувьд Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.5 дахь зүйлд "Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал гишүүдийнх нь дийлэнх олонх оролцсоноор хүчин төгөлдөр болно", 80.6 дахь хэсэгт "хуульд өөрөөр заагаагүй, эсхүл компанийн дүрмээр тусгайлан өндөр хувь тогтоогоогүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оролцож байгаа гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно", 80.9 дахь хэсэгт "төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар асуудал шийдвэрлэхэд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн бүр саналын нэг эрхтэй байна" гэж тус тус заасан байна. Эрдэнэс Сольюшинс ХК-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.11 дэх хэсэгт "Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд нийт гишүүний 2/3 нь оролцсоноор хүчин төгөлдөр болж, хуралд оролцсон саналын эрхтэй гишүүдийн дийлэнх олонхын саналаар хурлын шийдвэр хүчин төгөлдөр болно", 9.12 дахь хэсэгт "Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд аливаа асуудлыг шийдвэрлэхэд гишүүн бүр саналын нэг эрхтэй байна", 9.13 дахь хэсэгт "Тухайн шийдвэрлэж буй асуудлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн зарим гишүүд Компанийн тухай хуульд заасны дагуу санал өгөх эрхгүй бол шийдвэрийг саналын эрхтэй гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэнэ" гэж Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол, шийдвэр хүчин төгөлдөр болох нөхцөл, саналын тоо, хэмжээг зохицуулсан. Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2022 оны 01 сарын 31-ний өдрийн №ТУЗТ02/2022 тоот тогтоолоос үзвэл Төлөөлөн удирдах зөвлөлийн 100 (зуун) хувийн саналаар шийдвэрлэж, гарын үсэг зурагдсан байх тул төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол нь хүчин төгөлдөр байна гэж үзлээ.

Иймд Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нийтэд санал болгох энгийн хувьцааны тоо хэмжээ, нэгж энгийн хувьцааны үнийг тогтоох тухай шийдвэр нь Компанийн тухай хуульд болон Компанийн дүрэмд нийцсэн, хуульд заасан шаардлагыг хангасан Компанийн эрх барих байгууллага өөрийн бүрэн эрхийн хүрээнд гаргасан шийдвэр байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон нэмж гаргасан хувьцааг үнэт цаасны бүртгэл болон арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд бүртгэхийг зөвшөөрсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасан нөхцөл, журмын дагуу Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулж, Компанийн дүрмийн шинэчилсэн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж батлаж, улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэхийг Хуулийн фирмээс зөвлөж байна.

**Хоёр. Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомж болон Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Компанийн засаглалын кодекс"-т заасан шаардлага хангасан эсэх, тэдгээрийн удирдах чадвар, дадлага туршлагын байдал асуудлын хувьд үзвэл:**

Хуулийн фирм нь Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомж болон Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Компанийн засаглалын кодекс"-т заасан шаардлага хангасан эсэх, тэдгээрийн удирдах

гүйлгээнд гаргах эрхтэй байна. Зарласан энгийн хувьцаанаас гүйлгээнд гаргах, компанийн дүрэмд заасан бусад төрлийн үнэт цаас болон өрийн бичиг гаргах асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэх эрхтэй байна.



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК

Нууц баримт
Эх хувь

чадвар, дадлага туршлагатай холбоотойгоор тус Компаниас гаргаж өгсөн баримт материалд үндэслэн дүн шинжилгээ хийлээ.

Үнэт цаас гаргагчийн Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 01 сарын 24-ний өдрийн ээлжит бус хурлын №ХЭХ03/2020 тоот шийдвэрээр Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр Ц.Худэрмөнх, Т.Золбоо, Б.Батхүү, Ц.Хишигбаатар, Э.Цэндсүрэн, Г.Аззаяа, хараат бус гишүүдээр Б.Энхзориг, С.Энхжаргал, П.Нарантунгалаг нарыг 3 (гурван) жилийн хугацаатайгаар кумулятив аргаар тус тус сонгосон байна.

Эрдэнэс Сольюшинс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 01 сарын 28-ны өдрийн №ТУЗТ02/2020 тоот тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Т.Золбоог сонгосон байгааг дурдаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөл

Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн зохицуулалтын хүрээнд үзвэл хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь төлөөлөн удирдах зөвлөл[7] байх бөгөөд хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоог компанийн дүрмээр тогтоохоор[8] нарийвчлан зохицуулсан.

Хуулийн зохицуулалтын дагуу авч үзвэл Үнэт цаас гаргагч Эрдэнэс Сольюшинс ХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт "Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт", 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт "Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь нийт 9 гишүүнтэй байх бөгөөд Компанийн тухай хуулийн 75.4-д зааснаар тэдгээрийн 1/3-ээс доошгүй нь хараат бус гишүүн байна" гэж заасан байх бөгөөд эдгээр зохицуулалт нь дээрх хууль тогтоомжид нийцсэн байна гэж үзэх үндэслэлтэй байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, бүрэлдэхүүний хувьд авч үзвэл энэхүү Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар Эрдэнэс Сольюшинс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

*Хүснэгт №01. Эрдэнэс Сольюшинс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд.*

| № | Овог, нэр | Албан тушаал |
|---|---|---|
| 1. | Төмөрболдын Золбоо | Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга |
| 2. | Цогтбаярын Худэрмөнх | Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн |
| 3. | Цэрэндуламын Хишигбаатар | Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн |
| 4. | Галбадрахын Аззаяа | Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн |
| 5. | Эрдэнээгийн Цэндсүрэн | Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн |
| 6. | Базарын Батхүү | Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн |
| 7. | Бавуужамцын Энхзориг | Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн |
| 8. | Сумбараагийн Энхжаргал | Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн |
| 9. | Пүрэвдоржийн Нарантунгалаг | Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн |

[7] Компанийн тухай хууль (2011).
75 дугаар зүйл.Төлөөлөн удирдах зөвлөл
75.1.Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь төлөөлөн удирдах зөвлөл байна.
75.2.Хувьцаат компани нь төлөөлөн удирдах зөвлөлтэй байх бөгөөд хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлгүй байж болно.
[8] 75.3.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоог компанийн дүрмээр тогтооно.
75.4.Хувьцаат компани болон төрийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна.
75.8.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна.

СЗХ
2022-05-25
№ 01

MONGOLIAN STOCK EXCHA
2022-05-22
БҮРТГЭВ-03

Нууц баримт
Эх хувь

**Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга**

**Т.Золбоо** нь Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 01 сарын 24-ний өдрийн ээлжит бус хурлын №ХЭХ 03/2020 тоот шийдвэрээр Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдсон. Улмаар Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 01 сарын 28-ний өдрийн №ТУЗТ02/2020 тоот тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар сонгогдсон байна. Тэрээр Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Компьютерын техник, менежментийн сургуулийг 2007 онд программ хангамж мэргэжлээр бакалаврын зэрэгтэй, 2012 онд магистр зэрэгтэйгээр тус тус төгссөн. Т.Золбоо нь 2006-2007 онд Каракас зураг ХХК-д программист, 2007-2009 онд МИАТ ХК-д программист, 2009-2010 онд Алтан тариа ХК-д системийн шинжээчээр тус тус ажиллаж байсан. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Мэдээлэл холбооны технологийн сургуульд 2010 оноос хойш багшаар ажиллаж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Т.Золбоо нь Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга нарт зориулсан Компанийн засаглалын сургалтад 2020 оны 01 сард хамрагдаж №0430728 дугаартай гэрчилгээ авсан байна.

**Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд**

**Ц.Хүдэрмөнх** нь Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 01 сарын 24-ний өдрийн ээлжит бус хурлын №ХЭХ03/2020 тоот шийдвэрээр Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдсон. Тэрээр Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Компьютерын техник, менежментийн сургуулийг 2007 онд программ хангамж мэргэжлээр бакалаврын зэрэгтэйгээр төгссөн. Ц.Хүдэрмөнх нь 2009-2016 онд ХасБанкинд систем хөгжүүлэгч, систем дизайнер, системийн шинжээч, системийн ахлах шинжээч, төслийн удирдагч, бизнесийн ахлах шинжээч, 2016-2018 онд Бодь даатгал ХК-д системийн шинжээч, цахим банкны хэлтсийн захирал, ISOL ХХК-д мэдээллийн технологийн хэлтсийн захирлаар тус тус ажиллаж байгаад Эрдэнэс Сольюшинс ХК-ийн Гүйцэтгэх захирлаар 2019 оноос хойш өнөөдрийг хүртэл ажиллаж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн Ц.Хүдэрмөнх нь Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга нарт зориулсан Компанийн засаглалын сургалтад 2020 оны 01 сард хамрагдаж №0430729 дугаартай гэрчилгээ авсан байна.

**Ц.Хишигбаатар** нь Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 01 сарын 24-ний өдрийн ээлжит бус хурлын №ХЭХ03/2020 тоот шийдвэрээр Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдсон. Тэрээр Ховд аймгийн арван жилийг 1989 онд төгссөн бүрэн дунд боловсролтой. Одоогоор хувиараа ажиллаж байгаа. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн Ц.Хишигбаатар нь Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга нарт зориулсан Компанийн засаглалын сургалтад 2020 оны 01 сард хамрагдаж №0430732 дугаартай гэрчилгээ авсан байна.

**Г.Аззаяа** нь Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 01 сарын 24-ний өдрийн ээлжит бус хурлын №ХЭХ03/2020 тоот шийдвэрээр Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдсон. Тэрээр Нийслэлийн Оюуны үндраа цогцолбор сургуулийг 1998 онд төгссөн бүрэн бус дунд боловсролтой бөгөөд Союз номин ХХК-д 2006 оноос хойш харуулын захирлаар ажиллаж байгаа. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн Г.Аззаяа нь Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга нарт зориулсан Компанийн засаглалын сургалтад 2020 оны 01 сард хамрагдаж №0430730 дугаартай гэрчилгээ авсан байна.

**Э.Цэндсүрэн** нь Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 01 сарын 24-ний өдрийн ээлжит бус хурлын №ХЭХ 03/2020 тоот шийдвэрээр Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдсон. Тэрээр Япон улсын Шинсү Их Сургуулийг 2009 онд барилга, дэд бүтцийн инженер мэргэжлээр бакалаврын зэрэгтэйгээр төгссөн. Э.Цэндсүрэн нь 2009-2011 онд Говь ХК-д үйлдвэр хариуцсан ахлах менежер, 2011-2011 онд Бридж групп-д Технологийн инженер, 2011-2015 онд Таван богд трейд ХХК-д брэнд менежер, төслийн менежер, 2015-2017 онд Монос Улаанбаатар ХХК-д төслийн менежерээр тус тус ажиллаж байсан. 2019 оноос хойш Шинэ Монгол Коосэн технологийн коллеж-д Гүйцэтгэх захирлаар ажиллаж байгаа. Төлөөлөн удирдах зөвлөлийн

ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company

УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК

СЗХ 2022.05.25 БҮРТГЭВ
2022-03-22 БҮРТГЭВ-03

Нууц баримт
Эх хувь

ердийн гишүүн Э.Цэндсүрэн нь Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга нарт зориулсан Компанийн засаглалын сургалтад 2020 оны 01 сард хамрагдаж №0430731 дугаартай гэрчилгээ авсан байна.

**Б.Батхүү** нь Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 01 сарын 24-ний өдрийн ээлжит бус хурлын №ХЭХ03/2020 тоот шийдвэрээр Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдсон. Тэрээр 1997 онд Санхүү эдийн засгийн их сургуулийг банк санхүүгийн мэргэжлээр бакалавр зэрэгтэйгээр төгссөн. Б.Батхүү нь 1996-2004 онд Худалдаа, Хөгжлийн банкинд эдийн засагч, ахлах эдийн засагч, Үйл ажиллагаа хариуцсан захирал, 2004-2007 онд Улаанбаатар хотын банкинд Хөрөнгө зохицуулалтын газрын захирал, Дэд захирал, Гүйцэтгэх захирал, 2009-2011 Капитрон банкинд Гүйцэтгэх захирлын зөвлөх, Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн Ажлын Албанд банк санхүү хариуцсан референтээр тус тус ажиллаж байсан. 2011 оноос хойш Экспонэйншл фанд менежмент ҮЦК ХХК-д Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн Б.Батхүү нь Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга нарт зориулсан Компанийн засаглалын сургалтад 2016 оны 10 сард хамрагдаж №0430452 дугаартай гэрчилгээ авсан байна.

**Б.Энхзориг** нь Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 01 сарын 24-ний өдрийн ээлжит бус хурлын №ХЭХ03/2020 тоот шийдвэрээр Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдсон. Тэрээр Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Компьютерын техник, менежментийн сургуулийг 2007 онд программ хангамж мэргэжлээр бакалаврын зэрэгтэйгээр, Хүмүүнлэгийн ухааны их сургуулийг 2013 онд англи хэлний орчуулагч мэргэжлээр бакалаврын зэрэгтэйгээр, Санхүү эдийн засгийн их сургуулийг 2016 онд Бизнесийн удирдлага мэргэжлээр магистрын зэрэгтэйгээр тус тус төгссөн. Б.Энхзориг нь 2006-2007 онд Хасабэ интернэйшнл ХХК-д захиргааны ажилтан, 2008-2011 онд Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яаманд НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн төслийн нарийн бичгийн дарга, 2011-2014 онд Швейцарын хөгжлийн агентлагт Монголын хөгжил судлалын төвд төслийн менежерээр тус тус ажиллаж байсан. 2014 оноос хойш Санхүү эдийн засгийн их сургуульд сургалтын менежер багшаар ажиллаж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Б.Энхзориг нь Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга нарт зориулсан Компанийн засаглалын сургалтад 2020 оны 01 сард хамрагдаж №0430727 дугаартай гэрчилгээ авсан байна.

**С.Энхжаргал** нь Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 01 сарын 24-ний өдрийн ээлжит бус хурлын №ХЭХ03/2020 тоот шийдвэрээр Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдсон. Тэрээр Улаанбаатар их сургуулийг 2002 онд дүрслэх урлаг дизайн мэргэжлээр бакалаврын зэрэгтэйгээр төгссөн. С.Энхжаргал нь 2003 онд Говь ХК-д дизайнер, 2004 онд Эдмон ХХК-д дизайнер, 2008-2019 онд Мон хорус интернэйшнл ХХК-д гэрээт дизайнераар тус тус ажиллаж байсан. 2019 оноос хойш Авто ойл ХХК-д гэрээт дизайнераар ажиллаж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн С.Энхжаргал нь Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга нарт зориулсан Компанийн засаглалын сургалтад 2020 оны 01 сард хамрагдаж №0430726 дугаартай гэрчилгээ авсан байна.

**П.Нарантунгалаг** нь Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 01 сарын 24-ний өдрийн ээлжит бус хурлын №ХЭХ03/2020 тоот шийдвэрээр Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдсон. Тэрээр Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Компьютерын техник, менежментийн сургуулийг 2007 онд программ хангамж мэргэжлээр бакалаврын зэрэгтэйгээр төгссөн. П.Нарантунгалаг нь 2007-2012 онд Интерактив ХХК-д программист мэргэжлээр ажиллаж байсан. 2012 оноос хойш ХасБанкинд систем аналистаар ажиллаж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн П.Нарантунгалаг нь Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга нарт зориулсан Компанийн засаглалын сургалтад 2020 оны 01 сард хамрагдаж №0430725 дугаартай гэрчилгээ авсан байна.



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК ERDENES SOLUTIONS Joint Stock Company
УЛААНБААТАР ХОТ ГҮЙДСЕК ҮЦК ХХК ТТБ0674 ш. 5208173

СЗХ 2022.05.25 БҮРТГЭВ

2022-03-22 БҮРТГЭВ-03

Нууц баримт
Эх хувь

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод

Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн зохицуулалтын хүрээнд үзвэл Хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын, цалин, урамшууллын, нэр дэвшүүлэх хороодтой байх бөгөөд эдгээр хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээс бүрдэх[9], аудитын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн байх[10], Хороо нь тухайн үйл ажиллагааг явуулах өндөр ур чадвар бүхий мэргэшсэн, туршлагатай 3-аас доошгүй гишүүдтэй байх...[11]" гэж зохицуулсан байна.

Эрдэнэс Сольюшинс ХК-аас Хуулийн фирмд гаргаж өгсөн мэдээллийг шалгахад Үнэт цаас гаргагчийн 2020 оны 01 сарын 24-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн нь Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 01 сарын 28-ны өдрийн №ТУЗТ02/2020 тоот тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороодын гишүүдийг шинэчлэн томилсон бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

*Хүснэгт №02. Эрдэнэс Сольюшинс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хорооны гишүүд.*

| № | Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороо | Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын гишүүд | Төлөв |
|---|---|---|---|
| 1. | Цалин, урамшууллын хороо | Т.Золбоо | Хорооны дарга |
| | | С.Энхжаргал | Гишүүн |
| | | Б.Энхзориг | Гишүүн |
| 2. | Аудитын хороо | П.Нарантунгалаг | Хорооны дарга |
| | | С.Энхжаргал | Гишүүн |
| | | Э.Цэндсүрэн | Гишүүн |
| 3. | Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо | Б.Энхзориг | Хорооны дарга |
| | | Ц.Худэрмөнх | Гишүүн |
| | | П.Нарантунгалаг | Гишүүн |

Мөн Үнэт цаас гаргагчийн аудитын хорооны даргаар Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 01 сарын 24-ний өдрийн ээлжит бус хурлын №ХЭХ03/2020 тоот шийдвэрээр Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдсон П.Нарантунгалагийг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 01 сарын 28-ны өдрийн №ТУЗТ02/2020 тоот тогтоолоор Аудитын хорооны даргаар томилсон байна.

Дээр дурдсан хүснэгт дэх мэдээлэл болон Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн баримт материалд үндэслэн Үнэт цаас гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод нь холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байна гэж үзэхээр байна.

Эрх бүхий албан тушаалтан

Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1 дэх хэсэгт "Компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга зэрэг компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд

[9] Компанийн тухай хууль (2011).
81 дүгээр зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороо
81.1.Төлөөлөн удирдах зөвлөл нь шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог байгуулж болно.
81.2.Хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын, цалин, урамшууллын, нэр дэвшүүлэх хороодтой байх бөгөөд эдгээр хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээс бүрдэнэ.
[10] 81.4.Энэ хуулийн 81.2-т заасан аудитын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн байх...
[11] Компанийн засаглалын кодекс (2014).
5.2.3 Хороо нь тухайн үйл ажиллагааг явуулах өндөр ур чадвар бүхий мэргэшсэн, туршлагатай 3-аас доошгүй гишүүдтэй байх...



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК ERDENES SOLUTIONS Joint Stock Company 2080899 2015

УЛААНБААТАР ХОТ ГҮҮДСЕК ҮЦК ХХК ТТБ8674 5208173

Нууц баримт
Эх хувь

болон шууд бусаар оролцдог этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно" гэж хуульчилсан байдаг бөгөөд хуулийн этгээд өөрийн үүсгэн байгуулах баримт бичиг буюу дүрмээрээ илүү нарийвчлан тодорхойлох эсхүл албан тушаалаар нэр заан тодорхойлох боломжийг олгосон байдаг.

Үнэт цаас гаргагч Эрдэнэс Сольюшинс ХК-ийн Дүрмийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт "Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, Гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргыг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно" гэж тусгасан байна. Тус нөхцөл, журмыг удирдлага болгон Хуулийн фирмд ирүүлсэн баримт материалд үндэслэн дараах эрх бүхий албан тушаал буюу ажлын байр, орон тоо Эрдэнэс Сольюшинс ХК-ийн бүтцэд байна гэж үзлээ. Үүнд:

*Хүснэгт №03. Эрх бүхий албан тушаалын ажлын байрны мэдээлэл.*

| № | Эрх бүхий албан тушаалтны овог, нэр | Албан тушаал | Орон тоо |
|---|---|---|---|
| 1. | Төмөрболдын Золбоо | Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга | 1 |
| 2. | Цогтбаярын Хүдэрмөнх | Гүйцэтгэх захирал, Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн | 1 |
| 3. | Цэрэндуламын Хишигбаатар | Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн | 1 |
| 4. | Галбадрахын Аззаяа | Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн | 1 |
| 5. | Эрдэнэзэгийн Цэндсүрэн | Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн | 1 |
| 6. | Базарын Батхүү | Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн | 1 |
| 7. | Бавуужамцын Энхзориг | Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн | 1 |
| 8. | Сумбараагийн Энхжаргал | Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн | 1 |
| 9. | Пүрэвдоржийн Нарантунгалаг | Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн | 1 |

**Гүйцэтгэх удирдлага**

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.3 дахь хэсэгт "Хувь хүн гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлж байгаа тохиолдолд уг этгээд нь гүйцэтгэх захирал байна" гэж хуульчилсан. Үнэт цаас гаргагч Эрдэнэс Сольюшинс ХК-ийн дүрмийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгээс үзвэл "14.1. Гүйцэтгэх удирдлага нь энэхүү дүрэм болон Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан хөлсөөр ажиллах гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, ажлаа Төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнана" гэж тусгасан байна.

Эрдэнэс Сольюшинс ХК-ийн дүрэм, Улсын бүртгэлийн гэрчилгээ болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 2022 оны 03 сарын 02-ны өдрийн №22900002000834 тоот лавлагаа, Гүйцэтгэх захирлын анкет болон тэдгээрт холбогдох баримт материалаас үзэхэд Үнэт цаас гаргагч Эрдэнэс Сольюшинс ХК-ийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал Ц.Хүдэрмөнх хэрэгжүүлж байна.

Ц.Хүдэрмөнх нь Эрдэнэс Сольюшинс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 03 сарын 06-ны өдрийн №ТУЗТ03/2020 тоот тогтоолоор Эрдэнэс Сольюшинс ХК-ийн Гүйцэтгэх захирлын албан тушаалд томилогдсон байна. Гүйцэтгэх захирлаар томилогдсон бүртгэлийг Компанийн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд 2020 оны 03 сарын 16-ны өдөр бүртгэгдэж, тэмдэглэгдсэн байна.

Хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа хууль тогтоомжийн зохицуулалт болон Компанийн засаглалын кодексийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтанд тавигддаг шаардлагын хүрээнд Хуулийн фирм нь Компанийн эрх бүхий албан тушаалтнуудын мэдээлэл, анкет, тэдгээрийн мэдлэг чадварыг тодорхойлох баримт материалыг гаргаж өгөхийг хүссэн.

Хуулийн фирм нь Компаниас ирүүлсэн баримт материалд үндэслэн Үнэт цаас гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага болон эрх бүхий албан тушаалтан нь холбогдох

2022 -03- 22
БҮРТГЭВ-03

Нууц баримт
Эх хувь

хууль тогтоомж болон Компанийн засаглалын кодекст заасан шаардлагыг дараах хүснэгтээр дэлгэрүүлэн авч үзлээ.

***Хүснэгт №04. Эрдэнэс Сольюшинс ХК-ийн эрх бүхий албан тушаалтан Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекст тавигдсан шаардлагыг хангасан эсэх мэдээлэл.***

| № | Эрх бүхий албан тушаал | Эрх бүхий албан тушаалтны нэрс | Компанийн тухай хууль (КТХ) | | | | Компанийн засаглалын кодекс (КЗК) |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан эсэх Тийм/Үгүй/N/A* | Төрийн болон нутгийн захиргааны байгууллагад удирдах албан тушаал хашдаг эсэх Тийм/Үгүй | Ял шийтгэл эдэлж байгаа эсэх Тийм/Үгүй | Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, Гүйцэтгэх удирдлагыг хувь хүн хэрэгжүүлдэг эсэх Тийм/ Үгүй/ N/A | Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь КЗК 5.2.1-т заасан чиглэлээр мэргэшсэн эсэх Тийм/Үгүй/ N/A |
| | | | Нэг. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд | | | | |
| 1. | Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга | Төмөрболдын Золбоо | Тийм | Үгүй | Үгүй | Тийм | Тийм |
| 2. | Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн | Цогтбаярын Хүдэрмөнх | Тийм | Үгүй | Үгүй | Тийм | Тийм |
| 3. | Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн | Цэрэндуламын Хишигбаатар | Тийм | Үгүй | Үгүй | Тийм | Тийм |
| 4. | Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн | Галбадрахын Аззаяа | Тийм | Үгүй | Үгүй | Тийм | Тийм |
| 5. | Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн | Эрдэнэзэгийн Цэндсүрэн | Тийм | Үгүй | Үгүй | Тийм | Тийм |
| 6. | Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн | Базарын Батхүү | Тийм | Үгүй | Үгүй | Тийм | Тийм |
| 7. | Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн | Бавуужамцын Энхзориг | Тийм | Үгүй | Үгүй | Тийм | Тийм |
| 8. | Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн | Сумбараагийн Энхжаргал | Тийм | Үгүй | Үгүй | Тийм | Тийм |
| 9. | Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн | Пүрэвдоржийн Нарантунгалаг | Тийм | Үгүй | Үгүй | Тийм | Тийм |
| | | | Хоёр. Бусад эрх бүхий албан тушаалтан | | | | |
| 1. | Гүйцэтгэх захирал | Цогтбаярын Хүдэрмөнх | Тийм | Үгүй | Үгүй | Тийм | Тийм |

*N/A: Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодексийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага болон эрх бүхий албан тушаалтанд тусгайлан тавигдсан шаардлагад үндэслэн шалгах шаардлагагүй гэж үзсэн этгээдийн харгалзах нүдэнд тус тэмдэглэгээг оруулсан болно. Хуулийн фирм

Дээр дурдсан хүснэгт дэх мэдээлэл болон Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн баримт материалд үндэслэн Үнэт цаас гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага болон



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company

УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК
ТТБ0074 т. 5208173

СЭХ
он 2022 сар 05 25-ны
БҮРТГЭВ

2022 -03- 22
БҮРТГЭВ-03

Нууц баримт
Эх хувь

эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомж болон Компанийн засаглалын кодекст заасан шаардлага хангасан эсэх асуудлыг дэлгэрүүлэн авч үзэж, дараах байдлаар дүгнэлээ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байх шаардлагыг Компанийн тухай хуулийн 75.8 дахь хэсэгт[12] хуульчилсан байх бөгөөд Компаниас ирүүлсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн анкет, засаглалын сургалтад хамрагдсан гэрчилгээний хуулбарыг үзвэл Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Т.Золбоо, Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн Ц.Хүдэрмөнх, Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн Ц.Хишигбаатар, Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн Г.Аззаяа, Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн Э. Цэндсүрэн, Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн Б.Батхүү, Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Б.Энхзориг, Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн С.Энхжаргал, Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн П.Нарантунгалаг нар нь Компанийн засаглалын сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байх тул Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байх хуулийн шаардлагыг хангасан байна гэж үзлээ.

Эрх бүхий албан тушаалтны хувьд Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд[13] (i) хуульд өөрөөр заагаагүй бол төрийн болон нутгийн захиргааны байгууллага, цэрэг, цагдаа, шүүх, прокурорын байгууллагад удирдах албан тушаал хашдаг байхыг хориглох; болон (ii) ял шийтгэл эдэлж байгаа этгээдийг Компанийн эрх бүхий албан тушаалд ажиллахыг хориглохоор заасан хуулийн шаардлагын хүрээнд Компаниас ирүүлсэн эрх бүхий албан тушаалтны эрхэлж байгаа ажил, албан тушаал, анкет, баримт бичигт тусгагдсан мэдээлэл, эрх бүхий албан тушаалтнуудын гаргаж өгсөн Баталгаанд үндэслэн Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнууд нь төрийн болон нутгийн захиргааны байгууллага, цэрэг, цагдаа, шүүх, прокурорын байгууллагад удирдах албан тушаал хашдаггүй бөгөөд ял шийтгэл эдлээгүй гэж Хуулийн фирмээс дүгнэсэн болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн мэргэшсэн дадлага, туршлагын шаардлагын талаар Компанийн засаглалын кодексийн 5 дугаар зүйлийн 5.2.1 дэх заалтад[14] аудит эсвэл нягтлан бодох бүртгэл, санхүү, хууль, эрх зүй, хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэшсэн дадлага, туршлага бүхий хувь хүнийг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгон ажиллуулах зүйтэй гэж нарийвчилсан зохицуулалттай байх бөгөөд Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх удирдлага, бусад дурдагдсан эрх бүхий албан тушаалтнуудын мэдээлэл, анкетад үндэслэн Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх удирдлага, бусад дурдагдсан эрх бүхий албан тушаалтнууд нь санхүү, эдийн засаг, инженер, бизнесийн удирдлагын чиглэлээр мэргэшсэн бөгөөд эдгээр албан тушаалтнууд нь удирдах албан тушаал эрхлэхэд шаардагдах мэргэжлийн боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн түүхтэй байна гэж үзлээ.

Иймд Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэгт заасан "Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь төлөөлөн удирдах зөвлөл

---

[12] Компанийн тухай хууль (2011).
75 дугаар зүйл.Төлөөлөн удирдах зөвлөл
75.8.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна.
[13] Компанийн тухай хууль (2011).
84 дүгээр зүйл.Компанийн эрх бүхий албан тушаалтан
84.3.Дараах этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалд ажиллахыг хориглоно:
84.3.1.хуульд өөрөөр заагаагүй бол төрийн болон нутгийн захиргааны байгууллага, цэрэг, цагдаа, шүүх, прокурорын байгууллагад удирдах албан тушаал хашдаг;
84.3.2.ял шийтгэл эдэлж байгаа.
[14] Компанийн засаглалын кодекс (2014).
Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх ба түүний бүтэц
5.2.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн үйл ажиллагааг зохистой удирдах, хяналт тавихад нийцэхүйц бүтэцтэй байна. Аудит эсвэл нягтлан бодох бүртгэл, санхүү, хууль, эрх зүй, хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэшсэн дадлага, туршлага бүхий хувь хүнийг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгон ажиллуулах нь зүйтэй.



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company

УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК

MONGOLIAN STOCK EXCHANGE 2022 -03- 22 БҮРТГЭВ-03

СЗХ 2022 оны 03 сарын 25 өдөр БҮРТГЭВ № 01



байна", Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4 дэх хэсэгт "Хувьцаат компани болон төрийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна", Компанийн засаглалын кодексийн 5 дугаар зүйлийн 5.2.3 дахь заалтад "Төлөөлөн удирдах зөвлөл нь хангалттай тооны (гуравны нэгээс доошгүй хувь) хараат бус гишүүдтэй байна", Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.6 дахь хэсэгт "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас энэ хуулийн 75.4-т заасан тооны хараат бус гишүүнийг төлөөлөн удирдах зөвлөлд сонгож ...", 78 дугаар зүйлийн 78.1 дэх хэсэгт "Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дотроос нийт гишүүний олонхын саналаар сонгоно", 82 дугаар зүйлийн 82.1 дэх хэсэгт "Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргыг төлөөлөн удирдах зөвлөлийн даргын санал болгосноор төлөөлөн удирдах зөвлөл томилно", 75 дугаар зүйлийн 75.8 дахь хэсэгт "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна", 81 дүгээр зүйлийн 81.1 дэх хэсэгт "Төлөөлөн удирдах зөвлөл нь шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог байгуулж болно", 81.2 дахь хэсэгт "Хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын, цалин, урамшууллын, нэр дэвшүүлэх хороодтой байх бөгөөд эдгээр хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээс бүрдэнэ", 81 дүгээр зүйлийн 81.4 дэх хэсэгт "энэ хуулийн 81.2-т заасан аудитын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн байх" 83 дугаар зүйлийн 83.2 дахь хэсэгт "Компанийн дүрэмд гүйцэтгэх удирдлагыг багаар хэрэгжүүлэхээр заагаагүй бол хувь хүн хэрэгжүүлнэ", 83 дугаар зүйлийн 83.4 дэх хэсэгт "Компанийн гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэгч этгээд нь Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байж болох бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн дарга байхыг хориглоно", 84 дүгээр зүйлийн 84.2 дахь хэсэгт "Компани өөрийн онцлогтоо тохируулан эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг компанийн дүрэмдээ заасан байна" гэсэн холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг тус тус хангаж байна гэж үзлээ.

Үнэт цаас гаргагч нь Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.2 дахь хэсэгт "Компани өөрийн онцлогтоо тохируулан эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг компанийн дүрэмдээ заасан байна" гэж заасан байна. Үүний дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилон ажиллуулах нь зүйтэй гэж Хуулийн фирмээс үзэж санал болгож байна.

**Гурав. Компанийн дүрэм, бусад дотоод дүрэм, журмууд нь холбогдох хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Компанийн засаглалын кодекс"-т нийцсэн эсэх асуудлын хувьд үзвэл:**

Хуулийн фирм нь энэхүү асуудлын хүрээнд Компанийн үйл ажиллагааг зохицуулж байгаа хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа дотоод дүрэм, журмыг гаргуулан авч дүн шинжилгээ хийлээ. Үнэт цаас гаргагч Эрдэнэс Сольюшинс ХК-аас Хуулийн фирмд ирүүлсэн баримт материалаас үзвэл нийт 7 (долоон) журам хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Компанийн дотоод дүрэм, журмын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг **Хавсралт №01. "Эрдэнэс Сольюшинс ХК-ийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй журмын жагсаалт"** хүснэгтээс дэлгэрүүлэн үзнэ үү.

***Хүснэгт №05. Эрдэнэс Сольюшинс ХК-ийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй журмын жагсаалтын тоон үзүүлэлт.***

| № | Журмын нэр, төрөл | Батлагдсан огноо | Баталсан тогтоол, шийдвэрийн дугаар |
|---|---|---|---|
| 1. | Хувьцаа эзэмшигчдийн хурлын журам | 2016.05.12 | ТУЗТ03/2016 |
| 2. | Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам | 2016.05.12 | ТУЗТ03/2016 |
| 3. | Ногдол ашгийн бодлого, шийдвэр гаргах, мэдээлэх, тараах, олгох журам | 2016.05.12 | ТУЗТ03/2016 |
| 4. | Нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны журам | 2016.05.12 | ТУЗТ03/2016 |
| 5. | Аудитын хорооны үйл ажиллагааны журам | 2016.05.12 | ТУЗТ03/2016 |
| 6. | Мэдээллийн үйл ажиллагааны журам | 2016.05.12 | ТУЗТ03/2016 |
| 7. | Цалин, урамшууллын хорооны үйл ажиллагааны журам | 2016.05.12 | ТУЗТ03/2016 |



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК ERDENES SOLUTIONS Joint Stock 9020080899 2015

УЛААНБААТАР ХОТ ГҮЙДСЕК ҮНЭТ ЦААС ТТ58674 РД 5208173

Нууц баримт
Эх хувь

Компанийн засаглалын кодексийн 2 дугаар зүйлийн 2.2.5.в дэх дэд заалтад "Компани ямар төрлийн мэдээллийг нийтэд тогтмол болон тухай бүр хүргэх, түүнтэй холбогдон гарах харилцааг зохицуулсан мэдээллийн үйл ажиллагааны журмыг боловсруулан төлөөлөн удирдах зөвлөл батлан мөрдүүлдэг байх ёстой", 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх хэсэгт "Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах тухай журамтай байна", Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалтад "Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол ногдол ашгийн хэмжээ, түүнийг төлөх журмыг тодорхойлох эрхийг хэрэгжүүлнэ", 80 дугаар зүйлийн 80.4 дэх хэсэгт "Төлөөлөн удирдах зөвлөл үйл ажиллагааныхаа журмыг тогтоож батлах", Компанийн засаглалын кодексийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтад "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмыг боловсруулж батлах нь зүйтэй", 7 дугаар зүйлийн 7.2.3 дахь заалтад "Компани нь хөндлөнгийн аудитыг томилох үйл ажиллагааг зохицуулсан дотоод журамтай байна", 7.3.1 дэх заалтад "Төлөөлөн удирдах зөвлөл холбогдох этгээдийг компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллээр хангах журамтай байна" гэж заасан шаардлагад тус тус нийцэж байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

**Нэгтгэн дүгнэвэл Компанийн дотоод үйл ажиллагаандаа мөрдөж байгаа 7 (долоон) дотоод дүрэм, журам нь холбогдох хууль, тогтоомжид нийцсэн байна гэж Хуулийн фирмээс үзлээ.**

Үнэт цаас гаргагч нь Компанийн засаглалын кодексийн 5 дугаар зүйлийн 5.8.1 дэх заалтад "Компани нь компанийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл ба сонирхлыг зөрчлийг зохицуулах бодлоготой байна, Төлөөлөн удирдах зөвлөлийн ёс зүйн кодекстой байна" гэж заасны дагуу компанийн засаглалтай холбоотой дотоод дүрэм, журмыг баталж ажиллахыг Хуулийн фирмээс зөвлөж байна.

**Дөрөв. Бусадтай байгуулсан худалдах болон худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн гэрээ болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх, компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар байгаа эсэх асуудлын хувьд үзвэл:**

Хуулийн фирм нь Хар хорум пропертийс ХК-д Компанийг нэгтгэх болон Эрдэнэс Сольюшинс ХК-ийн хувьцааг хуваасантай холбогдуулан хуулийн хөндлөнгийн дүн шинжилгээ хийж, Хуулийн дүгнэлт гаргаж ажилласан бөгөөд өмнөх Хуулийн дүгнэлт дээр үргэлжлүүлэн энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд Үнэт цаас гаргагчийн 2020 оны 09 сарын 01-ний өдрөөс 2022 оны 01 сарын 01-ний өдрийн хооронд бусадтай[15] бичгээр байгуулсан нийт гэрээ, хэлцлийг гаргуулан авч 2022 оны 01 сарын 01-ний өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа гэрээ, хэлцлийг сонгон авч дүн шинжилгээ хийлээ.

Эрдэнэс Сольюшинс ХК-аас ирүүлсэн баримт материалаас үзвэл дурдсан хугацаанд нийт 38 (гучин найман) гэрээ, хэлцлийг байгуулснаас тасалбар болгосон өдрийн байдлаар 22 (хорин хоёр) гэрээ, хэлцэл хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Үүнд:

[15] Бусадтай байгуулсан гэрээ, хэлцэлд дотооддоо буюу ажилчидтай байгуулсан хөдөлмөрийн харилцаа үүсгэх гэрээ, хэлцлийг оруулж тооцоогүй анхаарна уу. Хуулийн фирм.

2022 -03- 22
БҮРТГЭВ-03

Нууц баримт
Эх хувь

*Хүснэгт №06. Эрдэнэс Сольюшинс ХК-ийн 2020 оны 09 сарын 01-ний өдрөөс 2022 оны 01 сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд бусадтай бичгээр байгуулсан нийт гэрээ, хэлцлийн тоон үзүүлэлт.*

| № | Гэрээ, хэлцэл | Гэрээ, хэлцлийн тоо |
|---|---|---|
| 1. | Хүчин төгөлдөр гэрээ, хэлцэл | 22 |
| 2. | Дуусгавар болсон гэрээ, хэлцэл | 16 |
| | НИЙТ | 38 |

Түүнчлэн 2020 оны 09 сарын 01-ний өдрөөс өмнө байгуулагдсан хэдий ч гэрээ, хэлцлийг тасалбар болгосон өдрийн байдлаар 8 (найман) гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Иймд гэрээ, хэлцлийг тасалбар болгосон өдрийн байдлаар нийт 30 (гучин) гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байгааг дурдаж байна. Үүнд:

*Хүснэгт №07. Эрдэнэс Сольюшинс ХК-ийн 2020 оны 09 сарын 01-ний өдрөөс өмнөх хугацаанд бусадтай бичгээр байгуулсан нийт гэрээ, хэлцлийн тоон үзүүлэлт.*

| № | Гэрээ, хэлцэл | Гэрээ, хэлцлийн тоо |
|---|---|---|
| 1. | Тасалбар болгосон өдрөөс хойших гэрээ | 22 |
| 2. | Тасалбар болгосон өдрөөс өмнөх гэрээ | 8 |
| | НИЙТ | 30 |

Эрдэнэс Сольюшинс ХК-ийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа нийт гэрээ, хэлцлийн дэлгэрэнгүй мэдээлэл, хүчин төгөлдөр байдлыг **Хавсралт №02. "Эрдэнэс Сольюшинс ХК-ийн бусадтай бичгээр байгуулсан гэрээ, хэлцэл"**-ийн дэлгэрэнгүй мэдээлэл хүснэгтээс дэлгэрүүлэн танилцана уу.

Хуулийн фирмийн зүгээс Эрдэнэс Сольюшинс ХК-ийн бусадтай байгуулсан гэрээ, хэлцлээс гэрээ, хэлцлийг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа 30 (гучин) гэрээ, хэлцлийг үүрэг үүсгэсэн төрлийн хувьд авч үзвэл худалдах, худалдан авах 3 (гурван) гэрээ, зээлийн 1 (нэг) гэрээ, үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх 10 (арван) гэрээ, бусад гэрээ ангилалд хамаарах 16 (арван зургаан) гэрээ, хэлцэл хүчин төгөлдөр хэрэгжиж байна.

*Хүснэгт №08. Бусадтай бичгээр байгуулсан бөгөөд хүчин төгөлдөр үйлчилж байгаа гэрээ, хэлцлийн нэр, төрлийн тоон үзүүлэлт*

| № | Гэрээ, хэлцлийн нэр, төрөл | Гэрээ, хэлцлийн тоо |
|---|---|---|
| 1. | Худалдах, худалдан авах гэрээ | 3 |
| 2. | Зээлийн гэрээ | 1 |
| 3. | Бэлтгэн нийлүүлэх гэрээ | - |
| 4. | Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх гэрээ | 10 |
| 5. | Бусад гэрээ | 16 |
| | НИЙТ | 30 |

Хуулийн фирм нь Компаниас хүлээн авсан хүчин төгөлдөр хэрэгжиж буй гэрээ, хэлцлийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржээс тавьсан шалгуур үзүүлэлтийн хүрээнд дэлгэрүүлэн авч үзэж холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийлээ.

**Худалдах, худалдан авах гэрээ, хэлцэл**

Эрдэнэс Сольюшинс ХК-аас ирүүлсэн гэрээ, хэлцлийн бүртгэлээс үзвэл 2020 оны 09 сарын 01-ний өдрөөс 2022 оны 01 сарын 01-ний тасалбар болгосон өдрийн байдлаар 3 (гурван) худалдах, худалдан авах гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Эдгээр гэрээ, хэлцлийн дэлгэрэнгүй мэдээллийг **Хавсралт №02. "Эрдэнэс Сольюшинс ХК-ийн бусадтай бичгээр байгуулсан гэрээ, хэлцэл"**-ийн дэлгэрэнгүй мэдээлэл хүснэгтээс дэлгэрүүлэн үзэж танилцана уу.

Хуулийн фирмийн зүгээс худалдах, худалдан авах гэрээ, хэлцэл нь бичгээр байгуулагдах хэлцлийн хэлбэрийн шаардлагыг хангасан, талуудыг төлөөлөх этгээдийн гарын үсэг зурагдсан,



ERDENES SOLUTIONS Joint Stock Company
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК

СЗХ 2022 05 25 БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-03-22 БҮРТГЭВ-03



тамга тэмдэг дарагдсан байх тул хүчин төгөлдөр гэж үзэх үндэслэлтэй, холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна гэж дүгнэлээ.

**Бэлтгэн нийлүүлэх гэрээ, хэлцэл**

Эрдэнэс Сольюшинс ХК-ийн дурдсан хугацаанд бусадтай байгуулсан гэрээ, хэлцлээс үзвэл аливаа бэлтгэн нийлүүлэх буюу бусдын өмчлөлд хөрөнгө нийлүүлэх гэрээ, хэлцлийг байгуулаагүй байна.

**Зээлийн гэрээ**

Монголбанкны Зээлийн мэдээллийн сангийн 2022 оны 02 сарын 15-ны өдрийн лавлагаанаас үзвэл Эрдэнэс Сольюшинс ХК-ийн нэр дээр Монголбанкны Зээлийн мэдээллийн санд мэдээлэл нийлүүлэгч банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс авсан аливаа зээлийн өр төлбөр, хугацаа хэтрүүлсэн зээлийн үлдэгдэл байхгүй байна.

Эрдэнэс Сольюшинс ХК-ийн гаргаж өгсөн гэрээ, хэлцлээс үзвэл Үнэт цаас гаргагч нь Субашид Тек ХХК-тай 2021 оны 01 сарын 01-ний өдөр байгуулсан Зээлийн гэрээ байгуулсан нь хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Тус Зээлийн гэрээний дагуу зээл авагч Эрдэнэс Сольюшинс ХК нь 2023 оны 12 сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд, хүүгүй мөнгөн хөрөнгө зээлэхээр харилцан тохиролцсон байна. Энэхүү зээлийн гэрээ, хэлцлээс үзвэл талууд хэлэлцэн тохиролцож хүү тогтоож, тооцохгүйгээр тохиролцсон зээлийн гэрээг байгуулсан байх бөгөөд Иргэний хуулийн 282 дугаар зүйлийн 282.1 дэх хэсэгт[16] зээлийн гэрээгээр талууд хэлэлцэн тохиролцсон хүү тогтоохгүйгээр байгуулж болох хуулийн зохицуулалтай нийцэж байх тул Хуулийн фирм нь эдгээр зээлийн гэрээ, хэлцэл нь хуульд заасан шаардлагыг хангасан, бичгээр байгуулагдаж, талуудын төлөөлөгчид гарын үсэг зурсан, тамга тэмдэг дарагдсан хүчин төгөлдөр гэж дүгнэх үндэслэлтэй тул холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна гэж үзлээ.

**Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх гэрээ**

Хуулийн фирм нь хүлээн авсан гэрээ, хэлцлийг судлаад Эрдэнэс Сольюшинс ХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгагдсан үйл ажиллагааны чиглэлд хамаарах, бизнесийн үйл ажиллагаанд голлох ач холбогдолтой, борлуулалт, мөнгөн хөрөнгийн урсгалыг дэмжих, үйл ажиллагааг өргөжүүлэн дэмжсэн дараах төрлийн гэрээ, хэлцлийг тус Компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх буюу чухал ач холбогдолтой гэж үзлээ. Эдгээр дурдсан гэрээ, хэлцлийн дэлгэрэнгүй мэдээллийг **Хавсралт №02. "Эрдэнэс Сольюшинс ХК-ийн бусадтай бичгээр байгуулсан гэрээ, хэлцэл"**-ийн дэлгэрэнгүй мэдээлэл хүснэгтээс дэлгэрүүлэн үзэж танилцана уу.

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх гэрээ нь гэрээний талуудын хүсэл зоригт нийцсэнээр байгуулагдсан байх бөгөөд бичгээр байгуулагдсан хэлцлийн хэлбэрийн шаардлагыг хангасан, талуудыг төлөөлөх этгээдийн гарын үсэг зурагдсан, тамга, тэмдэг дарагдсан, хууль, тогтоомжид нийцсэн хүчин төгөлдөр гэрээ, хэлцэл байна гэж үзлээ.

**Бусад гэрээ хэлцэл**

Дээр дурдсан ангилал буюу худалдах худалдан авах гэрээ, бэлтгэн нийлүүлэх гэрээ, зээлийн гэрээ болон Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой гэрээнээс бусад бусадтай бичгээр байгуулсан нийт 16 (арван зургаан) гэрээ, хэлцэл хүчин төгөлдөр хэрэгжиж байна.

Эдгээр хүчин төгөлдөр хэрэгжиж буй гэрээ, хэлцэлд харилцах болон цахим данс нээх, төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэх, онлайн үйлчилгээ үзүүлэх гэрээ, түрээсийн гэрээ, нууц хадгалах гэрээ, хэрэглэгчийн үйлчилгээ үзүүлэх гэрээ, сервер байршуулах гэрээ, Эрдэнэс Сольюшинс ХК-аас нэмж хувьцаа гаргахтай холбогдуулан ажил гүйцэтгэх, туслалцаа үзүүлэхтэй

[16] Иргэний хууль (2002).
282 дугаар зүйл. Зээлийн гэрээний хүү
282.1. Зээлийн гэрээгээр талууд хэлэлцэн тохиролцож хүү тогтоож болно.



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК ERDENES SOLUTIONS Joint Stock Company

УЛААНБААТАР ХОТ ГҮҮДСЕК ТТБ8674 5308173

Нууц баримт
Эх хувь

холбогдсон хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ, андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ, аудитын гэрээ хэлцэл зэрэг гэрээ, хэлцэл багтсан байгааг дурдаж байна. Нийт хүчин төгөлдөр үйлчилж буй бусад гэрээний дэлгэрэнгүйг **Хавсралт №02. "Эрдэнэс Сольюшинс ХК-ийн бусадтай бичгээр байгуулсан гэрээ, хэлцэл"**-ийн дэлгэрэнгүй мэдээлэл хүснэгтээс дэлгэрүүлэн үзнэ үү.

Хуулийн фирм нь эдгээр хүчин төгөлдөр хэрэгжиж буй гэрээ, хэлцэл нь бичгээр байгуулагдсан хэлцлийн хэлбэрийн шаардлагыг хангасан, талуудыг төлөөлөх этгээдийн гарын үсэг зурагдсан, тамга тэмдэг дарагдсан хүчин төгөлдөр гэж үзэх үндэслэлтэй, Иргэний хууль болон холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна гэж дүгнэлээ.

Хуулийн фирм нь Эрдэнэс Сольюшинс ХК-ийн энэхүү бүлэгт дурдсан, хүлээн авч танилцсан гэрээ, хэлцэл нь агуулгын хувьд хууль зөрчсөн буюу нийтээр хүлээн зөвшөөрсөн ёс суртахууны хэм хэмжээнд харшилсан гэж тооцох үндэслэлтэй аливаа гэрээ, хэлцэл байхгүй бөгөөд эдгээр гэрээ, хэлцэлтэй холбоотойгоор үүссэн маргаан, компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар үүсгээгүй байна гэж үзэх үндэслэлтэй гэж үзлээ.

**Нэгтгэн дүгнэж үзвэл Эрдэнэс Сольюшинс ХК-ийн бусадтай байгуулсан, хүчин төгөлдөр хэрэгжиж буй худалдах, худалдан авах гэрээ, бэлтгэн нийлүүлэх гэрээ, зээлийн гэрээ болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ, контракт нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна гэж дүгнэлээ.**

**Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, тэдгээрийн хэрэгжилтийн талаар:**

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5.7 дахь заалтад[17] заасан Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, хэлцэл, тэдгээрийн хэрэгжилтийн талаар авч үзлээ. Үнэт цаас гаргагч Эрдэнэс Сольюшинс ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийг сүүлийн 3 (гурван) жилийн байдлаар авч үзвэл дараах тоон үзүүлэлттэй байна. Үүнд:

*Хүснэгт №09. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ болон түүний 5 (таван) хувийн мэдээлэл*

| № | Улирал | Хувь нийлүүлсэн хөрөнгө (төгрөгөөр) | Хувь нийлүүлсэн хөрөнгийн 5% (төгрөгөөр) |
|---|---|---|---|
| 1. | 2019 оны 1 улирал | 3,616,700.00 | 180,835.00 |
| 2. | 2019 оны 2 улирал | 3,616,700.00 | 180,835.00 |
| 3. | 2019 оны 3 улирал | 3,616,700.00 | 180,835.00 |
| 4. | 2019 оны 4 улирал | 3,616,700.00 | 180,835.00 |
| 5. | 2020 оны 1 улирал | 1,578,745,700.00 | 78,937,285.00 |
| 6. | 2020 оны 2 улирал | 1,578,745,700.00 | 78,937,285.00 |
| 7. | 2020 оны 3 улирал | 1,578,745,700.00 | 78,937,285.00 |
| 8. | 2020 оны 4 улирал | 1,578,745,700.00 | 78,937,285.00 |
| 9. | 2021 оны 2 улирал | 1,578,745,700.00 | 78,937,285.00 |
| 10. | 2021 оны 4 улирал | 1,578,745,700.00 | 78,937,285.00 |

Дээрх хүснэгтэд үндэслэн Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн бөгөөд Үнэт цаас гаргагчийн гэрээ хэлцлийг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа нийт 5 (таван) гэрээ, хэлцлийн мэдээллийг Хуулийн фирмд ирүүлсэн. Мөн гэрээ, хэлцлийг тасалбар болгосон өдрөөс өмнө буюу 2020 оны 09 сарын 01-ний өдрөөс өмнө байгуулагдсан хэдий ч гэрээ, хэлцлийг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа 4 (дөрвөн) гэрээ байна. Үүнд:

[17] Үнэт цаасны зах зээлийн тухай хууль (2013).
10 дугаар зүйл. Үнэт цаасны танилцуулга
10.5.Үнэт цаасны танилцуулгад доор дурдсан мэдээллийг тусгана:
10.5.7.үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, хэлцэл, тэдгээрийн хэрэгжилтийн тухай.

Нууц баримт
Эх хувь

*Хүснэгт №10. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 (тав) болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээний төрлийн тоон үзүүлэлт.*

| № | Гэрээний нэр, төрөл | Хүчин төгөлдөр бус гэрээний тоо | Хүчин төгөлдөр гэрээний тоо |
|---|---|---|---|
| 1. | Худалдах, худалдан авах гэрээ | 3 | 1 |
| 2. | Зээлийн гэрээ | - | 1 |
| 3. | Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх гэрээ | - | 3 |
| 4. | Бусад гэрээ | 1 | - |
| | НИЙТ | 4 | 5 |

Эдгээр гэрээнээс худалдах, худалдан авах гэрээний төрөлд хамаарах хүчин төгөлдөр 1 (нэг) гэрээ байна. Энэхүү худалдах, худалдан авах гэрээ нь 2021 оны 06 сарын 02-ны өдөр Монгол Улсын иргэн Ц.Бат-Эрдэнэтэй байгуулсан Үл хөдлөх эд хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ байх бөгөөд уг гэрээний дагуу Үнэт цаас гаргагч компани нь Монгол Улсын иргэн Ц.Бат-Эрдэнийн өмчлөл дэх үл хөдлөх эд хөрөнгийг худалдан авахаар харилцан тохиролцож байгуулсан байна. Тус гэрээ нь Иргэний хуульд заасан бичгээр байгуулагдах хэлцлийн хэлбэрийн шаардлагыг хангасан, талуудыг төлөөлөх этгээдийн гарын үсэг зурагдсан, тамга тэмдэг дарагдсан байх тул хүчин төгөлдөр гэж үзэх үндэслэлтэй, холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна гэж дүгнэлээ.

Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн 1 (нэг) зээлийн гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Компани болон Субашид Тек ХХК-ийн хооронд 2021 оны 01 сарын 01-ний өдөр байгуулагдсан Зээлийн гэрээний дагуу зээл авагч Эрдэнэс Сольюшинс ХК нь 2023 оны 12 сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд, хүүгүй мөнгөн хөрөнгө зээлэхээр харилцан тохиролцсон байна. Энэхүү зээлийн гэрээ, хэлцлээс үзвэл талууд хэлэлцэн тохиролцож хүү тогтоож, тооцохгүйгээр тохиролцсон зээлийн гэрээг байгуулсан байх бөгөөд Иргэний хуулийн 282 дугаар зүйлийн 282.1 дэх хэсэгт[18] зээлийн гэрээгээр талууд хэлэлцэн тохиролцсон хүү тогтоохгүйгээр байгуулж болох хуулийн зохицуулалттай нийцэж байгааг дурдаж байна. Мөн зээлийн гэрээ нь хуульд заасан шаардлагыг хангасан, бичгээр байгуулагдаж, талуудын төлөөлөгчид гарын үсэг зурсан, тамга тэмдэг дарагдсан хүчин төгөлдөр гэрээ байна гэж үзэх үндэслэлтэй байна.

Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол бүхий 2 (хоёр) гэрээ, хэлцэл хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Эдгээр гэрээ, хэлцлийг авч үзвэл Эрдэнэс Сольюшинс ХК нь өрийн хэрэгслийн үндсэн төлбөр болон хүүг төлөх, өрийн хэрэгсэл худалдан авагч нь өрийн хэрэгслийг эзэмшихтэй холбогдуулан өрийн хэрэгсэл гаргагч болон андеррайтер нь Хувьцаа барьцаалсан хаалттай бондын гэрээг (i) Монголын Улсын иргэн Ц.Жаргалсайхантай 2021 оны 05 сарын 27-ны өдөр байгуулсан №21/32 тоот гэрээ; болон (ii) Бүгд Найрамдах Солонгос Улсын иргэн Чун Ёнг /Chun Yong/-тай 2021 оны 09 сарын 16-ны өдөр байгуулсан №21/43 тоот гэрээг тус тус байгуулсан байна. Эдгээр гэрээ, хэлцэлтэй холбоотой дүгнэлтийг энэхүү Хуулийн дүгнэлтийн дөрөвдүгээр хэсгийн Бусадтай байгуулсан Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх хэсгээс дэлгэрүүлэн танилцана уу.

Түүнчлэн Үнэт цаас гаргагч нь 2021 оны 10 сарын 21-ний өдөр Нүбисоцт ХХК-тай сургалтын моодл программ хангамжийг хийх зорилгоор №21/10 тоот ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан байна. Тус гэрээ нь Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ байх бөгөөд Иргэний хуульд нийцсэн, талуудыг

[18] Иргэний хууль (2002).
282 дугаар зүйл. Зээлийн гэрээний хүү
282.1. Зээлийн гэрээгээр талууд хэлэлцэн тохиролцож хүү тогтоож болно.



ERDENES SOLUTIONS Joint Stock Company
УЛААНБААТАР ХОТ ГҮҮДСЕК ХУУЛЬЧ ТТБ0674 № 5208173
MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-03-22 БҮРТГЭВ

2022-03-22 БҮРТГЭВ-03

Нууц баримт
Эх хувь

төлөөлөх эрх бүхий этгээдийн гарын үсэг зурагдсан, тамга, тэмдгээр баталгаажуулсан хүчин төгөлдөр гэрээ байна гэж үзэх үндэслэлтэй байна.

**Тав. Сүүлийн 3 (гурван) жилийн дотор хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх асуудлаар:**

Хуулийн фирм нь энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд 2020 оны 09 сарын 01-ний өдрөөс 2022 оны 01 сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд Эрдэнэс Сольюшинс ХК-ийн бусадтай бичгээр байгуулсан гэрээ, хэлцэл дотор их хэмжээний хэлцэл болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулагдсан эсэх, 2020 оны 09 сарын 01-ний өдрөөс өмнө байгуулагдсан хэдий ч 2022 оны 01 сарын 01-ний өдрийн байдлаар хэрэгжиж байгаа их хэмжээний хэлцэл болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгаа эсэх, байгаа нөхцөлд Компанийн тухай хуулийн дагуу хийгдсэн эсэх асуудлыг судалж үзлээ.

**(i) Сүүлийн 3 (гурван) жилийн дотор хийгдсэн их хэмжээний хэлцэл нь холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх асуудлаар:**

Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1.1 дэх заалтад "хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл (компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй) болон 87 дугаар зүйлийн 87.1.2 дахь заалтад "компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалт"-ыг их хэмжээний хэлцэлд тооцохоор заасан байна.

Үнэт цаас гаргагчийн дүрмийн 19 дүгээр зүйлийн 19.1.1 дэх заалтад "хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл (компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй)" болон 19 дүгээр зүйлийн 19.1.2 дахь заалтад "компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалт"-ыг их хэмжээний хэлцэлд тооцохоор заасан байна.

Үнэт цаас гаргагч Эрдэнэс Сольюшинс ХК-аас Хуулийн фирмд ирүүлсэн аудитын байгууллагаар баталгаажсан санхүүгийн тайлангаас балансын нийт актив[19] болон балансын активын 25 хувийн дүнг тооцож үзвэл дараах хэмжээтэй байна. Үүнд:

*Хүснэгт №11. Балансын актив болон балансын активын 25%-ийн тоон үзүүлэлт.*

| № | Гэрээний нэр, төрөл | Тухайн улирлын балансын нийт актив (төгрөгөөр) | Тухайн улирлын балансын активын 25% (төгрөгөөр) |
|---|---|---|---|
| 1. | 2019 оны 1 улирал | 45,300.00 | 11,325.00 |
| 2. | 2019 оны 2 улирал | 45,300.00 | 11,325.00 |
| 3. | 2019 оны 3 улирал | 45,300.00 | 11,325.00 |
| 4. | 2019 оны 4 улирал | 45,300.00 | 11,325.00 |
| 5. | 2020 оны 1 улирал | 1,564,976,258.61 | 391,244,064.65 |
| 6. | 2020 оны 2 улирал | 1,585,628,431.99 | 396,407,108.00 |
| 7. | 2020 оны 3 улирал | 1,585,628,431.99 | 396,407,108.00 |
| 8. | 2020 оны 4 улирал | 1,623,817,101.44 | 405,954,275.36 |
| 9. | 2021 оны 2 улирал | 3,131,455,436.24 | 782,863,859.06 |
| 10. | 2021 оны 4 улирал | 2,871,795,411.79 | 717,948,852.95 |

[19] "Балансын нийт актив" гэдэгт Санхүү байдлын тайлангийн 2.4 дэх мөр /хэвтээ үзүүлэлт/ буюу "Өр төлбөр ба Эздийн өмч" гэсэн үзүүлэлтийн эцсийн үлдэгдэл гэсэн харгалзах баганад /босоо үзүүлэлт/ байгаа мөнгөн хөрөнгийг тооцож ойлгосон болно. Хуулийн фирм.



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК ERDENES SOLUTIONS Joint Stock Company
УЛААНБААТАР ХОТ ГҮЙДСЕК ҮЙЛ... ТБ8674 ... 5208173

2022-03-22 БҮРТГЭВ-03

Нууц баримт
Эх хувь

Дээрх хүснэгтэд тусгагдсан Үнэт цаас гаргагчийн хэлцэл хийхийн өмнөх балансын сүүлийн балансын активын 25 хувийн дүн болон Компаниас ирүүлсэн гэрээ, хэлцэл, мэдээлэлд үндэслэж үзвэл Компани нь дурдсан хугацааны дотор их хэмжээний хэлцэл байхгүй байна.

Иймд Эрдэнэс Сольюшинс ХК-ийн гэрээ, хэлцлийг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа их хэмжээний хэлцэл байгуулагдаагүй байна гэж дүгнэх үндэслэлтэй байна.

(ii) **Сүүлийн 3 (гурван) жилийн дотор хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл нь холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх асуудлаар:**

Хуулийн фирм нь Үнэт цаас гаргагч Эрдэнэс Сольюшинс ХК-аас 2020 оны 09 сарын 01-ний өдрөөс 2022 оны 01 сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд бусадтай бичгээр байгуулсан нийт гэрээ, хэлцлийн дотор сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулагдсан эсэх, 2020 оны 09 сарын 01-ний өдрөөс өмнө байгуулагдсан хэдий ч 2022 оны 01 сарын 01-ний өдрийн байдлаар хэрэгжиж байгаа сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулагдсан эсэх, байгуулагдсан нөхцөлд Компанийн тухай хуулийн дагуу хийгдсэн эсэхийг судалж үзлээ.

Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэгт “Компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшиж байгаа компанитай Компанийн тухай хуульд тодорхойлсон харилцаанд орсон бол компанитай, эсхүл түүний хараат болон охин компанитай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тооцогдоно” гэж хуульчилсан.

Компанийн тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.3 дахь хэсэгт[20] заасны дагуу компани нэгдмэл сонирхолтой этгээдийн бүртгэлийг тухай бүр хөтлөх үүрэгтэй бөгөөд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд нь компанийн төлөөлөн удирдах зөвлөлд өөрийн хувийн байдлын талаар мэдээлэл өгөх хуулиар ногдуулсан үүрэгтэй байна. Үнэт цаас гаргагчаас Хуулийн фирмд гаргаж өгсөн нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалттай **Хавсралт №03. “Эрдэнэс Сольюшинс ХК-ийн нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалт”** хүснэгтээс танилцана уу. Тус мэдээлэл Эрдэнэс Сольюшинс ХК-ийн хувьцаа эзэмшигч, нэгдмэл сонирхолтой этгээд, тэдгээрийн хувийн мэдээллийг агуулсан хуулиар хамгаалагдсан хувь хүний нууцад хамаарах баримт тул төрийн эрх бүхий байгууллага болон одоогийн хувьцаа эзэмшигчид, ирээдүйн хөрөнгө оруулагчдаас бусад этгээдэд хаалттай, нууц мэдээлэлд тооцогдох болохыг анхаарч ажиллахыг Хуулийн фирмээс санал болгож байна.

Эрдэнэс Сольюшинс ХК-ийн зүгээс 2020 оны 09 сарын 01-ний өдрөөс 2022 оны 01 сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд байгуулагдсан гэрээ, хэлцлийн жагсаалтаас авч үзвэл нийт 9 (есөн) сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцэл байгуулснаас тасалбар болгосон өдрийн байдлаар 3 (гурван) гэрээ, хэлцэл болон 2020 оны 09 сарын 01-ний өдрөөс өмнө байгуулагдсан хэдий ч тасалбар болгосон өдрийн байдлаар 1 (нэг) гэрээ, хэлцэл буюу нийт 4 (дөрвөн) сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцэл хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Хуулийн фирм нь Эрдэнэс Сольюшинс ХК-аас хэлцэл хийхийг үндэслэл болгосон холбогдох материалуудыг гаргуулан авч Компанийн тухай хуульд заасны дагуу хийгдсэн эсэхийг судалж үзлээ. Эдгээр сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцэл, тэдгээрийн хэлцэл хийхийг үндэслэл болгосон холбогдох материалуудын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг **Хавсралт №04. “Эрдэнэс Сольюшинс ХК-ийн сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцлийн мэдээлэл”** хүснэгтээс дэлгэрүүлэн үзэж танилцана уу.

---

[20] **Компанийн тухай хууль (2011).**
91 дүгээр зүйл. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тавих шаардлага.
91.3.Компани өөрийн болон эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг хөтлөж, сонирхогч этгээд үзэх боломжоор хангах үүрэгтэй.



ERDENES SOLUTIONS Joint Stock Company ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК 9020080899

УЛААНБААТАР ХОТ ГҮҮДСЕК ҮЦК

СЗХ
оны 2022 оны 05 сарын 25 өдөр
БҮРТГЭВ

2022 -03- 22
БҮРТГЭВ

Нууц баримт
Эх хувь

Сонирхлын зөрчилтэй хэлцлийн хувьд Компанийн тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасан журмын дагуу байгуулдаг бөгөөд тус хэсэгт "сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай шийдвэрийг уг хэлцлийг хийх талаар сонирхлын зөрчилгүй төлөөлөн удирдах зөвлөл (байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал)-ын гишүүдийн олонхын саналаар гаргана", 92 дугаар зүйлийн 92.2 дахь хэсэгт "Сонирхлын зөрчилтэй хэлцлээр худалдах, худалдан авах, захиран зарцуулах эд хөрөнгө, эд хөрөнгийн болон мөнгөөр үнэлж болох бусад эрхийн зах зээлийн үнэ, үйлчилгээний хөлсний хэмжээг энэ хуулийн 55 дугаар зүйлд заасан журмын дагуу төлөөлөн удирдах зөвлөл тогтооно" гэж тодорхойлсон байна. Өөрөөр хэлбэл сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах нөхцөлд гэрээний зүйлийн үнийг төлөөлөн удирдах зөвлөл тогтоох бөгөөд хэлцэл хийх зөвшөөрлийг сонирхлын зөрчилгүй төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонхын саналаар зөвшөөрөл олгохоор хуулиар зохицуулсан байна.

Энд дэлгэрүүлэн авч үзвэл гэрээ, хэлцлийг тасалбар болгосон өдрийн байдлаар дараах 4 (дөрвөн) сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцэл хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Үүнд:

(i) Эрдэнэс Сольюшинс ХК нь 2020 оны 03 сарын 31-ний өдөр лиценз эзэмшигч Эс Жи Капитал ҮЦК ХХК-ийн хөгжүүлсэн Брокерсмн програм хангамжийн харилцагчийн бүртгэл хөтлөх модулыг лиценз ашиглагч Эрдэнэс Сольюшинс ХК нь веб системд үйл ажиллагаандаа үнэ төлбөргүй ашиглахаар харилцан тохиролцож Програм хангамжийн лиценз ашиглалтын гэрээг байгуулсан байна.

(ii) Эрдэнэс Сольюшинс ХК нь 2020 оны 01 сарын 01-ний өдөр Субашид Тек ХХК-тай Зээлийн гэрээ байгуулж, тус гэрээний дагуу зээл авагч Эрдэнэс Сольюшинс ХК нь 2023 оны 12 сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд, хүүгүйгээр мөнгөн хөрөнгө зээлэхээр харилцан тохиролцсон байна. Тус гэрээг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 02 сарын 23-ны өдрийн №ТУЗТ01/2021 тоот тогтоолоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийснийг зөвшөөрч баталгаажуулсан байна.

(iii) Эрдэнэс Сольюшинс ХК нь 2021 оны 08 сарын 02-ны өдөр Эс Жи Капитал ҮЦК ХХК-тай Түрээсийн гэрээг 5 (таван) жилийн хугацаатай байгуулсан байна. Тус гэрээг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 09 сарын 06-ны өдрийн №ТУЗТ09/2021 тоот Компанийн оффисын талбай түрээслэх, сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай тогтоолоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийснийг зөвшөөрч баталгаажуулсан байна.

(iv) Эрдэнэс Сольюшинс ХК нь 2021 оны 09 сарын 08-ны өдөр Экспонэйшнл Фанд Менежмент ҮЦК ХХК-тай Түрээсийн гэрээг 5 (таван) жилийн хугацаатай байгуулсан байна. Тус гэрээг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 09 сарын 06-ны өдрийн №ТУЗТ09/2021 тоот Компанийн оффисын талбай түрээслэх, сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай тогтоолын дагуу зөвшөөрөл олгосон байна.

Хэлцэл хийх тухай зөвшөөрөл олгосон Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэр, тогтоол болон хэлцэл хийснийг баталгаажуулсан Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолд уг хэлцлийг хийх талаар сонирхлын зөрчилгүй Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн гарын үсэг зурагдсан, сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх асуудлаар аливаа эсрэг санал тэмдэглэгдээгүй байх тул сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай зөвшөөрлийг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон, баталгаажуулсан байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

Эрдэнэс Сольюшинс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал)-өөс зөвшөөрөл авч хийгдээгүй дээр дурдсан 1 (нэг) сонирхлын зөрчилтэй хэлцлийн хувьд хувьцаа эзэмшигчийн зүгээс тус хэлцлийн талаар нэхэмжлэл гаргасан нөхцөлд хэлцлийн хүчин төгөлдөр байдал хөндөгдөх бөгөөд бусад нөхцөлд эдгээр гэрээ, хэлцлийг хэрэгжүүлэх боломжтой байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

КТХ-ийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсэгт заасны дагуу сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах журам зөрчсөний улмаас компани буюу түүний хараат болон охин компанид учруулсан хохирлын хэмжээгээр, эсхүл хэлцлийн үр дүнд авсан зүйлийн олсон ашгийн хэмжээгээр хариуцлага хүлээх хуулийн зохицуулалттай байна. Түүнчлэн сонирхлын зөрчилтэй хэлцлийг



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company

УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК
5208173

Нууц баримт
Эх хувь

байгуулах хуульд заасан журмыг зөрчсөн нөхцөлд хувьцаа эзэмшигчийн үүсгэсэн нэхэмжлэлээр тухайн хэлцлийг шүүхээс хүчин төгөлдөр бус гэж тооцох хүртэл үр дагавартай байдаг. Цаашид сонирхлын зөрчилтэй хэлцлийг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу байгуулж ажиллахыг Хуулийн фирмээс зөвлөж байна.

**Дүгнэж үзвэл Эрдэнэс Сольюшинс ХК-аас нэгдмэл сонирхолтой этгээдтэй байгуулсан 4 (дөрвөн) сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцэл хүчин төгөлдөр хэрэгжиж байгаагаас 3 (гурван) сонирхлын зөрчилтэй хэлцлийг Төлөөлөн удирдах зөвлөлөөс хэлцэл хийх зөвшөөрөл олгосон/баталгаажуулсны үндсэн дээр байгуулсан байх тул хуульд заасан журмын дагуу байгуулсан байна гэж дүгнэлээ.**

**Зургаа. Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой, сөргөөр нөлөөлж болохуйц нөхцөл бүй эсэх асуудлаар:**

Хуулийн фирм нь Үнэт цаас гаргагч нь үйл ажиллагаа эрхлэхдээ хууль тогтоомжид заасны дагуу төрийн эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл авахыг шаардсан буюу тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагааг тогтоосон хугацаа, нөхцөл, шаардлагын дагуу эрхлэн явуулах эрхийг үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз гэж үзэж дүн шинжилгээ хийлээ.

Үнэт цаас гаргагчийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм болон Хуулийн фирмд ирүүлсэн анхан шатны баримт материалаас үзвэл Үнэт цаас гаргагчийн эрхэлж буй үйл ажиллагаа нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан төрийн эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл авахыг шаардсан үйл ажиллагаа эрхэлдэггүй байна.

Үнэт цаас гаргагч нь аливаа зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг, тохирлын гэрчилгээ эзэмшдэг эсэх, тэдгээр нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн асуудлыг хувьд дэлгэрүүлэн авч үзлээ.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Оюуны өмчийн газрын 2022 оны 01 сарын 06-ны өдрийн №1/08 тоот тодорхойлолтоос үзвэл оюуны өмчийн мэдээллийн нэгдсэн сангийн зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн мэдээллийн нэгдсэн санд Эрдэнэс Сольюшинс ХК-ийн нэр дээр бүртгэлтэй №11397 дугаартай "БрокерсМН", №12311 дугаартай "Цахим өгөгдөл цуглуулах, баримт бичигт дүн шинжилгээ хийх, олж авах $D^3$ARS систем"[21] тус тус эрхийн хамгаалалт хийгдсэн болохыг тодорхойлсон байна.

Засгийн газрын тохируулагч агентлаг, Стандарт хэмжил зүйн газрын Бүтээгдэхүүн, тогтолцооны баталгаажуулалтын газрын даргын 2022 оны 01 сарын 21-ний өдрийн №07/56 тоот албан бичгээс үзвэл Эрдэнэс Сольюшинс ХК нь аливаа тохирлын гэрчилгээг эзэмшдэггүй болохыг тодорхойлсон байна.

Үнэт цаас гаргагчийн нэр дээр бүртгэлтэй зохиогчийн эрх нь аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх асуудлын хувьд Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт[22] заасны дагуу хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийн бүртгэх цахим мэдээллийн сангийн 2022 оны 01 сарын 11-ний өдрийн байдлаарх бүртгэлээс хайлт хийж үзвэл Эрдэнэс Сольюшинс ХК-ийн нэр

[21] http://copyright.ipom.mn/

[22] **Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль (2015).**
7 дугаар зүйл.Барьцааны зүйл
7.1 Иргэний гүйлгээнээс хасагдаагүй бусдын өмчлөлд шилжүүлж болох бодитой байгаа, эсхүл ирээдүйд бий болох хөдлөх эд хөрөнгө, бүх төрлийн хувьцаа, үнэт цаас, шаардах эрх, шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүх төрлийн бүтээл, шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, барааны тэмдэг, ашигтай загвар болон бусад хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгө нь барьцааны зүйл байж болно.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -03- 22
БҮРТГЭВ-03

2022 сар 05 өдөр 12

Нууц баримт
Эх хувь

дээр бүртгэлтэй зохиогчийн эрхийн барьцаатай холбоотой мэдээлэл байхгүй болохыг дурдаж байна.

Иймд Эрдэнэс Сольюшинс ХК-ийн нэр дээр бүртгэгдэж, оюуны өмчийн эрхийн хамгаалалт хийгдсэн 2 (хоёр) зохиогчийн эрхийн гэрчилгээ нь хүчин төгөлдөр бөгөөд Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийн бүртгэх цахим мэдээллийн сангийн бүртгэлд үндэслэн Үнэт цаас гаргагчийн нэр дээр бүртгэлтэй оюуны өмч нь аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээгээгүй байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

**Нэгтгэн дүгнэж үзвэл Үнэт цаас гаргагчийн нэр дээр олгогдсон оюуны өмчийн эрхийн хамгаалалт хийгдсэн 2 (хоёр) зохиогчийн эрхийн гэрчилгээ нь хүчин төгөлдөр бөгөөд тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээгүй байна.**

**Долоо. Үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх асуудлаар:**

Тус асуудлын хүрээнд Үнэт цаас гаргагчийн зүгээс эзэмшил, өмчлөлдөө аливаа төрлийн үнэт цаас буюу үнэт цаасны зах зээлд арилжаалагдах боломжтой санхүүгийн хэрэгсэл эзэмшдэггүй талаар Хуулийн фирмд мэдэгдсэн.

Эрдэнэс Сольюшинс ХК нь эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгэгдсэн, эрхийн улсын бүртгэлийн Ү-2202025501 дугаартай, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн №000836859 дугаартай гэрчилгээтэй, 130.46 м.кв талбайтай, оффис, үйлчилгээний зориулалттай 1 (нэг) үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг Хуулийн фирмд ирүүлсэн. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн 2022 оны 01 сарын 07-ны өдрийн Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн лавлагаанаас үзвэл Үнэт цаас гаргагчийн нэр дээр бүртгэлтэй, эрхийн улсын бүртгэлийн Ү-2202025501 дугаартай үл хөдлөх эд хөрөнгө нь бүртгэлтэй байх бөгөөд 2021 оны 06 сарын 24-ний өдөр Мирэ Эссет Секьюритис Монгол ҮЦК ХХК-тай байгуулсан үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээнд барьцаалагдсан тус үл хөдлөх эд хөрөнгийг 2021 оны 06 сарын 25-ны өдөр эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн бүртгэлд бүртгэгдсэн болохыг тодорхойлсон байна. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн хүчин төгөлдөр хэрэгжиж буй зохицуулалтаар[23] барьцаалуулагч өөрийн өмчлөлд байгаа аливаа үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийг барьцаалуулах эрхтэй болохыг хуульчилсан. Иймд Хуулийн фирмээс Үнэт цаас гаргагч нь өөрийн өмчлөлийн үл хөдлөх эд хөрөнгийг үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаа болгож барьцаалсан бөгөөд холбогдох бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн байна гэж үзлээ.

Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны 2022 оны 01 сарын 11-ний өдрийн №03-06/75 тоот лавлагаанаас үзвэл Үнэт цаас гаргагч нь Нийслэлийн Засаг даргын захирамжаар газар ашиглуулж, эзэмшүүлсэн эрхийн бүртгэл газрын кадастрын мэдээллийн нэгдсэн сангийн "Лэнд менежер" программд бүртгэлгүй болохыг тодорхойлсон байна.

Автотээврийн Үндэсний Төвийн 2022 оны 01 сарын 04-ний өдрийн №003 тоот Лавлагаанаас үзвэл Эрдэнэс Сольюшинс ХК-ийн нэр дээр бүртгэлтэй тээврийн хэрэгсэл байхгүй болохыг тодорхойлсон байна.

[23] **Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль (2009).**
**9 дүгээр зүйл.Үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийг барьцаалуулах**
9.1.Барьцаалуулагч өөрийн өмчлөлд байгаа Иргэний хуулийн 84.3-т заасан үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийг барьцаалуулах эрхтэй.
9.2.Барьцааны гэрээг байгуулахдаа бусад этгээдийн зөвшөөрлийг урьдчилан авахаар хуульд заасан бол зөвшөөрлийг хуульд заасан хэлбэрээр авсан байна.
9.3.Үүрэг гүйцэтгэгч /түрээслэгч, хөлслөгч/ нь үл хөдлөх эд хөрөнгийг түрээслэх, хөлслөх эрхийг гагцхүү үүрэг гүйцэтгүүлэгч /түрээслүүлэгч, хөлслүүлэгч/-ийн бичгээр өгсөн зөвшөөрөлтэйгээр барьцаалуулж болно.
9.4.Хуулийн этгээдийн өмчлөлд байгаа эд хөрөнгийг барьцаалуулах шийдвэрийг хууль буюу дүрэмд заасан эрх бүхий этгээд гаргана.



ERDENES SOLUTIONS Joint Stock Company
УЛААНБААТАР ХОТ
ГҮЙДСЕК ҮЦК ХК
ТТБ0674 ☎ 5208173

2022 -05- 25 БҮРТГЭВ
2022 -03- 22 БҮРТГЭВ-03

Нууц баримт
Эх хувь

Хуулийн фирмийн зүгээс өмчлөх эрхийг баталгаажуулах боломжгүй бусад хөрөнгийн хувьд тусгайлан дүгнэлт хийгээгүй бөгөөд шалгуур асуултын хүрээнд Үнэт цаас гаргагчийн эзэмшиж байгаа эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх асуудлаар холбогдох баримт материал, төрийн эрх бүхий байгууллагын баримт материал дээр үндэслэн дүн шинжилгээ хийсэн болохыг дурдаж байна. Түүнчлэн өмчлөх эрхийг баталгаажуулах боломжгүй бусад хөрөнгө болон Мөнх Оргил Трейд ХХК-ийн Хөрөнгийн үнэлгээний тайлан болон Үнэт цаас гаргагчийн санхүү байдлын тайланд тусгагдсан хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг баталгаажуулах боломжгүй тул хөрөнгөтэй холбоотой асуудлаар Үнэт цаас гаргагчаас тодруулж асууна уу.

**Нэгтгэн дүгнэж үзвэл Үнэт цаас гаргагчийн өмчлөлд байгаа 1 (нэг) үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрх хүчин төгөлдөр бөгөөд хугацаа дуусах, цуцлагдах нөхцөл байдал үүсээгүй бөгөөд үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн барьцааны эрхийг улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн байна гэж Хуулийн фирмээс дүгнэлээ.**

**Найм. Үнэт цаасыг бүртгүүлэх танилцуулгад тусгагдсан хууль зүйн мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх асуудлын хувьд үзвэл:**

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэгт "Үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээллийн үнэн зөв, хүчин төгөлдөр эсэхийг энэ хуулийн 33.2.1-д заасан хууль зүйн зөвлөгөө үзүүлэх үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээр, санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв эсэхийг энэ хуулийн 33.2.3-т заасан аудитын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээр тус тус хянуулж, дүгнэлт гаргуулна" гэж заасны дагуу тус Хуулийн фирм нь Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээллүүдийг нягталж нийтэд илэрхий мэдээ баримт, төрийн болон эрх бүхий байгууллагуудаас гаргаж өгсөн лавлагаа, тодорхойлолтууд, Үнэт цаас гаргагчийн зүгээс гаргаж өгсөн баримт бичигт харьцуулсан дүн шинжилгээ хийсэн.

Хуулийн фирм нь андеррайтер компани болох Гүүдсек ҮЦК ХХК-ийн бэлтгэсэн Үнэт цаасны танилцуулгатай танилцаж дүн шинжилгээ хийсэн бөгөөд Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хууль зүйн ач холбогдол бүхий Үнэт цаас гаргагчийн оноосон нэр, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн болон регистрийн дугаар, бүртгэсэн он, сар, өдөр, хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл, хувь нийлүүлсэн хөрөнгийн хувь хэмжээ, Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт, эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод, зарласан болон гаргасан үнэт цаасны тоо, төрөл, нэрлэсэн үнэ болон өөрийн хөрөнгийн хэмжээ, нийтэд санал болгож байгаа үнэт цаасаар гэрчлэгдэх эрх, үүргийн талаарх мэдээлэл нь Хуулийн фирмд Үнэт цаас гаргагчийн зүгээс гаргаж өгсөн баримттай нийцэж байх тул үнэн зөв тусгагдсан байна гэж үзлээ.

Эдгээр дурдсан хууль зүйн ач холбогдолтой мэдээллээс бусад Үнэт цаас гаргагчийн санхүүгийн үзүүлэлт, борлуулалтын хэмжээ, ашиг, алдагдал зэрэг бизнесийн үйл ажиллагаа, Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны тухай болон Үнэт цаас гаргагчийн зах зээлийн төлөвлөгөө зэрэг агуулагдсан эдийн засгийн ерөнхий мэдээлэл, салбарын үзүүлэлт, Үнэт цаас гаргагчийн талаар олон нийтэд ил, тодорхой үйл баримт, үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд тусгагдсан баталгаажуулах боломжгүй тоон үзүүлэлт болон хараат бус байгууллагуудын хийсэн дүн шинжилгээ, санхүүгийн тооцоолол, төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэр зэрэг мэдээлэлд Хуулийн фирмийн зүгээс дүн шинжилгээ хийгээгүй болохыг дурдаж байна.

Нэгтгэн дүгнэж үзвэл Үнэт цаас гаргагчийн үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хууль зүйн ач холбогдол бүхий мэдээлэл нь үнэн зөв, хүчин төгөлдөр байна гэж Хуулийн фирм дүгнэж байна.



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК ERDENES SOLUTIONS Joint Stock Company
УЛААНБААТАР ХОТ ГҮҮДСЕК ҮЦК ХХК

он сар өдөр
2022.05.25
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -03- 22
БҮРТГЭВ-03

Нууц баримт
Эх хувь

**Ес. Компанийн толгой, охин, хараат, зэргэцээ компанийн талаарх мэдээлэлд үндэслэн Үнэт цаас гаргагч компанийн хяналтыг хэрэгжүүлэгч, эцсийн өмчлөгч этгээдийг тодорхойлох асуудлын хувьд үзвэл:**

Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт "Компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 20-50 хувийг өөр (толгой) компани дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа тохиолдолд уг компанийг хараат компани гэнэ", 6.3 дахь хэсэгт Компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 50-аас дээш хувийг өөр (толгой) компани дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшдэг бие даасан компанийг охин компани гэнэ", 6.15 дахь хэсэгт "Нэг толгой компанийн хараат болон охин компаниуд, эсхүл нэг этгээд дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран хувьцааных нь хяналтын багцыг эзэмшдэг компаниудыг зэргэлдээ компани гэнэ" гэж хуульчилсан.

Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн баримт материалаас үзвэл энэхүү Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар Эрдэнэс Сольюшинс ХК нь дараах хуулийн этгээдийн энгийн хувьцааг эзэмшиж байна. Үүнд:

*Хүснэгт №12. Эрдэнэс Сольюшинс ХК-ийн эзэмшиж буй хувьцаа, хөрөнгө оруулалтын бүтэц.*

| № | Компанийн нэр | Хувь хэмжээ |
|---|---|---|
| 1. | Эрдэнэс Капитал Маркетс ХХК | 100% |
| 2. | Эрдэнэс Агро энд Ресорт ХХК | 100% |
| 3. | Эрдэнэс Рийл Эстэйт ХХК | 100% |
| 4. | Эйс Ассошэйтс ББСБ ХХК | 85% |

Компанийн тухай хуулийн зохицуулалтын дагуу компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байх бөгөөд хувьцаа эзэмшигчид нь хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж байгаа асуудлыг санал хураалтаар шийдвэрлэхэд энгийн хувьцаа эзэмшигч саналын нэг эрхтэй оролцдог үндсэн зохицуулалттай байдаг[24]. Үнэт цаас гаргагчийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээдийг тодорхойлох асуудлын хүрээнд Хуулийн фирм нь Эрдэнэс Сольюшинс ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдэгдэж байгаа аливаа асуудлаар саналын давуу эрхтэй, эцсийн шийдвэрийг гаргахад саналын давуу эрхээрээ шууд нөлөөлөх боломжтой хувьцаа эзэмшигчийг жинхэнэ хяналтыг хэрэгжүүлэгч, эцсийн өмчлөгч[25] этгээд гэж тооцож авч үзэж тогтоохыг зорьсон.

[24] **Компанийн тухай хууль (2011).**
59 дүгээр зүйл.Хувьцаа эзэмшигчдийн хурал
59.1.Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна.
63 дугаар зүйл.Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр хүчин төгөлдөр болох
63.1.Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж байгаа асуудлыг санал хураалтаар шийдвэрлэхэд энгийн хувьцаа эзэмшигч энэ хуулийн 34 дүгээр зүйлд, давуу эрхийн хувьцаа эзэмшигч энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан саналын эрх эдэлнэ.
63.2.Хуульд өөрөөр заагаагүй бол нэг хувьцаа саналын нэг эрхтэй байна.
34 дүгээр зүйл.Компанийн энгийн хувьцаа эзэмшигчийн эрх
34.1.Компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь дараах эрх эдэлнэ:
34.1.1.хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хурлаар хэлэлцэж байгаа бүх асуудлаар өөрийн эзэмшлийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн санал өгөх;
34.1.2.давуу эрхийн хувьцааны ногдол ашиг төлсний дараагаар компанийн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-өөс тогтоосон хэмжээгээр ногдол ашиг авах,
34.1.3.компанийг татан буулгах үед энэ хуулийн 28 дугаар зүйлд заасан журмын дагуу үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх.

[25] **Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль (2018).**
4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт
4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:
4.1.11."эцсийн өмчлөгч" гэж Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3.1.6-д заасныг.
**Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль (2013).**
3 дугаар зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт
3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:
3.1.6."эцсийн өмчлөгч" гэж:
/Энэ заалтыг 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./
3.1.6.а.харилцагч нь хуулийн этгээд бол тухайн хуулийн этгээдийн хөрөнгийн дийлэнх хэсгийг дангаараа, эсхүл бусадтай хамтран өмчилж байгаа, эсхүл тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж, эсхүл өөрийн үйлдлийг бусдаар



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company

УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК
58674 5208173

Нууц баримт
Эх хувь

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн 2022 оны 03 сарын 02-ны өдрийн №22900002000834 тоот Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн лавлагаанаас үзвэл Үнэт цаас гаргагч Эрдэнэс Сольюшинс ХК (Улсын бүртгэлийн дугаар №9010001131, Регистрийн дугаар №: 2015358) нь нэг бүр нь 10 (арван) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 157,874,570 (нэг зуун тавин долоон сая найман зуун далан дөрвөн мянга таван зуун далан) ширхэг энгийн хувьцаатай буюу 1,578,745,700 (нэг тэрбум таван зуун далан найман сая долоон зуун дөчин таван мянга долоон зуун) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, хэлбэрийн хувьд хувьцаат компани болохыг тодорхойлсон байна.

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн 2022 оны 01 сарын 12-ны өдрийн Үнэт цаас эзэмшигчдийн хураангуй судалгаанаас үзвэл Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид Эрдэнэс Сольюшинс ХК-ийн нэр дээр 157,874,570 (нэг зуун тавин долоон сая найман зуун далан дөрвөн мянга таван зуун далан) ширхэг хувьцаа бүртгэгдсэн бөгөөд 2022 оны 01 сарын 10-ны өдрийн байдлаар 241 (хоёр зуун дөчин нэгэн) хувьцаа эзэмшигчтэй бөгөөд Компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 63.74 хувийг Субашид Тек ХХК эзэмшиж байна. Үүнд:

***Хүснэгт №13. Эрдэнэс Сольюшинс ХК-ийн саналын эрх бүхий хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг эзэмшдэг хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл.***

| № | Хувьцаа эзэмшигч | Нэгж хувьцааны үнэ (төгрөгөөр) | Хувьцааны тоо (ширхгээр) | Нийт дүн (төгрөгөөр) | Хувь хэмжээ |
|---|---|---|---|---|---|
| 1. | Субашид Тек ХХК | 10 | 100,628,934 | 1,006,289,340 | 63.74% |
| 2. | Ц.Хүдэрмөнх | 10 | 9,400,000 | 94,000,000 | 5.95% |
| 3. | Т.Дөлгөөн | 10 | 9,400,000 | 94,000,000 | 5.95% |
| 4. | Г.Дулмаа | 10 | 9,176,581 | 91,765,810 | 5.81% |
| 5. | М.Бат-Эрдэнэ | 10 | 9,400,000 | 94,000,000 | 5.95% |

Хүснэгт дэх Компанийн саналын эрх бүхий хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг эзэмшдэг хувьцаа эзэмшигчдийн хувь эзэмшлийн мэдээллээс үзвэл Компанийн гаргасан нийт энгийн хувьцааны 63.74 хувьд ногдох хувьцааг Субашид Тек ХХК хуулийн этгээд эзэмшиж байна.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн 2022 оны 03 сарын 02-ны өдрийн №22900002000834 тоот Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн лавлагаанаас үзвэл Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт энгийн хувьцааны 63.74 хувьд ногдох хувьцааг Субашид Тек ХХК эзэмшиж байх бөгөөд Эрдэнэс Сольюшинс ХК-ийн эцсийн өмчлөгчөөр Монгол Улсын иргэн Б.Батхүү, Монгол Улсын иргэн Т.Золбоо, Монгол Улсын иргэн Ц.Хүдэрмөнх нар бүртгэгдсэн байна.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн 2022 оны 03 сарын 02-ны өдрийн №22900002000834 тоот Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн лавлагаанаас үзвэл Эрдэнэс Сольюшинс ХК-ийн гаргасан энгийн хувьцааны 33.30 хувийг Монгол Улсын иргэн Б.Батхүү, 33.30 хувийг Монгол Улсын иргэн Т.Золбоо болон 33.30 хувийг Монгол Улсын иргэн Ц.Хүдэрмөнх нар тус тус эзэмшдэг болохыг тодорхойлсон байна.

Иймд дээр дурдсан хуулийн зохицуулалт болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн лавлагаанд үндэслэж үзвэл Эрдэнэс Сольюшинс ХК-ийн хөрөнгийн дийлэнх хэсгийг өмчилж байгаа, тус хуулийн этгээдийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж, хуулийн этгээдийг болон уг хуулийн этгээдээс хийх аливаа хэлцэл, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдах замаар тухайн хуулийн этгээдийг өмчилж үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа Монгол Улсын иргэн Б.Батхүү,

төлөөлүүлэн хийлгэж байгаа, эсхүл хуулийн этгээдийг болон уг хуулийн этгээдээс хийх аливаа хэлцэл, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдах замаар тухайн хуулийн этгээдийг өмчилж үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг;
3.1.6.б.харилцагч нь хувь хүн бол тухайн хүний үйлдэл, үйл ажиллагааг удирдан чиглүүлж, эсхүл тухайн хүнээр өөрийн үйлдлийг төлөөлүүлэн хийлгэж үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг;
3.1.6.в.хөрөнгийг удирдах хэлцлийн хувьд тухайн хөрөнгө итгэмжлэн удирдах хэлцлийн үндсэн дээр үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг;

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-03-22
БҮРТГЭВ-03

СЗХ
он 2022 сар 05 өдөр 25
БҮРТГЭВ

Нууц баримт
Эх хувь

Монгол Улсын иргэн Т.Золбоо, Монгол Улсын иргэн Ц.Худэрмөнх нарыг Үнэт цаас гаргагчийн хяналтыг хэрэгжүүлэгч бөгөөд эцсийн өмчлөгч этгээд байна гэж Хуулийн фирмээс дүгнэлээ.

**Арав. Үнэт цаас гаргагч нь аж ахуйн үйл ажиллагааны эсрэг гэмт хэрэг, иргэн, захиргааны хэрэгт хариуцагчаар татагдаж байсан эсэх асуудлын хувьд үзвэл:**

Хуулийн фирм нь Компани нь Монгол Улсын арбитр, шүүхэд хэргийн оролцогчоор оролцсон болон оролцож байгаа эсэх талаар төрийн байгууллагаас ирүүлсэн лавлагааны хариу болон Компаниас ирүүлсэн материал дээр үндэслэн хэрэг маргааны шалтгаан, хүлээгдэж буй үр дүнд хуулийн дүн шинжилгээ хийлээ.

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрын 2022 оны 01 сарын 04-ний өдрийн №4/18 тоот тодорхойлолтоос үзвэл Эрдэнэс Сольюшинс ХК нь тус арбитраар хянан шийдвэрлэгдсэн болон арбитрын ажиллагаа явагдаж байгаа хэрэгт нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцоогүй болохыг тодорхойлсон байна.

Улаанбаатар хотын Худалдааны танхимын дэргэдэх Арбитрын 2022 оны 01 сарын 10-ны өдрийн №GS-2022-002 тоот тодорхойлолтоос үзвэл Эрдэнэс Сольюшинс ХК нь арбитрын маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд өнөөдрийг хүртэл хэргийн оролцогчоор оролцоогүй болохыг тодорхойлсон байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн тусгай архивын 2022 оны 01 сарын 04-ний өдрийн №1/28 тоот тодорхойлолтоос үзвэл Эрдэнэс Сольюшинс ХК нь сүүлийн 3 жилийн байдлаар Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх, Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх, Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх, Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн иргэний хэрэгт хариуцагчаар оролцож байгаагүй болохыг тодорхойлсон байна.

Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын 2022 оны 01 сарын 17-ны өдрийн №23 тоот албан бичгээс үзвэл Эрдэнэс Сольюшинс ХК нь Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэгч, хариуцагч болон гуравдагч этгээдээр сүүлийн 3 (гурван) жилийн хугацаанд оролцож байгаагүй болохыг тодорхойлсон байна.

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын 2022 оны 01 сарын 05-ны өдрийн №0020 тоот албан бичгээс үзвэл Эрдэнэс Сольюшинс ХК нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэгч болон гуравдагч этгээдээр сүүлийн 3 (гурван) жилийн хугацаанд оролцож байгаагүй болохыг тодорхойлсон байна.

Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 01 сарын 10-ны өдрийн №21 тоот тодорхойлолтоос үзвэл Эрдэнэс Сольюшинс ХК болон эрх бүхий этгээд Ц.Худэрмөнх нь 2019 оноос хойш Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүдийн бүртгэл хяналтын нэгдсэн систем, архивын бүртгэлээс шүүж үзэхэд холбогдох хэрэг материал шүүхэд шилжин ирээгүй болохыг тодорхойлсон байна.

Иймд Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн баримт материал болон эрх бүхий байгууллагын лавлагаа, тодорхойлолтод үндэслэн Үнэт цаас гаргагч нь аж ахуйн үйл ажиллагааны эсрэг гэмт хэрэгт татагдаж байгаагүй, аливаа иргэний хэрэг, маргаанд нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцож байгаагүй байна.

**Арван нэг. Үнэт цаас гаргагч татвар, нийгмийн даатгал болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт өр төлбөртэй эсэх асуудлын хувьд үзвэл:**

Хуулийн фирм нь Эрдэнэс Сольюшинс ХК-ийн татвар, нийгмийн даатгал болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт өр төлбөртэй эсэх болон бусдын өмнө хүлээсэн өр төлбөртэй эсэх



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company
9020080899

УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ХХК
ТТ58674

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
2022 .05. 25

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -03- 22
БҮРТГЭВ-03



асуудлыг нягталж харьяа төрийн эрх бүхий байгууллагаас дэлгэрэнгүй лавлагаа, тодорхойлолт гаргуулан авлаа. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий байгууллагаас авсан лавлагаа, тодорхойлолтыг **Хавсралт №05. "Эрдэнэс Сольюшинс ХК-тай холбогдуулан эрх бүхий байгууллагаас авсан хөндлөнгийн лавлагаа, тодорхойлолт"** хүснэгтээс дэлгэрүүлэн үзнэ үү. Үүнд:

Монголын татварын албаны 2022 оны 01 сарын 04-ний өдрийн №22.1003.0ce156f3-eb65-446a-98f0-31553304c302 тоот цахим лавлагаа, тодорхойлолтоос үзвэл Эрдэнэс Сольюшинс ХК нь 1,985,500 (нэг сая есөн зуун наян таван мянга таван зуун) төгрөгийн дутуу төлөлттэй бөгөөд 5,420,000 (таван сая дөрвөн зуун хорин мянган) төгрөгийн илүү төлөлттэй болохыг тодорхойлсон байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2022 оны 01 сарын 20-ны өдрийн №O221AW27K260023477642 тоот лавлагаанаас үзвэл Эрдэнэс Сольюшинс ХК нь 5,209,600 (таван сая хоёр зуун есөн мянга зургаан зуун) төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгтэй болохыг тодорхойлсон байна.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Шийдвэр гүйцэтгэх албаны 2022 оны 01 сарын 04-ний өдрийн №0026145 тоот тодорхойлолтоос үзвэл Эрдэнэс Сольюшинс ХК нь шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд төлбөргүй болохыг тодорхойлсон байна.

Иймд дээр дурдсан төрийн эрх бүхий байгууллагын лавлагаа, тодорхойлолтод үндэслэн Үнэт цаас гаргагч Эрдэнэс Сольюшинс ХК нь дээр дурдсан татварын дутуу төлөлт болон нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрөөс бусдаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт болон бусдад төлөх өр төлбөргүй байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

Нэгдсэн дүгнэлт

**Үнэт цаас гаргагч Эрдэнэс Сольюшинс ХК нь Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржийн Үнэт цаасны бүртгэлийн журмаар тогтоосон шалгуурыг хангаж байна гэж Хуулийн фирмээс дүгнэлээ.**

-------ooOoo-------

ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS
Joint Stock
Company
9020080899 2015

УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК
ХХН ХХК
ТТБ8674 ☎ 5208173

Нууц баримт
Эх хувь

**Хариуцлага хязгаарлах тухай**

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаанд бүхэлд нь өгсөн үнэлэлт, дүгнэлтэд тооцогдохгүй бөгөөд зөвхөн нийтэд санал болгон нэмж хувьцаа гаргахтай холбогдуулан төрийн байгууллагын тавьсан шаардлагын хүрээнд буюу дээр дурдагдсан асуудлуудын хүрээнд хязгаарлагдана.

Энэхүү Хуулийн дүгнэлтийг Компанийн хүсэлтээр, түүнээс тодорхойлсон ажлын даалгаврыг үндэслэн Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд Үнэт цаас гаргагчийн нэр дээр хаяглан хүргүүлсэн болно. Үнэт цаас гаргагч, түүнээс эрх олгогдсон этгээдийн зөвшөөрөлгүйгээр энэхүү Хуулийн дүгнэлтийг бүхэлд нь болон хэсэгчлэн салган авч ашиглах, түгээх, дамжуулахыг хориглоно.

Эрдэнэс Сольюшинс ХК, түүний холбоо, хамааралтай этгээд, тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан энэхүү Хуулийн дүгнэлтийг харилцан тохиролцсоноос бусад зорилгоор ашигласан, түгээсэн, бусдад танилцуулсан, тайлбарласан, хэсэгчлэн задруулсан, нийтэд ил болгосноос үүсэх асуудлаар Хуулийн фирм хариуцлага хүлээхгүй бөгөөд энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаа болон анх удаа нийтэд санал гаргаж буй үнэт цаасанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй.

Хуулийн фирм нь хараат бус байх, гаргаж өгсөн баримт материалын хүрээнд дүн шинжилгээ хийх зарчмыг баримтлан хөндлөнгийн дүн шинжилгээг хийж гүйцэтгэсэн тул дүн шинжилгээнд хамруулах шаардлагатай чухал үйл баримт, Компаниас орхигдуулсан аливаа бусад гол баримт, материал, буруу дутуу, худал мэдээлэл гаргаж өгсөн, дүн шинжилгээ хийхэд ашигласан лавлагаа, тодорхойлолт бусад баримт материалд дурдагдсан хууль зүйн ач холбогдолтой аливаа нөхцөл, байдал дүн шинжилгээ хийснээс хойш Хуулийн фирмд мэдэгдэлгүйгээр өөрчлөгдсөнөөс үүдэн гарах аливаа асуудлаар хариуцлага хүлээхгүй болно.

ХҮНДЭТГЭСЭН,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Д.ХУЛАН

Хавсралт №01. Эрдэнэс Сольюшинс ХК-ийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй журмын жагсаалт

ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
МӨРДӨГДӨЖ БУЙ ЖУРМЫН ЖАГСААЛТ

| № | Журмын нэр, төрөл | Батлагдсан огноо | Баталсан тогтоол, шийдвэрийн дугаар |
|---|---|---|---|
| 1. | Хувьцаа эзэмшигчдийн хурлын журам | 2016.05.12 | ТУЗТ03/2016 |
| 2. | Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам | 2016.05.12 | ТУЗТ03/2016 |
| 3. | Ногдол ашгийн бодлого, шийдвэр гаргах, мэдээлэх, тарааж, олгох журам | 2016.05.12 | ТУЗТ03/2016 |
| 4. | Нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны журам | 2016.05.12 | ТУЗТ03/2016 |
| 5. | Аудитын хорооны үйл ажиллагааны журам | 2016.05.12 | ТУЗТ03/2016 |
| 6. | Мэдээллийн үйл ажиллагааны журам | 2016.05.12 | ТУЗТ03/2016 |
| 7. | Цалин, урамшууллын хорооны үйл ажиллагааны журам | 2016.05.12 | ТУЗТ03/2016 |

Хүснэгт №02. Эрдэнэс Сольюшинс ХК-ийн бусадтай бичгээр байгуулсан гэрээ, хэлцлийн дэлгэрэнгүй мэдээлэл

*Үйл ажиллагааны чиглэл*: Мэдээллийн технологи, программ хангамжийн үйл ажиллагаа, компьютерийн тоног төхөөрөмжийн худалдаа, вэб сайт хийх, онлайн худалдаа, худалдааны зуучлал

*Захиалагчийн хаяг*: Улаанбаатар хот, ЧД, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, Денвер оффис, 401 тоот

*Захиалга*: 2022 оны 01-р сарын 20-ны өдрийн ЭС/МОТ 02 - 2022 тоот гэрээ

### 1.2. Гүйцэтгэгчийн талаарх мэдээлэл

*Гүйцэтгэгчийн нэр*: "Мөнх-Оргил трейд" ХХК

*Гүйцэтгэгчийн бүртгэл, регистрийн дугаар*: 9011106018, 2041537

*Үйл ажиллагааны чиглэл:* Хөрөнгийн үнэлгээ, байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, бизнес, хуульзүйн зөвлөгөө

*Гүйцэтгэгчийн хаяг*: Улаанбаатар хот, ЧД, 1-р хороо, Сүхбаатарын талбай-7, МҮЭХ-ны байр, 211 тоот

Үнэлгээний ажилд оролцсон үнэлгээчдийн талаарх мэдээлэл

| Нэр | Үнэлгээч-ний зэрэг, дэв | Албан тушаал | Үнэлгээний чиглэлээр ажилласан жил | Хөрөнгийн үнэлгээ хийх тусгай эрхийн гэрчилгээний дугаар | Үнэлгээний ажилд оролцсон хуваарь |
|---|---|---|---|---|---|
| Б.Эрдэнэбаатар | Тэргүүлэх үнэлгээчин | Хөрөнгийн үнэлгээний "Мөнх-Оргил трейд" ХХК-ний захирал | 24 | 071200004 | Багийн ахлагч |
| Ч.Дарамбазар | Хөрөнгийн тэргүүлэх үнэлгээчин | Хөрөнгийн үнэлгээний "Мөнх-Оргил трейд" ХХК-ний үнэлгээчин | 24 | 071200078 | Үнэлгээчин |

Гүйцэттгэгчийн мэргэжлийн хариуцлагын даатгалын талаарх мэдээлэл

| Даатгалын компаний нэр | Даатгалын хугацаа | Даатгалын хэмжээ, сая төг | Даатгалын гэрээний дугаар |
|---|---|---|---|
| "Монгол даатгал" ХХК | 2022.09.11-ний өдрийг дуустал | 50.0 | 90C2120009980 |

Гүйцэтгэгчийн хараат бус бие даасан байдлын талаарх мэдэгдэл

| Д/д | Шалгуур | Хариулт | |
|---|---|---|---|
| | | Тийм | Үгүй |

2022 -03- 22
БҮРТГЭВ-03



| | | | |
|---|---|---|---|
| 1 | Үнэлгээчид нь "Эрдэнэс сольюшинс" ХК-тай ямар нэг хамааралтай эсэх /урьд нь хамтран ажиллаж байсан, удирдах түвшний этгээдтэй хамаатан, садан, бусад төрлийн хобоотой/ | | + |
| 2 | Үнэлгээчид нь "Эрдэнэс сольюшинс" ХК-д ямар нэг хувьцаа, хувь оролцоотой эсэх | | + |
| 3 | Үнэлгээчид нь нь "Эрдэнэс сольюшинс" ХК-тай урьд өмнө үүссэн өр, авлагын тооцоотой эсэх | | + |
| 4 | Үнэлгээчид нь үнэлж байгаа хөрөнгийн өмчлөгч /эзэмшигч/-тэй хамааралтай эсэх /урьд нь хамтран ажиллаж байсан, удирдах түвшний этгээдтэй хамаатан, садан, бусад төрлийн хобоотой/ | | + |
| 5 | Үнэлгээчид нь үнэлж байгаа хөрөнгийн өмчлөгч /эзэмшигч/ хуулийн этгээдэд ямар нэг хувьцаа, хувь оролцоотой эсэх | | + |
| 6 | Үнэлгээчид нь үнэлж байгаа хөрөнгийн өмчлөгч /эзэмшигч/-тэй урьд өмнө үүссэн өр, авлагын тооцоотой эсэх | | + |
| 7 | Үнэлгээг хийхэд нь "Эрдэнэс сольюшинс" ХК болон үнэлж байгаа хөрөнгийн өмчлөгч /эзэмшигч/-ийн зүгээс хөрөнгийн үнэ, цэнэд нөлөөлж болох ямар нэг нөлөө үзүүлсэн эсэх | | + |
| 8 | Үнэлгээчид нь тухайн хөрөнгийг урьд, өмнө нь үнэлж байсан эсэх | | + |
| 9 | Тухайн хөрөнгийн үнэ, цэнийн түвшин нь үнэлгээчинд ямар нэг ашиг авчрах эсэх | | + |
| 10 | Үнэлгээний ажлын хөлс нь үнэлгээний ажлын үр дүнтэй хамааралтай эсэх | | + |
| 11 | Үнэлгээчид нь тухайн ажлыг гүйцэтгэх хангалттай ур чадвартай эсэх | + | |

**1.3. Үнэлгээний зорилго, зориулалт, хугацаа, хамрах хүрээ /ҮОУС 2020-101/**

**1.3.1.** Энэхүү үнэлгээний ажлын зорилго нь "Эрдэнэс сольюшинс" ХК-ний бизнес /өмчийн 100.0%-ийн хувийн хувь оролцоо/-ийн зах зээлийн үнэ, цэнийг тодорхойлоход оршино.

**1.3.2.** Үнэлгээний үр дүнг "Эрдэнэс солюшинс" ХК-иас нэмэлт хувьцааг олон нийтэд санал болгож, хөрөнгийн биржээр худалдахад зорилгоор нэгж хувьцааны үнэ, цэнийг тодорхойлоход хэрэглэнэ.

**1.3.3.** Үнэлгээг 2022 оны 01-р сарын 20-ноос 2022 оны 02-р сарын 28-ны хооронд хийсэн бөгөөд үнэлгээний дүгнэлтийг 2021 оны 12-р сарын 31-ний байдлаар гаргасан болно.

Үнэлгээний огноо: 2021.12.31.

Үнэлгээний тайлангийн огноо: 2022 оны 02-р сарын 28-ны өдөр.

**1.3.4.** Үнэлгээний хамрах хүрээ

Үнэлгээний Олон Улсын Стандартууд /IVS 2020/ нь үнэлгээний ажлуудын цар хүрээг хамарч ашиглагдахаар зориулагдсан байдаг.

Энэхүү үнэлгээний ажлын хамрах хүрээг ҮОУС 101-ын холбогдох заалтын дагуу захиалагчтай тохиролцсон бөгөөд өөрчлөх асуудал талуудын зүгээс гаргаагүй болно.

**Тодорхойлох үнэ, цэнийн түвшин.** "Үнэлгээний Олон улсын Стандарт 200. Бизнес ба бизнесийн хувь оролцоо"-ны 20.3-т "Үнэлгээг аж ахуйн нэгжийн хувьд бүхэлд нь гүйцэтгэж байгаа ч гэсэн тухайн үнэ цэнийг илэрхийлж болох өөр өөр түвшингүүд байж болох учраас үнэлж буй бизнес болон бизнесийн хувь оролцоог оновчтой тодорхойлох нь маш чухал юм" гэж заасны дагуу энэхүү үнэлгээнд уг стандартын 20.3-ын "г"-д заасан **"Өмчийн үнэ цэнэ"**-ийг тодорхойлсон болно. Энэ нь 20.3-ын "г"-д зааснаар "Өмчийн үнэ цэнэ: Түүний бүх хувьцаа эзэмшигчдэд хамаарах бизнесийн үнэ цэнэ юм".

Энэ талаар тайлангийн 2.2-т оруулсан болно.



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company

УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК
ТТБ0674 5209173

2022-03-22 БҮРТГЭВ-03



## ХОЁР. ҮНЭЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ, СТАНДАРТУУДЫН ХОЛБОГДОХ ЗААЛТУУД, ТАЙЛАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

### 2.1. Бизнесийн үнэлгээнд баримталсан ҮОУС-ууд

Энэхүү үнэлгээнд Үнэлгээний Олон Улсын доор заасан стандартуудыг мөрдлөг болгов. Үүнд:

1) Олон улсын үнэлгээний стандарт 2020-101. Үнэлгээний ажлын цар хүрээ,
2) Олон улсын үнэлгээний стандарт 2020-103. Тайлагнал,
3) Олон улсын үнэлгээний стандарт 2020-104. Үнэ, цэнийн сууриуд,
4) Олон улсын үнэлгээний стандарт 2020-105. Үнэлгээний хандлагууд болон аргууд,
5) Олон улсын үнэлгээний стандарт 2020-200. Бизнес ба бизнесийн хувь оролцоо.

### 2.2. "Үнэлгээний Олон улсын стандарт 2020-200. Бизнес ба бизнесийн хувь оролцоо" стандартын зарим заалтууд

Бизнесийн үнэлгээний аргазүй, хандлагын талаарх тодорхойлолт, үндсэн зарчмуудыг "Олон улсын үнэлгээний стандарт-200. Бизнес ба бизнесийн хувь оролцоо" стандартад тусгагдсанаар доор оруулав. Үүнд:

*20.1. Бизнесийн юу бүрдүүлдэг талаарх тодорхойлолт нь үнэлгээний зорилгоос хамааран өөр өөр байж болно. Гэвч бизнес нь ерөнхийдөө худалдааны, үйлдвэрлэлийн, үйлчилгээний эсвэл хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг явуулдаг. Бизнес нь корпораци, нөхөрлөл, хамтарсан үйлдвэр, хувиараа эрхлэх аж ахуй гэх мэт олон хэлбэртэй байдаг. Бизнесийн үнэ цэнэ нь түүнийг бүрдүүлж буй тусдаа хөрөнгө ба өр төлбөрийн үнэ цэнүүдийн нийлбэрээс хамааран өөр өөр байж болох юм.*

*20.3. Үнэлгээчин нь нийт аж ахуйн нэгжийн, хувьцааны эсвэл уг аж ахуйн нэгж дэх хувьцаа эзэмшилтийн (хяналтын эсвэл хяналтын бус хувь оролцооны) эсвэл тухайн аж ахуйн нэгжийн тодорхой бизнесийн үйл ажиллагааны үнэлгээг хийх эсэхийг тогтоох ёстой. Үнэ цэнийн суурь нь үнэлгээний зорилгын хувьд тохиромжтой байх бөгөөд гэрээт ажлын цар хүрээний нэг хэсэг болон танилцуулагдах ёстой (ҮОУС 101 Ажлын цар хүрээ-г үз). Үнэлгээг аж ахуйн нэгжийн хувьд бүхэлд нь гүйцэтгэж байгаа ч гэсэн тухайн үнэ цэнийг илэрхийлж болох өөр өөр түвшингүүд байж болох учраас үнэлж буй бизнес болон бизнесийн хувь оролцоог оновчтой тодорхойлох нь маш чухал юм. Тухайлбал:*

***(а) Байгууллагын үнэ цэнэ:** Бизнес дэх өмчийн нийт үнэ цэнэ дээр түүний өр буюу үүрэгтэй холбоотой өр төлбөрийг нэмж, тэдгээр өр төлбөрийг барагдуулах боломжтой мөнгө буюу мөнгөтэй адилтгах зүйлсийг хассанаар ихэвчлэн тодорхойлдог.*

***(б) Нийт оруулсан капиталын үнэ цэнэ:** Их үүсвэрээс үл хамааран бизнест одоогоор оруулсан байгаа мөнгөний нийт дүн бөгөөд нийт хөрөнгөөс өр төлбөр болон мөнгийг хассан үнэ цэнэ байдлаар ихэвчлэн тусгадаг.*

***(в) Үйл ажиллагааны үнэ цэнэ:** Бизнесийн үйл ажиллагааны нийт үнэ цэнэ бөгөөд үйл ажиллагааны бус аливаа хөрөнгө болон өр төлбөрийг үүнд оруулдаггүй.*

*(г) Өмчийн үнэ цэнэ: Түүний бүх хувьцаа эзэмшигчид хамаарах бизнесийн үнэ цэнэ юм.*

*40. Үнэлгээний хандлагууд ба аргууд*

*40.1. ҮОУС 105 Үнэлгээний хандлагууд ба аргууд-д тодорхойлсон үнэлгээний үндсэн гурван хандлагыг бизнесийн болон бизнесийн хувь оролцооны үнэлгээнд хэрэглэж болох юм.*

*50. Зах зээлийн хандлага*

*50.1. Бизнес ба бизнесийн хувь оролцоо нь ҮОУС 105 Үнэлгээний хандлагууд ба аргуудын, үүн дотроо догол мөр 20.2 буюу 20.3-ын шалгуурыг ямагт хангадаг тул тэдгээр хөрөнгийн үнэлгээнд зах зээлийн хандлагыг ихэвчлэн хэрэглэдэг. Бизнес ба бизнесийн хувь оролцоог зах зээлийн хандлагын дагуу үнэлэх тохиолдолд үнэлгээчин нь ҮОУС 105 Үнэлгээний хандлагууд ба аргуудын, хэсэг 20 ба 30 дахь шаардлагуудыг даган мөрдвөл зохино.*

*50.2. Зах зээлийн хандлагын дагуу бизнесийн ба бизнесийн хувь оролцоог үнэлэхэд ашигладаг мэдээний хамгийн нийтлэг гурван эх үүсвэр нь дараах байдалтай байна:*

*(а) төсөөтэй бизнесийн өмчлөлийн хувь оролцоог арилжаалдаг нийтийн хувьцааны зах зээл,*
*(б) нийт бизнес буюу бизнес дэх хяналтын хувь оролцоог худалдан авах ба борлуулдаг бизнесийн худалдан авалтын зах зээл, ба*
*(в) үнэлж буй бизнесийн өмчлөлийн хувьцаа буюу өмчлөлийн санал гаргалтын өмнөх ажил гүйлгээнүүд.*
*50.3. Зах зээлийн хандлагын хувьд төсөөтэй бизнесийн жишилт хийх ба итгэл үзүүлэх үл үндэслэлтэй суурь байх ёстой. Эдгээр төсөөтэй бизнесүүд нь үнэлж буй бизнестэй нэг ижил салбарт эсвэл эдийн засгийн ижил хувьсагчдад хариу үзүүлэх тийм салбарт байдаг байвал зохино. Жишилт хийх үл үндэслэлтэй суурь оршин байгаа эсэхийг үнэлэхдээ харгалзан үзвэл зохистой хүчин зүйлсэд дараах зүйлс багтдаг:*
*(а) бизнесийн чанарын болон тоон ойролцоо шинжүүдийн хувьд үнэлж буй бизнестэй төсөөтэй байх,*
*(б) төсөөтэй бизнесийн талаарх нийт дүн болон мэдээний шалгах боломжтой байдал, ба*
*(в) төсөөтэй бизнесийн үнэ нь харилцан хамааралгүй талуудын болон эрэмбэ дараатай үстгалтын ажил гүйлгээг илэрхийлэх эсэх.*
*50.4. Зах зээлийн үржүүлэгчийг хэрэглэх тохиолдолд догол мөр 60.8-д харуулсан гэх мэт тохируулга нь үнэлж буй компани болон жишиг компаниудын аль алины хувьд тохиромжтой байж болох юм.*
*50.5. Жишиг ажил гүйлгээг сонгох ба тохируулах үедээ үнэлгээчин нь ҮОУС 105 Үнэлгээний хандлагууд ба аргууд-ын, догол мөр 30.7-30.8 дахь шаардлагуудыг даган мөрдвөл зохино.*
*50.6. Жишиг нийтийн өмчлөлт компанийн мэдээллийг сонгох ба тохируулах үедээ үнэлгээчин нь ҮОУС 105 Үнэлгээчний хандлагууд ба аргуудын, догол мөр 30.13-30.14 дахь шаардлагуудыг даган мөрдвөл зохино.*

*60. Орлогын хандлага*
*60.1. Бизнес ба бизнесийн хувь оролцоо нь ҮОУС 105 Үнэлгээний хандлагууд ба аргуудын, догол мөр 40.2 буюу 40.3-ын шалгуурыг ямаст хангадаг тул эдгээр хөрөнгийн үнэлгээнд орлогын хандлагыг тогтмол хэрэглэдэг.*
*60.2. Орлогын хандлагыг хэрэглэх үед үнэлгээчин нь ҮОУС 105 Үнэлгээний хандлагууд ба аргууд-ын, хэсэг 40 ба 50 дахь шаардлагуудыг даган мөрдвөл зохино.*
*60.3. Бизнес буюу бизнесийн хувь оролцоотой холбоотой орлого ба мөнгөн гүйлгээг янз бүрийн арга замаар хэмжээг бөгөөд татварын өмнөх эсвэл татварын дараах суурь байж болно. Хэрэглэх капиталжуулалтын болон дискаунтын хувь нь ашиглах орлого болон мөнгөн гүйлгээнийхээ төрөлтэй нийцсэн байх ёстой.*
*60.4. Ашиглах орлого буюу мөнгөн гүйлгээний төрөл нь үнэлж буй хувь оролцооны төрөлтэй нийцсэн байвал зохино. Тухайлбал:*
*(а) капиталын жинлэсэн дундаж зардал гэх мэт байгууллагын түвшний мөнгөн гүйлгээнд хамаарах зохих дискаунтын хувь, түүнчлэн өрийн үйлчилгээний зардлын өмнөх мөнгөн гүйлгээг ашигласнаар байгууллагын үнэ цэнийг ихэвчлэн тогтоодог, ба*
*(б) өмчийн зардал гэх мэт өмчийн түвшний мөнгөн гүйлгээнд хамаарах зохих дискаунтын хувь ба өмчид хамаарах, өөрөөр хэлбэл өрийн үйлчилгээний зардлыг хассаны дараах мөнгөн гүйлгээг ашигласнаар өмчийн үнэ цэнийг тогтоож болох юм.*
*60.5. Орлогын хандлага нь орлого буюу мөнгөн гүйлгээг капиталжуулах үед капиталжуулалтын хувийг, харин мөнгөн гүйлгээг хорогдуулахад дискаунтын хувийг тооцоолохыг шаардаг. Тохиромжтой хувийг тооцоолохдоо, төсөөтэй хөрөнгө оруулалтуудын хувьд оролцогчдын хүлээж буй хүүний хувь, өгөөжийн хувь ба урьдчилан төсөөлсөн өгөөжийн урсгалд угийн агуулагдах эрсдэл гэх мэт хүчин зүйлсийг харгалзан үздэг (ҮОУС 105 Үнэлгээний хандлагууд ба аргууд-ын, догол мөр 50.29-50.31-ийг үз).*
*60.6. Хорогдуулах аргуудын хувьд, прогнозчилсон орлого буюу мөнгөн гүйлгээнд хүлээгдэж буй өсөлтийг нилээд тодорхой харгалзан үзэж болох юм. Харин капиталжуулалтын аргын хувьд, хүлээгдэж буй өсөлтийг капиталжуулалтанд ихэвчлэн тусган оруулдаг. Хэрэв прогнозчилсон мөнгөн гүйлгээг нэрлэсэн дүнгээр илэрхийлдэг бол инфляци эсвэл дефляциас хамааран хүлээгдэж буй ирээдүйн үнийн өөрчлөлтүүдийг харгалзсан дискаунтын хувийг хэрэглэвэл зохино. Хэрэв прогнозчилсон мөнгөн гүйлгээг бодит дүнгээр илэрхийлдэг бол инфляци эсвэл дефляциас хамааран хүлээгдэж буй ирээдүйн үнийн өөрчлөлтүүдийг харгалзаагүй дискаунтын хувийг хэрэглэвэл зохино.*
*60.7. Орлогын хандлагын дагуу бизнесийн нэгжийн ирээдүйн орлого буюу мөнгөн гүйлгээг тооцоолох жишиг аж ахуйн нэгжийн түүхэн санхүүгийн тайланг ашигладаг. Харьцааны шинжилгээ хийснээр цаг хугацааны явц дахь түүхэн хандлагуудыг тодорхойлох нь тухайн салбар ба ирээдүйн гүйцэтгэлийн хэтийн төлөвийн хүрээнд уг бизнесийн үйл ажиллагаанд угийн агуулагдах эрсдлүүдийг үнэлэхэд шаардлагатай мэдээллээр хангахад туслалцаа үзүүлж болох юм.*

СЗХ 2022.05.25 өдөр БҮРТГЭВ

MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-03-22 БҮРТГЭВ-03



*60.8. Түүхэн бодит мөнгөн гүйлгээ ба бизнесийн хувь оролцоог худалдан авагчийн үнэлгээний өдрөөр гаргах мөнгөн гүйлгээний хоорондох зөрүүг тусгахад тохируулгууд тохиромжтой байж болох юм. Үүний жишээнд дараах зүйлс хамаарна:*

*(а) хүлээгдэж буй тасралтгүй үйл ажиллагааны ул үндэслэлтэй төсөөлөл болох түвшингүүд хүртэл орлого ба зардлуудыг тохируулах,*

*(б) үнэлж буй бизнесийн ба жиших бизнесийн талаарх санхүүгийн мэдээг ижил суурьтай сууриар төлөвлөх,*

*(в) харилцан хамааралтай талуудын ажил гүйлгээг (худалдан авагчид буюу бэлтгэн нийлүүлэгчидтэй байгуулсан гэрээ хэлцлүүд гэх мэт) зах зээлийн хувь хэмжээгээр тохируулах,*

*(г) зах зээлийн үнэ буюу хувь хэмжээг тусгахын тулд холбоотой талуудын хөдөлмөрийн зардал эсвэл тэндээс түрээслэсэн буюу бусад байдлаар гэрээлэн гүйцэтгэсэн зүйлсийг тохируулах,*

*(д) дахин үл давтагдах үйл явдлуудын нөлөөг түүхэн орлого ба зардлын зүйлсээс салган тусгах. Дахин үл давтагдах үйл явдлуудын жишээнд ажил хаялтаас учирсан хохирол, шинэ үйлдвэрийн нээлт, байгалийн үзэгдэл зэрэг хамаардаг. Гэхдээ ул үндэслэлтэйгээр урьдчилан төсөөлж болох бөгөөд урьд өмнөх тохиолдол нь ижил төсөөтэй ирээдүйн үйл явдлын илэрхийлэл байж болох аливаа дахин үл давтагдах орлого буюу зардлуудыг прогнозчилсон мөнгөн гүйлгээнд тусгавал зохино,*

*(е) үнэлж буй бизнесээс өөр сууриар данс бүртгэлээ хөтөлдөг байж болох ижил төсөөтэй бизнестэй жиших эсвэл эдийн засгийн бодит үйл явдлыг үнэн зөв тусгахын тулд бараа материалын нягтлан бодох бүртгэлийг өөрчлөн тохируулах.*

***70. Өртгийн хандлага***

*70.1. Бизнес ба бизнесийн хувь оролцоо нь ҮОУС 105 Үнэлгээний хандлагууд ба аргуудын, догол мөр 70.2 буюу 70.3-ын шалгуурыг маш цөөн тохиолдолд хангадаг тул эдгээр хөрөнгийн үнэлгээнд өртгийн хандлагыг ихэвчлэн хэрэглэдэггүй. Гэвч өртгийн хандлагыг зарим үед, ялангуяа дараах тохиолдолд бизнесийн үнэлгээнд хэрэглэдэг:*

*(а) бизнес нь эхлэлийн буюу эхэн үеийн шатандаа байгаа, иймээс ашиг ба/буюу мөнгөн гүйлгээг найдвартайгаар тодорхойлж чадахгүй бөгөөд зах зээлийн хандлагын дагуу бусад бизнестэй жишилт хийх практик боломжгүй эсвэл найдвартай бус байх,*

*(б) бизнес нь хөрөнгө оруулалтын буюу холдинг компани байх, энэ тохиолдолд ҮОУС 105 Үнэлгээний хандлагууд ба аргууд-ын, догол мөр 70.7-70.9-д заасанчлан, нийлбэрийн аргыг хэрэглэх, ба/буюу*

*(в) бизнес нь тасралтгүй байдлаар үйл ажиллагаа явуулахааргүй болсон ба/буюу түүний хөрөнгийн устгалтын үнэ цэнэ нь тасралтгүй байдлаар үйл ажиллагаа явуулах бизнесийн үнэ цэнээс давж, илүү гарсан байж болно.*

*70.2. Бизнесийн буюу бизнесийн хувь оролцоог өртгийн хандлага ашиглан үнэлэх тохиолдолд үнэлгээчид нь ҮОУС 105 Үнэлгээний хандлагууд ба аргууд-ын, хэсэг 70 ба 80-ын шаардлагуудыг баримталвал зохино.*

**2.3. Монгол улсын "Хөрөнгийн үнэлгээний тухай" хуулийн зарим заалтууд**

**8 дугаар зүйл. Хөрөнгийн үнэлгээ хийх арга, аргачлал**

8.1. Хөрөнгийн үнэлгээг тухайн үнэлгээний зүйлийн шинж байдал, онцлог, зориулалтыг харгалзан хөрөнгийн үнэлгээний өртгийн, жишиг үнийн, орлогын аргуудыг хослуулан, олон улсын болон хөрөнгийн үнэлгээний үндэсний стандарт, энэ хуулийн 8.2-т заасан хөрөнгийн үнэлгээний аргачлалд нийцүүлэн тодорхойлно.

8.2. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дангаараа, эсхүл төрийн холбогдох эрх бүхий байгууллагатай хамтран тухайн хөрөнгийн үнэлгээний зүйлийн шинж байдал, зориулалтад нийцсэн хөрөнгийн үнэлгээний аргачлалыг баталж, мөрдүүлнэ.

**13 дугаар зүйл. Үнэлгээчний эрх**

13.1. Үнэлгээчин дараах эрх эдэлнэ:

13.1.1.хөрөнгийн үнэлгээний олон улсын болон үндэсний стандартад нийцүүлэн энэ хуульд заасан журмын дагуу хөрөнгийн үнэлгээ хийх аргыг бие даан сонгох;

13.1.4.хөрөнгийн үнэлгээ хийхэд бусад үнэлгээчин болон мэргэжилтнийг гэрээний үндсэн дээр татан оролцуулах;

13.2.Үнэлгээчин үйл ажиллагаагаа аж ахуйн нэгжийн хэлбэрээр явуулж болно.



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК ERDENES SOLUTIONS Joint Stock Company



УЛААНБААТАР ХОТ ГҮҮДСЕК ҮЦК ХХК ТТ50674 5208173

СЗХ
2022 05 сар 25 өдөр
БҮРТГЭВ

2022 -03- 22
БҮРТГЭВ-03



**2.4. Үнэлгээний тайланд тавигдах шаардлагууд.** Үнэлгээний үндэслэл, зорилго болон үнэ цэнийн саналд хүргэдэг судалгаа, шинжилгээний үр дүн, ажлын зааварчилгаа, удирдамжуудыг тусгасан баримт бичиг. Тайлангийн агуулга, төрөл, хэлбэр хэмжээ нь хэрэглэгч, эрх зүйн шаардлага, ажлын шинж чанар, нарийн төвөгтэй байдал зэргээс хамаарна.

*Хөрөнгийн үнэлгээний тайлан нь* дараахь шаардлагад нийцсэн байна. (Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 9.2) Үүнд:

1. Хөрөнгийн үнэлгээний суурийг тодорхойлохдоо тухайн хөрөнгийн үнэлгээний зүйлийн шинж байдал, онцлогт үндэслэсэн байх;

2. Хөрөнгийн үнэлгээ хийх явц дахь хөрөнгийн үнэлгээний стандарт, дүрэм, журам, норм, нормативыг зөрчсөн аливаа тохиолдлын талаар тэмдэглэсэн байх;

3. Хөрөнгийн үнэлгээний зүйлийн тогтоосон үнэ цэнэ зохих үндэслэл бүхий, тодорхой байх.

**ҮОУС 103 Тайлагнал**-д тусгагдсан зарим шаардлагатай заалтуудыг доор оруулав.

10.3. Тайлан нь дэлгэрэнгүй хүүрнэсэнээс эхлээд хураангуйлсан товч тайлан хүртэлх хэлбэрүүдтэй байж болох ба стандарт нь үнэлгээний бүх тайлангуудад болон үнэлгээний нягтлах шалгалтын үр дүнгийн талаарх тайлангуудад нэгэн адил мөрдөгдөнө.

20.1. Үнэлгээний зорилго, үнэлэгдэж буй хөрөнгийн нарийн төвөгтэй байдал, хэрэглэгчдийн шаардлага нь үнэлгээний тайлангийн хэр дэлгэрэнгүй байдлын түвшинг тодорхойлдог. Ажлын цар хүрээг (ҮОУС 101 Ажлын цар хүрээ-г үз) тогтоох ажиллагааны нэг хэсэг болгон үнэлгээний тайлангийн хэлбэр, загварыг талууд тохиролцсон байвал зохино.

30.1. Тайлан нь хөрөнгийн үнэлгээг хамарсан гэрээт ажлын үр дүн байх тохиолдолд түүнд наад зах нь дараах зүйлсийг тусгах ёстой:

(а) гүйцэтгэсэн ажлын цар хүрээ, үүн дотроо ҮОУС 101 Ажлын цар хүрээ-ний догол мөр 20.3-д тэмдэглэсэн элементүүд ба тухайн гэрээт ажилд тэдгээрийн тус бүрийн хамааралтай байх хэр хэмжээ,

(б) баримталсан хандлага (хандлагууд),

(в) хэрэглэсэн арга (аргууд),

(г) ашигласан гол орцууд,

(д) хийсэн төсөөллүүд,

(е) үнэ цэнийн гаргасан дүгнэлт (дүгнэлтүүд) болон аливаа дүгнэлтүүдийн үндсэн учир шалтгаанууд,

(ж) тайлангийн өдөр (энэ нь үнэлгээний өдрөөс өөр байж болно).

30.2. Дээрх шаардлагуудын заримыг тайланд илүү тодорхой тусгах ба өөр бусад баримт бичгийг (гэрээт ажлын захидал, ажлын цар хүрээний баримт бичгүүд, дотоод бодлого ба горимууд гэх мэт) лавлагаагаар дамжуулан тайланд оруулж болох юм.



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company
2015

УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦ ХХК
ТТ58674 5208173

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -03- 22
БҮРТГЭВ-03



## ГУРАВ. ҮНЭЛГЭЭНИЙ ҮНЭ ЦЭНИЙН СУУРЬ, ҮНЭЛГЭЭ ТООЦСОН ВАЛЮТ, ҮНЭЛГЭЭНИЙ ТӨСӨӨЛӨЛ, АРГАЗҮЙ, ҮОУС-ЫН ШААРДЛАГУУД

**3.1. Үнэлгээнд хэрэглэсэн үнэ цэнийн суурь:** Энэхүү үнэлгээнд ажлын зориулалт болон захиалагчтай тохирсоны дагуу "ҮОУС 104 Үнэ, цэнийн сууриуд" стандартад тодорхойлсон **Үнэ цэнийн суурь – Зах зээлийн үнэ цэнэ**-ыг хэрэглэв.

ҮОУС 104-ийн догол мөр 30-д "Зах зээлийн үнэ цэнийн суурь"-ийн талаар доорх байдлаар тодорхойлсон.

**30. ҮОУС-тодорхойлсон үнэ цэнийн суурь - Зах зээлийн үнэ цэнэ**

30.1. Зах зээлийн үнэ цэнэ гэдэг нь зохих маркетинг, сурталчилгаа хийгдсэний дараа, талууд тус бүр зохих мэдлэгтэй, бодол төлөвлөгөөтэй бөгөөд албан шахалт шаардлагагүйгээр оролцох тохиолдолд арилжаанд оролцоход бэлэн байгаа худалдан авагч ба борлуулагчийн хоорондох харилцан хамааралгүй талуудын ажил гэрээгээр хөрөнгө, өр төлбөрийг арилжвал зохино гэж уг үнэлгээний өдрөөр тооцоолсон дүн юм.

30.2. Зах зээлийн үнэ цэнийн энэ тодорхойлолтыг дараах онолын үзэл баримтлалын дагуу хэрэглэнэ.

*(а) "Тооцоолсон дүн" нь харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээгээр хөрөнгийн төлөө төлөх мөнгөөр илэрхийлэгдэх үнэ юм.*

*Зах зээлийн үнэ цэнийн тодорхойлолтын дагуу зах зээлийн үнэ цэнэ нь тухайн зах зээлээс ул үндэслэлтэйгээр олж авч болох, үнэлгээчний өдрөөрх хамгийн их магадлалтай үнэ байдаг. Энэ нь борлуулагчийн ул үндэслэлтэйгээр олж авч чадах хамгийн сайн үнэ ба худалдан авагчийн ул үндэслэлтэйгээр олж авч чадах хамгийн давуу талтай үнэ байна. Харин ерөнхий санхүүжилт, борлуулалт ба буцаан түрээслэх тохиролцоо, борлуулалттай холбоотойгоор хэн нэгнээс олгосон тусгай хөтөлбөр, хөнгөлөлт гэх мэт тусгай нөхцөл буюу заалтаар, эсвэл зөвхөн тодорхой нэг өмчлөгч буюу худалдан авагчид үнэ цэнийн ямар нэг элементээр нэмэгдүүлэх буюу бууруулах байдлаар тооцоолсон үнийг энэхүү тооцоололд тусгайлан хамруулдаггүй.*

*(б) "Хөрөнгө, болон өр төлбөрийг арилжвал зохино" гэдэг нь хөрөнгө ба өр төлбөрийн үнэ цэнэ бол урьдчилан тодорхойлсон дүн эсвэл бодит борлуулалтын үнэ биш, харин тооцоолсон дүн байх нөхцлийг илэрхийлнэ. Энэ нь Зах зээлийн үнэ цэнийн тодорхойлолтын бүх элементүүдийг үнэлгээний өдрөөр хангах уг ажил гүйлгээний үнэ байдаг.*

*(в) "Үнэлгээний өдрөөр" гэдэг нь тухайн үнэ цэнэ уг өдрийн байдлаар гэх мэт тусгай хугацаатай байхыг шаарддаг. Зах зээл ба зах зээлийн нөхцөл байдал нь өөрчлөгдөж болох учраас уг тооцоолсон үнэ цэнэ нь өөр нэг хугацаанд буруу эсвэл тохиромжгүй байж болох юм. Үнэлгээний дүн нь өөр бусад өдрийн биш, харин үнэлгээний тэр өдрийн байдлаарх зах зээлийн төлөв байдал ба нөхцлүүдийг тусган илэрхийлдэг.*

*(г) "Бэлэн байгаа худалдан авагч" гэдэг нь худалдан авах сэдэл санаачлагатай боловч тийм албан үүрэг хүлээлгээгүй талыг илэрхийлнэ. Уг худалдан авагч нь ямар ч хамаагүй үнээр худалдан авахаар хэт хүссэн эсвэл худалдан авна гэж урьдчилан тодорхойлогдсон этгээдийн аль нь ч биш юм. Мөн худалдан авагч нь оршин байгаа гэдгийг батлан харуулж эсвэл урьдчилан баримжаалж чадахгүй тийм төсөөллийн буюу таамаглалын зах зээлтэй холбоотойгоор биш, харин одоогийн зах зээлийн бодит байдал одоогийн зах зээлийн хүлээлтийн дагуу худалдан авах этгээд байдаг. Уг төсөөлсөн худалдан авагч нь зах зээлээр шаардагдахаас илүү өндөр үнийг төлөхгүй. Одоогийн эзэн нь "тухайн зах зээл"-ийг бүрдүүлэгчийн нэг болдог.*

*(д) "Бэлэн байгаа борлуулагч" нь ямар ч хамаагүй үнээр борлуулахаар хэт хүссэн буюу албадлагын дагуу борлуулагч эсвэл одоогийн зах зээлийг ул үндэслэлтэйгээр харгалзан үзэхгүйгээр үнэ тогтоож буй этгээдийн аль нь ч биш юм. Бэлэн байгаа борлуулагч нь зохих маркетинг, сурталчилгаа хийгдсэний дараа нээлттэй зах зээлээс олж авах хамгийн сайн үнэ бүхий зах зээлийн нөхцлөөр хөрөнгийг борлуулах сэдэл санаачлагатай байдаг, гэхдээ уг сайн үнэ нь хэд ч байж болох юм. Бэлэн байгаа борлуулагч бол таамагласан эзэн бөгөөд жинхэнэ бодит эзний үнэн бодит нөхцөл байдал нь энэхүү хэлэлцүүлгийн хэсэг болохгүй.*

*(е) "Хамааралгүй талуудын ажил гүйлгээ" нь жишээлбэл, толгой ба охин компаниуд эсвэл газрын эзэн ба хөлслөгч гэх мэт үнийг зах зээлийн шинж, агуулгагүй болгох буюу нэмэгдүүлж болох тийм тусгайлсан буюу тусгай харилцаа хамааралтай биш байх талуудын хоорондох ажил гүйлгээ юм. Зах зээлийн үнэ цэнээр тооцогдох ажил гүйлгээ нь тус бүрдээ хараат бусаар үйл ажиллагаа явуулж буй*



УЛААНБААТАР ХОТ
ГҮЙДСЕК ҮЦК ХХК
ТТБ0674 д. 5208173

2022 05 25 өдөр БҮРТГЭВ
MONGOLIAN STOCK EXCH
2022 -03- 2 2
БҮРТГЭВ-03



*холбоогүй талуудын хооронд хийгдэнэ гэж урьдчилан таамагладаг.*

*(ж) "Зохих маркетинг, сурталчилгаа хийгдсэний дараа" гэдэг нь Зах зээлийн үнэ цэнийн тодорхойлолтын дагуу ул үндэслэлтэйгээр олж авч чадах хамгийн сайн үнээр борлуулахад нөлөө үзүүлэхийн тулд тухайн хөрөнгийг хамгийн тохиромжтой арга замаар зах зээлд гарган танилцуулахыг хэлнэ. Борлуулагчийн хандан нэвтрэх зах зээлээс хамгийн сайн үнийг олж авахад борлуулалтын арга нь хамгийн тохиромжтой гэж үздэг. Зах зээлд гарган таниулах хугацаа нь тодорхой тогтсон байдаггүй бөгөөд хөрөнгийн төрөл, зах зээлийн нөхцөл байдлаас хамааран өөр өөр байдаг. Цорын ганц шалгуур нь зах зээлд оролцогчдын зохих тоон хэсгийн анхаарлад уг хөрөнгийг хандуулах боломж олгох хангалттай хугацаатай байх ёстой. Зах зээлд гарган таниулах хугацаа нь үнэлгээний өдрөөс өмнө байна.*

*(и) "Талууд тус бүрийн зохих мэдлэгтэй, бодол төлөвлөгөөтэй" гэдэг нь тухайн хөрөнгийн төрөл ба шинж чанар, түүний бодит болон боломжит ашиглалт, зах зээлийн төлөв байдлын талаар уг бэлэн байгаа худалдан авагч болон бэлэн байгаа борлуулагчийн аль алинд үнэлгээний өдрийн байдлаар ул үндэслэлтэйгээр мэдээлэн байсан гэсэн урьдчилсан нөхцлийг илэрхийлнэ. Талууд тус бүр нь уг ажил гүйлгээ дэх өөрийн хэтийн байр суурины хувьд хамгийн таатамжтай байх үнийг олохыг тулд тухайн мэдлэгийг бодол төлөвлөгөөтэйгээр ашиглана гэж урьдчилан төсөөлдөг. Хожмын нэгэн өдрийн урьдчилан харах боломжгүй үр ашгийг биш, харин тухайн үнэлгээний өдрөөрх зах зээлийн байдлыг лавлагаа болгосноор "бодол төлөвлөгөө"-г үнэлдэг. Жишээлбэл: борлуулагч нь зах зээлийн үнэ буурсан үед хөрөнгийг зах зээлийн өмнөх үүнээс бага үнээр борлуулах нь заавал бодол төлөвлөгөөгүй байна гэсэн үг биш юм. Ийм тохиолдолд энэ нь үнэ өөрчлөгдсөн зах зээл дэх өөр арилжааны хувьд зөв байх бөгөөд бодол төлөвлөгөөтэй худалдан авагч буюу борлуулагч нь тухайн үед бэлэн боломжтой байгаа зах зээлийн хамгийн сайн мэдээллийн дагуу үйл ажиллагаагаа явуулдаг.*

*(к) "Албан шахалт шаардлагагүй" гэдэг нь тал тус бүр уг ажил гүйлгээг хийх сэдэл санаачлагатай боловч түүнийг гүйцэтгэхээр аль ч талыг хүчлээгүй буюу хэт албадан шахаагүй байхыг илэрхийлнэ.*

30.3. Зах зээлийн үнэ цэнийн үзэл баримтлал нь зах зээлд оролцогчид чөлөөтэй ажиллах нээлттэй, өрсөлдөөнт зах зээлд хэлцэн тохирох үнийг урьдчилан төсөөлдөг. Хөрөнгийн зах зээл нь олон улсын зах зээл эсвэл орон нутгийн зах зээл байж болно. Зах зээл нь маш олон тооны худалдан авагчид ба борлуулагчдаас бүрддэг эсвэл зах зээлийн хязгаарлагдмал тооны оролцогчдоос тогтсон байж болно. Хөрөнгийг борлуулахаар гарган танилцуулна гэж төлөвлөсөн зах зээл нь борлуулна гэж хийсвэрээр төсөөлсөн хөрөнгийг хэвийн байдлаар арилжих зах зээл байна.

30.4. Хөрөнгийн зах зээлийн үнэ цэнэ нь түүний хамгийн өндөр ба хамгийн сайн ашиглалтыг тусгадаг (догол мөр 140.1-140.5). Хамгийн өндөр ба хамгийн сайн ашиглалт нь түүний боломжийг хамгийн их болгох хөрөнгийн тийм ашиглалт бөгөөд хуулийн хувьд хүлээн зөвшөөрөгдөх ба санхүүгийн хувьд хэрэгжих боломжтой байдаг. Хамгийн өндөр ба хамгийн сайн ашиглалт нь хөрөнгийн одоогийн ашиглалтын үргэлжлүүлэлт эсвэл өөр хувилбар ашиглалт байж болох юм. Энэ нь санал болгох үнийг томъёолох үедээ зах зээлд оролцогч нь тухайн хөрөнгийн хувьд дотроо төлөвлөн бодсон ашиглалтаар тодорхойлогдоно.

30.6. Үнэлж буй хөрөнгийн зах зээлд хамааралтай, бэлэн олдоцтой байгаа мэдээлэл болон нөхцөл байдлууд нь үнэлгээний аль арга эсвэл аргууд хамгийн хамааралтай, тохиромжтой гэдгийг тодорхойлох ёстой. Хэрэв зохих ёсоор шинжилж, шалгасан зах зээлийн үүсэлтэй мэдээнд тулгуурласан бол тухайн хэрэглэх хандлага болон арга нэг бүр нь Зах зээлийн үнэ цэнийг илэрхийлдэг байвал зохино.

30.7. Зах зээлийн үнэ цэнэ нь уг зах зээл дэх бусад худалдан авагчдад хамаарах боломжгүй, тухайн нэг өмчлөгч буюу худалдан авагчид тусгайлсан үнэ цэнэтэй байх хөрөнгийн тийм шинжүүдийг тусган харуулдаггүй. Ийм тусгай давуу шинжүүд нь хөрөнгийн биет, газарзүйн, эдийн засгийн эсвэл хуулийн шинж чанаруудтай холбоотой байж болох юм. Зах зээлийн үнэ цэнэ нь тухайлсан нэг бэлэн байгаа худалдан авагчийг биш, харин тодорхой нэг өдрөөр бэлэн байгаа худалдан авагчийг зөвхөн төсөөлж байгаа учраас үнэ цэнийн аливаа ийм элементүүдийг харгалзахгүй байхыг шаарддаг.



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company
9020080899
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК
ТТБ0674 ₮ 5208173

**3.2. Үнэлгээнд хэрэглэсэн валют.** Тухайн бизенсийн үнэлгээг төгрөгөөр тооцоолсон бөгөөд үр дүнг төгрөгөөр илэрхийлсэн болно.

***3.3. Үнэлгээнд ашигласан төсөөллүүд***

ҮОУС /2020/-ын Ерөнхий стандарт "104 – Үнэ цэнийн сууриуд"-ын догол мөр 200 – "Төсөөллүүд ба тусгай төсөөллүүд"-ийн талаар дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

Догол мөр 200.1. Үнэ цэнийн суурийг тогтоохоос гадна төсөөлсөн арилжаан дахь уг хөрөнгийн төлөв байдал эсвэл хөрөнгийг арилжихаар төсөөлсөн нөхцөл байдлын аль алиныг тодруулахын тулд төсөөлөл буюу олон төсөөллүүдийг байнга хийх шаардлагатай байдаг. Ийм төсөөллүүд нь үнэ цэнэд мэдэгдэхүйц нөлөө үзүүлж болно. *Төсөөллүүд* нь ямар нэг баталгаа, нотолгоогүйгээр үнэлгээний ажлын нөхцөл байдалд үнэн гэж зөвшөөрөгдөх үндэслэл бүхий зүйлс болно.

Тайлангийн энэхүү дэд бүлэг болон бусад бүлэг, дэд бүлгүүдэд үнэлгээчний зүгээс хийсэн төсөөлөл болон тусгай төсөөллүүд нь бүгд нэг адил хүчин төгөлдөр байна.

Дээрх ҮОУС-ын шаардлагын хүрээнд дараах төсөөллүүдийг дэвшүүлсэн болно.

Үүнд:

- "Эрдэнэс сольюшинс" ХК-ийн бизнес нь цаашид тасралтгүй үргэлжилнэ,
- "Эрдэнэс сольюшинс" ХК-ийн бизнесийн үйл ажиллагааны чиглэлд ирээдүйд, мэдэгдэхүйц өөрчлөлт орохгүй,
- Бизнесийн орчин /эдийн засгийн байдал, татвар, тарифын зохицуулалт/-д огцом, мэдэгдэхүйц өөрчлөлт орохгүй,
- Аливаа "давагдашгүй хүчин зүйл"-ийн нөлөөлөл байхгүй.

***<u>Тусгай төсөөлөл.</u>*** Энэхүү үнэлгээнд доорх тусгай төсөөллүүдийг хийсэн болно.

Үүнд:

- 2022 оны 01-р сарын 20-ний өдрийн ЭС/МОТ 02-2022 тоот гэрээний хавсралтын дагуу Захиалагчаас Гүйцэтгэгчид гаргаж өгсөн компаний болон салбарын, төслийн холбоотой мэдээлэл, материалууд нь үнэн зөв бөгөөд гүйцэтгэгчийн зүгээс хууль, эрхзүйн чиглэлээр аудит хийгээгүй болно,
- Захиалагчийн гаргаж өгсөн "Эрдэнэс сольюшинс" ХК-ний бизнес төлөвлөгөө нь үндэслэл, судалгаатай боловсруулагдсан, биелэх боломжтой,
- Компанийн мөнгөн гүйлгээний төсөөлөл нь "Эрдэнэс сольюшинс" ХК-ний дунд хугацааны бизнес төлөвлөгөөнд суурилсан бөгөөд түүний агуулга, тооцоолол нь ул үндэстэй,
- Компанийн санхүүгийн тайланд тусгагдсан бизнесийн хэвийн үйл ажиллагаанаас бусад тодруулаагүй хөрөнгө, өр төлбөр, хэвийн бус үүрэг, хариуцлага, шийдвэрлэгдээгүй шүүхийн маргаан зэрэг үнэлгээний үр дүнд мэдэгдэхүйц нөлөө үзүүлж болзошгүй аливаа зүйл байхгүй,
- "Эрдэнэс сольюшинс" ХК-ний бизнес нь прогнозын дараах жилүүдэд тогтворжиж, жигд өсөлттэй байх бөгөөд өсөлтийн дундаж хувь нь 3.0 – 5.0%-ийн хооронд байна.
- "Эрдэнэс сольюшинс" ХК-ний бизнес нь тусдаа 100.0% бие даасан байдлаар борлогдох боломжтой.

**3.4. Үнэлгээнд ашигласан нийтлэг арга зүй**

**3.4.1. Үнэлгээний аргын сонголтын талаарх тайлбар**

Үнэлгээний Олон Улсын Стандарт /IVS/-2020-105-ын 10.4 дэх догол мөрд "Хөрөнгийн үнэлгээний хувьд, ялангуяа үнэлгээчин нь тухайн үнэлгээний гэрээт ажлын

бодит байдал ба нөхцөл байдлуудыг харгалзан үзсэнээр нэг аргыг үнэн зөв бөгөөд найдвартай гэдэгт өндөр түвшний итгэлтэй байгаа тохиолдолд нэгээс олон арга ашиглахыг үнэлгээчнээс шаарддаггүй. Гэвч ялангуяа нэг аргын хувьд бодит баримтын буюу ажиглалтын хангалттай орцууд байхгүй тохиолдолд үнэлгээчин нь найдвартай дүгнэлт гаргахын тулд олон хандлагууд ба аргуудын хэрэглээг, мөн түүнчлэн үнэ цэнийн үзүүлэлтийг гаргахдаа харгалзан үзвэл зохистой ба ашиглаж болох нэгээс олон хандлага буюу аргыг авч үзвэл зохино. Нэгээс олон хандлага ба аргыг эсвэл нэг хандлагын хүрээн дэх олон аргуудыг ашигласан тохиолдолд тэдгээр олон хандлагууд ба/буюу аргуудад үндэслэсэн үнэ цэнийн дүгнэлт нь ул үндэслэлтэй байвал зохистой бөгөөд үнэлгээчин нь тэдгээр өөр өөр үнэ цэнүүдийг дундажлахгүйгээр, харин шинжилж, тохируулах замаар нэг дүгнэлтэнд хүргэсэн үйл явцаа үнэлгээний тайланд тусган илэрхийлвэл зохино." гэж заасан байдаг

"Хөрөнгийн үнэлгээний тухай" хуулийн 13.1.1-р заалт болон Үнэлгээний Олон Улсын Стандарт /IVS/-2020-105-ын дагуу үнэлгээний аргачлалыг доор зааснаар сонгосон болно. Үүнд:

Энэхүү үнэлгээг хийхдээ тухайн компанийн одоогийн нөхцөл байдлыг судалж үзээд орлогын, зах зээлийн, өртгийн хандлагуудаар үнэлгээний тооцооллыг хийхээр сонгосон бөгөөд Үнэлгээний Олон Улсын Стандарт /IVS/-2020-105-ын 10.4 дэх догол мөрд дэх заалтын дагуу зах зээлийн, өртгийн хандлагуудын үнэлгээний үр дүнг орлогын хандлагаар хийсэн үнэлгээний дүнг шалгах, магадлах чиглэлээр ашиглана.

Үнэлгээний хандлага, ашигласан аргуудын талаарх дэлгэрэнгүй тайлбар, мэдээллийг тайлангийн 5-р бүлэгт, үнэлгээний хандлага тус бүрээр оруулсан болно.

### *3.5. Үнэлгээний зүйлийн хамгийн сайн ашиглалт*

***Хамгийн сайн ашиглалт*** гэдэг нь тэр хөрөнгийн хүчин чадал ашиглалтыг дээд хэмжээнд байлгах биет байдлаараа боломжтой, хууль ёсоор зөвшөөрөгдсөн, санхүүгийн хувьд биелэгдэх ашиглалтыг хэлнэ.

Тухайн үнэлж байгаа бизнесийн хувьд одоогийн оршин буй ашиглалтыг хамгийн сайн ашиглалт гэж үзнэ.

### 3.6. Үнэлгээний Олон Улсын Стандартын гажилт

Энэхүү үнэлгээг хийхэд Үнэлгээний Олон Улсын Стандарт болон Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, тогтоомж, дүрэм журмаас гажих онцгой нөхцөл байгаагүй.

### 3.7. Үнэлгээнд ашигласан мэдээллийн эх үүсвэр

Энэхүү үнэлгээний ажилд ашигласан баримт, материалууд, мэдээллийг олон эх үүсвэрүүдээс янз бүрийн аргаар олж бүрдүүлсэн болно. Эдгээр мэдээллийн эх үүсвэрүүдийн дараахи хэд хэдэн бүлэгт хувааж болно. Үүнд:

1. Захиалагчаас гаргаж өгсөн мэдээллүүд
2. Бусад эх үүсвэрээс авсан зах зээлийн мэдээллүүд

**Захиалагчаас гаргаж өгсөн мэдээллүүд:**

- Компанийн товч танилцуулга,
- Компанийн бүртгэлийн гэрчилгээ (хуулбар),
- Компанийн удирдлагуудын талаарх мэдээлэл,
- Компанийн сүүлийн 2 жилийн санхүүгийн байдлын тайлан /аудитлагдсан/,

MONGOLIAN STOCK EXCH...
2022 -03- 22
БҮРТГЭВ-03

он сар өдөр
2022.03.25



- Компанийн /2022-2025 оны/ бизнес төлөвлөгөө, орлогын болон санхүүгийн тайлан-тэнцлийн төсөөлөл,
- Салбарын мэдээллүүд,

*Хөрөнгийн талаарх мэдээллүүд*

- Үндсэн хөрөнгийн жагсаал,
- Үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ /хуулбар/,
- Биет бус хөрөнгийн "Зохиогчийн эрхийн гэрчилгээ", 2 ш /хуулбар/.

**Бусад эх үүсвэрийн мэдээлэл**

- "Хөрөнгийн үнэлгээний тухай" Монгол улсын хууль
- Олон улсын үнэлгээний стандарт. 2020 он
- Доцент .О.В.Тихоновын "Бизнесийн үнэлгээний тухай" лекц
- Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан 2011 оны 274/240 тоот тушаалаар батлагдсан "Бизнесийн үнэлгээ хийх аргачлал"

**Интернэт дэх мэдээллийн эх үүсвэрүүд**

- www.1212.mn
- www.mse.nm
- www.mongolbank.mn
- www.mof.gov.mn
- www.frc.mn
- (https://www.imf.org/external/datamapper/PCPIPCH@WEO/WEOWORLD/VEN/USA/MNG)
- Damodran's data



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company

УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК
ТТЕ0674 д. 5208173

СЗХ он сар өдөр 2022.03.25 № 01

2022 -03- 22 БҮРТГЭВ-03



## ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭНИЙ ЗҮЙЛИЙН МЭДЭЭЛЭЛ

### *4.1. Үнэлгээний үйл явц*

Энэхүү үнэлгээний ажлыг ҮОУС 101-ын ажлын хамрах хүрээ, захиалагчтай байгуулсан ерөнхий гэрээ, хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 7.1-д нийцүүлэн үнэлгээ хийх ажлын бэлтгэл хангасан. Үүнд:

1. Үнэлгээ хийх төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулж, баталгаажуулсан.
2. Уг хөрөнгийн талаар захиалагчийн шийдвэр, өгсөн мэдээлэлтэй танилцаж шаардлагатай материалыг гаргуулан авсан.
3. Тус компанийн үйл ажиллагаа, үндсэн хөрөнгийн байдалтай 2022 оны 01-р сарын 22, 02-р сарын 08-ны өдрүүдэд танилцаж, компанийн удирдлагуудтай уулзаж, ярилцлага хийсэн.
4. Хөрөнгийн үнэлгээний стандарт, аргачлал, журам, норм норматив болон шаардлагатай бусад материал бэлтгэсэн.
5. Уг хөрөнгийн талаар захиалагчийн өгсөн мэдээлэл, хөрөнгийн ашиглалтын одоогийн байдал, холбогдох баримт бичгүүд, ижил төстэй хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээллийг үндэслэн үнэлгээг хийж гүйцэтгэв.

### 4.2. Макро эдийн засгийн өнөөгийн байдал, цаашдын төлөв

Монгол улсын макро эдийн засгийн өнөөгийн байдал, цаашдын төлөвийн талаарх мэдээллийг Монголбанкнаас гаргасан 2021 оны 12-р сарын "Инфляфийн тайлан", Монгол улсын Санхүүгийн тогтвортой байдлын тайлан, 2021 оны 9-р сар, № 15, ОУВС-гийн сайт (https://www.imf.org/external/datamapper/PCPIPCH@WEO/ WEOWORLD/VEN/USA/MNG) зэрэг баримт бичгүүдээс авч оруулсан болно.

***Мөнгөний бодлогын стратеги:*** Төв банкны тухай хуульд Монголбанкны үндсэн зорилт нь төгрөгийн тогтвортой байдлыг хангах гэж тодорхойлсон байдаг. Энэ зорилтын хүрээнд Монголбанк хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцыг дунд хугацаанд зорилтот түвшний орчимд тогтворжуулах бодлогыг "Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл"-д тусган хэрэгжүүлж байна. Инфляцыг нам түвшинд тогтворжуулснаар иргэдийн бодит орлого, хөрөнгийг үнэгүйдлээс хамгаалж, банк санхүүгийн тогтолцооны тогтвортой байдал хангагдах нөхцлийг бүрдүүлэх төдийгүй урт хугацаанд хөрөнгө оруулалт, эдийн засгийн өсөлтийн тогтвортой байдлыг дэмжинэ. Монголбанк хэрэглээний үнийн индексээр илэрхийлсэн инфляцыг 2021-2023 онд жилийн 6 хувь орчимд, +/-2 нэгж хувийн интервалд тогтворжуулахыг зорьж байна.

***Мөнгөний бодлогын шийдвэр:*** Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2021 оны 12-р сарын 16-ны өдрийн ээлжит хурлаар:

1. Бодлогын хүүг 6 хувьд хэвээр хадгалах;
2. 2022 оны 1 дүгээр улирлын Урт хугацаат репо санхүүжилтийн хэмжээг 250 хүртэлхтэрбум төгрөгөөр тогтоох;
3. Репо санхүүжилтийн хүүг бодлогын хүү+0.5 хувиар тогтоох;
4. Гадаад валютын татан төвлөрүүлсэн хөрөнгөнд тооцох заавал байлгах нөөцийн хувийг 3 нэгж хувиар нэмэгдүүлж 18 хувьд хүргэх багц шийдвэрийг гаргалаа.

**ТОЙМ.** Гадаад болон дотоод эдийн засгийн ерөнхий төлөв өмнөх төсөөллөөс бага хэмжээгээр муудсан ч цаашид сэргэх хандлага үргэлжлэх хүлээлттэй байна. Эдийн засгийн идэвхжлийг даган эрэлтийн шинжтэй инфляц алгуур нэмэгдэх болович нийлүүлэлтийн



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК ERDENES SOLUTIONS Joint Stock Company

УЛААНБААТАР ХОТ ГҮЙЦЭТГЭХ ҮЙЛ ХЭРЭГ ТТБ6874 5203173

2022 -03- 25
БҮРТГЭВ
№ 01
2022 -03- 22
БҮРТГЭВ-03



шалтгаантайгаар инфляц эрчимжин өмнөх төсөөллөөс өслөө. Цаашид хилийн хязгаарлалтын нөхцөл байдал, түүнтэй холбогдон эдийн засгийн сэргэлт удаашрах, зардлын болон нийлүүлэлтийн шалтгаантай инфляц удаан хугацаанд үргэлжлэх, одоогийн түвшнээс нэмэгдэх эрсдэлтэй байна.

**Инфляцын хувьд өмнөх төсөөллөөс нэмэгдэн богино хугацаанд Төв банкны зорилтот интервалыг даваад байгаа ч дунд хугацаанд зорилтын орчимд тогтворжих төсөөлөл хэвээр байна.** 2021 оны 11 дүгээр сард инфляц улсын хэмжээнд 10.5 хувь, Улаанбаатар хотод 10.0 хувьд хүрч нэмэгдэхэд нийлүүлэлтийн шинжтэй хүчин зүйлс голлон нөлөөллөө. Тодруулбал, богино хугацаанд хил, гааль дээр үүссэн импортын хадгалалт, тээвэрлэлтийн зардал, малын халдварт өвчин дэгдсэнээс шалтгаалсан махны үнийн өсөлт, шатахууны үнийн өсөлт, түүний дам нөлөө инфляцыг өсгөх нөлөө үзүүлж байна. Мөн эрэлтийн хүчин зүйлсийн инфляцад үзүүлэх нөлөө эдийн засгийн идэвхжлийг даган аажмаар нэмэгдэх хүлээлт хэвээр байна. Дунд хугацаанд ханш сулрах, дэлхийн зах зээл дээрх хүнсний үнэ өсөх нь инфляцын төсөөллийг бага хэмжээгээр нэмэгдүүлэх ч 2022 оны сүүлийн хагасаас Төв банкны зорилтын орчимд тогтворжих төсөөлөлтэй байна. Цаашид нийлүүлэлтийн, зардлын шинжтэй хүчин зүйлсийн нөлөө саарахгүй байх нь инфляц дунд хугацаанд өндрөөр тогтох болгоомжлолыг үүсгэж байна.

**Эдийн засгийн өсөлтийн төлөвийг өмнөх төсөөллөөс бууруулллаа.** Эдийн засгийн өсөлт уул уурхайн бус салбараас шалтгаалж 2021 оны 3-р улиралд төсөөллөөс бага гарав. Засгийн газар, Төв банкнаас хэрэгжүүлж буй эрэлтийг дэмжих бодлогын нөлөөгөөр зарим салбарын үйлдвэрлэл өсч байгаа ч хөдөө аж ахуйн салбар малын халдварт өвчнөөс үүдэн хүлээлтээс бага, төсвийн хөрөнгө оруулалтын зардлын гүйцэтгэл болон хилийн хязгаарлалттай холбоотойгоор гадаад худалдаа, бүтээгдэхүүний татварын бүрдүүлэлт муудаж барилга, тээврийн салбар үйлдвэрлэл удаашран өрхийн хэрэглээ буурахад нөлөөлөв. Энэ хандлага он дуустал үргэлжлэхээр байгаа тул 2021 оны эдийн засгийн төсөөллийг бууруулав. Ирэх онд төсвийн төлөв харьцангуй сулрахаар байгаа нь өсөлтөд эерэг нөлөөтэй боловч гадаад эрэлт, худалдааны нөхцөл, гадаадын шууд хөрөнгө оруулалтын төсөөлөл буурч байгаа нь уул уурхайн бус салбарын идэвхжлийг өмнөх төсөөллөөс сааруулахаар байна. Түүнчлэн, эдийн засгийн өсөлтийн цаашдын төлөв КОВИД-19 вирусын шинэ хувилбарын тархалт, хилийн нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдөхөөс шууд хамааралтай.

Дунд хугацаанд зэсийн баяжмал, түүний агууламж буурахаар байгаа нь уул уурхайн үйлдвэрлэлийг бууруулах нөлөө үзүүлэх ч бусад салбарууд цар тахалтай холбоотой уналтаас гарч урт хугацааны хэвийн түвшиндээ хүрэх, мөн гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэх нөлөөгөөр дотоод эрэлт сэргэж уул уурхайн бус салбар эрчимжин эдийн засгийн өсөлтийг дэмжихээр байна.

**Гадаад эдийн засгийн төлөв муудаж, тодорхой бус байдал нэмэгдэж байна.** Дэлхий дахинд вакцинжуулалт үргэлжилж байгаа ч КОВИД-19 вирусын шинэ хувилбарын тархалт нэмэгдэж, АНУ болон БНХАУ-ын өсөлтийн төлөв буурснаас манай гадаад эрэлт өмнөх төсөөллөөс муудлаа. 2022-2023 онд дийлэнх орнуудын өсөлт тогтворжиж, төсөв, мөнгөний бодлого нормалчлагдан, урт хугацааны хэвийн түвшиндээ орох төлөвтэй байгаа ч КОВИД-19 вирусын шинэ хувилбарууд тархах, шинэ давлагаа үүсэх, инфляц өсч улс орнууд мөнгөний бодлогын төлөвөө хурдтай чангаруулах нь гадаад орчны гол эрсдэл болж байна.

**Дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ өндөр байгаа ч, цаашид буурах хандлагатай байна.** Түүхий эдийн эрэлт өндөр, нийлүүлэлт хязгаарлагдмал байгаагаас зэс, алт, газрын тосны үнийн төлөв өмнөхөөс сайжирсан бол харин БНХАУ-ын гангийн үйлдвэрлэл буурч, төмрийн хүдрийн үнийн төлөв өмнөх улирлын хүлээлтээс муудлаа. Мөн



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК
ТТБ0674 ☎ 5208173

СЗХ
2022 .05. 25өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -03- 22
БҮРТГЭВ-03



БНХАУ-ын байгаль орчны зорилт, 0-КОВИД бодлогын улмаас нүүрсний нийлүүлэлт буурч, нүүрсний үнэ 3-р улиралд огцом өссөн бол эргээд нийлүүлэлт сэргэж, үнэ буурах хандлагатай байна. Улмаар экспортын үнэ импортын үнээс хурдтай өсөж, худалдааны нөхцөл (гадаад худалдааны үнэ) 2021 онд өмнөх төсөөллөөс сайжирч байгаа бол 2022 оноос эргэн муудна.

## 1. ИНФЛЯЦ

*Монголбанк хэрэглээний үнийн индексээр илэрхийлсэн инфляцыг 2021-2023 онд жилийн 6 хувийн орчимд, ±2 нэгж хувийн интервалд тогтворжуулах зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.*

### 1.1. Инфляцын динамик

Энэ оны III улиралд инфляц1 улсын хэмжээнд 8.6 хувь, Улаанбаатар хотод 8.9 хувь болж өмнөх улирлаас өслөө (Зураг I.1). Инфляцад нэг талаас эдийн засгийн сэргэлт тодорхой хэмжээгээр нөлөөлж байгаа бол дийлэнх хэсгийг нийлүүлэлтийн хүчин зүйлс тайлбарлаж байна. Тодруулбал, цар тахлын сөрөг нөлөөг зөөллөх бодлогын арга хэмжээнүүд үргэлжлэн хэрэгжиж, эдийн засгийн үйл ажиллагаа сэргэж буй хэдий ч өрхийн хэрэглээ 4 улирал дараалан буурсан, хэрэглээний зээлийн өсөлт бага байгаа зэргээс эрэлтийн шалтгаантай инфляц алгуур нэмэгдэх хандлагатай байна. Нийлүүлэлт талаас шатахууны үнэ III улиралд өмнөх улирлаас 31 хувиар огцом өссөн, тээвэр, логистикийн зардал нэмэгдэж нийлүүлэл-тийн доголдол үүссэн нь инфляцад өндөр нөлөөтэй байлаа (Зураг I.2). Энэ оны 11 дүгээр сард инфляц улсын хэмжээнд жилийн 10.5 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 10.0 хувьд хүрэхэд махнаас бусад хүнсний бүлэг болон шатахууны үнэ нэмэгдсэн нь голлон нөлөөлөв (Зураг I.1, I.2, I.3).

Зураг I.1

Инфляц




Эх сурвалж: ҮСХ

Зураг I.2

Ерөнхий инфляц болон инфляцад өндөр нөлөөтэй бүтээгдэхүүнүүдийн жилийн өсөлт




Эх сурвалж: ҮСХ, Монголбанк

*Инфляцын хөдөлгөөнд гол нөлөө үзүүлж буй бүтээгдэхүүнүүд:*

- **Махны үнэ улирлын хандлагаараа** 11 дүгээр сард алгуур хямдарч жилийн инфляцын 2.1 нэгж хувийг бүрдүүлж байна (Зураг I.2, Зураг I.3). Тодруулбал, үхрийн махны үнэ өсөх хандлагатай байсан бол бусад төрлийн мах буурчээ. Орон нутагт дэгдсэн малын гоц халдварт өвчин нь голлон үхэрт халддаг учраас үхрийн махны нийлүүлэлтэд тавих хяналт чангарахаас гадна, нийлүүлэлтэд нь сөргөөр нөлөөлсөн байж болохоор



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company

УЛААНБААТАР ХОТ
ГҮЙЛСЕН ХХК
ТТБ0674 5208173

2022-03-22
БҮРТГЭВ-03



байна.

- **Махнаас бусад хүнс:** Хил хаагдсантай холбоотойгоор 10 дугаар сард үнэ нь огцом өссөн импортын нарийн ногоог төмөр замын тээврээр татан авах замаар нийлүүлэлтийг дэмжсэн нь үнэ2 20 орчим хувиар эргэн буурахад нөлөөллөө.

Харин хүнсний ногооны бүлэгт өндөр жин эзэлдэг дотоодын хүнсний ногооны хувьд үнэ нь өссөн байна. Ийнхүү хүнсний ногооны бүлгийн инфляцад үзүүлэх нөлөө 0.9 нэгж хувь болж нэмэгдлээ. (Зураг I.2, I.3).

Зураг I.3

Улаанбаатар хотын жилийн инфляцын бүрэлдэхүүнээр




Эх сурвалж: ҮСХ, Монголбанк

Түүнчлэн нарийн ногооноос бусад импортын хүнсний үнэ мөн өсөж, инфляцад үзүүлэх нөлөө нь 0.7 нэгж хувьд хүрч нэмэгдлээ. Замын-Үүд боомтын ачаа тээвэр саатсан, олон улсын хүнсний үнэ өндөр байгаа, тээврийн зардал өссөн зэрэг нь үнэ өсөх үндсэн шалтгаан болж байна (Зураг I.3).

- **Шатахууны үнэ** 11 дүгээр сарын байдлаар оны эхнээс төрлөөсөө3 хамааран 700-750 орчим төгрөгөөр өсөн инфляцыг 2.0 нэгж хувийг бүрдүүлж байна. Дэлхийн зах зээл дэх газрын тосны үнэ (11 дүгээр сарын дундаж үнэ брент газрын тос $81/баррель) өндөр байгаа нь хилийн үнээр дамжин дотоодын шатахууны үнэ өсөх үндсэн шалтгаан болсоор байна (Зураг I.2, I.3).

- **Хатуу түлш** бүлэгт багтдаг түлшний модны үнэ галлагааны улиралтай уялдан өсөж инфляцын 0.7 нэгж хувийг бүрдүүлж байна. Харин 10 дугаар сараас Засгийн газрын шийдвэрийн хүрээнд сайжруулсан түлшийг 50 хувийн хөнгөлөлттэй үнээр худалдаалж буй нь инфляцыг -1.4 нэгж хувиар бууруулах нөлөөтэй (Зураг I.2, I.3).

**1.2. Төсөөллийн зөрүү**

III улирлын дундаж инфляц 8.9 хувь гарсан нь өмнөх улиралд гаргасан төсөөллөөс 1.0 нэгж хувиар өндөр байв. Засгийн газраас ирэх оны 3 дугаар сар дуустал сайжруулсан түлшийг 50 хувийн хөнгөлөлттэй үнээр худалдаалах шийдвэр гаргасан. Үүнийг төсөөлөлд тусгахдаа галлагааны улиралтай зэрэгцэн 9 дүгээр сард эхэлнэ гэж үзсэн бол борлуулалт 10 дугаар сард буюу төсөөллөөс хожуу эхэлсэн нь төсөөллийн гол зөрүүг (0.6 нэгж хувь) тайлбарлаж байна. Мөн хүнсний бүтээгдэхүүний үнэ төсөөллөөс өндөр буюу жилийн 12.9 хувиар өссөн байна.

**1.3. Инфляцын цаашдын төлөв**

Ирэх улирлуудад хүнсний болон шатахууны үнийн өсөлт өмнөх төсөөллөөс нэмэгдэхээр байгаа нь нийт инфляцын төсөөллийг нэмэгдүүлэхэд голлон нөлөөллөө. Тодруулбал, орон нутагт малын халдварт өвчин дэгдсэн нь махны үнийн өсөлт улирлын хандлагаасаа давж нэмэгдэхэд хүргэж байгаа бол БНХАУ-ын хилийн хязгаарлалтаас шалтгаалан нийлүүлэлт саатсан нь импортын хүнсний ногоо болон бусад хүнсний үнэ өсөхөд нөлөөлж, үүнийг дагаад дотоодын хүнсний үнийн өсөлт мөн өмнөхөөс нэмэгдэх төлөвтэй байна. Түүнчлэн дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнийн өсөлтөөс үүдэн дотоодын шатахууны үнэ өндөр түвшинд хадгалагдахаар байгаа нь инфляцын төсөөллийг өмнөхөөс нэмэгдүүлэхэд нөлөөллөө (Зураг I.4).



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company
УЛААНБААТАР ХОТ
ГҮЙДСЕК ҮЦК ХХК

СЭХ
2022 05 25
БҮРТГЭВ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -03- 22
БҮРТГЭВ-03



Зураг I.4

Инфляцын төсөөлөл




Эх сурвалж: Монголбанк

2022 оны эхний хагаст инфляц зорилтот түвшнээс давахаар байгаа нь голлон өмнөх онд инфляц буурсан суурь үеийн нөлөө болон нийлүүлэлтийн шинжтэй хүчин зүйлсийн нөлөөгөөр тайлбарлагдаж байна. Тухайлбал, хилийн боомтын хязгаарлалтаас үүдэлтэй импортын хүнсний барааны үнийн өсөлт, тээврийн зардлын өсөлт болон малын өвчлөлтэй холбоотой махны үнийн өсөлт зэрэг нь ирэх оны эхний хагас хүртэл үргэлжлэх төлөвтэй бол 2022 оны сүүлийн хагасаас үнийн өсөлт тогтворжиж инфляц алгуур буурах хүлээлттэй байна.

Засгийн газар болон Монголбанкнаас хэрэгжүүлж буй эдийн засгийг сэргээх бодлогын нөлөө уул уурхайн бус салбарыг дэмжиж дотоод эрэлт сэргэх, ханш сулрах нөлөөгөөр эрэлтийн шинжтэй инфляцын дарамт дунд хугацаанд алгуур нэмэгдэх хүлээлттэй байна. Түүнчлэн дэлхийн зах зээл дээрх хүнсний үнэ, гадаад инфляцын төсөөлөл нэмэгдсэн бөгөөд эдийн засгийн сэргэлтийг дагасан инфляцын дарамт нэмэгдэхээр байгаа зэрэг нь инфляцын дунд хугацааны төсөөллийг өмнөхөөс нэмэгдүүлж байгаа ч инфляц Төв банкны зорилтот интервалд тогтворжих хүлээлт хэвээр байна.

## 2. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

Бодит ДНБ6 2021 оны эхний 3 улирлын нийлбэр дүнгээр өмнөх оны мөн үеэс 3.6 хувиар өслөө. I улиралд 14.8 хувьд хүрч огцом өсөж байсан эдийн засаг II, III улирлуудад дараалан саараад байна. Тухайлбал, III улирлын байдлаар эдийн засаг өмнөх оны мөн үеэс 0.9 хувиар агшив. Нэг талаас эдийн засгийг сэргээх, өрхийн орлогыг дэмжих бодлогын арга хэмжээ үргэлжилж, хөл хорионы дэглэм шат дараатай суларч байгаа нь эдийн засгийн идэвхжилийг дэмжих хэдий ч нөгөө талаас хилийн боомтууд дээр үүсээд буй логистикийн асуудлууд нь гадаад худалдааны эргэлтийг хязгаарлаж, сэргэлтэд сөргөөр нөлөөлж байна. Түүнчлэн, цар тахлын өмнөх үе буюу 2019 оны мөн үетэй харьцуулахад бодит ДНБ эхний 3 улиралд 3.4 хувиар бага бага байна.

### 2.1. Нийт эрэлт

Нийт эрэлт7 III улиралд 1.2 хувиар агшлаа. Нийт хөрөнгийн хуримтлал эрэлтийг дэмжих гол бүрэлдэхүүн хэвээр байгаа бол өрхийн хэрэглээ хүлээлтээс удаан сэргэж байна (Зураг II.1).

Зураг II.1

Нийт эрэлт дахин 1.2 хувиар агшив.




Эх сурвалж: ҮСХ

Энэ оны II улирлаас эхлэн хөл хорионы дэглэм шат дараатай суларч, иргэдийн хөдөлгөөнт байдал нэмэгдсэн, мөн Засгийн газар, Монголбанкнаас өрхийн орлогыг дэмжсэн бодлогын арга хэмжээ хэвээр үргэлжилж өрхийн сарын дундаж орлого нэмэгдсэн хэдий ч өрхийн хэрэглээ



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК ERDENES SOLUTIONS Joint Stock Company
УЛААНБААТАР ХОТ ГҮҮДСЕК ҮЦК ХХК

сүүлийн 4 улиралд бууралттай байна. Цар тахлын үед тээвэр, зочид буудал, нийтийн хоолны үйлчилгээний болон зарим нэр төрлийн импортын барааны хэрэглээ түлхүү тангардах хандлагатай байгаа бөгөөд эдгээр бараа, үйлчилгээний хэрэглээ 2021 оны III улирлын байдлаар эргэн сэргээгүй хэвээр байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт (7.5 хувь), бизнесийн зээл (19.5 хувь) болон суурь үеийн нөлөө (2020 онд 40% буурсан)-гөөр нийт хуримтлал оны турш эдийн засгийн өсөлтийн гол хүчин зүйл болж байна (Зураг II.3). Харин оны эхний 3 улирлын байдлаар төсвийн хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 20 орчим хувиар бага гүйцэтгэлтэй байна.

Зураг II.3

Нийт хөрөнгийн хуримтлал дотоод эрэлтийн голлох шалтгаан болсон хэвээр байна.



Бодит экспорт өмнөх оны мөн үетэй харьцуулахад II улиралд 20 хувь, III улиралд 39 хувиар тус тус буурсан нь нийт эрэлт удаашрахад нөлөөлж байна. Тухайлбал, сүүлийн 2 улирлын нийлбэрээр өмнөх оноос нүүрсний экспорт 11.3 сая тн (68%), боловсруулаагүй болон хагас боловсруулсан алтны экспорт 11.3 тн (60%)-оор буурчээ (Зураг II.4).

Зураг II.4

Алт болон нүүрсний экспорт огцом буурав.



## 2.2. Нийт нийлүүлэлт

Эдийн засгийн өсөлтийг нийлүүлэлт талаас авч үзвэл 2021 оны эхний 3 улиралд уул уурхайн салбар өмнөх оны мөн үеэс 11.7 хувь, уул уурхайн бус салбар 2.4 хувиар өсөөд байна. Харин цар тахлын өмнөх үе буюу 2019 оны эхний 3 улиралтай харьцуулахад уул уурхай 13.0 хувь, уул уурхайн бус салбар 1.7 хувиар бага байна (Зураг II.5).

Зураг II.5

Нийт нийлүүлэлт цар тахлын өмнөх түвшинд хараахан хүрээгүй байна.



Нийт нийлүүлэлт III улиралд 0.9 хувиар саарахад хөдөө аж ахуй, барилга, уул уурхай, тээврийн салбаруудын уналт нийтдээ 3.5 нэгж хувийн сөрөг нөлөөг үзүүлсэн бол худалдаа, үйлчилгээний салбаруудын өсөлт 2.4 нэгж хувиар тэтгэжээ. Харин бараа, бүтээгдэхүүнд ногдуулж буй татварын орлого тайлант улиралд өмнөх оны орчимд байлаа

Тайлант улиралд зэсийн баяжмалаас бусад бүтээгдэхүүний олборлолт буурч уул уурхайн салбар нийт нийлүүлэлтийг 0.7 нэгж хувиар сааруулах нөлөө үзүүлжээ. Тухайлбал, нүүрс олборлолт өмнөх оны III

2022 -03- 22
БҮРТГЭВ



улиралтай харьцуулахад 60.4 хувь, газрын тос 31.8 хувь, төмрийн хүдэр баяжмал 19.7 хувь, алт олборлолт 12.4 хувиар тус тус буураад байна. Харин Оюу толгойн ил уурхайгаас олборлож буй зэсийн баяжмал 57.7 хувиар, үүнд агуулагдах алтны хэмжээ 2.6 дахин нэмэгджээ.

Уул уурхайн үйлдвэрлэлийн идэвхжил саарсантай уялдан тээврийн салбар агшиж, нийт нийлүүлэлтийг 1.0 нэгж хувиар бууруулах нөлөө үзүүлэв. Үүнд авто замын ачаа эргэлт өмнөх оны мөн үеэс 76.8 хувь, зорчигч эргэлт 53.2 хувь, төмөр замын ачаа эргэлт 5.4 хувь, зорчигч эргэлт 90.5 хувиар тус тус буурсан байна.

Өргөн хэрэглээний бараа, барилгын материал, нефтийн бүтээгдэхүүний импорт эрчимжсэнээр дотоод худалдааны салбар өсөж, нийт нийлүүлэлтийг 0.9 нэгж хувиар тэтгэв. Харин машин механизм, тоног төхөөрөмжийн худалдаа тайлант улиралд төдийлөн өндөр өсөөгүй байна.

Импортын барааны НӨАТ болон гаалийн албан татварын орлогын өсөлт тайлант улиралд хадгалагдсан хэдий ч дотоодын барааны НӨАТ бүрдүүлэлт өмнөх оны мөн үеэс ихээр нэмэгдээгүй тул бүтээгдэхүүний татварын орлого нийт нийлүүлэлтэд өндөр нөлөө үзүүлсэнгүй.

Барилгын салбарын хувьд сүүлийн 6 улирал дараалан уналттай байж, тайлант улиралд нийт нийлүүлэлтийг 1.1 нэгж хувиар буурууллаа. Үүнд орон сууцны барилга угсралтын ажил бодит дүнгээр өмнөх оны мөн үеэс 43.0 хувь, орон сууцны бус барилга 43.9 хувь, инженерийн барилга байгууламж 32.7 хувиар тус тус агшсан байна.

Дотооддоо үйлдвэрлэж буй нэхмэл, химийн бүтээгдэхүүн болон мах, үр тарианы гурилын үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс буурснаар боловсруулах салбар эдийн засгийн өсөлтийг 0.2 нэгж хувиар сааруулах нөлөө үзүүлжээ. Харин дотоодын барилгын материал, төмөр, резинэн бүтээгдэхүүн болон ундааны үйлдвэрлэл тайлант улиралд идэвхэжсэн байна.

Ажиллах хүч ихээр шингээдэг үйлчилгээний салбар тайлант улиралд нийт нийлүүлэлтийг 1.5 нэгж хувиар дэмжлээ. Үүнд санхүү даатгалын зуучлал болон эрүүл мэндийн үйлчилгээ нэмэгдэж голлох эерэг нөлөөг үзүүлсэн бол үл хөдлөх хөрөнгө, төрийн удирдлагын үйл ажиллагаа өмнөх оны мөн үеэс буурчээ. Өмнөх улирлуудад үйл ажиллагаа нь хязгаарлагдмал байсан зочид буудал, зоогийн газар зэрэг үйлчилгээний орлого дорвитой сэргэж эхлээгүй байна.

Хөдөө аж ахуйн салбар энэ он гарсаар уналттай байж, тайлант улиралд нийт нийлүүлэлтийг 0.8 нэгж хувиар бууруулав. Үүнд энэ онд хүн амын хүнсний болон экспортын хэрэгцээнд зориулан бэлтгэх малын тоо толгой өнгөрсөн оны хэмжээнд хүрэхээргүй байгаагийн зэрэгцээ том малын зүй бус хорогдол өмнөх оноос өндөр байгаа нь голлон нөлөөлж байна.

**2.3. Тэнцвэртэй үйлдвэрлэл**

Уул уурхайн салбарт хийгдсэн бүтээн байгуулалтын нөлөөгөөр уул уурхайн бус салбар идэвхжиж, 2017-2019 онд тэнцвэртэй үйлдвэрлэлийн өсөлт нэмэгдсэн бол КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр 2020 оноос дотоод эдийн засгийн идэвхжил хумигдаж, тэнцвэртэй үйлдвэрлэл буураад байгаа бөгөөд сүүлийн улирлуудад бага түвшинд хэлбэлзэж байна.

Эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн мэдээлэл, тэдгээрийн хоорондын хамаарлыг ашигладаг олон хувьсагчийн Калман филтер аргачлалаар тооцсон тэнцвэртэй үйлдвэрлэл алгуур буурч 2020 оноос хойш 1.5-2.5 хувийн хооронд хэлбэлзэж байна. Нэг хувьсагчийн HP филтерийн аргачлалаар тооцсон тэнцвэртэй үйлдвэрлэлийн хувьд 2020 оны дунд үед өсөлтгүй болж буурсан бол 2021 он гарсаар алгуур сэргэн тайлант улиралд 2.5 хувьд хүрээд байна. Харин үйлдвэрлэлийн функцээр тооцсон үр дүнгээр тэнцвэртэй өсөлт хөдөлмөр эрхлэлтийн түвшин саарснаас үүдэн буурсан хэвээр байна.



ERDENES SOLUTIONS Joint Stock Company
УЛААНБААТАР ХОТ ГҮЙДСЕК ҮЦК ХХК

СЗХ
2022 .02. 25 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022 -03- 22
БҮРТГЭВ-03



**2.4. Үйлдвэрлэлийн зөрүү**

КОВИД-19 цар тахлаас шалтгаалсан эдийн засгийн хүндрэл бий болж үйлдвэрлэлийн зөрүү, ялангуяа уул уурхайн бус үйлдвэрлэлийн зөрүү 2020 оноос хойш тасралтгүй сөрөг түвшинд хадгалагдаж байна. Уул уурхайн салбарын хувьд эрдэс бүтээгдэхүүний олборлолт 2020 оны сүүлийн хагасаас 2021 оны 1 дүгээр улирал хүртэл сайжирсан нь уул уурхайн үйлдвэрлэлийн зөрүүг эерэг түвшинд хүргэсэн ч сүүлийн 2 улирал хилийн хязгаарлалтаас үүдэн нүүрсний экспортын хэмжээ буурсан нь буцаад сөрөг болоход нөлөөллөө.

**2.5. Эдийн засгийн өсөлтийн цаашдын төлөв**

Эдийн засгийн өсөлтийг салбаруудаар авч үзвэл, уул уурхайн салбарын хувьд БНХАУ- ын хилийн хязгаарлалттай холбоотойгоор гол бүтээгдэхүүнүүдийн үйлдвэрлэл саарахаар байгаа хэдий ч зэсийн баяжмалын олборлолт, түүний алтны агууламж төлөвлөгөөнөөс давсан биелэлттэй байгаа нь энэ онд уул уурхайн салбарын өсөлтийн төсөөллийг өмнөхөөс нэмэгдүүлэхэд голлон нөлөөллөө. Харин Засгийн газар болон Төв банкнаас хэрэгжүүлж буй эдийн засгийг дэмжих бодлогын нөлөө нь уул уурхайн бус зарим салбарын өсөлтийг дэмжиж байгаа боловч хөдөө аж ахуй, барилга, тээвэр зэрэг бусад салбаруудын өсөлтийн төлөв хүлээлтээс бага байгаа нь уул уурхайн бус салбарын төсөөллийг бууруулахад нөлөөлж, нийт дүнгээр эдийн засгийн өсөлт 2021 онд өмнөх төсөөллөөс саарахаар байна.

Ирэх онд төсвийн төлөв харьцангуй сулрахаар байгаа нь эдийн засгийн өсөлтийг дэмжих нөлөөтэй хэдий ч гадаад эрэлт өмнөх төсөөллөөс саарахын зэрэгцээ худалдааны нөхцөл, гадаадын шууд хөрөнгө оруулалтын төсөөлөл өмнөхөөс буурч байгаа нь өсөлтийн төсөөллийг бууруулах нөлөө үзүүллээ. Ийнхүү 2021- 2022 оны төсөөлөл буурсан суурь үеийн нөлөө болон худалдааны нөхцөл сайжирч, төсвийн төлөв өмнөх төсөөллөөс сулрах төлөвтэй байгаа нь 2023 оны эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхээр байна (Зураг II.9).

Зураг II.9

4 улирлын нийлбэр ДНБ-ий жилийн өсөлт




Эх сурвалж: Монгол банк

*Уул уурхай:* Уул уурхайн салбарын үйлдвэрлэл ирэх оныг дуустал саарч, 2023 онд сэргэх хүлээлт хэвээр байна. Хилийн боомтын үйл ажиллагаа хязгаарлагдаад байгаа нь нүүрс, төмрийн хүдэр, газрын тос зэрэг гол бүтээгдэхүүнүүдийн үйлдвэрлэлийг сааруулж байгаа хэдий ч зэсийн баяжмалын олборлолт, түүний алтны агууламж нэмэгдсэн нь уул уурхайн салбарын 2021 оны өсөлтөд эерэгээр нөлөөлж байна. 2022-оос 2023 онд түүхий эдүүдийн дэлхийн зах зээл дээрх үнэ харьцангуй өндөр түвшинд хадгалагдах, хилийн хязгаарлалт байхгүй гэж үзсэнээр түүхий эдүүдийн үйлдвэрлэлийн түвшин урт хугацааны хэвийн түвшиндээ алгуур хүрэх ч Оюу толгойн зэсийн баяжмал болон түүний алтны агууламж 2022 онд буурах хүлээлттэй байгаа нь уул уурхайн салбарын өсөлт саарахад хүргэж байна. Харин 2023 оноос Оюу толгойн алт, зэсийн агууламж буцаад сэргэх хүлээлттэй байна.

*Уул уурхайн бус:* Засгийн газар болон Төв банкнаас хэрэгжүүлж буй эдийн засгийг дэмжих бодлогын нөлөөгөөр уул уурхайн бус салбарын өсөлт алгуур сэргэж, дунд хугацаанд цар тахлын нөхцөл байдал сайжирснаар салбаруудын өсөлт хэвийн үеийн түвшинд тогтворжих төлөвтэй байна. Тодруулбал, худалдаа, мэдээлэл холбоо, санхүү даатгал, эрчим хүчний



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company

УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК
ТТБ6674 № 5208173

2022 -03- 22
БҮРТГЭВ



Зураг III.2.1.1

М2 мөнгөний жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, актив тал




Эх сурвалж: Монголбанк

салбарууд 2021 оны өсөлтийг голлон тайлбарлаж байгаа бол төсвийн зардлын дутуу гүйцэтгэл болон хилийн хязгаарлалттай холбоотойгоор барилга, боловсруулах, тээврийн салбарын үйлдвэрлэл хүлээлтээс муу байж, бүтээгдэхүүний татвар бүрдүүлэлтийн төлөв бага байгаа нь эдийн засгийн өсөлтийг сааруулах нөлөөтэй байна. Эрэлт талаас гадаад худалдаа, өрхийн хэрэглээ төдийлөн сэргэхээргүй байна.

2022 онд төсвийн төлөв сулрах, гадаадын шууд хөрөнгө оруулалт, тэр дундаа Оюу толгойн хөрөнгө оруулалт нэмэгдэх нөлөөгөөр дотоод эрэлт сэргэж, салбарууд цар тахлын үеийн уналтаас гарснаар эдийн засгийн үйл ажиллагаа идэвхжиж, уул уурхайн бус салбарын өсөлт сэргэх төлөвтэй. Харин 2023 онд худалдааны нөхцөл эдийн засгийн өсөлтийг дэмжих хэдий ч гадаад эрэлтийн эерэг нөлөө саарч, хөрөнгө оруулалт болон дийлэнх салбарын үйлдвэрлэл хэвийн үеийн түвшинд хүрч тогтворжсоноор уул уурхайн бус салбарын өсөлт удаашрах төлөвтэй байна (Хүснэгт II.1.1).

Хүснэгт II.1.1

Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл

| | 2020 | 2021* | 2022* төсөөлөл | 2023* |
|---|---|---|---|---|
| ДНБ-ий өсөлт | -4.6 | 4.0 [2.8-5.2] | 5.5 [3.6-7.5] | 5.6 [3.0-8.2] |
| Уул уурхай | -9.[illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| Уул уурхайн бус | [illegible] | 3.6 [illegible] | [illegible] [5.3 – 9.[illegible]] | 5.9 [illegible] |

Эх сурвалж: Монголбанк

## 3. МӨНГӨ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ

### 3.1. Мөнгө, зээлийн үзүүлэлтүүд

Банкуудын зээлийн өсөлт тогтворжиж, мөнгөний нийлүүлэлтийн өсөлт саарч байна. Банкуудын зээлийн шалгуур 2021 оны 3 дугаар улиралд төдийлөн өөрчлөлтгүй, харин зээлийн нөхцөл суларч байна. Банкны системийн долларжилт сүүлийн саруудад харьцангуй тогтвортой хадгалагдав.

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг зээлийн өсөлт голлон бүрдүүлж байна. Харин төлбөрийн тэнцлийн алдагдал нэмэгдэж гадаад цэвэр актив (ГЦА)-ын өсөлт огцом саарав. Тухайлбал, төлбөрийн тэнцэл 2021 оны 2 дугаар улиралд 225 сая ам.долларын алдагдалтай, 3 дугаар улиралд 523 сая ам.долларын алдагдалтай гарлаа.

Харин 2021 оны 1 дүгээр улирлаас эхлэн "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө"-ний хэрэгжилттэй холбоотойгоор нэмэгдэж буй банкны системийн зээл олголт мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг голлон тэтгэж байна. Мөнгөний нийлүүлэлт 2021 оны 10 дугаар сард өмнөх жилийн мөн үеэс 19 хувиар нэмэгдэхэд ГЦА 3.1 нэгж хувь, зээлийн өсөлт 13.5 нэгж хувийг бүрдүүлэв (Зураг III.2.1.1).

Энэ оны эхний 10 сарын байдлаар төсвийн шаардлагатай санхүүжилтийн дүн 2.7 их наяд төгрөгт15 хүрэв. Уг шаардлагатай санхүүжилтийн 1.7 орчим их наяд төгрөгийг дотоод банкны систем дэх хуримтлалаас, 1 их наяд төгрөгийг гадаад зээлээр тус тус санхүүжүүлэв. Ийнхүү Засгийн газрын цэвэр зээл (ЗГЦЗ) өмнөх жилийн мөн үеэс төдийлөн өөрчлөлтгүй



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company
УЛААНБААТАР ХОТ
ГҮЙДСЕК ҮЦК ХХК

2022 -03- 22 БҮРТГЭВ



байна.

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт төгрөгийн харилцах, хадгаламжийн эх үүсвэрээс голлон бий болж байна. Тодруулбал, төгрөгийн хадгаламжийн өсөлт 12.5 нэгж хувь, төгрөгийн харилцахын өсөлт 8.4 нэгж хувийг бүрдүүлэв. Харин гадаад валютын хадгаламж -3.9 нэгж хувь, гадаад валютын харилцах 1.3 нэгж хувийн нөлөөг тус тус үзүүлжээ. Улмаар банкны системийн эх үүсврийн долларжилт өмнөх жилийн мөн үеэс 7.3 нэгж хувиар буурч, 2021 оны 10 дугаар сард 24.1 хувьд хүрэв (Зураг III.2.1.3).

Зураг III.2.1.3

Банкуудын зээл, хадгаламжийн долларжилт




Банкны системийн зээлийн үлдэгдэл 2021 оны 10 дугаар сарын байдлаар оны эхнээс 2.8 их наяд төгрөгөөр нэмэгдэж 19.9 их наяд төгрөгт хүрч, жилийн 16.6 хувиар өссөн байна. Эдийн засгийн салбараар нь харвал үл хөдлөх болон худалдааны салбарын зээлийн өсөлт голлон бүрдүүлж байгаа бол бусад салбаруудын зээлийн үлдэгдэл мөн өсөлттэй байв. Харин сүүлийн саруудад банкуудын өөрийн эх үүсврийн зээл өсөлтгүй, 10 их наядын цогц төлөвлөгөөний зээл олголт төдийлөн нэмэгдэхгүй байгаагаас банкны системийн зээлийн өсөлт тогтвортой байна. Валютын төрлөөр нь авч үзвэл төгрөгийн зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 18 хувиар, гадаад валютын зээлийн үлдэгдэл 4 хувиар тус тус өссөн.

Зураг III.2.1.4

Арилжааны банкуудын зээлийн жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, салбаруудаар




2021 оны эхний 10 сарын байдлаар банкны системээс 22.9 их наяд төгрөгийн зээл олгож зээл олголт өмнөх оны мөн үеэс 6.3 их наяд төгрөгөөр буюу 38 хувиар өслөө. Үүнээс 3.1 их наяд орчим төгрөг нь 10 их наядын цогц төлөвлөгөөтэй холбоотой байж улмаар бизнесийн зээл жилийн 17.2 хувиар өсөхөд нөлөөлөв.

Зураг III.2.1.5

Банкны системийн нийт зээл олголт, эргэн төлөлт (Тухайн жилд хуримтлагдах байдлаар)




Харин хэрэглээний зориулалттай зээл 1 хувиар буурсан бол сүүлийн улирлуудад иргэдийн хадгаламж барьцаалсан зээлийн өсөлт эрчимжиж байна. Ийнхүү бизнесийн зээл олголт илүүтэй эрчимжиж нийт зээлийн үлдэгдлийн бүтцийг өөрчилж байна. 2021 оны 10 дугаар сарын байдлаар хэрэглээ болон

2022-03-22 БҮРТГЭВ

хадгаламж барьцаалсан зээл нийт зээлд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 3.2 нэгж хувиар буурч 25.3 хувьд хүрлээ. Харин үл хөдлөх болон худалдааны салбарын зээлийн нийт зээлд эзлэх хувь 4.9 орчим нэгж хувиар нэмэгджээ.

"Банкны зээлийн төлөв" түүвэр судалгааны 2021 оны 3 дугаар улирлын тайланд дараах гол үр дүнг дурдсан байна. Үүнд, арилжааны банкны зээлийн шалгуур 2021 оны 3 дугаар улиралд төдийлөн өөрчлөгдөөгүй бол зээлийн нөхцөл бага зэрэг суларчээ. Үүнд хүүний түвшин, барьцаа хөрөнгийн үнэлгээ болон хүүний бус шимтгэлийн бууралт голлон нөлөөлжээ. Зээлийн эрэлт 2021 оны 3 дугаар улиралд бага зэрэг нэмэгдэв.

Энэ оны 4 дүгээр улиралд жижиг банкууд зээлийн шалгуурыг бага зэрэг чангаруулах, харин дунд болон том банкууд сулруулахаар байгаа нь банкны системийн дүнгээр зээлийн шалгуур сулрах төлөвийг бий болгохоор байна. Түүнчлэн нийт банкууд зээлийн нөхцөлийг үргэлжлүүлэн сулруулах хүлээлттэй байна. Банкны систем дэх ААН, иргэдийн зээлийн эрэлт бага зэрэг өсч байгаагаас зээлийн нийлүүлэлт (Уул уурхай, барилга, худалдаа, үйлчилгээний салбар, иргэдийн зээлийн хувьд) мөн өсөхөөр байна.

Зураг III.2.1.6

Банкны системийн нийт зээлийн үлдэгдлийн бүтэц, эдийн засгийн салбаруудаар




Зээлийн чанар өмнөх жилээс төдийлөн өөрчлөгдөөгүй, харин зээл олголт огцом өсч, зээлийн үлдэгдэл нэмэгдэж байгаа нөлөөгөөр анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь буурлаа. Түүнчлэн цар тахалын нөхцөл байдалтай холбоотойгоор эргэн төлөлтийн доголдолд орсон зээлийн ангиллыг түр хугацаанд бууруулахгүй байх асуудлыг банкууд бие даан шийдвэрлэх зохицуулалт нь үүнд нөлөөлж байгааг дурдах нь зүйтэй. Чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 1.4 хувиар хумигдаж чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 1.5 нэгж хувиар буурч 2021 оны 10 дугаар сарын байдлаар 9.9 хувьд хүрэв. Харин анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл 2021 оны 10 дугаар сард жилийн 15.6 хувиар буурав. Үүнд, хэрэглээ, хадгаламж барьцаалсан зээл, үйлчилгээ болон барилгын салбарын анхаарал хандуулах зээлийн дүн буурсан байна. Анхаарал хандуулах зээлийн нийт зээлд эзлэх хувь 2021 оны 10 дугаар сарын байдлаар 5.2 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 2 нэгж хувиар буурлаа.

Зураг III.2.1.7

Банкуудын анхаарал хандуулах зээлийн жилийн өсөлт, эдийн засгийн салбаруудаар




### 3.2. Хүү

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны сүүлийн дөрвөн ээлжит хурлаар бодлогын



ERDENES SOLUTIONS Joint Stock Company

УЛААНБААТАР ХОТ ГҮҮДСЕК ҮЦК ХХК

СЗХ 2022 05 25
2022-03-22 БҮРТГЭВ



хүүг 6 хувьд хэвээр хадгалах, өөрчлөхгүй байх шийдвэр тус тус гаргалаа.
Тайлант хугацаанд банк хоорондын захын хүүнүүд хүүний коридорын голч буюу бодлогын хүүний орчимд тогтвортой байв.

Цар тахлын өмнөх үе буюу 2019 оны эцэстэй харьцуулахад төгрөгийн шинээр татаж буй хадгаламжийн хүү 3.8 нэгж хувиар буурч 6.74 хувьд, олгосон зээлийн хүү 2.8 нэгж хувиар буурч 13.8 хувьд хүрлээ. Ийнхүү хүү буурахад төв банкнаас мөнгөний бодлогын хүрээнд болон банкны системд хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд, мөн "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө"-ний дагуу олгож буй хөнгөлөлттэй зээл голлон нөлөөлж байна.

Хүснэгт III.2.2.1
Шинээр олгосон зээлийн хүү (T), зээлдэгчдээр

| Хувь, % | 2020.10 сар | 2021.10 сар |
|---|---|---|
| Зээлийн хүү (хөнгөлөлттэй зээлийг оруулснаар) | 15.7 | 13.8 |
| Зээлийн хүү | 16.0 | 14.3 |
| i.Улсын байгууллага | 4.7 | 4.7 |
| ii.Хувийн байгууллага | 15.8 | 14.6 |
| *Үүнээс: ААН-ийн ЖДҮ* | 12.3 | 12.9 |
| iii.Санхүүгийн байгууллага | 17.4 | 15.6 |
| iv.Иргэд | 16.4 | 14.4 |
| *Үүнээс: Иргэдийн ЖДҮ* | 16.5 | 14.5 |
| *Хэрэглээ, мөө бөрь* | 17.5 | 14.2 |
| v.Бусад байгууллага | 9.8 | 2.2 |

*Эх сурвалж: Монголбанк*

Банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү 2021 оны 10 дугаар сард өмнөх сараас нэгж хувиар өсч 6.07 хувьд хүрэв. Үүнд ТБҮЦ барьцаалсан репо хэлцлийн хүү нэгж хувиар өссөн нь голлон нөлөөллөө. Харин банк хоорондын хадгаламжийн хүү 0.52 нэгж хувиар буурч 6.09 хувьд хүрлээ. Банк хоорондын захын бусад хэлцлүүдийн хүү 6 хувьд тогтвортой байв (Зураг III.2.2.1).

Энэ оны 10 дугаар сард банкуудын шинээр татсан төгрөгийн хадгаламжийн хүү өмнөх оны мөн үеэс 3.68 нэгж хувиар буурч 6.74 хувьд хүрсэн бол шинээр олгосон төгрөгийн зээлийн дундаж хүү хөтөлбөр (төлөвлөгөө)-ийн зээлийг хасч тооцвол 1.62 нэгж хувиар буурч 14.34 хувьд хүрлээ. Харин хөтөлбөрийн зээлийг оруулж тооцвол нийт зээлийн хүү 1.91 нэгж хувиар буурсан буюу 13.80 хувьтай байна. Улмаар зээл, хадгаламжийн хүүний зөрүү өмнөх оны мөн үеэс 1.77 нэгж хувиар өсч 7.06 хувьд хүрэв (Зураг III.2.2.2).

Зураг III.2.2.1
Банк хоорондын захын хэлцлийн хүү




*Эх сурвалж: Монголбанк*

Цар тахлын өмнөх үе буюу 2019 оны эцэстэй харьцуулахад валютын шинээр татаж буй хадгаламжийн хүү 3.1 нэгж хувиар буурч 1.37 хувьд, олгосон зээлийн хүү 0.5 нэгж хувиар буурч 8.24 хувьд хүрэв.

Тайлант хугацаанд шинээр олгосон гадаад валютын зээлийн хүү болон шинээр татсан гадаад валютын хадгаламжийн хүүний зөрүү нэмэгдлээ. Шинээр олгосон гадаад валютын

Зураг III.2.2.2
Шинээр олгосон зээлийн болон шинээр татсан хадгаламжийн хүү




*Эх сурвалж: Монголбанк*



ERDENES SOLUTIONS Joint Stock Company
УЛААНБААТАР ХОТ ГҮҮДСЕК ҮЦК ХХК

2022.05.25 он сар өдөр БҮРТГЭВ
2022-03-22
Хөрөнгийн үнэлгээний "Мөнх-Оргил трейд" ХХК БҮРТГЭВ-03

зээлийн дундаж хүү 2021 оны 10 дугаар сард өмнөх оны мөн үеэс 1.85 нэгж хувиар буурч 8.24 хувьд хүрсэн бол шинээр татсан гадаад валютын хадгаламжийн хүү өмнөх оны мөн үеэс 2.01 нэгж хувиар буурч 1.37 хувьд хүрснээр гадаад валютын зээл, хадгаламжийн хүүний зөрүү өмнөх оны мөн үеэс 0.16 нэгж хувиар өсч 6.87 хувьд хүрэв (Зураг III.2.2.2).

### 3.3. Валютын ханш

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш тогтвортой хэвээр байна. Сүүлийн нэг жил гаруй хугацаанд ам.долларын ханш 2850 төгрөгийн орчимд тогтвортой, хэлбэлзэл багатай байгаа ба 2021 оны 11 дүгээр сарын эцсийн байдлаар 2849.2 төгрөгтэй тэнцэж байна (Зураг III.2.3.1).

Зураг III.2.3.1
Төгрөгийн ам.доллартай харьцах ханш




Эх сурвалж: Монголбанк

Тайлант улиралд импортын хэмжээ мэдэгдэхүйц өссөн хэдий ч экспортын хэмжээ өнгөрсөн оны мөн үеийн түвшинд байснаар худалдааны тэнцэл ашигтай гарлаа. Түүнчлэн, Монгол улсын Засгийн газрын гадаад өрийн дахин санхүүжилтийн амжилттай хийсэн нь зах зээлийн хүлээлтэд эергээр нөлөөлөв.

Гадаад худалдааны эргэлтээр жигнэж тооцсон төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханш (NEER) 2020 оны 4 сараас эхлэн суларч байгаа бөгөөд 2021 оны 10 дугаар сард өмнөх оны мөн үеэс 2.9 хувиар сулрав. Үүнд, төгрөгийн ханш юанийн эсрэг жилийн 4.7 хувиар, рублийн эсрэг 12.4 хувиар суларсан нь голлон нөлөөлөв. Харин 2021 оны 10 дугаар сарын байдлаар ам.доллар болон еврогийн эсрэг төгрөгийн ханш өмнөх оны мөн үеэс бараг өөрчлөлтгүй байна (Зураг III.2.3.2). Харин сарын өөрчлөлтийг авч үзвэл 7 сараас хойш төгрөгийн ханш еврогийн эсрэг алгуур чангарсан бол рублийн эсрэг сүүлийн 2 сарын хугацаанд 1-3 хувиар суларсан.

Зураг III.2.3.2
Төгрөгийн гол валютуудтай харьцах ханш болон нэрлэсэн үйлчилж буй ханшийн (NEER) жилийн өөрчлөлт




Эх сурвалж: Монголбанк

Төгрөгийн бодит ханш дотоод үнийн харьцангуй өсөлтөөс үүдэн чангарч буй хандлага үргэлжилж сүүлийн 3 жилийн хамгийн чанга түвшиндээ хүрээд байна. Төгрөгийн нэрлэсэн ханш 3.2 хувиар суларч, гадаад үнэтэй19 харьцуулахад дотоод үнэ20 8.4 хувиар чангарснаар бодит ханш энэ оны 9 дугаар сард өмнөх оны мөн үеэс 5.2 хувиар чанга тогтлоо (Зураг III.2.3.3).

Зураг III.2.3.3
Төгрөгийн бодит ханшийн жилийн өөрчлөлт




Эх сурвалж: Монголбанк

Төгрөгийн харьцангуй өгөөж сүүлийн 1 жил



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК ERDENES SOLUTIONS Joint Stock Company
УЛААНБААТАР ХОТ ГҮҮДСЕК ҮЦК ХХК

он 2022 сар 05 өдөр БҮРТГЭВ
2022 -03- 22 БҮРТГЭВ-03

гаруй хугацаанд эерэг түвшинд хадгалаг-даж, төгрөгийн ханшийн өөрчлөлтийг даган тогтвортой байна. Тайлант улиралд өгөөж жилийн 4.9 хувьтай байна (Зураг III.2.3.4).

Зураг III.2.3.4
Төгрөгийн харьцангуй өгөөж




Ийнхүү төгрөгийн харьцангуй өгөөж өндөр байгаа нь Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 6 сарын ээлжит хурлын шийдвэрээр өндөр хүүтэй гадаад валютын хадгаламж болон хүү төлж буй гадаад валютын харилцахын эзлэх хувиар банкинд олгох төгрөгийн заавал байлгах нөөцийн урамшууллыг бууруулан тооцох шийдвэр гарснаар валютын хадгаламжийн хүү буурсантай холбоотой юм. Үр дүнд нь төгрөгийн хадгаламжийн хэмжээ нэмэгдэж, валютын хадгаламжийн хэмжээ буурч байна. Тодруулбал, хадгаламжийн долларжилтын хэмжээ 2020 оны 9 сараас хойш 10 орчим нэгж хувиар буурч 2021 оны 10 сарын байдлаар 24.1 хувьд хүрээд байна.

## 4. ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Тайлант улиралд орон сууцны үнийн өсөлт эрчимжсэн бол хөрөнгийн захын идэвхжил сэргэж, ТОП-20 индекс түүхэн өндөр түвшинд хүрэв. Хөрөнгийн захын идэвхжил тайлант улиралд эрчимжиж, ТОП-20 индекс 2021 оны 9 дүгээр сард түүхэн дээд түвшиндээ хүрч өссөн бол 10 дугаар сараас эргээд буурах хандлага ажиглагдав. Тодруулбал, ТОП-20 индекс 2021 оны 9 дүгээр сард дунджаар 44,824.4 нэгжид хүрч, оны эхнээс хоёр дахин өссөн бол 10 дугаар сарын дунджаар 40,357.5 нэгжид хүрээд байна. Харин зах зээлийн үнэлгээ 10 дугаар сард оны эхэнтэй харьцуулахад 62.0 хувиар өсч, 4,867 тэрбум төгрөгт хүрлээ (Зураг III.2.4.4).

Зураг III.2.4.4




Хөрөнгийн зах зээлд арилжаалагдах бүтээгдэхүүний төрөл нэмэгдсэний зэрэгцээ хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын үйл ажиллагаа идэвхжин ногдол ашиг тараалт, шинээр үнэт цаас гаргах явдал ихэссэн бөгөөд нөгөө талаас банкны хадгаламжийн хүү буурснаар хөрөнгийн зах зээлд оролцогчдын идэвх өсч хөрөнгийн захын үзүүлэлтүүд сэргэхэд нөлөөлж байна. 2021 оны эхний 10 сарын байдлаар Монголын хөрөнгийн бирж дээр нийт 1,173 тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжаа хийгдээд байна. Тайлант улиралд Эрдэнэс Таван Толгой компаний ЭТТ бондын 2-р шатны захиалгын хүрээнд 164 тэрбум төгрөг, 13.1 сая ам.долларын арилжаа, Инвескор ББСБ-ын бондын 2 ба 3-р шатны захиалгын тус бүр 6 тэрбум төгрөгийн арилжаа анхдагч зах дээр хийгдсэн бол "Мандал Ассет Менежмент ҮЦК"-ий гаргасан "Мандал Ирээдүйн өсөлт" хамтын хөрөнгө оруулалтын сан нийт 47.5 тэрбум төгрөгийн хөрөнгийг олон нийтээс татан төвлөрүүлсэн зэрэг нь үнэт цаасны арилжаанд томоохон дүн эзэлж байна.

Сүүлийн саруудад хувьцааны арилжааны идэвхийг үнийн дүнгээр "Ард санхүүгийн нэгдэл",



ERDENES SOLUTIONS Joint Stock Company
УЛААНБААТАР ХОТ ГҮЙДСЕК ҮЦК ХХК

2022 -03- 22
БҮРТГЭВ



"Тэнгэрлиг медиа групп", "АПУ" компаниуд тэргүүлсэн бол арилжааны тоо ширхэгээр "Мандал даатгал", "Лэндмн ББСБ", "Монос хүнс" буюу санхүү болон хүнсний салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниуд тэргүүлжээ26. Хөрөнгийн захын арилжааны идэвх сүүлийн саруудад харьцангуй идэвхжиж, 8 дугаар сард хөрвөх чадварын харьцаа 16.1 хувьд хүрч хамгийн өндөр түвшинд хүрсэн бол 10 дугаар сарын байдлаар 6.4 хувь болж буураад байна (Зураг III.2.4.5).

Зураг III.2.4.5

Хөрвөх чадварын харьцаа




Эх сурвалж: ҮСХ, Монголбанк

## 5. ЭДИЙН ЗАСГИЙН ГАДААД ОРЧИН

**Гадаад эдийн засгийн орчны талаарх төсөөлөлд ашигласан таамаглал**

Евро бүс, ОХУ-ын эдийн засгийн өсөлтийн төсөөлөл 2021 онд өмнөх улирлын төсөөлөлтэй харьцуулахад сайжирсан бол БНХАУ, АНУ-ын эдийн засгийн өсөлтийн төсөөлөл муудлаа. Гадаад эдийн засгийн дунд хугацааны өсөлтийн төлөв өмнөх төсөөллийн орчимд байна.

Улс орнуудад КОВИД-19-ийн вакцинжуулалт үргэлжилж, хөл хорио сулран, дэлхийн эдийн засаг 2021 оны 3-р улиралд сэргэсэн ч өсөлтийн моментум буурах тал руу хэлбийж, энэ онд дэлхийн эдийн засаг 5.9 хувиар өсөх төлөвтэй байна. 2021 оны эдийн засгийн өсөлтийн төсөөлөл БНХАУ, АНУ-д муудсан бол Евро бүс, ОХУ-д сайжирлаа. Цаашид улс орнуудын эдийн засгийн өсөлт 2022-2023 онд тогтворжиж, төсөв, мөнгөний бодлогууд нормалчлагдан, урт хугацааны хэвийн түвшиндээ хүрэх төлөвтэй. Гэсэн хэдий ч цар тахал улс орнуудад тархсан хэвээр, вирусын шинэ хувилбар олон оронд бүртгэгдсэн зэрэг нь гадаад орчны гол эрсдэл болж байна.

**БНХАУ**-д эрчим хүчний хямрал нүүрлэж, аж үйлдвэрлэлийн өсөлт саарсан, үл хөдлөх хөрөнгийн зах нь хүндрэлд орсон зэргээс шалтгаалан эдийн засаг нь 2021 оны 3-р улиралд хүлээлтээс бага буюу 4.9 хувиар өсөв. БНХАУ цар тахлын тархалтын эсрэг Тэг-КОВИД-19-ийн бодлого хэрэгжүүлж эхэлсэн нь зарим бүс нутгийн хэрэглээ, аж үйлдвэрлэл, тээвэр, логистикт сөргөөр нөлөөлж байна. БНХАУ-ын эдийн засаг 2021 онд өмнөх төсөөллөөс 0.5 нэгж хувиар бага буюу дунджаар 8.0 хувиар өсөхөөр шинжээчид30 төсөөлж байна.

БНХАУ-ын эрх баригчид ирэх онд төсөв, мөнгөний бодлогоор дотоод эрэлт, өсөлтийг дэмжихээр байна. Тухайлбал, БНХАУ-ын Ардын Банк эдийн засгийн өсөлтийг тэтгэх зорилгоор 2021 оны сүүлийн улиралд, мөн 2022 онд ЗБН-ийн хувийг бууруулах хүлээлттэй бол засгийн газраас төсвийн тэлэх бодлогыг 2022 оны сүүлээр болох БНХАУ-ын Ардын намын коммунист их хурлыг хүртэл үргэлжлүүлэх төлөвтэй тул төсвийн төлөв мөн ирэх онд сулрахаар байна. Дунд хугацаанд БНХАУ-ын хүн амын насжилттай холбоотойгоор ажиллах хүчний оролцоо буурахаар байгаа ч БНХАУ-ын Засгийн газраас хэрэгжүүлэх "Хос эргэлтэт" бодлого, технологийн салбарын хөрөнгө оруулалт нь эдийн засгийн өсөлтийг тэтгэхээр байна.

**ОХУ**-ын эдийн засаг 2021 онд шинжээчдийн төсөөллийн дунджаар2 4.3 хувиар өсөхөөр байгаа нь өмнөх төсөөллөөс 0.6 нэгж хувиар сайжирсан үзүүлэлт юм. ОХУ-д энэ оны 3-р улиралд хөл хорио суларч, эдийн засаг хүлээлтээс сайн буюу 4.0 хувиар өссөн, өмнөх төсөөлөлтэй харьцуулахад газрын тосны үнэ өссөн, гадаад эрэлт (Евро бүс) болон дотоод



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company
УЛААНБААТАР ХОТ
ГҮЮДСЕК ҮЦК ХХК

2022-05-25 БҮРТГЭВ
2022-03-22
БҮРТГЭВ-03


эрэлт сэргэн, ажил эрхлэлт, хувийн хэрэглээ, аж үйлдвэрлэл эрчимжиж байгаа нь төсөөллийг сайжруулахад нөлөөлөв. Газрын тосны үнэ өссөн нөлөөгөөр хувийн секторын газрын тосны салбар дахь хөрөнгө оруулалт нэмэгдэх хандлагатай байна. Харин ургац хураалт хүлээлтээс бага байсан, малын өвчлөл нэмэгдсэн зэрэг нь ХАА салбарын үйлдвэрлэлд сөргөөр нөлөөлөхөөр байна.

ОХУ-д эрэлт, нийлүүлэлтийн шалтгаантай инфляц эрчимжиж байгаагаас Оросын Төв банк энэ оны 3-р сараас хойш 6 удаагийн бодлогын шийдвэрээр бодлогын хүүг нийт 3.25 нэгж хувиар өсгөж, 7.5 хувьд хүргэв.Мөн 2022 оны сүүлийн хагасаас мөнгөний бодлогын төлөвийг алгуур сулруулах хүлээлттэй байна. Өмнөх төсөөлөлтэй харьцуулахад мөнгөний бодлогын төлөв хурдтай чангарсан, энэ оны 4-р улирлаас цар тахлын тархалт нэмэгдэж буй, 2021 оны өсөлтийн төсөөлөл сайжирсан суурь үеийн нөлөө нь ирэх оны өсөлтийн төлөвийг өмнөхөөс 0.1 нэгж хувиар бууруулахад нөлөөллөө. Тус улсын Засгийн газар төсвийн бодлогоо 2021 оны сүүл, 2022 онд чангаруулж, гадаад шокын эрсдэлийг бууруулах нөөц бүрдүүлэхэд анхаарч байгаа бөгөөд төсвийн алдагдал 2021 онд ойролцоогоор ДНБ-ий 1.8 хувь, харин 2022 онд 1.2 хувь болж багасахаар байна.

Евро бүсийн эдийн засаг 2021 онд дунджаар 5.1 хувиар өсөхөөр шинжээчид таамаглаж байна. Энэ нь өмнөхөөс 0.5 нэгж хувиар сайжирсан төсөөлөл юм. Евро бүсийн орнуудад вакцинжуулалт эрчтэй үргэлжилж, хөл хорио сулран, хэрэглээ, бизнесийн идэвхжил нэмэгдсэнээр 3-р улирлын гүйцэтгэл хүлээлтээс сайн буюу жилийн 3.7 хувиар өслөө. Мөн Евро бүсийн хэрэглэгчийн сентимент сайжирч, хэрэглээ нэмэгдэх хандлагатай болов. Гэхдээ өвлийн улиралд дельта вирусын тархалт нэмэгдэж, үйлчилгээний салбарын сэргэлт удаашраад байна. Нийлүүлэлтийн гинжин сүлжээний доголдолтой холбоотой эд ангийн нийлүүлэлт хомс байгаа нь аж үйлдвэрлэлийн өсөлтийг хязгаарлаж байна. Европын Төв банкны хасах хүүгийн бодлого, уламжлалт бус мөнгөний бодлого болон бүсийн голлох эдийн засгуудад хэрэгжүүлж буй төсвийн тэлэх бодлого нь төсөөллийн хугацаанд дотоод эрэлтийг тэтгэх хүлээлттэй.

Гадаад хүү: АНУ-ын Холбооны нөөцийн банк 2021 оны 11-р сард бодлогын хүүгээ 0.0-0.25%-д хэвээр хадгалах, харин сар тутам бонд худалдан авах дүнгээ алгуур бууруулахаар шийдвэрлэв32. Цаашид Холбооны нөөцийн банк АНУ-ын хөдөлмөрийн зах зээл урт хугацааны бүрэн ажил эрхлэлтийн түвшинд хүрэх болон инфляц 2 хувийн зорилтот түвшин хангагдах хүртэл бодлогын хүүгээ тэг орчим хувьд хадгалахаа мэдэгдэв. Гэсэн хэдий ч ХНБ хүүгээ өсгөх хүлээлт 2023 оноос урагшилж 2022 оны дунд үеэс өсгөх, мөн бодлогын хүүг илүү том алхмаар өсгөнө гэж зарим шинжээчид хүлээж байна.

Гадаад инфляц: АНУ, ОХУ-ын инфляцын төсөөлөл өмнөхөөс нэмэгдсэн бол БНХАУ-ын инфляцын төлөв буурч, манай гадаад инфляцын төлөв өмнөх төсөөллийн орчимд байна.

БНХАУ-ын инфляц энэ онд Блүүмберг, EIU, Рубини судалгааны байгууллагуудын дунджаар 1.0 хувь болж өмнөх төсөөллөөс нэгж хувиар буурахаар байна. Эрчим хүчний үнэ, үйлдвэрлэлийн үнэ өсөж, тээвэр логистикийн зардал нэмэгдэж, хүнсний бус инфляц өсөж байгаа ч гахайн махны нийлүүлэлт нэмэгдэн хүнсний инфляц буурсан нөлөө давамгайлж, нийт инфляц өмнөх төсөөллөөс буурлаа. БНХАУ-ын Ардын банк энэ оны төгсгөл, ирэх онд ЗБН- ийг бууруулж, бодлогын төлөвийг сулруулах хүлээлттэй байгаа нь инфляцыг өсгөх чиглэлд нөлөөлөхөөр байна.

АНУ-ын инфляц Блүүмберг, EIU, Рубини судалгааны байгууллагуудын дунджаар 2021 онд 4.1 хувь болж, өмнөх төсөөллөөс нэгж хувиар нэмэгдэхээр байна. Цар тахлын үеийн тээвэр, логистикийн хүндрэл, ажиллах хүчний хомсдолтой байдлаас нийлүүлэлт хомсдсон, түүхий эдийн үнэ өсөж, үйлдвэрлэл, тээврийн зардал нэмэгдсэн нь богино хугацаанд үнэ өсөхөд


ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК ERDENES SOLUTIONS Joint Stock Company
УЛААНБААТАР ХОТ ГҮЙДСЕК ҮЦК ХХК ТТБ8674 рд. 5208173

нөлөөлж байна. ХНБ-наас инфляцыг түр зуурын шинжтэй гэж үзэн, бодлогын хүүг ойрын хугацаанд өсгөхөөргүй байгаа ч бонд худалдан авалтаа бууруулж эхэллээ. Цаашид эрэлт, нийлүүлэлт тогтворжиж, инфляц тогтворжих хандлагатай байна.

ОХУ-ын инфляц Блүүмберг, EIU, Рубини судалгааны байгууллагуудын дунджаар 2021 онд 6.1 хувь болж өмнөх төсөөллөөс 0.3 нэгж хувиар нэмэгдэхээр байна. Намрын улиралд ургац хураалт муу байсны зэрэгцээ дэлхийн хүнсний үнэ нэмэгдэн, хүнсний инфляц нь өслөө. Мөн тээвэр, логистикийн доголдол, ажиллах хүчний хомсдлын улмаас нийлүүлэлт буурч, үйлдвэрлэлийн үнэ өндөр байгаа нь үнэ өсөхөд нөлөөлж байна. Төв банкнаас инфляцын хүлээлтийг бууруулахын тулд 3-р сараас хойш бодлогын хүүг өсгөж, 7.5 хувьд хүргээд байна. Цаашид эдийн засгийн сэргэлт аажмаар тогтворжиж, газрын тосны үнэ өссөн нөлөөгөөр рублийн ханш чангарч, инфляц буурах төлөвтэй тул дунд хугацаанд зорилтот түвшний орчимд тогтворжихоор байна.

**Эдийн засгийн гадаад орчны тодорхой бус байдал**

Бүс нутгуудад цар тахлын тархалт үргэлжилж байгийн зэрэгцээ мутацад орсон вирусын шинэ хувилбар зарим оронд бүртгэгдэж, цаашид тархах эрсдэлтэй байгаа нь гадаад орчны тодорхой бус байдлын гол эх сурвалж болж байна. Мөн улс орнуудад инфляц өндөр түвшинд хадгалагдах төлөвтэй болсон нь мөнгөний бодлогын төлөвийг хүлээлтээс эрт чангаруулж, гадаад өрийн хүүний зардлыг өсгөн, дахин санхүүжилтэд хүндрэл учруулж болзошгүй байна.

**ДҮГНЭЛТ.** Монголбанкнаас гаргасан 2021 оны 12-р сарын "Инфляфийн тайлан"-д инфляц-ийг доорх хүснэгтэд зааснаар төсөөлсөн.

Хүснэгт I.2

Инфляцын төсөөлөл[4]

| | 2020 | 2021* | 2022* | 2023* |
|---|---|---|---|---|
| | | | *төсөөлөл* | |
| Инфляц, ХҮИ | 2.9 | 10.5 [10.1-11.0] | 6.7 [5.0-8.4] | 7.4 [5.9-8.9] |

*Эх сурвалж: Монголбанк*

Уг тайланд "2022 оны эхний хагаст инфляц зорилтот түвшнээс давахаар байгаа нь голлон өмнөх онд инфляц буурсан суурь үеийн нөлөө болон нийлүүлэлтийн шинжтэй хүчин зүйлсийн нөлөөгөөр тайлбарлагдаж байна. Тухайлбал, хилийн боомтын хязгаарлалтаас үүдэлтэй импортын хүнсний барааны үнийн өсөлт, тээврийн зардлын өсөлт болон малын өвчлөлтэй холбоотой махны үнийн өсөлт зэрэг нь ирэх оны эхний хагас хүртэл үргэлжлэх төлөвтэй бол 2022 оны сүүлийн хагасаас үнийн өсөлт тогтворжиж инфляц алгуур буурах хүлээлттэй байна" гэсэн төсөөллийг хийсэн байна. Дээрх хүснэгтээс харахад инфляц 2022 онд 5.0% - 8.4%, дундажаар 6.7%, 2023 онд 5.9% – 8.9%, дундажаар 7.4% байхаар харагдаж байна.

Эдийн засгийн өсөлт-ийг доорх байдлаар төсөөлж байна. 2021- 2022 оны төсөөлөл буурсан суурь үеийн нөлөө болон худалдааны нөхцөл сайжирч, төсвийн төлөв өмнөх төсөөллөөс сулрах төлөвтэй байгаа нь 2023 оны эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхээр байна. 2022 онд төсвийн төлөв сулрах, гадаадын шууд хөрөнгө оруулалт, тэр дундаа Оюу толгойн хөрөнгө оруулалт нэмэгдэх нөлөөгөөр дотоод эрэлт сэргэж, салбарууд цар тахлын үеийн уналтаас гарснаар эдийн засгийн үйл ажиллагаа идэвхжиж, уул уурхайн бус салбарын өсөлт сэргэх төлөвтэй. Харин 2023 онд худалдааны нөхцөл эдийн засгийн өсөлтийг дэмжих хэдий ч гадаад эрэлтийн эерэг нөлөө саарч, хөрөнгө оруулалт болон дийлэнх салбарын

үйлдвэрлэл хэвийн үеийн түвшинд хүрч тогтворжсоноор уул уурхайн бус салбарын өсөлт удаашрах төлөвтэй байна

Хүснэгт II.1.1

Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл[10]

| | 2020 | 2021** | 2022** төсөөлөл | 2023** |
|---|---|---|---|---|
| ДНБ-ий өсөлт | -4.6 | 4.0 [2.8-5.2] | 5.5 [3.6-7.5] | 5.6 [3.0-8.2] |
| Уул уурхай | -9.9 | 6.3 [5.1-7.5] | (-5.5) [(-7.5) – (-3.5)] | 3.5 [0.9 – 6.1] |
| Уул уурхайн бус | -3.7 | 3.6 [2.4-4.8] | 7.5 [5.3 – 9.3] | 5.9 [3.3 – 8.5] |

Эх сурвалж: Монголбанк

Монголбанкны "Мөнгөний бодлогын хороо"-ны 2022 оны 01-р сарын 28-ны өдрийн ээлжит бус хурлаар эдийн засаг, банк, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал гадаад, дотоод орчны төлөв, эрсдэлийг харгалзан үзээд "Бодлогын хүү"-г 0.5 нэгж хувиар нэмэгдүүлж **6.5 хувь**-д хүргэх шийдвэрийг гаргалаа.

Монголбанкны 2022 оны 01-р сарын 28-ны өдөр гаргасан мэдэгдэлд "КОВИД-19 вирусын Омикрон хувилбарын тархалт эрчимжиж, дэлхийн эдийн засгийн төлөв өмнөх төсөөллөөс муудаж, тээвэр, логистикийн саатал, нийлүүлэлтийн гинжин хэлхээний доголдлоос үүдэн зардлын инфляц олон улс оронд огцом нэмэгдэж байна. Манай улсын хувьд мөн адил гадаад худалдааны тээврийн саатал үргэлжилсээр импортын барааны үнэ нэмэгдлээ. Мах, хүнсний ногоо, шатахуун, импортын барааны үнэ нэмэгдсэн нь бусад бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийг хүлээлтээс ихээр өсгөлөө. **Жилийн инфляц 2021 оны 12 дугаар сард улсын хэмжээнд 13.4 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 14.8 хувьтай гарав.**" гэж тэмдэглэсэн байна.

**Дээрх мэдээллээс харахад инфляцийн түвшин 2022 – 2023 онуудад 6.7% - 7.4%, эдийн засгийн өсөлт 5.5% - 5.6% байхаар төсөөлөгдөж байна.**

Олон улсын валютын сангийн https://www.imf.org/external/datamapper/PCPIPCH@WEO/%20WEOWORLD/VEN/USA/MNG сайтнаас авсан мэдээллээр Монгол улсын хувьд инфляцийн хувийг 2022 онд 7.3%, 2023 онд мөн 7.3%, 2024 онд 6.7%, 2025 онд 6.3%, 2026 онд 6.0% байхаар төсөөлсөн байна.

### 4.3. Салбарын байдал, зах зээл

Монгол улс 3.3 сая хүн амтайгаас үнэт цаасны 2 бирж үйл ажиллагаа эрхэлж байна. Монголын хөрөнгийн биржийн хувьцааны арилжаанд 2021 онд нийт 68'000 хүн оролцсон байна.

Хөрөнгийн биржийн болон биржийн бус зах зээл, койны зах зээл дээр мэдээлэл нилээд дутмаг байгаагаас хөрөнгө оруулагчид мэдээллийг компаниас эсвэл Монголын хөрөнгийн биржийн сайтнаас авч байна.

***Үнэт цаасны зах зээл дээрх хэрэглэгчдийн зах зээл***

Хөрөнгийн зах зээл дээр нийт 300 хувьцаат компани, 55 брокерийн компани байна.

Эдгээр брокерийн компаниудын 13 орчим буюу 25% нь ЕСМ ХХК, 1 брокерийн компани буюу 2% нь Стандарт ХХК-ийн программ хангамж хэрэглэж байна.

он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01
2022 -03- 22
БҮРТГЭВ-03



ТДБ Капитал ҮЦК ХХК болон Голомт Секюритиз ҮЦК ХХК нь өөрийн хөгжүүлсэн программ хангамжийг ашиглаж байна.

Нийт брокерийн компанийн 70% хувь нь ямар нэгэн программ хангамж ашиглахгүй Excel sheet ашиглан ажиллаж байна.

Монголын хөрөнгийн биржийн MIT программ хангамжтай FIX/FAST протоколоор дамжин онлайн холболттой Голомт Секюритиз ҮЦК ХХК болон ТДБ капитал ҮЦК-ийн ашиглаж буй өөрийн программ хангамж, Стандарт ХХК-ийн хөгжүүлсэн программ хангамжаар холбогдсон 3 брокерийн компани байна.

Нийт брокерийн компанийн зах зээлийн 25%-ийг эзлэж буй ЕСМ ХХК-ний программ хангамж Монголын хөрөнгийн биржийн программ хангамжтай онлайн холболтгүй байна.

Банк бус санхүүгийн зах зээл дээр 600 гаруй банк бус санхүүгийн байгууллага байгаагаас мэдэгдэж байгаагаар 200 гаруй банк бус санхүүгийн байгууллага огт программ хангамжгүй Excel sheet ашиглаж байгаа бөгөөд 100 гаруй компанийн ашиглаж буй программ хангамж нь бүрэн ашиглах боломжгүй хөгжүүлсэн компаниуд цаашид хөгжүүлэхээ больсон байна. Бусад компаниудын талаар мэдээлэл хомс байгаа бөгөөд Лендмн, Инвескор, Ард кредит, зэрэг цөөхөн компаниуд өөрсдийн хөгжүүлсэн программ хангамжийг ашиглаж байна.

### 4.4. "Эрдэнэс сольюшинс" ХК-ний талаарх мэдээлэл

| | |
|---|---|
| Компанийн нэр: | "Эрдэнэс сольюшинс" ХК /хуучин нэр: "Хар хорин пропертис" ХК/ |
| Үүсгэн байгуулагдсан огноо: | 1996.04.20 |
| Улсын бүртгэлийн дугаар: | 9010001131 |
| Регистерийн дугаар: | 2015355 |
| Үйл ажиллагааны чиглэл: | - Программ хангамж /код-62010/<br>- Компьютерийн тоног төхөөрөмжийн худалдаа /код-47410/<br>- Вэб сайт хийх /код-63120/<br>- Онлайн худалдаа /код- 47910/<br>- Мэдээллийн техниологийн үйлчилгээ /код- 63990/<br>- Худалдааны зуучлал /код-46100/ |

**Товч түүх.** Компани нь анх "Хархорин Хүнсний үйлдвэр" байсныг Монгол Улсын Засгийн газрын 1991 оны 170-р тогтоолын хүрээнд хүнс спиртийн үйлдвэрийг төрийн өмч давамгайлсан ХК болгон хувьчлахаар заасны дагуу хувьчлахаар шийдвэрлэж, Өвөрхангай аймгийн Ардын Хурлын Гүйцэтгэх захиргааны Өмч хувьчлалын комиссын 1992 оны 04-р сарын 02-ны өдрийн №6 тоот тогтоолыг үндэслэн "Амтлаг" ХК болон өөрчлөгдөж, нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 90,038 ширхэг энгийн хувьцааг 1992 оны 10 дугаар сарын 21-ний өдөр "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн үнэт цаасны бүртгэлд бүртгүүлсэн. Түүнээс хойш 3 удаа МХБ-ийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулсан байна.

Үүнд:

- Компанийн нэрийг Үнэт цаасны хорооны 1997 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 18 дугаар тогтоолыг өөрчилж "Шимтлэг" ХК болгосон;

- Компанийн энгийн хувьцааг Үнэт цаасны хорооны 1998 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 08 дугаар тогтоолыг үндэслэн нийт гаргасан 90,038 ширхэг хувьцаанаас төрийн эзэмшлийн 53'843 ширхэг хувьцааг хасаж, 36'195 ширхэг хувьцаанаас бүрдэж байхаар



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company
2015358



УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК
ТТ58674 др. 5208173

2022 05 25 БҮРТГЭВ №21

2022-03-22 БҮРТГЭВ-03



шийдвэрлэсэн;

- Компанийн нэрийг Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2015 оны 07-р сарын 03-ны 207 тоот тушаалаар өөрчлөхийг зөвшөөрч, Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын 2016 оны 05 дугаар сарын 13-ний өдрийн 187 дугаар тушаалаар "Хар хорум пропертийс" АМТ нэрээр бүртгэлд өөрчлөлт оруулсан байна.

Уг компанид програм хангамжийн "Эрдэнэс сольюшинс" ХХК-ийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулахыг Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 02-р сарын 28-ны өдрийн 80 тоот тогтоолоор зөвшөөрсөн бөгөөд компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн бүртгэлд нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 15'787'457 ширхэг энгийн хувьцаатай болсон. Компанийн энгийн хувьцааг Санхүүгийн зохицулах хорооны 2021 оны 01-р сарын 13-ны өдрийн 01 тоот тогтоолоор 10 дахин хувааж нэг бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1,578,745,7 ширхэг энгийн хувьцаатай болгосон.

**"Эрдэнэс сольюшинс" ХК-ийн Хувьцааны мэдээлэл**

| | |
|---|---|
| Үнэт цаасны үсгэн болон тоон код: | АМТ |
| Нийт гаргасан хувьцааны тоо: | 1,578.745,7 |
| Хувьцааны нэрлэсэн үнэ: | 10 төгрөг |
| 52 долоо хоногийн доод, дээд ханш: | 53-586 төгрөг |
| Хувьцааны ханш (12/08/2021): | 84 төгрөг |
| Зах зээлийн үнэлгээ (02/05/2010): | 13.261,463,880.00 төгрөг |

**"Эрдэнэс сольюшинс" ХК-ийн хувьцааны арилжааны мэдээлэл**

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ | САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН | ХУРЛЫН МЭДЭЭЛЭЛ

Эрдэнэс сольюшинс ХК (АМТ)

| | | | |
|---|---|---|---|
| [illegible] | 89.99 | [illegible] | 89.99 - 90.00 |
| [illegible] | 89.99 | [illegible] | 1,083 |
| [illegible] | 90.00 | [illegible] | 97,468.00 |
| Тухайн өдрийн VWAP | 90.00 | [illegible] | 2 |
| [illegible] | 65.00 x 1,975 | [illegible] | 60.00 - 120.00 |
| [illegible] | 90.00 x 7,750 | ISIN | MN00AMT01758 |
| Нийт гаргасан хувьцаа | 157,874,570 | [illegible] | 14,208,711,300.00 |
| [illegible] | 157,874,570 | | |



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК ERDENES SOLUTIONS Joint Stock Company

33 УЛААНБААТАР ХОТ ГҮҮДСЕК ҮЦК ХХК ТТБ0674 5208173

СЗХ
он 2022 сар 05 25 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022 -03- 22
БҮРТГЭВ-03

*Хөрөнгийн үнэлгээний "Мөнх-Оргил трейд" ХХК*




*Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж. www.msc.mn*

**Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл**

Компаний нийт гаргасан хувьцааны тоо 1 бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 157,874,570 ширхэг байна.

Компаний нийт гаргасан энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшигч хувьцаа эзэмшигчдийн мэдээллийг доорх хүснэгтэд оруулав.

| № | Нэр | Регистр | Хаяг | Хувьцааны тоо, хувь эзэмшил |
|---|---|---|---|---|
| 1 | "Субашид тек" ХХК | 6295541 | Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, Денверийн 4-р давхар | 64.71% 100,710,784 ширхэг |
| 2 | Иргэн Ц. Хүдэрмөнх | ТЯ85080719 | Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 24-р хороо, Энгельсийн гудамж, Алтай хотхоны 18-143 тоот | 5.95% 9,400,000 ширхэг |
| 3 | Иргэн Т.Дэлгээн | | | 5.95% 9,400,000 ширхэг |
| 4 | Иргэн М.Бат-Эрдэнэ | РЭ 76032576 | УБ, Хан уул дүүрэг, 15-р хороо, Кэй эйч, 6Д-105 | 5.95% 9,400,000 ширхэг |
| 5 | Иргэн Г. Дулмаа | УЗ48070209 | УБ, СБ дүүрэг, 5-р хороо, Нарны замын 13/2-1 | 5.85% 9,236,502 ширхэг |

***"Эрдэнэс сольюшинс" ХК-ийн одоогийн бүтэц, зохион байгуулалт байгуулалт***






ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company
2015358



УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК
ТТБ0674 ☏ 5203173

СЗХ 2022 сар 25 өдөр БҮРТГЭВ № 01

MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-03-22 БҮРТГЭВ-03



Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих дээд байгууллага нь төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) байна. Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь 9 гишүүнтэй ба ТУЗ-ийн гишүүдийг 3 жилийн хугацаатай сонгодог байна.

Компаний 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас дараах гишүүд ТУЗ-ийн гишүүдээр сонгогдсон байна.

***"Эрдэнэс сольюшинс" ХК-ний ТУЗ-ийн гишүүд***

| № | Овог, нэр | Албан тушаал |
|---|---|---|
| 1 | Ц.Хүдэрмөнх | ТУЗ-ийн ердийн гишүүн |
| 2 | Т.Золбоо | ТУЗ-ийн ердийн гишүүн |
| 3 | Ц.Хишигбаатар | ТУЗ-ийн ердийн гишүүн |
| 4 | Г.Аззаяа | ТУЗ-ийн ердийн гишүүн |
| 5 | Э.Цэндсүрэн | ТУЗ-ийн ердийн гишүүн |
| 6 | Б.Батхүү | ТУЗ-ийн ердийн гишүүн |
| 7 | Б.Энхзориг | ТУЗ-ийн хараат бус гишүүн |
| 8 | С.Энхжаргал | ТУЗ-ийн хараат бус гишүүн |
| 9 | П.Нарантунгалаг | ТУЗ-ийн хараат бус гишүүн |

**Компаний гүйцэттэх удирдлага**

| Нэр | Боловсрол | Ажлын туршлага |
|---|---|---|
| **Ц.Хүдэрмөнх** | ШУТИС-КТМС-ийг 2007 онд програм хангамжийн бакалавр зэрэгтэйгээр төгссөн. | Хас банкинд систем хөгжүүлэгч, систем дизайнер, системийн шинжээч, системийн ахлах шинжээчээр, төслийн удирдагч, бизнесийн ахлах шинжээчээр 2009-2016 онд, Бодь даатгал ХХК-д системийн шинжээч, цахим банкны хэлтэсийн захиралаар 2016-2018 онд, ISOL ХХК-д мэдээлэлийн технологийн хэлтсийн захиралаар ажиллаж байсан. Эрдэнэс сольюшинс ХХК-ийн Гүйцэтгэх захиралаар 2019 оноос, Эрдэнэс сольюшинс ХК-ийн Гүйцэтгэх захирлаар 2020 оноос хойш өнөөдрийг хүртэл ажиллаж байна. |

**КОМПАНИЙ БҮТЭЦ**






ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК ERDENES SOLUTIONS Joint Stock Company

УЛААНБААТАР ХОТ ГҮҮДСЕК ҮЦК ХХК ТТБ0674 ⚓ 5208173

## КОМПАНИЙН ДОТООД БҮТЭЦ




**4.5. “Эрдэнэс сольюшинс” ХК-ийн хөрөнгө, санхүүгийн байдлын талаарх мэдээлэл, шинжилгээ**

Тус “Эрдэнэс сольюшинс” ХХК-ний 2020, 2021 оны санхүүгийн байдлын талаарх үзүүлэлтүүдийг “аудитлагдсан”санхүүгийн тайлангаас авч доор оруулав.

**“Эрдэнэс сольюшинс” ХК-ийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд**

| Үзүүлэлт | СТГ | 2020.12.31 | 2021.12.31 |
|---|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | | |
| **Эргэлтийн хөрөнгө** | | | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 3 | 17,066,189.35 | 12,752,280.33 |
| Татвар, НДШ-ийн авлага | 4 | | 928,840.46 |
| Бусад авлага | 5 | - | 260,000.00 |
| Бараа, материал | 6 | 24,660,000.00 | 91,055,068.76 |
| Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 7 | 33,575,000.00 | 46,500,000.00 |
| **Эргэлтийн хөрөнгийн дүн** | | **75,301,189.35** | **151,496,189.55** |
| **Эргэлтийн бус хөрөнгө** | | | |
| Үндсэн хөрөнгө | 8 | - | 297,174,210.82 |
| Биет бус хөрөнгө | 9 | 1,528,455,912.09 | 1,528,455,912.09 |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | 10 | 20,060,000.00 | 890,054,745.50 |
| **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | | **1,548,515,912.09** | **2,715,684,868.41** |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | | **1,623,817,101.44** | **2,867,181,057.96** |
| **ӨР, ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | | | |
| **ӨР, ТӨЛБӨР** | | | |
| Богино хугацаат өр, төлбөр | | | |
| Дансны өглөг | 11 | 30,032,388.20 | 159,854,197.16 |
| Цалингийн өглөг | 12 | 21,959,750.00 | - |
| Татвар, НДШ-ийн өр | 13 | 6,413,241.81 | 97,813,934.85 |
| Урьдчилж орсон орлого | 14 | - | 30,000,000.00 |
| Бусад богино хугацаат өр, төлбөр | 15 | 148,427,000.00 | 464,937,804.00 |
| **Богино хугацаат өр, төлбөрийн дүн** | | **206,832,380.01** | **752,605,936.01** |
| **Урт хугацаат өр, төлбөрийн дүн** | | - | - |
| **ӨР, ТӨЛБӨРИЙН ДҮН** | | **206,832,380.01** | **752,605,936.01** |
| **ЭЗДИЙН ӨМЧ** | | | |
| Хувийн өмч | 16 | 1,578,745,700.00 | 1,578,745,700.00 |

2022 он 03 сар 25 өдөр БҮРТГЭВ № 01

2022 -03- 22 БҮРТГЭВ-03



| | | | |
|---|---|---|---|
| Хуримтлагдсан ашиг | 17 | (161,760,978.57) | 535,829,421.95 |
| **ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | | **1,416,984,721.43** | **2,114,575,121.95** |
| **ӨР, ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | | **1,623,817,101.44** | **2,867,181,057.96** |

**"Эрдэнэс сольюшинс" ХК-ний орлогын тайлангийн үзүүлэлтүүд**

| Үзүүлэлт | СТГ | 2020.12.31 | 2021.12.31 |
|---|---|---|---|
| **БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО (ЦЭВЭР)** | 17 | **21,262,623.71** | **869,800,000.00** |
| Борлуулалтын өртөг | | - | - |
| **НИЙТ АШИГ (АЛДАГДАЛ)** | | **21,262,623.71** | **869,800,000.00** |
| Хүүний орлого | 18 | - | 70,255.86 |
| Бусад орлого | 18 | - | 2,000,000.00 |
| | | | **2,070,255.86** |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 19 | 168,644,516.88 | 74,772,958.59 |
| Санхүүгийн зардал | 20 | - | 21,035,326.92 |
| Бусад зардал | 20 | - | 790,000.00 |
| | | **168,644,516.88** | **96,598,285.51** |
| Гадаад валютын ханшийн зөрүүний бодит олз (гарз) | 21 | - | (83,726.33) |
| Гадаад валютын ханшийн зөрүүний бодит бус олз (гарз) | 21 | - | (19.10) |
| | | - | **(83,745.43)** |
| **ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ (АЛДАГДАЛ)** | **22** | | |
| Орлогын татварын зардал | 23 | - | 77,597,824.40 |
| **ТАТВАРЫН ДАРААХЬ АШИГ (АЛДАГДАЛ)** | | **(147,381,893.17)** | **697,590,400.52** |
| Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал) | | | |
| **ТАЙЛАНТ ҮЕИЙН ЦЭВЭР АШИГ (АЛДАГДАЛ)** | **24** | **(147,381,893.17)** | **697,590,400.52** |
| **БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГО** | | | |
| **ОРЛОГЫН НИЙТ ДҮН** | | **(147,381,893.17)** | **697,590,400.52** |

*<u>Тайлбар:</u> "Эрдэнэс сольюшинс" ХХК нь 2020 оно "Хархорин пропертис" ХК-тай нэгтгэж, "Эрдэнэс сольюшинс" ХК болж хэлбэрээ өөрчилсөн тул санхүүгийн үзүүлэлтүүдийн динамик судалгааг нэгдэлтээс хойшхи 2020, 2021 онуудын үзүүлэлтийг хамруулан хийсэн болно.*

**<u>Горзинтал шинжилгээ:</u>** Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө нь 2021 оны тайлангийн үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн дүнтэй харьцуулахад 4.3 сая төгрөгөөр буюу 25.0%-иар, татвар нийгмийн даатгалын шимтгэл 928.0 мян.төгрөгөөр, бараа материалын дүн 66.4 сая төгрөгөөр буюу 269 хувиар, урьдчилж төлсөн зардал 12.9 сая төгрөгөөр буюу 38.0%-иар өссөн үзүүлэлттэй байна. Нийт эргэлтийн хөрөнгө 76.2 сая төгрөгөөр буюу 101.0%-иар өссөн байна. Эргэлтийн хөрөнгийн өсөлтөнд бараа материалын үзүүлэлт голлох нөлөөг үзүүлж байна. Харин эргэлтийн бус хөрөнгө 1.2 тэрбум төгрөгөөр буюу 75.0%-иар өссөн нь урт хугацаат хөрөнгө оруулалт 870.0 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна. Эргэлтийн бус хөрөнгийн биет бус хөрөнгөд өөрчлөлт ороогүй байна. Нийт хөрөнгийн дүн 77.0%-ийн өсөлттэй буюу 1.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Өр төлбөрийн хувьд богино хугацаат өр төлбөр 545.8 сая төгрөгөөр буюу 264.0%-иар өссөн байгаа нь дансны өглөгийн өсөлт мөн татварын өр нэмэгдсэнтэй холбоотой байна. Урт хугацаат өр төлбөргүй байна. Эзэмшигчийн өмчийн дүн 697.6 сая төгрөгөөр буюу 49.0%-иар өссөн байгаа нь хуримтлагдсан ашигтай шууд холбоотой байна.

**<u>Вертикал шинжилгээ:</u>** Нийт хөрөнгийн дунд эргэлтийн хөрөнгө 5.3%-ийг, эргэлтийн бус хөрөнгө 94.7%-ийг эзэлж байна. Эргэлтийн хөрөнгийн дунд 3.2%-ийг бараа материал, 1.6%-ийг урьдчилж төлсөн зардлын дүн, 0.4%-ийг мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө бүрдүүлж байна. Харин **эргэлтийн бус хөрөнгийн 53.3%-ийг биет бус хөрөнгө, 10.4%-ийг үндсэн хөрөнгө**, 0.31%-ийг урт хугацаат хөрөнгө оруулалт бүрдүүлж байна. Өр төлбөр ба эздийн өмчийн дүнгийн 26.2%-ийг нийт өр төлбөр эзэлж байгаагийн 100.0%-ийг богино хугацаат өр төлбөр /урт хугацаат өр төлбөргүй/ бүрдүүлж байна. Өр төлбөр ба эздийн



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК ERDENES SOLUTIONS Joint Stock Company

УЛААНБААТАР ХОТ ГҮҮДСЕК ҮЦК ХХК

2022 оны 03 сарын 25 өдөр БҮРТГЭВ №01

2022-03-22 БҮРТГЭВ-03



өмчийн дүнгийн 73.8%-ийг эздийн өмч эзэлж байна.

Гол санхүүгийн харьцаануудыг тодорхойлсон байдлыг доор оруулав.

"Эрдэнэс сольюшинс" ХК-ийн санхүүгийн гол харьцаанууд

| Үзүүлэлт | 2020.12.31 | 2021.12.31 |
|---|---|---|
| Нийт хувьцаа, ш | 1,578,745,700 | 1,578,745,700 |
| Компаний зах зээлийн үнэлгээ, мян.төг | | 14,208,711.3 |
| **Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд** | | |
| Үндсэн хөрөнгө | - | 297,174,210.82 |
| Биет бус хөрөнгө | 1,528,455,912.09 | 1,528,455,912.09 |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | 20,060,000.00 | 890,054,745.50 |
| НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 1,623,817.1 | 2,867,181.06 |
| Богино хугацаат өр, төлбөрийн дүн | 206,832.38 | 752,605.94 |
| ӨР, ТӨЛБӨРИЙН ДҮН | 206,832.38 | 752,605.94 |
| ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН | 1,416,984.72 | 2,114,575.12 |
| **Орлогын тайлангийн үзүүлэлтүүд** | | |
| ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ (АЛДАГДАЛ) | -147,381.89 | 775,188.22 |
| ТАЙЛАНТ ҮЕИЙН ЦЭВЭР АШИГ (АЛДАГДАЛ) | -147,381.89 | 697,590.40 |
| **Санхүүгийн харьцаанууд** | | |
| Нийт хөрөнгийн өгөөж /ROA/ | -0.09 | 0.24 |
| Хувь нийлүүлсэн хөрөнгийн өгөөж /ROE/ | -0.10 | 0.33 |
| Нийт хөрөнгийн эргэц /ROTA/ | -0.09 | 0.27 |
| Нэгж хувьцааны өгөөж /EPS/ | -0.09 | 0.44 |
| Нийт хөрөнгөнд эзлэх үндсэн хөрөнгийн хувь, % | - | 10.0 |

Дээрх хүснэгтээс харахад 2021 онд тус компаний өгөөжийн үзүүлэлтүүд сайжирсан байна. Нийт хөрөнгийн дүнд үндсэн хөрөнгө 10.0%-ийг эзэлж байгаа нь мэдээллийн технологийн компаниудийн хувьд гол хөрөнгө нь газар, барилга, тоног төхөөрөмж зэрэг биет хөрөнгө харьцангуй бага, компьютерийн программ хангамж, аппликейшн зэрэг биет бус хөрөнгө их жинтэй байдагтай холбоотой юм.

**"Эрдэнэс сольюшинс" ХК-ний хөрөнгийн талаарх мэдээлэл**

Тус "Эрдэнэс сольюшинс" ХК нь өнөөдрийн байдлаар оффис, үйлчилгээний зориулалттай, 130.46 $м^2$ талбай бүхий үл хөдлөх хөрөнгө 1, 2 ш компютерийн программ, 11 нэрийн 55 ш компьютер, дагалдах хэрэгсэл, тавилга, эд хогшил зэрэг хөрөнгөтэй байна.

**Хөрөнгийн өмчлөлийн мэдээлэл**

| Хөрөнгийн нэр | Байршил, төрөл | Тоо, ш | Хөрөнгийн өмчлөлийн гэрчилгээ | Хөрөнгийн өмчлөгч |
|---|---|---|---|---|
| 1. Оффис, үйлчилгээний зориулалттай үл хөдлөх хөрөнгө | ЧД, 2-р хороо, 40, 50-н мянгат /15171/, Бакула Ринбучийн гудамж, 30-р байр, 10-р давхарт | 1 | Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ, № 000836859, Огноо: 2021.06.20 | "Эрдэнэс сольюшинс" ХК |
| 2. Брокерсмн | Компьютерийн программ | 1 | Зохиогчийн эрхийн гэрчилгээ, № 11397 Огноо: 2020.02.17 | "Эрдэнэс сольюшинс" ХК |
| 3. Цахим өгөгдөл цуглуулах, баримт бичигт дүн шинжилгээ хийх, олж авах "D³ARS" систем | Компьютерийн программ | 1 | Зохиогчийн эрхийн гэрчилгээ, № 12311 Огноо: 2020.12.23 | "Эрдэнэс сольюшинс" ХК |

**Хөдлөх хөрөнгийн жагсаалт**

| № | Хөрөнгийн нэр | Нэг бүрийн үнэ, төг | Тоо, ш | Нийт үнэ, төг |
|---|---|---|---|---|
| 1 | Asus Монитор | 650,000.0 | 12 | 7,800,000.0 |



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК ERDENES SOLUTIONS Joint Stock Company



УЛААНБААТАР ХОТ ГҮЙДСЕК ҮЦК ХХК

2022 08 сар 25 өдөр БҮРТГЭВ № 01

2022-03-22 БҮРТГЭВ-03



| | | | | |
|---|---|---|---|---|
| 2 | MagicRefiner Keyboard Mouse | 80,000.0 | 6 | 480,000.0 |
| 3 | Lenovo Keyboar Mouse | 50,000.0 | 6 | 300,000.0 |
| 4 | DELL PowerEdge R720 | 1,800,000.0 | 3 | 5,400,000.0 |
| 5 | Ширээ | 400,000.0 | 2 | 800,000.0 |
| 6 | Ширээ жижиг | 200,000.0 | 6 | 1,200,000.0 |
| 7 | Сандал | 90,000.0 | 12 | 1,080,000.0 |
| 8 | Дугуй ширээ | 600,000.0 | 1 | 600,000.0 |
| 9 | Бор енгийн ширээ | 200,000.0 | 4 | 800,000.0 |
| 10 | Шилэн самбар | 100,000.0 | 2 | 200,000.0 |
| 11 | Olleh Router | 250,000.0 | 1 | 250,000.0 |
| - | Дүн | - | 55 | 18,910,000.0 |

**4.6. "Эрдэнэс Сольюшинс" ХХК-ний Бизнес төлөвлөгөө, түүний шинжилгээ**

Тус "Эрдэнэс сольюшинс" ХК-ний боловсруулсан, компаний үйл ажиллагааны 2022-2025 оны "Бизнес төлөвлөгөө"-нөөс гол, гол мэдээллийг доор оруулав.

"Эрдэнэс Сольюшинс" ХК нь өөрийн хөгжүүлсэн програм хангамжуудыг дотоод, гадаадын зах зээл дээр борлуулах, компаниудын захиалагаар тэдэнд төрөл бүрийн програм хангамж нийлүүлэх, хөгжүүлэхээр төлөвлөж, бизнес телвлөгөө болон санхүүгийн төсөөллөө боловсруулсан байна.

**<u>Компаний бүтээгдэхүүн, үйлчилгээ</u>**

***<u>D³ARS систем</u>***

Энэ систем нь **цахим өгөгдөл цуглуулах, баримт бичигт дүн шинжилгээ хийх, олж авах буюу** англиар **the Digital Data Disclosure, Analysis and Retrieval System болон the Digital Data Gathering, Analysis, and Retrieval System** гэх үгнүүдийн эхний үсгүүдийн нийлбэрээр **"D³ARS"** гэж нэрлэгдсэн, хувьцаат компани, хөрөнгө оруулалтын сангууд болон койн гаргагч эрх бүхий этгээдүүдийн нийтэд мэдээлэх үүрэг бүхий мэдээллийг мэдүүлэх үндсэн чиг үүрэг, зорилго, зориулалт бүхий программ бөгөөд **D³ARS** системийг тус компани нь 2019 оноос хойш хөгжүүлж дуусгаад байна. **D³ARS** систем нь мэдээлэх үүрэг бүхий этгээдүүдийн тухай бүр мэдүүлж буй мэдээллийг огноо болон цагаар бүртгэж, мэдүүлсэн мэдээллийг мэдээллийн санд цуглуулан, цугларсан мэдээллийг интернэтээр дамжуулан олон нийтэд чөлөөтэй хүргэх боломжтой систем юм. Тухайлбал Монголын хөрөнгийн бирж болон бусад санхүү, бараа таваарын арилжааны биржид оролцогч олон нийтийн компаниуд, бусад үнэт цаас гаргагчид болон оролцогч байгууллагууд хууль, төрийн эрх бүхий байгууллагын журмаар шаардсан мэдээллийг /дата өгөгдөл/ мэдүүлэг гаргах замаар заавал бүрдүүлэх, мэдээллийг тогтсон маягтын дагуу системд оруулах замаар цуглуулж, баталгаажуулах, индексжүүлэх, хүлээн авах, дамжуулах, хайх ажлыг энэ систем гүйцэтгэнэ.

**D³ARS** системийн өгөгдлийн санги

йн хөгжүүлэлт банк болон санхүүгийн байгууллагуудын ашиглаж эхлээгүй байгаа **"Oracle 21c version"** дээр хөгжүүлэгдсэн тул блокчэйнтэй технологи ашиглах, өгөгдлийн тандалт хийх боломжтой, веб технологид суурилсан тул олон нийтэд мэдээлэх болон хэрэглэгчийн олон ялгаатай эрхээр хандах боломжийг бүрдүүлсэн, бусад системтэй холбогдох API-тай тул төрийн болон хувийн хэвшлийн системүүдтэй мэдээлэл солилцох бүрэн боломжтой, **XBRL** ашигладаг тул олон улсын бизнесийн мэдээлэл солилцох стандарттай олон хэлээр нийтлэгдэх боломжтой бөгөөд компани одоогоор Хувьцаа эзэмшигчдийн болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг хуульд нийцэж буй эсэхийг хянах хиймэл оюун ухаан дээр ажиллаж байна.

**D³ARS** систем нь АНУ-д EDGAR of the US Form 8-K, Form 10-K, Form 10-Q, Form S-1, Канадад Sedar, Англид <u>Companies House</u>, Япон улсад EDINET, БНСУ-д DART зэрэг систем /мэдүүлсэн үнэт цаас гаргагчдын мэдүүлгийг **/Filing/** хөрөнгө оруулагчид ашиглан хөрөнгө



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК ERDENES SOLUTIONS Joint Stock Company



УЛААНБААТАР ХОТ ГҮҮДСЕК ҮЦК ХХК ТТБ6674 рд. 5203173

2022 .05р 25 өдөр
БҮРТГЭВ

2022 -03- 22
БҮРТГЭВ-03



оруулах эсэх шийдвэрээ гаргадаг/-тэй ижил түвшинтэй, ижил хэмжээнд хөгжүүлсэн систем юм.

**D³ARS системийн хийж гүйцэтгэх ажлууд:**

Хувьцаат компаниудын хувьцаагаа халааслах, сонирхолын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийх, эцсийн өмчлөгчийн мэдүүлэг, үнэ ханшид нөлөөлөхүйц мэдээлэл, эрх бүхий албан тушаалтануудын хамаарал, эзэмшил, Хорооны хяналт тавих зэрэг нийт 32 мэдүүлгээр компаниудыг мэдээллийг ил болгоно. Тухайлбал:

- Компанийн хувьцаа эзэмшигчдэд хагас жилийн болон жилийн эцсийн санхүүгийн тайлангуудыг тайлагнах;
- Компанийн хувьцаа эзэмшигчдэд компанийн үйл ажиллагааны тайлангуудыг тайлагнах;
- Компанийн сонирхолын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэлүүдийг тайлагнах;
- Компанийн 5 хувиас дээш болон хяналтын хувьцааг эзэмшигчдийг тайлагнах;
- Үнэт цаас гаргагчаас тухай бүр мэдээлэх мэдээлэл гэдэгт хувьцаа эзэмшигч болон хөрөнгө оруулагчаас шийдвэр гаргахад шаардлагатай компанийн бизнесийн болон санхүүгийн үйл ажиллагаанд бий болсон ажил хэрэг, үйл ажиллагаатай холбоотой цогц мэдээллүүдийг тайлагнах;
- Компанийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, бизнест шууд нөлөө үзүүлэхүйц гэрээ, хэлцэл байгуулах, нэмэлт өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, дуусгавар болгох, татгалзах, гэрээний хугацаа дууссантай холбоотой мэдээллийг олон нийтэд мэдээлэх бөгөөд мэдээлэлд гэрээг байгуулсан огноо, гэрээний нөхцөл, гэрээнд оролцогч талуудын эрх үүрэг, гэрээний нэг талд түүний охин хараат компани оролцсон эсэх талаарх мэдээллийг тайлагнах;
- Шүүх, прокурор, төрийн эрх бүхий байгууллагаас үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан, түүний хараат, охин компанийг хариуцагчаар татаж, захиргааны болон эрүүгийн хэрэг үүсгэсэн, шүүхээс дампуурлын тухай хууль тогтоомжийн дагуу эрх хүлээн авагч томилогдсон талаарх мэдээллийг тайлагнах;
- Үнэт цаас гаргагч нийт активын 25 хувь ба түүнээс дээш хэмжээтэй тэнцэх үл хөдлөх хөрөнгийгбусдад шилжүүлэх, барьцаалсан эсхүл бусад компанийн хяналтын багц худалдан авсан талаарх мэдээлэл, холбогдох гэрээ, хэлцэлийг тайлагнах;
- Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдлын гадуурх бүртгэлтэй холбоотой санхүүгийн болон санхүүгийн бус эрх үүрэг бий болгосон гэрээ, хэлцэл, гүйлгээтэй холбоотой мэдээллийг мэдээлэх бөгөөд мэдээлэлд гэрээ, хэлцлийн хугацаа, үнийн дүн, төлбөрийн нөхцөл, гүйлгээний товч утга, богино болон урт хугацаат түрээсийн гэрээнээс бий болсон эрх үүрэг, төлбөр түргэн гүйцэтгэх чадвартай холбоотой мэдээлэл Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь үүрэгт ажлаас чөлөөлөгдсөн, гарсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд тухайн ажиллаж байсан компанийн хувьцааг бирж болон биржийн бус зах зээл дээр худалдах, худалдан авахыг хориглосон арга хэмжээ болон үүнтэй холбогдуулан компанийн төлөөлөн удирдах зөвлөлөөс гарсан шийдвэрийг тайлагнах;
- Компани хувьцаа болон бондыг олон нийтэд гаргаж буй үнэт цаасны танилцуулга зэргийг тодорхой маягтын дагуу харуулах.
- Хөрөнгө оруулагчид Мэдээллийн сангийн хайлтыг компанийн нэр, салбарын бүлэг, баримт бичгийн төрөл эсвэл гаргасан огноогоор хайж болох боломжтой.

**D³ARS системийн ач холбогдол**



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company

40
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК
ТТБ8674 ☎ 5208173

Олон тооны компанийн мэдүүлгийг багтаасан D3ARS систем нь хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, нийтэд мэдүүлэх үүрэг бүхий мэдээллийн төрлийг нэмэгдүүлж, мэдээлэл хүргэх процессийг хялбаршуулж, олон нийтэд түргэн шуурхай хүргэх боломжийг бий болгон, үнэт цаасны зах зээлийн үр ашиг, ил тод байдал, компаниудын шударга байдлыг нэмэгдүүлэх замаар хөрөнгө оруулагчид, компаниуд болон Монгол улсын эдийн засагт үр өгөөжөө өгнө.

Нээлттэй компаниуд санхүүгийн болон бусад чухал мэдээллүүдийг тогтмол, цаг тухайд нь үнэн зөв, бүрэн гүйцэд гаргаж байх ёстой бөгөөд хөрөнгө оруулалтын сан, хөрөнгийн менежерүүд, хөрөнгө оруулалтын мэргэжилтнүүд болон бусад зах зээлд оролцогчдоос мэдлэг, мэдээлэлтэй байдлаар хэзээ, ямар компанид хөрөнгө оруулах болон хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад энэ систем ихээхэн ач холбогдолтой.

Түүнчлэн Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, буруутай этгээдэд хариуцлага тооцох, цаашдын буруутай үйлдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хөрөнгө оруулагчдыг хамгаалахад системийн ач холбогдол өндөр юм.

***Брокерсмн систем***

Энэхүү системийн гол зорилго нь хөрөнгийн зах зээлд оролцогч брокерийн компаниуд, тэдгээрийн харилцагчдад үнэт цаасны арилжааны эскроу данс нээхэд иргэд өөрийн биетээр цаг хугацаа, зардал гаргалгүйгээр данс нээх, үнэт цаасны арилжаанд оролцох, брокерийн компаниуд харилцагчиддаа чанартай хурдан, 24/7 үйлчилгээ үзүүлэхэд оршино.

Арилжаа хийх "Брокерсмн" систем нь ямар нэгэн бүтээгдхүүний арилжааны бирж болон хөрөнгийн бирж дээр иргэн, аж ахуйн нэгж оролцож арилжаа хийх, брокерийн болон банк санхүүгийн байгууллагуудын харилцагчдын бүртгэл үүсгэх, хөтлөх, харилцагчийн харилцах дансны бүртгэл хөтлөх, үнэт цаасны төлбөр тооцоо хийх, хувьцааны бүртгэл хийх, хөтлөх цогц систем юм.

Энэ систем нь дараах үндсэн хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

1. Брокерийн үндсэн модул - Brokers Core Module
2. Хувьцааны болон Валютын Арилжаа хийх платформ – Stock/FX Trading Platform
3. Харилцагчийн бүртгэл – Customers Registration
4. Харилцагч арилжаа хийсэн болон нээлттэй байгаа арилжаагаа харах, хийгдсэн хэлцэлүүдээ харах, түүнтэй холбоотой ашиг алдагдалаа харах, тооцоолох – Open Position & Profit / Loss & Historical Reports
5. Харилцагч өөрийн дансны мөнгөн хөрөнгийн гүйлгээнүүдээ хянах, дансаа зузаатгах болон мөнгө татаж авах – Customer Account, Money Deposit & Withdrawal
6. Арилжааны арын алба – Back Office
7. Арилжааны дундын алба – Middle Office
8. Хувьцааны үүсмэл хэрэгслийн арилжаа – CFD & Margin Trade
9. Санхүүгийн бүртгэл болон тайлан – Financial Module & Reports
10. Харилцагч үнэт цаасны төлбөр тооцоо гүйцэтгэгч арилжааны банкинд үнэт цаасны төлбөр тооцоо гүйцэтгэх эскроу данс нээх хүсэлт илгээх - Open Escrow Account at Commercial Banks
11. Брокер харилцагчийн дансыг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд дансыг нь үүсгэх- Create Customer Account at Mongolian Central Securities Depository

Системийн дээр дурьдсан хэсгүүдийг тайлбарлавал:

Брокерийн үндсэн модул нь:

- нягтлан бодох бүртгэлийн ерөнхий дэвтэр;

- харилцагчийн бүртгэл хөтлөх модул;
- арилжааны бүртгэл хөтлөх модул;
- дансны бүртгэл хөтлөх модул;
- төлбөр тооцооны бүртгэл зэрэг үндсэн модулаас бүрдэнэ.

Арилжаа хийх платформ нь вэб суурьтай бөгөөд харилцагч веб болон мобайл апп IOS, Андройд үйлдлийн систем ашиглан арилжаанд оролцох боломжийг олгоно.

Харилцагчийн бүртгэл нь системд бүртгэлтэй брокерийн компаниас сонголт хийн харилцагч болох хүсэлтийг алсын зайнаас бүртгүүлж дараах үйлчилгээг харилцагч хүлээн авна:

- Харилцагч брокерийн болон банк бус санхүүгийн байгууллагын компанид данс нээх хүсэлт илгээх;
- Арилжааны бүтээгдэхүүний үнэ ханш харах;
- Арилжааны бүтээгдхүүнтэй холбоотой зах зээлийн мэдээлэл авах;
- Харилцагч арилжааны бүтээгдхүүнтэй холбоотой хийсэн хэлцэлүүд, дансны гүйлгээнүүдээ харах;
- Харилцагчийн тухайн мөчид худалдан авсан эсхүл худалдсан арилжааны бүтээгдхүүний хэлцэлийг харах, зах зээлийн ханштай харьцуулсан ашиг, алдагдалаа харах;
- Дансны мөнгөн гүйлгээнүүдээ харах;
- Харилцагч дансаа зузаатгах, мөнгө татан авах үйлчилгээ авах.

Харилцагч арилжаа хийсэн болон нээлттэй байгаа арилжаа, хийгдсэн хэлцэлүүд, түүнтэй холбоотой ашиг алдагдалаа харах, тооцоолох нь харилцагч тухайн үед худалдан авсан болон худалдсан арилжааны бүтээгдхүүнээ тухайн мөчид зах зээлийн ханштай харьцуулж ашиг, алдагдалаа хянах, өмнө нь хийсэн арилжааны хэлцэлүүд, тэдгээрээс бий болсон ашиг алдагдалаа харах боломжийг олгоно.

Харилцагч өөрийн дансны мөнгөн хөрөнгийн гүйлгээнүүд, мөнгөний үлдэгдлээ хянах, хэзээ дансандаа мөнгө хийж, татаж байсан гүйлгээнүүд, одоо байгаа мөнгөний үлдэгдэлээ харах, дансандаа хэрхэн мөнгө зузаатгах, татаж авах шийдвэр гаргахад туслана.

Арилжааны арын алба нь брокерийн компанийн харилцагчдын хийсэн арилжааны хэлцэлүүдийг баталгаажуулах, хийгдсэн арилжааны гүйлгээнүүдийг автоматаар хийнэ.

Арилжааны дундын алба нь брокерийн компанийн харилцагчдийн зээлжих зэрэглэл /Credit Rating/, рейтингийг тогтоох, тэдгээрт VAR-Value at Risk арга ашиглах, харилцагчдын арилжаанд стоп лосс, лимит зэргийг тооцоолно.

Хувьцааны үүсмэл хэрэгсэл арилжаа нь харилцагчдад үүсмэл хэрэгсэл /жиш хувьцаа г.мэт/ болох бүтээгдэхүүнүүдийг зээлээр олгож арилжаанд оролцох боломжийг олгоно.

Санхүүгийн бүртгэл болон тайлан нь брокерийн компанийн санхүүгийн тайлан, орлогын тайлан, мөнгөн урсгалын тайлан зэргийг тухайн өндөрлөх үед гаргаж холбогдох тайлан мэдээлэлийг боловсруулж гаргана.

Харилцагч үнэт цаасны төлбөр тооцоо гүйцэтгэгч арилжааны банкинд үнэт цаасны төлбөр тооцоо хийх эскроу данс нээх хүсэлт илгээх нь зарим бүтээгдэхүүн тухайлбал үнэт цаасны компанийн брокерийн болон банк санхүүгийн байгууллагын харилцагчдын дансыг арилжааны банкуудад хүсэлт хэлбэрээр илгээн нээх боломжийг олгоно.

Брокер, банк санхүүгийн байгууллагын харилцагчийн дансыг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд үүсгэх нь зарим бүтээгдхүүний арилжаа хийдэг брокерийн компани турхайлбал үнэт цаасны брокерийн компанийн харилцагчдын дансыг үнэт цаасны төвлөрсөн хадагламжийн төвд шууд илгээх боломжийг олгоно.

**Банк бус санхүүгийн байгууллагын бүртгэлийн систем**

Энэ систем нь Банк бус санхүүгийн байгууллагын суурь бүртгэлийн ерөнхий дэвтэр, харилцагчийн бүртгэл хөтлөх, тайлан мэдээ, санхүүгийн тайлан гаргах, онлайн горимд зээл

олгох зэрэг бусад хэрэгцээт модулыг агуулсан систем юм.

**Бусад хөгжүүлж буй болон хөгжүүлэхээр төлөвлөж буй бүтээгдэхүүнүүд**
**Зочид буудлын бүртгэлийн систем**
Захиалга хүлээн авах, бүртгэх процестой, буудлын өрөө, үйлчилгээний төрлүүдийг ангилсан үндсэн үнэ болон хямдралтай үнийн зохицуулалт хийх, захиалгын төлөвлөгөө, хуваарийг хүссэнээрээ зохион байгуулах боломжтой үр дүн, тайлан болон анализ шинжилгээ хийх боломжтой систем юм.

**Системүүдийг хөгжүүлж дуусахаар төлөвлөж байгаа хугацаа**

| № | Хөгжүүлж буй систем | Зах зээлд нэвтрүүлэх хугацаа | Хэнд |
|---|---|---|---|
| 1 | Үнэт цаасны арилжааны платформ | 2022-IY | Үнэт цаасны компаниуд |
| 2 | Банк бус санхүүгийн байгууллагын систем | 2022-I | Эйс ассошиэйтс ББСБ болон бусад ББСБ-д |
| 3 | Зээлийн оноо олгох & Онлайн байдлаар зээл олгох модуль | 2022-II | Эйс ассошиэйтс ББСБ-д |
| 4 | Гадаад валютын арилжааны платформ | 2022-IY | Эрдэнэс капитал маркетс ХХК-д |
| 5 | Үнэт металлын арилжааны платформ | 2022-IY | Эрдэнэс коммодитиес трейдинг ХХК-д |
| 6 | Үл хөдлөх хөрөнгө зуучлалын систем | 2022-IY | Эрдэнэс риел эстейт ХХК-д |

**Зах зээлийн судалгаа, сегментчлэл**

*Нийтэд мэдүүлэх үүрэг бүхий мэдээлэл*

Монгол улс 3.3 сая хүн амтайгаас үнэт цаасны 2 бирж үйл ажиллагаа эрхэлж байна. Монголын хөрөнгийн биржийн хувьцааны арилжаанд 2021 онд нийт 68’000 хүн оролцсон байна.

Хөрөнгийн биржийн болон биржийн бус зах зээл, койны зах зээл дээр мэдээлэл нилээд дутмаг байгаагаас хөрөнгө оруулагчид мэдээлэлийг компаниас эсвэл Монголын хөрөнгийн биржийн сайтнаас авч байна.

*Үнэт цаасны зах зээл дээрх хэрэглэгчдийн зах зээл*

Үнэт цаасны зах зээлд оролцогчтой холбоотой зах зээлийн мэдээллийг тайлангийн 4.3-т оруулсан болно.

*Маркетингийн бодлого*

Цаашид компани нь зөвхөн эхний хэрэглэгч гэлгүй бүх хэрэглэгчдэдээ идэвхтэй маркетингийн бодлого баримтлан ажиллаж илүү өсөлтөд хүрэхээр төлөвлөж байна. Үүний тулд:

- Компанийн өөрийн нэрийн болон бусад бүтээгдэхүүнийг багтаасан апп гаргах:
    - Хэрэглэгчдэд зориулсан Хямд болон бусад компанийн бүтээгдэхүүнийг багтаасан байх.
- Технологийн Компанийн давуу талыг ашиглах
    - Өдөрт хэрэглэгч үйлчилгээний АПП руу хандаж ямар нэгэн үйлдэл хийдэг. Эдгээр хэрэглэгчдэд зориулсан смарт мэдэгдлийн үйлчилгээг нэвтрүүлэх,
    - CSE (Customer Self Enroll) буюу хэрэглэгч өөрөө өөрийгөө бүртгүүлээд шууд ашигладаг болох. Борлуулалтын сувгийг технологийн давуу талыг ашиглан өргөтгөх.
- Үнэ цэнэтэй хэрэглэгчид чиглэсэн ажил хийх. Үнэ цэнэтэй хэрэглэгчээр дамжуулан шинэ хэрэглэгч татах

он 2022 сар 25 өдөр
БҮРТГЭВ
№ 01
2022 -03- 22
БҮРТГЭВ-03



- Компанийн үйлчилгээний үнэ цэнэтэй буюу сард 100 болон түүнээс дээш гүйлгээ хийдэг өндөр хэрэглээтэй хэрэглэгчдийн хүсэл сонирхолд нийцсэн шинэ боломжуудыг нэвтрүүлнэ.

**Зах зээлийн зорилтот сегментэд хүрэх стратеги**

Компанийн санал болгож буй бүтээгдхүүнүүд нь бүтээгдэхүүнийг хэрэглэж байгаа компаниуд болон тэдгээрийн хэрэглэгч, харилцагчдад ашиглахад хялбар, найдвартай, боловсон хүчний зардлыг хэмнэсэн, байж болох бүх зүйлийг програмчилсан, бүхий л системд холбогдож болохуйц, хямд, сүүлийн үеийн технологи бүхий систем, програм хангамжаар хангах явдал юм. Ингэснээр програм хангамжууд нь гацах, удах, шаардлага хангахгүй байх зэрэг асуудлуудтай тулгарч байгаа компаниуд, хэрэглэгчдийг өөртэй татаж бүтээгдэхүүн хэрэглэгчдийн тоогоо өсгөх зорилт тавьж байна.

**Зорилтот зах зээл**

Компани зах зээл дээр бүтээгдхүүнээ борлуулахдаа гадаад болон дотоод зах зээл дээр гэсэн 2 зах зээл дээр борлуулахаар төлөвлөж байна. Аль ч зах зээл дээр нэмж захиалгат ажил нэмж авахаар төлөвлөж байна. Зах зээлийн хувьд аль ч зах зээл дээр програм хангамж хийлгэх эрэлт хангалттай байна.

**Гадаад зах зээл**

Компани гадаад зах зээл дээр бүтээгдэхүүнээ 2023 оноос нэвтрүүхээр төлөвлөж байгаа бөгөөд 2022 онд бэлтгэл хангах үүднээс АНУ-ын Делавер мужид охин компани болон Сингапур улсад төлөөлөгчийн газар нээхээр төлөвлөж байна.




Гадаад зах зээл харьцангуй том бөгөөд хангалттай зах зээлтэй болно. Компани 2022 онд зочид буудлын, сууц өмчлөгчдийн, цаг захиалгын, гишүүнчлэлийн систем програм хангамжуудыг хөгжүүлж Монголын зах зээлд туршиж дуусгасанаар гадаад зах зээл дээр нэвтрүүлэхэд бэлэн болно. Компани гадаад зах зээлийг АНУ, Сингапур, Японы зах зээлд бүтээгдэхүүн гаргахаар төлөвлөж байгаа бөгөөд эдгээр зах зээлээс мобайл апп, веб сайтын програм хангамжийн захиалгыг аутсоурсинг хэлбэрээр авахаар төлөвлөж байна.

**Дотоод зах зээл**

**Дарс систем**-ээр хувьцаат компани, нээлттэй хөрөнгө оруулалтын сангууд, койн гаргагчид нийтэд мэдүүлэх үүрэгтэй мэдээллийг заавал "Үнэт цаасны зах зээлийн тухай" хууль болон холбогдох журамд нийцүүлэн мэдүүлэх тул хөрөнгө оруулагчид, зах зээлийн шинжээчид, эдийн засгийн ангийн оюутанууд өргөн ашиглана гэж тооцоолж байна.

Хөрөнгийн зах зээл дээр 2021 онд нийт 68'000 хүн оролцсон тул энэ зах зээлээс 2022 онд 1'000 гаруй хэрэглэгчидэд, 2025 он гэхэд 9'000 гаруй хэрэглэгчдэд бүтээгдэхүүнийг хүргэхээр зорилт тавин төлөвлөж байна.



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК

2022 .05 сар 25 өдөр
БҮРТГЭВ
№ 01
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -03- 22
БҮРТГЭВ-03



**Брокерсмн систем-**нийт хөрөнгийн зах зээлд 55 гаруй үнэт цаасны компаниуд байгаа болович өнөөдрийг хүртэл шаардлага хангасан иж бүрэн нэг ч програм хангамж байхгүй байгаа бөгөөд хэдийгээр хөрөнгийн зах зээлд 2021 онд 68'000 хүн оролцсон болович энэ too компаныг хөгжүүлж буй програм хангамжийн ачаар 120'000 хэрэглэгчлдэд хүргэх боломжтойгоор төлөвлөж байна. Энэ системийн борлуултын орлогыг бизнес төлөвлөгөөнд тусгаагүй болно.

**Банк бус санхүүгийн байгууллагын ашиглах бүртгэлийн систем-**нийт зах зээл дээр 600 гаруй банк бус санхүүгийн байгууллага байгаагаас мэдэгдэж байгаагаар 200 гаруй банк бус санхүүгийн байгууллага огт програм хангамжгүй байгаа бөгөөд 100 гаруй компанийн ашиглаж буй програм хангамж нь бүрэн ашиглах боломжгүй хөгжүүлсэн компаниуд цаашид хөгжүүлэхээ больсон байна. Бусад компаниудын талаар мэдээлэл хомс байгаа бөгөөд Лендмн, Инвескор, Ард кредит, зэрэг цөөхөн компаниуд өөрсдийн хөгжүүлсэн програм хангамжийг ашиглаж байна.
Компанийн хөгжүүлсэн банк бус санхүүгийн байгууллагын бүртгэлийн системийг 2022 онд 20 хүртэл, 2025 он гэхэд 50 банк бус санхүүгийн байгууллагад лиценз ашиглах замаар борлуулахаар төлөвлөж байна.Одоогоор 10 гаруй банк бус санхүүгийн байгууллагууд ашиглах сонирхолтойгоо илэрхийлсэн болно.

## САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨЛТ

**Санхүүжилт**

Компанийн тухайн жилийн үйл ажиллагааны зардлыг төлөөд бэлэн мөнгөний нөөц хангалттай байхаар төсөвлөгдсөн болно. Энэ Компани энэ бизнес төлөвлөгөөнд тусгагдаагүй шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх боломжийг бий болгож байна.

Компанийн програм хангамж зах зээлд борлогдож эхлэх үе буюу 2022 онд Компани хөрөнгийн биржид компанийн 8-10 хувийг олон нийтэд нэг ширхэг энгийн хувьцаа бүрийн үнийг 115-130 төгрөгөөр нийт 1.5-2.5 тэрбум төгрөг татан төвлөрүүлэх замаар хөрөнгө оруулалт татан үүний 1.7 тэрбум төгрөгийг Эйс ассошиэйтс ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэн зээлийн үйл ажиллагаа эрхлэхээр төлөвлөж байна. Татан төвлөршүүлсэн хөрөнгийн 1.7 тэрбум төгрөгөөс давсан хөрөнгийг онлайн худалдааны компанид хөрөнгө оруулах замаар төлөвлөж байна.

**Хөрөнгө оруулалт**

Компанийн үйл ажиллагаанд тавилга, компьютер, оффисын түрээс, цалин хөлс, интернэт болон сервер ашиглалтын болон бусад үйл ажиллагааны зардал гарна.

**Үл хөдлөх хөрөнгө ба тоног төхөөрөмж.** Компанийн үл хөдлөх хөрөнгийг ажилтануудын орон тоо нэмэгдүүлэхтэй хобоотойгоор 2022 оноос эхлэн жилд 300 сая төгрөгөөр нэмэгдүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд 2024 оноос эхлэн 400 сая төгрөгөөр нэмэгдүүлж 2025 оны эцэс гэхэд 1.6 тэрбум төгрөгт хүргэхээр төлөвлөж байна.

**Зардал**

Компанийн үйл ажиллагаанд хүний нөөцийн, элэгдлийн, сургалтын гэсэн 3 том зардал гарч байгаа бөгөөд 2022 оны хувьд нэмж хувьцаа гарахтай хобоотойгоор 287 сая төгрөгийн зарал гарахаар төсөвлөгдсөн.

**Хүний нөөцийн зардал.** Компани 2025 он гэхэд нийт 25-30 хүнтэйгээр үйл ажиллгаа эрхлэхээр төлөвлөж байгаа бөгөөд 2022 оноос эхлэн Гүйцэтгэх захирал орон тоон дээр нэмж Үйл ажиллагаа эрхэлсэн захирал, Санхүү эрхэлсэн захирал, 10 програмистууд гэсэн орон тоотоогоор үйл ажиллагаа эрхлэхээр төлөвлөж прогамистуудын тоог 2025 он гэхэд 25 орон тоотойгоор үйл ажилагаа эрхлэхээр төлөвлөсөн. Хүний нөөцийн зардлыг он тус бүрээр харуулбал:

/Сая.төг/

| он | 2022 | 2023 | 2024 | 2025 |
|---|---|---|---|---|
| Хүний нөөцийн зардал | 517,6 | 710,9 | 918,4 | 1,098,8 |



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company
УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК
ТТБ8674 РД 6208173

СЗХ 2022 .05. 25 бдэр БҮРТГЭВ

MONGOLIAN STOCK EXCHANGE 2022 -03- 22 БҮРТГЭВ-03



Цалингийн өсөлтийг жил бүрийн инфляцитай уялдуулж 8 хувьд байхаар төсөвлөсөн. Энэ зардалыг олон улсын нягтлан бодох бүртгэлийн дагуу бүтээгдэхүүн хөгжүүлэх шууд хөдөлмөрийн зардал тул бүтээгдэхүүн болгон актив хөрөнгөд бүртгэсэн.

**Сургалтын зардал.** Компани сургалтын зардалд гадаад дотоод зардалд 2022 оноос эхлэн 42.7 сая төгрөг 2025 он гэхэд 54 сая төгрөг зарцуулахаар төсөвлөж байна.

**Сервер, интернэт, үүлэн тоцоололын зардал.** Компани 2022-2025 онд жилийн турш ашиглах интернэт ашиглах, сервер түрээслэх, үүлэн тооцололын зардалд 39.6 сая төгрөг зарцуулахаар төсөвлөж байна. Энэ зардлыг технологийн хөгжилтэй холбоотойгоор өсөхгүйгээр тооцоолж байна.

**Борлуулалтын таамаглал**
Борлуулалтын таамаглалыг 4-н жилээр хийж хүснэгтэд харуулав.

Компаний борлуулалтын орлого нь 4 зүйлийн борлуулалтын орлогоос бүрдүүлнэ:

- Өөрийн хөгжүүлсэн бүтээгдэхүүний орлогоос
- Охин компаниудын ноогдол ашигаас
- Захиалгаар хийсэн програм хангамжийн орлогоос
- Захиалгаар хийсэн програм хангамжийн жил тутмын үйлчилгээний орлогоос

Орлогоо дотоод болон гадаад зах зээлээс олохоор төлөвлөсөн.

Орлогыг нэгтгэж харуулбал дараах байдалтай байна. Нийт орлого 2022 онд 2,2 тэрбум төгрөг олох, 2025 онд 10.3 тэрбум төгрөг олохоор төлөвлөж байна. Энэ нь өөрсдийн бүтээгдэхүүнийг дотоодод хөгжүүлж бэлэн болсоны дараа гадаад зах зээл дээр худалдахаар төлөвлөж байгаатай холбоотойгоос гадна гадаад зах зээл дээр програм хангамжийн үнэлгээ дотоод зах зээл дээрээс илүү үнэтэй байдагтай холбоотой. Гадаад зах зээлийг АНУ, Сингапур, Япон улсын зах зээлээр төлөөлүүлж байгаа бөгөөд тухайн улсын програм хангамжтай чанар ижил, илүү хэд дахин хямд бүтээгдэхүүн, програм хангамжийг санал болгохоор төлөвлөж байна. 2022 онд нийт орлогод эзлэх өөрсдийн бүтээгдэхүүн 39,3 хувь, охин компанийн ноогдол ашиг 21,6 хувь, захиалгат ажил, үйлчилгээ 31,2 хувь, програм хангамжийн жил тутмын төлбөр 7,9 хувь байхааар байгаа бол 2025 он гэхэд өөрсдийн бүтээгдэхүүнээс олох орлого нийт орлогын 30 хувь, охин компаниудын ноогдол ашиг 44 хувь, захиалгат ажил, үйлчилгээнээс 23 хувь, програм хангамжийн жил тутмын төлбөрт үйлчилгээнээс 3% олохоор төлөвлөж байна.

| № | Үзүүлэлтүүд | 2020 аудитид | 2021 аудитид | 2022 | 2023 | 2024 | 2025 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | **Орлого** | **21,262,624** | **871,870,256** | **2,213,400,000** | **4,839,918,779** | **7,840,746,767** | **10,358,181,220** |
| 2 | Өөрсдийн бүтээгдэхүүнээс | | 0 | 870,000,000 | 1,515,000,000 | 2,400,000,000 | 3,150,000,000 |
| 3 | Охин компаниудын ноогдол ашиг | | 0 | 478,050,000 | 2,425,788,779 | 3,772,322,267 | 4,570,526,720 |
| 4 | Програм хангамжийн жил тутмын төлбөр | | 0 | 175,350,000 | 148,500,000 | 157,594,500 | 271,624,500 |
| 5 | Захиалгат ажил үйлчилгээнээс | 21,262,624 | 869,800,000 | 690,000,000 | 750,630,000 | 1,510,830,000 | 2,366,030,000 |
| 6 | Бусад орлого | | 2,070,256 | | | | |

Гадаад зах зээл дээр Мобайл апп захиалгыг 10 мянган ам доллараар, Вэб сайтын захиалгыг 5 мянган ам доллараар, зочид буудлын захилагат програм хангамжийг 20 мянган ам доллараар, Сууц өмчлөгчдийн програм хангамжийг 15 мянган ам доллараар зарахаар төлөвлөж байгаа бөгөөд 2025 он гэхэд компанийн тухайн улсад байгуулсан охин компани, төлөөлөгчийн газраар дамжуулан АНУ, Сингапурын зах зээл дээр тус бүр 5 програм хангамжийг Япон улсын зах зээл дээр 2 програм хангамжийг борлуулахаар төлөвлөж байна. Эдгээр бүтээгдэхүүнүүд нь тухайн улсын програм хангамжтай чанарын хувьд ижил түвшиний, харьцангуй хямд үнэтэй байх болно. Орлого, зардлын төсөөллийн задаргааг дэлгэрэнгүй харуулбал дараах байдалтай байна.



ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК ERDENES SOLUTIONS Joint Stock Company

УЛААНБААТАР ХОТ ГҮҮДСЕК ҮЦК ХХК

2022-03-22

*Хөрөнгийн үнэлгээний "Мөнх-Оргил трейд" ХХК*

| № | Үзүүлэлтүүд | 2020 аудитад | 2021 аудитад | 2022 | 2023 | 2024 | 2025 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | **Орлого** | 21,262,624 | 871,870,256 | 2,213,400,000 | 4,839,918,779 | 7,840,746,767 | 10,358,181,220 |
| 2 | Өөрсдийн бүтээгдэхүүнээс | | 0 | 870,000,000 | 1,515,000,000 | 2,400,000,000 | 3,150,000,000 |
| 3 | Охин компанийн ноогдол ашиг | | 0 | 478,050,000 | 2,425,788,779 | 3,772,322,267 | 4,570,526,720 |
| 4 | Програм хангамжийн жил тутмын төлбөр | | 0 | 175,350,000 | 148,500,000 | 157,594,500 | 271,624,500 |
| 5 | Захиалгат ажил үйлчилгээнээс | 21,262,624 | 869,800,000 | 690,000,000 | 750,630,000 | 1,510,830,000 | 2,366,030,000 |
| 6 | Бусад орлого | | 2,070,256 | | | | |
| 7 | **Үйл ажиллагааны зардал** | | | | | | |
| 8 | ТУЗ-ын зардал | | - | 71,550,000 | 82,282,500 | 123,423,750 | 185,135,625 |
| 9 | Цалин, түүнтэй холбогдох зардал | 168,644,517 | 0 | - | - | - | - |
| 10 | Аутсорсингийн зардал | | | 41,580,000 | 45,738,000 | 50,311,800 | 55,342,980 |
| 11 | Байрны түрээс холбогдох зардал | | | 3,434,400 | 3,709,152 | 4,005,884 | 4,326,355 |
| 12 | Интернет болон серверийн зардал | | | - | - | - | - |
| 13 | Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал | | | - | - | - | - |
| 14 | Бичиг хэргийн зардал | | | 20,044,332 | 22,048,765 | 24,253,642 | 26,679,006 |
| 15 | Цайны зардал | | | 1,593,900 | 1,753,290 | 1,928,619 | 2,121,481 |
| 16 | Тээвэр болон шатахууны зардал | | | 6,950,097 | 7,645,107 | 8,409,617 | 9,250,579 |
| 17 | Шуудан холбооны зардал | | | 4,966,920 | 5,364,274 | 5,793,415 | 6,256,889 |
| 18 | Албан томилолт | | | 10,368,000 | 11,197,440 | 12,093,235 | 13,060,694 |
| 19 | Сургалт | | | 42,768,000 | 46,189,440 | 49,884,595 | 53,875,363 |
| 20 | Банкны үйлчилгээний шимтгэл | | | 71,177 | 74,736 | 78,473 | 82,397 |
| 21 | Санхүүгийн зардал | | 21,035,327 | 35,652,472 | | | |
| 22 | Аудитын зардал | | | 14,300,000 | 32,890,000 | 59,734,000 | 24,667,500 |
| 23 | МХБ, ҮЦТХТ-ийн зохицуулалтын үйлчилгээний хөлс | | | 1,300,000 | 1,300,000 | 1,365,000 | 1,433,250 |
| 24 | Тайлан хэвлүүлэх зардал | | | 150,000 | 150,000 | 157,500 | 165,375 |
| 25 | Зар сурталчилгаа | | | 13,998,600 | 15,398,460 | 16,938,306 | 18,632,137 |
| 26 | Хуульчийн зардал | | | 19,800,000 | 21,780,000 | 23,958,000 | 26,353,800 |
| 27 | Зочин төлөөлөгч, баяр ёслолын зардал | | | 53,581,500 | 57,868,020 | 62,497,462 | 67,497,259 |
| 28 | IPO хийхтэй холбоотой зардал | | | 286,926,682 | - | - | - |
| 29 | Бусад зардал | | 75,646,704 | | | | |
| 30 | Элэгдлийн зардал | | 0 | 99,827,000 | 159,827,000 | 239,827,000 | 319,827,000 |
| 31 | **Үйл ажиллагааны зардал** | 168,644,517 | 96,682,031 | 728,863,080 | 515,216,184 | 684,660,299 | 814,707,688 |
| 32 | Нэмэгдэж болзошгүй зардал /үа-ны зардлын 2 хувь/ | | 0 | 14,577,262 | 10,304,324 | 13,693,206 | 16,294,154 |
| 33 | **Үйл ажиллагааны нийт зардал** | 168,644,517 | 96,682,031 | 743,440,341 | 525,520,507 | 698,353,505 | 831,001,842 |
| 34 | **Татвар төлөхийн өмнөх ашиг** | -147,381,893 | 775,188,225 | 1,469,959,659 | 4,314,398,272 | 7,142,393,262 | 9,527,179,378 |
| 35 | Орлогын албан татвар | | 77,518,822 | 146,995,966 | 431,439,827 | 999,837,642 | 1,834,512,782 |
| 36 | **Татварын дараах цэвэр ашиг** | -147,381,893 | 697,669,402 | 1,322,963,693 | 3,882,958,445 | 6,142,555,620 | 7,692,666,596 |

## 2022-2025 оноор төсөвлөгдсөн орлого, санхүүгийн байдлын тооцоолол

/мян.төг-өөр/

### ОРЛОГЫН ТӨСӨӨЛӨЛ

| Үзүүлэлт | 2022 | 2023 | 2024 | 2025 |
|---|---|---|---|---|
| **Орлого** | **2,213,400** | **4,839,919** | **7,840,747** | **10,358,181** |
| Өөрсдийн хөгжүүлсэн бүтээгдэхүүнээс | 870,000 | 1,515,000 | 2,400,000 | 3,150,000 |
| Охин компанийн ноогдол ашгаас | 478,050 | 2,425,789 | 3,772,322 | 4,570,527 |
| Програм хангамжийн жил тутмын төлбөр | 175,350 | 148,500 | 157,595 | 271,625 |
| Захиалгат ажил үйлчилгээнээс | 690,000 | 750,630 | 1,510,830 | 2,366,030 |
| **Үйл ажиллагааны зардал** | **743,440** | **525,521** | **698,354** | **831,002** |
| Үйл ажиллагааны зардал | 728,863 | 515,216 | 684,660 | 814,708 |
| Үйл ажиллагааны бус зардал | 14,577 | 10,304 | 13,693 | 16,294 |
| **Татварын өмнөх ашиг** | **1,469,960** | **4,314,398** | **7,142,393** | **9,527,179** |
| Орлогын татвар | 146,996 | 431,440 | 999,838 | 1,834,513 |
| **ЦЭВЭР АШИГ** | **1,322,964** | **3,882,958** | **6,142,556** | **7,692,667** |

### САНХҮҮГИЙН ТАЙЛАН-ТЭНЦЭЛ

| АКТИВ ХӨРӨНГӨ | 2022 | 2023 | 2024 | 2025 |
|---|---|---|---|---|
| Мөнгө | 23,713 | 1,935,978 | 4,551,688 | 6,746,891 |

2022-03-22
БҮРТГЭВ-03

*Хөрөнгийн үнэлгээний "Мөнх-Оргил трейд" ХХК*

| | | | | |
|---|---|---|---|---|
| Хөрөнгө оруулалт | 2,766,638 | 2,766,638 | 2,766,638 | 2,766,638 |
| Биет хөрөнгө | 499,135 | 799,135 | 1,199,135 | 1,599,135 |
| Биет бус хөрөнгө | 1,984,715 | 2,575,973 | 3,296,621 | 4,119,708 |
| **НИЙТ АКТИВ ХӨРӨНГӨ** | **5,274,201** | **8,077,724** | **11,814,082** | **15,232,372** |
| **ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ** | | | | |
| Богино хугацаат өр төлбөр | 150,000 | - | - | - |
| Урт хугацаат өр төлбөр | - | - | - | - |
| **Өр төлбөр** | **150,000** | - | - | - |
| Энгийн хувьцаа | 1,725,405 | 1,725,405 | 1,725,405 | 1,725,405 |
| Нэмж төлөгдсөн капитал | 1,539,924 | 1,539,924 | 1,539,924 | 1,539,924 |
| Хуримтлагдсан ашиг | 535,908 | 929,436 | 2,406,197 | 4,274,376 |
| Тухайн жилийн ашиг | 1,322,964 | 3,882,958 | 6,142,556 | 7,692,667 |
| **Өөрийн хөрөнгө** | **5,124,201** | **8,077,724** | **11,814,082** | **15,232,372** |
| **ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ** | **5,274,201** | **8,077,724** | **11,814,082** | **15,232,372** |

## Компанийн санхүүгийн үзүүлэлтүүдийн харьцаанууд

| № | Үзүүлэлт | 2021 аудитгд | 2022 | 2023 | 2024 | 2025 |
|---|---|---|---|---|---|---|
| | Санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд | | | | | |
| 1 | Өөрийн хөрөнгийн өгөөж /ROE/ | 33.0% | 25.8% | 48.1% | 52.0% | 50.5% |
| 2 | Нэг ширхэг хувьцаанд ноогдох ашиг /EPS/ | 44.2% | 76.7% | 225.0% | 356.0% | 445.8% |
| 3 | Активын өгөөж /ROA/ | 24.3% | 25.1% | 48.1% | 52.0% | 50.5% |
| 4 | Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар | 1.7% | 0.16 | | | |
| 5 | Өөрийн хөрөнгийн хүрэлцээ | 74.1% | 97.6% | 131.5% | 162.7% | 179.5% |
| 6 | Өр, нийт активын харьцаа | 26.2% | 2.8% | 0.0% | 0.0% | 0.0% |
| 7 | Өөрийн хөрөнгө нийт активын харьцаа | 1.36 | 1.03 | 1.00 | 1.00 | 1.00 |
| 8 | Өр, өөрийн хөрөнгийн харьцаа | 0.36 | 0.03 | 0.00 | 0.00 | 0.00 |




**Ноогдол ашгийн төлөвлөлт**

Компанийн ирэх 4 жилийн санхүүгийн тайлан ашигтай байхаар төсөвлөгдсөн бөгөөд хөрөнгө оруулагчдад жил бүр цэвэр ашгийн 50 хувь болон түүнээс дээш хувиар ноогдол ашиг өгөхөөр төсөвлөж байна.

**ДҮГНЭЛТ**

"Эрдэнэс сольюшинс" ХК-ийн Бизнесийн үнэлгээ

ERDENES SOLUTIONS Joint Stock Company

УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК

*Хөрөнгийн үнэлгээний "Мөнх-Оргил трейд" ХХК*

"Эрдэнэс сольюшинс" ХК нь одоогийн байдлаар тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд хөрөнгө, санхүүгийн хувьд 2021 оноос бэхжиж, орлого, ашгийн байдал сайжирч байна. Үндсэн үйл ажиллагааны чиглэл нь ирээдүйтэй бөгөөд компаний боловсруулсан 2022-2025 оны дунд хугацааны бизнес төлөвлөгөөг шинжилж үзээд цаашид хэрэгжих магадлалтай юм гэсэн төсөөллийг хийсэн болно.

СЗХ 2022 оны 7-5 өдөр БҮРТГЭВ № 01
MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-03-22 БҮРТГЭВ-03



## ТАВ. БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТООЦООЛОЛ

### 5.1. Орлогын хандлагын үнэлгээ

Энэхүү үнэлгээнд ҮОУС 2020-200 стандартын 20.3-ын "г"-д заасан **"Өмчийн үнэ цэнэ"**-ийг тодорхойлсон болно. Энэ нь 20.3-ын "г"-д заасаар "Өмчийн үнэ цэнэ: Түүний бүх хувьцаа эзэмшигчдэд хамаарах бизнесийн үнэ цэнэ юм".

Энэ талаар үнэлгээний тайлангийн 1.3.4-т "Үнэлгээний хамрах хүрээ"-нд оруулсан **Үнэлгээний арга. Хорогдуулсан Мөнгөн Гүйлгээ арга (ХМГ-ний арга)**

Орлогын хандлагаар тухайн бизенсийг үнэлэхдээ доор заасан 2 загвараар тооцооллыг хийсэн болно. Үүнд:

**1-р. Цэвэр мөнгөн гүйлгээг хорогдуулах загвар /ЦМГХ/**
**2-р. Ноогдол ашгийг хорогдуулах загвар /НАХ/**

| 1 | Өөрийн хөрөнгийн хэмжээ 445,000.0 мян.төг-р нэмэгдэж нийт 505,000.0 болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2011.12.09 | Н.Батцэцэг |
| 2 | 1. ХААН банк банкны 5112021406 тоот төгрөгийн дансыг хасав.<br>1. Капитрон банк банкны 3011005443 тоот валютын дансыг бүртгэв. | 2012.05.03 | Д.Чулуунтуяа |
| 3 | 671000, Андеррайтерийн үйлчилгээ эрхлэх туслах үйл ажиллагааг шинээр бүртгэв. | 2012.05.03 | Д.Чулуунтуяа |
| 4 | 1. ХААН банк банкны 5112025751 тоот төгрөгийн<br>2. Капитрон банк банкны 3011005443 тоот валютын<br>3. Капитрон банк банкны 3011005314 тоот төгрөгийн дансыг хасав. | 2012.07.20 | Б.Оюун-Эрдэнэ |
| 5 | Хас банк банкны 5000743880 тоот төгрөгийн дансыг бүртгэв.<br>Хас банк банкны 5000743891 тоот төгрөгийн дансыг бүртгэв. | 2012.09.25 | Ш.Цэнгэл |
| 6 | Энхбаяр овогтой Содэрдэнэ -г Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв. | 2014.05.28 | Э.Эрдэнэбилэг |
| 11 | Улаанбаатар, Чингэлтэй, 3-р хороо, энхтайвны өргөн чөлөө, , 54, Пийс тауэрын 1306 тоот тоот. Утас1 91919568, Утас2 , Факс хаягийг шинээр бүртгэв. | 2014.09.16 | Д.Аюурзана |
| 12 | 'Эс Жи капитал' оноосон нэр 'Эс Жи капитал ҮЦК' болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2014.09.16 | Д.Аюурзана |
| 13 | Ариг банк банкны 2102009555 тоот төгрөгийн дансыг бүртгэв. | 2014.10.21 | Д.Чулуунтуяа |
| 14 | Хас банк банкны 5000743891 тоот төгрөгийн дансыг хассаныг бүртгэв.<br>Ариг банк банкны 2102009555 тоот төгрөгийн дансыг хассаныг бүртгэв. | 2015.05.04 | Г.Алтай |
| 15 | Өөрийн хөрөнгийн хэмжээ 928609.7 мян.төг-р нэмэгдэж нийт 1433609.7 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв. | 2016.04.05 | С.Мөнхсанчир |
| 16 | Улаанбаатар, Чингэлтэй, 1-р хороо, , жуулчин, 44, Арт хаус 6 давхар тоот. Утас1 91919568, Утас2 , Факс хаягийг шинээр бүртгэв. | 2018.08.08 | Я.Батдэлгэр |
| 17 | 6612 Номинал данснаар харилцагчдад брокерийн үйлчилгээ үзүүлэх эрхлэх үйл ажиллагаа шинээр бүртгэв. | 2019.02.02 | Д.Чулуунтуяа |
| 18 | Улаанбаатар, Чингэлтэй, 2-р хороо, 40 ,50 мянгат/15171/Бакула ринбучийн гудамж,30-р байр, 10давхарт Утас1: 91919568, Утас2: , Факс: хаягийг шинээр бүртгэв. | 2021.08.11 | Н.Энхцэцэг |

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company

УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК
ТТБ0674 № 5208173

СЗХ 2022 .05. 25 БҮРТГЭВ № 01

2022 -03- 22 БҮРТГЭВ-03

ХАВСРАЛТ 8. "Субашид тек" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ

Хууль зүйн сайдын 2016 оны А/204 дугаар тушаалаар батлав

МОНГОЛ УЛС
## ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000195567

2018.04.06
/ Бүртгэсэн он,сар,өдөр /

9011736019
/ Хувийн хэргийн дугаар /

6295541
/ Регистрийн дугаар /

Субашид тек — Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

| Тогтоол | 01/2018 | 2018.04.02 |
|---|---|---|
| / шийдвэрийн нэр / | / дугаар / | / он, сар, өдөр / |

| / Код/ | / Үйл ажиллагааны чиглэл / |
|---|---|
| 4741 | Програм хангамж, компьютерийн тоног төхөөрөмжийн худалдаа |
| 6209 | Вэб сайт хийх |
| 6202 | Мэдээлэл технологийн үйл ажиллагаа |
| 4791 | Вэб сайтаар онлайн худалдаа |
| 6201 | Програм хангамжийн үй ажиллагаа |

| Хугацаагүй | 4 | 200.00 |
|---|---|---|
| / хугацаа / | / гишүүдийн тоо / | / хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр / |

Улаанбаатар, Чингэлтэй, 1-р хороо, Деннер оффис, 4-р давхар, Утас1: 99993396, Утас2: 99911083, Факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг/

Улсын бүртгэлийн ерөнхий газар Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар
/ Бүртгэсэн байгууллагын нэр /

Гэрчилгээ дахин олгосон 2019 он 12 сар 17 өдөр

ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК ERDENES SOLUTIONS Joint Stock Company

УЛААНБААТАР ХОТ ГҮҮДСЕК ХХК ТТБ0874 ⁂ 5208173

СЗХ
он 2022 сар 05 өдөр 25
БҮРТГЭВ
№ 01

2022-03-22
БҮРТГЭВ-03

## Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтан тэмдэг |
| 1 | Төмөрболд овогтой Золбоо-г Гүйцэтгэх захирал -р томилсныг бүртгэв | 2019.12.03 | Д.Чулуунтуяа |
| 2 | Дахин гэрчилгээ олгов. | 2019.12.17 | Ж.Нямдорж |
| 3 | Дүрмийн 1.3,5.2.1-т оруулсан өөрчлөлтийг бүртгэв. | 2021.09.23 | Н.Э[illegible] |
| 4 | Хувьцаа эзэмшигч 1 нэмэгдэж 1 хасагдаж хувьцаа эзэмшигчийн тоо нийт 4 болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2021.09.2[illegible] | Н.Энхц[illegible] |
| 5 | Эцсийн өмчлөгч 4 иргэн бүртгэв. | 2021.09.2[illegible] | Н.Энхц[illegible] |
| 6 | Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 50 мян.төг-р хасагдаж нийт 150 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв. | 2021.12.07 | Н.Долгоржав |
| 7 | Хувьцаа эзэмшигч 1 хасагдаж хувьцаа эзэмшигчийн тоо нийт 3 болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2021.12.07 | Н.Долгоржав |
| 8 | Эцсийн өмчлөгч 3 иргэн бүртгэв. | 2021.12.07 | Н.Долгоржав |

*0001955 67*

ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS
Joint Stock
Company

УЛААНБААТАР ХОТ
ГҮЙЦЭТГЭХ
ТТ5674 ... 5298173

СЗХ 2022 он 03 сар 22 өдөр БҮРТГЭВ № 01

2022 -03- 22 БҮРТГЭВ-03

ХАВСРАЛТ 9. "Субашид тек" ХХК-ийн дүрэм

Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 12-р сарын 01-ний өдрийн № ХЭХ 08/2021 тоот хурлын шийдвэрийн 1 дүгээр хавсралтаар батлав.

9011736019 2021 12 07

## "СУБАШИД ТЕК" ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ДҮРЭМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Компанийн оноосон нэр (монголоор)

- а) Бүтэн нэр: **"СУБАШИД ТЕК" ХХК** /цаашид энэхүү дүрэмд "Компани" гэх/
- б) Товчилсон нэр: "СУБАШИД ТЕК" ХХК

1.2. Компанийн ажлын үндсэн байрны болон шуудангийн хаяг:

- Улсын нэр: МОНГОЛ
- Аймаг, нийслэлийн нэр: УЛААНБААТАР
- Сум, дүүргийн нэр: ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ
- Баг, хороо, хорооллын нэр: 1-Р ХОРОО,
- Гудамж, өргөн чөлөө, тойрог, талбайн нэр: ЭНХТАЙВАНЫ ӨРГӨН ЧӨЛӨӨ, 7/2
- Хашаа, байшин, хаалганы дугаар: ДЕНВЕР ОФФИС, 4-Р ДАВХАР
- Шуудангийн хаяг: ..........................................
- Шуудангийн хайрцагны дугаар: ..........................................
- Харилцах утасны дугаар: .............................. Факсын дугаар: ..............................
- И-мэйл хаяг: ..........................................................................................

1.3.Компанийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчийн нэр:

| № | Иргэний тухайд эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр | Хуулийн этгээдийн тухайд нэр, хэлбэр, регистрийн дугаар | Иргэний тухайд регистрийн дугаар | Хувьцаа эзэмшигчийн хаяг | И-мэйл хаяг, харилцах утас, факсын дугаар |
|---|---|---|---|---|---|
| 1 | Базар Батхүү | | ЧО71101197 | УБ, ХУД, 11-Р ХОРОО,6-Р ХЭСЭГ, ХАТАН ТУУЛ, С-2 ТООТ | 99902335 |
| 2 | Цогтбаярын Хулэрмөнх | | ТЯ 85080719 | УБ, БАЯНГОЛ ДҮҮРЭГ, 1-Р ХОРОО, ЭНГЕЛЬСИЙН ГУДАМЖ, АЛТАЙ ХОТХОНЫ 18-143 | 99037119 |
| 3 | Төмөрболдын Золбоо | | ТЯ 86012116 | УБ, БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ, 13-Р ХОРОО, 90В-57 | 99993396 |

1.4.Компани нь бие даасан тайлан тэнцэлтэй, харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэх, үүрэг, хариуцлага хүлээх, хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, түүнийг захиран зарцуулах эрх нь Иргэний болон Компанийн тухай хууль, энэхүү дүрмээр хязгаарлагддаг, хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр ажиллана.

1.5.Компани нь үйл ажиллагаагаа дараах чиглэлээр явуулна. Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааг энэ заалтад хамааруулахгүй.

1.5.1.Программ хангамжийн үйл ажиллагаа

1.5.2.Программ хангамж, компьютерийн тоног төхөөрөмжийн худалдаа

1.5.3.Вэб сайт хийх

1.5.4 Вэб сайтаар онлайн худалдаа эрхлэх

1.5.5 Мэдээллийн технологи

1.6.Компани нь тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг хуульд заасны дагуу холбогдох эрх бүхий байгууллагаас зөвшөөрлийг бичгээр авч, энэхүү дүрэмдээ өөрчлөлт оруулан бүртгэх байгууллагад бүртгүүлнэ.

1.7.Компанийн үйл ажиллагаа эрхлэх хугацаа: Хугацаагүй

/доогуур нь зурах буюу хугацааг бичих/

ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК ERDENES SOLUTIONS Joint Stock Company 9020080899 2015358

УЛААНБААТАР ХОТ ГҮҮДСЕК ҮЦК ТТБ0374 5205173

1.8.Компани нь Монгол Улсад болон гадаад улсад өөрийн салбар, төлөөлөгчийн газартай байж болно. Компанийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу салбар, төлөөлөгчийн газраа байгуулан, бүртгэх байгууллагад бүртгүүлж, үйл ажиллагаагаа явуулна.

1.9.Компани нь үүсгэн байгуулах баримт бичиг болон улсын бүртгэлийн жагсаалтад агуулагдаж байгаа бусад мэдээлэлд оруулсан өөрчлөлтүүдээ хуульд заасан хугацаанд бүртгэх байгууллагад бүртгүүлнэ.

## ХОЁР. КОМПАНИЙН ЭРХ

2.1.Компанийн иргэний эрх зүйн чадвар нь улсын бүртгэлд бүртгүүлснээр үүснэ.

2.2.Компани нь өөрийн бэлэгдэл (эмблем), албан бичгийн хэвлэмэл хуудас, өөрийн нэр бүхий тэмдэг хэрэглэнэ.

2.3.Компани нь Компанийн тухай хуулийн 6.1-6.8 дахь хэсэгт заасны дагуу хараат болон охин компани байгуулж болох бөгөөд үүнийгээ бүртгэх байгууллагад бүртгүүлнэ.

2.4.Компани нь өөрийн үйл ажиллагаагаа бие даасан байдлаар, эсхүл бусад хуулийн этгээдтэй хамтран Монгол Улсын хуулийн хүрээнд эрхлэн явуулна.

2.5.Компани нь үндсэн ба туслах үйл ажиллагаагаа хэвийн явуулах зорилгоор мэргэжил, ур чадвар, дадлага туршлагатай хүмүүсийг Монгол Улсын хөдөлмөрийн тухай хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актын дагуу авч ажиллуулах, тэдгээрийн ажиллах нөхцөл, цалин хөлс, урамшууллын хэмжээг тогтооно.

## ГУРАВ. КОМПАНИЙН ҮҮРЭГ

3.1.Компани нь энэхүү дүрмийн 1.5, 1.6-д заасан үйл ажиллагааг Монгол Улсын хуульд заасны дагуу эрхлэнэ.

3.2.Компани нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын тухай хууль болон Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлд заасны дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн, санхүүгийн тайлан гаргана.

3.3.Компани нь Монгол Улсын татварын хуулиудын дагуу орлого, татвараа өөрөө тодорхойлж, албан татвараа сайн дураар төлнө.

3.4.Компани нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шаардлагатай мэдээ, мэдээллийг тухай бүр төрийн эрх бүхий байгууллагуудад гаргаж өгнө.

3.5.Компани нь Монгол Улсын Хөдөлмөрийн хуулийн дагуу ажиллагсадын өмнө хуулиар хүлээсэн үүргүүдийг биелүүлнэ.

3.6.Компани нь энгийн хувьцааг заавал гаргах үүрэг хүлээж, давуу эрхийн хувьцааг гаргаж болно.

3.7.Компани нь хувьцаа эзэмшигчийн шаардлагаар компанийн дүрэм, түүнд орсон нэмэлт түүнд танилцуулах үүрэгтэй.

3.8.Компанийн дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлт, шинэчлэн найруулсан дүрэм нь улсын бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.

3.9.Компани хувьцаагаа нэгтгэх, хуваахдаа түүнийг худалдан авах эрхийн бичиг болон түүнд хөрвөх үнэт цаасны бүрдүүлбэрт зохих өөрчлөлт оруулах үүргийг хүлээнэ.

3.10.Компани нь хувьцаа эзэмшигчийн шаардлагаар компанийн дүрэм, түүнд орсон нэмэлт өөрчлөлтийг танилцуулна.

3.11.Компани нь ногдол ашиг аваагүй хувьцаа эзэмшигчийн ногдол ашгийг түүнд төлөх өр болгон нягтлан бодох бүртгэлд хувьцаа эзэмшигчийн нэрээр тусгайлан бүртгэнэ.

3.12.Хувьцаагаа худалдахаар санал болгож байгаа хувьцаа эзэмшигч нь ут саналаа компанид мэдэгдэх бөгөөд энэ тухай компани нь бусад хувьцаа эзэмшигчидэд бичгээр мэдэгдэнэ.

3.13.Компанийн тухай хуулийн 84.1, 84.2 дугаар зүйлд тодорхойлсон .....................................................................................................................................-г компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.

3.14.Компани нь Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлд заасан баримт бичгийг зохих журмын дагуу холбогдох этгээдээс хүлээн авч хадгалах, эрх бүхий этгээдэд танилцуулах, тэдгээрийг архивт шилжүүлнэ.

## ДӨРӨВ. КОМПАНИЙН ХАРИУЦЛАГА

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-03-22
БҮРТГЭВ-03

4.1.Компани нь Компанийн тухай хуулийн 9.1 дэх хэсэгт заасан хариуцлага хүлээнэ.

4.2.Компани нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдын эрхийг зөрчсөн тохиолдолд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээнэ.

4.3.Компани нь улсын бүртгэлд бүртгүүлэхээсээ өмнө иргэний эрх зүйн харилцаанд бие даан оролцохыг хориглоно. Энэхүү заалтыг зөрчсөний улмаас бусдад гэм хор учруулсан бол буруутай этгээд гэм хорыг арилгана.

4.4.Компанийн эрх бүхий албан тушаалтан нь Компанийн тухай хуулийн 84, 85 дугаар зүйлүүдэд заасан хариуцлагыг хүлээнэ.

4.5.Компани нь Монгол Улсын хуульд заасан бусад хариуцлагыг хүлээнэ.

## ТАВ. КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ БОЛОН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

5.1.Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг Компанийн тухай хуулийн 30.1 дэх хэсэгт заасны дагуу тодорхойлно.

5.2 Компанийн зарласан хувьцаа нэг бүр нь 100/нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 500 /таван зуу/ ширхэг нийт 50'000 /тавин мянга/ төгрөгийн үнэи бүхий хувьцаа байна.

5.2.Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 150'000 /нэг зуун тавин мянга/ төгрөг ба нэг бүр нь 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1'500 нэг мянга таван зуу/ ширхэг энгийн хувьцаа байна.

5.2.1.компанийн хувь нийлүүлэгчид дараах байдлаар гаргасан хувьцааг эзэмшинэ:

| № | Хувьцаа эзэмшигч иргэн болон хуулийн этгээдийн нэр | Гаргасан хувьцаа | | | Хувь нийлүүлсэн хөрөнгөд эзлэх хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Тоо ширхэг | Нэрлэсэн үнэ /төгрөгөөр/ | | |
| | | | Нэг бүрийн | Бүгд | |
| 1 | Базар Батхүү | 500 | 100 | 50 000 | 33.33% |
| 2 | Цогтбаярын Хүдэрмөнх | 500 | 100 | 50 000 | 33.33% |
| 3 | Төмөрбаатарын Золбоо | 500 | 100 | 50 000 | 33.33% |
| Нийт | | 1'500 | 100 | 150'000 | 100.00% |

5.3.Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээг Компанийн тухай хуулийн 30.2 дахь хэсэгт заасны дагуу тодорхойлно.

5.4.Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөхдөө Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасныг баримтлана.

5.5.Компанийн хувьцаа, компанийн зарласан болон гаргасан хувьцаатай холбоотой асуудлыг Компанийн тухай хуулийн 32, 33 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

## ЗУРГАА.КОМПАНИЙН УДИРДЛАГА

6.1.Компанийн эрх барих дээд байгууллага нь Компанийн тухай хуулийн 59.1 дэх хэсэгт заасан хувьцаа эзэмшигчдийн хурал байна.

6.2.Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит ба ээлжит бус хурал, хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах шийдвэр гаргах, хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх, хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр хүчин төгөлдөр болох, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрх хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг хүргэх, хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудалд санал оруулах, хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комисс, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох журам, хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц, хувьцаа эзэмшигчдийн хурал хүчин төгөлдөр болох, хувьцаа эзэмшигчдийн хурал, түүний шийдвэрийн талаар гомдол гаргах, саналын хуудас, саналын хуудсыг хүчинтэйд тооцох, эчнээ санал хураалтаар компанийн хувьцаа эзэмшигчид шийдвэр гаргах, хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлтэй холбоотой асуудлыг Компанийн тухай хуулийн 59-74 дүгээр зүйлд заасны дагуу зохицуулна.

6.3.Компанийн гүйцэтгэх захирлыг хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр сонгож, өөрчилнө. Гүйцэтгэх захиралтай хувьцаа эзэмшигчид гэрээ байгуулна.

6.3.Компанийн хувьцаа эзэмшигчид компанийг өөрчлөн байгуулах асуудлыг шийдвэрлэнэ.

ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company
9020080899 2015358

УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК
ТТБ0674 № 5209170

6.4.Компанийг өөрчлөн байгуулсантай холбогдуулан хувьцаа эзэмшигч Компанийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан эрхийг эдэлнэ.

## ДОЛОО. КОМПАНИЙН ЭНГИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ

7.1.Компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан эрхийг эдэлнэ.

## НАЙМ. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

8.1.Компанийн гүйцэтгэх удирдлага нь компанийн гүйцэтгэх захирал байна. Гүйцэтгэх захирал нь хувьцаа эзэмшигчидтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

8.2.Компанийн гүйцэтгэх захирал нь хувьцаа эзэмшигчидтэй байгуулсан гэрээний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна.

8.3.Компанийн хувьцаа эзэмшигч нь гүйцэтгэх захирал байж болно. Энэ тохиолдолд үүсгэн байгуулагч буюу хувьцаа эзэмшигчийн шийдвэрт тусгах бөгөөд гэрээ байгуулахгүй.

8.4.Компанийн гүйцэтгэх захирал нь Компанийн тухай хуулийн 7.11 дэх хэсэгт заасны дагуу компанийн салбар, төлөөлөгчийн газрын удирдлагыг томилж, чөлөөлнө.

8.5.Компанийн гүйцэтгэх захирал нь компанийн өрийг хувьцаагаар солих асуудлыг шийдвэрлүүлэхдээ Компанийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасныг баримтална.

8.6.Компанийн гүйцэтгэх захирал нь компанийг татан буулгах комисс томилох, татан буулгах хугацаа, журам, зээлдүүлэгчдийн нэхэмжлэлийг барагдуулсны дараа компанид үлдэх эд хөрөнгийг хувьцаа эзэмшигчдэд хуваарилах журам зэргийг тусгасан татан буулгах төслийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж, хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор шийдвэрлүүлнэ.

8.7.Компанийн гүйцэтгэх захирлын шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор зарлан хуралдуулна.

8.8.Компанийн гүйцэтгэх захирал хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг Компанийн тухай хуулийн 61.1 дэх хэсэгт заасны дагуу зарлан хуралдуулна.

8.9.Компанийн гүйцэтгэх захирал Компанийн тухай хуулийн 61.5 дахь хэсэгт заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахаас татгалзах шийдвэр гаргах бөгөөд санал, шаардлага гаргасан хувьцаа эзэмшигчид нэн даруй мэдэгдэнэ.

8.10.Компанийн гүйцэтгэх захирал Компанийн тухай хуулийн 61.4 дэх хэсэгт заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай шийдвэр гаргасан тохиолдолд санал, шаардлага хүлээн авсан өдрөөс хойш 45 хоногийн дотор тухайн хурлыг хуралдуулна.

8.11.Компанийн гүйцэтгэх захирал Компанийн тухай хуулийн 66.1 дэх хэсэгт заасан хувьцаа эзэмшигч, 66.3 дахь хэсэгт заасны дагуу саналаа бичгээр гаргасан тохиолдолд 66.5 дахь хэсэгт заасан үүргийг хүлээнэ. Мөн хуулийн 66.6 дахь хэсэгт заасны дагуу компанийн гүйцэтгэх захирал үндэслэл бүхий тайлбарыг шийдвэр гаргаснаас хойш ажлын гурван өдрийн дотор санал гаргасан хувьцаа эзэмшигчид хүргүүлнэ.

8.12.Компанийн гүйцэтгэх захирлын бүрэн эрх нь дуусгавар болсон өдрөөс хойш байгуулсан гэрээ, хэлцэл хүчин төгөлдөр бус байна.

8.13.Компанийн гүйцэтгэх захирал нь Компанийн тухай хуульд заасан их хэмжээний хэлцэл мөн эсэхийг тодорхойлохдоо аудиторын зөвлөмжийн дагуу эд хөрөнгийн балансын үнийг мөнгөний ханшийн уналтын түвшинтэй зохицуулан шинэчилж дахин тогтоож болно.

8.14.Компанийн гүйцэтгэх захирал нь компанийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна.

## НАЙМ. КОМПАНИЙН САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-03-22
БҮРТГЭВ-03

8.1.Компанийн хувьцаа эзэмшигчид Компанийн тухай хуулийн 94.1 дэх хэсэгт зааснаар гэрээний үндсэн дээр аудитын байгууллагыг томилон ажиллуулж болно.

8.2.Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийх аудитын байгууллагын шалгалт нь ээлжит ба ээлжит бус байна.

8.3.Компанийн жилийн санхүүгийн тайланг баталгаажуулахын тулд хийсэн аудитын байгууллагын шалгалт нь ээлжит байна.

8.4.Аудитын байгууллагын шалгалтын зардлыг Компанийн тухай хуулийн 94.8 дахь хэсэгт заасны дагуу компани болон хувьцаа эзэмшигч хариуцан төлнө.

8.5.Компани нь санхүүгийн тайлангаа төрийн эрх бүхий байгууллагад танилцуулна.
8.6.Компанийн санхүүгийн жил 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэж, 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно.

8.7.Компани нь компанийн санхүүгийн тайланд Компанийн тухай хуулийн 96.1 дэх хэсэгт заасан зүйлийг тусгана.

8.8.Компани нь Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлд заасан баримт бичгийг хадгалах, зохих журмын дагуу холбогдох этгээдээс хүлээн авч хадгалах, эрх бүхий этгээдэд танилцуулах, архивт шилжүүлнэ.

## ЕС. КОМПАНИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ

9.1.Компанийн хувьцаа эзэмшигч нь компанийг өөрчлөн байгуулахдаа Компанийн тухай хуулийн 18-23 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

## АРАВ. КОМПАНИЙГ ТАТАН БУУЛГАХ

10.1.Компанийг Компанийн тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан үндэслэлээр татан буулгана.

10.2.Компанийг татан буулгах шийдвэр гаргасан эрх бүхий этгээд татан буулгах комиссыг томилно.

10.3.Компанийг татан буулгах шийдвэр гаргасан эрх бүхий этгээд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 24.1 дэх хэсэгт заасан хугацаанд бүртгэх байгууллагад бичгээр мэдэгдэж, холбогдох баримт бичгийг хавсаргасан байна.

10.4.Татан буулгах комисс Иргэний хуулийн 32.2-32.10 дахь хэсэг, Компанийн тухай хуулийн 26, 27, 28 дугаар зүйлд заасны дагуу компанийг татан буулгах ажлыг эрхлэн гүйцэтгэнэ.

10.5.Компани татан буугдсаныг улсын бүртгэлд бүртгүүлэхдээ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан баримт бичгийг бүрдүүлж бүртгэх байгууллагад ирүүлнэ.

## АРВАН НЭГ. БУСАД ЗҮЙЛ

11.1.Энэхүү дүрмийг монгол хэлээр 3 хувь үйлдэж, нэг хувийг бүртгэх байгууллагад, хоёр хувийг компанийг улсын бүртгэлд бүртгүүлэх эрх бүхий этгээдэд өгнө.

11.2.Компанийн дүрмийг улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болсонд тооцогдоно.

"Субашид тек" ХХК-ийг хувьцаа эзэмшигч

1. ................/ Т. Золбоо .........../
(гарын үсэг) (үүсгэн байгуулагчийн овог нэр)
2. ................/ ...................../
(гарын үсэг) (үүсгэн байгуулагчийн овог нэр)
3. ................/ Б. БАТХҮҮ .........../
(гарын үсэг) (үүсгэн байгуулагчийн овог нэр)
4. ................/ ...................../
(гарын үсэг) (үүсгэн байгуулагчийн овог нэр)

2021 оны 12 дугаар сарын 01-ний өдөр

ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company
ХТУ3261 2015358

УЛААНБААТАР ХОТ
ГҮҮДСЕК ҮЦК ХХК
ТБ8674 ☎ 5208173

ХАВСРАЛТ 10. ТУЗ-ийн тогтоол №ТУЗТ 05/2022, хавсралт"Ноогдол ашгийн бодлого, шийдвэр гаргах, мэдээлэх, тарааж олгох журам"

# "ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС" ХК

2022 оны 03-р сарын 05-ны өдөр ТУЗХ 05/2022 Улаанбаатар хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурал 2022 оны 03 дугаар сарын 05-ний өдрийн 13.00 цагаас 14.00 цагийн хооронд онлайнаар хуралдав. Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хуралд гишүүн Т.Золбоо, Э. Цэндсүрэн, Б.Батхүү, Ц. Хишигбаатар, Г.Аззаяа, Ц.Худэрмөнх, Б.Энхзориг, С.Энхжаргал, П.Нарантунгалаг нарын гишүүд оролцов. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн ирц 100/нэг зуу/ хувь буюу Компанийн тухай хууль, Компанийн дүрэмд заасны дагуу ирц бүрдсэн тул хурал хүчин төгөлдөр болов.

**Хэлэлцэх асуулал:**

1. Компанийн охин компани "Эйс ассошиэйтс ББСБ" ХХК-ийн цэвэр ашгийг татан төвлөрүүлж байх тухай;
2. Компанийн Ноогдол ашгийн бодлого, шийдвэр гаргах, мэдээлэх, тарааж олгож журам батлах тухай.

Хэлэлцэж буй асуудлаар:

Ц.Худэрмөнх: Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн ТУЗТ 11/2021 тоот тогтоолоор Компанийн 2022-2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй "Бизнес төлөвлөгөө" баталж, компани нийтэд нэмж хувьцаа гарган татан төвлөрүүлсэн хөрөнгийн 1 тэрбум 650 сая төгрөгийг охин компани болох "Эйс ассошиэйтс ББСБ" ХХК-д хийхээр төлөвлөсөн. Үүнтэй холбоотойгоор компанийн "Эйс ассошиэйтс ББСБ" ХХК-д эзлэх хувь 95 хувьд хүрч ноогдол ашгийг жил бүр толгой компанид хуваарилж байхаар төлөвлөсөн. Үүнтэй холбоотойгоор "Эйс ассошиэйтс ББСБ" ХХК-ийн жил бүрийн ноогдол ашгийг 100 хувь хувиарлаж байхаар шийдвэр гаргах саналтай байна. Өмнөх тогтоолуудаар "Эйс ассошиэйтс ББСБ" ХХК-ын хувьцаа эзэмшигчдийн хуралд суух шийдвэр гаргах эрхийг хэрэгжүүлэх эрхийг надад олгосон тул ноогдол ашиг олгож байхыг даалгасан тогтоол гаргах саналтай байна.

Б. Энхзориг: Бизнес төлөвлөгөөнд тэгээд тусгасан бол тэрүүгээр нь батлах саналтай байна. Гишүүдээс өөр ямар нэгэн санал байна уу? Санал хураах уу?

Гишүүдийн 100 хувийн саналаар Гүйцэтгэх захирлын оруулж буй саналыг зөвшөөрч батлав.

2-р хэлэлцэх асуудлаар:

Ц.Худэрмөнх: Бизнес төлөвлөгөөнд тусгасанаар тус компани жил бүр ноогдол ашгийг 50 хувь тарааж байхаар тусгасан. Үүнийг ноогдол ашгийн бодлогын баримт бичигт тусгаж өгөх саналтай байна. Манай ноогдол ашгийн бодлого ТУЗ-ын 2016 оны 05-р сарын 12-ны өдрийн хурлын ТУЗТ 03/2016 тоот тогтоолын 7-р хавсралтаар баталсан юм байна. Ингэснээр манай хөрөнгө оруулагчдад энэ бодлого их тодорхой байх болов уу. Энэ дээр ямар нэгэн санал байна уу. Жил бүр цэвэр ашгийн 50 болон түүнээс дээш хувийг заавал хувиарлаж байх бодлого болно.

Б. Энхзориг: Тэгэхээр энэ хувьцаа эзэмшигчдэд тватай мэдээлэл болох нээ. 2022 онд 1,3 тэрбум төгрөг цэвэр ашиг хийхээр төлөвлөж байл уу. Үүний 50 хувийг олгох юмуу. Бараа бүтээгдэхүүнээр олгох юмуу гэдгийг тодорхой болгомоор байна.

СЗХ он 2022 сар 05 өдөр 25 БҮРТГЭВ № 01

2022-05-22 БҮРТГЭВ-03

Ц. Хүдэрмөнх: Компанийн ноогдол ашгийн бодлогод аль болох бэлэн мөнгөөр олгохоор тусгагдсан Бизнес төлөвлөгөөн бас бэлэн мөнгө олгохоор тусгасан: Програм хангамжийн компанийн 1 онцлог бол 1 бүтээгдэхүүн гаргахаар байнга мөнгө орж ирж байдаг. Бэлэн мөнгө яваандаа ихтэй байхаар байгаа. Тэгэхээр ер нь аль чталаа бодсон өөлж өгвөл 100 хувь олгож байхаар төлөвлөж байна. Бид гадаад зах зээлд бүтээгдэхүүнээ зараад ирэхээр ашиг нилээд нэмэгдэн гэж байгаа. Хувьцаа эзэмшигчид маань энэ талаар мэдэж байвал их зүгээр болов уу гэж бодож байна.

Б. Энхзориг: Энэ жил зах зээлд гаргахаар төлөвлөж байгаа бүттээдэхүүнүүд чинь хэзээ дуусахаар байна.

Ц.Хүдэрмөнх: Дарсыг бол ерөнхийдөө дууссан Санхүүгийн зохицуулах хороонд танилцуулж байгаа, ББСБ-ын бүтээгдэхүүн маань энэ 4-р сард бүрэн дуусгахаар ажиллаж байна. Цаана нь брокерийн програмыг дуусгана. 4-р сард мөнгө татан төвлөрүүлэхээр хүний нөөц болон тоног төхөөрөмжийг нилээд нэмж авахаар судлаж байна. Зарим 1 захиалгат ажилууд банкнаас авахаар судлаж байна. Ерөнхийдөө эдгээр ажилуудыг хийхэд хүний нөөцийн бодлого их чухал байна.

Б.Энхзориг: Энэ жилийн цэвэр ашиг 690 гаруй сая төгрөг байсан. Үүнээс ноогдол ашиг хувиарлах уу?

Ц.Хүдэрмөнх: Энэ жил арай болохгүй. Бид банк бус санхүүгийн байгууллага худалдаж авсан.Компанийн тухай хуулиар төлбөрийн чадвартай байх ёстой. Ирэх 2023 оноос хуварлахаар төлөвлөж байна.

Б.Энхзориг: За тэгвэл саналаа хураах уу?

Гишүүдийн 100 хувийн саналаар Гүйцэтгэх захирлын оруулж буй саналыг зөвшөөрч батлав.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2022 ОНЫ 03-Р САРЫН 05-НЫ ӨДРИЙН ХУРЛААС ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН 100 ХУВИЙН САНАЛААР ДАРААХ АСУУДЛУУДЫГ ШИЙДВЭРЛЭВ. ҮҮНД:**

1. Компанийн охин компани болох "Эйс ассошиэйтс ББСБ" ХХК-ийн тухайн жил олсон цэвэр ашгийг 2023 оноос эхлэн 100 (нэг зуу) хувь хувьцаа эзэмшигчдэд хувиарлан, Компанид ноогдох ашгийг татан төвлөрүүлж байхыг Гүйцэтгэх захирал (Ц. Хүдэрмөнх)-д даалгав;
2. Компанийн Ноогдол ашгийн бодлого, шийдвэр гаргах, мэдээлэх, тарааж олгож журамыг хавсралтаар батлав.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА /Т.ЗОЛБОО/

ГИШҮҮН /Ц.ХҮДЭРМӨНХ/

ГИШҮҮН /П.НАРАНТУНГАЛАГ/

ГИШҮҮН /Б.ЭНХЗОРИГ/

ГИШҮҮН /С.ЭНХЖАРГАЛ/

ГИШҮҮН /Ц.ХИШИГБААТАР/

ГИШҮҮН /Э.ЦЭНДСҮРЭН/

ГИШҮҮН /Б.БАТХҮҮ/

ГИШҮҮН /Т.АЗЗАЯА/

ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК ERDENES SOLUTIONS Joint Stock Company

УЛААНБААТАР ХОТ ГҮЮДСЕК ҮЦК ХХК ТТ58674 ☎ 5208173

СЗХ он 2022 сар 05 өдөр БҮРТГЭВ № 01

2022-03-22 БҮРТГЭЗ-03

# "ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС" ХК

2021 оны 12 дугаар сарын 13-ны өдөр №ТУЗТ 11/2021 Улаанбаатар хот

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

Нийтэд санал болгох энгийн хувьцааны хэмжээг тогтоох, хөндлөнгийн үнэлгээ, дүгнэлт гаргуулах, тэдгээрт холбоотой зардлын дээд хэмжээ тогтоох тухай

Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2.2 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэг, 42 дугаар зүйлийн 42.1, 42.4 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.4, 76.1.9, 76.1.10, 76.1.18 дэх хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6.1 дэх хэсэг, 81 дүгээр зүйлийн 81.4.1, 81.4.3, 81.4.5 дахь хэсэг, "Эрдэнэс сольюшинс ХК ("Компани")-ийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.10.12 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хурлаас гаргасан дүгнэлт болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн 2022-2025 онд хэрэгжүүлэх "Бизнес төлөвлөгөө 2022-2025 он"-г энэхүү тогтоолын 1-р хавсралтаар батлагсугай.

2. Компанийн дүрмийн 5.4-т заасан нэг бүр нь 10 \арав\ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 19,842,125,430 \арван есөн тэрбум найман зуун дөчин хоёр сая нэг зуун хорин таван мянга дөрвөн зуун гуч\ ширхэг зарласан энгийн хувьцаанаас 10,077,100 (арван сая далан долоон мянга нэг зуу) ширхэг хүртэлх энгийн хувьцаа буюу нийт гаргасан хувьцааны 6.00 (зургаа) хувьтай тэнцэх энгийн хувьцааг нэмж гарган "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-аар дамжуулан нийтэд санал болгох замаар худалдахаар тогтоосугай.

3. Нийтэд санал болгон нэмж гаргаж буй энгийн хувьцааны анхдагч зах зээлийн арилжааны захиалгын хэмжээ нэмж гаргаж буй 10,077,100 (арван сая далан долоон мянга нэг зуу) ширхэг энгийн хувьцааны захиалгаас давсан нөхцөлд Компанийн зарласан энгийн хувьцаанаас нэмж дахин 5,536,868 (таван сая таван зуун гучин зургаан мянга найман зуун жаран найм) ширхэг хүртэлх энгийн хувьцааг нэмж гүйлгээнд гаргахаар тогтоосугай.

4. Энэ тогтоолын 1 болон 2-т заасан нийтэд санал болгох нэмж гаргаж буй энгийн хувьцааны тоо хэмжээ нийтдээ 15,613,968 (арван таван сая зургаан зуун арван гурван мянга есөн зуун жаран найм) хүртэлх ширхэг буюу Компанийн эргэлтэд гаргасан нийт энгийн хувьцааны 9.00 (ес) хүртэлх хувь байхаар тогтоосугай.

5. Компанийн эргэлтэд гаргасан хувьцааны 9.00 (ес) хүртэлх хувьтай тэнцэх 15,613,968 (арван таван сая зургаан зуун арван гурван мянга есөн зуун жаран найм) хүртэлх ширхэг энгийн хувьцааны нийтэд санал болгох нэг бүрийн үнийг Компанийн бизнесийн үнэлгээний тайланд үндэслэн андеррайтерийн компанитай харилцан тохиролцсоны үндсэн дээр Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар шийдвэрлүүлэхийг Гүйцэтгэх захирал (Ц.Хүдэрмөнх)-д үүрэг болгосугай.

6. Компаниас нэмж энгийн хувьцаа гаргахтай холбоотойгоор андеррайтерийн компанийг сонгон шалгаруулж Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар шийдвэрлүүлэхийг Гүйцэтгэх захирал (Ц.Хүдэрмөнх)-д даалгасугай.

ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК ERDENES SOLUTIONS Joint Stock Company 9020080809 2015358

УЛААНБААТАР ХОТ ГҮЙДСЕК ҮЦК ХХК

7. Компанийн 2020 оны 7 дугаар сарын 20-ны өдөр андеррайтерын "Эс Жи Капитал ҮЦК"-тай байгуулсан "Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ"-г цуцалсугай.

8. Компаниас нэмж энгийн хувьцаа гаргахтай холбоотойгоор 2021 оны жилийн эцсийн Компанийн бизнесийн үнэлгээг хөрөнгийн үнэлгээний "Мөнх-Оргил трейд" ХХК-иар, аудитыг "Пи Кэй Эф Монголиа" ХХК-иар, хуулийн дүгнэлтийг "Батбаяр энд Партнэрс" ХХН-иар тус тус хийлгэхээр шийдвэрлэсүгэй.

9. Энэ тогтоолын **8-т** заасан бизнесийн үнэлгээ, хөндлөнгийн аудит болон хуулийн дүгнэлт хийх зардлын дээд хэмжээг 80,000,000 /наян сая/ төгрөгөөр тогтоож, холбогдох гэрээ, хэлцэл байгуулж ажиллах, тэдгээрт гарын үсэг зурах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал (Ц.Хүдэрмөнх)-д олгосугай.

10. Нийтэд санал болгож байгаа энгийн хувьцааг "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-аар дамжуулан нийтэд санал болгох, стратегийн хөрөнгө оруулагчтай хэлэлцээ хийх, худалдах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, шаардлагатай бусад гэрээ хэлцэл байгуулж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Ц.Хүдэрмөнх)-д үүрэг болгосугай.

11. Компаниас нэмж энгийн хувьцаа гаргаж буйтай холбоотойгоор стратегийн хөрөнгө оруулагчтай хэлэлцээ хийх, шаардлагатай гэрээ, хэлцэл байгуулж ажиллах болон тэдгээртэй холбогдон байгуулах бүхий л гэрээ, хэлцэл, баримт бичигт Компанийг төлөөлөн гарын үсэг зурах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал (Ц.Хүдэрмөнх)-д олгосугай.

12. Компаниас нэмж энгийн хувьцаа гаргаж буйтай холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн бирж ТӨХК-д холбогдох журмын дагуу мэдэгдэж зөвшөөрөл авах, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт хандаж холбогдох өөрчлөлтийг бүртгүүлэх, шаардлагатай бусад арга хэмжээг тухай бүр авч ажиллахыг Гүйцэтгэх захирал (Ц.Хүдэрмөнх)-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА /Т.ЗОЛБОО/

СЗХ БҮРТГЭВ он сар өдөр №01

2022-03-22 БҮРТГЭВ-03

# "ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС" ХК

2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр №ТУЗТ 02/2022 Улаанбаатар хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Нийтэд санал болгох энгийн хувьцааны
тоо хэмжээ, нэгж энгийн хувьцааны үнийг тогтоох тухай

Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2.2 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэг, 42 дугаар зүйлийн 42.1, 42.4 дэх хэсэг, 55 дугаар зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.4, 76.1.6, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6.1 дэх хэсэг, "Эрдэнэс сольюшинс ХК ("**Компани**")-ийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн ТУЗТ 11/2021 тоот тогтоолын 2-т заасан "Компанийн дүрмийн 5.4-т заасан нэг бүр нь 10 (арав) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 19,842,125,430 (арван есөн тэрбум найман зуун дөчин хоёр сая нэг зуун хорин таван мянга дөрвөн зуун гуч) ширхэг зарласан энгийн хувьцаанаас 10,077,100 (арван сая далан долоон мянга нэг зуу) ширхэг хүртэлх энгийн хувьцаа буюу нийт гаргасан хувьцааны 6.00 (зургаа) хувьтай тэнцэх энгийн хувьцааг нэмж гарган "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-аар дамжуулан нийтэд санал болгох замаар худалдахаар тогтоосугай." гэснийг "Компанийн дүрмийн 5.4-т заасан нэг бүр нь 10 (арав) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 19,842,125,430 (арван есөн тэрбум найман зуун дөчин хоёр сая нэг зуун хорин таван мянга дөрвөн зуун гуч) ширхэг зарласан энгийн хувьцаанаас 14,665,944 (арван дөрвөн сая зургаан зуун жаран таван мянга есөн зуун дөчин дөрөв) ширхэг хүртэлх энгийн хувьцааг нэмж гарган "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-аар дамжуулан нийтэд санал болгох замаар худалдахаар тогтоосугай." гэж өөрчилсүгэй.

2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн ТУЗТ 01/2021 тоот тогтоолын 3-т заасан "Нийтэд санал болгон нэмж гаргаж буй энгийн хувьцааны анхдагч зах зээлийн арилжааны захиалгын хэмжээ нэмж гаргаж буй 10,077,100 (арван сая далан долоон мянга нэг зуу) ширхэг энгийн хувьцааны захиалгаас давсан нөхцөлд Компанийн зарласан энгийн хувьцаанаас нэмж дахин 5,536,868 (таван сая таван зуун гучин зургаан мянга найман зуун жаран найм) ширхэг хүртэлх энгийн хувьцааг нэмж гүйлгээнд гаргахаар тогтоосугай." гэснийг "Нийтэд санал болгон нэмж гаргаж буй энгийн хувьцааны анхдагч зах зээлийн арилжааны захиалгын хэмжээ нэмж гаргаж буй 14,665,944 (арван дөрвөн сая зургаан зуун жаран таван мянга есөн зуун дөчин дөрөв) ширхэг энгийн хувьцааны захиалгаас давсан нөхцөлд Компанийн зарласан энгийн хувьцаанаас нэмж дахин 3,855,654 (гурван сая найман зуун тавин таван мянга зургаан зуун тавин дөрөв) ширхэг хүртэлх энгийн хувьцааг нэмж гүйлгээнд гаргасугай." гэж өөрчилсүгэй.

3. Энэ тогтоолын 1 болон 2-т заасан нийтэд санал болгох нэмж гаргаж буй энгийн хувьцааны тоо хэмжээ нийтдээ 18,521,598 (арван найман сая таван зуун хорин нэгэн мянга таван зуун ерэн найм) хүртэлх ширхэг байхаар тогтоосугай.

4. Компанийн эргэлтэд гаргаж буй нийт 18,521,598 (арван найман сая таван зуун хорин нэгэн мянга таван зуун ерэн найм) хүртэлх ширхэг нийтэд санал болгож буй энгийн хувьцааны нэг ширхэг бүрийн үнийг 115 (нэг зуун арван тав) төгрөгөөр тогтоож, нийтэд тогтоосон үнийн аргаар санал болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА /Т.ЗОЛБОО/

ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК ERDENES SOLUTIONS Joint Stock Company 9020080899 2015358

УЛААНБААТАР ХОТ ГҮЙДСЕК ҮЦК ХХК ТТБ0674 № 5208173

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

ХАВСРАЛТ 13. ТУЗ-ийн тогтоол №ТУЗТ 04/2022

2022-03-22
БҮРТГЭЭ-03

# "ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС" ХК

2022 оны 03 дугаар сарын 01-ний өдөр №ТУЗТ 04/2022 Улаанбаатар хот

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

Нийтэд санал болгох энгийн хувьцааны тоо хэмжээнд өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2.2 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэг, 42 дугаар зүйлийн 42.1, 42.4 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.4, 76.1.18, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6.1 дэх хэсэг, "Эрдэнэс сольюшинс ХК ("**Компани**")-ийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.3, 5.4 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.10.12 дах хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12-р сарын 13-ны өдрийн ТУЗТ 11/2021 тоот тогтоолын 2 болон 3-дах заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 01-р сарын 31-ний өдрийн №ТУЗТ 02/2022 тоот тогтоолын 1 болон 2 дах заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн ТУЗТ 11/2021 тоот тогтоолын 2-т заасан "Компанийн дүрмийн 5.4-т заасан нэг бүр нь 10 (арав) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 19,842,125,430 (арван есөн тэрбум найман зуун дөчин хоёр сая нэг зуун хорин таван мянга дөрвөн зуун гуч) ширхэг зарласан энгийн хувьцаанаас 10,077,100 (арван сая далан долоон мянга нэг зуу) ширхэг хүртэлх энгийн хувьцаа буюу нийт гаргасан хувьцааны 6.00 (зургаа) хувьтай тэнцэх энгийн хувьцааг нэмж гарган "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-аар дамжуулан нийтэд санал болгох замаар худалдахаар тогтоосугай." гэснийг "Компанийн дүрмийн 5.4-т заасан нэг бүр нь 10 (арав) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 19,842,125,430 (арван есөн тэрбум найман зуун дөчин хоёр сая нэг зуун хорин таван мянга дөрвөн зуун гуч) ширхэг зарласан энгийн хувьцаанаас 16,572,469 (арван зургаан сая таван зуун далан хоёр мянга дөрвөн зуун жаран ес) ширхэг хүртэлх энгийн хувьцааг нэмж гарган "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-аар дамжуулан нийтэд санал болгох замаар худалдахаар тогтоосугай." гэж өөрчилсүгэй.

2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн ТУЗТ 01/2021 тоот тогтоолын 3-т заасан "Нийтэд санал болгон нэмж гаргаж буй энгийн хувьцааны анхдагч зах зээлийн арилжааны захиалгын хэмжээ нэмж гаргаж буй 10,077,100 (арван сая далан долоон мянга нэг зуу) ширхэг энгийн хувьцааны захиалгаас давсан нөхцөлд Компанийн зарласан энгийн хувьцаанаас нэмж дахин 5,536,868 (таван сая таван зуун гучин зургаан мянга найман зуун жаран найм) ширхэг хүртэлх энгийн хувьцааг нэмж гүйлгээнд гаргахаар тогтоосугай." гэснийг "Нийтэд санал болгон нэмж гаргаж буй энгийн хувьцааны анхдагч зах зээлийн арилжааны захиалгын хэмжээ нэмж гаргаж буй 16,572,469 (арван зургаан сая таван зуун далан хоёр мянга дөрвөн зуун жаран ес) ширхэг энгийн хувьцааны захиалгаас давсан нөхцөлд Компанийн зарласан энгийн хувьцаанаас нэмж дахин 1,949,129 (нэг сая есөн зуун дөчин есөн мянга нэг зуун хорин ес) ширхэг хүртэлх энгийн хувьцааг нэмж гүйлгээнд гаргасугай." гэж өөрчилсүгэй.

3. Компанийн Дүрмийн төслийг 1-р хавсралтаар батласугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА /Т.ЗОЛБОО/

ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС ХК
ERDENES SOLUTIONS Joint Stock Company
ХТҮ3261 9020080899 2015358

УЛААНБААТАР ХОТ
ГҮЙДСЕК ҮЦК ХХК

ХАВСРАЛТ 14. “Эйс ассошиэйтс ББСБ” ХХК-ийн дүрэм

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ХУРЛЫН 2021 ОНЫ ХЭШ 03/2021 ТООТ ШИЙДВЭРИЙН 1-Р ХАВСРАЛТ**

**" Эйс ассошиэйтс ББСБ " Хязгаарлагдмал хариуцлагатай ББСБ-ийн дүрэм**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. ББСБ-ийн оноосон нэр (монголоор)

- а) Бүрэн нэр: **"ЭЙС АССОШИЭЙТС ББСБ "** ХХК /цаашид энэхүү дүрэмд "ББСБ" гэх/
- б) Товчилсон нэр: "........" ХХК

1.2. ББСБ-ийн оршин байгаа газар:

- Улсын нэр: **Монгол**
- Аймаг, нийслэлийн нэр: **Улаанбаатар хот**
- Сум, дүүргийн нэр: **Чингэлтэй дүүрэг**
- Баг, хороо, хорооллын нэр: **2-р хороо**
- Гудамж, өргөн чөлөө, тойрог, талбайн нэр: 40 50 мянгат /15171/ Бакула ринбучийн гудамж
- Хашаа, байшин, хаалганы дугаар: 30 байр, 10-р давхар
- Шуудангийн хаяг: ..............................................
- Шуудангийн хайрцагны дугаар: ..........................................
- Харилцах утасны дугаар: **99037119** Факсын дугаар: ........................
- И-мэйл хаяг: ..............................................................................

1.3. ББСБ-ийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчийн

нэр 1.3.1.Иргэний тухайд:

- Иргэний эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр: **Базар овогтой Батхүү**
- Иргэний иргэний үнэмлэхийн дугаар:
- Регистрийн дугаар: **ЧО71101197**
- Гэрийн хаяг: **Улаанбаатар хот, Хан уул дүүрэг, 11-р хороо, Хатан туул, С-2 тоот**
- Харилцах утасны дугаар: **99902135**

1.3.2.Хуулийн этгээдийн тухайд:

- Хуулийн этгээдийн нэр: **Эрдэнэс сольюшинс ХК**
- Иргэний иргэний үнэмлэхийн дугаар:
- Регистрийн дугаар: **2015358**
- Гэрийн хаяг: **Улаанбаатар хот, Чингэлтэй дүүргийн 2 дугаар хороо, 40 50 мянгат /15171/ Бакула ринбучийн гудамж 30 байр, 10-р давхар**
- Харилцах утасны дугаар: **99037119**

1.4. ББСБ нь бие даасан тайлан тэнцэлтэй, харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг, хариуцлага хүлээх, нэг хувьцаа эзэмшигчтэй, хязгаарлагдмал хариуцлагатай ББСБ-ийн хэлбэрээр ажиллана.

1.5. ББСБ нь үйл ажиллагаагаа дараах чиглэлээр явуулна.

а. Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа;

1.6. ББСБ нь тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг хуульд заасны дагуу холбогдох эрх бүхий байгууллагаас зөвшөөрлийг бичгээр авч, энэхүү дүрэмдээ өөрчлөлт оруулан бүртгэх байгууллагад бүртгүүлнэ.

1.7. ББСБ-ийн үйл ажиллагаа эрхлэх хугацаа: Хугацаагүй, Хугацаа .......... жил. /доогуур нь зурах буюу хугацааг бичих/

1.8. ББСБ нь Монгол Улсад болон гадаад улсад өөрийн салбар, төлөөлөгчийн газартай байж болно. Компанийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу салбар, төлөөлөгчийн газраа байгуулан, бүртгэх байгууллагад бүртгүүлж, үйл ажиллагаагаа явуулна.

1.9. ББСБ нь үүсгэн байгуулах баримт бичигт болон улсын бүртгэлийн жагсаалтад агуулагдаж байгаа бусад мэдээлэлд оруулсан өөрчлөлтүүдээ хуульд заасан хугацаанд бүртгэх байгууллагад бүртгүүлнэ.

**Хоёр. ББСБ-ийн эрх**

2.1. ББСБ-ийн иргэний эрх зүйн чадвар нь улсын бүртгэлд бүртгүүлснээр үүснэ.

2.2. ББСБ нь өөрийн бэлгэдэл (эмблем), албан бичгийн хэвлэмэл хуудас, өөрийн нэр бүхий тэмдэг хэрэглэнэ.

2.3. ББСБ нь Компанийн тухай хуулийн 6.1-6.8 дахь хэсэгт заасны дагуу хараат болон охин ББСБ байгуулж болох бөгөөд үүнийгээ бүртгэх байгууллагад бүртгүүлнэ.

2.4. ББСБ нь өөрийн үйл ажиллагаагаа бие даасан байдлаар, эсхүл бусад хуулийн этгээдтэй хамтран Монгол Улсын хуулийн хүрээнд эрхлэн явуулна.

2.5. ББСБ нь үндсэн ба туслах үйл ажиллагаагаа хэвийн явуулах зорилгоор мэргэжил, ур чадвар, дадлага туршлагатай хүмүүсийг хөдөлмөрийн гэрээгээр авч ажиллуулах, тэдгээрийн ажиллах нөхцөл, цалин хөлс, урамшууллын хэмжээг тогтооно.

**Гурав. ББСБ-ийн үүрэг**

3.1. ББСБ нь энэхүү дүрмийн 1.5, 1.6-д заасан үйл ажиллагааг Монгол Улсын хуульд заасны дагуу эрхэлнэ.

3.2. ББСБ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын тухай хууль болон Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлд заасны дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн, санхүүгийн тайлан гаргана.

3.3. ББСБ нь Монгол Улсын татварын хуулиудын дагуу орлого, татвараа өөрөө тодорхойлж, албан татвараа сайн дураар төлнө.

3.4. ББСБ нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шаардлагатай мэдээ, мэдээллийг тухай бүр төрийн эрх бүхий байгууллагуудад гаргаж өгнө.

3.5. ББСБ нь Монгол Улсын Хөдөлмөрийн хуулийн дагуу ажиллагсдын өмнө хуулиар хүлээсэн үүргүүдийг биелүүлнэ.

СЗХ
2022 05. 25
БҮРТГЭВ
№ 01
2022-03-22
БҮРТГЭЗ-03

3.6. ББСБ нь энгийн хувьцааг заавал гаргах үүрэг хүлээж, давуу эрхийн хувьцааг гаргаж болно.

3.7. ББСБ нь хувьцаа эзэмшигчийн шаардлагаар ББСБ-ийн дүрэм, түүнд орсон нэмэлт түүнд танилцуулах үүрэгтэй.

3.8. ББСБ-ийн дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлт, шинэчлэн найруулсан дүрэм нь улсын бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.

3.9. ББСБ хувьцаагаа нэгтгэх, хуваахдаа түүнийг худалдан авах эрхийн бичиг болон түүнд хөрвөх үнэт цаасны бүрдүүлбэрт зохих өөрчлөлт оруулах үүргийг хүлээнэ.

3.10. ББСБ нь хувьцаа эзэмшигчийн шаардлагаар ББСБ-ийн дүрэм, түүнд орсон нэмэлт өөрчлөлтийг танилцуулна.

